

ЭХ МЭТЭЛЭЙ ДЭМТЭГЭЭ БОСЛОГ НАСААД ГЭРЭЭГЭЙГ ИТГЭЛЭЙ, ХИРЭМСЭН ГЭРЭГЭЙ ҮНЭЭЛЭЙГ ТОНШИЛГОНО!



Аливаа технологийн төлөө Хүн Хөрөөдөггүй. Э.Б.Энхбат

Ц.Ууганбаяр

# ШУУЛМЫН ИН ЭЭД

Аймгийн эрхэмчлэл-1

**Ц.УУГАНБАЯР**

**ШУЛМЫН ИНЭЭД**

## Зохиогчийн үг

Айдас гэж юу вэ? Та айх дуртай юу?

Яагаад айх дуртай байдаг вэ?

...Айдсыг жинхэнэ утгаар нь мэдэрсэн хүн л амар тайван байдал, аз жаргалынхаа үнэ цэнийг мэдэрдэг.

Айдсын мэдрэмжийг амсаагүй, айж түгшиж үзээгүй хүн байдаггүй гэсэн. Айдас хаа сайгүй бий. Шөнө хөнжилдөө ороод унтахад чинь, зүүд нойрон дундаа хөвж явахад чинь, өглөө босоод нүүрээ угааж, хоолоо идэхэд чинь хүртэл айдас эргэн тойронд байсаар байна. Хаана оюун ухаан байна, тэнд үргэлж айдас бий. Айдас хэзээ ч салан ангижрахгүй, холдон олдохгүй. Яагаад гэвэл төрөх үхэхийн завсар оршин буй хүн гэдэг дэндүү өчүүхэн, төгс үнэнийг мэдэхгүй “Яагаад?” гэсэн асуултыг өөртөө тавьсаар байдаг болохоор тэр. “Яагаад” гэдэг үг чиний толгойд орж ирж л байгаа бол чамд айх сэдэл бий гэсэн үг. Мэдэхгүй зүйл бүхэн араасаа айдас дагуулж байдаг болохоор хүн гэдэг бүхнийг мэддэг болтлоо айдсаас зугтаж чадахгүй. Хүмүүс хэрвээ бүхний мэддэгсэн бол түүнд айдас гэж үгүй байх байсан нь дамжиггүй. Даанч бүхнийг мэднэ гэдэг бүтэшгүй хэрэг болохоор айдсаас зугтах биш түүнтэй нөхөрлөх гээд үзэгтүн.

Ингээд олныг үл нуршиж таныг мэдэхгүйн дунд тэнүүчилсэн айдсын ертөнцийн босгоор алхуулан оруулья.

Тэгээд эцэст нь амар амгаланг хүсье.

*Ц. Ууганбаяр*

## ХӨРГӨГЧ

Хөргөгчний моторын хүнгэнэсэн чимээ яагаад ч юм Бурмаагийн нойрыг бүр хулжааж орхижээ. Уг нь зүгээр л нэг хөргөгчний дуу шүү дээ. Энэ шөнө Бурмаагийн дүү нь түүнтэй хань болж хонож байгаа бөгөөд хааяа хааяахан зөөлхөн хурхирах чимээ гарах нь Бурмаагийн жихүүцсэн сэтгэлийг тайтгаруулах мэт. Хэрвээ үе үе дуулдах дүүгийн нь хурхирах амьсгалах чимээ гарахгүй байсан бол Бурмаа гэрээсээ гараад гүйхэд бэлэн байсан биз. Өөрийгөө чухам яагаад айгаад байгаагаар сайн ойлгохгүй байгаа ч сүүлийн үед өөрийнхөө жихүүцсэн сэтгэлийг тайтгаруулж чадахаа ер больжээ. Нөхөр нь нас бараад зургаахан сар болж байгаа түүний хувьд харин хаа очиж ганцаардаж нөхрөө үгүйлээд байгаа хэдийн больсон. Чухам яагаад ч юм бүү мэд нөхрөө ослоор өөд болоход нь бүр тэгтлээ их харамсаагүйгээ бодохоор Бурмаа өөрийгөө хааяа гайхаад бардаггүй ажээ.

“Би нөхрөө өөд болоосой гэж хүсч байсан хэрэг үү. За үгүй дээ, яалаа гэж тэгэх вэ дээ. Би түүндээ хайртай л байсан. Хорвоо биднийг салгасан учраас үхсэний хойноос гуниглахгүй байгаа нь харин сайн хэрэг. Хувь заяатайгаа эвлэрээд ингээд л болох бүтэхээрээ сайхан амьдрах хэрэгтэй” Бурмаа ийн бодол болон хэвтсээр. Гэр хороололд тохилог хашаа бүхий хоёр давхар хашаанд амьдрах түүний хувьд энэ шөнө үнэхэр ямар нэгэн юм болох гээд байгаа юм шиг л зөн совин татаад байв.

...Үгүй бас гайхалтай юмаа. Энэ хөргөгч ингэж чанга дуугардаг билүү. Уг нь шинэхэн хөргөгч юмсан. Шөнө дунд болоод ирэхийн үед л ингэж трактор шиг дуугараад байгааг нь ердөө ч ойлгохгүй юм хэмээн Бурмаа өөрөө өөртөө хэлж босч үзэхийг завдсанаа орон дээрээ хэсэг тээнэгэлзэх нь тэр. Ядаж тог тасарчихсан, сарны гэрэл ч тусахгүй энэ шөнө гэр гадаа тэр аяараа л харанхуй. Хав харанхуй энэ байшин дотор зөвхөн ор хөнжлийн цагаан хэрэглэл нь л ялгарч харагдана. Бурмаад өчигдөр шөнийн зүүд нь бодогдоод энэхэн агшинд бүр хөшиж орхижээ. Тэр зүүд ёстой муу ёрын зүүд байсан. Тэрээр зүүдэндээ тачигнаж дуугарсан хөргөгчөө чухам яагаад байгааг нь очиж шалгасан. Гэтэл тэндээс үнэхээр аймшгийн дүр зураг олж хараад эгээтэй л зүүдэндээ цус харвачихаагүй. Бурмаа хоёр давхарт байх унтлагын өрөөнөөсөө яаран бууж галын өрөөнийхөө гэрлийг асаагаад хөргөгчөө хартал...тийм ээ, үнэхээр хөргөгчин дотор нь ямар нэг юм пижигнэтэл буцалж, тэндээ багталгүй цагаан мөлгөр хаалгыг нь даван улаан цус урсаж байсан. Дотор нь чухам юу байгааг очиж үзэхээр хөргөгч рүүгээ алгуурхан дөхөж байгаад цочоод сэрчихсэн. Тэгээд л айсандаа үүр цайтал унтаагүй. Өглөө нар гарсан хойно бага зэрэг тайвширч өнөөдөр ийн охин дүүгээ гэртээ авчран хамтдаа хонож байгаа билээ.

Тар тар хийн хүчтэй дуугарах тэр чимээ яах аргагүй хөргөгчнөөс нь дуулдаж байгааг Бурмаа зөнгөөрөө мэдэж байлаа. Магадгүй өөрийгөө зүүдэлж байна гэж бодоод хацраа хүртэл чимхээд үзтэл өвдөж байна аа. Тэгэхээр би сэрүүн байна хэмээн хэлээд зүүд биш байсанд харамсах ч шиг болов. Ядахдаа хөргөгчнөөс гарч байгаа тэр дуу яг л урьд шөнийн зүүдэнд дуулдаж байсан тэр хэмнэлээр дуугараад болдоггүй. Бүр сүүлдээ тэр чимээ нь Бурмааг нэрээр нь дуудаад байгаа ч юм шиг санагдаж эхлэх нь тэр. “Хэрвээ одоо доошоо буугаад очвол яг өчигдрийн зүүдэндээ үзсэн тэр дүр зургийг олж харах юм биш байгаа” хэмээн бодсоноо гэнэт энэ бодлоосоо цочих шиг боллоо. Бурмаа айсандаа бүр дагжин чичирч байв. Хамаг биеийн нь хар хөлс цутгажээ. Тэр хөргөгч ердөө чимээгүй болсонгүй, улам л чанга

дуугараад байв. Бурмаа бүр яахаа мэдэхээ байж дүүгээ татаж сэрээлээ. Дүү нь нойроо харамлан “яав” хэмээн дурамжхан асуух нь хэзээ мөдгүй эргээд унтахад бэлэн байгаа нь илт.

-Тэр доор юу дуугараад байна аа. Трактор дуугарч байгаа юм шиг л сонсогдож байна. Энэ дуу яах аргагүй хөргөгчнөөс гараад байна даа. Хоёулаа очиж үзье тэгэх үү Одноо?

-Бурмаа эгч ээ унт л даа. Юу ч сонсогдохгүй л байна даг. Алив чимээгүй сонсоё. Тээр та бид хоёрын амьсгалаас өөр чимээ энэ гэрт гарахгүй л байгаа биздээ.

-Чамд үнэхээр сонсогдохгүй байна уу?

-За за унтаа, би өглөө эрт хичээлтэй.

Ингэж хэлээд дүү нь хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөн таг чиг боллоо. Бурмаа бүр мэл гайхаж хоцров. Яах аргагүй л дуугарсан даа. Одоо ч гэсэн дуугарч л байна. Одноо л нойрмоглоод юу ч сонссонгүй хэмээн хэдийн унтчихсандүү рүүгээ зэмлэнгүй харснаа чимээ гарч буй доод давхар луу зүглэлээ. Гартаа лаа асаан шатны гишгүүр дамжин алгуурхан доошлох Бурмаагийн зүрх хурдан хурдан цохилох аж. Доод давхар луу дөхөх тусам хөргөгчний тачигнах чимээ улам чанга сонсогдож байлаа. Бурмаа хэдий буцаж гүйгээд дүүгийнхээ өвөрт ормоор болсон ч энэ удаа зориг гаргахаар хатуу шийдэв. Хэрвээ гэрт өөр хүн байж гэмээнэ нь унтлагын цагаан хувцастай үсээ задгайлж гартаа лаа барин сэмхэн гэтэх Бурмааг хараад үхтлээ айх байсан нь дамжиггүй биз.

Одоо Бурмаад гал тогооны өрөөнд ороход ердөө долоо эсвэл наймхан алхам үлдээд байв. Гартаа барьсан лаа нь чичигнэж буйгаас үзэхэд Бурмаа маш ихээр айж байгаа нь илт. Ийнхүү Бурмааг яг галын өрөөний үүдэн дээр тулаад ирэх үед хөргөгчний дуу гэнэт зогсч асаалттай лаа нь унтран өрөөний гэрэл ч мэлс хийтэл аслаа.

Бурмаа ч гартаа атгасан лаагаа алдаж орхиод орь дуу тавин гүйсээр нэг л мэдэхэд унтлагынхаа өрөөнд орсон байв. Дүү Одноо нь юу ч болоогүй юм шиг тайван унтах аж. Удалгүй үүр цайж гэгээ орсноор Бурмаа тайвширч нам унтаж орхижээ. Дөнгөж зүүрмэглэх төдийд л нөгөө зүүд нь давтагдаж хөргөгчнийх нь хаалгыг давж нэлий улаан цус урсаж байгаа мэт зүүдэнд нь үзэгдэнэ.

-Бурмаа эгч ээ, өглөөнийхөө цайг уугаарай гэх дүүгийнхээ цовоо дуунаар Бурмаа нойрноосоо бүрмөсөн сэрлээ. Шөнө тачигнаж байсан хөргөгчний дуу одоо дуулдахаа больжээ. Бурмаагийн шөнийн айдас нь ор мөргүй алга болсон ч царай нь их л шаналангуй харагдах аж. Гал тогооны өрөөнд дүү нь хоёр хүний өглөөний цай бэлдчихсэн хүлээж байлаа. Одноо өчигдөр шөнийн тухай юу ч дурссангүй. Харин ум хумгүй цайгаа ууж дууссанахаа дараа “Өглөө хөргөгчний чинь шалан дээр цус тунарчихсан байхаар нь арчсан. Доторх махаа хөлдөөж чадахгүй, их л муу хөргөгч байна даа” гэж хэлээд гарч одов. Энэ үгийг сонссон Бурмаагийн дотор палхийгээд явчихав. Тэр зүүдэлсэн зүүд нь үнэхээр бодит амьдрал дээр биеллээ олсон юм биш байгаа. Бас өчигдөр шөнө тог тасарсан байснаа галын өрөөний гэрэл гэнэт ассан, тэгсэн мөртлөө хөргөгч дуугараад байсан шүү дээ. Ингэж бодоод Бурмаа хөргөгчнийхөө хаалгыг нээж үзлээ. Ямар ч мах гэсч цус нь урссан шинж алга. Тэс хөлдүү байсан тэр л чигээрээ. Дүү Одноо нь хичээлдээ яарч байсан болохоор гэссэн махны учрыг

олно гэхээс тээршааж эгчдээ даатгаж орхиод ум хумгүй зугтаж орхисон нь ойлгомжтой. Тэгээд л хөргөгчийг нээж үзэхийг завдсангүй доор нь тунарсан цусыг арчихаад явчихжээ. Бурмаа дүүгээ худлаа ярьсан юм болов уу ч гэж бодох шиг. Гэхдээ л ямар ч шалтгаангүй дүү нь ингэж худлаа хэлэхгүй гэдгийг Бурмаа мэдэхийн дээдээр мэдэж байв. Энэ шөнө эгч дүү хоёр гэртээ хоносонгүй. Мэдээж энэ бол Бурмаагийн санаачлага байсан бөгөөд хоёр давхар ямар ч эр хүнгүй байшинд дахин шөнийг өнгөрөөнө гэхээс яс нь хавгайсных.

Шөнө болжээ. Энэ шөнө Бурмаагийн чихэнд ямар нэгэн хөргөгчний чимээ сонсогдоогүй, тэгээд ч аав ээж, дүү нар нь шуугилдаад сэтгэл тэнэгэр байлаа. Дахиад л зүүд. Гэхдээ Бурмаа өөрийгөө зүүдэлж байгаага мэдэж байгаа хэрнээ сэрэх гээд сэрж чадсангүй. Гэрийн нь хөргөгчин дотроос хэн нэгэн гарах гээд хамаг тэнхээгээ шавхаж байгаа юм шиг санагдаж өөрийн мэдэлгүй гэр лүүгээ хамаг хурдаараа гүйж байх юм. Гэрийнхээ босгон дээр тулж ирэхэд бүх өрөөнийх нь гэрэл унтраалттай хэрнээ зөвхөн галын өрөөнийх нь гэрэл асаалттай, цаана нь хэн нэгэн байгаа мэт бөгтөлзсөн сүүдэр үзэгдэж байлаа. Гэрт ороход анир чимээгүй, галын өрөөнийх нь хаалга хаалттай. Харин завсраар нь гэрэлтэй байгаа нь харагдаж байлаа. Энэхэн агшинд Бурмаа сэрэхийг үнэхээр их хүсч хэн нэг нь биеийн нь хаа ч хамаагүй нэг хэсэгт нь хүрээсэй хэмээн тэсэлгүй хүсч байлаа. Тэгэхгүйгээр сэрж чадахгүй гэдгээ ч мэдэж байв. Оюун ухаан нь зүүдэлж байгаага мэдсэн хэрнээ зүүд үргэлжилсээр...

...Галын өрөөнийхөө хаалгыг алгуурхан нээлээ. Хөргөгч нээлттэй, хамгийн аймшигтай нь хэн нэгэн халзан толгойтой чармай нүцгэн эр буруу харж явган суугаад шир шир хийтэл ямар нэгэн юм идэж байх юм. Бурмаа бүрэн айдаст автан гарч гүймээр байсан ч тэгсэнгүй. Тэр ховдоглон идэж буй залуугаас нүдээ салгаж ч чадсангүй. Түүн рүү алгуурхан дөхлөө. Араас нь хэн нэгэн гэтэж байгааг ер мэдсэн шинжгүй, үхээнц цагаан биетэй, ямар ч үсгүй энэ мөлчгөр эрийн биеэр цус гүйж байгаа шинж алгаа. Хөргөгчний хаалгыг нээчихсэн ямар нэг юм ухаан жолоогүй ховдоглон идэх энэ эр чухам хэн юм бол гэж Бурмаа гайхаж мөрнөөс нь татаж үзэхээр шийджээ. Мөрөнд нь гараа хүргэв. Чармай нүцгэн мөлчгөр эрийн бие хөлдүү гэмээр сэтгэгдэл төрүүлэх аж. Ховдоглон идэх нүцгэн эр эргэж харсангүй. Бүр араас нь хэн нэгэн ирээд мөрөн дээр нь гараа тавьж байгааг ч мэдсэнгүй, юуг ч юм амтархан идсээр.

Бурмаа гайхаж бүр мөрнөөс нь хүчтэй угзран татахад ямар ч хөмсөг сормуусгүй, тас хар нүдтэй, завьжийг нь дагаж цус урссан нүцгэн эр сая эргэж харав... Ээ бурхан минь, энэ чинь хэн бэ? Таньдаг хүн бүр таних танихдаа дэр нэгтгэн хамтдаа амьдрач байсан эр нөхөр нь байхыг олж хараад зүүднээсээ цочин муухай орилон сэрлээ. Гэрт анир чимээгүй нам жим байх агаад эцэг эх дүү нар нь бүгд гүн нойрондоо авгаж байв. Бурмаа яаран хувцаслаад гараад гүйлээ. Бурмаагийн өөрийн нь гэр эндээс нэг их холгүй бөгөөд түүнийг ийн гэрээс гараад явахыг хэн ч мэдсэнгүй. Бурмаа хар эрчээрээ гүйсээр хашааныхаа гадаа иржээ. Хашааныхаа хаалгыг нээж ортол үнэхээр гал тогооных нь өрөөний гэрэл асаалттай байлаа. Бурмаа өөрийгөө чухам хий юм харав уу хэмээн гайхсан хэдий ч яалт ч үгүй ганцхан галын өрөөнийн нь гэрэл асаалттай үзэгдэнэ. Хараал идмэр гэж ядаж дотор нь үнэхээр хэн нэгэн байгаа бололтой шүү.

Бурмаа дахиад л бүсгүй хүнд баймгүй зориг гаргаж байшингийнхаа хаалгыг түлхүүрдэн нээлээ. Хэрвээ үнэхээр гаднаас хүн нэвтрэн орж ирсэн бол хаалга нь нээлттэй байх ёстой гэдгийг Бурмаа тэрхэн агшинд санаад амжив. Гэсэн ч гал тогооны өрөө рүү дөхөхдөө

цааргалсангүй. Хамаг бие нь салгалж баахан эргэлзэж тээнэгэлзэж байсан ч хаалгыг хүчтэй түлхэн дотогш орлоо. Саяхан л байшингийн гаднаас харахад дотор нь сүүдэр бөгтгөнөж харагдсан бол одоо хэн ч алга. Гэрэл асаалттай, хөргөгчний хаалга нээлттэй байлаа. Гал тогооныхоо өрөөнд суун аяга ус ууж жаахан тайвшраад бодолхийлэв. Уг нь Бурмаа сүнс, чөтгөрт тэгтлээ их итгээд байдаггүй, ямар ч сүсэг бишрэлгүй нэгэн. Гэхдээ энэ удаа өөрийг нь яалтчгүй нэг юм ээрээд, тайван байлгахгүй байгааг мэдрэх шиг. Тийм ээ, яалт ч үгүй нөхөр нь. Нөхрийн нь сүнс, магадгүй өөрийг нь тайван байлгахгүй хоргоогоод ч байгаа юм уу гэсэн бодол Бурмаагийн толгойд төрөхтэй нь зэрэгцэн хөргөгчийг ямар мөнгөөр худалдаж авсан нь санаанд нь орлоо. Тийм ээ, талийгаачийн буяны ажилд цугларсан мөнгөөр энэ хөргөгчийг худалдаж авснаа яагаад арай эрт санасангүй вэ. Тэр мөнгөөр хөргөгч худалдаж авахдаа Бурмаа огтхон ч тоогоогүй. Харин ч боломж олдсон дээр нь нэг юмтай болоод авах нь зөв гэж өөрийгөө сайшааж байсансан.

Өглөө боллоо. Бурмаа хөргөгчний дуу, шөнийн зүүднүүдийнхээ учрыг олсон шиг санагдана. Юм мэддэг, үздэг хардаг гэсэн лам нараар явж учраа хэлж, аргалж өгөхийг хүсэхэд “Хөргөгчөө зараад мөнгөөр нь буян үйлд” хэмээн айлдацгаав. Гэсэн ч харамсалтай нь Бурмаа тэр зөвлөгөөг дагасангүй. Нөхрөө амьд сэрүүнд нь ийм хөргөгч аваад өгөөч гэж хичнээн шалсан ч нөхөр нь авахыг завдаагүй. Тэгтэл харин нөхрийн нь буяны ажилд овоо хэдэн төгрөг цуглараад нөгөө бараг л мөрөөдөл болоод байсан хөргөгчөө сая нэг авах боломж гарч билээ. Магадгүй түүнээс болоод ч тэр юм авах боломж гарч билээ. Магадгүй түүнээс болоод ч тэр юм уу Бурмаа хөргөгчийг нэг тийш нь болгох гэсэн бодлоо хүчээр мартаж орхижээ. Тун удалгүй Бурмаагийн сэтгэхүйд өөрчлөлт өөрчлөлт орж хөргөгчийнхөө дуунаас айхыг ч болив. Харин ч хөргөгчөө нээж өмнө нь явган суугаад хэн нэгэнтэй ярилцдаг болох нь тэр. Энэ байдал даамжирсаар эцэг эх нь Бурмааг сэтгэхүйн эмнэлэгт хэвтүүлжээ. Гэсэн ч Бурмаа шөнө болоод ирэх үест “Манай нөхөр намайг хүлээгээд хөргөгчиндөө сууж байна. Би очихгүй бол болохгүй” хэмээн эмч сувилагч нарыг сандаргадаг болов. Түүгээр ч зогсохгүй хаана хөргөгч харагдана тэнд оччихоод хаалгыг нь нээн хэн нэгэнтэй элдвийг ярилцан тас тас хөхөрч заримдаа бүр мэгшин уйлдаг боллоо. Тэр бүрмөсөн солиорчээ.

... Шөнө болж сэтгэцийн эмнэлгийн орон дээр унтаж байсан Бурмаа хөргөгч дуугарах чимээнээр инээмсэглэн сэрлээ.

## Төгсөв

## I ХЭСЭГ

... Бороо цутгаж байв. Зуны улирал атал цаанаа л нэг жиндүүхэн бөгөөд гудамжаар холхих хүмүүс цөм дүнсийж ууртай царайлан хаа нэг тийшээ яарна. Өнөөдөр чинь ямар гээчийн өдөр вэ?

...Хаа сайгүй замын түгжрээ, уурлаж хашхичсан жолооч нарын дуу бүр дээд цэгтээ хүрч бие бие рүүгээ чанга чанга зандарна. Зэвхий тэнгэрээс цутгах их усан дуслууд хэзээ ч дуусч дундрахгүй нь уу гэлтэй цутгасаар л. Уг нь бороо ороход хүмүүс баярладаг байтал энэ удаа шал эсрэгээрээ. Бүгд л айдас түшүүр ямар нэгэн бухимдалд автжээ. Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын хажуугаар өнгөрөөд Тэнгис кино театрын хойно байрлах гэрийнхээ зүг явж байгаа Сэлэнгээгийн нүдэнд залуухан эх тав орчим насны болов уу гэмээр жаахан хүүхдээ ямар ч хайр энэрэлгүй зодож бахируулах нь өртөв. Ийм залуухан, бас давгүй царайлаг энэ туранхай бүсгүйд өрөвдөх сэтгэл гэх юм ер алга аа. Энэ хүйтэн борооноор нимгэн хувцасласан жаахан хүү ээж ээ хэмээн аврал эрэн сарвалзаж газар хэвтэх авч өнөөх бүсгүй хүүг үг дуугүй дэвслэн өшигчих нь Сэлэнгээд аргагүй аймшигтай санагдаж байлаа. Хамгийн гайхалтай нь түүний хажуугаар өнгөрөх хүмүүс “Хүүгээ зодож байгаа эх бидэнд ямар ч хамаагүй” гэж үзсэн үү эсвэл бүр анзаарсан ч үгүй юу ямартай ч огтхон ч эмзэглэсэнгүй, бүр тоож ч харсангүй.

Өнөөдөр чинь энэ хүмүүс ер нь юу болчихоо вэ? Сэлэнгээ өөрийн эрхгүй амандаа ийн дуу алдаж энэ асуултанд нь хэн нэгэн хариулчих юм биш байгаа гэсэн шиг орчин тойрноо горьдлогын нүдээр харан бүлтгэнэж, алхааныхаа хурдыг улам түргэсгэлээ. Ийнхүү Сэлэнгээ цаашаа алхсаар орон сууцнуудын дунд ороод ирлээ. Тэрээр нэгэн угсармал есөн давхар байшингийн булан тойрох агшинд 26 орчим насны л болов уу гэмээн өөрийнхөө үеийн нэг бүсгүйтэй мөрөөрөө мөргөлдчихөв. Гэтэл тэр үл таних бүсгүй Сэлэнгээг амаа ч нээж амжаагүй байхад хараалын үгээр булж гарах нь тэр.

“Нүд нь ширгэж сохойсон үрчгэр амьтан минь. Наад хоёр цэхрээ сайн нээгээд замаа хараач” гэж тодхон хэлээд цаашаа амандаа элдвийг бувтнан явж одлоо. Үнэндээ түүний юу гэж үргэлжлүүлэн хараахыг ч Сэлэнгээ сонсохыг хүссэнгүй. Амьдралдаа анх удаа л хүнд ингэтлээ доромжлуулсан шиг санагдаж байсан ч энэ дайралтын эсрэг өөрийгөө хамгаалсан ганц ч үг хэлсэнгүй, эргэж ч харалгүй ум хумгүй гүйчихлээ. Бороо улам хүчтэй ширүүссээр. Энэ нь хүмүүсийн уур бухимдлыг бүр ч их нэмэгдүүлж байгаа гэлтэй хаа сайгүй л хялалзаж цэхэлзсэн хүмүүс хараалын үгс шидлэн холхилдоно. Энэ хүмүүсийн дунд ядаж шүхэр барин тайван алхах хүн ч алга. Хувцас нь нэвт норж бүр тогтохын аргаргүй болсон мэт харагдах авч хөмсгөө зангидан ярвалзан алхлаад л...

Тайван явах ямар ч арга алга аа. Энэ муу ео шингэсэн гэлтэй усан бороо ямар нэгэн муу зүйл зөгнөөд амьдралыг нь орвонгоор нь эргүүлж там болгон хувиргах гэж байгаа юм шиг л Сэлэнгээд санагдах нь тэр. Энэ бодолтой нь зэрэгцэн ар нуруугаар нь аалз гүйх шиг болж өөрийн эрхгүй дотор нь арзасхийв. Сэлэнгээ энэ мөчид өөрийн амьдардаг танил дотно болсон орон сууцаа харахыг тэсгэлгүй хүсэх авч гэртээ хүрэх хараахан болоогүй байлаа. Хурдхан гэртээ харьж энэ замбараагүй, зэвүүн, муу ёр зөгнөсөн орчноос ангижирч зурагтаа



үзэхсэн гэдэг бодол түүнийг бүр хурдан алхахад, магадгүй бүр гүйхэд хүргэх аж.

Дахин нэг байшингийн булан тойрон эргэлээ. Гэтэл Сэлэнгээгийн нүдэнд эрхгүй нэгэн зүйл өртсөн нь гартаа ганцхан ширхэг улаан сарнай атгачихсан, гүн цэнхэр өнгийн костюмтай залуу байлаа. Залуугийн царай цонхигор зэвхий бөгөөд цэнхэр костюмтай зогсох түүний гарт нь байгаа улаан сарнай нэг л зохицохгүй харагдана. Энэ үл таних залуугийн Сэлэнгээгийн нүдэнд ялгарч өртсөн хамгийн гол шалтгаан нь бүх хүмүүс уурлаж дүнсийсэн байхад ганцаархнаа инээмсэглэж байсан явдал. Гэхдээ энэ цонхигор залуугийн хүйтэн инээмсэглэл Сэлэнгээд огтхон ч сайхан сэтгэгдэл төрүүлсэнгүй. Уг нь энэ олон уурлаж бухимдсан хүмүүсийн дундаас ядаж ганц ч гэсэн инээмсэглэсэн царай олж харсандаа баярлаж байх ёстой атал тэгсэнгүй. Ердөө л сэтгэлд нь нэгэнт хуралдаад байгаа, өөрт нь үл ойлгогдох айдсыг нь харин ч бүр хөглөөд ирэх шиг. Яагаад энэ залуу инээмсэглэж байгаа хэрнээ ийм муухай таагүй сэтгэгдэл төрүүлнэ вэ?

Сэлэнгээ өөрөөсөө ийн асуугаад үргэлжлүүлэн өөртэйгөө бодлоороо ярилцлаа.

... Уг нь өчигдөр, уржигдар за ер нь тэрний урдах бүх л өдрүүдэд өөрөөр хэлбэл хэвийн өдрүүдэд тайван инээмсэглэн алхаж байгаа хүмүүсийн дунд уурлаж бухимдсан хүн таагүй сэтгэгдэл, цаашлаад айдас төрүүлдэг бол энэ удаад яг эсрэгээрээ үйлчилж байгаа нь энэ үү? Уурлаж бухимдсан хүмүүсийн дунд уурласан царай гаргахгүй бол бусдыг айлгачихдаг байх нь.

Энэ чинь тэгэхээр юу гэсэн үг вэ? Уурлаж бухимдсан хүмүүсийн дунд ууртай царай гаргаж, инээмсэглэсэн хүмүүсийн дунд бол инээгээд бай гэсэн үг үү. Тэгвэл ердөө л бусадтай ижилхэн биш байгаа тэр байдал л айдас төрүүлдэг байх нь. Яг л амьд хүн үхсэнээсээ айдаг шиг. Үхсэн нь амьдаасаа ялгаатай учраас амьд хүмүүс түүнээс айж, сэжиглэж, цэрвэдэг. Бүр тэгээд үхсэн нэгийгээ босоод ирэх вий гэсэн шиг авсанд хийж таглаад газар доор булж дээрээс нь цементлэдэг. Тэгвэл яг үүнтэй адилаар үхсэн нь амьдаасаа айдаг... За биш юм аа. Үхсэн хүн гэдэг бол айх, баярлах мэдрэмжээ алдсан юу ч мэдрэхгүй болсон тийм л нэг цогцос шүү дээ. Гэхдээ юмыг яаж мэдэхэв. Үхэгсдийн эсвэл цаашлаад сүнснүүдийн ертөнц гэж байдаг ч юм билүү. Тэгээд л магадгүй хэн нэгэн амьд хүн ямар нэгэн байдлаар тэр газарт нь оччих юм бол үхэгсдэд эсвэл сүнснүүдэд айдас төрүүлэх нь дамжиггүй. Сэлэнгээ ингэж бодсоноо жихүүцэж орхив. Юун ч дэмий юм боддог юм бэ дээ гэж өөртөө дуулах төдий шивнэн алхааныхаа хурдыг жаахан сааруулав. Сэлэнгээ ингэж бодол болон алхаж байхдаа өнөөх цэцэг барьсан цэнхэр костюмтай этгээдээс нүднийхээ харцыг огтхон ч салгаж чадахгүй байсан билээ. Учир нь тэр залуу руу ойртох тусам царай нь тодрон харагдаж тэр нь эрхгүй сонирхол татахуйц байсан ажээ.

Залуугийн том алаг нүдний нэг нь долир байх бөгөөд энэ нь мөлчгөр цонхигор царай, спорт маягийн тачирхан үсэнд ердөө ч зохицохгүй харагдана. Яг л хаа хамаагүй хүмүүсийн нүд, шүд, үс чих, царай төрхийг нь цуглуулаад нэг хүн болгоод эвлүүлчихсэн юм шиг. Товчхондоо бол тэр залуу яг л эвлүүлдэг тоглоом гэлтэй. Тэр тоглоомыг хэн нэгэн этгээд маш сайн эвлүүлчихсэн юм шиг. Тэр үл таних залуу Сэлэнгээ рүү л ширтэн хараад инээгээд байгаа юм шиг атлаа үнэн хэрэг дээрээ Сэлэнгээ дээр тэр залуугийн харц тогтохгүй байлаа. Магадгүй

Сэлэнгээгийн биед байгаа тэр нь өөрт нь харагдахгүй байгаа тийм зүйлийг энэ цэнхэр костюмтай залуу олж харчихаад инээгээд байх шиг. Сэлэнгээгийн алхаа бүр удааширч зүрхнийх нь цохилт мэдэгдэхүйцээр түргэсээд иржээ. Энэ залуу руу ингээд л дөхөөд байх нь зөв үү буруу юу эсвэл бүр тойроод гүйчих үү. Ядаж байхад энэ залуу яг гэр хүрэх замд нь тааралддаг хүүхдийн тоглоомын талбайн сандал дээр суучихсан инээж байгааг ч хэлэх үү. Бас тэр гартаа барьсан ганц ширхэг нүцгэн сарнай нь энэ эцэс төгсгөлгүй цутгах бороонд цохигдож шалчийсан шинж ердөө ч алга. Ер нь л энэ залуугийн бүх эд эс нь нэг л ойлгомжгүй, ганцхан үгээр хэлбэл нэг л авцалдахгүй байв.

Сэлэнгээ гайхаж эргэлзсэн бас айсан бодолдоо автан аажмаар алхсаар нэг л мэдэх нь ээ өнөөх залуу руу нэлээн дөхөөд иржээ. Гэтэл өнөөх цэнхэр костюмтэй долир залуу сууж байсан сандлаасаа өндийн инээмсэглэсээр Сэлэнгээ рүү ойртов. Ингэнэ гэж санаагүй Сэлэнгээ давхийн цочсоноо айдастайгаа тэмцэж хэвийн байдлаа хадгалахыг хичээж эхэллээ. “Орчин тойронд нь уур уцаартай л болохоос биш өч төчнөөн хүмүүс явж байхад энэ долир залуу яав л гэж” хэмээн өөртөө хэлж тайвширахыг хичээнэ. Гэхдээ энэ залуугийн нэг л юм аргагүй эгдүүцэм зэвүүн санагдаад байгаа нь цонхигор нүүрэндээ тодруулаад байгаа хүйтэн инээмсэглэл нь байлаа. Инээмсэглэл ч гэж дээ. Инээмсэглэл гэдэг бол хүмүүст хөгжилтэй, аз жаргалтай байгааг илэрхийлдэг илэрхийлэл болохоос биш айдас төрүүлдэг мушийлт биш шүү дээ. Гэхдээ бас энэ залууг зүгээр л нэг мушийсан гэж хэлэхэд бас болохгүй. Ядаж байхад энэ орчин тойрон тэр аяараа гунигт автах мэт дүнсийн сааралтаж муу ёр зөгнөсөн гэлтэй зуны хүйтэн бороо эцэс төгсгөлгүй цутган гудамжинд явах хүмүүс ууртай ярвагар царайгаар нүүрээ чимэглэсэн байгаа нь Сэлэнгээгийн сэтгэлийг хямраах хангалттай шалтаг болж байлаа.

Инээмсэглэсэн долир залуу Сэлэнгээгийн өмнө тулж ирээд өнөөх гартаа барьж байсан улаан сарнайгаа түүнд барив. Гайхшруулж бас жихүүцүүлмээр энэ үйлдэл нэг л муу ёр зөгнөх шиг л Сэлэнгээд санагдана. Сэлэнгээ цэцгийг авахыг тэгтлээ их яарсангүй. Харин өнөөг хэр нь инээсээр байгаа цэнхэр костюмтай долир залуу руу асуусан харцаар ширтэв.

Бороо улам хүчтэй асгарсаар. Залуу юу ч хэлсэнгүй зүгээр л цэцгээ түүн рүү сарвайсаар зогсоно. Сэлэнгээ ямар нэг зүйл асуух гэснээ больж энэ залуугаас хурдхан салж гэртээ харихын түүс болжээ. Тэгээд шууд л цэцгийг аваад гүйж одлоо. Эргэж ч харсангүй, хурдхан гэртээ ороод энэ толгой өвггөсөн дүнсгэр орчноос салахсан гэхээс байж ядна. Сэлэнгээгийн санаанаас саяын залуу гарсангүй. Ялангуяа тэр долир нүд, хүйтэн инээмсэглэл. Бас тэр өмсчихсөн гүн цэнхэр өнгийн костюмийг нь өөр хэн ч хэзээ нэгэн цагт өмсөж байсан нь Сэлэнгээгийн санаанд буухгүй байв. Ингэж бодмогцоо Сэлэнгээгийн царай гэнэт барайгаад зогтусах нь тэр ээ. Тийм ээ, тэр залуугийн өмссөн тэр гүн цэнхэр өнгийн костюм нь огтхон ч нуруугүй байсан. Үүнийг нь тухайн үедээ ажиглаж байсан ч яагаад гайхаагүй өнгөрчихсөн юм бол оо? Сэлэнгээ өөрийн эрхгүй эргэн харлаа. Өнөөх цэнхэр костюмтай залуу аль хэдийн алга болжээ. Түрүүхэн тоглоомын талбай дээр сууж байсан ямар ч ул мөр алга. Харин тэр долир нүдтэй залуугийн үнэхээр байсан гэдгийн баталгаа болсон улаан сарнай Сэлэнгээгийн гарт үлдэж хоцорчээ. Хавь ойрд холхиж байгаа хүмүүсээс цэнхэр костюмтай долир нүдтэй залууг хаашаа явсныг асуух гэсэн боловч яахаас ч буцахгүй шинжтэй ууртай хүмүүс рүү харж чадсангүй орц руугаа орлоо.

... Орц хав харанхуй байлаа. Уг нь дандаа л гэрэлтэй байдаг энэ орцны бүх гэрэл нь яагаад ингээд унтарчихсан байдаг билээ. Цахилгааны ямар нэгэн саатал гарсан эсвэл нэг сайн эр орцны жижүүрийн азгүй байх чөлөөнөөр сэм орж ирээд бүгдийг нь дэлсэж орхио юу. Хэн мэдлээ, ямартай ч орц ямар ч гэрэлгүй харанхуй байлаа. Сэлэнгээгийн орц руу орох агшинд сүүмэлзэж байсан оройны нар ямар нэгэн чөтгөрөөс айгаа юу гэлтэй хэзээ ч мандаж байгаагүй юм шиг жаргачихаж. Нар ийм хурдан бас огцом жаргаж, уулын цаагуур далд орчихож байсныг Сэлэнгээ ердөө ч санахгүй байв. Тэрээр энэ харанхуй орцонд гар утасныхаа гэрлийн тусламжтайгаар шатанд бүдэрчихгүйхэн шиг болгоомжтой өгсөж явлаа. Одоо дахиад хоёрхон давхар өгсчихвөл тэрээр гэрийнхээ хаалганы өмнө тулж ирэх байв. Түүний гэр нь таван давхарт байдаг бөгөөд ямартай ч эхний гурван давхрыг давчихжээ. Гэртээ орох хүртэлх энэ хоёр давхар шатанд Сэлэнгээг юу ч хүлээж байж мэдэх юм шиг түүнд санагдана. Гар утасных нь гэрэл ойр ойрхон унтарч орц тэр аяараа харанхуй болоход Сэлэнгээгийн хамаг биеэр нь хүйтэн цус гүйх шиг болж түргэхэн шиг утасныхаа аль нэг товчлуурыг даран дахин гэрэл асаана. Утасныхаа гэрлийг шат өөд тусган аажимхан нэг хоёр гишгэн дээш өгсөж байснаа санамсаргүй өмнөх замаа харахад дөрвөн давхарт нэг этгээд харанхуй булан руу нүүрээрээ шигдэн зогсож байх нь тэр. Сэлэнгээ золтой л хашхирчихаагүй ч айсандаа хамаг бие нь тогонд цохиулж байгаа юм шиг татвасхийснээ хойшоо хэдэн алхам ухарчээ. Энэ үед гар утасных нь гэрэл ахин унтрав. Сэлэнгээгийн нүүрээр хүйтэн хөлс дааварлан шатаар үргэлжлүүлэн дээш өгсөх нь зөв үү гэсэн бодол толгойд нь урган гарч ирлээ. Саяын нүдэнд өртдөг хэн эсвэл юу байсан бэ? Сэлэнгээ өөрөөсөө ийн асуугаад утасныхаа гэрлийг дахин асааж харлаа.

Харин одоо бол түрүүний буланд шигдэн хойшоо харан зогсож байсан өндөр биетэй хүн алга болжээ. Магадгүй өөр нэг булан руу шилжиж зогсоод өөрийг нь алахаар тож байгаа ч юм билүү гэж бодсоноо утасныхаа гэрлийг тусган дөрвөн давхрын бүх булан тохойг нүдээрээ нэгжин харлаа. Нүдэнд нь юу ч өртсөнгүй. Сэлэнгээгийн дотор жаахан ч гэсэн уужрах шиг болж дээд давхар луу гүйчихэв. Уг нь одоо ганцхан давхар үлдсэн юм чинь юухан байх вэ. Замд юу ч тааралдсан бай нүдээ аниад л гүйчихье гэж шийджээ. Чулуун шатан дээр товор товор хийлгэн гишгэлсээр дээшээ өгсөх Сэлэнгээгийн хөл доор гэнэт ямар нэгэн “өөр” зүйл гишгигдэх нь мэдрэгдлээ. Тэгмэгц шууд л Сэлэнгээгийн толгойд “Энэ чинь юу вэ, хүн байсан уу?” гэсэн бодол төрж хамаг цус нь толгой руу нь юүлэгдэх шиг болов. Сэлэнгээ эргэж ч харсангүй гүйсээр гэрийнхээ үүдэн дээр иржээ. Гэр оронгүй гудамжны хүн унтаж байсан юм болов уу. Тэгвэл ядаж дээрээс нь хүн гишгээд гарахад дуугармаар юм. Тэгэхдээ бүр өсгийтэй гутлаар шүү. Эсвэл бүр үхсэн хүн байв уу? Хэн мэдлээ. Ямартай ч хэн ч юу ч байлаа гэсэн тийм ч таатай биү учраас хурдхан шиг гэртээ орох минь гэсэн бодол нь Сэлэнгээг хаалгаа ухаан жолоогүй балбахад хүргэжээ. Нэлээд хэдэн удаа хүчтэй цохисон боловч хэн ч хаалга тайлж өгсөнгүй. Чимээ аниргүй, нам жим байдал энэ харанхуй орцонд ноёрхож байгаа нь Сэлэнгээг бүр тэсэхийн аргагүй айдаст автуулж байлаа. Тэрээр гэнэт нэг зүйлийг олж мэдмэгцээ огло үсрэн хаалганаас холдов. “Чөтгөр авмар. Би орцоо андуурчээ” хэмээн Сэлэнгээ өөртөө хэлээд яахаа мэдэхгүй бүр хөшиж орхилоо. Одоо яах билээ. Саяын ирсэн замаараа буцаад буух хэрэг үү, хэдий бууж болох хэдий ч саяхан хөл доор нь гишгэгдсэн хүн эсвэл өөр ямар нэгэн амьтан яах бол гэхээс хамаг бие нь салганан чичирхийллээ. Одоо яанаа. Сэлэнгээгийн нүднээс нулимс асгаран хацарт нь халуун зам татуулан урсаж байгааг тэрээр өөрөө мэдэрсэнгүй. Зөвхөн одоо яаж эндээс гарах вэ гэсэн бодол хамаг оюун ухаан, бие сэтгэлийг нь эзэмдэж түүнийг нь дагаад бүх цусаар нь айдас тархжээ. Түрүүний гадаа

тааралдсан цэнхэр костюмтай этгээдийн бэлэглэсэн ганц ширхэг сарнай өнөөг хүртэл түүний гарт байсаар байгааг энэхэн хугацаан Сэлэнгээ түр мартагнаад байлаа. Сэлэнгээ яахаа мэдэхгүй айж эргэцүүлэн зогссоор. Аз таарч хэн нэгэн айлын хаалга нээгдэж доош хүн буувал хамт гарчихъя гэж бодоод харанхуй орцны хананд нуруугаараа наалдан хэн нэгнийг хаалгаа тайлан гарахыг хүлээв. Гэсэн ч арваад минут өнгөрсөн хэдий ч хэн ч хаалга тайлсангүй, бүр ямар ч чимээ гарсангүй. Сэлэнгээ яах ч аргагүй доошоо буулаа. Өнөөх ойртож ирээд утасныхаа гэрлийг тусган хартал нүдэнд нь юм өртсөнгүй. Тэгмэгц нь сэлэнгээ доогоо яаран гүйлээ. Энэ үед харанхуй орцонд түүний гүйх хөлийн чимээнээс өөр ямар ч зүйл сонсогдсонгүй. Ядаж байхад гадаа ч гэсэн машины явах, сигналдах, өөр ямар нэгэн юмны чимээ гарахгүй байгаа нь ганцаараа үлдээ юу гэлтэй бороо цутган асгарах чимээнээс өөр юу ч түүний чихэнд сонсогдсонгүй.

Сэлэнгээ арайхийж сая нэг юм орцноос гарч чадлаа. Гадаа харуй бүрий байдал ноёрхож байх бөгөөд түрүүний дотор жихүүцүүлэм хүйтэн бороо зогсох янзгүй цутгасаар л. Хүмүүсийн хөл хөдөлдгөөн бүр татарчээ. Борооноос айсан уу, эсвэл бүгдээрээ аль нэг тийшээ алга болчихоо юу ямартай ч Сэлэнгээгийн нүдэнд юу ч өртсөнгүй. Цахилгаан тасарсан бололтой. Учир нь тэр хавийн орон сууцнуудын цонхноос асаалттай байгаа нэг ч гэрэл харагдсангүй. Сэлэнгээ орц руугаа гүйж орлоо. Өөрийн нь бас л гэрэлгүй харанхуй байгаа ч тэрээр энэ удаад торсонгүй. Зүрх нь хурдан хурдан цохилж бүх эд эсээр нь айдсын мэдрэмж тархаж байсан ч асар их зориг тэвчээр гарган зогсолгүй бас эргэж харалгүй гүйсээр гэрийнхээ хаалганы өмнө тулж ирлээ.

.....Харанхуй орцонд “тог тог” хийн модон хаалга тогших чимээнээс өөр юу ч сонсогдохгүй аж. Сэлэнгээ гэрийнхээ хаалгыг хэд хэдэн удаа үргэлжлүүлэн тогшсон ч хэн нэгэн хаалгыг нь тайлсангүй. Тэрээр гэртээ нөхөр бас нөхрийнхөө ухаан нь доройтож өтөлсөн өндөр настай эмээтэй нь хамт гурвуулаа амьдардаг билээ. Сэлэнгээ ийнхүү хаалгаа тайлахгүй байсаар байгаад нь гайхасхийж нөхрөө одоо болтол гэртээ ирээгүй юм байна гэж бодов. Гэхдээ яагаад эмээ нь хаалга тайлахгүй байгааг ойлгосонгүй. Гэрээсээ хэзээ ч гардаггүй хөгшин хүн энэ усан борооноор гадагшаа бүр хамраа ч цухуйлгахгүй нь ойлгомжтой. Тиймээс эмээ унтсан, эсвэл хаалга тогшихыг сонсохгүй байгаагийн аль нэг нь болж таарлаа. Сэлэнгээ ингэж бодмогцоо цүнхнээсээ гэрийнхээ түлхүүрийг хайн ухаж эхлэв. Харанхуй орцонд түлхүүрээ хйаж олоод түүнийгээ түлхүүрийн нүхэнд шургуулж хийнэ гэдэг тийм ч амар ажил биш бөгөөд тэрээр ингэж түлхүүрээ хайх үелээ гартаа өнөөх сарнайг атгасаар байгаагаа сая анзаарлаа. Тэр цэцэг нь гарт нь саад болж байсан болохоор хаячих гэснээ больчихов. Яагаад ч юм энэ цэцгийг хаяна гэдэг Сэлэнгээд нүгэл хийсэнтэй ялгаагүй санагдаад хаяж түвдсэнгүй. Сэлэнгээ цэцэг барьсан гараараа түлхүүрээ эрж олоод түвэггүйхэн шиг нүхэнд нь шургуулж чадлаа. Хаалга ч амархан нээгдэж Сэлэнгээ дотогшоо оров.

... Гэрт хав харанхуй бас чимээ аниргүй. Энэ хоёр өрөө орон сууцанд амьд хүн байгаа шинж ер алга аа. Сэлэнгээ харанхуйд хаалгаа дотроос нь сайтар түгжсэнийхээ дараа юмыг яаж мэдэхэв гэсэн шиг коридорын гэрлийн унтраалгыг дартал гэрэл мэлсхийн асах нь тэр. Сэлэнгээ бүр гайхаж орхилоо. Уг нь цахилгаан тасраагүй л байсан байна шүү дээ. Гэтэл энэ үед эмээгийн нь байдаг жижиг өрөөнд хэн нэгний шаахайгаа чирэн нэг хоёр алхлах чимээ гарахад тэрээр эмээгээ мөн байна гэдгийг таньжээ.

Эмээ гэж дуудсан ч Сэлэнгээгийн дууг сонсоогүй бололтой хариу өгсөнгүй. Эмээ гэртээ байсан хирнээ яагаад одоо болтол гэрлээ асаадаггүй байна аа. Уг нь өдийд гэрлээ ч зурагтаа ч асаагаад суучихсан байдагсан. За яахав эмээ гэрлээ асаахаа мартжээ гэхэд яагаад бусад айлууд энэ харанхуй болсон үед гэрлээ асаадаггүй байна аа? Сэлэнгээ ийн бодсоор нойтон гадуур хувцасаа тайлж өлгүүрт тохоод том өрөөнийхөө хаалгыг нээж дотогшоо ормогцоо гэрлээ асаалаа. Танил дотно болсон гэрийн нь тавилга эд хогшил түүний нүдэнд өртөж үгээр илэрхийлж барамгүй баяр баясал, тайвшралыг эзэндээ бэлэглэх нь тэр. Гэрийн танил дотно болсон орчин, тавилга хэрэгсэл хүний сэтгэлд ийм сайхан мэдрэмж төрүүлдэг ажээ. Сэлэнгээ нэг их гүнзгий амьсгаа аваад том өрөөнийхөө хөшигний завсраар хармагцаа дахин цочих шиг болж түрүүнийхээ айдаст дахин автав. Хөрш зэргэлдээ орон сууцнуудын гэрэл унтраалттай хэвээрээ байжээ. Уг нь Сэлэнгээ гэртээ орж ирээд унтраалга дарах тэрхэн агшинд цахилгаан тасарсан байснаа иржээ гэж дотроо бодож байсан атал энэ нь тийм биш байсан нь ойлгомжтой болох нь тэр. Яагаад, яагаад энэ олон айлуудын ядаж ганц нь ч гэрлээ асаадаггүй билээ. Сэлэнгээ энэ бодлоосоо айгаад цочих шиг болжээ. Манай гэрийн цахилгаан тасраагүй байгаа болохоор бусад айлынх ч ялгаагүй байлтай. Эсвэл цөмөөрөө унтчихсан хэрэг үү, за үгүй дээ. Бүгдээрээ нэгэн зэрэг ингээд унтчихна гэдэг байж боломгүй зүйл. Эсвэл бүгд гэртээ байхгүй байх нь. Хаа нэг тийшээ бүгдээрээ хамтдаа гэрээ орхиод явчихаж. Зөвхөн Сэлэнгээг өтөлж доройтсон бие муутай эмээтэй орхиод бүгд ямар нэгэн зүйлээс айгаад аль нэг тийшээ ум хумгүй арилаад өгөх нь энэ үү?

Сэлэнгээ үнэхээр тэвчсэнгүй. Дахиад л бүх бие, сэтгэлийг нь айдас эзэмдэж хацрыг нь даган нулимс урсаж эхлэв. Түрүүний гудамжинд таарсан гүн цэнхэр өнгийн костюмтай, эвлүүлдэг тоглоом шиг долир залуу түүний санаанд орж өмнө нь хэзээ ч түүн шиг тийм хачин хүнтэй таарч байгаагүйгээ саналаа. Бас түүний өмссөн тэр хачин өнгийн хувцас бороонд норсон шинж ердөө байгаагүй. Энэ нь хэдий зөвхөн өөрт нь л тэгж санагдсан байж болох хэдий ч үнэндээ тийм биш гэдгийг Сэлэнгээ зөнгөөрөө мэдэж байх шиг. Сэлэнгээ гэнэт энэ зүүд биш байгаа гэж бодмогцоо хацраа чангахан чимхээд авлаа. Өвдөж байна гэж жигтэйхэн. Тиймээс сэрүүн байна аа. Бас түрүүний тэр эвлүүлдэг тоглоом шиг хачин эрийн өгсөн сарнай цэцэг буйдан дээр тавьсан цүнхтэй нь хамт өөрийг нь хүлээх мэт гулдайн хэвтэнэ. Сэлэнгээ цэцгийг авч өөр амьд цэцэг хийсэн устай шилэн саванд хамтад нь хийлээ. Сэлэнгээ тайвширч чадсангүй. Яг л харь гарагт ганцаараа төөрч ирээд тэндээ үүрд хоригдож байгаагаар өөрийгөө төсөөлж байх нь тэр. Цонхныхоо ойр орчмоор ойрхон ойрхон эргэлдэж нүднийхээ булангаар гэрэл нь асаалттай тасалгааны цонх хайх хэдий ч байдал өөрчлөгдсөнгүй. Уг нь энэ бүхнийг тохиолдол гэж үзээд зүгээр л зурагтаа асаагаад нөхөр лүүгээ утсаар ярих хэрэгтэй гэж өөртөө хэлж байсан ч энэ бодолдоо эзэн болж чадахгүй л байв. Ер нь л энэ олон айлуудын ядаж нэг нь гэрлээ асаахгүй бол огтхон ч тайвширч чадахгүйгээ л тэрээр сайн мэдэж байв.

“Алив алив ээ ядаж зурагтаа ч гэсэн асаагаад бага ч атугай сүүмгэр гэрэл гаргаадахаач дээ” Сэлэнгээ энэ үгийг өөртөө бүр сонсогдохуйцаар чанга хэлжээ. Тэгмэгцээ гэрийнхээ халаадыг авч одоо болтол даардас нь арилаагүй байгаа хүйтэн биен дээрээ эгэлдэргэллээ. Түүний бүр голд нь хүйт орсон байгаа ч ядаж өөртөө халуун цай аягалахыг завдсангүй. Зүгээр л гараа элгэндээ зөрүүлж цонхныхоо өмнүүр нааш цааш холхино. Сэлэнгээ үнэндээ яахаа мэдэхгүй байсан билээ. Тэрээр чухам энэ л үед хүн хүнээрээ дэндүү их дутдагийг ёстой л голдоо ортол мэдрэх шиг. Бага байхдаа ууланд дүүтэйгээ нуугдаж тоглоод дүүгээсээ бүр хол зугтаж байсан нь Сэлэнгээгийн санаанд оров. Тэгээд л тэр холоос дүүгээ сэмхэн харж яахыг нь сонирхон

нуугдаж байсансан. Тэгэхэд түүний дүү Ганболд нь дөнгөж л найман настай байж билээ. Эгчийгээ хайж нүүрэндээ инээмсэглэл тодруулан гүйж байснаа удалгүй түүний тэр жаргалтай гэнэн инээд нь ор мөргүй арилчихсан. Дараа нь бүр нүүрэнд нь айж сандарсны шинж тодхон харагдаж “эгч ээ та гараад ирээч” гээд л хоолойныхоо чадлаар хашхирч эхлэхэд нь Сэлэнгээ бүр ч их баярлаж хөөрч байсан. Ёстой л нэг маш сайн нуугдаж чадлаа шүү гэж өөрөөрөө бахархаад л, чанга инээхгүйн тулд алгаараа амаа таглаад л. Тэгсэн чинь харин дүү нь удахгүй уйлж эхэлсэн. Тэр үед Сэлэнгээ хэдий арван хоёр нас хүрч байсан ч дүүгээ чухам яагаад уйлсныг нь ойлгоогүй. Дүүгээ уйлаад зогсохгүй болохоор нь нуугдаж байсан газраасаа гардаг ч юм билүү гэж бодсоноо дахиад жаахан гүрийе гэж шийдээд азнасан. Тэгтэл дүү нь уйлахаа болих нь бүү хэл эхэр татаж эхэлснээ ухаан алдаад уначихаж билээ. Тэр үед Сэлэнгээ үнэхээр дүүгээ яагаад тэгж их айгаад бүр ухаан алдаж унасныг ойлгоогүй. Харин одоо л тэр үеийн дүүгийнхээ айдсыг уинхэнэ утгаар нь ойлгох шиг, бас мэдрэх шиг болж байв. Хэн ч байхгүй энэ хорвоо дээр орь ганцаархнаа үлдчихлээ гэсэн айдас. Тиймээ энэ айдас л ертөнцийн өч төчнөөн айдсуудаас хамгийн тэргүүнд тавигдах нь дамжиггүй гэж Сэлэнгээ дотроо бодно.

Хүн үхэхээс айдаг. Яагаад үхлээс айдаг нь ойлгомжтой. Үхэл гэдгийг мэдэхгүй болоод л тэр. Үхээд амилсан хүн гэж байдаггүй. Хэрвээ хүн үхээд эргээд ирж болдог бол үхлийн нууц тайлагдаж үхлийн тухай айдас айдас биш болчихно шүү дээ.

Үхлээс айдгийн гол шалтгаан бол өөрийн олон жилийн турш танил дотно болсон орчноосоо бүрмөсөн ангижирч байгаа явдал бөгөөд ингэснээр орь ганцаархнаа болж бусдын амьдралаас тусгаарлагдах явдал биз. Сэлэнгээгийн толгойд өөрийн эрхгүй ийм бодол эргэлдэх аж. Гэхдээ яг одоо бол Сэлэнгээгийн сэтгэлд төрж байгаа айдас нь үхлийн тухай айдсаас ч бүр долоон дор юм. Тэр айдас бол мэдээж энэ ертөнцөд ганцаараа амьд үлдэх. Тиймээ.... ганцаархнаа, бусад нь яасан нь мэдэгдэхгүй аль нэг тийшээ явахад түүнийг нь мэдэлгүй үлдчихнэ гэдэг аймшигтай. Энэ хэдий байж боломгүй гэлээ ч үнэхээр тийм бол яана аа гэсэн бодол Сэлэнгээгийн санаанаас гарахгүй зовоосоор. Тэр үед айснаасаа болоод ухаан алдаж байсан дүүгээ одоо бодоод бүр маш их өрөвдөх шиг л боллоо. Тиймээ яг л орь ганцаархнаа үлдчихсэн юм шиг.

.... Гэрт ханын цагны чаг чаг цохилохоос өөр ямар ч чимээ аниргүй хэвээрээ. Сэлэнгээ гэртээ орж ирснээс хойш бүр нэг цаг гаран өнгөрчээ. Хамаг бие сэтгэлийг нь айдас жихүүдэс эзэмдээд ухаан нь өнгөрөн одсон руу бэдчин тэнүүчлээд цаг хугацаа хэрхэн өнгөрөхийг анзаарсангүй бололтой. Сэлэнгээгийн харц цонхноосоо салж чадахгүй байгаа хэвээр. Ядахад энэ хугацаанд машин яваа нь ч харагдсангүй, бүр машины гэрэл хаа нэгтээ ёлтойх ч үзэгдсэнгүй. Цаг хугацаа өнгөрөх тусам л айдас нь нэмэгдэж бүр галзуурахад хүрээд байгаа Сэлэнгээ энэ үед өөдөөс нь харсан есөн давхар байшингийн хамгийн дээд давхрын бололтой цонхоор гэрэл тусахыг харлаа. Сэлэнгээ баярласандаа золтой л ура хашхираагүй билээ. Гэвч харамсалтай нь түүний энэ баяр тэгтлээ удаан үргэлжилсэнгүй. Удалгүй асаалттай цонхны цаана хэн нэгэн хөх өнгийн костюмтай этгээд ирж зогссон нь түүний энэ баярласан сэтгэлийг ор мөргүй замхруулж орхих хангалттай шалтгаан болсон билээ. Өнөөх эвлүүлдэг тоглоом шиг долир нүдтэй хачин залуу. Түүний тэр долир нүд яг Сэлэнгээ рүү инээмсэглэн ширтэж байгаа нь энэ харанхуй орчинд тодоос тод ялгаран харагдлаа. Тэгсэнээ өнөөх цэнхэр костюмт гараараа Сэлэнгээ рүү дуудах мэт даллах нь тэр. Сэлэнгээ цонхноосоо цочих мэт

холдож, тэгснээ буцаж гүйж ирээд ум хумгүй хөшгөө хааж орхилоо.

Сэлэнгээ айснаасаа болоод бүр дагжин чичирч байх нь тэр. “Тайвшир, тайвшрах хэрэгтэй. Энэ бол хэвийн үзэгдэл, бүх юм хэвийн” Сэлэнгээ хэсэг хугацааны дараа өөртөө ингэж хэлээд хөшгөөр халхалсан цонх руугаа эргэлзсэн байртай аажмаар дөхлөө. Тэрээр удалгүй хөшигнийхөө өмнө тулж ирээд нэг үзээрээс нь хумьж атгаад зөөлхөн ярав. Гадаа бороо цутгасан хэвээр бөгөөд түрүүний цонх гэрэлтэй, харин өнөөх цэцэг бэлэглэсэн эр харагдсангүй. Энэ үед мөн л урьдын адил бусад орон сууцнуудын гэрэл асаагүй хэвээр байв. Сэлэнгээ хөшгөө буцааж хаагаад нөхөр лүүгээ ярихаар гар утсаа нээтэл нөхрөөс нь мессеж ирсэн байх нь тэр. “Өнөөдөр яаралтай ажил гараад уулзаж хэлж амжилгүй томилолтоор явах болчихлоо. Хэр удахыг одоохондоо хэлж мэдэхгүй нь. Уучлаарай, чамайгаа үнсье” Энэ мессежийг хараад Сэлэнгээ үнэндээ нүдэндээ ч итгэсэнгүй. Хэзээ ч томилолтоор явж байгаагүй нөхөр нь гэнэт ингээд явчихдаг байжээ. Сэлэнгээгийн нүднээс том том нулимс унаж, нөхөр лүүгээ утсаар холбгдох гэснээ боловч бүтсэнгүй. Тэгээд Сэлэнгээ зурагтаа асаах гэснээ больж дахин цонх руугаа очиж харсан хэдий ч түрүүний ганцаас бусад нь унтраалттай хэвээрээ байлаа. Магадгүй өнөөх цэнхэр костюмт дахин цонхны цаанаас өөр лүү нь даллаж байхвий гэж бодсон ч азаар тийм дүр зураг олж харсангүй. Эсвэл түрүүн зүгээр л хий юм харсан байж болох. Гэтэл хий юм харсан байж болно гэж өөртөө хэлэх нь дэндүү худлаа зүйл гэдгийг Сэлэнгээ сэтгэлийнхээ мухарт мэдэрч байлаа. Гэнэт Сэлэнгээд нэгэн хачин жигтэй муухай зүйл санаанд нь буух нь тэр. Арай тэр эвлүүлдэг тоглоом шиг долир залуу ганцхан манай гэрийн цонхноос гэрэл тусч байгаа болохоор наашаа ирж яваа хэрэг биш байгаа даа. Тийм ээ түрүүн яалт ч үгүй намайг харчихаад гараараа даллаад дуудаж байсан. Тэгээд намайг ирэхгүй болохоор наашаа ирж байгаа юм болов уу? Засмал зам дээр тогтсон шалбаагийг харанхуйд огтхон ч ажралгүй туучиж, зогсоо зайгүй цутгах хүйтэн бороонд гараа өмднийхөө халаасанд хийгээд нүүрэндээ инээмсэглэл тодруулан бээвийтэл алхсаар ирж яваа болов уу?

Сэлэнгээгийн хамаг биеийн шар үс айснаасаа болоод босох нь тэр. Нээрээ тэр долир нүдтэй залуу энд ирж гэмээнэ тийм сайн сайхан зүйл болохгүй нь лавтай. Сэлэнгээ ингэж бодмогцоо хаалганыхаа түгжээг сайтар түгжсэн эсэхийг нягтлахаар үүд рүүгээ дөхөж ирэхэд өөдөөс нь хэн нэгэн хаалга тогших нь тэр. “Тог... тог... тог...” Хоорондоо нэг секунд орчмын зайтай нэгэн хэмнэлээр ингэж хаалга тогших нь аргагүй хачирхалтай байлаа. Сэлэнгээ цочсондоо хойшоо ухран нэг хөлөндөө нөгөө хөл нь тээгэлж бөгсөөрөө шалан дээр уначихав. Сэлэнгээгийн гэрт ингэж зочилж ирдэг найз нөхөд ах дүүс нь өмнө нь хэзээ ч ингэж цохиж байсан нь үгүй бөгөөд нөхөр нь тэр өөрийн гэсэн хаалгаа тогших тусгай хэмнэлтэй байдаг билээ. Сэлэнгээ яахаа мэдэхгүй хаалганыхаа өмнө суусан чигтээ хөшиж орхилоо. Нөхөр маань томилолтоор явна гэсэн болохоор гэнэт ингэж ирнэ гэж байхгүй. Бас миний таньдаг хүн ч биш. Яг саяын өөрийг нь даллан дуудаж байсан цэнхэр костюмт мөн байх нь. Сэлэнгээ өөртөө ингэж хэлээд хаалга руугаа нүдээ ч цавчихаас айн гөлрөн ширтсээр. Хаалгыг үргэлжлүүлэн цохисон хэвээр байсан бөгөөд Сэлэнгээ хэн бэ ч гэж асууж чадахгүй хөшин зогсож байснаа чухам юу гээд байгаа нь сайн сонсогдохгүй нэг зүйлийг амандаа бувгнах нь тэр.

... Хэр удсаныг бүү мэд. Ямартай ч магадгүй азаар хаалганы цаана байгаа өнөөх этгээд хаалга тогшихоо больжээ. Сэлэнгээ арайхийж нэг юм сэхээ авах шиг болоод нөхрийнхөө эмээг жижиг өрөөнд байгааг санан түүн дээр очихоор алхлаа.

-Эмээ та унтаагүй байна уу?

.... /Таг чиг/

Сэлэнгээ эмээгийнхээ өрөө рүү гэтсээр тулж ирээд хаалганд нь чихээ наан чагнав. Гэтэл эмээ нь унтаагүй байгаа бололтой, юу нь мэдэгдэхгүй “шол шол” хийсэн чимээ өрөөн дотроос сонсогдож байх нь тэр. Ямартай ч хаалганы гаднаас өрөөнийхөө гэрлийг асаагаагүй байгаа нь тодорхой байв.

Нөхрийн нь энэ өтөлсөн эмээ нэг жилийн өмнө цус харваад хайртай ач хүүгээ бараадан гэрт нь ирсэн нь энэ. Эмгэнийг анх нүүж ирснээс нь хойш Сэлэнгээ хурдхан шиг өөр тийшээ яваасай. Эсвэл зүгээр шулуухан шиг нүд аньчихаасай гэж дотроо үргэлж хүсдэг байхдаа “амьд үхдэл” шиг болж орхисон энэ эмээгээр хэзээ нэгэн цагт хань татна гэж төсөөлсөн ч үгүй явжээ. Энэ өндөр настай эмээ хэдий цус харваснаасаа хойш ярих сонсох чадвар нь эрс доройтсон ч гэсэн ямар ч байсан ач хүү, бэр хоёртойгоо ойлголцож чаддаг билээ. Бас түүгээр зогсохгүй чөөчөгнөн алхаж өөртөө хэрэгтэй идэж уух юмаа олоод авчихдаг, дулаан өдөр гараад орцны үүдэн дээр хэдэн минут нарлаад суучихтайгаа.

Сэлэнгээ өрөөн дотор ортол эмээ орон дээрээ суучихсан үргэлж орныхоо хажууд байдаг жижиг ширээ рүүгээ тонгойсон байгаа нь бүдэг бадаг харагдав. Сэлэнгээ хана дагуулж гараараа тэмтрэн өрөөний гэрлийг асаагаад орчин тойрныг тодоос тод харлаа. Гэтэл эмээ нь хоёрдугаар хоол хийдэг пял тавганд хальтал нь ус дүүргээд дотор нь хэрчсэн түүхий мах хийсэн байв. Уснаас ямар ч уур гарахгүй, мах нь түүхий улаанаараа нялцайн харагдаж байгаагаас үзэхэд эмээ зүгээр л крантны хүйтэн ус пял тавгандаа хийж авсан бололтой. Эмээ өрөөнд Сэлэнгээг орж ирэхийг мэдсэн ч түүн рүү тогтоож харсангүй. Харин Сэлэнгээ түүн рүү дөхөж ирээд “Эмээ та юу хийж байгаа нь энэ вэ?” гэж айх гайхах зэрэгцэн асуулаа. Эмгэн сонсогдохтой үгүйтэй нэг юм амандаа шивэгнэж ямар нэгэн зүйл ам руугаа хийж байгааг үйл хадлалаараа үзүүлэхэд Сэлэнгээ эмээгийнхэ юу гэснийг сайтар ойлгожээ. Эмээ нь их өлсөөд хол хийж идсэн нь тэр ажээ. Өмнөө байгаа энэ крантны устай% түүндээ түүхий нялцгай нойтон мах хийсэн. Зүйлээ өмнө нь хэд хэдийг идсэн, их амттай байсан гэж хэлсэн нь тэр. Сэлэнгээ айж бүр ч их балмагдлаа. Эмээгийн нь ой ухаан доройтлоо ч арай ингэж түүхий ус, түүхий мах иддэггүй билээ. Сэлэнгээ яахаа мэдэхгүй эмээ рүүгээ айсан нүдээр харж байснаа эмээ нь бүр нүдэн дээр нь өнөөх өмнөө байгаагаа идэж эхлэлэхэд нь тэр крантны ус бүхий түүхий “махан хоол”-ыг нь авах гэж оролдлоо.

-Эмээ би танд хоол хийж өгье. Энийг идэх хэрэггүй.

Гэтэл эмээ түүнд хоолоо өгсөнгүй. Яг л гуравхан настай жаахан хүүхэд хамаг хоолойныхоо чадлаар муухай хашхирахтай адилаар чарлан тийчигнэв. Сэлэнгээ урьд өмнө нь эмээгээсээ ийм ааш авир гарахыг хэзээ ч харж байгаагүй билээ. Яг л өнөөдрийн уурлаж дүнсийсэн хүмүүсийн нэгэн адилаар эмээ нь ч гэсэн ямар нэгэн зүйлд ховсдуулчих нь энэ үү?

Эмгэнийг чарлаад болохгүй болохоор нь Сэлэнгээ өмнөх пял тавгийг нь тэр чигт нь тэнд нь орхиод хурдхан шиг холдлоо. Сэлэнгээгийн хамаг бие нь салганан чичирч, нүүрээр нь хүйтэн хөлс дааварлана. Саяхан өнөөх цэнхэр костюмт ирээд хаалгыг нь тогшсон. Магадгүй баталгаатай мэдээгүй ч тэр бол яалтчгүй өнөөх цэцэг бэлэглэсэн долир залуу мөн гэдэгт



Сэлэнгээ бүрэн итгэлтэй байгаа. Бас түүгээр ч зогсохгүй тэр этгээд одоо хүртэл хаалганых нь цаана цоож тайлагдахыг хүлээгээд нүүрэндээ хүйтэн инээмсэглэл тодруулан хуруугаа мэрэн зогсож байгаа. Гэтэл дээрээс нь энэ шүдгүй эмээ түүхий мах усанд дэвтээж идээд араас нь крантны хүйтэн усаар даруулж байдаг. Муу ёрын гэдэг нь өнөөдөр чинь ямар гээчийн өдөр вэ? Бас юу үзэх нь энэ вэ? Ганцхан өдрийн дотор дэндүү хангалттай юм үзлээ, боллоо, гүйцээ. Бүхнийг мартаад унтаж амрах минь. Сэлэнгээ өөртөө ингэж хэлээд эмгэнийг түүхий махтай нь орхиод өрөөнөөс гарч одлоо. Өнөөх цэцэг бэлэглэгч этгээд чинь дахиад хаалга тогших вий гэсэн бодол Сэлэнгээд төрж байсан ч аль болохоор энэ бодолдоо автахгүйг хичээн самгардана. Дахин цонх руу очиж харахыг ч хүссэнгүй, зүгээр л хөнжилдөө шургахын яаравчиллаа. Сэлэнгээ хэдхэн цагийн өмнө хүйтэн бороонд цохигдон чичирч байсан бол одоо айснаасаа болоод мөн л тасралтгүй чичирхийлж байв. Өнөөх цэнхэр костюмт магадгүй халганы цаана байж л байгаа, гэхдээ яах гэж? Чухам ямар учиртай өөрт нь цэцэг өгснийг ч мэдэхгүй, тэгээд бас яагаад өөрийг нь ингэж хоргоож үүдэн дээр нь хүртэл ирчихээд байгаа билээ. Ямар ч хүнгүй эцэс төгсгөлгүй цутгах хүйтэн борооноос өөр үзэгдэлгүй энэ муу ёрын үдэш чөтгөр хүртэл бусдаар хань татаж байгаа нь энэ үү?

Сэлэнгээ хэдий хоёр давхар хөнжлөөр өөрийгөө давхарлан хучсан ч дагжин чичирсээр. Тэрээр өөрийгөө яаж тайвшруулах ёстойгоо мэдэхгүй дэмий л хөнжилдөө мэгшинэ. Өрөөнийхөө гэрлийг ч унтраасангүй. Мэдээж энэ нь түүний айдастай холбоотой бөгөөд гэрэлтэй байвал сэтгэл нь жаахан тайвширч магадгүй унтах ч юм билүү.

Шөнө дунд хэдийнэ болжээ. Айснаасаа болоод Сэлэнгээгийн нойр бүр хулжиж орхиод, хөнжлөөр биеэ хучиж буйдан дээр хэвгэнэ. Дахин хаалга цохисонгүй, ямар ч чимээ аниргүй хэвээр. Гэтэл энэ нам гүмийг эвдсэн чимээ гарсан нь хажуугийн өрөөний эмгэний огиулах дуу. Түүхий мах крантны усаар хооллож байсан эмээгээ огиулж тэрэндээ хахаж байна гэж бодсон ч Сэлэнгээ очиж туслахыг хүссэнгүй. Яршиг, тэндээ тэгээд үхвэл үхэг. Юу ч сонсоогүй унтаад өгсөн л хүн байгаа биз. Сэлэнгээ өөртөө ингэж хэлмэгцээ хоёр давхар хөнжлөө толгой дээгүүрээ давуулан хучаад нүдээ анин хэвглээ. Хэсэг хугацааны дараа эмгэн ч огиулахаа зогсож, Сэлэнгээгийн нүд ч анилдаад ирэв. Ингэсээр нэг л мэдэхнээ Сэлэнгээ унтаж орхижээ. Түүний ухаан санаа зүүд нойрын ертөнцөд тэнүүчилж одов.

## II ХЭСЭГ

... Нойтон цас тасралтгүй хаялсан гудамжаар Сэлэнгээ гэр рүүгээ яаран алхаж байв. Зам талбай нэлэнхүйдээ хар өнгөнд хучигджээ. Яагаад хар өнгөнд хучигддаг билээ. Яагаад гэвэл цас цагаан биш хар өнгөтэй байна. Цас маш ихээр хаялан орсоор байсан ч яг л зуны улирал шиг огтхон ч даарахгүйбайгаадаа Сэлэнгээ их л баяртай алхах аж. Гудамжаар зөрж өнгөрсөн бүх л хүмүүс түүн рүү инээмсэглэн харж зарим нь бүр гараараа даллан толгой дохиж байв. Сэлэнгээ гэртээ нэлээд ойртож ирлээ. Гэтэл замд нь тааралддаг өнөхө хүүхдийн тоглоомын талбайн сандал дээр нэгэн ад зэтгэрийн гэмээр этгээд түүнийг үзэн ядсан байдалтай ширтэн сууж байв. Тэрээр гүн цэнхэр өнгийн костюм өмссөн байх агаад нүүр царай нь ердөө ч ойлгомжгүй, урьд өмнө нь үзэж байгаагүй тийм дүр төрх байлаа. Тэр этгээд сагс дүүрэн хар сарнай тэвэрсэн байх бөгөөд Сэлэнгээ рүү дөхөж ирээд түүнийгээ өгөв. Сэлэнгээ ч тэр сагс дүүрэн хар сарнайг аваад гэр лүүгээ алхлаа. Гэхдээ Сэлэнгээ энэ хачин этгээдээс огтхон ч айж цэрвэхгүй байх бөгөөд удалгүй сагс дүүрэн сарнайгаа тэвэрсээр гэртээ ороод ирлээ.

Эмээ нь түүнд зориулан маш сайхан амттай хуушуур хайрчихсан хүлээж байх бөгөөд түүнийг хоолоо амтархан идэх хооронд нь толгойг нь илэн өхөөрдөнгүй харна. Тэгснээ нөхрийн нь эмээ Сэлэнгээгийн өмнө байгаа том тавагтай олон хуушуураас нэгийг авч шүдгүй буйлаараа арайхийн зажлан идэх нь тэр. Гэтэл эмгэний хоёр завьжийг нь даган нөжирсөн хар цус урсав. Хамгийн гайхалтай нь Сэлэнгээ үүнийг нь тоосонгүй зүгээр л өрөөндөө ороод унтчихав. Өглөө болжээ. Цонхоор нар тусаж гадаа хүмүүсийн чанга чанга инээлдэн ярилцах чимээ машины давхилдах дуутай хоршин сонсогдоно. Хэдий зүүд ч гэлээ энэ яг л бодит амьдрал гэлтэй ил тод, эмх замбараатай байх аж. Сэлэнгээ өөрийгөө зүүдэлж байгаагаа сайн мэдэж байв. Гэхдээ тэр энэ зүүдэндээ улам автан бүр гүнд нь орж сэрэхийг огтхон ч хүсэхгүй байлаа. Яг л аз жаргалын ертөнцөд амьдарч байна гэлтэй. Түүний зүүд үргэлжилсээр. Хэн нэгэн этгээд гэрийн нь хаалгыг нэг секундын хэмнэлтэй тогших нь сонсогдов. Сэлэнгээ ч ямар ч эргэлзээгүй өнөөх сагс дүүрэн хар сарнай бэлэглэсэн цэнхэр костюмтай залууг мөн байна гэж бодоод хаалгаа тайллаа. Сэлэнгээгийн таамагласан нь ч биеллээ олсон байх бөгөөд өнөөх цэнхэр костюмтай залуу түүнээс цэцгээ буцааж авахыг хүсэх нь тэр. Харин Сэлэнгээ зөвшөөрсөнгүй тэр залууг түлхэж орхиод хаалгаа хаачихлаа. Яагаад ч юм цэцгийн өөртөө авч үлдэхийг хүссэн бололтой. Харин цэнхэр костюмтай залуу явахаасаа өмнө “Чи хүсээд байгаа бол наад үхлээ өөртөө ав л даа. Уг нь би чамд өгөхөө больё гэж бодсоон юм. Одоо яая гэхэв, тамд уулзатлаа түр баяртай” гэж цахиртсан сөөнгө хоолойгоор хэлээд арилаад өгөв. Дөнгөж түрүүхэн л сайхан байсан хангай дэлхийн муухай ааш нь хөдлөв бололтой шороон шуурга нарны гэрэл бүүдийгээд ирлээ. Түрүүний чанга чанга ярилцан инээж хөөрөлдсөн хүмүүсийн дуу аврал эрэн бархирах дуугаар солигдож, уйлж хашхичих чимээ газар авах нь тэр ээ. Яг л галав юүлэх нь энэ үү гэлтэй. Сэлэнгээ гэрээсээ гарахаар үүд рүүгээ зүглэв. Гэтэл жижиг өрөөнөөс эмээгийн нь ёолж гэнгэнэх дуу гарснаа нэгэн хүнд юм шалан дээр түсхийтэл унах нь сонсогдлоо. Хэдий зүүд ч гэлээ яг л бодит байдал шиг үзэгдэх энэхүү зүүдэндээ Сэлэнгээ улам бүр живэн орж байгаагаа мэдрэх шиг.

Эмээгийнхээ өрөөний хаалгыг нээж харахад эмгэн аль хэдийнэ шалан дээр тэрийн унаад амьсгал хураасан байх нь тэр. Сэлэнгээ уйлж гашуудсан ч үгүй эмгэнийг тэнд нь орхиод гэрээсээ гарлаа. Орцны хана чулуун шатаар хэн нэгэн этгээд цусан зам татуулан явсан бололтой дүр зураг Сэлэнгээгийн нүднээ тусав. Гэхдээ энэ бүхэн Сэлэнгээд ердөө ч айдас төрүүлсэнгүй зөвхөн ямар нэгэн далдын хүч өөрийг нь урин дуудахыг мэдрэх шиг. Сэлэнгээ орцноосоо яаран гарлаа. Өчигдөр цастай гудамжаар алхаж ирсэн бол одоо тэр битүү орсон хар өнгөтэй их цас нь ямар ч ор мөргүй алга болжээ. Зөвхөн шороон шуурга л нүүр нүдгүй шуурна. Сэлэнгээ байрныхаа өмнөх машин замыг хөндлөн гарахаар алхтал нэгэн ес орчим насны бололтой жаахан эрэгтэй хүүхэд хурд хэтрүүлэн давхиж яваа sonata маркийн машинд мөргөгдөн тээр хол шидэгдэх нь тэр. Машин ч зогсож Сэлэнгээ зам хөндлөн яаран гарлаа. Тэрээр энэхүү зүүдэндээ өөрийгөө чухам хаашаа ингэтлээ яараад байгаагаа нэг л сайн ойлгохгүй байгаа ч яагаад ч юм аль нэг тийш яарсаар. Магадгүй үхэл рүүгээ яарах нь энэ үү.

Түүнийг байшингийн булан тойрон эргэтэл “Сэлэнгээ” хэмээн дуудах хэн нэгний танил дотно хоолойг сонсмогцоо тэрээр нөхрийнхөө ирж яваа зүг харав. Нөхөр нь их л сандарсан байртай Сэлэнгээ рүү зангаж “Холдооч ээ” хэмээн хашхирч байх нь тэр. Тэгмэгц Сэлэнгээ сая л өөрийгөө машин зам дээр зогсож байгаагаа анзаарч хажуунаас нь хэдий тоормосоо гишгиж байгаа ч асар хурдтай ирж яваа ачааны машиныг олж харав. Сэлэнгээ муухай хашхиран цочин сэржээ.

### Ш ХЭСЭГ

... Өглөө болж нар манджээ. Гадаа шувуудын жиргээн сонсогдож хүмүүс чангаар инээлдэн ярилцана. Үүний хажуугаар машины давхих, сигналдах чимээ Сэлэнгээд сонсогдож өчигдрийн ганцаардсан, айдас хүйдсээр бялхсан орчныг ор мөргүй арилсан гэдгийг батлах мэт. Сэлэнгээ сэрмэгцээ хар дарсан зүүдээ санаж байсан ч аажмаар мартаж эхэллээ. Хэлэн минутын туршид хөнжилдөө өчигдрийн болсон явдлыг бас там тум санаж байгаа зүүднийхээ тухай эргэцүүлээ. Энэ бүхэн нь яг л зүгээр нэг үзээд өнгөрсөн кино, уншсан ном шиг нь тийм л нэг хар бараан өнгө аясыг илтгэсэн дурдатгал мэт. Өчигдрийн эцэс төгсгөлгүй цутган асгарч байсан бороо ор мөргүй арилж оронд нь үүлгүй шахам цэлмэг тэнгэрээс нарны дулаан илч ээж байх нь тэр. Гадаа аз жаргалтай амьдрал буцалж байна уу гэлтэй.

Сэлэнгээгийн санаанаас өчигдрийн бүх муу муухай үйл явдөл арчигдан алга болж байгааг тэрээр мэдэрч байлаа. Эмээгийнхээ идэж байсан түүхий мах, крантны ус бүхий хоол бас тэрхүү ямар ч гэрэлгүй чимээ аниргүй жихүүн шөнө гээд л бүгдийг нь мартаж байв. Гэхдээ өнөөх цэнхэр костюмтай этгээд л түүний санаанд бүр тодоос тод үлдэж орхио юу гэлтэй. Бараг л нүдэнд нь харагдаж байв. Яг л зүүд шиг санагдаж байсан ч тэр хачин залуу өөрт нь цэцэг бэлэглэснийг санаав. Ганцхан ширхэг нүцгэн улаан сарнай. Сэлэнгээ цэцгийн хийсэн шилэн ваар луугаа харав. Аймшигтай. Сэлэнгээ үнэхээр нүдэндээ ч итгэсэнгүй. Өнөөх улаан сарайн чинь улаан биш хар сарнай болчихсон байх нь тэр. Уг нь өчигдөр яалт ч үгүй л улаан байсан тэрхүү өнчин ганц сарнай яахаараа хар өнгөтэй болчихсон байдаг билээ. Сэлэнгээ ийнхүү цэцгийн өнгө хувирсан шалтгааныг үнэндээ л бодоод олсонгүй. Эсвэл угаасаа л хар өнгөтэй цэцэг байсныг өчигдөр улаан болгож харсан нь тэр үү? Хэн мэдлээ. Ямартай ч улаан гэж итгэж байсан өнөөх цэцэг нь хар өнгөтэй харагдаж байна. Сэлэнгээ урьда өмнө нь хэзээ ч ийм хар өнгөтэй цэцэг харж байсангүй. Улаан өнгийн цэцэг хайр сэтгэл, цагаан нь хүндэтгэл илэрхийлдэг бол хар өнгө юуг илэрхийлдэг байж таарах вэ? Лав л сайныг илэрхийлэхгүй санагдана. Тэгээд бас дээрээс нь тэр хар цэцгэнд үхэж хорчийсон шинж ердөө ч алга. Уг нь үхсэн байсан бол үхээд өнгө нь хувирчээ гэж дүгнэж болмоор байсан ч үнэндээ тийм боломж байсангүй. Гэнэт Сэлэнгээгийн санаанд түүний урьд шөнийн зүүд орлоо. Тэрээр зүүдэндээ сагс дүүрэн хар сарнай гэртээ авчирсан шүү дээ. Тэгээд тэр цэцэг нь муу ёр, үхэл зөгнөж байсан. Сэлэнгээгийн бүх сэтгэл зүрх нь дахиад л айдас жихүүдэст бүрэн эзэмдүүлээд ирэв. Өчигдрийн тэр үл ойлгогдох муу ёрын муухай орчин өөрийг нь үхэлд бэлдүүлсэн, үхлийн өмнөх мөч байв уу. Гэнэт гар утасных нь мессежний хонх дуугарч Сэлэнгээг бага зэрэг цочоон бодлыг нь сарниуллаа. Нөхрөөс нь мессеж иржээ. Томилолтынхоо ажлыг хойшлуулаад одоо гэртээ ирж байна гэсэн байв. Сэлэнгээ өөрийн хайртай нөхрөө зөндөө их хүлээж болсон явдлуудын тухай нэгд нэгэнгүй ярихыг хүсч байсан боловч тэсэлгүй гарч тосохоор яарав. Тэрээр хөнжлөө ч эвхэж хураасангүй. Гартаа тааралдсан хувцсаа өмсөөд хөлдөө пүүз углаад гарах гэтэл жижиг өрөөнөөс нь эмээгийн нь ёлон гинших нь сонсогдож байснаа нэгэн хүнд юм түсхийтэл унах чимээ дуулдлаа. Сэлэнгээгийн сэтгэлд шөнийн зүүдтэй нь холбоотой айдас дахин амилан босч ирэх нь тэр. Сэлэнгээ эмээгийнхээ өрөө рүү орохыг хүссэнгүй. Учир нь ... тийм ээ, магадгүй зүүдэнд нь үзэгдсэн шиг үхчихсэн биз. “Юу ч сонсоогүй, мэдээгүй хүн болоод л гараад гүйчихье. Намайг гарсан хойно л эмээ унасан байгаа биз” гэж өөртөө хэлээд хаалганыхаа замаган түгжээг мулталлаа. Сэлэнгээгийн зүрхний цохилт түргэсэн гар нь үл мэдэг чичирхийлнэ. Ингээд гараад явах нь зөв үү, буруу юу гэсэн бодол түүнийг ээрэн хоргоож, ийнхүү тээнэгэлзэхэд хүргэжээ. Гэсэн ч Сэлэнгээ эцсийн

эцэст хаалгаа түлхэн гадагш гарлаа. Эмээгээ үхэж байна гэж зүүдэлсэн тэр зүүд нь үнэхээр биелсэн гэдгийг хоёр нүдээрээ харахаас айсан нь тэр биз. Сэлэнгээгийн хамаг бие нь дагжин чичирч харц нь тогтохгүй дальдчин шатаар аажимхан доошилж байв. Гэтэл Сэлэнгээгийн нүдэнд хана шатанд үсэрч наалдсан цусан толбууд хаа сайгүй байгаа нь өртөв. Тиймээ яг л өчигдрийн зүүд биеллээ олох нь тэр үүе

Зүүд... зүүд... зүүд... Хараал идсэн тэр зүүд. Бас өчигдрийн цэнхэр костюмтай эвлүүлдэг тоглоом шиг долир залуу, хэн ч байхгүй мэт харанхуй ганцаардмал орчин, ганц ширхэг нүцгэн хар сарнай, тасралтгүй цутгасан хүйтэн бороо. Энэ бүхэн юуг зөгнөх нь энэ вэ?

Одоо аягүй бол орцны гадаа гармагц өмнөх машин зам дээр арав орчим насны жаахан эрэгтэй хүүхэд машинд мөргүүлж хол шидэгдэх байх даа. Ээ бурхан минь, битгий л тийм юм болоосой доо. За байз тэр жаахан хүүхэд машинд мөргүүлсний дараа би үргэлжлүүлэн юу зүүдэллээ. Сэлэнгээгийн ухаан санаа самууран хямарч өөрийгөө хянах чадваргүй товчхондоо бол хагас галзуурлын байдалтай хүн цусан зам татуулсан чулуун шатаар аажимхан доошилсоор. Сэлэнгээ энэ хэдэн болсон явдалд автаад зүүднийхээ төгсгөлийг үнэндээ л санаж чадахгүй байв.”Одоо хүүхэд машинд мөргүүлнэ дээ яана аа” гэсэн бодол Сэлэнгээгийн сэтгэлийг эрхгүй шаналгаж ухаан санааг нь бүр бодит ертөнцөөс тусгаарлаж орхижээ. Сэлэнгээ роцны үүдэнд гарч ирлээ. Гадаа хэдийн нартай дулаахан байгаа ч өчигдрийн борооноос үлдсэн шавар шалбааг энд тэндгүй тогтсон харагдана. Тэгтэл энэ үед байшингийн булан тойроод нэгэн sonata маркийн авто машин гарч ирсэн ч харин өнөөх зүүдэнд нь уг машинд дайруулсан хүүхэд харагдсангүй. Сэлэнгээгийн дотор уужрах шиг болоод зам хөндлөн гарч цааш алхлаа. Тэрээр нөхөр лүүгээ л хамгаас ир яарч түүндээ тэврүүлээд сэтгэлээ тайвшруулахыг маш ихээр хүсч байв. Гэнэт Сэлэнгээгийн ард тас хийх чимээ гарснаа машины огцом тоормослох чимээ үргэлжлүүлэн дуулдлаа. Сэлэнгээ сонссондоо бүрэн итгэлтэй байсан ч эргэж харахыг хүссэнгүй.

... Нэг л мэдэхнээ Сэлэнгээгийн хоёр нүднээс нулимс цувж царай нь цонхийн цайрчээ. Тэрээр гар утсаа гартаа атгасан байх бөгөөд мессеж ирэх дуунаар утсаа нээж харлаа. Ямартай ч нөхрөөс нь мессеж ирсэн байсныг мэдсэн ч тэндээ чухам юу гэж бичсэнийг уншаад ойлгосонгүй. Сэлэнгээгийн хамаг ухаан санаа нь ард нь дуулдаж байгаа “Яана аа үхчихлээ... Тархи нь гоожиж байна шүү дээ. Түргэн дуудаарай. Хөөрхий минь жаахан хүүхэд байна шүү дээ” гэх мэт олон хүмүүсийн сандралдан бачимдсан чанга яриан дээр л төвлөрч байв. Сэлэнгээ тэссэнгүй бололтой. Утсаа халаасандаа хийгээд хоёр гараараа чихээ таглан гүйчихэв. Сэлэнгээ нэг л мэдэхнээ өөрийнхөө суудаг байрны зэргэлдээх хажуугийн байрыг тойрон эргэжээ. За байз өчигдөр шөнө энэ зүүд, тийм ээ үүний дараа юу болсон билээ. Санахгүй байна аа, санахгүй байна. Гэхдээ л энүүхэнд ойрхон байна. Жаахан сэжүүр л гарах юм бол шөнийн хар дарсан зүүдээ одоо санахад бэлэн байна.

Уйлж хамаг сэтгэл нь хямарсан тэрээр осол болсон газраас холдож чадсан гэж бодоод чихээ тагласан гараа сая нэг буулгалаа. Тэгмэгц хаа нэгтэйгээс “Сэлэнгээ” хэмээн өөрийг нь дуудахад тэрээр нөхрийнхөө хоолойг төвөггүйхэн танив. Сэлэнгээ баярлан хөөрч, хамгийн хайртай хүнээ харцаараа хайн, инээмсэглэн зогссоор нөхрөө өөр лүү нь ирж явааг олж харлаа. Сэлэнгээ баярласандаа эгээтэй л уйлчихсангүй. Гэтэл нөхөр нь наанаасаа холдооч ээ хэмээн гараа саван хашхирахад Сэлэнгээ өчигдөр шөнийнхөө зүүдний төгсгөлийг санаж

өөрийгөө машин зам дээр зогсож байгаагаа сая мэдлээ.

**Төгсөв**

# ШУУРГАТАЙ ШӨНӨ

Ховд аймгаас Улаанбаатар хотын чиглэлд пургон автомашин шөнийн зам дээгүүр цас манарган хурдалж байв. Ганаа хэмээх гуч орчим насны энэ жолооч эр хоёр хотын хооронд гуравдахь жилдээ хүн зөөж буй нэгэн. Энэ шөнө нэг л ёозгүй бөгөөд гадаа тэсгим хүйтэн байгаа нь андашгүй аж.нүүр нүдгүй цасан шуурга шуурч ямар ч ээлжийн жолоочгүй тэрээр зорчигчдыг хугацаанд нь хүргэхийн тулд нүд цавчилгүй хурдалсаар. Уг нь өглөө аймгийн төвөөс гарахад цаг агаар сайхан байсан боловч яг энэ эзгүй хээр талд хүн байтугай машин явахад бэрхтэй байлаа. Хүмүүсийн амнаас ч дуу шуу гарахгүй бүгд суудал дээрээ унтаа байдалтай явах бөгөөд харин жолоочийн хажуугийн суудал дээрх нэгэн настай эмгэний өвөр дээр суух тавхан настай бяцхан охин л нүд цавчилгүй зам ширтэж явна. Машинд суугаа хүмүүс бараг үхчихсэн юм уу гэлтэй амьсгалах нь сонсогдохгүй байгаа энэ цаг мөчид зөвхөн танихгүй эмгэний өвөр дээр томоотой суух бүлтгэр нүдтэй охин л Ганаад хань болж яваа мэт санагдаж байлаа. Машины моторын хүнгэнэсэн чимээ дуулдаж зах хязгааргүй зам үргэлжилсээр.

Хэн ч юу ч ярихгүй унтах энэ харанхуй шөнө машин жолоодон яваа Ганаагийн нойр хүрч үе үе нүд нь анилдаж эхэллээ. Гэнэт “Ах аа, манай ээж сая зам хөндлөн гарлаа шүү дээ, унтлагынхаа хувцастай гүйж явна” гэсэн охины цовоо дуугаар Ганаа сэртэсхийх нь тэр.

-Юу гэнэ ээ, миний дүү?

-Манай ээж байсан

-Хаана?

-Сая зам хөндлөн гүйснийг ахаа та хараагүй юм уу?

-Үгүй ээ. Ганаа ингэж хэлээд хурдаа сааж эхлэв.”Машиных нь гэрлээс өөр ёлтойх ч зүйлгүй энэ эзгүй хээр газар амьд хүн байгаа гэсэн ямар ч ул мөр баймааргүй санагдах.Үгүй ер нь яаж ч бодсон энэ их цасан шуургатай, чөтгөр тогтохын аргагүй хүйтэн шөнөөр хэн л эзгүй хээр газар бүр унтлагын хувцастай гүйж явах билээ” гэсэн бодол төрж охиныг дэмий ярьлаа гэж боджээ.

-Миний дүү түрүүн ээжийгээ харсан гэв үү?

-Тийм ээ, унтлагынхаа хувцастай гүйж байсан. Машины урдуур гарахдаа намайг хараад инээгээд л байсан

-Ахын дүү хий юм харсан байлгүй дээ.

-Үгүй ээ, үнэхээр миний ээж мөн байсан. Тээр ахаа яг таны хажуугийн цонхны чинь харалдаа ээж маань гүйгээд байна шүү дээ. Машинаа зогсоо л доо ахаа. Манай ээж даарч байгаа гэж хэлээд охин уйлагнаж эхлэх нь тэр. Ганаагийн дотор харанхуйлаад явчихав. Бие нь жихүүцэж хажуугийн салхивч руугаа харна гэхээс хамаг биеийн нь хүйтэн хөлс аяндаа чийхраад ирлээ. Машинаа жолоодсоор... гэсэн хэдий ч маш удаанаар явж байв. Охин уйлж эхэлсэн ч машинд

унтаж буй хүмүүс, бүр охиныг өвөр дээрээ тэвэрсэн эмгэн ч сэрсэнгүй. Ганааг хажуугийн цонх руугаа харах тэр агшинд үнэхээр хэн нэгэн сэгсийсэн этгээд машиныг гүйцэж чадалгүй хоцрон үлдэх нь тэр.

Ганаа хүмүүсийг дуудаж сэрээмээр байсан ч дуу нь ер гарсангүй. Баахан сандарч жолоогоо алдах дөхөв. Толинд хартал хэн ч юу ч алга. Ганаа машинаа зогсоолоо. Хачирхалтай нь одоо хэр нь зорчигчид юу ч ажралгүй унтсаар.

-Миний дүү үнэхээр ээж чинь саяны хүн мөн байсан бол яагаад энд ингээд цасан шуурганаар гүйж байдаг билээ. Ээж чинь гэртээ үлдсэн биздээ. Энд бидэнтэй зэрэгцээд эзгүй хээр газар явах учиргүй хэмээн Ганаа түрүүнээс хойш тайвширч чадахгүй эхэр татан уйлах бяцхан охиныг тайвшруулах санаатай дэмий л ээрч мууран асуулаа.

-Миний ээж хэдэн хоногийн өмнө хадан гэртээ очсон. Тэгээд хадан гэр нь энд байдаг юм байлгүй хэмээн юмны учир ойлгох болоогүй жаахан охин уйлагнан хариулав.

Ганаагийн нүд харанхуйлж нүдэнд нь нулимс гүйлгэнээд ирлээ. Гучин хэд наслахдаа үүн шиг юм үзсэнгүй хэмээн бодохын завсар түрүүний нөгөө нүдэнд өртдөг сэгсийсэн амьтныг машиных нь араас хүрээд ирэх вий хэмээн болгоомжилсон нүдээр эргэн харав. Ээ тэнгэр минь, Ганаа ийн дуу алдаад нүдэндээ ч итгэсэнгүй. Үнэхээр машины араас нэвсийсэн хувцастай сэгсэлзсэн үстэй нэгэн этгээд асар хурдтай хурдлан ирж байлаа. Ганаа ч яахаа мэдэхгүй хэсэг алмайрснаа машинаа асааж хурдлан давхив. Үнэхээр л хүн дүрстэй сэгсгэр энэ амьтан гайхалтай хурдан гүйж эгээтэй л машиныг нь гүйцэх нь үү гэлтэй. Ганаа байн байн толиндоо харж хурдаа нэмсээр. Ямартаа ч яалт чүгүй араас нь гүйх чөтгөр шулмын алин болох нь үл мэдэгдэх энэ амьтанд л гүйцэгдэж болохгүйгээ тэрээр сайн мэдэж байлаа. Хэврээ тэгж гэмээнэ сайн юм болохгүй нь лав. Ядаж байхад ойр хавьд ямар ч суурин газар байхгүй. Зурагсан зам бүхий эзгүй хээр талд хот газрыг зорьсон пургон автомашинтай хэсэг хүмүүс л энэхэн хавьдаа амь голтой нь байх шиг санагдана. Охин ч уйлж миний ээжийг аваад яв л даа хэмээн эхэр татах ажээ. Ингэсээр удалгүй хальтаргаатай шөнийн зам дээгүүр хурдлан давхих пургон автомашин ховилд алгадуулан айхтар хазайж ирснээ ашгүй буцаад дөрвөн дугуйн дээрээ буулаа. Хүмүүс ч сэрлээ. Нүүрэнд нь хөлс дааварласан Ганаа машинаа зогсоож эргэн хартал харин өнөөх ад зэтгэрийн амьтан харагдахгүй байв. Машинд унтаж байсан хүмүүс ч яав ийв болцгоон бужигналдаж сандарч эхлэх нь тэр. Ганаа ч зорчигчдод юу болсноо нэгд нэгэнгүй тоочлоо. Нэгэн ад зэтгэрийн сэгсийсэн амьтан араас нь хөөсөн% жаахан охин түүнийг хараад ээж ээ гээд уйлаад байсан тухай ч дурсаж та нар харин сэрэхгүй байсан гэдгийг ч хэллээ. Гэнэт жолоочийн хажуугийн суудал дээр зорчиж буй эмгэн миний өвөр дээр байсан охин хаачив хэмээн хашхирах нь холгүй асуув. Үнэхээр охин алга байлаа. Эмгэний өвөр дээр битгий хэл машинд байсангүй. Хүмүүс ч сандралдан машинаас буун гэрэл чийдэн тусгаад охины ямар ч ул мөрийг олсонгүй. Ганаагаар ахлуулсан дөврөн залуу хүнд төмөр маниулаар зэвсэглэн ирсэн замаараа гар чийдэн тусган гүйлээ. Амьд хүн битгий хэл гишгэсэн мөр ч байсангүй. Охин хэдий завандаа буугаад алга болдог байна аа. Үгүй ядаж буулаа гэхэд машин дүүрэн хүмүүсийн хэн нь мэдэхгүй өнгөрнө гэдэг байж боломгүй санагдана. Охины эрэлд мордсон таван залуу яалт чгүй гар хоосон машин руугаа буцаж ирлээ. Охин байхгүй одоо яах билээ гэсэн бодол Ганаагийн толгойноос гарахгүй сэтгэлийг нь зовоосоор. Бүх хүмүүс айдас түгшүүрт бүрэн автжээ. Ядаж байхад үүр цайх болоогүй байдаг.

Залуусыг машинд эргэн иртэл үлдсэн хэдэн эмэгтэйчүүд нус нулимсандаа хутгалдчихсан бөөн юм болчихсон байж байлаа. Юу болсон бэ яагаад ингээд сүйд болоо вэ? гэж залуусын нэг нь асуухад бөмбөгнөтлөө чичирсэн хөөрхий эмгэн “Нөгөө чиний яриад байдаг сэгсгэр амьтан чинь энд ирж машин тойроод хаалга онгойлгох гээд сүйд боллоо” гэх нь тэр.

-Охин яасан гэж балмагдаж чичирхийлсэн хоолойгоор Ганааг асуухад цөм мэдэхгүй гэж ам амандаа дуугаран хурдан явцгаая гэж яаруулав. Түрүүнээс хойш яахаа мэдэхгүй чимээгүй суусан нэг эмэгтэй сая ам нээлээ. “Наад охиныг чинь Сэлэнгэ гэдэг юм. Долоо хоногийн өмнө ээж нь өөд болоод охиныг харгалзах хүнгүй учир хот руу аваачин асрамжийн газар өгөхөөр болсон. Би уг нь цэцэрлэгийн нь багшийн нь найз нь. Хот орох далимдаа хүүхэд үрчлүүлэх газар өгөхөөр явж байсан юм л даа” гэх нь тэр. Хүмүүс нэг нэгэндээ улам наалдан сууж, залуучууд өөрсдийнхөө гарт тааралдсан үзүүртэй хүнд гэсэн зүйлүүдээрээ зэвсэглээд авав. Ганаагийн хажууд сууж явсан эмгэн ч арын хэсэг рүү шилжиж харин оронд нь хамгийн хүдэр бадир зоригтой залууг суулгалаа.

Гай болох нь тэр. Машин асдаггүй ээ. Өдий дайны хүйтэнд ер ажралгүй асчих ёстой машин нь бүр таг шүү. Ийнхүү маниулдаж ноцолдсоор байж арай гэж нэг юм машин асаад хөдөлж эхэллээ. Яг энэ үед ахаа намайг битгий орхиоч ээ гэсэн Сэлэнгэ охины дуу хүмүүст сонсогдох нь тэр. Машинд яваа хүмүүсийн хэнд ч тэр жаахан охиныг цасан шуурганаар хаяад зугтах хүсэл байсангүй. Машинаа зогсоотол охин ч ашгүй амьсгаадан гүйж ирлээ. Тэгээд л удалгүй охиныг машиндаа суулгаад Ганаа ум хумгүй давхиж гарах нь тэр.

-Сэлэнгээ миний дүү чи зүгээр үү, чи хаашаа алга болчихов оо?

-Ээжтэйгээ уулзаад ирлээ.

-Юу? ээж чинь тэгээд юу гэж байнае

-Ээж даараагүй байна аа. Харин их өлсөөд мах л идмээр байна гэнэ ээ. Надад мах байхгүй болохоор та нараас мах аваад ир гээд явууллаа. Хэрвээ мах өгөхгүй бол намайг аваад явна гэсэн. Та нар одоо ээжийг одоо гүйцээд ирвэл битгий мах өгөөрэй, би ээжтэйгээ хамт явмаар байна гэж хэлэх нь тэр. Бүгд л мэл гайхаж цэл хөхөрнө гээч нь болоод дагжин чичирцгээж бараг зэрэг шахам эргэж харлаа. Үнэхээр өнөөх Сэлэнгээгийн ээж гэж нэрлээд байгаа үхээрийн амьтан маш хурдтайгаар хазганан гүйж айсуй. Машинд сууж яваа настай эмгэн “Ямар нэгэн юманд хоргодоод нөгөө ертөнцдөө очиж чадаагүй хүний сүнс үгээр хэлэхийн аргагүйгээр их өлсөж ховдог болдог юм гэсэн. Хурдан энэ газраас холдохгүй бол биднийг ч хүртэж мэднэ” гээд хүнгэнэтэл маани уншаад эхэллээ. Ганаа ч хурдаа нэмэв. Гэвч яаж ч хурдаллаа гээд өнөөх амьтан машиныг гүйцээд ирлээ. Ганаа ч зориг шулуудан зөвхөн өмнөх замаа л харан давхисаар. Нэг л мэдэхнээ өнөөх амьтан машины урдах зам дээр гараа алдлан хөндлөлдөн зогсож байх нь тэр. Ганаа нүдээ аниад хурдаа улам нэмлээ. Үнэхээр бидэнтэй адилхан хүн л юм бол хурдтай давхиж байгаа машиныг гүйцэж ирэх нь байж боломгүй зүйл гэж Ганаа бодож байв. Намайг битгий дайраач гэсэн охины дуутай зэрэгцэн хэн нэгнийг дайрах чимээ гарлаа. Уг нь элдэв сүнс, хий үзэгдэл байсан байж гэмээнэ зүгээр л хий дайраад өнгөрөх байсан гэж тооцоолж байсан Ганаа машинаа зогсоолоо.

Үнэхээр ямар нэгэн зүйлийг мөргөж зам дагуу хол шиджээ. Цөм сандралдан гарч өнөөх



ухаангүй хэвтэх амьтан дээр болгоомжлон очив. Ганаа нүдэндээ ч итгэсэнгүй. Саяхан л жолоочийн хажуугийн суудал дээр сууж явсан тавхан настай бяцхан охин цустайгаа холилдон ухаангүй хэвтэж байна. Цөмөөрөө гайхан балмагдав. Охиныг машиндаа байгаа эсэхийг нь олж үзэхээр яаран буцаж гүйх Ганаагийн нүд ёстой л нэг улаанаараа эргэлдэнэ. Охин машинд алга. Өнөөх ад чөтгөрийн амьтан ч дахиж харагдсангүй. Сэлэнгэ охин хэдийнэ амьсгал хураажээ. Ашгүй үүр цайж эхэлж буй энэ үед шөнөөс хойш тасралтгүй маани уншсан настай эмгэн “нас барсан эхийн сүнс охиноо ганцааранг нь хэцүү амьдралд орхиод явж чадаагүй бололтой. Охиноо аваад явсан нь энэ юм байлгүй дээ” гэсээр үгээ төгсгөв.

Нар мандаж цасан шуурга тогтон өвлийн тогтуухан өдөр охины шарилыг ачсан пургон автомашин их хотын зүг алгуурхан дөхсөөр...

**Төгсөв**

... Нэг их цас мөс болоогүй хэрнээ хүйтэн жавар тачигнасан өвлийн жихүүн өдөр байлаа. Хотын төвөөс нэлээд зайдуу оршуулгын газрын хаяаг залган өч төчнөөн айл өрхүүд түрэн орж иржээ. Үхэгсдийн хотод голомтоо асаасан эдгээр айл өрхүүдийн аж амьдрал нэг өөдлөхгүй байгаа мэт.

Галсангийнх энэ жил мөн “Үхэгсдийн хот”-ын хаяаг дэрлэн буусан айлуудын тоог нэгээр нэмжээ. Эхнэр арван настай охин хоёрынхоо хамт амьдардаг тэрээр угийн сүсэг бишрэлгүй нэгэн. Санасны бодоход овоо том хашаатай болсондоо баахан олзуурхаж ирэх жилээс хэрхэн яаж одоо байгаа дээрээ нэмээд хэд хэдэн байшин барих тухай төлөвлөгөө толгойдоо зохионо. Галсан энэ жил 34 нас хүрч байгаа, өндөр нуруутай, биерхүү өндөр улаан хүрэн царайтай нэгэн аж. Шулуун цэх хамар, зоримог бээрийн бага зэрэг онигордуу нүд нь түүний бусдад таалагдах гол сэжүүр болдог болов уу гэлтэй. Түүний спорт хэлбэртэй засуулсан тачирхан үс нь өөрт нь гайхалтай зохисон байх агаад хулгар чих нь барилдаж ноцолддог нэгэн байсныг нь гэрчилнэ. Харин эхнэр Хэрлэн нь намхавтар нуруутай, давхраатай алаг нүдтэй, далыг нь даван ургаж буй өтгөн хар үстэй, тэр нь өөрт нь тун чиг зохисон царайлаг бүсгүй аж. Ийнхүү Галсангийнх шинэ газарт бууж юм хумаа цэгцэлсээр нэг л мэдэхэд харуй бүрий болжээ. Шинэхэн барьсан байшин хэрнээ эзэн нь яагаад удаан суулгүй хямд үнээр зараад арилж өгснийг залуу хосууд огтхон ч тоосонгүй. Эхэндээ энэ хашаа байшинг худалдаж авна гэхэд Хэрлэн дургүйцэж байсан ч өөр хүнд алдахаасаа өмнө хямд үнэтэй боломжийн хашаа байшинг өөрийн болгоод авахыг илүүтэй хүссэн билээ. Хоёр давхар энэ байшин нийтдээ найман өрөөтэй бөгөөд хашааных нь буланд байх жорлон нь байшингаас нь нэлээд зайтай аж. Өвлийн улирал учраас дээд давхрын дөрвөн өрөөндөө хэрэггүй новшоо хурааж орхиод амархан халдгаар нь доод давхартаа гурвуулаа өвлийг өнгөрөөхөөр тохирчээ. Дээд давхрын тэдгээр өрөөнүүдийн хоёр нь илүү том талбайтай, харин нөгөө хоёр нь жижигхэн зайтай. Хэрвээ Галсангийнх олон хүүхэдтэй байсан бол зуны цагт дээд давхрын саруулхан том цонхтой энэ хоёр жижиг өрөөнд хүүхдүүдээ оруулах байсан нь дамжиггүй биз.

Харин доод давхрын хувьд дөнгөж үүдээр ороод баруун гар тийш эргэхэд том саруулхан галын өрөө байрлах агаад байрны хуучин эзэд яарч сандран нүүхдээ бүх тавилгуудаа Галсангийнх орхисон. Ийм гоёмсог бүх юм нь бүрдсэн гал тогооны өрөөтэй болсондоо гэрийн эзэгтэй баярлаад барахгүй байгаа билээ. Гал тогооны өрөөтэй залгаа нар мандахыг харж болохуйц цонхтой тохилог өрөөг Галсан Хэрлэн хоёр унтлагын өрөө болгохоор тохиров. Харин охин Саруул нь үүдээр ороод зүүн гар тийш эргэхэд дайралдах том жижгээрээ яг ижилхэн хоёр өрөөний нэгийг нь өөрийнхөө өрөө болгож зарлан тунхаглав. Гэхдээ Саруул аав ээжтэйгээ ойрхон, гарах үүднээс арай хол байрлах өрөөг сонгосон билээ.

Ийнхүү аав ээж охин гурав төвхнөж аваад оройныхоо хоолыг амтархан идэцгээлээ. Нүүж сууна гэдэг хэрэндээ л нүсэр ажил байдаг юм хойно аав ээж охин гурав бүр ядарч орхисноо сая анзаарав бололтой унтах гэж яарцгаалаа. Саруулын өрөөг аав ээж нь маш сайхан тохижуулж өгчээ. Өнгөрсөн жилийн төрсөн өдрөөр нь авга ах Батжаргалын нь бэлэглэсэн хүүхдийн орон дээр Саруулыг хэвтүүлж хөнжлөөр хучиж өгөөд өөрсдөө унтлагынхаа өрөөнд

орлоо.

Шөнө дунд болжээ. Гадаа жавар тачигнаж салхи хүүгэхээс өөр чимээ анир үл дуулдана. Эхнэрээ тэврэн тайван нойрсох Галсан хүн дуудав уу гэлтэй гэнэт сэрлээ. Тэрээр өөрийгөө чухам яагаад сэрчихсэнээ ч сайн ойлгосонгүй. Хар дарж зүүдлэв үү гэтэл үгүй ээ, эхнэр Хэрлэн нь тайван унтсан хэвээр. Гэтэл охиных нь унтах хажуугийн зэргэлдээ өрөөнд хэн нэгэн дүнгэр дүнгэр ярих дуудав. Энэ харанхуй шөнө чинь ганцаараа унтаж байгаа охины минь өрөөнд хэн байдаг билээ гэсэн бодол Галсангийн толгойд төрөхтэй зэрэгцэн хамаг биеэр нь цахилгаан гүйдэл гүйх шиг боллоо. Эхнэрээ сэрээх гэснээ больж хэсэг азнаан чагналаа. Тэгтэл харин тэр яриад байгаа нь охин нь өөрөө бололтой. Галсан охин Саруулыгаа зүүдэлж байна гэж боджээ. Тайван босоод өрөөнийх нь хаалганд чихээ наан чухам юу яриад байгаа тухай нь сонирхов. Үнэхээр охин нь ярьж байна аа. “Зооринд муухай хүйтэн юмаа. Хэн нэг нь намайг энэ зоориноос гаргаад өгдөг ч болоосой. Би үнэхээр их даарч байна. Надад туслаач дээ” гэх нь тэр. Өөрийгөө хий юм сонсоогүй гэдэгтээ баттай итгэж байсан Галсан охиныхоо өрөө рүү ямар ч эргэлзэх зүйлгүй явж орлоо. Энэ үед сарны гэрэлд охиноо харсан Галсан цочсондоо золтой л хашхирсангүй. Үсээ задгай тавьж нүүрнийхээ өмнүүр унжуулсан Саруул унтлагынхаа хувцастай орон дээрээ өвдгөө тэврэн сууж байлаа. Ийм дүр зураг харна гэж санаагүй Галсан баахан барьц алдан тэмтчин байж өрөөний гэрэл асаав. Охины нүд хагас аниатай байх бөгөөд нүднээс нь нулимс асгарчээ.

“Саруулаа миний охион. Бие нь зүгээр үү? Миний охин хэнтэй яриад байгаа юм бэ, яагаад уйлчихсан юм. Одоо аав нь дэргэд нь байна” гэх зэрэг олон зүйлийг ар араас нь асуусаар Галсан охиноо тэврээд авлаа. Охинд аав нь өөрийг нь тэвэрч байна гэдгийг мэдсэн ямар ч шинж байсангүй.

“Миний охин айх хэрэггүй. Одоо аав нь охинтойгоо хамт унтах учраас битгий сандраарай” гэсээр Галсан өнөөг хэр нь сэрээгүй байгаа охиноо хөнжлөөр сайтар хучин өөрөө хажууд нь зэрэгцэн хэвглээ. Хэдий Галсан охиныхоо өрөөний гэрлийг унтраасан ч цонхоор сарны гэрэл нэвг тусч өрөөн доторх хамаг юм ив илхэн харагдаж байв. Саруулын өрж тавьсан тоглоомын хүүхэлдэйнүүд амьд хүн шиг Галсанг цоо ширтэх мэт үзэгдэх нь цаанаа л нэг ёозгүй. Охин ч дахин зүүдэлсэнгүй. Галсан охиноо тэвэрч хэвтсээр нам унтжээ. Өглөө болж нар гарсны дараа хамгийн түрүүнд Галсан сэрэв. Охин нь юу ч болоогүй мэт тайван сайхан амарч байгааг хараад Галсан бүр тайвширч цай чанахаар гал тогооныхоо өрөө рүү зүглэлээ. Удалгүй эхнэр Хэрлэн нь ч түүний араас ороод ирэв.

-Миний хань сайхан амрав уу?

-Тэглээ. Харин чи ч шөнө бөх гэгч нь тайван нойрсож байсан шүү хэмээн Галсан хариулаад өглөөнийхөө цайг үргэлжлүүлэн бэлтгэлээ.

-Чи намайг шөнө сэрээгүй гэж бодож байна уу. Чамайг шөнө сэрээд Саруулын өрөө рүү явсныг чинь би нүдээ нээгээгүй болохоос мэдсэн шүү

-Өө тэгээ юу?

-Мэдсэн. Охин жаахан хар дарж зүүдлээ юу? Чамайг нэг их удалгүй хөнжилдөө эргээд ороод

ирэхээр чинь би гайгүй юм байлгүй гэж санаад асуугаагүй шүү. Нойроо харамлаад л тэр байхгүй юу.

Галсан чихэндээ итгэсэнгүй. Шөнө ганц л удаа босоод охиныхоо өрөөнд тэр чигтээ тэндээ хоносон биш билүү. Эхнэрийнхээ өвөрт шөнө дахин ороогүй дээ. Тэгээд л сая босоод шууд галынхаа өрөөнд орж ирсэн гэдгээ Галсан хэнээр ч хэлүүлэлтгүй сайн мэдэж байлаа. Ийнхүү Галсан хэсэг гайхснаа ам нээх гэтэл Хэрлэн түүний үгийг таслан “Үгүй ингэхэд чи шөнө бүр гадаа гарсан уу? Бие чинь цэв хүйтэн л араар ороод хэвтсэндэг”

-Үгүй ээ би гараагүй

-Худалч гэдэг нь. Ямар хүйтэн байнаа гээд л чичирхийлсэн хоолойгоор гэнгэнээд байсан биздээ. Залуугаараа хөгшрөөд орж гарснаа ч мэдэхээ байчихаа юу

Галсан юу ч хэлж чадсангүй. Хэрлэнд хэлэх гэсэн хамаг үг нь хоолой дээр нь ирээд гацчихав. Хэрлэнгийн дууны өнгө, царайнаас нь харахад тоглосон шинж ер алга. Гэтэл Саруул өглөөнийхөө цайг уух гэж яарсан хүн инээж хөөрсөөр гүйгээд ороод ирлээ. Галсан хэдий шөнийн болсон явдлыг Хэрлэнд хэлэхийг хүссэн ч ээж охин хоёр шинэ байшингийнхаа гоё сайхныг ярин инээлдээд Галсанд ярих завдал олгосонгүй. Галсангийн хоолойгоор хоол давсангүй ээ. Охин ч хичээлдээ явж харин Хэрлэн сайн цэгцэлж амжаагүй байгаа гэрийнхээ хогшилтой ноцолдоод завгүй хүн болж хувирав. Галсан эхнэрийнхээ өглөөний ярьсан, бас охиныхоо юу ч болоогүй мэт царайг толгойдоо бодон эргэцүүлж гайхаш тасраад байлаа. Уг нь ядаж охин нь “шөнө аймар муухай хар дарж зүүдэллээ” гэж өглөө хэлнэ гэж тооцоолж байсан хэдий ч өнгөрсөн шөнийн тухай бүр огтхон ч дурсаагүй. Эхнэр нь ч гэсэн өөрийг нь гадаа гарсан юм уу хаашаа юм гэж асууж байдаг. Учир нь миний бие цэв хүйтэн байсан гэнэ. Би Хэрлэнгийн хөнжилд ороогүй дээ. Тэгэхээр эхнэр зүүдэлсэн хэрэг. Гэтэл бас тийм биш ээ, намайг босоод охины өрөө рүү орохыг нүдээ нээгээгүй хэдий ч мэдсэн гэсэн. Тэгвэл энэ гэрт бид гурваас өөр хүн байна уу, Хэрлэнгийн өвөрт хэн оров. Энэ мэт бодлууд Галсангийн толгойд хөвөрсөөр хариуг нь олж дөнгөсөнгүй.

Сүүлдээ бүр өөртөө ч эргэлзэх шиг болж бухимдаж эхлэх нь тэр. Ингэсээр эцсийн эцэст Галсан энэ бүхнээ эхнэр охин хоёртоо хэлэх ямар ч шаардлагагүй гэж үзээд ор тас мартахаар шийдлээ.

## II

Үд өнгөрчээ. Саруул охин хичээлээсээ ирэх цаг хэдийнэ болсон ч алга. Галсан Хэрлэн хоёр бага зэрэг санаа нь зовж үе үе хашааныхаа хаалгаар шагайж охиноо харуулдана. Буйдхан газар хөл хөдөлгөөн багатай хотын захруу буусан, бас дээрээс нь гэгээ тасарч эхэлсэн энэ үед тэдний охиндоо санаа зовних нь аргагүй. Гэтэл ашгүй охин нь айсуй. Гэхдээ ганцаараа биш өөрөөсөө арай дүү болов уу гэмээр нуруугаар намхан охин гараасаа хөтөлчихсөн ирж явна. Өвлийн хүйтэн улирал гэхэд Саруултай хамт ирж яваа охин нь гадуур хувцас өмсөөгүй, зүгээр л сурагчийн орос дүрэмт хувцастай алхаж яваа нь Хэрлэнд жаахан хачирхалтай санагдав. Тэрээр охиноо ийм хурдан найзтай болоод амжмааргүй юм даа хэмээн гайхсан хэдий ч “бусадтай хурдан эвээ олсон байна, одоо доо миний охин” хэмээн дотроо олзуурхаад өнгөрчээ.

Охидууд гэрт орж ирэв. Саруул охин шинэхэн найзаа аав ээждээ танилцууллаа. Саруулын найзыг Цэнгэл гэх бөгөөд хэд хоногийн өмнө гэр нь шатахад аав нь харамсалтайгаар өөд болсон ажээ. Цэнгэл охин найм орчим настай л болов уу гэмээр цэвэрхэн жаахан охин хэрнээ нүдэнд нь ямар ч амьд хүний гал цог байхгүй мэт. Тэр охин ганцхан аавтайгаа хамт амьдардаг байсан бөгөөд аав нь ийн өөд болсон болохоор хөдөөнөөс аавынхаа ах дүү нарыг иртэл хэдхэн хоног толгой хоргодох газар хайж яваа гэнэ.

Ийм жаахан хэрнээ айхтар хэрсүү ярьсан жаахан охиныг Галсан нэг л сэжиглэсэн нүдээр цоо ширтэж байхад харин Хэрлэн өрөвдөж хайрласан харцаар харж байлаа. Ингээд ямартай ч энэ шөнөдөө Цэнгэл охин Галсангийн толгой хоргодох болжээ. Саруул охин өрөөндөө найзтайгаа хамт хонох болсондоо баахан олзуурхаж хөл нь газар хүрэхгүй хүүхэд дээд доод давхраар гүйнэ. Харин Цэнгэл Саруул шиг тэгж огтхон ч хөөрч догдолсон шинжгүй харагдана. Зүгээр л харц нь нэг цэгт төвлөрчихсөн гэлтэй ямар ч хөдөлгөөнгүй галын өрөөний мухарт сууж байв. Энэ байдал нь Галсанд нэг л сэжигтэй санагдаж эхнэртээ хэлтэл Хэрлэн тас намжирдаж өнчирсэн жаахан охин яаж өөдтэй байх билээ гээд амыг нь таглажээ.

Шөнө дунд болжээ. Урьдын адил эхнэрээ тэврэн тайван нойрсож байсан Галсан шөнө дундын энэ үед дахиад л сэрүүлэг тавьсан юм шиг сэрчихэв. Гадаа хав харанхуй, ядаж сарны гэрэл хүртэл тусахгүй байгаа учраас байшинд ч гадаа ч хаана ву байгаа нь мэдэгдэхгүй байлаа. Энэ харанхуй зэвхий байдал гэнэт сэрсэн Галсанд огтхон ч таалагдахгүй байх бгөөд хэн нэгний ярихыг өчигдрийн адил сонсох нь тэр. Байшинд нь дахиад л хэн нэгэн шивнэн ярих нь үгүйсгэхийн аргагүй тод сонсогдож байлаа. Галсан үүнийг сонсоод жаахан хэвтэж байснаа өндийлөө. Охиноо дахин хар дарж зүүдэлж байгаа юм болов уу хэмээн бодож өрөө рүү нь алгуурхан дөхөхөд нөгөө шивнэж яриад байгаа чимээ өөр өрөөнөөс дуулдаж байв. Галсан амьсгаагаа даран жаахан чагналаа. “Энд л байх ёстой доо, хурдан гараад ирээч дээ” хэмээн эмэгтэй хүн шаналан шивэгнэж байх нь тэр. Галсан гал тогооныхоо өрөө рүү ганцаараа орж зүрхэлсэнгүй. Өлмий дээрээ дэгдсээр унтлагынхаа өрөө рүү буцаж ороод эхнэрээ сэрээлээ.

-Яасан бэ хаа. Унтахгүй яаагаав?

-Чимээгүй ээ, гэрт бид хэдээс өөр хүн байна.

-Юу?

-Галын өрөөнд л ямар нэгэн юм хайгаад шивнэж яриад байн, хоёулаа очъё хэмээн Галсан хэллээ.

Эр хүн болсоор анх удаа ийн зүрх алдаж эхнэрээрээ хань хийх болсондоо энэхэн агшинд Галсан өөрөөрөө ичих шиг болсон ч энэ бодол нь даруйхан замхрав. Учир нь энэ бодлоос нь илүүтэй гал тогооных нь өрөөнд хэн байна вэ гэсэн бодол сонирхлыг нь эрхгүй татаж Хэрлэнтэй хамт галынхаа өрөө рүү сэмхэн гэтлээ. Хэрлэн эхэндээ нойрмоглож юу болоод байгааг нь сайн ойлгоогүй хэдий ч “хэн нэгэн гадны хүн гэрт нь байна” гэсэн нөхрийнхөө үгийг сонсоод нойр нь айдас түгшүүрээр солигдоод иржээ. Охин нь өрөөндөө тайван унтаж байгаа нь амьсгалж буй чимээнээс нь андашгүй аж. Тийээс галын өрөөнд яалт ч үгүй гадны хүн байгаа нь тодорхой.

Галсан юмыг яаж мэдэхэв гэсэн шиг унтлагын өрөөний мухарт байсан том цохиур модыг гартаа атгажээ. Үнэхээр хэн нэгэн хүн гал тогооны өрөөнд холхиж ямар нэгэн юм ухаж төнхөж буй чимээ гарч байлаа. Хэрлэн бүрэн айдаст автжээ. Тэрээр нөхрийнхөө зүүн гараас чанга атган гэтсээр гал тогооны өрөөг тусгаарласан энэ жижиг хаалгыг хаагаагүй гэдгээ сайн санаж байв. Гэтэл хэн нэгэн этгээд хаагаад зогсохгүй, бүр дотор нь ямар нэгэн юм онгичих чимээ гарах аж. Хамгийн гайхалтай нь хаалганы завсраар гэрэл тусахгүй байгаа нь галын өрөөний гэрэл унтраалттай хэвээр байгааг илтгэж байлаа. Өрөөн дотроос хэн нэгэн хүний энд л байгаа даа, хурдан гараад ирээч гэсэн шаналсан дуу хэдий шивнэж байсан ч эхнэр нөхөр хоёрт тодоос тод сонсогдож байв. Ийм харанхуй рчинд яасан айхтар хардаг этгээд вэ гэсэн бодол Галсанд төрөхтэй зэрэгцэн галын өрөөний хаалгыг хүчтэй саван дотогш орлоо. Хэрлэн ч нөхрөө даган орж өрөөний гэрлийг асааж харав. Гэтэл харин Галсангийн толгой хорогдох болсон Цэнгэл охин тэдний өөдөөс хүйтэн харцаар ширтэн сууж байв. Гал тогооны өрөөнд байсан хоолны хүнд ширээг хажуу тийш нь бүр зайчилж орхиод шалан дээр байсан хивсийг нэг тийш нь хуйлж байх нь тэр. Галсан ч тэсгэлгүй “Чи энд юу хийж байгаа юм бэ?” хэмээн хашхиран асуулаа. Охиныг хариулж амжихаас өмнө Хэрлэн ч гэсэн “Чи юу хулгайлах санаатай хүмүүс унтсан хойно харанхуй шөнөөр энд юм онгичиж байх билээ” гэж бухимдсан дуугаар давшлах нь тэр. Цэнгэл охин өчүүхэн ч айж санаа нь зовсон шинж алга. Үхдэл мэт цэлдэн хөх хувхай царайтай тэрээр Хэрлэн рүү нүд салгалгүй хэсэг ширтэж байснаа “Миний гэдэс өлсөөд байна” гэх нь тэр. Энэ үгийг сонссон эхнэр нөхөр хоёр хоорондоо харц солилцоод авав. Хэрлэн ч хэсэг тээнэгэлзэж байснаа талхныхаа савыг онгойлгон охинд идэх юм өглөө. Удалгүй Хэрлэн тайвширч өнөөх өлссөн охиныг Саруулын өрөөнд оруулаад хөнжлөөр хучив. Харин Галсангийн санаа амарсангүй. Энэ харанхуй шөнө өрөөнд юу ч харагдахгүй байхад энэ ширээг зайчлада хивс хуйлж байдаг. Энэ хивсийг энэ шөнөөр ийм жаахан охин өргөөд явна гэхэд бүтэхгүй. Ингэж бодсоор Галсан дутуу хуйлсан хивсийг гүйцээн хуйлахдаа шаланд нь ямар нэгэн жижгэвтэр хаалга гэмээр зүйл байхыг сая олж харлаа. Тэрээр үүнийг юу болохыг шууд нэрлэчихэж чадсангүй. Ойртож очоод дээрээс нь сайтар ажиглавал зоорины таг бололтой. Үнэхээр л шаланд гаргасан, хүний нүдэнд шууд өртөөд байхааргүй энэ тэг дөрвөлжин хаалга гэмээр зүйл зоорины таг байхаас өөр юу байх билээ.

Энэ байшинд ийм зоорь байдаг гэдгийг Галсан ер мэдээгүй. Магадгүй Цэнгэл охин идэх юм биш энэ зоорийг хайж байсан юм биш байгаа гэж бодмогцоо эхнэрээ дуудан уг зоорины хаалгыг үзүүлэв. Харин эхнэр нь үүнд ач холбогдол өгсөнгүйгээр барахгүй “Хөөрхий охин оройн хоол идээгүй болохоор өлсөх нь аргагүй” гэж хэлээд нөхрийгөө хамт орондоо орьё гэж гуйлаа. Эхнэр нь гэнэт ингэж наалинхай аашилж цээжийг нь тэврэн үнсэхэд Галсан татгалзаж чадалгүй ор луугаа явлаа.

Өглөө болжээ. Галсан нүдээ нухлан шингэн юм олж уух санаатай гал тогооныхоо өрөө рүү орж яваад цочсондоо дуу алдах нь тэр. Цэнгэл охин хэдийнэ босоод галын өрөөний сандал дээр сууж байв.

-Бас л чи юу, үгүй чи чинь ингэхэд яагаад ийм эрт босчихсон байдаг хүүхэд вэ. дахиад л өлсөө юу. Манай гал тогооны өрөөний юу нь чамд тэгтлээ их таалагдаав?

- ... /таг чиг/ Цэнгэл охин Галсангийн нүд рүү хүйт даасан харцаар нэвт ширтсээр. Галсан энэ харцанд удаан тэсч чадсангүй өөрийн эрхгүй дальдчив

-Чи өнөөдөр манайхаас яваарай дуулав уу?

-...Би явахгүй

-Яагаад явдаггүй билээ. Хаанаас ирсэн тэр газар луугаа яв мэдэв үү. Одоо бид нар чамайг гэртээ дахин хонуулахгүй

-Би ..би энд байх ёстой. Түүний энэ дууны өнгө хүүхдийнх гэхэд дэндүү үнэмшилгүй алсаас сөөнгөтөж байгаа мэт аж.

-Үгүй шүү миний дүү. Чамд манайд байх ямар ч шаардлага шалтгаан байхгүй. Галсан ингэж хэлээд охиныг ум хумгүй хөөж гаргалаа. Цэнгэл явахдаа нэг л хүйтэн хөндий дуугаар “би дараа ирнэ ээ” гэж хэлэх нь тэр. Энэ үед Саруул түүнийг явуулахгүй гэж аавыгаа эсэргүүцсэн ч нэмэр болсонгүй. Харин ч бүр Галсан уурлан хашхичиж охиноо хайр найргүй зэмлэж гар далайж сүрдүүлэв. Энэ бүхэнд Хэрлэн багагүй эмзэглэж гэрээс нь хөөгдсөн өнчин охины араас гарч хартал байхгүй байлаа. Бүр дөнгөж сая л хашааны хаалгыг гаднаас нь хаагаад гарсан бил билүү. Ийм хурдан гүйгээд нүдэнд харагдахгүй алга болно гэдэг яавч байж боломгүй мэт санагдана.

Хэрлэн Цэнгэл охиныг бараа сураггүй алга болсон байна гэж нөхөртөө хэлэхийг хүссэн ч Галсан маш ихээр бухимдаж байсан болохоор хэлэхээ түр азнажээ.Багагүй хугацаа өнгөрсний дараа Галсан сая нэг хагас дутуу тайвшрав. Тэрээр болсон явдлуудыг маш нухацтайгаар бодон эргэцүүлж байлаа. Энэ байшинг худалдсан хуучин эзэн гал тогооны хэрэгслийг тэр чигт нь орхисон. Шалан дээр нь дэвссэн тэр хивсийг ч гэсэн. Тэгээд л энэ бүхэнд нь эхнэр бид хоёр татагдсан шүү дээ. Гал тогооны өрөөнд тийм зоорь байгаа гэдгийг харин хэлээгүй. За яахав, байрны хуучин эзэн зоорины талаар танилцуулахаа мартсан байлаа гэхэд тэр цонхигор царайтай өнчин охин яагаад хивс хуйлж тэр зоорийг хайх болов. Мэдээж хэрэг зоорь хайснаас гарцаагүй. Хивсэн дороос идэх юм хайна гэж байхгүй гэдэг нь лавтай. Тэгээд ч эхнэртэйгээ хамжин байж өргөдөг хоолны том ширээг тийм жаахан охин яаж зайлуулж хүчирсэн байх вэ Галсангийн толгойд энэ мэт бодлууд ар араасаа хөвөрсөөр гэнэт цочих шиг болж сууж байсан сандал дээрээсээ огло үсрэн босоод ирлээ. Нээрээ тийм, Саруулын зүүдэндээ яриад байсан зоорь. Зооринд хүйтэн байна, намайг гаргаач дээ гэж гуйгаад уйлж зүүдэлсэн шүү дээ. Гэтэл бас Хэрлэнгийн өвөрт орсон тэр цэв хүйтэн биетэй залуу хэн байж таарах вэ. Бас хаанаас гарч ирсэн байх билээ.

Галсан өмнө нь тэр шөнийн тухай хэдий бодож байсан ч одоогийнх шигээ ингэж их ач холбогдол өгөөгүй билээ. Эхнэрээ зүгээр л зүүдэлсэн гэдэгтээ өөрийгөө хүчээр итгүүлсэн байсан бол энэ удаад үнэхээр хэн нэгэн эхнэрийн нь өвөрт орсон үнэмшилтэй санагдаж байлаа.

Арай тэр зоориноос ... гэсэн бодол Галсангийн толгойд төрөв үү үгүй юу л Галсан гал тогооныхоо өрөөний зоорины дэргэд ирсэн байв. Дотроос нь ямар нэгэн аймшгийн амьтан гараад ирэх вий гэсэн шиг нимгэн төмрөөр зоорины тагийг шалтай нь холбон том хадаасаар

сайтар хадаж орхижээ. Мэдээж зоорийн анх ухаж бэлдсэн хүн хожим нь ингэж хадаж битүүмжилнэ гэж санаагүй нь лавтай. Одоо ингээд бодоод байх нь ээ, хашаа байшинг зарсан эзэн нь гал тогооныхоо өрөөг үзүүлэхдээ царай нь нэг хувхайрчихсан байсан нь Галсанд харагдах шиг болов. Энэ зоорин дотор ямар нэгэн амьан байгаа юм биш биз гэсэн адын бодол Галсангийн толгойд төрөнгүүт ар нурууных нь хүйтэн хөлс дааварлаад ирлээ.

## IV

Өглөөнөөс хойш нөхрийн нь уурласан уур гарахгүй байгаа нь Хэрлэнд яршигтай санагдаж эхлэв. Бүр хачирхалтай нь гал тогооныхоо өрөөнд ганцаараа орчихоод гарч ирдэггүй. Араас нь орох гэхээр наашаа битгий ороорой, би ганцаараа хэсэг баймаар байна гэж хэлээд Хэрлэнг халгаасангүй. Ядаж гадаа хүйтэн болохоор гэр нь хүйт даагаад Хэрлэн гал түлэхийг хүсч байвч ийнхүү яаж ч чадахгүй гараа элгэндээ зөрүүлэн хоёр тийш холхино.

... Галсан санамсаргүйгээр олж нээсэн тэр зоорины хаалгыг гөлрөн бодолд дарагдан суусаар. Гэхдээ Галсангийн энэ байдал нь тийм ч их удаан үргэлжилсэнгүй. Магадгүй байрны хуучин эзэн зүгээр л зоорь гаргах гэж үзээд бүтээгүй болохоор ингэж хадсан байж болно. Галсан энэ бодолдоо өөрийгөө хүчээр шахуу итгүүллээ. Тэгээд энэ бодлоо ямар ч байсан баталж санаагаа амрахын тулд зоорины хаалгыг нээж үзэхээр шийджээ. Гэтэл хамгийн гайхалтай нь энэ зоорины хаалгыг нээнэ гэдэг тусгай хамгаалалттай төмөр сейфийг нээхээс ялгаа байхгүй мэт. Галсан үнэндээ энэ зоорины хаалгыг санасныхаа зоргоор нээчихэж чадсангүй. Аргаа бараад алхаар тогшиж үзэхэд цаанаа хөндий байгаа нь цохилтных нь дуунаас андашгүй боллоо. Тэгэхээр ямар ч байсан энэ зоорины модон хаалганы цаана доошоо ухсан нүх байна. Энэ зооринд чухам юу байна вэ, анх ямар зорилгоор ухаж бэлдсэн хэрэг вэ, юунаас болоод хадаж битүүлэх болов гэх мэт зоорийг тойрсон олон асуултууд Галсангийн толгойд асуулт хэвээр үлдэв. Галсан өөрийнхөө дотроо болж байгаа энэ бүх түгшүүр, сэтгэл эмзэглүүлмээр бодлуудаа эхнэр охин хоёртойгоо хуваалцахыг хүссэнгүй. Ямар ч байсан тэднийгээ хайрлаж хамгаалах ёстой цорын ганц хүн нь өөрөө болохоор тэдэндээ энэ бүхнийг ярьж айлгаж сэтгэлийг нь түгшүүлэхийг хүссэнгүй бололтой. Ядаж байхад оршуулгын газартай хаяа залгаж буусан болохоор эхнэр нь амархан айн түгших нь дамжиггүй. Ингээд Галсан тэр шөнийн эхнэрийнх нь өвөрт орсон хүйтэн биетэй хүнийг өөрийгөө биш гэж үнэнээ хэлэх бодлоосоо бүрмөсөн татгалзжээ.

-Галсаан, миний хөгшин өлсөж байгаа биздээ. Хоёулаа хоол хийж идэх үү гэсэн эхнэрийнхээ аргадангуй дуунаар Галсан бодлоосоо цочин сэрэх мэт болов.

-Тэгье ээ хөө. Саруул хичээлдээ яваа юу?

-Тэглээ. Түрүүн явсан. Охины маань сургууль жаахан зайтай байгаа нь их хэцүү юмаа.

-Гэхдээ ингэлээ гээд яахав дээ. Ганцхан манайх ийм байдалтай байгаа биш. Энэ байдалдаа дасахаас өөр сонголт бид гуравт одоохондоо байхгүй л байна.

-Тийм дээ. Миний хөгшин ямар хоол идмээр байна. Би чиний хамгийн дуртай хоолыг чинь хийж өгөх үү. Чи минь амралтаа ердөө сайхан өнгөрөөж чадахгүй байсаар ажилдаа орох болох нь. Нүүж суусаар байгаад миний хөгшин бүр цутарчихаж гэж хэлээд Хэрлэн нөхөртөө



өөрөө эрхлэх, эсвэл нөхрөө эрхлүүлж байгаагийн аль нь мэдэгдэхгүй инээмсэглэв.

Галсан эхнэрийнхээ хэлсэн саяны үгийг сонсоод удахгүй ажилдаа орох дөхөж буйгаа саналаа. Баахан нүүдэл суудал болсоор байгаад өөрийгөө бараг ажилтай гэдгээ ч мартаж орхижээ.

-Миний хань сайхан цуйван хийчих. Би энэ зоорийг нээх гээд оролдоод үзье хэмээн Галсан эхнэртээ хэлээд зоорины хаалгатай ноцолдож эхлэв.

-Хэрэггүй ээ, наадахаа орхи цаашаа. Хүн чамайг сайхан амар гээд байхад өөрийгөө зовоогоод л. Маргаашнаас л болно биздээ. Тэгээд ч одоохондоо манайд наад зоорины чинь хэрэг ер алга.

Галсан ч эхнэрийнхээ үгэнд эргэлзэх зүйлгүй орлоо. Нэгдүгээрт зоорины хаалгыг нээнэ гэдэг тийм амар биш, хоёрдугаарт энэ зоорийг нээж гэмээнэ дотор нь юу ч байж мэдэх юм гэсэн айдас түүнийг эхнэрийнхээ үгэнд ороход нөлөөлөв бололтой. Ингээд Галсан Хэрлэн хоёр гал түлж гэрээ сайхан дулаацуулж аваад дутуу цэгцэслэн новштойгоо ноцолдох их ажилд ханцуй шамлан орлоо. Хэрлэнгийн хувьд одоохондоо ажилгүй байгаа бөгөөд нөхрийгөө ганцаараа ажиллаж өрх гэрээ тэжээж яваа гэдэг утгаар нь аль болох амраах сонирхолтой байв. Ингэсээр нэг мэдэхэд л өдөр өнгөрч Саруулын хичээлээсээ ирэх цаг болжээ. Өвлийн улирал учраас эрт гэгээ тасарч цас бударч эхлэв. Галсан энэ удаа нөгөө Саруултай хамт ирдэг өчигдрийн охиныг дахиад хүрээд ирэх вий хэмээн битүүхэн болгоомжлон охиноо харуулдсаар. Ашгүй удсан ч үгүй охин нь ганцаараа ирлээ. Саруул аавтайгаа дуугарсангүй. Уг нь өмнө нь загнууллаа ч тэр дороо мартчихдагсан. Гэтэл энэ удаа нэг л бишээ. Бүр нэг хар элгийн хүн шиг өөртэй нь хүйтэн хөндий харьцахад охиндоо жаахан гомдох шиг ч болов. Оройн хоолон дээр ч гэсэн охин аавтайгаа юу дуугарсангүйгээр барахгүй өрөөндөө ороод хаалгаа дангинатал түгжээд орондоо орчихов. Галсан охинтойгоо чухам яаж ярилцах учраа нэг л сайн олж өгөхгүй энэ тухайгаа эхнэртээ хэллээ. Гэтэл Хэрлэн үүнд нь ер ач холбогдол өгсөнгүй.

“Удалгүй хуучин хэвэндээ орно биздээ. Найзыг нь явуулчихсан болохоор л тэгж байгаа юм. Санаа зовсны хэрэггүй дээ хө” гэж хэлээд унтахаар ороо заслаа. Нээрээ ч эхнэрийн нь үг үнэн юм шиг түүнд санагдаж охиныхоо өрөө рүү орох гэснээ больж бие засахаар гадагш гарлаа. Гадаа харин хаа очин тийм их хүйтэн байсангүй. Одод түгсэн шөнийн цэлмэг тэнгэрт өнчин саран хорвоо ерөнцийг гийгүүлж ядан байх мэт. Хашааны буланд байх жорлон руу хүрэхэд ойролцоогоор тавь орчим алхам болов. Ийнхүү Галсан бие засч аваад жорлонгоосоо гарах гэхэд хаалга нь нээгдсэнгүй. Жорлонгийн хаалга ийм амархан хөлдөөд наалдчихна гэж байж боломгүй санагдаж хүчлэн түлхсэн ч онгойсонгүй. Гэтэл доошоо ухсан жорлонгийн нүхнээс ямар нэгэн шажигнасан чимээ гарах нь тэр. Харанхуйд чухам юу байгаа нь үнэндээ харагдсангүй. Учир нь тэр чимээ чихэнд нь улам тод сонсогдож өөр лүү нь хэн нэгэн тэр доороос дөхөж байгааг илтгэх мэт. Галсан сандрах жорлонгийнхоо хаалгыг хар тэнхээгээр өшиглөснөөр сая хаалга нээгдлээ. Жорлонгоос арайхийн гарч ирсэн Галсан энэхэн агшинд олон жил хоригдоод эрх чөлөөгөө олж авсан хүн шиг баярлах сэтгэлд автав. Гар лүүгээ шууд орох гэснээ хэсэг азналаа. Саяын жорлонгийн нүхнээс сонсогдсон тэр чимээ юу байв. Жорлонгийн доошоо ухсан нүхнээс ямар нэгэн амьтан гарч ирэх нь энэ үү. Галсан энэ бодолдоо эрхгүй хөтлөгдөн бие засах жижиг модон байшин луу буцаад очлоо. Түрүүн дуулдаж байсан чимээ ор мөргүй замхран арилжээ. Нэг л ёозгүй сонсогдсон тэр чимээг дахин сонсоогүйдээ сэтгэл нь сэргэв. Галсан өөрийгөө хий юм сонсчээ гэж бодон гүнзгий

амьсгаа аваад гэртээ орлоо. Эхнэр нь хэдийнэ гэрлээ унтраагаад орондоо ороод амжжээ.

-Гадаа хүйтэн биш байна уу хэ?

-Тийм ч хүйтэн биш байна аа. Цас овоо тогтуухан хаялж байна шөнөдөө шуурч мэдэх л юм. За тэр ч яахав, ядарч байна гэдэг жигтэйхэн. Унтъя даа. Галсан ингэж хэлээд эхнэрээ тэврэн нүдээ анин хэвглээ.

Шөнө дундын үед Галсан дахин сэрлээ. Гадаа цасан шуурга шуурахаас өөр ямар ч чимээ аниргүй. Гэр нь хүйт даагаад нэг л ёозгүй. Гэтэл гал тогооны өрөөнөөс дахин юм түжигнэх чимээ сонсогдож эхлэх нт тэр. Хэн нэгэн этгээд нэгэн жигдхэн хэмнэлээр юм балбаад ч байгаа юм шиг. Гэрт нь биш хаа нэгтэйгээс сонсогдож байгаа биз гэж өөртөө хэлсэн ч яалт чгүй зэргэлдээ гал тогооных нь өрөөнөөс дуулдаад байв. Түрүүн унтахынхаа өмнө бие засахдаа жаахан айсандаа ч юм уу гэрийнхээ үүдийг хэдэн давхар цоожоор дангинатал түгжсэнсэн. Тэгэхээр гадны хүн орж ирэх ямар ч боломжгүй мэт санагдана. Саруул юм болов уу гэтэл энэ шөнө дундын үеэр галын өрөөнд юуг яах гэж тэгж балбах билээ. Галсан ийн бодсоор орныхоо хажууд байсан алхыг аваад босоод ирлээ. Энэ удаад эхнэрээ сэрээсэнгүй. Гал тогооны өрөө рүүгээ аажмаар дөхөх тусам нөгөө балбах чимээ тод сонсогдож байв. Гартаа барьсан алхаа улам чанга атгасаар гал тогооныхоо өрөөг нээж гэрлийг нь асаалаа. Галсангийн нүдэнд хэн ч өртсөнгүй. Харин өнөөх зоорины хаалгыг хэн нэг нь доороос нь цохиж байснаа болих нь тэр. Магадгүй өрөөний гэрэл гэнэт ассан болохоор зоорин доороос цохих тэр чимээ гэнэт гарахаа больчихов уу гэсэн бодол Галсангийн толгойд зурсхийн орж ирлээ. “Сая яалт чгүй зоорин доороос балбаж байсан даа” Галсан ийн бодсоор зоорины хаалгыг нягталж үзээд дотроос нь цохисон болов уу гэсэн ямар ч ул мөр олсонгүй. Тэгээд буцаж яваад галынхаа өрөөний гэрлийг унтрааж өрөөний буланд зогсоод дахин цохих тэр чимээг хүлээлээ. Магадгүй гэрэл унтраад чимээгүй болохоор зоорин доороос дахин цохино гэж тооцоолж байлаа.

V

Нам жим. Зоорин доороос балбах чимээ дахин гарсангүй. Галын өрөөтэй залгаа байрласан унтлагын өрөөнөөс эхнэрийн нь амьсгалахаас өөр юу ч энэ гэрт дуулдсангүй. Галсан өнөөх зоорины зүг чих тавьсаар багагүй хугацааг өнгөрөөв. Галсангийн нүүрээр хөлс дааварлажээ. Яалтчгүй зоорин доороос цохиж байсан тэр чимээ одоо дахин дуулдахаа больсон болохоор орлуугаа очиж эхнэрийнхээ өвөрт шургахыг завдан алхлаа. Гэтэл түүнийг дөнгөж галын өрөөнөөс гарах гэж байтал Хэрлэн “Чи чинь одоо ямар их даарчихаа вэ” гэж тодоос тод хэлэх нь тэр. Эхнэрээ зүүдэлж байна гэж бодсон ч Галсангийн нүд харанхуйлаад ирлээ. Эхнэрээ дуудаж “Чи сая юу гэв ээ?” хэмээн асуусан боловч Хэрлэн сэрсэнгүй. Галсан тэр хүйтэн биетэй этгээд хэн болохыг харахыг хүссэн ч эхнэрийн нь хажууд магадгүй азаар хэн ч байсангүй. Галсан ч эхнэрээ дахин дуудсангүй хажуугаар нь шургалаа. Түүний нойр хүрсэнгүй, гартаа атгасан алхаа ч тавьсангүй. Бие нь жихүүцэж муу ёрын адын бодлууд бүх оюун санааг нь эзлээд байлаа. Эхнэртэйгээ арав гаран жил амьдарч гал голомтоо бадрааж явахдаа ингэж барьц алдаж, айж сандарсан нь ер нь үгүй мэт бодогдоно. Уг нь Галсан угийн хүдэр чийрэг биетэй, хэр баргийн юмнаас айгаад байдаггүй зоримог эр атлаа энэ удаа тэр үл мэдэгдэх дуу чимээ, ялангуяа зоориноос багагүй жийрхэж байлаа. Хуучин байшиндаа амьдарч байхдаа нэг ч удаа ингэж хий сонсож бас эхнэр охин хоёр нь зүүдэндээ ярьж

байгаагүй гэдэгт бүх хөрөнгөөрөө дэнчин тавихад ч бэлэн тийм их итгэлтэй байв. Гэтэл энэ хэдхэн хоногийн хугацаанд юу болоод өнгөрөв өө? Хамгийн уур хүрмээр нь энэ болж байгаа бүхний утга учир ердөө олдохгүй байгаад оршиж байв. Анхны шөнө охин нь зүүдэндээ зоориноос гармаар байна, хүйтэн байна гэж уйлаад л, эхнэр нь чи чинь ямар хүйтэн биетэй юм бэ гээд л...Бас тэр охины нь дагуулж ирсэн Цэнгэл гэдэг жаахан охин. Нүд нь шар шувууных юм уу гэлтэй пад харанхуй шөнө айхтар сайн харж тэр зоорийг хайж байдаг. Галсангийн энэ бодож байгаа бүх бодлууд нь хоорондоо ямар нэг зүйлээр холбогдоод ч байх шиг. Галсан ийнхүү бодол болон шаналан хэвтсээр үүр цайлгалаа. Энэ хугацаанд зоорин доороос дахин балбах чимээ гарах нь уу гэж чих тавин хүлээсэн хэдий ч юу ч сонсогдсонгүй.

Галсан дутуу нойртой хоносноос болж нүд нь улаанаар эргэлдсэн хүн галынхаа өрөөнд зоорины хаалгыг ширтэн гөлрөн сууна. Эхнэр охин хоёр нь зэрэг шахам босоцгоож өглөөнийхөө цайг уухаар уван цуван орж ирлээ.Саруулын аав руугаа ширтсэн харц өчигдөрийнхөөс ч илүү хурц хүйтэн болжээ. Өглөөний цайн дээр хэн ч юу ч ярьсангүй. Удалгүй охин ээждээ баяртай гэж хэлээд хичээлийнхээ цүнхийг үүрэн сургууль руугаа гүйн одлоо. Галсангийн гар утсанд түүний ажилладаг барилгын компанийн албаных нь даргаас гурав хоногийн дараа ажилдаа орохыг нь сануулсан хоёр ч мессеж иржээ.

Галсан уг барилгын компанид инженер хийгээд гурван жил болж байгаа. Өвлийн улиралд барилгын компанийн захиалга харьцангуй багасдаг учраас энэ байдлыг нь далимдуулан амралтаа авсан нь энэ ажээ. Гэтэл амралтын энэ 14 хоног нэг мэдэхнээ дуусч байгаа нь Галсангаас илүү түүний эхнэрт хамгийн их харамсалтай байлаа. Мэдээж хэрэг нөхөрт нь тэр болгон олдоод байдаггүй амралтын өдрүүд нүүдэл суудал гэсээр байтал нэг л мэдэхэд дуусах дөхөж, хамтдаа өдрийг сайхан өнгөрөөнө гэсэн жаргалтай бодлууд нь бөхөх мэт болж байгаад сэтгэл нь гонсойсон биз.

Галсан өөрийгөө тайвшруулахыг хичээнэ. Уг нь энэ амралтынхаа хугацаанд шинэ орон гэрээ сайхан төвхнүүлж аваад ажилдаа орно гэж бодож байтал энэ байшинд болоод байгаа учир нь үл ойлгогдох зүйлүүдээс болоод сэтгэл нь түгшиж байв.Эхнэрээ бие засахаар явах гэхэд нь Галсан өөрөө ч мэдэлгүй “Болгоомжтой яваарай” гэхэд Хэрлэн гайхаж харснаа инээмсэглээд гарч одлоо. Удалгүй эхнэр нь гэртээ орж ирэхэд Галсан өнгөрсөн шөнийн зоорины хаалгыг доорос нь балбасан чимээний тухай ярьлаа. Гэхдээ жорлонд гацаж доороос нь ямар нэгэн нүдэнд үл үзэгдэх амьтан маш хурднаар өөр лүү нь ойртсон гэдгийг хэлэхээ азнажээ. Хэрлэн эхэндээ гайхаж байсан ч сүүлдээ Галсан хий юм сонссон гэж ятган тайвшруулахыг хичээж эхлэх нь тэр. Галсан ч гэсэн хэдий өөрийгөө хий юм сонссон байгаасай хэмээн эрхгүй хүсч байсан ч урьд шөнө дуулдсан тэр чимээ бол яах аргагүй бодитой байсан гэдгийг сайн мэдэж байлаа. Галсан өчигдөр зоорины хаалгыг нээхийг эрхгүй хүсч байсан бол одоо огт өөр бодолтой болжээ.Явал энэ зоорийг илүү сайн түгжих вэ гэсэн бодол сэтгэлийг нь шаналгах нь тэр. Тэрээр энэ зоориноос ад зэтгэрийн амьтан гараад ирж гэмээнэ лав сайн юм болохгүй гэдгийг зөнгөөрөө мэдрэх шиг. Ингээд л энэ шөнөөс эхлээд Галсан унтахдаа алх бороохой тэргүүтнийг эхнэрээсээ нууцаар орныхоо хажууд тавьдаг боллоо. Энэ гэрийн ганц эр хүн болохоор түүнд эдгээр зэвсгүүдээс нь өөр үнэнч хань байхгүй мэт санагдана. Саруул охин ч аавдаа уурласан хэвээрээ. Энэ байдалд нь аав ээж нь хоёулаа эмзэглэх болж охиноо янз бүрээр аргадах боловч тусыг эс олно. Галсан ажилдаа орох болжээ. Охиных нь харьцаа тааламжгүй байгааг эс тооцвол гэрийн бусад бүх зүйлээ цэгцлээд амжсэн мэт түүнд

санагдаж байв. Энэ орой ч гэсэн Саруул охин урьдын адил өрөөндөө ороод хаалгаа дотроос нь түгжээд гаралгүй нам жим боллоо. Галсан охиныхоо үүдэнд ирж “Саруул аа, миний охин өрөөнийхөө түгжээг тайл. Аав нь чамд бэлэг авсан. Тэгээд бас аав нь маргааш ажилдаа орох болох нь” гээд гартаа атгасан жижиг чихмэл бамбаруушийг өхөөрдсөн харцаар харснаа үнэрлээд авлаа. Харамсалтай нь Саруулын амнаас ямар ч үг гарсангүй, хаалганыхаа түгжээг ч тайлсангүй. Сүүлдээ Галсан уурлах ч биш, гуйх ч биш байдалтай яахаа мэдэхгүй зогсохыг харсан Хэрлэн нөхрөө тайвшрууллаа.

-Миний хөгшин одоо унтаж амар аа. Би Саруултай маргааш ярилцана. Тэгээд чамайг маргааш орой ажлаа тараад ирэхэд чиньв Саруул урьдын адил аавыгаа хүзүүгээр нь тэврэн үнсүүлэх болно, чамд амлая

Эхнэрийнхээ хэлэхийг сонссон Галсан нээрээ л тайвшрах шиг болов. Ээж нь арай өөр аргаар ярилцаад учрыг нь олж дөнгөнө гэж тэрээр дотроо бодоод хөнжилдөө орлоо.

Шөнө дунд болжээ. Галсан Хэрлэн хоёр тэврэлдэн тайван нойрсож байлаа. Гэтэл яг л шөнө дундын үед гал тогооны өрөөний өнөөх зоорины хаалгыг урьдынхаасаа илүү хүчтэйгээр балбах нь тэр. Галсан сэрлээ. Тэрээр орон доороо бэлдэж тавьсан зэвсгүүдээрээ өөрийгөө хангалттай зэвсэглэж аваад галын өрөө рүү дөхлөө. Өрөөнд ороод гэрэл асаасан хэдий ч үнэхээр хэн нэгэн тоос бостол шалан доороос цохих нь тэр. Зоорины хаалга эгээтэй л эвдрэх нь үү гэлтэй. Барьц алдан яахаа мэдэхгүй сандарсан тэрээр арайхийн сэхээ авах шиг боллоо. Хоёр гартаа том бороохой, төмөр шөвөг хоёрыг нэг нэгээр нь атгасан тэрээр зоорины хаалганы тэнд дөхөж очоод “хэн бэ чи?” гэсэн чанга дуугаар хашхиран асуув. Тэгмэгц цохих балбах чимээ нам жим болов. Галсан бүр бухимдаж гүйцжээ. “Новш минь чи гараад ир. Чи хэн юм бэ?” хэмээн хэдэнтээ цөхрөн хашхирлаа. Таг чиг, дахин чимээ гарсангүй. Харин энэ үед Хэрлэн цочин сэрээд нөхрийнхөө хажууд яаран сандран иржээ. Галсан бүх болсон явдлыг хэлэхэд Хэрлэн түүнийг тайвшруулаад хамтдаа унтлагынхаа өрөөнд эргэж ирлээ. Энэ шөнө тэд хоёулаа унтаж чадсангүй. Үүр цайхын алдад охин нь мөн л зүүдэндээ ярьж ямар нэгэн зоорь, дотроос нь гарч ирэх гээд чадахгүй байгаа хэн нэгний тухай хойно урд нь оруулан зогсоо зайгүй шулганав. Эхнэр нөхөр хоёр охиноо тайвшруулах гэж багагүй сандралдсаар арай хийж үүр цайлгалаа.

## VI

Даваа гарагийн энэ өглөө Галсангийн гэрийнхэн хоорондоо юу ч ярьсангүй.

Уг нь өглөөний цай болгон дээр ямар нэгэн хөгжилтэй зүйлийн тухай ярилцаж инээлдэцгээдэг байсан бол энэ удаа ядаж хэн нэгнээс нь хоолойгоо засах чимээ ч гарсангүй. Саруул охин жаахан идэж уусан болоод хичээлийнхээ цүнхийг үүрэн яаран гарч одлоо. Шөнийн болсон явдал одоо болтол санаанаас нь гарахгүй байгаа Галсан охиндоо баяртай ч гэж хэлж чадсангүй. Удалгүй Галсан ч ажилдаа явахаар гэрээсээ гарахдаа эхнэртээ “Болгоомжтой байгаарай. Юмыг яаж мэдэхэв, зоорь луу битгий ойртоорой” гэж хэлээд гарч одлоо. Харин Хэрлэн ганцаархнаа шинэхэн орсон байшиндаа айдас түгшүүрээс өөр ханьгүй хоцрох нь тэр. Хөршүүдтэйгээ танилцах гэж оролдсон ч яагаад ч юм өөрөөс нь нэг л дөлж дуугарч ядаад болсонгүй. Хөршүүдтэйгээ танилцаж чадаагүйдээ Хэрлэн урам муутайхан гэртээ буцаж ороод дутуу цэгцэлсэн сав суулга, хувцас хунартай ноцолдлоо. Ингэж байхдаа ч

тэр Хэрлэн хөршүүдийн өөрийг нь огт тоохгүй, илэрхий зугтаж байсан нь бодогдож “Сүнс чөтгөр харсан амьтад шиг юун ч сүртэй юм бэ дээ” хэмээн өөрийн мэдэлгүй амандаа үглэв. Тэрээр дээд давхартаа гарч хураалттай хогшил хэрэгслээсээ ойр зуур хэрэглэх зүйл олдож мэдэх юм гэж бодоод ухаж гарав. Ухах тусам л улам сонирхолтой санагдаж бүр хэдэн цагаар суучихав. Гэтэл доод давхарт нь түжигнэх чимээ дуулдав. Охиноо ийм эрт хүрээд ирсэн юм болов уу хэмээн бууж ирсэн хэдий ч хэн ч байсангүй. Арай дахиад л өнөөх зоорийг чинь доороос нь нүдсэн хэрэг биш байгаа даа гэж бодоод хамаг бие нь жихүүцээд ирэв. Хэрлэн хоёр гартаа жижиг хогийн шүүр, хамуураа атгасан хэвээр байлаа. Гал тогооныхоо өрөөнд ортол өнөөх муу ёрын зоорь өөрийг нь хүлээгээд байж байгаа мэт Хэрлэнд эрхгүй санагдав.

Хэрлэн зоорь луу нэг хоёроор маш удаанаар алхан дөхлөө. Түүний зүрхний цохилт илт түргэсч гар нь үл мэдэг салгалж байгааг өөрөө тэрхэн агшинд анзаарсангүй бололтой. Хэрлэнгийн бүх анхаарао, оюун ухаан зоорины хаалган дээр төвлөрч өөрийн эрхгүй тийш дөхөх аж. Гэтэл энэ үед Хэрлэн өөрөөс нь гадна өөр хэн нэгэн тэр зоорины хаалгыг нүд салгалгүй ширтэж байгааг сая олж хараад давхийтэл цочих нь тэр. Галын өрөөний цонхны гадна талаас нэгэн үхдэл мэт цэлдэн хөх, цонхигор царайтай охин яг тэр Хэрлэнгийн дөхөж яваа зоорины хаалга руу нүд салгалгүй ширтэж байв. Тэрээр яг л Хэрлэнг зоорины дэргэд дөхөж очоод хаалгыг нь татаж онгойлгох тэр мөчийг тэсэн ядан хүлээж байх мэт. Эхэндээ зоорь луу дөхөж буй Хэрлэнд өөр зүйл рүү анхаарлаа хандуулах ямар ч сөхөө байгаагүй хэдий ч нүднийн нь буланд хэн нэгэн эрхгүй өртөхөд яалтчгүй цонх руугаа өндийн харсан нь энэ байлаа. Хэрлэн тэр этгээдийг хараад дуу алдан балмагдсан хэдий ч өнөөх охин харин Хэрлэн рүү огтхон ч харсангүй зөвхөн зоорь луу л тас гөлрөн ширтсээр. Одоо Хэрлэнд зоориноос илүү тэр охин аймшигтай санагдаж эхэлсэн бөгөөд тарж бутарсан ухаанаа цуглуулан байж охиныг тогтоон ажиглаад өнөөх Цэнгэл байхыг сая танилаа. Хэрлэн охины таниад “Чи энд юу хийж яваа юм бэ?” хэмээн асуусан хэдий ч Цэнгэл амьгүй мэт зоорь луу гөлөрсөн хэвээр. Бүр тэр охин хүний урманд ганц ч болов хөдөлгөөн хийгээгүйгээр барахгүй нүүрнийхээ арьсыг ч хөдөлгөсөнгүй. Хэрлэн өөрийг нь анхаарах сөхөөгүй байгаа охинтой гарч уулзахаар үүд рүүгээ яаран зүглэлээ.

Тэрээр аль хэдийнэ гадаа гарч өнөөх галын өрөөнийхөө цонхны дэргэд ирсэн ч дөнгөж сая зоорины хаалгыг ширтэн зогсож байсан Цэнгэл бараа сураггүй арилаад өгчээ. Хэрлэнгийн сэтгэл нэг мөсөн түгшлээ. Тэрээр эргэж гэртээ орохоосоо ч жийрхэж байлаа. Бас дандаа л бараа сураггүй алга болчихдог тэр охин яагаад энэ хавиар ингээд эргэлдээд байгаад ч гайхаж эхлэв. Эхлээд тэр Цэнгэл охиныг хашаанаас нь дөнгөж гарахад араас нь очиж харсан хэдий ч аль хэдийн алга болсон байсан. Харин одоо бас дахиад л урьдын адил Хэрлэнгийн нүдэнд нь огтхон ч өртөлгүйгээр ор мөргүй арилаад өгч. Бас тэр охин зоорины хаалга руу айхтар зэвүүн харцаар нүд салгалгүй ширтэж байсан нь Хэрлэнгийн санаанаас гарч өгөхгүй зовоох аж. Ингээд Хэрлэн охиноо хичээлээсээ удахгүй хүрээд ирэхээр нь хамт гэртээ оръё гэж шийдээд хүлээсэн ч 30 орчим минут болоход Саруул байдаггүй. Гэрийнхээ нимгэн хувцастай гадаа зогсож байгаа Хэрлэн эрхгүй даарч, яалт чгүй гэртээ орохоор үүд рүүгээ дөхлөө. Гэхдээ тэрээр галынхаа өрөө рүү ч харсангүй бараг нүдээ аних шахам чигээрээ гүйж унтлагынхаа өрөөнд оров. Түүний галын өрөө рүүгээ эргэж харалгүй гүйж орсон нь ч аргагүй биз. Түүрүүн дээд давхартаа байхад доороос дуулдсан тэр чимээг зоорин доороос гарсан болов уу гэж таамаглаж байсантай нь шууд холбоотой. Хэрлэн унтлагынхаа өрөөний хаалгыг дотроосоо түгжжээ. Ядаж байхан саяын цонхоор нь зоорь луу ширтэж байсан хувхай царайтай Цэнгэл

охины төрх санаанаас нь гарахгүй зовооно. Хэрлэн айсан сэтгэлээ тайвшруулахын тулд нөхөр лүүгээ ярья гэж бодлоо. Бүсгүй амьдралдаа айж үзээгүйгээрээ айж бүр нүдэнд нь нулимс гүйлгэнээд иржээ.

Хотын төвөөс алслагдсан гэр хорооллын айл учраас суурин утас тавиулах боломжгүй, зөвхөн гар утсаар л бусадтай холбоо барьдаг нь энэ удаа Хэрлэнд дэндүү хяслантай санагдаж байв. Халаасаа сандран тэмтчих нь гар утсаа хайсан хэрэг байлаа. Хараал идмэр... Түүний халаас хоосон байх бөгөөд тэрээр ийн дуу алдаад түрүүн галынхаа өрөө рүү орохдоо утсаа зоорины хажуугийн ширээн дээр орхисноо сая саналаа. Дөнгөж энэ бодолтой нь зэрэгцэн галын өрөөнөөс дахиад нэгэн бөглүү чимээ гарах шиг болов. Үүнийг сонссон гэртээ ганцаархнаа бүсгүй яах ёстойгоо үнэндээ л мэдсэнгүй. Нуруугаараа хаалгаа дарж суугаад чимээгүй нулимс дуслуулж эхэллээ. Магадгүй чанга цурхиран уйлж гэмээнэ өнөөх зоорин доор байгаа ад зэтгэрийн амьтан сонсоод гараад ирэх юм шиг л түүнд санагдаж байсан нь лавгай. Дахин чимээ гарсангүй. Арваад минут өнгөрөхөд Хэрлэн сая нэг жаахан тайвшрав. Одоо түүний бодолд зөвхөн охин нөхөр хоёр нь хурдан ирээсэй гэсэн бодол л эргэлдэх аж. Тэрээр ямар ч хөдөлгөөнгүй суусаар. Гэтэл гэнэт түүний гар утасных нь хонх жингэнэж эхэллээ. Энэ нь Хэрлэнд төдийлөн таатай санагдаагүйгээр үл барам жаахан тайвширч эхлээд байсан сэтгэлийн нь айдсыг дахин сэдрээх нь тэр. “Галсан байж мэдэх юм” Хэрлэнд төрсөн энэ бодол өөрийн эрхгүй харилцуураа авах хүслийг бадраагаад ирлээ. Гэхдээ өнөөх дуугараад байгаа гар утас зоорины хажууд байгаа шүү дээ. Аягүй бол өнөөх Цэнгэл дахиад л зоорь луу ширтээд зогсож байж мэднэ. Бүр магадгүй зоорин доор байгаа тэрхүү үл мэдэгдэх этгээд өөрийг нь энэ өрөөнөөс нь гаргаж ирэх гэсэндээ утасных нь хонхыг дуугаргаж байгаа ч юм билүү. Ингэсээр Хэрлэн баахан эргэлзэж цаг алдсан хэдий ч утас дуугарсаар....

## Ⅶ

Хэрлэн бүр хөшиж орхижээ. Айснаасаа болоод асгарсан нулимс нь доошл дусалж амжилгүй хацрыг нь исгэн тэндээ шингээ юу гэлтэй. Гэрт нам жим байх бөгөөд түрүүхэн жингэнэж байсан гар утасных нь хонх одоо бүр дуулдахаа больжээ. Хэрлэн хаалгаа налан суусан хэвээрээ л байв. Бүр босохоосоо ч айх шиг болж Галсан Саруул хоёрыг иртэл ингээд л энд суугаад байхаар шийдээд байлаа. Хэдэн цагаар ингэж сууснаа тэрээр өөрөө ч мэдсэнгүй. Нэг л мэдэхэд охиных нь гэртээ ирэх цаг аль хэдийн болоод бүр өнгөрсөн байлаа. Харанхуй болсныг Хэрлэн одоо л анзаарч байгаа бололтой өрөөнийхөө гэрлийг яаран асаалаа. Ингээд гэрэл ассанаар Хэрлэн жаахан тайвширч сэтгэлд нь хургасан айдас үргэв бололтой Хэрлэнгийн айсан сэтгэл нь одоо тайвширсан болохоор өнөө хүртэл ирээгүй байгаа охиндоо санаа зовж эхэллээ. Тэр аажуухан өндийв. Унтлагынхаа өрөөний хананд үүд рүүгээ харуулж тавьсан толинд өөрийнхөө нулимсанд халтардсан төрхийг хараад гэнэт инээд нь ч хүрэх шиг болов. Юу ч болоогүй байхад ямар ч утгагүй юмнаас айж бүр нулимс унагачихсан байх шив гэж Хэрлэн өөртөө дуулдах төдий хэллээ. Гэхдээ тэрээр магадгүй үүдэнд нь хэн нэгэн өөрийг нь хүлээж байна гэж бодсон уу ямартай ч унтлагынхаа өрөөний хаалгыг шууд нээхийг хүссэнгүй. Толины доор байрлах гурван шургуулгатай шүүгээний хамгийн дээд талын шургуулгыг аяархан татаад нойтон салфеткаар нүүрээ арчсан болов. Аль хэдийн 19 цаг өнгөрч байлаа. Хэрлэнд ядаж нөхөр охин хоёроо ирэхэд хоолоо бэлдсэн байх ёстой гэсэн үүрэгт бодол толгойд нь орж ирлээ. Ингээд тэрээр гүнзгий амьсгаа аваад хаалганыхаа түгжээг өөртөө их л эргэлзсэн байртай торхийтэл тайлж хаалгаа нээлээ. Хаалга чихран

дуугарч удаанаар нээгдэхэд магадгүй азаар Хэрлэнгийн нүдэнд хэн ч өртсөнгүй. Коридор гэж нэрлэж заншсан үүдний өрөөнийхөө гэрлийг мөн асааснаар гэр тэр чигтээ л гэрэл гэгээтэй болох шиг Хэрлэнд санагдав.

Одоо тэрээр галынхаа өрөө рүү орохдоо түрүүчийнх шигээ айхаа больжээ. Гэхдээ бодлын нь мухарт өнөөх амьгүй мэт гөлрөн зогссон Цэнгэл охин дахин цонхоор нь зорь луу ширтээд байж байх вий гэсэн айдас хургасан хэвээр. Гал тогооныхоо өрөөнд ормогцоо хаалганы хажууд байх унтраалгыг яаран дарж гэрэл асаалаа. Өрөөнд хэн ч байсангүй, бас цонхны цаана ч хэн нэгэн харагдсангүй. Зоорины хажууд байрлах хоолны том ширээн дээр тавьсан гар утсаа авлаа. Галсан түүн рүү хэд хэдэн удаа залгажээ. Нөхөр лүүгээ залгах гэснээ хэмнэж мессеж бичиж зогссон Хэрлэн өмнө нь галын өрөөнд дэвссэн байсан хивсийг хэрэггүй л хуйлав уу даа хэмээн бодох аж. Магадгүй хивсийг нь авсан болохоор зоорин доор янз бүрийн хулгана энэ тэр гүйлдэхэд тэр чимээ нь тод сонсогдоод байгаа биз гэж өөртөө хэллээ. Гэхдээ тэрээр ийм хүйтэн өвлийн улиралд хүйтэн зооринд ямар оготно байх билээ гэж бодсон ч энэ бодолдоо ач холбогдол өгөхийг хүссэнгүй.

“Охин одоо болтол ирдэггүй. Миний хөгшин ирэх дөхөж байна уу. Би ганцаараа жаахан айгаад байна” гэсэн Хэрлэнгийн мессежийг Галсан авчээ. Гадаа ийм орой болчихсон байхад Саруул одоо болтол гэртээ ирээгүй байгаа нь Галсангийн санааг эрхгүй зовоох нь тэр. Бас дээрээс нь Хэрлэнгийн жаахан айгаад байна гэсэн үг Галсанд нэг л ёозгүй санагдаж Хэрлэн рүү залгалаа.

-Байна уу. Хөгшин нь одоо ажил дээрээсээ гарлаа. Айх хэрэггүй ээ, намайг очтол зурагтаа асаагаад тайвшраад сууж бай? Би удахгүй за юу

-За. Гэхдээ Саруулыг одоо болтол ирэхгүй байгаад бүр санаа зовоод тогтож сууж ч чадахгүй нь, чи хурдан ирээрэй.

-За ойлголоо, удахгүй

Галсан ингэж хэлээд утсаа салган хийж байсан ажлаа дутуу орхин ажил дээрээсээ яаран гарлаа. Гадаа маш хүйтэн байх бөгөөд үе үе цасан шуурга шуурч, тэнгэр бүүдийн сааралтана. Галсан нэг л мэдэхэд гэрийн зүг такси барин хурдалж байв. Гэрлүүгээ нэлээд дөхөж ирээд машинаасаа бууж явган гүйлээ. Гэтэл яг түүний өмнөх зам дээр Саруул охин нуруугаа бөгтийлгөн алхаж явах нь тэр. Саруул аа хэмээн дуудтал охин зогтусав. Харанхуйд андуурсан байж мэдэх юм хэмээн бодож байсан Галсан охиныг зогсохоор Саруул мөн байна гэж баттай итгэн гүйж очлоо. Өвлийн пальтохоо малгайг өмссөн жаахан охин Галсангийн нүүрлүү толгойгоо өргөн харах үед тэрээр цочсондоо золтой л ухаан алдчихсангүй. Шөнийн харанхуйд ч тод ялгармаар зэвхий цагаан царайтай Цэнгэл охин Галсанг тас гөлрөн ширтсээр. Галсан юу ч хэлж чадахгүй ээрч байснаа Цэнгэлийг тойрон гэрийнхээ зүг гүйж одох нь тэр. Эргэж харахаасаа ч жийрхэн яаран гүйх Галсангийн чихэнд “Би дараа ирнэ гэж хэлсэн биздээ” гэсэн үг сонсогдох шиг. Гэртээ дөнгөж ортол гараа элгэндээ зөрүүлэн тэвэрсэн Хэрлэн санаа нь зовсон нүдээр нөхрөө угтлаа.

-Охин ирдэггүй би бүр санаа зовоод байж байна. Одоо яах вэ?

-Харин л дээ. Уг нь сая замд таарсан жаахан охин яг Саруул шиг харагдаад. Тэгтэл биш байдаг байгаа. Галсан ингэж хэлэхдээ Цэнгэлийн үүрч явсан цүнх, гадуур хувцас нь яг Саруулынхтай ижилхэн байсныг саналаа. Арай Саруулыг маань тэр үхээрийн царайтай охин... гэж бодсоноо хар эрчээрээ гүйж гарав. Хашааныхаа үүдэнд хальтарч унаад босохдоо Галсан хувцасаа ч гүвсэнгүй. Тэрээр саяын Цэнгэлтэй тааралдсан тэр харанхуй гудамж руу гүйсээр хүрч ирлээ. Эл хуль оргисон энэ бөглүү газар ямар ч хүн амьтан байсангүй. “Саруул аа миний охин хаана байна аа” хэмээн хашхирах Галсангийн дууг хэн ч сонссонгүй ээ. Галсан уруу царайлсаар шөнө дундын үед гэртээ ганцаараа иржээ. Саруул охин гэртээ ирээгүй байх бөгөөд Хэрлэн ч бүр цөхрөнгөө барж гүйцжээ. Охиныхоо очсон байж магадгүй гэсэн бүх газар луу утасдсан боловч хаана ч байсангүй. Охиндоо санаа зовсон эхнэр нөхөр хоёр шөнө цурам хийлгүй хоножээ. Өглөө болж нар мандахтай зэрэгцэн Галсан Саруулын сургууль руу охиныхоо сургийг гаргахаар яаран гарлаа. Хэрлэн хэдий хамт явахыг завдсан ч Галсан охин ирж магадгүй тэгвэл над руу утсаар ярьж хэл гэхэд үгэнд нь орж үлджээ. Галсан охиныхоо ангийн багш Ганцэцэгтэй уулзаж учир явдлаа ярихад охин нь өчигдөр хичээлдээ ирээгүй гэсэн хариу сонсчээ. Галсангийн сэтгэлийн түгшүүр шаналал бүр ч нэмэгдээд ирлээ. Өчигдөр өглөө охин нь гэрээсээ гараад сургууль руугаа очоогүй байх нь ээ. Ангийн нь сайн найз нөхөд байдаг болов уу гэж Галсанг асуухад Ганцэцэг “Анх шилжиж ирснээс хойш хэнтэй ч юу ч яриагүй ангийнхантайгаа дотносч арай амжаагүй байгаа” гэж хариулжээ. Галсангийн бүх горьдлого талаар болов. Галсан урамгүйхэн сургуулийн үүд рүү алхаж байснаа гэнэт нэгийг санав бололтой Ганцэцэг багш руу эргэж “Уучлаарай багш аа. Ингэхэд танай сургуулийн бага ангид Цэнгэл гэж охин сурдаггүй биз. Аавтайгаа хоёулхнаа амьдардаг байсан. Саяхны нэг өдөр гэр нь шатаад аав нь өөд болсон гэсэн” хэмээн асуулаа. Энэ үгийг сонссон Ганцэцэг багшийн царайд илт гайхсан төрх тодроод ирэв.

-Мэдэхгүй ээ. Тийм охин одоо байхгүй дээ

Галсан багшийн энэ хариултын “одоо” гэсэн үгийг онцолж сонссонгүй гарч оджээ. Тэрээр ажил төрлөө ч бүр умартаж орхиод зөвхөн охиноо гэр хүртэлх замаараа хаа сайгүй хайсаар ямар ч үр дүнд хүрсэнгүй. Өмнө нь хэзээ ч гэрээсээ гадуур ганцаараа хонож үзээгүй охиндоо ямар нэгэн муу юм тохиолдсон хэрэг биш байгаа даа хэмээн шаналан алхсаар нэг л мэдэхэд хашааныхаа өмнө тулж иржээ. Хэрлэн түүнийг хүлээгээд гэрийнхээ үүдэн дээр нөмгөн хувцастай зогсож байв. Тэд хоёулаа бие биесээ асуусан харцаар ширтэж байлаа. Өдөр болоод ирэх үест эхнэр нөхөр хоёр аргаа баран цагдаагийн газар очиж охиноо алга болсон хэмээн тэмдэглүүлээ. Газар дээрх ганц хайртай охин нь туйлын эрх танхи учраас яавч хэл чимээгүй гадуур тэнэж алга болохгүй гэдэгт тэдний хэн хэн нь бат итгэлтэй байв. Үдэш болжээ. Саруул бараа сураггүй хэвээр. Ядахад өвлийн улирал болохоор 17 цаг өнгөрөв үү үгүй юу гэгээ тасарчихаар охиноо харуулдсан эхнэр нөхөр хоёрын сэтгэл үгээр илэрхийлэхийн аргагүй хөндүүрлэж байлаа. Удалгүй шөнө болов. Тэд охиноо хүлээн ганц хором цурамхийгээгүй, хэлэн дээрээ юу ч тавиагүй болохоор аргагүй ядрав бололтой унтлагынхаа өрөөний орон дээр хоёулаа бүхлээрээ хэвтээд өгчээ. Шөнө дундын үед Галсан дахиад л гэнэт сэрлээ. Аргагүй ядарсан учир тэд нэг мэдэхнээ нам унтчихсан байжээ. Хэрлэн гадуур хувцастай тэр чигээрээ нөхрийнхөө хажууд нулимсандаа хавдсан нүдээ гараараа хагас дараад унтаж байлаа. Үүдэнд хөлийн чимээ гарах нь тэр. Охиноо ирсэн юм биш байгаа хэмээн баярласан Галсан Саруул аа, чи юу хэмээн аяархан дуудсаар үүднийхээ өрөөнд орж гэрэл асаатал хэн ч байсангүй. Байшингаасаа гарч хашааныхаа гэрлийг асаасан хэдий ч тэр том



хашааг нэлэнхүйд нь гэрэлтүүлж үнэхээр чадсангүй. Битүү цас даржээ. Энэ шөнө харин тогтуухан байх бөгөөд хашааны сүүмгэр гэрлийн тусгалд Галсангийн нүднээ модон жорлон өртлөө. Арай энэ жорлон дотор охин нь байгаа юм биш биз гэсэн бодол яагаад ч юм Галсанд төрөөд болсонгүй. Галсан үл мэдэг мөрөө хавчаад гараа өмднийхөө халаасанд хийж жорлонгийнхоо зүг алхлаа. Үнэхээр энэ модон жорлон руу дөхөх тусам Галсан нэг л зүрх алдаад байгаадаа өөрийгөө гайхаж байлаа. Ингээд тэрээр нэг мэдэхэд жорлонгийн хаалганы өмнө тулж иржээ.

Галсан хоолойгоо нэг сайн засаад хаалгыг нээтэл өнөөх Цэнгэл охин Галсанг хүлээж байсан юм шиг өөдөөс нь хүйт даасан харцаар ширтэн зогсоно.

-Чи охиноо хайж байна уу?

-Хараал ид гэж. Чи энд юу хийж байгаа юм. Миний охин яасан, Саруул хаана байна?

Галсанг ингэж асууж дуусаагүй байтал шавар шавхайд хутгалдсан болов уу гэмээр сурагчийн дүрэмт хувцастай жаахан охин хажуугаар нь гараад гүйчихэв. Цэнгэл хашааны хаалгаар гарч одлоо. Галсан араас нь хөөж барих гэснээ болиод гэнэт зогтусах нь тэр. Учир нь Цэнгэлийн гүйж одсон цасан дээр хэн ч гишгэсэн дурайсан тод хөлийн мөр гарах ёстой биш үү. Гэтэл Цэнгэл охины гүйж одсон тэр битүү цас бүрхсэн зам дээр мөр гээд оноогоод хэлчихээр юм үнэндээ л байсангүй. Гайхаш тасарсан Галсан өөрөө цасан дээр гишгэж үзэх нь энэ цасан дээр гишгэсэн хүний хөлийн мөр гарч байгаа эсэхийг нягталж байгаа мэт. Галсан гал тогооныхоо өрөөнд ороод тамхи асааж бодол болон суулаа. Цэнгэл анх Саруулыг дагаж ирэхдээ яг л саяын өмссөн шавар шавхай болсон дүрэмт хувцастайгаа байсан нь тодхон санагдаж байв. Галсан саяын болсон явдлаас үүдэн энэ хувхай царайтай жаахан охин яавч амьд хүн биш гэсэн дүгнэлтэнд хүрээд байлаа. Анх энэ үхээрийн цонхигор царайтай охин яаж яваад Саруултай танилцсан тухай ч өмнө нь охиноосоо асууж байгаагүйдээ Галсан одоо харамсаад барахгүй байх аж. Бас тэгээд сая тэр Цэнгэл “Охиноо хайж байна уу?” гэж асуусныг нь эргээд бодохоор нэг л зэвүүн санагдаад болсонгүй. Саруулыг гэртээ ирээгүйг тэр амьд үхсэн нь мэдэгдэхгүй Цэнгэл охин сайн мэдэж байгаа байх нь. Галсан ийнхүү гайхаш тасран шаналсаар нэг мэдэхнээ ширээгээ дрэлэн зүүрмэглэж орхижээ. Нэг цаг орчим л өнгөрсөн болов уу. Тэрээр ямар нэгэн юм түжигнэх чимээнээр гэнэт сэрлээ. Өнөөх Цэнгэл охин аль хэдийнэ галынх нь өрөөнд ороод ирчихсэн зоорины хаалгыг нээх гэж хар тэнхээгээрээ хүчилж байх нь тэр. Галсан нүдэндээ ч итгэсэнгүй. Харин Галсанг сэрснийг мэдсэн Цэнгэл даруйхан гарч одлоо.

## VIII

... Галсан яахаа ч мэдэхгүй дэмий л зоорины хаалгыг тас гөлрөн суусаар өглөө болгожээ. Ар араасаа учир нь үл ойлгогдох зүйлүүд болсоор эцэст нь охин нь ор сураггүй алга болсонд Галсан цочирдож ухаан нь балартав бололтой. Галсан эхнэртэйгээ юу ч ярьсангүй. Харин чимээгүй гөлрөн суусаар байснаа өдөр болонгуут юмаа мартсан хүн шиг гэнэт хэл чимээгүй гарч одлоо. Саруул сураг чимээгүй хэвээр. Уг нь Хэрлэн нөхөртэйгээ ярилцаж өчигдрийн Цэнгэлийн цонхны цаанаас зоорины хаалга руу цоо ширтэж байсан тухай хэлэхийг оролдсон ч охиндоо санаа нь зовоод хүнээс үг сонсохтой манатай болсон Галсан эхнэрээ ойшоогоогүй аж. Хэрлэн гэртээ ганцаараа охиноо, бас хаашаа явсан нь мэдэгдэхгүй нөхрөө хүлээхийн

хажуугаар өчигдрийн болсон явдал санаанд нь орж сэтгэлдээ жихүүцэж байлаа. Энэ байдалтайгаа удаан эвлэрч чадаагүй Хэрлэн гадуур хувцасаа өмсч гэрээ цоожлоод автобусны буудлын хажуугийн дэлгүүрт ороод зогсчихов. Юу ч худалдаж авахгүй хирнээ зүгээр л цонх руу ширтэн зогсох үл таних бүсгүйг дэлгүүрийн худалдагч ад үзэж байгаа нь андашгүй байлаа. Хэрлэн уг нь энэ байдлыг нь тоохгүй дэлгүүрт зогсоод байж чадах байсан хэдий ч охиноо гэртээ ирж мэдэх юм гэж санаад гараад гүйчихэв. Саруул өөртөө нэг түлхүүртэй учраас хүн байхгүй байсан ч хамаагүй гэртээ ороод ганцаараа айж эмээх вий гэсэн бодол Хэрлэнг түргэн алхахад нь эрхгүй нөлөөлөв бололтой. Хэрлэн гэртээ иржээ. Гэрт хүн ирсэн болов уу гэх ямар ч шинж тэмдэг алга. Саруул ирээгүй байлаа. Охиноо ирээгүйд эхийн сэтгэл хямарч урам нь хугарчээ. Уг нь сая гэр лүүгээ бараг л гүйх шахам явж ирэхдээ үнэхээр охиноо ирчихээд ээжийгээ хүлээж байгаа юм шиг л санаж байсансан.

Охиндоо зовсон эхийн сэтгэл одоо юунаас ч айхаа больсон бололтой. Хэрлэн галынхаа өрөөнд орж гал түлж эхэллээ. Магадгүй охиноо жигтэйхэн их даарчихсан ирэх байх, ирэхэд нь ядаж гэрийг нь дулаахан байлгахсан гэсэн сэтгэл нь түүнийг ийм үйлдэл хийхэд хүргэжээ. Шавар пийшинд шад пад хийн асах гал руу ширтэн бодол болон суух Хэрлэнгийн нүдэнд охиндоо санаа зовсных нь илрэл болсон нулимс мэлтгэнэж байлаа. Оройхон Галсан том биетэй монгол банхар нохой хүзүүнээс нь хөтөлсөөр гэртээ ирлээ. Уг нохой бол энэ байшинд нүүж ирэхээсээ өмнө хуучин хашаагаа мануулдан байсан нохой нь билээ. Шинэ газарт нүүж ирэх гээд түр хугацаанд хуучин хөрш айлдаа орхиод одоо ийн авчирч байгаа ажээ. Харин Хэрлэн нохойгоо айлд орхисноо түр мартагнаад байсан бөгөөд Банхарыгаа хараад жаахан ч гэсэн баярлав. Галсан Хэрлэн хоёр хоорндоо ямар ч үг сольж зөвлөлдөлгүйгээр нохойгоо шууд галынхаа өрөөнд орууллаа. Энэ нь магадгүй өнөөх зоорьтой холбоотой байсан биз. Үнэндээ энэ байшинд дахин нэг хононо гэхээс тэдний хэн хэний нь яс хавтайх шиг болж байсан ч охиноо энд хүрээд ирнэ гэсэн бодол нь байшинд аргагүй уяж байлаа. Галсангийн гэр нь хүйт даагаад нэг л зэврүүн. Охиндоо санаа зовнисон эцэг эхийн сэтгэлийг нохой нь хүртэл ойлгосон бололтой пийшингийн хажууд эвхрэн хөлөө дэрлэн гунигтай хэвгэнэ. Галсан Хэрлэн хоёр ээлж ээлжээр очоод л нохойгоо эрхлүүлэхэд нь Банхар үүнийг нь хүлээж байсан юм шиг хүзүүгээ сунгаж өгөх нь ингэж эрхэлсээр байгаад сурчихсныг нь илтгэх аж. Тэд ийнхүү юу хийхээ мэдэхгүй дэмий л охиноо хүлээн шаналж гадаа гарч харуулдсаар нэг л мэдэхэд харуй бүрий болжээ. Эхнэр нөхөр хоёр жаахан хуурай идэх юм идэж цай уужээ. Тэд унтлагынхаа өрөөнд орохын өмнө Банхарыгаа сайн хооллож аваад гал тогооныхоо өрөөнд үлдээлээ. Хэдий шөнө болсон ч эхнэр нөхөр хоёрын хэн хэнийх нь нойр хүрэхгүй сэрвэлзэх аж. Унтлагын өрөөний том ханын цаг чаг хийн дуугарах нь энэ гэрт чимээ гаргадаг цорын ганц эд мэт. Гэхдээ энэ цагны дуу бага ч атугай тайвшралыг илтгэх биш, харин ч ямар нэгэн санаанд оромгүй айдас түгшүүр ирж явааг Галсанд анхааруулж байгаа мэт үргэлжлүүлэн цохилсоор. Галсан дагзаа салаавчлан орон дээрээ бөгтийн сууна. Ийнхүү унтлагынхаа өрөөний орон дээр зэрэгцэн суух эхнэр нөхөр хоёр цаг орчим амнаасаа ганц ч үг унагахгүй байснаа Хэрлэн сая ам нээлээ.

-Өчигдөр чамайг ажилдаа явсан хойгуур өнөөх Цэнгэл ирээд явсан. Яагаав манай Саруулыг дагаж ирдэг охин

Эхнэрийн нь хэлсэн энэ үг Галсангийн анхаарлыг эрхгүй татаж толгойгоо өндийлгөн “Тэгээд?” гэж асуув. Хэрлэн сандарч буй бололтой хуруугаараа оролдож байснаа гүнзгий

амьсгаа авч цааш үргэлжлүүлэн ярилаа.

-Би чамайг явсан хойгуур хэдий өдөр байсан ч жаахан айгаад дэмий байхаар хөршүүдтэйгээ танилцаж гэртээ урьж оруулья гэж бодсон юм. Тэгтэл харин “Манайд ор” гэж хэлэхийг минь сонсоод баярлах нь битгий хэл гэрийнхээ хаалгыг тас хийтэл саваад надтай ганц ч үг сольсонгүй. За яахав, их л ааш муутай хөрштэй болждээ гэж бодоод гэртээ орж ирээд дээд давхартаа новшоо цэгцэлж байлаа. Гэтэл доор ямар нэгэн юм түжигнэх чимээ гарсан. Хэн нэгэн магадгүй Саруулыг овоо эртхэн ирсэн юм болов уу гэж бодоод буугаад хартал хэн ч байхгүй байсан. Арай дахиад л нөгөө зоориноос гарсан чимээ биш байгаа даа гэж бодоод галынхаа өрөөнд ортол өнөөх Цэнгэл гэдэг охин чинь цонхны цаанаас зоорь луу гөлийчихсэн харж байдаг байгаа. Би маш их айсан. Бүр хамгийн аймшигтай нь тэр охин намайг огтхон ч анзаарахгүй яр л үхээд хөшчихсэн хүн шиг зоорь луу ширтээд л байлаа. Би жаахан сэхээ аваад юу хийж явааг нь асуухаар гараад хартал байхгүй болчихсон байсан. Би яахаа ч мэдэхгүй гэртээ ганцаараа охин та хоёрыг хүлээсээр орой чам руу мессеж бичсэн нь тэр.

-...Цэнгэл гэнэ ээ? Тэр муу үхээрийн охин юу шиншилж яваа юм бол?

Галсан ингэж хэлээд чимээгүй боллоо. Хэрлэн саяын үгийг нөхөртөө хэлэхдээ дахин айдаст автаж Галсангаас эрхгүй тайвшруулсан, аргадуулсан ямар нэгэн дулаахан үг сонсохыг хүссэн ч Галсан ойлгосонгүй. Тэрбээр эхнэрээ тайвшруулах ч сөхөөгүй өөрөө айдаст автсан бололтой. Охиндоо санаа зовохын хажуугаар тэр Цэнгэл гэдэг охины тухай учир нь үл ойлгогдох бөөн асуултууд Галсангийн толгойд эргэлдэж байлаа. Гэрт дахиад л чимээ аниргүй болжээ. Өнөөх цагний чаг чаг хийн цохилох дуун адын муу ёрын зүйл болох цаг мөч улам ойртож буйг эхнэр нөхөр хоёрт сануулж ядан байх мэт. Ханын цаг ийнхүү цохилох чимээний хажуугаар үе үе нэгэн содон чимээ сонсогдох нь Галсангийн шүдээ хавирах дуу байлаа. Хэрлэн нөхрийнхөө шүдээ хавирч байгааг анзаарсан ч гүй магад сонирхсон чгүй бололтой. Хэрвээ Галсанг шүдээ хавирахад нь Хэрлэн нөхөр лүүгээ харсан бол нэгэнт хуралдаад байсан айдас нь бүр ч нэмэгдэх байсан биз. Учир нь Галсан яг л амьд үлдэх боломжгүй болоод эцсийн хүчээ шавхан дайсантайгаа тэмцэх гэж байгаа араатны нүдээр шал руу ширтэж байжээ. Охиноо өнөөг хэр нь ирэхгүй байгаа энэ үед Галсан чухам яах ёстойгоо ердөө мэдэхгүй байлаа. Тэрээр барьц алдан айдаст автсан ч хайртай эхнэр охин хоёрт нь ямар нэгэн муу юм болвол эцсээ хүртэл хамгаалан тэмцэх болно гэх бодолтойгоо зэрэгцэн шүдээ хавирах аж. Галсан ингэхдээ чухам хэнийг занаад байгаагаа ч өөрөө ойлгосонгүй. Ямартай ч хэн нэгэн этгээд гэр бүлд нь муу юм хийхээр бүр улайраад байх шиг санагдаж тэр үл үзэгдэгч этгээд чөтгөр, шулам, ороолон ер нь юу байсан ч хамаагүй түүнтэй нэгийгээ үзэхсэн гэсэн бодол Галсанг байж ядуулна.

Гэнэт л галын өрөөнд нохой нь хуцаж архиран бөөн үймээн болох нь тэр. Галсан ч яг л энэ мөчийг хүлээж байсан юм шиг галын өрөө рүүгээ хэдхэн харайгаад орлоо. Хэрлэн ч нөхрөөсөө хоцролгүй араас нь даган яаран ирэв. Нохой нь улаан галзуу зоорины хаалга руу хуцаж тойрч эргэлдэх аж. Үнэндээ тэр зоорь луу хуцах ямар шалтгаан байгааг эхнэр нөхөр хоёр хоёулаа сайн ойлгосонгүй. Тэд нохойгоо арайхийн тайвшруулжээ.

Энэ үйл явдал яг л Галсангийн таамаглаж байсан шиг болсон ч нохой арай л хурдан ид шидээ үзүүлэх шиг санагдаж байв. Энэ шөнөжингөө Галсан нохойтойгоо хамт өнөөх зоорийг

харуулдаж үүр цайлгасан ч ямар нэгэн чимээ дуулдсангүй. Өвлийн сүүмгэр наран тэнгэрт хөөрсөн нь энэ жихүүн зэврүүн хорвоог бүлээцүүлэхээс нэгэнт өнгөрөө юу гэлтэй. Галсан Хэрлэн хоёр галынхаа өрөөний ширээг дэрлэн сандал дээрээ суугаагаараа унтжээ. Хэрлэн нөхрөөсөө түрүүлж сэрлээ. Гэр нь хүйт даагаад нэг л зэврүүн. Нохой нь өнөөх зоорины хаалгыг дээрээс нь дарж цагираглаад хэвтсэн байх бөгөөд үүнийг харсан Хэрлэн баярлах ч шиг болов. Банхар нь ингээд л зоорины хаалган дээр хэвтээд байвал магадгүй дор нь байгаа ад зэтгэрийн амьтан гарч ирж чадахгүй юм шиг түүнд санагдана. Хүнийг ойр дотныхон нь орхиод явсан ч нохой л эзэндээ үнэнч хэвээр хамт үлддэг гэсэн хэзээ ч юм бэ дээ хаа нэгтээ сонсож байсан яриа Хэрлэнгийн санаанд орохтой зэрэгцэн Банхарынхаа хүзүүг илж эрхлүүлээд өрөөнөөс гарлаа. Эхийн сэтгэл горьдлого гэдэг хэзээ ч тасардаггүйг энэ удаа Хэрлэн ч бас харуулав. Магадгүй охиноо хүрээд ирсэн ч юм билүү гэж горьдсон тэрээр Саруулын өрөө рүү орж хоосон байхыг нь хараад сэтгэл нь бүр гонсойчихлоо. Саруулын удахгүй болох төрсөн өдрөөрөө өмсөнө гэж бэлдэж байсан гоёлын хувцас нь орон дээр нь эзнээ хүлээн гунигт автан хэвгэх мэт. Хэрлэн орон дээр суух биш уначихав. Охиныхоо дэрийг үнэрлэн суух эхийн хацрыг доголлон нулимс исгэн доошилж байлаа. Тэгтэл гэнэт галын өрөөнд тар няр хийх чимээ гарч нохой нь хуцах нь тэр. Хэрлэнгийн сэтгэлд дахин бөөн айдас түгшүүр хуралдаж нөхрийнхөө байгаа өрөө рүү яаран гүйж орлоо. Дахиад л өнөөх зоорь ... хэмээн бодсон Хэрлэн нөхрийнхөө сандлаас унасныг хараад санаа нь зовох биш харин ч баярлав бололтой. Галсан сая сэхээ аван босч ирээд “Хөгшин чинь бүр айхтар хар дарж зүүдлээд сандлаасаа хүртэл унадаг байна шүү” гэж хошигнохыг хичээсэн ч түүний нүүрэнд айж түгшсэн төрх тодхон харагдаж байгааг Хэрлэн анзаарчээ.

-Миний хөгшин тэгээд яг юу гэж хар дарж зүүдлэв дээ?

-Заавал сонсохыг хүсээд байгаа юм уу?

-Ярь л даа, сонсмоор байна

-Өмнө нь хэзээ ч ийм муу ёрын зүүд зүүдэлж байсангүй. Энэ хараал идсэн зоорин доороос Саруулын аврал эрэн уйлах чимээ сонсогдох шиг болоод... Галсан ингэж хэлээд түгдрээд ирэв. Түүний сэтгэл айдас түгшүүрээр дүүрэн оволзож байгаа бололтой харц нь тогтохгүй ийш тийш үсчих аж. Нөхрийнхөө энэ хэлснийг сонссон Хэрлэнгийн дотор харанхуйлаад ирлээ. Тэрээр нэг л мэдэхэд өнөөг хэр нь Банхарын дээр нь хэвтэж байгаа зоорин дээр харц нь тусчээ. Галсан яриагаа үргэлжлүүлээ.

-Саруул аав аа гээд л уйлаад байсан. Би энэ зоорины хаалгыг нээхийг үнэхээр хүсэхгүй байсан ч хаалгыг нь нээх гэж оролдож эхэлсэн. Зоорины хаалгыг хариугүй нээх гэж байтал хэн нэгэн хүн наадахаа битгий нээ, тэгвэл муу юм болно шүү гэж араас шивнээд байсан. Би тоолгүй зоорин доор бүр гүнд нь охинд минь ямар нэгэн муу юм тохиолдож байгаа юм шиг санагдаад хурдхан хойноос нь орохын тулд хаалгыг нээсэн.

-Тэгсэн чинь? Хэрлэнгийн ингэж хэлсэн үг нь дуулах төдий сонсогдож байлаа. Хэрлэн нөхөр лүүгээ биш зоорь луу цөхөрсөн нүдээр харж уйлж байлаа. Харин Галсан эхнэрийнхээ энэ байдлыг ч сайн анзаараагүй бололтой. Түүний оюун ухаан зөвхөн саяын зүүдэлсэн муу ёрын зүүдээ нэгд нэгэнгүй санахад чиглэгдэж байх шиг. Галсан яриагаа цааш үргэлжлүүлээ.

-Тийм ээ, намайг зоорины хаалгыг нээхэд өөдөөс уур савсаж байсан хэрнээ тэр нь их хүйтэн байсан. Маш хүйтэн агаар өөдөөс үлээгээд л... Зоорь маш гүнзгий эгц байсан ч би доошоо ямар ч шат тавилгүйгээр буух гэж үзсэн. Гэтэл өөдөөс үгээр тийм гээд илэрхийлэхийн аргагүй муухай амьтан зоорины ханыг дагаад л авираад ирсэн. Түүний бие түлэгдчихээ юу гэлтэй улаан эрээн шарх сорвиор дүүрэн, зарим арьс нь бүр зумарчихсан, үс гээд байхаар юм үлдээгүй эрэгтэй хүн байсан. Шууд л хүн гээд оноогоод хэлэхэд хэцүү ч яалт чгүй л дөрвөн мөчтэй зэвүүн, зэвхий онигордуу харцтай этгээд байсан. Галсан ингэж хэлээд түр амсхийж гүнзгий амьсгаа аваад эхнэрээ тэвэрлээ. Хэрлэн нөхрөө тэврэн эхэр татан уйлж буй хэрнээ зоориноос нүд салгахгүй ширтсэн хэвээр байлаа. Галсан одоо түрүүний айдаст автсан зүүднээсээ бага багаар ангижирч бодит амьдралаа илүү мэдрэх шиг болж ирэв. Тэрээр саяынхаа муу ёрын зүүдээ эхнэртээ хэрэггүй л хэллээ гэж өөрийгөө зүхэж байлаа. Тэд хэсэг чимээгүй тэврэлдэн зогсов. Хэрлэн нөхрөөсөө “Тэгээд дараа нь юу болсон бэ?” гэж тэсгэлгүй асуухад түүний дууны өнгөнд илт сандарсан бас айсан байдал тодхон илэрч байгааг Галсан анзаарчээ. Тэрээр зүүднийхээ төгсгөлд чухам юу үзсэнээ эхнэртээ хэлэхээс эргэлзэж эхлэв. Магадгүй дараа нь ямар зүйл болсон тухай Хэрлэнд хэлбэл сэтгэлийг нь бүр ч их түгшээчих болов уу гэж бодохоос Галсан аман дээрээ гарч ирсэн үгээ буцааж залгих аж. Хэрлэн дахин дахин гуйж гувшисны эцэст Галсан зүүдээ үргэлжлүүлэн ярилаа.

## IX

-Тэр аймшгийн амьтан надруу бүр дөхөж ирээд ямар ч чимээ анир гаргалгүй намайг гараараа татаад доош нь унагахыг оролдсон. Би хичнээн хичээгээд ч дийлэхгүй доошоо унангаа алдаж өнөөх амьтныг өөрийг нь доошоо унагахаар оролдож байлаа. Тэр аймшгийн ад зэтгэрийн амьтан нэг гараараа зоорины ирмэгээс барьж нөгөө гараараа миний бугуйнаас атгаад доошоо чангаагаад л. Хамгийн хирдхиймээр нь тэр гар нь цэв хүйтэн байсан. Би хөлөөрөө мөр лүү нь жийгээд яг тавиулахын даваан дээр Саруул “Аав аа, намайг битгий унагаач дээ, доор их хүйтэн байгаа, би айж байна” гэж хэлсэн. Гэтэл өнөөх түлэгдчихсэн юм шиг аймаар этгээд биш охин маань миний гараас чаргууцалдаж байлаа. Яг л бодит амьдрал дээр болж байгаа юм шиг тийм их үнэмшилтэй санагдсан. Даанч охиноо татаж авах гэхэд дэндүү хоцорсон байлаа. Саруул доошоо унаж би хам хум ханцуйнаас нь шүүрээд л алдсан. Тэгээд гэнэт цочоод сэрсэн. Гэхдээ энэ бол зөвхөн зүүд шүү. Миний хайрт битгий сэтгэлээ зовоогоорой.

-Тийм ээ, зүүд. Гэхдээ дэндүү муу ёрын, аймар зүүд байна

Хэрлэн ингэж хэлээд гүнзгий амьсгаа авлаа. Тэд хоёулаа жаахан тайвширъя гэж ярилцаад хоол иддэг ширээнийхээ ард зэрэгцэн суугаад худгаас авсан хүйтэн ус уулаа. Уг нь халуун цай уухыг хэн хэн нь хүсч байсан ч халуун саванд хийсэн сүүтэй цай нь аль хэдийнэ гашилжээ. Эхнэр нөхөр хоёр хоёулаа дагжин чичирч байлаа. Сүүлийн үед охиндоо санаа нь зовоод гэрээ ч олигтой галлаагүй болохоор гэр нь яг л мөсөн хонгил гэлтэй. Галсан Хэрлэн хоёр бүр голдоо ортол даарчээ. Банхар ч гэсэн ялгаа алга. Ямар ч идэвхгүй хамаг биеэ хураан хэвтэх нь жаахан ч гэсэн дулаацахыг эрхгүй хүсэж байгаа мэт. Галсан бээрсэн гараараа арайхийж шүдэнз зурж пийшиндээ гал ноцоож эхэллээ. Удалгүй гэр нь бүлээцэж Хэрлэн тогоон дээр цай үйлээ. Зоорины хаалган дээр биеэ хураан хэвтэх Банхар ч гэсэн дулаацав бололтой нэг сайн суниаж аваад нааш цааш холхиж эхлэв. Удсан ч үгүй цай буцалжээ. Гал тогооны өрөөний ширээн дээр зэрэгцэн сууж халуун цай оочлох эхнэр нөхөр 2 хоорондоо ганц ч үг

сольсонгүй. Галсан үе үе зоорь луу хяламхийх нь үнэхээр Саруул энэ дор байгаа юм биш биз гэж бодсоных биз. Харин Хэрлэн нөхрийнхөө энэ бодлыг тааварласан бололтой. Хэрлэн аргагүй л Галсангийн арав гаран жил ханилсан хань нь юм болохоор Галсангийн чухам юу бодож байгааг бараг л харцаар нь уншдаг болсон гэхэд хилсдэхгүй. Ингээд Хэрлэн цай оочохоос өөр чимээгүй нам гүмийг эвдэн түрүүлж ам нээлээ.

-Галсаан, чи зоорь луу ганцаараа орно гэж санасны хэрэггүй шүү. Энэ бол зүгээр л чиний зүүд. Хэрвээ манай охин зоорин дотор ямар нэгэн санаанд оромгүй байдлаар орсон байлаа гэхэд ямартай ч зоорины бэхэлгээ тайлагдсан байх ёстой шүү дээ. Саруул маань зүгээр л хотын хаа нэгтээ байгаа. Удахгүй гэртээ ирнэ, үүнд итгэх хэрэгтэй, тийм биздээ.

Эхнэрийнхээ ингэж хэлэхийг сонссон Галсан хэсэг чимээгүй сууснаа чиний зөв гэж хэллээ. Үнэндээ Галсанд зоорийг нээгээд доошоо ороод үздэг ч юм билүү гэсэн бодол төрсөөр л байв. Энэ зоорийг нээгээд охиноо олж чадахгүй байсан ч ингэж гэмээнэ ямар нэгэн зүйлийн нууцыг тайлах юм шиг Галсанд санагдах аж. Гэхдээ энэ бодолтой нь зэрэгцэн өнөөх түлэгдсэн хэрнээ цэв хүйтэн биетэй аймшгийн этгээд санаанд нь орж сэтгэлийг нь тавгүйтүүлж өөрийн эрхгүй зүрх алдахад хүргэж байв. Галсан хэдийгээр зүүдэндээ охиноо аварч чадаагүй ч энэ нь яг л бодит амьдрал дээр болоод өнгөрсөн юм шиг санагдаж үе үе гүнзгий санаа алдахад хүргэж байлаа. Галсан тайвшрах санаатай гараа халаасандаа хийж тамхи хайлаа. Уг нь Галсан нэг их тамхи татаад байдаггүй ч хаа нэг сорохоосоо татгалздаггүй нэгэн. Ялангуяа сүүлийн үед сэтгэл нь жаахан тавгүйтээд ирэхээр заавал тамхи асаадаг зуршилтай болоод байгаа. Галсан халааснаасаа тамхиа олсонгүй. Уг нь хэд хоногийн өмнө хайрцаг янжуур худалдан авсан санагдаж байсан ч түүнийгээ эрээд олсонгүй. Харин оронд нь нэгэн жижигхэн хуванцар эд олов. Яг чухам юу болохыг нь таах санаатай гараараа тэмтэрч үзэхэд товч бололтой. Галсан түүнийг нь гаргаж ирээд харлаа. Цамцных болов уу гэмээр ягаан өнгөтэй хуванцар товч аж. Гэхдээ энэ товч чухам хэзээ яагаад өөрийн нь халаас руу орчихсныг Галсан бодоод олсонгүй. Бас хэний юуных нь товч болохыг ч шууд оноогоод нэрлэж чадсангүй.

-Энэ одоо юун товч байдаг билээ? Хэмээн Галсан эхнэртээ өнөөх товчийг үзүүлэн асуув. Хэрлэн юу ч бодсонгүй өнөөх товчийг гартаа барьж үзээд сонирхож байснаа сууж байсан сандал дээрээсээ огло үсрэн босоод ирэв.

-Хэрлээн, миний хөгшин яав? Хэмээн Галсан сандран асуув

-Саруулын цамцны товч. Яг мөн байна. Саруулын хамгийн сүүлд хичээлдээ явахдаа өмссөн ноосон цамцны товч мөн байна. Хэрлэн ингэж хэлээд хоолой нь зангираад ирлээ. Галсан одоо чухам яах ёстойгоо үл мэдэн самгардан зогсоно. Хэрлэн яриагаа цааш үргэлжлүүллээ.

-Энэ яалт чгүй манай Саруулын цамцны ханцуйных нь товч мөн байна. Чи яахаараа энэ товчийг халаасандаа хийчихээд явж байдаг билээ. Хэзээ яаж хаанаас авсан юм бэ? Хэмээн Хэрлэн одоо болтол яахаа мэдэхгүй гайхан зогсож байгаа нөхөр лүүгээ давшлан асуултаар булж гарлаа.

-Мэдэхгүй ээ, ямар ч байсан миний халаасанд л байж байна. Галсан ингэж хэлээд гэнэт нэгийг санав бололтой царай нь хувираад ирлээ. Тийм ээ, түрүүний зүүд. Галсан энэ үгийг дуулдах төдий шивнэв. Гүнзгий харанхуй зоорь луу унах охиныхоо гараас амжиж атгаж

чадалгүй цамцных нь ханцуйнаас зуураад алдсан тэр дүр зураг Галсангийн нүдний өмнө дахин тодрон үзэгдэх шиг болов.

Галсан ингэж бодоод Хэрлэнтэй юу ч ярьсангүй дуугаа хураагаад зоорь луу гөлрөн суулаа. Яалт ч үгүй л охиных нь хамгийн сүүлд гэрээсээ явахдаа өмссөн цамцных нь товч халаасанд нь байж байдаг. Гэтэл энэ товчийг Саруулын цамцнаас хэзээ авсан байж таарах билээ. Лав Саруулыг хичээлдээ явахад нь би гэртээ ч байгаагүй шүү дээ. Тэгээд бас саяын болсон явдал зүгээр л зүүд. Галсан ингэж бодсоор хямарч орхижээ.

Хэрлэн Галсан руу асуусан харцаар харж байсан ч Галсанд эхнэртэйгээ ярилцах сөхөө ч байсангүй. Галсан ийн бодол болсоор өнөөх Саруулын цацны товчтой холбоотой бодлынхоо хариуг олж дөнгөсөнгүй. Тэрээр эхнэртэйгээ ч ярихгүй байсаар бүр өдөр өнгөрч байхад “Саруулын цамцны товч яагаад миний халаасанд орсныг ойлгохгүй байна” гэсэн ганцхан өгүүлбэрээр Хэрлэнгийн амыг таглажээ.

\* \* \*

Саруул бараа сураггүй хэвээр. Энэ янзаараа дахин дөрөв хоног өнгөрөхөд байдал огтхон ч өөрчлөгдсөнгүй. Гагцхүү охиндоо сэтгэл зовних эцэг эхийн сэтгэл улам бүр харанхуйлж итгэл найдвар нь бага багаар бөхсөөр байлаа. Банхар шөнө хааяа нэг ямар нэгэн зүйл рүү боргон хуцаж бөөн чимээ шуугиан болох хэдий ч сэжигтэй юм юу ч олдсонгүй. Бас Галсан зоорио нээх үү яах вэ гэж эргэлзэн бодсоор өнөөдрийг хүрчээ. Магадгүй Галсан охиноо хүрээд ирэх ч юм билүү хэмээн горьдон итгэж найдаж байсантай нь ч зоорийг нээхээсээ түдгэлзсэн нь холбоотой байсан биз. Мэдээж Саруул гэртээ эсэн мэлн хүрээд ирж гэмээнэ Галсанд энэ муу ёр шүглэсэн зоорийг нээх ямар ч шаардлага байхгүй нь тодорхой байсан билээ. Бас Галсан тэр Цэнгэл гэдэг хүн, чөтгөрийн аль нь болох үл мэдэгдэх охины сургийг гаргах гэж хирэндээ хичээсэн боловч ямар ч үр дүнд хүрээгүй билээ.

Х

Хүйт даасан гэртээ охиноо үгүйлэн бэтгэрэн суух эцэг эх хоёр Мягмар гарагийн энэ өглөө охиныхоо сургийг хаанаас гаргаж болох талаар ярилцан хашаандаа зогсож байлаа. Тэгтэл Галсангийн нэгэн зочин ирсэн нь Саруулын ангийн багш Ганцэцэг байв.

Тэрээр охиноос нь одоо болтол сураг гараагүй байгаа эсэхийг лавлаж мэдээд явах гэснээ гэнэт эргэж Галсангийн нүд рүү харж хэсэг азнаснаа буцаж эргэлээ. Галсан

-Та ямар нэгэн юм хэлэх гээ юу?

-Юу л даа. Хэд хоногийн өмнө та сургууль дээр ирээд явахдаа Цэнгэл гэдэг охины тухай асууж байсан шүү дээ

-Тийм ээ. Тэр охины сураг гараа юу?

-Үнэндээ тэр охины гэр нь хэд хоногийн өмнө биш бүр олон жилийн өмнө шатсан юм. Үнэхээр таны хэлснээр аав нь тэгэхэд айхтар түлэгдэн нас барсан гэсэн. Охин ч бас нас

барсан гэдэг. Их ядуу амьдралтай айл байсан. Ямар ч хашаа хороо байхгүй аав нь хар бор ажил хийж охинтойгоо амь зуудаг хэцүүхэн л амьдралтай байсан гэж хүмүүс ярьдаг. Тэгэхэд тэр Цэнгэл гэдэг охин манай сургуульд сурдаг байсан юм л даа. Тэр үед би дунд сургуулийн сурагч байсан. Гэхдээ энэ бол их олон жилийн өмнөх явдал шүү дээ. Таны асуусан Цэнгэл биш ч байж болно. Таныг хэд хоногийн өмнө асуухад чинь би тодорхой ярьж амжаагүй. Тэгээд л яагаад ч юм энэ тухай танд заавал дуулгах ёстой юм шиг санагдаад ...

Энэ үгийг сонссон Галсан Хэрлэн хоёр ёстой л нөгөө мэл гайхаж цэл хөхрөнө гээч нь болов бололтой. Тэд Ганцэцэг багш руу гайхсан харцаар хэсэг чимээгүй ширтэж байснаа хоорондоо харц солилцоод авав. Хэрлэн тэссэнгүй бололтой ам нээв.

-Сонин юмдаа. Нэлээд хэд хоногийн өмнө л манайд хоносон. Өөр Цэнгэл гэдэг нэртэй охин юм болов уу?

-...Мм... Мэдэхгүй. Магадгүй тийм байх. Ямар ч л байсан манай сургуульд сурдаг байсан Цэнгэл гэдэг охин дандаа л нэг янзын сурагчийн дүрэмт хувцастайгаа гэр гадаагүй л явж байдаг байсан. Их л хэцүү амьдралтай байсан даа.

-За тэр. Тэр мөндөө. Яалт ч үгүй мөн байх нь. Саяхан надтай жорлонд тааралдахдаа яг тэр сурагчийн дүрэмт хувцастайгаа л харагдсан. Магадгүй тэр охины сүнс л байнга ээрээд байгаа байх нь л дээ. Охиныг минь тэр л нэг тийш нь аваачсанаас зайлахгүй.

Галсан ингэж хэлээд царай нь тийм гэхийн тэмдэггүй барайгаад ирлээ. Харин Галсангийн хэлснийг сонссон Ганцэцэг мэдрэл муутай хүнтэй харьцаж байна гэж бодсон уу эсвэл сүнс чөтгөр гээчээс нь айв уу ум хумгүй гараад явлаа. Харин Хэрлэн Галсангийн “Хэд хоногийн өмнө Цэнгэлтэй жорлонд тааралдсан” гэсэн үгэнд нь гайхан байсан ч асуулгүй өнгөрлөө. Галсан дэмий л цагдаагийн хэсэг дээр очин охиныхоо талаар сураг ажиг гарсан эсэхийг асуугаад сэтгэл гонсгор гэртээ буцаж ирлээ. Галсангийн дотор одоо юуны өмнө охиноо олж аваад энэ хараал идэж муу юм шүглэсэн байшингаас хурдхан нүүе гэсэн бодол л эргэлдэж байв. Дахиад л шөнө боллоо. Цагдаа, түргэн тусламж, асрамжийн газар гээд бараг бүх л байж магадгүй гэсэн газрууд руу утасдаж найз нөхөд хамаатан саднууддаа хэлж сураг чимээ дахин дахин тавиулсан ч охиныхоо тухай нэг ч үг олж сонсож чадсангүй.

Харин энэ шөнө Галсан унтсангүй. Бүр унтахыг ч хүссэнгүй. Хэрлэнд ”Дэмий уйлж суухаар жаахан ч гэсэн унтаж амар” гэж зөвлөөд өөрөө гал тогооныхоо өрөөнд нохойгоо хажуудаа хэвтүүлээд өөртөө цай аягалаад суучихав. Харин Хэрлэн охиндоо санаа зовоод байхад юуны чинь унтах гэж хэлсэн ч эрхгүй ядрал бололтой нүдний хор гаргахаар хэвтлээ. Шөнө дунд болжээ. Галсан энэ удаа зоорин доороос дахиад хэн нэгэн балбах юм бол чухам юу болохыг нь олж мэдэх санаатай байлаа. Эсвэл өнөөх аль эрт үхсэн гэж яриад байгаа Цэнгэл охин ч хүрээд ирж мэдэх юм гэсэн бодол санаанаас нь гарсангүй. Ямартай ч энэ шөнө тэрээр огт унтахгүй байхаар шийджээ.

Гадаа салхи исгэрч, хааяа нэг машин явах нь дуулдана. Гэрт ч тэр гадаа ч тэр нам жим байсаар. Галсангийн нүд өөрийн эрхгүй анилдаад эхлэв. Тэрээр харин нойртойгоо тэмцэхийг хүссэнгүй бололтой нүдээ анин ширээгээ дэрлэн хэвтлээ. Галсан дөнгөж дугхийв үү үгүй юу зүүдний ертөнцийн босго даван орлоо. Галсангийн зүүд яг л бодит амьдрал дээр болж байгаа



юм шиг ил тод ойлгомжтой байх аж.

Тэрээр зүүдэндээ өөрийгөө унтлагынхаа өрөөнд шөнө ганцаараа сонин гарчиглаж байгаагаар эхлээд харав. Гэтэл нөгөө л гал тогооны өрөөнд байгаа муу ёрын зоорины ямар нэгэн бүгтхэн чимээ дуулдаж доороос нь тогших бөгөөд тэр нь чухам юу болохыг нь мэдэхээр Галсан эрхгүй тэр зүг алхаж байв. Галын өрөө рүү ойртох тусам өнөөх чимээ улам тод сонсогдож байлаа. Удалгүй гал тогооны өрөө рүү ороход хамаг юм нь эмх замбараагүй ундуй сундуй болсон байх бөгөөд зоориноос хэн нэгэн гарах гэж амь тэмцэн балбах аж. Галсан хэдий айж байсан ч зоорины дэргэд очиж “чи хэн бэ?” гэж асуулаа. Гэтэл өнөөх нүдэх чимээ хэсэгхэн зуур зогссоноо зоорины хаалганы завсраар хэн нэгний нүд Галсанг хорссон байртай цоо ширтэх аж. Тэгснээ тэр эрэгтэй хүн “Чи намайг эндээс гарга. Хурдан гаргаадах, зоориныхоо түгжээг мултал. Энд маш хүйтэн байна. Хэрвээ хаалгаа нээхгүй бол... нээхгүй бол...” хэмээн цахиртаж сөөнгөтсөн хоолойгоор Галсанг заналаа.

Банхарын уурлан хуцах чимээгээр Галсан нойрноосоо цочин сэрэв. Үнэхээр саяын зүүдэндээ үзсэн шиг хэн нэгэн зоорин доороос гарах гэж самардаад байх шиг байлаа. Галсан ч гартаа тааралдсанаар нь мод хагалдаг сүхээ авч далайгаад зоорь луу тонгойн “чи ер нь хэн юм бэ, гараад ир, нэгийгээ үзье” хэмээн уурсан хашхирлаа. Тэгмэгц өнөөх чимээ гэнэт дуулдахаа болих нь тэр. Хэрлэн ч энэ бөөн дуу чимээнээр гал тогооны өрөөнд сандран орж ирлээ. Гадаа үүр цайх болоогүй тас харанхуй хэвээр. Нохой уурсан архирч хуцсаар. Харин Галсан эхнэрээ орж ирснийг ч анзаарсангүй гартаа атгасан сүхээрээ зоорины хаалгыг дээрээс нь балбаж гарав. Новш минь, би чамайг алаад өгье л дөө хэмээн хашхичих тэрээр бүр цөхрөнгөө барж дуусав бололтой. Удалгүй зоорины хаалгыг захалж хадсан төмөр бэхлээс хугарав. Одоо зөвхөн зоорины хаалгыг дээрээс нь татахад л нээгдэхээр болжээ. Банхар боргон хуцсаар харин Хэрлэн энэ бүхнийг айж сандарсан нүдээр ширтэн гараа элгэндээ зөрүүлэн зогсоно. Яг зоорины хаалгыг ийнхүү дээш нь татаж нээх мөч тулаад ирэхэд Галсан өөртөө эргэлзэж ямар ч хөдөлгөөн хийлгүй зогслоо. Одоо Галсангийн толгой энэ хаалгыг нээх нь зөв үү буруу юу гэсэн тэрсэлдсэн бодлууд хоорондоо тэмцэлдэж байх аж. Зоорин доороос хэн нэгний дээшээ зүтгэх өнөөх чимээ гарахаа больжээ. Бүгд нам гүм болов. Нохой нь ч тэр зоорины хаалга руу тас ширтэж биеэ хураан бөгтийн зогсож байлаа. Банхар энэ хаалганы цаана юу ч гарч ирсэн шууд дайрахад бэлэн байгаа нь харваас андашгүй аж. Галсангийн нүүрээр хөлс дааварласан байх бөгөөд нэг гартаа атгасан сүхээ далайсан хэвээр.

Галсан зоорины хаалгыг огцом хүчтэй нээлээ. Энэ хаалгыг ийнхүү нээснээр хожим өөрийнхөө амьдралд ямар их гай дуудсанаа энэ агшинд Галсан яахан мэдэх билээ. Зооринд хэн ч байсангүй. Зоорины таг нугасаараа бүтэн эргэж модон шалан дээр түс хийн савагджээ. Эхнэр нөхөр нохой гурав гурвуулаа зоорь луу тонгойж харсан хэдий ч ямар ч гэрэл тусгаагүй учир юу ч харагдсангүй. Ямартай ч тийм гүехэн биш гэдэг нь андашгүй. Тэдний нүүр лүү хүйтэн агаар сэнгэнэж байх агаад таагүй үнэр ханхийх аж. Хэрлэн гэнэт муухай хашхирлаа.

-Хэрлээн, юу болов?

Хэрлэн дэмий л зоорины сөхөгдсөн хаалга руу заав. Хэн нэг нь хурууныхаа цусыг гартал самардсан тэмдэг зоорины дотор талын модон хаалганд тодхон үлджээ. Хаалганы дотор талын банзан дээр хумсаар маажсан ором энд тэндгүй харагдах бөгөөд саяхан малтаж байсан нь ойлгомжтой байв. Учир нь самардсан хурууны ором дагаж нялгадсан цус нойтон хэвээр

байлаа. Банхар гэнэт айхгар архиран хуцаж гадагшаа хар эрчээрээ давхиж одов. Галсан Хэрлэн хоёр ч хоёр бие рүүгээ гайхаж харснаа нохойныхоо араас яаран гүйлээ. Нохой жорлон руу ямар ч эргэлзэх юмгүйгээр эрчээрээ давхин дотогшоо ороход Галсан араас нь гүйгээд гүйцсэнгүй. Ямар нэгэн юм доошоо пад хийн хөлдүү газар унах чимээ гарч нохой хуцахаа болих нь тэр. Өнөөг хэр нь гартаа сүх атгасаар байгаа Галсан зогтусав. Банхар, банхар гараад ир хэмээн тэрээр хоолойны чадал мэдэн хашхирлаа. Жорлонгоос ямар ч чимээ гарсангүй. Галсан хэсэг алмайрч зогссоноо жорлон руу яаран гүйж очиход Банхар жорлонгийн нүх рүү унажээ. Тэр доор ямар ч хөдөлгөөнгүй гулдайн хэвтэх хар дүрс нохойг хэдийнэ үхсэнийг илтгэх мэт.

“Чи хаанахын ямар хараал идсэн новш нь вэ. Бид нар чамд ямар гай тарьсан юм” хэмээн хашхирах Галсангийн дууг сонссон хэн ч байсан хирдхиймээр. Хэрлэн нөхрийнхөө араас тэвэрчээ. Тэрээр хэдий өөрөө маш их айдаст автсан ч Галсанг тайвшруулах гэж аль болох сайн сайхан үг хэлэхийг хичээж байгаа нь нэг бодлын өрөвдмөөр. Хашааны сүүмгэр гэрэлд орчин тойрон тийм ч сайн харагдахгүй байх агаад Банхар аль хэдийнэ үхсэн нь нэгэнт тодорхой болжээ. Эхнэр нөхөр хоёр жорлонгийн умгар модон өрөөнд хамтдаа ороод доошоо нохойгоо өчнөөн дуудсан ч доор гулдайн хэвтэх бараан дүрс огтхон ч хөдөлсөнгүй, бас ямар ч дуу чимээ гарсангүй. Эхнэр нөхөр хоёр маш их айдас түгшүүрт автаж байсан хэдий ч түүнийг нь нохойн үхлээс үүдсэн харуусал хэсэгхэн хугацаанд мартагнуулав бололтой. Тэд өглөө нар гарахаар нохойныхоо цогцсыг жорлонгийн нүхнээс гаргаж авахаар тохиролцож гэрлүүгээ алгуурхан явж орлоо. Байшин дотор нам жим, чимээ аниргүй байх аж. Энэхэн хэсэг хугацаанд тэд түрүүн зоорины хаалгыг нээснээ мартагнаад байсан билээ. Гэнэт Хэрлэн муухай хашхиран нөхрөө тэврээд авлаа. Тэд түрүүн нохойныхоо араас сандран гарахдаа гал тогооны гэрлийг унтраагаагүй бөгөөд нээлттэй орхисон зоорины хаалгыг хэн нэгэн хаажээ. Эхнэр нөхөр хоёр хоёулаа яахаа мэдэхгүй айдаст автан зогсоно. Байшинд ямар ч чимээ аниргүй хэвээр. Галсан түрүүлж ам нээлээ.

-Чи зоорины хаалгы хаагаад гарснаа мартсан юм биш биз?

-Үгүй ээ, би хаагаагүй. Наадахыг чинь хаах нь битгий хэл ойртохоосоо ч айж байсан юм чин хэмээн Хэрлэн шивнэн хариулах нь хэн нэгэн этгээд ярихыг нь сонсчих вий гэж айсан шинжтэй байх аж. Эхнэрийнхээ ийнхүү шивнэн ярихад Галсан үнэхээр хэн нэгэн муу ёрын этгээд зоориноос сэмхэн гараад гэрт нуугдсан юм шиг санагдаж жийрхсэндээ ар нурууных нь үс босох шиг л боллоо.

## XI

Магадгүй Саруул зооринд байгаа хэрэг биш байгаа даа гэсэн Галсангийн санааны мухарт өнөөг хэр нь хадгалагдаж байсан бодол харин одоо ор мөргүй замхран арилжээ. Охин нь зооринд байсан байлаа гэхэд ийм удаан тэсэхгүй нь ойлгомжтой. Бас нөгөөтэйгүүр Саруул үхэж гэмээнэ сүнс нь эцэг эхдээ, ялангуяа хайртай нохойдоо халтай ийм муу муухай зүйл хийхгүй гэдэгт Галсан итгэлтэй байлаа. Тэгэхээр энэ зоориноос Саруул биш өөр муу ёрын этгээдийн үнэр үнэртэх шиг л Галсанд санагдав. Ингэсээр нэг их удалгүй өглөө болжээ. Эхнэр нөхөр хочрын хэн нь ч зоорь луу дахин ойртсонгүй. Урьд шөнө тогтуун байсан цаг агаар энэ өглөө нэг л зэвүүн хүйтэн байх аж. Зэгэлтсэн саарал тэнгэрийн чхуам хаанаас нь нар тусаж байгаа нь үл мэдэгдэнэ. Галсан дүүгээ гэртээ дууджээ. Галсангийн дүүг Батжаргал

гэх бөгөөд ахынхаа дуудсан ёсоор өглөө эрт гэрт нь ирээд байв. Тэрээр энэ жил 25 нас хүрч байгаа нуруугаар ахаасаа өндөр биерхүү залуу. Батжаргалын хувьд хувийн компанид хамгаалалтын албаны даргын ажил эрхэлдэг, ганц бие бөгөөд ахаа хэнээс ч илүү хүндэлдэг нэгэн. Түүний өмссөн спорж загварын энгийн хувцас нь хүдэр биенд нь яг л захиалсан юм шиг таарсан байх агаад цэвэрхэн цагаан царайд нь жигтэйхэн зохижээ. Галсан Батжаргал хоёр муу хувцас өмсөн жорлонгийн модон гишгүүрийг мулт татан авч шат тавин доошоо буув. Хөөрхий Банхар хэдийнэ амьсгаа хурааж бүр хөшиж орхижээ. Амнаас нь цус гоожсон нь хөлдсөн ялгадас, цагаан цасан дээр тодхон ялгарч харагдана. Хамгийн хирдхиймээр нь Банхарын нүд хараастай хэвээр байх бөгөөд тэр харцанд нь хэн нэгнийг өшиж занасан, эсвэл айсан мөр тодхон үлджээ. Ах дүү хоёр нохойн цогцосыг хамжин байж муу шуудайнд хийгээд дээш нь гаргалаа. Хэрлэн хайртай үнэнч нохойгоо үхсэнд харамсаж уйлан зогсох аж. Галсан Батжаргал хоёр нохойг оршуулахаар холхон уулын энгэр бараадан алхав. Батжаргал түрүүнээс хойг ахаасаа асуух гээд эв нь таарахгүй байсан үгээ асуухаар шийдэв бололтой.

-Банхар яагаад жорлон руу чинь давхиж ороод тэгээд бүр доошоо унаад үхчихдэг байна аа. Үгүй тэгээд уналаа гэхэд тийм амархан үхчихнэ гэж баймааргүй л санагдах юм. Батжаргалын дууных нь өнгө энэ хүдэр биенд байж боломгүй гэмээр нарийндуу сонсогдох аж.

-Харин тийм ээ. Би ч гэсэн гайхаад л байна. Саруулын амьд үхсэн нь ч мэдэгдэхгүй, сураг чимээ гарахгүй болохоор бүр шаналж гүйцлээ. Хэрлэн ч гэсэн ялгаа алга. Өдөр шөнөгүй л уйлж автобусны буудал тоссон хүн болж хувирлаа. Миний ажил ч цалгардаж гүйцлээ. Ядахад энэ байшинд учир нь ойлгогдохгүй муу ёрын зүйлүүд болоод ердөө сэтгэл амраахгүй юм. Ер нь Саруулын гэртээ ирэхгүй алга болсон шалтгаан, нохойн үхэл ч гэсэн бүгд л энэ муу ёрын байшин, зоорь бас тэр новшийн жаахан охины сүнстэй холбоотой. Ингэж хэлэхдээ Галсангийн хоолой чичирхийлж байв.

Ямар ч сүсэг бишрэлгүй ахынхаа гэнэт ингэж хэлэхэд Батжаргал баахан гайхжээ. Батжаргалын сонирхлыг хамгийн ихээр татсан үг бол яах аргагүй “Байшин, зоорь бас тэр муу ёрын жаахан охины сүнс” гэж хэлсэн нь байлаа.

-Юун сүнс, бас юун зоорь яриад байна аа та. Тэгэхээр та энэ байшинд буг чөтгөр шүглэсэн гэх гээд байна уу?

-Тийм ээ, магадгүй биднийг нүүж ирэхээс ч өмнө байсан л байх. Яавч зүгээргүй. Ялангуяа тэр зоорь. Тэр доороос ямар нэгэн муу ёрын амьтан эсвэл муу ёрын сүнс гарч ирэх гээд байгаа юм. Магадгүй гараад ирсэн ч байж мэднэ.

-Юу гэнэ ээ... Батжаргал юу хэлэхээ бас юу асуухаа ч мэдсэнгүй. Ахынхаа шаналж хорссон нүд рүү гайхаж харахаас хэтэрсэнгүй. Охин нь сураггүй алга болоод сэтгэл нь хямрахдаа хий юм харж сонссон юм болов уу гэж хүртэл бодож явлаа. Тэд ийнхүү явсаар уулын энгэрийн нэгэн буйдхан газар олж хайртай нохойгоо оршуулах ажлаа эхэллээ. Нохойны сүүлийг цавчиж толгой доор нь дэрлүүлээд аманд нь шар тос зуулгажээ. Өвлийн улирал болохоор газар хөлдүү бөгөөд ухна гэдэг хамгийн хүнд бэрх нэг үгээр хэлбэл тамын ажил байлаа. Гурав дөрвөн цаг ноцолдсны эцэст нохойгоо арайхийн хөдөөлүүлжээ.

Ингээд гэр лүүгээ буцах замдаа Батжаргал түрүүний ахынхаа ярьсан тэр сүнс чөтгөр

зоориных нь тухай лавлан асуулаа.

-Танай энэ байшин чинь зоорьтой тэгээд тэр зоориноос нь хэн нэгэн гарч ирэх гээд байгаа гэв үү?

-Тийм ээ, шөнө болохоор л доороос нь нүдээд л зүүдэнд элдэв юм үзэгдээд. Яагаад ч юм тэр зоорь нэг муу ёрын. Анх тийм зоорь байгааг нь ч мэдээгүй л дээ. Гэтэл харин тэр зоорийг бүр бэхлээд хадчихсан байсныг нь хараад эхэндээ гайхсан. Чи магадгүй миний ярьж байгаад итгэхгүй байж магадгүй юм. Хэрлэн миний хэлсэн үгийг батална даа.

-Та тэгээд тэр зоорийг нээж дотор нь орж үзэв үү?

-Үгүй ээ. Дотор нь орж үзээгүй. Үнэндээ орох зав ч гарсангүй. Харин өчигдөр нээсэн шүү. Ингэж хэлэхдээ Галсангийн дуу илт сулаад ирсэн нь өчигдрийн зоорины хаалга өөрөө хаагдсан байсныг санав бололтой.

-Тэгээд. Чухам яагаад дөнгөж өчигдөр нээж үзсэн юм бэ?

-Нээхэд тийм амар байгаагүй. Тэгээд ч үнэндээ тэр хаалгыг нээнэ гэхээс нэг л жийрхэж байсан шүү. Дороос нь балбаад л, самардаад л. Хөөрхий Банхарыгаа хэрэггүй л зоорины хажууд хонууллаа гэж одоо хүртэл харамсаж байна. Өчигдөр би зоорины хаалгыг тэсэлгүй нээгээд хартал нүдэнд юу ч өртөөгүй харанхуй нүх л харагдсан. Харин зоорины хаалганы дотор талд үнэхээр хэн нэгэн самардсан шинэхэн ул мөр байсан шүү. Чи одоо очоод хараарай.

Батжаргал Галсангийн энэ үгийг сонсоод өөрийн эрхгүй жихүүцээд ирлээ. Галсан яриагаа цааш үргэлжлүүлэв.

-Манай нохой ямар солиорсон биш. Бид нарын нүдэнд өртөхгүй ямар нэгэн амьтныг олж харснаас зайлахгүй. Айхтар архираад жорлон руу давхиад орсон. Тэгээд тэр амьтан ч дороос нь татаж унагаад алчихсан.

Ахынхаа энэ хэлснийг сонссон Батжаргал бүр учраа олохоо больж гүйцээд Галсангийн эрүүл эсэхэд эргэлзэх шиг болов.

-Тэгвэл тэр охины сүнс гэж яриад байгаа чинь юу билээ? Ингэж хэлэхдээ Батжаргалын дууны өнгө үл ялиг өөрчлөгдснийг Галсан анзаарсангүй.

-Тэр Цэнгэл гэдэг үхээрийн хувхай царайтай охин яавч амьд хүн биш. Уг нь анх Саруулыг дагаж манайд ирж нэг хоносон. Маргааш нь би хөөгөөд явуулчихсан юм. Тэр охин гал тогооны өрөөнийн нөгөө зоорийг нээх гээд байгаа юм. Харин манайхаас явахдаа “Дахиж ирнэ” гэж хэлж байсан. Хэлсэндээ хүрсэн шүү

-Яаж хэлсэндээ хүрсэн гэж?

-За за битгий олон юм шалгаагаад бай. Тэр охины явсан газар мөр үлддэггүй юм. Энэ үгийг сонссон Батжаргал юу гэж хэлэх бас яахаа ч мэдсэнгүй.

Тэд гэртээ иржээ. Хэрлэн хоол хийгээд ах дүү хоёрыг хүлээх байх бөгөөд мөн өөрийнхөө оюутан эмэгтэй дүүг гэртээ авчирчээ. Хэрлэнгийн дүүг Оюунчимэг гэдэг. Энэ жил гуравдугаар дамжааны оюутан, урт үстэй, дунд зэргийн нуруутай охин байлаа. Хэрлэн ч тэр Галсан, Батжаргал хоёрыг нохойгоо оршуулахаар явсан хойгуур гэртээ болоод байгаа явдлыг дүүдээ нэгд нэгэнгүй ярьсан бололтой. Тэр дөрөв дөрвүүлээ хоол идэж байхдаа юу ч ярьсангүй. Гал тогооны ширээн дээр хамтдаа хооллох тэдний хэн хэн нь зоорь луу үе үе хяламхийх аж. Саруул сураг чимээгүй хэвээрээ л байлаа. Ийнхүү охин гэртээ ирэлгүй бараг арваад хоносон болохоор охиноо амьд эргэж ирнэ гэдэгт эхнэр нөхөр хоёр хоёулаа эргэлзэх болжээ. Гэхдээ энэ эргэлзсэн бодлоо тэдний хэн хэн нь илэрхийлсэнгүй. Хэдэн цагийн турш хэн ч юу ч ярьсангүй. Галсан мөн л урьдын адил цагдаагийн хэсэгт очиж охиноо сурагласан боловч сэтгэлээ сэргээчих ямар ч үг сонсож чадсангүйгээр барахгүйгээр үл барам охиных нь алга болсон хэргийг хүлээж авсан ахлах дэслэгчээс зэмлэсэн үг сонсоод авлаа. Охины чинь тухай өчүүхэн төдий сэжүүр гарах юм бол шууд утсаар мэдэгдэнэ гээд байхад юунд өглөө оройгүй энэ хавиар эргэлдэж өөрсдийгөө ч бас биднийг ч улам зовоогоод байгаа юм бэ хэмээн хөөрхий эцэгт хэлжээ.

Галсангийн сэтгэл тийм гэхийн аргагүй шаналж толгойгоо гудайлган алхалсаар гэртээ яаж ирснээ ч мэдсэнгүй. Бүгд л түүнийг асуусан харцаар ширтэх хэдий ч Галсангийн гадаад байдлаас л Саруулын талаар ямар ч сураг гараагүй гэдэг нь андашгүй байв. Удалгүй үдэш болж гэгээ тасарлаа. Хэрлэн ч урьдын адил юмыг яаж мэдэхэв хэмээн охиноо тосохоор автобусны буудал руу Оюунчимэгийг дагуулан явав.

Галсангийн амнаас бүр дуу ч гарахаа боьжээ. Тэрээр унтлагынхаа өрөөний орон дээр элдвийг бодон бөгтийн сууна. Түүн дээр Батжаргал орж ирлээ. Харин Галсан дүүгээ орж ирснийг ч анзаарсангүй эсвэл анзаарсан ч тоосонгүй. Батжаргал ахыгаа тайвшруулах санаатай түүнтэй ганц нэг үг солихыг оролдсон ч тусыг эс олов. Батжаргал Галсангийн хажууд зэрэгцэн суужээ.

Тэрээр нэлээд эргэлзсэн байртай дороо займчиж байснаа Галсан руу харж “Ах аа хоёулаа зоорь луу орох уу?” гэж асуулаа.

## ХII

Аль хэдийнэ харуй бүрий болсон ч сар гарсангүй учраас гадаа хав харанхуй байлаа. Хэрлэн Оюунчимэг хоёр автобусны буудал руу горьдлого тавин Саруулыг тосох гэж яваад гэртээ ирээгүй хэвээр.

Галсан дүүгийнхээ хэлсэн саяын үгийг сонсоод цочих мэт болсноо урьдын адил хэсэг чимээгүй суув. Тэрээр толгойгоо салаавчилсан гараа доош нь буулгаад өндийж цэх боллоо

-Зоорь луу орьё гэнэ ээ. Чи харин загатнасан газар маажлаа даа. Яагаад тийшээ орьё гэж бодох болов?

-Галсан ах аа. Магадгүй тэр зорин дотор орсноос олон юмны учрыг олж мэдэх юм шиг санагдаад байна. Би сая зоорины хаалгыг нээж үзсэн харанхуй нүх л харагдсан. Харин үнэхээр зоорины хаалганы дотор талд хэн нэгний самардсан ул мөр тодхон үлдсэн байна лээ

шүү

-Тийм ээ, магадгүй чиний хэлж байгаа зөв байх. Эрт орой хэзээ нэгэн цагт энэ зоорь луу орох л байсан. Тиймээс одоо оръё

Галсан ингэж шийдэмгий нь аргагүй босоод ирлээ. Батжаргал ч гэсэн сууж байсан орон дээрээсээ босов. Тэдний хэн хэн нь зоорь луу орохоор хатуу шийдсэн нь хөдөлгөөнөөс нь андашгүй аж. Түрүүнээс хойш сууж босохдоо хүртэл бэртсэн хүн шиг хөдөлж ядаад байсан Галсан тамирчин шиг л хурдан хөдөлж өөрийгөө зэвсэглээд амжлаа. Тэрээр өнөөх түлэгдсэн болов уу гэлтэй аймшгийн хүйтэн биетэй “хүн чөтгөр”-тэй учирч мэднэ гэж таамагласан нь лав. Харин Батжаргал ахыгаа ингэж алх бороохойгоор зэвсэглэхэд нь гайхаж бас жаахан дургүй нь хүрэв бололтой

-Та тэгж их айгаад байгаа юм уу, наадуулын чинь хэрэг гарахгүй шүү дээ. Батжаргал ингэж хэлээд Галсангийн гартаа чанга гэгчийн атгаад амжсан бороохойг заалаа.

Галсан ямар ч хариулт өгсөнгүй. Дүүдээ араас дагаад яв гэж хэлээд шууд галын өрөө рүү орлоо. Гал тогооны өрөөний гэрлийг асааж зоорины дэргэд ирэв. Галсангийн царайд эргэлзсэн айсан байдал тодхон харагдаж байсан нь Батжаргалд ч бас нөлөөлөв бололтой. Батжаргал хоолойгоо зассанаа Галсангаас асуулаа.

-Зоорин дотор юу байгаа бол?

-Мэдэхгүй, үнэндээ юу ч байж мэднэ. Лав хоосон биш гэдгийг нь зөнгөөрөө мэдэрч байна.

-Зоорин дотор байгаа нөгөө ад зэтгэрийн амьтнаа та магадгүй гараад ирсэн ч байж мэднэ гэж өдөр хэлсэн.

Дүүгийнхээ саяын хэлснийг сонсоод Галсан зогтусав. Нээрээ тийм л дээ. Өчигдөр шөнөөс хойш зоориноос дахин чимээ гараагүй. Нөгөө нүдээд байсан амьтан нь гарч ирээд дээд давхарт бүгчихсэн хэрэг биш байгаа даа гэсэн бодол Галсангийн толгойд төрж энэ тухайгаа дүүдээ хэлэв

-Өчигдөр зоорины хаалгыг нээчихээд эргээд ороод иртэл хаагдчихсан байсан. Эхнэр бид хоёр хэн нь ч энэ хаалгыг хаагаагүй. Өөрөө хаагдах үндэс байхгүй гэдэг нь ойлгомжтой. Өөр хэн нэгэн хааснаас зайлахгүй. Тэгээд л магадгүй зоориноос гарч ирсэн амьтан эсвэл хэн ч юм зоорины хаалгыг буцааж хаасан байх.

Энэ үгийг сонссон Батжаргалын дотор арзасхийх шиг болов. Энэ мөчид ах нь яавч тоглоом тохуу хийхгүй гэдгийг тэрээр сайн мэдэж байлаа. Хамаг сэтгэл нь жихүүцэж бүр дагжин чичрэх мэт зогссон Батжаргал сэхээ авах гэсэн бололтой гарынхаа хоёр алгаар нүүрээ хүчтэй үрэв.

-Тэгвэл хоёулаа эхлээд танай гэрийн дээд давхрыг сайтар нэгжих хэрэгтэй юм бишүү?

-Тийм ээ, Үнэндээ дээд давхрын хэдэн өрөөгөөр орж үзье гэж бодсон ч Саруулыг харуулдсаар

завдсангүй. Эхлээд зоорь луу орчихоод эсэн мэнд гарч ирэх юм бол дээшээ гаръя.

-Юу гэнэ ээ, эсэн мэнд гарч ирэхгүй тэгээд яана гэж?

-энэ зоорин дотор юу байгаа бас хэр зэрэг гүнзгий гээд л ер нь энэ зоорины талаар юу ч мэдэхгүй болохоор л тэгсэн хэрэг

Ахынхаа хэлсэн энэ үгийг сонсоод Батжаргал өөрийн эрхгүй эргэлзэв. Зоорины тагийг нээсэн бөгөөд доошоо хав харанхуй. Өнөөх доороос нь самардсан ул мөр ч Батжаргалын харцыг эрхгүй өөр лүүгээ татах шиг түүнд санагдаж сэтгэлийг нь айдас түгшүүр эзэмдээд авлаа. Түрүүн сонирхолдоо хөтлөгдөөд зоорь луу орьё гэж санал гаргасан бол одоо сонирхол нь айдсаар солигджээ. Ингээд түрүүхэн зэвсэг хэрэггүй гэж бардам дуугарч байсан булиа залуу гутлынхаа түрийнд хурц үзүүртэй тонгорог хийгээд гартаа хөнгөн хэрнээ бүдүүн турба атгалаа.

Галсан гар чийдэндээ шинэ батарей сольж хийгээд харанхуй зоорь луу доош тусгав. Ах дүү хоёрын өөдөөс нэг л ёозгүй жихүүн, хүйтэн агаар сэнгэнэх аж. Өглөө жорлонгийн нүхрүү буулгаж Банхрын цогцсыг авсан шатыг Батжаргал авчирлаа. Хэрлэн Оюунчимэг хоёр ирээгүй хэвээр. Доош ухагдсан зоорины урт нь ямартай ч шатнаас урт байх аж. Зоорины хана нь ямар ч доторлогоогүй, хөлдүү шороо байлаа. Шатныхаа дээд ирмэгийг хөлдүү шороон хананд тулгав. Галсан түрүүлж доош буулаа. Тэрээр зоорь луу буухдаа шалны ирмэгээс бариад дүүлжлэгдэн байж өлмийгөө шатны хамгийн дээд талын гишгүүрт хүргэв. Батжаргал ч чийдэн тусган ахынхаа араас дагав. Тэд удалгүй зоорины ёроолд хүрлээ. Энд ямар ч чимээ аниргүй байх бөгөөд хэрэггүй болж шуудайлса нтөмөр эдлэл хог новш байх аж. Энэ зоорь хаалганыхаа хэмжээнээр хоёр алхмын дайтай илүү өргөн талбайтай байсан нь Галсангийн төсөөлж байснаас зөрөв бололтой. Энд үнэхээр хүйтэн байгаа нь Галсанд нэгийг бодогдуулах шиг болж хамга биеийг нь айдас эзэмдээд авав. Энд байх ч үнэхээр тэсэхийн аргагүй юм байна шүү гэж хэлснээ Галсан өөрөө мэдсэнгүй бололтой. Харин үүнийг нь хагас дутуу сонссон Батжаргал ах руугаа асуусан харцаар харсныг гэрэл муутай энэ харанхуйд Галсан анзаарсангүй. Батжаргал одоо яах ёстойгоо мэдэхгүй хэдэн тийшээ гэрлээ тусган зогсож байхад Галсан амандаа ямар нэгэн зүйлийг бувтнан чийдэнгээ доош тусган тонгойжээ.

-Энд үнэхээр хэн нэгэн байсан байна. Галсан ингэж хэлэхдээ дуу нь илт чангарч хурдхан энэ зоориноос гарах ёстойгоо мэдсэн юм шиг дээшээгээ яаран харав.

Батжаргал ахынхаа гэнэт ингэж чанга хашгиран асуухад цочсондоо гар чийдэнгээ газар алджээ.

-Хэн байсан гэж? Та юу олж харав?

Батжаргал ингэж хэлээд үгээ гүйцээж амжаагүй байхдаа газар унагасан гар чийдэнгээ авах гэж тонголзож байлаа. Тэр гар чийдэн нь хэдийнэ унтарчээ. Хэдийгээр Батжаргал асаах гэж оролдсон ч дахин гэрэл тусгаж чадсангүй. Одоо зөвхөн Галсангийн гарт байх чийдэн л асаалттай үлджээ.

Галсан Батжаргалын асуултанд хариулсангүй. Зөвхөн эндээс түргэн гаръя гэж дүүгээ

шамдуулаад шатны гишгүүрээс нэг гараараа барьлаа. Тэгтэл гэрт Хэрлэн Оюунчимэг хоёр ирсэн бололтой дээр хүний хөлийн чимээ сонсогдов. Тэгснээ гэнэт зоорины хаалга тас хийтэл савагдаж хаагдах нь тэр. Зооринд бүр ч харанхуй боллоо. Зооринд хичнээн хүйтэн байсан ч Батжаргалын нүүрэнд хөлс дааварлаж Галсан руу нуруугаараа налж гартаа барьсан төмрөө үл мэдэг далайв. Зоорины хаалга ингэж хаагдсанд Галсан яахаа мэдэхгүй бүр хөшиж орхижээ. Хав харанхуй бас тэсэхийн аргагүй хүйтэн орчин. Хаана юу байгаа нь үл харагдаж зөвхөн жихүүн агаар сэнгэнэх нь хэн нэгэн ирээд нүүр лүү үлээж байгаа ч юм шиг.

-Ах аа, хурдан дээшээ яваач ээ, эндээс гаръя

Батжаргалын ингэж хэлсэн нь Галсанг эрхбиш сэхээ авахад хүргэв. Галсангийн гар чийдэнгээ тал тал тийш тусган харахад тусгал нь тогтохгүй чичирхийлж байгаагаас үзэхэд түүнийг даарсан эсвэл айсан хоёрын аль нэгийг илтгэж байлаа. Галсан яг одоо өнөөх зүүдэнд нь үзэгддэд ад зэтгэрийн этгээд өөр лүү нь хүрээд ирэх юм шиг санаж айж түгшин чийдэнгээ хэдэн тийш нь хурдан хурдан тусган харна. Батжаргал тэссэнгүй “Ах аа яачихав аа. Хурдан дээшээ авираачээ” хэмээн дахин яаран хэлэв. Тэрээр гутлынхаа дүрийнд хийсэн хутгаа аль хэдийнэ гартаа атгаад амжжээ. Магадгүй энэ мөчид хаа нэгтэйгээс хэн нэгэн Батжаргалын гарнаас атгаад авлаа гэхэд тэрээр ямар ч өчиггүй хутгаараа бүлж орхиход бэлэн байв.

-Хэрлээн, чи дээр байна уу?

Галсангийн энэхүү чичирхийлсэн хоолойгоор чанга хашхиран асуухад хэн ч хариу хэлсэнгүй. Энэ хүйтэн зооринд ах дүү хоёрын амнаас уур гарах ньгар чийдэнгийн бяцхан тусгалд харагдаж байлаа. Галсан шатаараа дээш авирахад түүний зүрх хурдан хурдан цохилж муу ёр шүглэсэн энэ харанхуй хүйтэн зоориноос түргэхэн шиг гарахсан гэсэн бодол хамаг сэтгэлийг нь эзэмдээд байв. Энэхэн агшинд өөрийн нь хойноос хамгаас илүү хань түшиг тулгуур болж байгаа дүү нь яваа гэдгийг ч Галсан мартав бололтой. Шатны гишгүүрүүд дээр хичнээн хурдан хурдан гишгэлж дээшээ зүтгэсэн ч энэ удаад зам нь дэндүү холдоод байх шиг. Ингэсээр ашгүй Галсан шатны хамгийн дээд талын гишгүүр дээр хөлөө тавьлаа. Тэгмэгц Галсан яахаа мэдэхгүй хөших нь тэр.

-Галсан ахаа яачихваа. Хурдан наад хараал идсэн хаалгаа нээгээч ээ

Батжаргалын энэ цөхөрч хашхирсан үгийг сонсоод Галсан цочсондоо гар чийдэнгээ доош алдаж орхилоо. Пад харанхуй болов. Одоо энд зөвхөн ах дүү хоёрын амьсгалахаас өөр чимээ сонсогдохгүй байх аж. Ингэсээр нэлээд хэдэн хором өнгөрөхөд Галсан түрүүний дүүгийнхээ хэлснийг санах бололтой зоорины хаалгыг түлхэх гэж оролдлоо. Зоорины хаалга шатны хамгийн дээд талын гишгүүрээс нэлээд хол байгаа болохоор Галсангийн дөнгөж хурууны үзүүр л хаалганд хүрч байв. Галсан яг одоо түрүүн зооринд орохдоо буцаж гарахаа тооцоолоогүйдээ харамсаж байлаа. Зоорь луу буухад шат хангалттай хүрэхгүй шалны ирмэгээс гараараа дүүжлэгдэн байж бууснаа мэдсээр байж дээш гарахад хэцүү байх болно гэдгээ яагаад сэтгэсэнгүй вэ хэмээн өөрийгөө зэмлэх тэрээр хараал идмэр хэмээн амандаа үглэх аж.

-Батжаргал аа, яах вэ. Хаалганд гар хүрэхгүй байгаа болохоор сайн түлхэж чадахгүй байна.



-Би таныг доороос чинь өргөөд өгье. Миний хүзүүн дээр гишгээд наад новшийн хаалгаа хурдан нээж үз.

Галсан ч дахин юу ч хэлсэнгүй дүүгийнхээ үгэнд орлоо. Ингээд Батжаргал шатны дээд гишгүүр дээр хутга төмөр хоёр атгасан гараа тавьж цээжээ өргөхөд Галсан түүний мөрөн дээр гишгэн дээш цоройв. Одоо зоорины хаалгыг түлхэхэд хамаагүй дөхөмтэй болжээ. Тэгсэн ч хаалга гацчихав бололтой нээгдсэнгүй.

-Хэрлээн чи байна уу. Энэ хараал идсэн хаалгыг татаад өгөөч?

Галсангийн энэ цөхөрсөн гуйлтанд хэн ч хариу өгсөнгүй. Галсан хичнээн түлхэж байсан ч хаалга нээгдэхгүй л байлаа. Батжаргал ч гэсэн нэлээд ядарч байгаа бололтой “Ах аа нээгдэх нь үү?” хэмээн асуулаа. Харин Галсан үүнийг нь сонссонгүй зоорины хаалгыг балбан самардаж байв. Галсан зоорины хаалгыг нүдэхээ хэсэг азнаж бодолхийллээ.

Түрүүн дээр гарсан хөлийн чимээ Хэрлэн Оюунчимэг хоёрынх биш бол өөр хэнийх байх билээ. Мэдээж Хэрлэн байсан бол зоорины хаалгыг хаах нь битгий хэл ойртох ч үгүй. Үгүй ядаж хаалаа гэхэд эхлээд Батжаргал бид хоёрыггэрт байхгүй болохоор зооринд байгаа эсэхийг шалгаж харах нь дамжиггүй. Тэгэхээр энэ хаалгыг өөр хүн хаагаад магадгүй бүр түгжсэн хэрэг. Хаалга өөрөө хаагдана гэж байхгүй нь лав. Арай энд ингээд гацчихаж байгаа юм биш биздээ гэсэн бодол Галсанд төрж хамаг бие нь зарайгаад ирлээ. Гэтэл Галсангийн энэ түгшүүрт бодлыг ямар нэгэн зүйл тасалдуулахад хүргэсэн нь зоорины ёроолоос дуулдах чохарч шажигнасан чимээ байлаа. Шороо хөдөлж хэн нэгэн газар дороос гарч ирж байгаа ч юм шиг энэ чимээг Галсан Батжаргал хоёр хоёулаа сонсчээ.

### **XIII**

...Түргэлээрэй түргэл, энэ муу новш чинь яасан хурдан ойртож байна аа. Айдас түгшүүрт автаж балмагдан сандарсан энэ үг Батжаргалын амнаас гарчээ. Галсан байдаг тэнхээгээрээ хаалгыг түлхэж балбасаар.

-Ээ новш гэж, ахаа түргэлээч ээ

-Одоохон...

Зоорины хаалга арайхийн сая нэг нээгдлээ. Зоорины хаалгыг нээмэгцээ Галсан доошоо ч харсангүй ум хумгүй дээш зүтгэн гарч ирэв. Галсангийн хамаг бие салганан чичирж магнайд нь хүйтэн хөлс чийхарчээ. Тэрээр яг л тамын хаалгыг арайхийн нээж гараад диваажинд ирсэн хүн шиг тэрхэн агшинд баярлах сэтгэлд автаж байлаа. Гэрт хав харанхуй байх бөгөөд энэ нь Хэрлэн Оюунчимэг хоёрыг ирээгүйг батлах аж.

Галсан Батжаргалыг одоо болтол зоориноос гарч ирээгүйг гэнэт саналаа. Ингээд Галсан өнөөх хараал идэж муу ёр шүглэсэн нүхэн зоорь луу яаран тонгойж харсан ч нүдэнд нь юу ч торсонгүй. Арга ч үгүй биз. Өрөө хав харанхуй, дээрээс нь угийн хүйтэн харанхуй зооринд хаана юу байгаа нь яахан харагдах билээ.

-Батжаргал аа чи яасан бэ?

-.../таг чиг/

-Батжаргал аа хариулаач ээ. Чи хаана байна аа, зүгээр үү?

Галсан хэдий ийнхүү хэдэнтээ хашхиран асуусан ч Батжаргал ямар ч хариу өгсөнгүй. Уг нь саяхан л мөрөн дээрээ гишгүүлж байсан дүү нь зоорины энэ хаалганаас холгүйхэн байгаа гэж таамаглаж байсан ч энэ нь худлаа гэдэг нь ойлгомжтой болов. Галсангийн хоолой цахиртан сааралтаж “Батжаргал аа” хэмээн хамаг чадлаа шавхан хашхирсаар. Тэрээр зоорь луу тонгойн элгээрээ хэвтэж байснаа год үсрэн босоод өрөөний гэрэл асаав. Өрөө гэрэлтэй болсноор Галсан бага ч гэсэн тайвшрав. Дүүдээ санаа зовсон тэрээр яахаа мэдэхгүй хэдэн тийшээ харж орчин тойрноо ажиж байснаа зоорь луу буцаж орохоор шийдэж огтхон ч эргэзсэнгүй зоорины сөхөгдсөн хаалган дээр хоёр ч том шуудайтай нүүрс тавиад доошоо буулаа. Энэ нь мэдээж зоорины хаалгыг дахин хаалгахгүй гэсэн санаа биз

-Батжаргал аа, амьд уу. Ямар нэгэн юм дуугараач ээ

-.../таг чиг/

-Ах нь одоохон, миний дүү тэсээрэй. Би доошоо бууж байна.

Галсан амандаа ийн үглэсээр түрүүн Батжаргалтай хамт доош унжуулж тавьсан шатныхаа дээд гишгүүр дээр хөлөө тавьлаа. Одоо Галсанд айдас төрөх бишдүүдээ санаа зовсон сэтгэл л бүх оюун ухааныг нь захирч байв. Уг нь түрүүхэн л ахыгаа мөрөн дээрээ гишгүүлээд яг энэ шатны гишгүүр дээр зогсож байсан дүү нь одоо тэр газраа байхгүй байгаа нь түүнийг доошоо унасныг нь илтгэх мэт. Гэхдээ түрүүн Галсан амь тэмцэн дээшээ мацаж гарахдаа хэн нэгний доошоо унасан ямар нэгэн чимээ огтхон ч сонсоогүй. Эсвэл магадгүй анзаараагүй биз.

Үхтлээ айсан байсан юм чинь. Сүүлийн энэ үгийг Галсан өөртөө зориулж амандаа шивнэсэн нь дүүгээ орхин өөрөө амь тэмцэн зугтсан сэтгэлээ хаацайлах гэсэн мэт.

Галсан бараг зоорины ёроолд тулж ирлээ. Шатны харалдаа нэгэн бараан лүглийсэн дүрс дөнгөж ялгарах төдий үзэгдэхийг хараад Галсан дүүгээ гэж бодоод үлдсэн шатны гишгүүр дээр гишгэлгүй шууд үсрэн буув.

-Батжаргалаа, миний дүү зүгээр үү? Хэмээн Галсан асууж өнөөх амьгүй мэт гулдайн хэвтэх залуугийн мөрнөөс сэгсрэв. Энд хав харанхуй байгаа учраас шууд Батжаргал мөн гэдгийг таахад бэрх байгаа нь Галсанд айдас төрүүлэхэд хүргэв. Арай нөгөө...

Тийм ээ, энэ этгээд арай Батжаргал биш байвал яах билээ гэсэн бодол яагаад ч юм Галсанд төрөөд болсонгүй. Ийнхүү тэрээр уг бодолдоо захирагдан ухаангүй гулдайн хэвтэх энэ хэн нэгэн этгээдийн биед дахин хүрэхээсээ цэрвэлээ. Галсанд яг одоо гэрэл хэрэгтэй байлаа. Амьгүй мэт гулдайн хэвтэх энэ хэн нэгэн этгээдийг хэн ч байж мэднэ хэмээн айж байгаа хэдий ч тэрээр Батжаргалыг биш гэсэн бодлоо бүрмөсөн орхисонгүй. Түрүүн доошоо унагасан гар чийдэнгээ Галсан гэнэт санаж газар тэмтчин хайж эхлэв. Ашгүй нэг их

удсангүй түрүүн өөрийнхөө барьжбайсан гар чийдэнг олж тусгаж үзвэл ашгүй ажиллаж байв. Галсан гар чийдэнг ийнхүү олмогцоо шууд л өнөөх гулдайн хэвтэх этгээд рүү тусгаж харснаар Батжаргалыг мөн гэдэгт сая бүрэн итгэлээ.

-Батжаргал аа, чи яасан бэ. Амьд уу, ядаж өвдөж байна гэж хэлээч дээ

Галсангийн нулимс дуслуулан урсгасан энэ үг түүнийг үнэхээр цөхрөнгөө барж байгааг нь илтгэж байв. Батжаргал ямар ч хариу хэлэлгүй бас хөдлөлгүй гулдайн хэвтсэн хэвээр. Галсан дүүгээ өргөж дээш нь гаргахаар оролдож эхэллээ. Ядаж байхад Батжаргал дэндүү булиа, хүнд жинтэй болохоор түүнийг өргөх нь Галсанд тийм ч амар байсангүй. Галсан гар чийдэнгээ амандаа зууж доошоо харж хэвтсэн Батжаргалыг эргүүлэн царайг нь хартал нүд нь хагас аниатай ухаан алдсан шинжтэй байлаа. Тэрээр дүүгээ үхсэн эсэхийг нь нягтлахаар зүрхэн тушаа газар нь чихээ наан чагнавал ашгүй цохилж байх нь тэр.

-Батжаргал аа, ухаан ороорой хэмээн хацар луу нь хэдэнтээ алгадаж үзсэн ч нэмэр болсонгүй. Галсан дүүгээ нуруундаа үүрэхээр шийджээ. Дахиад л гар чийдэнгээ амандаа зууж дүүгээ дээш нь өндийлгөн татахад Галсангийн гар шингэн бүлээн зүйлийг мэдрэх нь тэр. Галсан арай ч үгүй байлгүй дээ хэмээн бодож тэр шингэн бүлээн зүйл юу болохыг ажиглавал үнэхээр Батжаргалын цус бололтой. Галсан бүр яахаа мэдэхээ айн сандарч эхлэх нь тэр. Ямар ч байсан хаанаа яаж бэртсэнийг нь олж мэдэхээр чийдэнгээ Батжаргалын биед нэгд нэгэнгүй тусган хараад учрыг олж мэдэв. Батжаргалын гартаа атгаж байсан өнөөх хурц иртэй тонгорог гуяыг нь айхтар гүнзгий хэрчиж орхижээ. Ингээд Галсан Батжаргалыг нуруундаа үүрч өндийлөө. Шатны гишгүүр дээр арайхийн гишгиж дээгээ авирах Галсангийн нүүрээр хар хөлс нь цутгаж гар чийдэн зуусан амнаас нь уур савсана. Дээр дахиад л хөлийн чимээ галаа. Галсан Хэрлэн Оюунчимэг хоёрыг байж мэднэ гэж бодоод хэдий орилохыг завдсан ч чадсангүй. Учир нь тусламж дуудлаа гэхэд амандаа зуусан чийдэнгээ алдана. Тэгээд ч Хэрлэн мөн бол бид хоёрыг хайгаад нээлттэй байгаа зорь луу заавал тонгойж харах учиртай гэж боджээ. Галсан хамаг хүчээ шавхан дээш мацсаар л. Дээр хэдий хүний хөлийн гарч байгаа хэдий ч зорь луу галын өрөөрүү зүглэхгүй байгаа бололтой. Гэтэл Оюунчимэгийн хэн нэгэнтэй ярих нь Галсанд сонсогдов. Ийм бүдэг дууддаж байгааг бодоход дээд давхарт байгаа юм болов уу гэсэн бодол Галсанд төрөхтэй зэрэгцээ Хэрлэн Оюунчимэг хоёр тэр дээр юугаа хийж байдаг байна аа хэмээн бухимдах аж. Гэтэл Оюунчимэг үнэхээр хэн нэгэн эрэгтэй хүнтэй дээд давхарт яриад байгаа нь сонсогдох шиг. Арай түрүүний зоорины хаалгыг хаасан этгээд тэр дээр бйгаа юм биш биз гэсэн бодол ч Галсанд төрж дээшээ яаран зүтгэсээр. Одоо зоориноос гарахад шатны тав эсвэл зургаан гишгүүр л үлджээ. Галсан байдгаараа тонгойж нэг гараараа дүүгээ түшиж нөгөө гараараа шатны гишгүүрээс зулгаана. Дүүгээ нуруундаа үүрч авирч байгаа болохоор Галсанд дээшээ өнгийн харах ч боломж байсангүй. Ашгүй галын өрөөнд хэн нэгэн орж ирэв бололтой хөнгөн хөлийн чимээ гарснаа Хэрлэнгийн “Ээж ээ” хэмээн уулга алдан цочих нь сонсогдов. Тэгмэгц Галсан амандаа зуусан гар чийдэнгээ унагаад “Хэрлээн би энд байна” хэмээн хоолойныхоо чадлаар хашхирлаа.

-Галсаан чи юу. Чи тэнд байна уу?

-Тийм ээ, би байна. Түргэн ирээд туслаарай.

Хэрлэн сая нэг нээлттэй байгаа зоорь луу тонгойж харав.”Тэнгэр минь яана аа. Хурдан наашаа гараа өгөөрэй” хэмээн уйлагнан дуугарсаар Хэрлэн нөхрийн нь нуруун дээр ухаангүй гулдайн хэвтэх Батжаргалын мөрнөөс зуураад авлаа. Хэрлэн Оюунчимэгийг хэдэнтээ дуудан хашхирав. Ингэсээр Оюунчимэгийг ирэхээс өмнө эхнэр нөхөр хоёр дээр доороосоо дэмнэн эцсийн хүчээ шавхан байж Батжаргалыг арайхийн зоориноос гаргалаа. Батжаргалын хөлнөөс цус алдсан хэвээрээ байх бөгөөд араас нь Галсан арайхийн гарч ирээд түрүүлгээ харан унаад өгөв. Галсан бүх хүчээ шавхжээ. Зооринд байсан энэ хэсэгхэн хугацаа нь бүр хэдэн сар жил болов уу гэлтэй санагдаж байв. Галсангийн ар нуруу нь тэр аяараа улаан цусанд будагдсан байхыг хараад Хэрлэн муухай хашхиран яахаа мэдэхгүй сандарна. Ингэхэд нь Галсан арайхийн сэхээ авч эхнэрээ тайвшруулахыг оролдож эхэллээ.

-Миний хөгшин битгий санаа зов. Би яагаа ч үгүй. Батжаргал хөлөндөө бэртчихсэн, хурдхан шиг боогоод эмч дууд.

-Чиний ар нуруу чинь тэр аяараа цусанд будагдчихаж. Та хоёр яах гэж доошоо орсон юм бэ?

-Миний цус бишээ. Би яагаа ч үгүй. Батжаргалын хөлнөөс цус алдаад балрах нь.

Хэрлэн яахаа мэдэхгүй сандран зогссоноо “Оюунчимэг ээ, чи яачихав аа” хэмээн уурсан хашхирлаа. Очиж явна аа одоохон эгч ээ гэсээр Оюунчимэгийн яаран гүйх чимээ сонсогдов. Галсан Хэрлэн хоёр Батжаргалыг орон дээр аваачиж хэвтүүлэх санаатай хоёр талаас нь яаран өргөж эхлэхэд Оюунчимэг сая галын өрөөнд орж ирэв.

-Оюунчимэг ээ, миний дүү Батжаргал ахын чинь хөлөөс цус алдаад балрах нь, хурдхан шиг түргэн дуудаарай хэмээн хамаг хөлс нь цутгасан Галсан аахилахынхаа завсраар яаран хэллээ.

Гэтэл Оюунчимэг ёстой л нөгөө чөтгөр харав уу гэлтэй царай нь хувхай цайж хөшиж орхих нь тэр.

-Үгүй чи чинь яачихав аа хэмээн Хэрлэн тэсвэр алдан дүү рүүгээ хашхирахад Оюунчимэг “Энэ хэн бэ?” хэмээн Батжаргал руу зааж сулхан асуугаад ухрав.

-Оюунаа чи чинь солиорчихоо юу. Батжаргал ах нь байна шүү дээ. Тэр үхэх нь, чамтай тоглож байх чадал алга хурдхан шиг явж түргэн дууд сонсов уу?

-...Батжаргал ах дээр байсан

Оюунчимэг ийнхүү дуулдах төдий хэлээд буцаад дээд давхар луу ар нуруугаараа ухарсаар авирлаа.

## XIV

Батжаргалыг дамжлан өргөж унтлагынхаа өрөөний орыг чиглэн алхсан эхнэр нөхөр хоёр Оюунчимэгийн саяын үгийг сонсоод хоёр бие рүүгээ зогтусан гайхан харлаа. Батжаргалыг орон дээр хэвтүүлмэгцээ тэд хөлийг нь яаран боох ажилдаа шамдав. Ядахад цэвэр даавуу олохгүй байсан учир цагаан хэрэглэлээ ханз татан боож цусыг нь тогтоов.

Гэтэл Оюунчимэг буцаж ирээд тэднийг харан зогсож байснаа “Батжаргал ах яалт ч үгүй дээр байна” гэж хэлээд ухаан алдан уналаа. Батжаргал дээр байна гэсэн энэ үг хэний ч гайхлыг төрүүлж анхаарлыг нь татахуйц байсан ч Галсан Хэрлэн хоёр нүдэн дээр нь ухаан алдаад уначихсан дүүдээ яалт ч үгүй санаа тавихаас өөр аргагүй болов. Тэд сандралдан Оюунчимэгийг Батжаргалтай зэрэгцүүлэн хэвтүүлээд сэргээх гэж аль байдгаараа оролдлоо. Оюунчимэг сэргэхгүй байх бөгөөд энэ үед Хэрлэн бүр яахаа мэдэхгүй сандарч нус нулимстайгаа холилдон зогсоход Галсан харин хаа очиж сэхээтэй байв.

-Хэрлэн, чи дэмий уйлж байхаар гарч хөршүүдээс тусламж дуудаад хэнийг ч хамаагүй дагуулаад ирээч.

Юу хийхээ мэдэхгүй сандрал зогссон Хэрлэн нөхрийнхөө энэ үгийг сонсоод год үсрэн гарлаа. Аль хэдийнэ шөнө болж айл амьтан унтжээ. Хэрлэн нэг л мэдэхэд өнөөх өөрийг нь халгаагагүй айлынхаа хаалгыг аврал эрэн балбаж байх нь тэр.

Удалгүй “хэн бэ” гэсэн цахиртсан хоолойтой хөгшин эмгэний дуу хаалганы цаанаас сонсогдов.

-Ах аа туслаарай манай гэрт хүн үхэх нь. Гуйж байна хаалгаа тайлаач дээ. Хэрлэнг ингэж хэлээд одоо хаалганы түгжээ тайлагдана хэмээн тооцоолж хүлээв. Хэдий хаалга нээгдэх хугацаа өнгөрсөн ч таг чиг. Хэрлэн яахаа мэдэхгүй дэмий л амьсгаагаа даран чимээ чагнан хүлээлээ.

-Наад айл чинь хаалгаа тайлахгүй ээ гэсэн жаахан эмэгтэй хүүхдийн дуунаар Хэрлэн салгалтал цочин эргэн харлаа. Дахиад л өнөөх Цэнгэл охин байв. Тэрээр өнөөх л дүрэмт хувцастайгаа зэвхий царайлан өөрийг нь ширтэж байгааг хараад айсандаа Хэрлэнгийн ухаан балартаад ирэх шиг боллоо. Өнөөг хэр нь хаалгаа тайлаагүй байгаа хөршийн том модон хаалгыг нуруугаараа налж зогссон Хэрлэн хэл амаа арайхийн эвлүүлэн байж дуугарлаа

-Чи яах гэсэн юм бэ, юу хэлэх гэв?

-Чи бас чиний нөхөр чинь ч үхнэ. Цэнгэл ингэж хэлээд Хэрлэнгийн нүд рүү надаас дахин юу асуух вэ гэсэн шиг өнөөх хүйтэн харцаараа нүд цавчилгүй ширтлээ. Хэрлэн дэмий л мэгшиж хөршийнхөө хаалгыг нуруугаараа налан доошоо суугаад сульдаж тамирдсан гараараа арай ядан цохилгов. Хөршүүд нь ямар ч хариу өгөхгүй нам жим хэвээрээ. Хэрлэн гүнзгий амьсгаа аваад дахин асуулаа

-Чи миний охинг яасан? Саруул хаана байна?

-Зоорин дорх шороогоо ух. Цэнгэл ингэж хэлээд харанхуйд замхран алга болов. Хэрлэн жаахан тайвширчээ. Тэрээр өндийж ирээд энэ айл хаалгаа тайлахгүй юм байна гэдгийг мэдээд хар тэнхээгээрээ хаалгыг хэдэнтээ өшиглөв. “Хувиа хичээсэн новшнууд минь наад муу өмхий байшиндаа илжирч үхээрэй. Мэдэв үү” гээд эргэтэл харин араас нь байшин дотроос түрүүний эмгэн “Бид биш та нар л үхнэ дээ” гэж хариулах нь тэр. Хэрлэн тэссэнгүй дахин очиж хаалгыг балбалаа.

-Та хаалгаа тайлаач. Ярилцъя, яагаад бид үхнэ гэж, хариулаач дээ. Наад хаалгаа одоохон тайл. Бидэнд туслаач дээ, гуйж байна Хэрлэн ийнхүү хичнээн учирласан ч хөрш нь хаалгаа тайлсангүй. Галсангийн хажуу хөршүүд нь ч гэсэн ямар нэгэн айдаст автан амьдардаг бололтой. Уг нь шөнө үдшийн цагаар ганц эмэгтэй хүн ингэж уйлж учирлаж байхад хэн ч байсан ядаж хаалгаа тайлж тайвшруулах ёстой баймаар. Гэтэл тэгсэнгүй. Магадгүй хаалгаа л тайлах л юм бол гэрт нь үхэл орж ирээд бүгдийг нь там руу аваад явах гэж байгаа юм шиг аашлах нь Хэрдэнд даанч эмэгнэлтэй байлаа.

-Чи чинь яачихав аа гэх нөхрийнхөө дуунаар Хэрлэн сая сэхээ авсан мэт эргэн харлаа.

-Энэ айл дотор нь хүн байгаа хэрнээ хаалгаа тайлахгүй байна.

-Орхи цаашаа. Батжаргал Оюунаа хоёр хоёулаа ухаан орсон, түргэн ч дуудсан хоёулаа гэртээ орьё гэж Галсан хэлээд Хэрлэнгийн гараас хөтлөн гэр лүүгээ алхахыг завдлаа. Галсан дэндүү их тэвчээр гаргаж байв. Үнэндээ түүнд гайхах эргэлзэх бас айх зүйл мундахгүй их байгаа ч энэ бүхнийг түр мартаад дүүгийнхээ амийг аврах талаар санаа тавин гэж өөрийгөө чадах ядахаараа хянан эрүүл ухаанаар асуудалд хандах гэж оролдоно. Харин Хэрлэнгийн хувьд бараг л хагас галзуурлын байдалд оржээ. Ор сураггүй алга болсон охиндоо санаа зовохын хажуугаар гэнэтийн маш олон үйл явдал айдас түгшүүрт автсаар ёстой л нөгөө орон гаран амьтан болон хувирчээ. Хэрлэн нөхөртөө саяын Цэнгэл охины тухай хэлэх гэсэн ч хамаг үг нь хоолой дээр нь ирээд гацчихсанд дэмий л нөхрөө тэврэн асгартал уйлсаар ухаан алджээ.

... Нэг л мэдэхэд Хэрлэн толгой дээрээ хүйтэн жин тавиулсан гэртээ хэвтэж байлаа. Нүдээ нээж орчин тойрноо сайтар ажиглав. Аль хэдийнэ гэгээ орсон байх бөгөөд Батжаргал Оюунчимэг хоёрыг хэвтүүлж байсан өнөөх унтлагын өрөөний өргөн орон дээрээ ганцаараа хэвтэж байв. Дөнгөж өндийтөл өөдөөс нь Галсан уур савссан цай, шөл, талх зэргийг цайны тавиур дээр барьсаар орж ирлээ.

-Өө ашгүй дээ. Чи минь сэрчихээ юу. Зөндөө их санаа зовлоо шүү. Яаж байна?

-Батжаргал, Оюунчимэг хоёр яасан? Хэмээн Хэрлэн асуултыг асуултаар хариуллаа.

-Батжаргал эмнэлэг хүргэгдсэн. Харин Оюунаа дээд давхарт байгаа.

-Тэгвэл би яасан хэрэг вэ. Юу ч санахгүй байна.

-Миний хайрт одоо тархиа их ажиллуулах хэрэггүй ээ. Эмч чамайг маш их айж ядарсан байна гэж хэлсэн. Чи өчигдөр шөнө гадаа намайг тэврээд уйлж байснаа гэнэт л ухаан алдаад унасан. Азаар түргэн ирж байсан болохоор чамайг жаахан сэргээгээд тайвшруулах тариа хийгээд унтуулсан. Олигтой хоол идэхгүй, үргэлж сэтгэлээ зовоосоор байгаад ядаргаанд орсон байна. Чамайг сайн амарч хоол унд идээд биеэ сайн тордох хэрэгтэй гэж эмч хэлсэн.

Хэрлэн уртаар санаа алдаад буцаж хэвтлээ. Цагаан халаадтай хоёр эмэгтэй ирж өөрт нь тариа хийж Галсан тэдний хажууд зогсоод өөрт нь тариа хийж Галсан тэдний хажууд зогсоод өөр лүү нь санаа зовсон нүдээр тасралтгүй ширтэж байсан нь бүүр түүрхэн санаанд нь орох шиг болов.

-Саруул ирээгүй биз?

-Ирээгүй, ямар ч сураг хэвээрээ л байна. Миний хань одоо битгий хямар. Ингэсээр байгаад бүр дордоод охиноо ирэхэд хэвтэрт орчихсон байвал яана. Галсан ингэж хэлэхдээ зориуд эхнэрээ тайвшруулахыг хичээсэн нь андашгүй аж. Хэрлэн үүнийг нь хэдий мэдэж байсан ч сэтгэл нь жаахан уужраад ирэх шиг болжээ.

Галсан эхнэртээ шөл халбагадан уулгаж аль болох сэтгэлийг нь сэргээх гэж сайн сайхан үгс хэлнэ. Үнэндээ Галсангийн сэтгэл тийм гээд илэрхийлэхийн аргагүй шаналж, айдас түгшүүр түнсэн янзын эргэлзээндээ төөрч хямралдан байсан ч ямартай ч эхнэрээ халамжлан тайван байлгах гэж ийн хичээж байгаа нь аргагүй бахархмаар. Галсангийн сэтгэл гарган чамгүй халамжилсны ачаар Хэрлэн овоо дээрдэн өндийгөөд ирлээ. Өчигдөр шөнө Батжаргалын хөлийг боохдоо дундуур нь цуулж сиймхий болгосон хөнжлийн даавууг Хэрлэн анзаарч хармагцаа нэгийг санав бололтой Галсан руу хараад асуув.

-Батжаргал тэгээд гайгүй юу. Аймар их цус алдаж байсан?

-Ямар ч байсан ухаан орсон. Гайгүй байхаа. Гэхдээ ярихгүй байсан.

-Ер нь өчигдөр та хоёр яагаад зорь луу орсон юм бэ?

-.../Энэ асуултанд Галсан хариулах шаардлагагүй гэж үзсэн бололтой/

-Тэгээд тэр зорин доор юу байна?

-Ямар ч байсан их хүйтэн байна лээ

-тэнд юу байна вэ гэж асуусан болохоос биш хэр зэрэг хүйтэн байна гэж асуугаагүй шүү дээ

Хэрлэнгийн ингэж бухимдан асуусан нь нэг бодлын аргагүй байлаа.

Өмнө нь үргэлж доороос нь цохиж үл мэдэх чимээ гарч байсан тэр харанхуй нүхэн дотор юу байсан бол гэдгийг олж сонсохсон гэхээс байж ядна. Галсан юу гэж хэлэхээ мэдэхгүй дэмий л эхнэрийнхээ царай руу харан хөмсгөө зангидан сууж байлаа. Хэрлэн хүлээж тэссэнгүй үргэлжлүүлэн асуулаа.

-Батжаргал яагаад тэгж айхтар бэртчихсэн юм бэ. Арай та хоёр муудалцаж тийм байдалд хүрсэн юм биш биздээ?

-За үгүй дээ. Бид хоёр яалаа гэж муудалцах билээ. Өчигдөр та хоёрыг автобусны буудал руу явсны хойгуур чинь Батжаргал надад зорь луу орох санал тавьсан юм. Тэгээд л хамтдаа доошоо орсон. Зорин доор юу ч байж мэднэ гэж бодож байсан болохоор бид өөрсдийгөө зэвсэглэсэн. Тэгээд гар чийдэн тусгаад шат тавиад буухад төсөөлж байснаас харьцангуй гүнзгий байсан. Удалгүй бид хоёр зоорины ёроолд хүрсэн.

-Тэгээд? Хэрлэн Галсангийн тэртэй тэргүй ярьж байгаа яриаг ийн таслан асуух нь дараа нь юу болсон бол гэдгийг мэдэхсэн гэхээс байж ядан байгааг нь илэрхийлж байлаа.

-Тэнд маш хүйтэн, харанхуй байсан. Шуудайлж хэрэггүй болсон новш л байгаа бололтой харагдсан шүү. Тэгтэл гай болж хэн нэгэн нээлттэй байсан зоорины хаалгыг хаачихсан. Гайхаад байж байтал гэнэт л миний хөлнөөс хэн нэгэн зуураад авах шиг санагдахад би айсандаа дээшээ зүтгэсэн. Галсан ингэж хэлээд дахин өчигдөрийнхөө айдаст автав бололтой дуугаа хурааж зорь байгаа галынхаа өрөөг тусгаарласан хана руу айдас хурсан нүдээр харлаа.

-тэгээд дараа нь юу болсон бэ? Яриач дээ?

-Тэгээд үү, бид хоёр дээшээ зугтсан. Галсангийн ингэж хэлэхэд түүний нүдэнд өчигдрийн зооринд байсан тэр бүх зүйл, үйл явдал дахин үзэгдэж байгаа бололтой. Тэрээр дуу нь сулран хөмсгөө зангидан ярьж байлаа.

Миний гартаа атгасан бороохой нэг мэдэхэд л гээгдчихсэн байсан. Би хамаг хурдаараа дээүүээ зүтгэж байхад Батжаргал миний араас авирч намайг яаруулж байлаа. Бидний доороос нэг тиймэрхүү чахарсан чимээ сонсогдох шиг болж хэн нэгэн хөөх шиг санагдсан. Байдаг хурдаараа дээшээ зүтгэсээр арай хийж зоорины хаалганд тулж ирэхэд гацчихсан байдаг байгаа. Шууд түлхэж хүрэхгүй байсан болохоор би Батжаргалын мөрөн дээр гишгээд хүчлэн түлхсэн. Гэвч нээгдээгүй. Би үнэндээ Батжаргалын юу гэж хэлээд байгааг нь сайн сонсож чадаагүй. Маш их сандарсан байсан. Ямар ч л байсан Батжаргал намайг амь тэмцэн яаруулж байгааг нь л мэдсэн. Өнөөх доороос дуулдаж байсан чимээ бид хоёр луу улам ойртож бараг тулаад ирэх үед зоорины хаалга арайхийн нээгдсэн. Тэгээд намайг тэр хараал идсэн зоориноос гарч ирэхэд Батжаргал араас гарч ирээгүй. Би буцаж ороод Батжаргалыг ухаангүй хэвгэж байгааг олсон. Батжаргал зоориноос гарах гээд шатаар өгсөж байхдаа санамсаргүй халтираад өөрийнхөө хутганд өртчихсөн юм билээ. Тэгээд үүнээс хойш юу болсныг нь чи мэдэж байгаа.

-Намайг ухаан алдсаны дараа юу болсон бэ?

Хэрлэнгийн энэ асуултыг сонссон Галсангийн царай өөрийн эрхгүй хувираад ирлээ. Хэрлэн нөхрийнхөө баргар царайнаас ямар нэгэн таагүй явдал болсныг гадарлаж түүнийг нь нөхөр нь өөрөөс нь нугаад байгааг мэдэх шиг боллоо. Галсан түүний асуултанд хариулахгүй чимээгүй суусаар байсанд Хэрлэн тэссэнгүй.

-Ингэхэд Оюунчимэг яасан бэ? Батжаргал ах дээд давхарт байна ч гэх шиг нэг хачин юм яриад байсан?

## XV

Галсан эхнэрээ ийн асуухад тааз руугаа ширтсэнээ юу ч дуугарсангүй биеэ хураан суув. Гэтэл гэнэт дээд давхарт Оюунчимэгийн тачигнатал хөхрөөд гүйх чимээ сонсогдов. Тэрээр дээд давхарт хэн нэгэнтэй тоглож байгаа бололтой. Хэрлэн хүзүүгээ өргөн дээшээ тааз ширтэж байснаа нөхөр лүүгээ харан асуулаа.

-Оюунчимэг дээр хэнтэй тоглоод байгаа юм бэ?



-...

-Хариулаач. Би галзуурах нь.

-Батжаргалтай

-Галсаан, чи чинь солиорчихоо юу. дөнгөж сая Батжаргалыг эмнэлэгт хэвтүүлсэн гэж хэлээ биздээ

-Тиймээ

-Тэгээд?

-Бас нэг Батжаргал байгаа юм байлгүй дээ

Хэрлэн тэссэнгүй. Хөнжлөө хуу татаж хаяад дээд давхар луугаа очихоор өндийлөө. Түүнийг дөнгөж өндиймөгц дахин толгой нь эргэж эгээтэй л уначихсангүй тул Хэрлэн хэдэн хором хөдлөлгүй зогсож байгаад дээшээ гүйлээ. Харин Галсан эхнэрээ хорьсонгүй араас нь ч дагасангүй. Оюунчимэг өрөөнд хүн орж ирсэнийг ч анзаарах сөхөөгүй хана руу харан сууж хэн нэгэнтэй ярилцана. Хэрлэн үнэхээр нүдэндээ итгэсэнгүй. Түүнийг харсаар атал энэ өрөөнд ганцхан Оюунчимэг байх аж. Тэгсэн хэрнээ л нүдэнд үл үзэгдэх хэн нэгэнтэй оройн хоолон дээр юу тдэх тухай ярилцаж амаа таглан хүзүүгээ савлан хөхрөх нь эрхгүй айдас төрүүлмээр.

-Оюунчимэг ээ, миний дүү хэнтэй яриад байгаа юм бэ? Хэрлэнг ингэж асуухад Оюунчимэг сая яриагаад зогсоолоо. Тэрээр Хэрлэн рүү хагас эргэж хараад “чшшшш..... аяархан Батжаргал ах их өлссөн учраас ууртай байгаа. Та яваад хоол хийж бай” гэх нь тэр.

Солиорчихжээ, солиорчихож хэмээн Хэрлэн амандаа үглэсээр доошоо буух гэж гүйх замдаа Галсантай мөргөлдлөө. Оюунчимэг дахиад хана руу харан ганцаараа яриагаад шивнэн ярьж байлаа. Галсан Оюунчимэгийн өрөөний хаалгыг хаагаад эхнэрээ дагуулан доошоо буухыг завдан гарыг нь атгав.Хэрлэн бүр хямарч орхижээ.

-Яагаад, яагаад ийм юм болж байгаа юм бэ. Би итгэхгүй байна. Энэ бол зүүд% би сэрмээр байна. Бас чи наад гараа тат мэдэв үү

-Миний хайрт тайвшир даа. Хоёулаа доошоо бууж ярилцъя.

-Үгүй ээ. Юу ярих юм бэ. Ярих юм юу ч байхгүй. Бидний амьдрал нүдэн дээр сүйрч байна, чи ойлгож байна уу. Яриад байх юу ч байхгүй дууссан. Саруул алга болсон.Магадгүй үхсэн. Хэрвээ амьд байсан бол гэртээ ирэх л байсан. Ирж чадахгүй боломж байдаггүй юм аа гэхэд ядаж өдийд сураг нь гарах болсон, тийм биздээ.

Галсан эхнэрийнхээ энэ асуултанд хариулсангүй. Үнэндээ Хэрлэнгийн хэлсэн саяын үг бүхэн үнэн гэдгийг Галсан дотроо хүлээн зөвшөөрч байв.

-Чи хариулаач, тийм биздээ. Оюунчимэг солиорчихож. Ердөө л манайд ганц хонохын дотор л

солиорсон байна. Батжаргал ч гэсэн эмнэлэгт юм ярьж чадахгүй шаналан хэвтэж байгаа. Бидний хайртай нохой ч бас үхсэн. Одоо зөвхөн бид хоёр л үлдлээ. Гэхдээ бид хоёр ч бас удахгүй, магадгүй өнөөдөр үхнэ. Энэ бүх юм асар хурдан болж байна. Тийм ээ яг тэр хөрш айлын тэр новшийн эмгэний хэлснээр бид мөдхөн үхнэ.

-Хөршийн эмгэн биднийг үхнэ гэж чамд хэзээ хэлээв?

-Өчигдөр шөнө. Тэрний хэлсэн яг үнэн байхаа. Би зөнгөөрөө мэдэрч байна. Бас тэр зэвхий царайтай зэтгэрийн охин ч гэсэн биднийг үхнэ гэж хэлсэн. Бас зоорин доорх шороогоо ух ч гэнэ үү нэг юм хэлсэн. Хэрлэн ингэж хашхиран хэлээд эхэр татан уyllлаа. Галсан эхнэрийнхээ саяын хэлсэнийг сонсоод хөшиж орхих нь тэр. Нээрээ бид мөдхөн үхэх байх даа гэсэн бодол Галсанд төржээ. Энэ бодол нь түүнд үнэхээр санагдаж байсан ч үхлээ хүлээж болж байгаа муу бүхэнтэй эвлэрч суух нь дэндүү ичгүүртэй санагдав. Ингээд Галсан Хэрлэнг тайвшруулж доод давхартаа хамтдаа бууж ирлээ. Галсан Хэрлэнг сэрэхээс өмнө зоорины тагийг бүдүүн дөрвөлжин модоор шалтай нь холбон хадаж орхижээ. Ингэснээр галын өрөөнд суух нь арай л тайван мэт болжээ. Тэд түргэн дуудаж Оюунчимэгийг хэвтүүлэх тухай ярилцав.

Үүрээр Хэрлэнг ухаан алдсан хойгуур Оюунчимэг сэргэж эрүүл хүн шиг л Батжаргалыг машинд оруулахад нь тусалсан гэнэ. Тэгээд түргэний машиныг явсны хойгуур дээд давхартаа Батжаргал ах намайг дуудаад байна гээд л хий юмтай ярьж эхэлсэн ажээ. Галсан эхнэрээ сахих хэрэгтэй байсан учраас Батжаргалыг дагаж эмнэлэг рүү явсангүй, харин өглөө очихоор болж эмч сувилагч нарын нь утасны дугаарыг авч үлдээд бусад ах дүү нартайгаа холбоо барьж Батжаргалыг хэвтүүлсэн эмнэлэг рүү явуулжээ.

Эхнэр нөхөр хоёрыг ийнхүү ярилцан суутал Оюунчимэг буугаад ирэв. Түүний нүдний харц тогтохгүй түргэн түргэн эргэлдэж ямар нэгэн зүйлийг хайна. Тэгснээ яагаад одоо болтол хоол хийгээгүй байгаа юм бэ? Хэмээн Хэрлэн рүү уурсан харав.

-Миний дүү өлссөн юм уу. Эгч нь одоохон хоол хийгээд өгье гээд Хэрлэн сандал дээрээсээ яаран бослоо. Хэрлэнгийн энэ үйлдэл нэгэнт сэтгэц нь өөрчлөгдөөд байгаа дүүгээ аргадан тайвшруулах гэснийх байлаа.

-Би өлсөөгүй ээ. Харин Батжаргал ах өлсөөд байна. Гоё амттай хоол хийгээрэй тэгэхгүй бол тэр идэхгүй шүү

Хэрлэн юу ч хариулж чадсангүй. Харин Галсан миний дүү ч гэсэн хоол идээрэй гэж хэлээд түрүүн Хэрлэнд зориулж буцалгасан шөлнийхөө үлдэгдлийг Оюунчимэгт савтай нь авч өгөв.

Оюунчимэг яг л жаахан хүүхэд шиг баярлажээ. Одоо бид хоёр хоолтой болсон доо, гоё доо хэмээн тэрээр амандаа шулганасаар жижиг савтай шөл хоёр гартаа барьсаар дээд давхар өөд яаран гарав. Галсан Хэрлэн хоёр ч араас нь дагалаа. Оюунчимэг өнөөх л дээд давхрын жижиг өрөөндөө оронгуутаа хаалгаа хаагаад замган түгжээгээр нь түгжчихэв.

Галсан Хэрлэн хоёр яаж ч чадсангүй хаалганы гадаа үлджээ. Түгжээг нь эвдээд хойноос нь орж болох байсан хэдий ч тэртэй тэргүй солиорчихоод байгаа хүнийг бүр их догшруулж мэднэ хэмээн болгоомжлов.

-За аа май Батжаргал ахаа цадталаа иднэ шүү

Оюунчимэгийн саяын хэлснийг сонссон Хэрлэн тэссэнгүй шууд л гар утсаа шүүрч аваад эмнэлэг рүү залгаж “Хүн солиорчихоод байна. Түргэн ирээрэй” гэж хашхирах шахам хэлээд хаягаа зааж өглөө. Харин Оюунчимэгийн хувьд өрөөний гадна юу болж байгаа нь огтхон ч падгүй байгаа бололтой. Эхнэр нөхөр хоёр өрөөний гадна яахаа мэдэхгүй зогсч байснаа түргэний машин иртэл доод давхартаа хүлээж байхаар шийдэж буув. Тэдний охиноо ирнэ гэсэн сэтгэл найдвар бараг бөхжээ. Гэхдээ л юмыг яаж мэдэхэв гэсэн шиг сэтгэлдээ битүүхэн харуулдсаар байх аж. Түргэн дуудаад бараг хоёр цаг болсон хэдий ч ирсэнгүй. Оюунчимэгийн дээд давхарт ярих нь үе үе сонсогдож байсан ч хашхирч сүйд болсонгүй тайван байв.

Оюунчимэгийн хувьд оюутны дотуур байранд амьдардаг одоохондоо Хэрлэнгээс өөр тулж түших хүнгүй байгаа нэгэн. Хотод байдаг ганц эгч нь Хэрлэн бөгөөд тэдний хөгшин аав ээж ах дүүс нь цөм хөдөө амьдардаг билээ. Харин Батжаргал Галсан хоёр хотод олон ах дүүстэй болохоор Батжаргалын хэвтэж байгаа эмнэлэгт Галсангаас бусад бүх л ах дүүс нь цуглараад байгаа сурагтай. Галсан Батжаргалын биеийг утсаар лавлан асуусаар байгаа бөгөөд Оюунчимэгийг эмнэлэгт хэвтүүлмэгцээ яаран очихоор шийдээд байжээ. Түргэн дуудсанаас хойш нэлээд хэдэн цаг өнгөрч үд болох дөхөж байсан ч өнөөх эмнэлгийн машин нь таг чиг. Хэрлэн тэсэлгүй сүүлчийнхээ нэгжээр дахин залгаж дуудлага өгсөн тухай сануулахад танайхыг олохгүй байна гэж хариулаад дахин заалгаж байтал утас нь тасарлаа. Гай таарч яг хэрэгтэй үед утасных нь нэгж дууссанд Хэрлэн бухимдахын дээдээр бухимдав. Эхнэр нөхөр хоёр яах ч аргагүй болжээ. Гадагшаа дэлгүүр лүү гарч нэгж худалдаж авья гэхэд гар утасны карт зардаг дэлгүүр чамгүй хол. Галсанг тийшээ явья гэхэд Хэрдэн энэ байшинд чамгүйгээр ганц ч хором байж чадахгүй гээд явуулсангүй. Хоёул хамт явья гэхэд Оюунчимэгт санаа зовоод болсонгүй. Магадгүй ийм байдалтай байгаа хүн өөрсдийг нь эзгүйд хашаа байшингаа шатаах эсвэл бүр амиа хорлож ч мэднэ хэмээн болгоомжлосондоо тэд хамт явахаас татгалзжээ. Гэвч утсандаа нэгжгүй, бусадтай холбоо барих боломжгүй бол бараг л амьдрал зогссоноос ялгаагүй байсан учраас Оюунчимэг ганцаараа дэлгүүр явахаар болов. Ингээд Галсан хий юм харж хий юмтай яриад байгаа өөрөөр хэлбэл байхгүй байгаа Батжаргалтай жигтэйхэн сайн найзалж байгаа Оюунчимэгийг эхнэрээ иртэл ганцаараа харгалзаж байхаар боллоо.

Гадаа маш хүйтэн байгаа блохоор Хэрлэн хэчиээн зузаан дулаан хувцсаа өмссөн ч даарч байлаа. Өчигдөр шөнө хямарч ухаан алдсанаас болж бие нь халуурч байгааг тэрээр мэдэж байсан ч утсандаа нэгж худалдаж авахыг чухалчлан яаран алхсаар. Бас юмыг яаж мэдэхэв хөөрхий нялх охиноос минь сураг гарсан ч юм билүү цагдаагийн газар луу утасдаж лавлая гэж өөртөө хэлж байлаа. Хэрлэн хагас цаг илүүтэй алхаж байж сая нэг юм арайхийн дэлгүүрийн гадаа ирсэн ч хаалттай байх нь тэр. Хэрлэнгийн урам хугарч цоожтой дэлгүүрийн өмнөх довжоон дээр хэсэг сууж амсхийлээ. Нэгэнт энд ирчихээд хоосон буцна гэхээс уур нь хүрч утасны нэгжийн карт зардаг дараачийн дэлгүүр лүү явахаар шийдлээ. Ядаж байхад Хэрлэн ямар ч илүү мөнгө авч гарагүй болохоор цаашаа унаанд сууж явах ямар ч боломж байсангүй. Хэрвээ алхвал очих ирэх нь нийлээд ойролцоогоор хоёр цаг болохоор зайтай байв. Гэсэн ч Хэрлэн алхахаар шийджээ. Хэрвээ одоо түргэлэхгүй бол гэр лүүгээ буцаж явж мөнгө авсаар байтал дэлгүүр хааж мэднэ хэмээн тэрээр өөртөө хэлэв. Ийнхүү гараа халаасандаа хийн зам даган яаран алхах хөөрхий бүсгүй гэрт нь ямар аймшигтай зүйл болох гэж байгааг хэрхэн төсөөлөх билээ.

Галсан эхнэрээ явсаны дараа хөршийнхөө хүнтэй уулзахаар хаалгыг нь тогшиж үзсэн ч нэмэр болсонгүй. Зүс таних хөгшин эмгэн цонхныхоо хаалттай хөшигний завсраар сэмхэн харснаа цааш орохыг Галсан харж амжжээ. Галсан “Би хажуу айлын чинь хүн байна аа. Яагаад хаалгаа тайлахгүй байгаа юм бэ?” хэмээн чанга дуугаар асуусан ч хэн ч хариу хэлсэнгүй. Хаалгыг нь тогшсоор байсан ч таг чиг хэвээрээ байсан болохоор Галсан орхи цаашаа хэмээн өөртөө хэлээд газар нулимж гэртээ орлоо. Оюунчимэг таг чимээгүй болжээ. Түргэний тэрэг ирээгүй хэвээр. Галсан гэртээ ороод хэсэг азнаснаа охиныхоо зургийн цомгийг гаргаж үзлээ.

Саруулын бүр нялх балчир байх үеийн нь бүх л дүр төрх аз жаргалтай дурсамжууд Галсангийн нүдний өмнө амилан босч ирэх шиг л болов. Галсан охиноо үнэхээр их санажээ. Аавынхаа хүзүүн дээр мордож алсыг харна гэж эрхлэхэд нь загнаж болиулж байснаа бодоод хоолой нь зангираад ирэв. Нэг удаа төрсөн өдрөөр нь охиноо эрхлүүлж өдөржин хүзүүн дээрээ суулгаж тоглосон. Тэр үеэс хойш саруул ааваараа бахархаж “Миний аав их өндөр, том биетэй болхоор би хүзүүн дээр нь суухаараа бүхнийг харж чаддаг” хэмээн ээждээ гайхуулдагсан. Тэгээд бүр аавдаа “Алсыг харагч” гээд нэр өгчихсөн байсан нь Галсанд санагдав. Галсан өөрөө ч мэдэлгүй нэг л мэдэхэд уйлчихсан сууж байлаа. Охиныхоо өрөөнд орж хураалттай байгаа хөнжлийг нь дэлгэж үнэрлэв. Саруулын үнэр хадгалагджээ. Дотно хөөрхөн энхрийхэн охиных нь үнэр яг хэвээрээ байв. Галсан охиныхоо хөнжлийг тэврэн хэвтжээ. Энэ үед тэр тэрээр дээр галзуурчихаад байгаа Оюунчимэгийг түр мартаж орхисон бололтой. Урьд шөнө ганц ч хором цурам хийгээгүй болохоор Галсан эрхгүй ядарсан байв. Ер нь л сүүлийн өдрүүдэд сайхан унтаж байснаа тэрээр огтхон ч санахгүй байлаа. Ингээд нэг л мэдэхнээ Галсан дугхийж орхижээ. Тэрээр дөнгөж нүдээ анин зүүдэлмэгц Батжаргал өөрөөс нь аврал эрэн гараа сарвайж зоорь луу унаж байгаа дүр зураг үзэгдэн зовооно. Бас Саруул үзэгдэнэ. Охин нь хаа нэгтээ Галсангийн хэзээ ч очиж үзээгүй тийм газар ирчихээд аавыгаа ирж авна хэмээн хүлээж байх нь тэр. Гэвч Галсан зүүдэндээ Саруулын ганцаархнаа уйлж суугаа энэ газрыг хаана байдгийг ердөө санахгүй байлаа. Огт танихгүй тийм л газар охин нь өөрөөс нь аврал эрэн уйлан дуудсаар. Галсан ийнхүү аймшигтай муухайгаар хар даран зүүдэлж байсан ч сэрж чадсангүй. Бүр сүүлдээ өөрийгөө зүүдэлж байгаагаа ч тэрээр сайн мэдсэн хэрнээ энэ нь сэрэхэд нь нэмэр болсонгүй. Зүүдэндээ тарчлагдан зовсоор байгаа тэрээр хэн нэгэн хүрч ирээд гараас нь татахад л сэрнэ гэж бодож байлаа. Гэвч харамсалтай нь хэн ч түүнийг сэрээсэнгүй.

\* \* \*

Өвөл цагийн нарны илч буурсаар харуй бүрий болох дөхөөд байв. Галсангийн унтаж буй хүүхдийн өрөөний харалдаа байрлах дээд давхрын өрөөнд байгаа Оюунчимэг амьгүй мэт чимээгүй байсаар сая нэг хөлийн чимээ гаргах шиг болов. Тэгснээ Оюунчимэгийн байгаа өрөөний хаалга торхийн нээгдэж хэн нэгэн этгээдийн нэг давхар луу аяархан гэтэн буух чимээ гэрт сонсогдлоо. Удалгүй галын өрөөний хаалга нээгджээ. Гадаа харанхуй болж байгаа болохор гэр доторх эд юмс тийм ч сайн харагдахгүй байв. Галын өрөөнд орсон энэ хүн бол Оюунчимэг байлаа. Үсээ задгайлж тэр нь ширэлдэн харагдах Оюунчимэгийг өөр хэн нэгэн харж гэмээнэ давхийтэл цочих байсан нь дамжиггүй бил. Тэрээр өрөөний гэрлийг

асаасангүй. Магадгүй гэрэл гэж чухам ямар зүйл байдгийг ч мартчихсан юм билүү хэн мэдлээ. Нүүрнийхээ урд руу ширэлдэн унжсан үсийг ч хойш нь илэлгүй улаанаараа эргэлдсэн нүдээрээ том том харж тэмтчин гэтэх тэрээр ямар нэг зүйл хайгаад байгаа бололтой.

Хоол ... хоол, амттай махаар хийсэн хоол хэрэгтэй байна. Хаана байна вэ хэмээн амандаа дуулдах төдий шивэгнэх Оюунаа хөргөгч шүүгээ сэлтийг маш аажимхнаар нээж үзэх аж. Энэ нь магадгүй хэн нэгэнд өөрийгөө мэдэгдчих вий гэсэн айдас болгоомжлол сэтгэлд нь төрж байгаагаас үүдэлтэй мэт. Гэхдээ түүний энэ болгоомжлол юунд хэрэгтэй байгааг тааж хэлэхэд бэрхтэй гэмээр. Оюунчимэг идчихмээр юм олсонгүй. Батжаргал ах аа би танд заавал идэх юм олж өгнө өө хэмээн амандаа үглэсээр галын өрөөнөөс гарав. Оюунчимэг сэмхэн гэтэж байлаа. Нэг давхрын хүүхдийн өрөөний дутуу хаалганы завсраар Галснгийн унтаж байгааг тэрээр тодхон харж амжлаа. Тэгснээ сэрээчих вий гэсэн шиг буцаж өлмий дээрээ дэгдсээр дээд давхар луугаа зүглэв. Уг нь Галсан сэрүүн байсанбол яг одоо дээд давхраас дуулдаж байгаа Оюунчимэгийн яриаг сонсох байв. Гэсэн ч харамсалтай нь Галсан нойрондоо эрхгүй дийлджээ.

-Та тэгээд хоол олдохгүй байвал түүхий мах ч хамаагүй идмээр байгаа юм уу?

Хэдий Оюунчимэг үнэхээр ингэж хэлсэн ч түүнд хэн ч хариу хэлсэнгүй. Дахиад л Батжаргалтай ярьж байгаа нь тэр бололтой. Ингээд удалгүй Оюунчимэгийн орогноод байгаа дээд давхрын өрөөний хаалга хяхтнан дуугарсаар нээгдлээ. Тэр дуу яг л зүрх зүсэм гэмээр аяархан бөглүү юм шиг хэрнээ тодхон дуулдаж байсныг нэг давхарт унтаж байгаа Галсан сонсчээ. Гэсэн ч Галсан дээд давхрын өрөөний хаалга нээгдэж байна даа хэмээн зүүдэндээ мэдсэнээс биш сэрж чадсангүй.

Оюунчимэг шатаар дахин гэтсээр буугаад шууд гал тогооны өрөө рүү зүглэв. Удалгүй хөргөгчинд байсан хөлдүү махыг авч тэврээд дараа шүүгээнээс хутга аваад дээд давхар луу шатаар аяархан өгслөө. Ингэж явахдаа Оюунчимэг амандаа элдвийг үглэн үе үе амаа таглан цээжээ савлан аальгүйтэн инээх аж.

Уг нь Хэрлэн гэрийнхээ үүдэн дээр очиж буугаад таксины жолоочид гэрээсээ орж мөнгө авч өгье гэж бодсон ч машин олдсонгүй. Ийнхүү Хэрлэн яах ч аргагүй машин зам дагаж явсаар гэртээ бараг хүрээд ирлээ. Одоо зөвхөн хэдхэн гудамж сүлжээд хашааныхаа хаалганы өмнө тулж ирэх байв. Сэтгэлийг нь нэг л айдас түгшүүр эзэмдээд яаруулж байсан ч охиноо ирсэн юм биш байгаадаа хэмээн горьдлого тавих Хэрлэнг хэн нэгэн ойлгож гэмээнэ өрөвдөхгүй байхын аргагүй. Гадаа маш хүйтэн байсан ч байдгаара хурдлан бараг л гүйж яваа Хэрлэн бүр хөлөрч гүйцжээ. Ингэсээр Хэрлэн удалгүй гэрийнхээ барааг харж дотор нь бага зэрэг онгойх шиг болов. Өвөл цагийн гэгээ тасарсан харанхуй үдэш ганцаархнаа алхсандаа айсан болоод ч тэр үү Хэрлэн гэрээ хараад өөрийн эрхгүй баярлах сэтгэлд автаад байгаа нь энэ байлаа. Хашааныхаа хаалганд тулж ирээд дотогшоо орох энэ мөчдөө Хэрлэн дахин айдаст автав. Учир нь хашааных нь гэрэл унтраалттай хэвээр бах бөгөөд тэр ч бүү хэл өрөөний гэрэл хүртэл асаагүй байгаа нь харанхуйд цонхоор нь батлагдах нь тэр. Уг нь өдийд Галсан гэрийнхээ ч хашааныхаа ч гэрлийг асаачихсан байх ёстой санагдана. Гэтэл гэр гадаагүй хав харанхуй хэвээр байгаа нь Хэрлэнд яах ч аргагүй хачирхалтай санагдав. Түргэний машин ирээд Оюунчимэгийг аваад явахад нь нөхрөө хамт явсан юм болов уу гэж бодсон ч энэ бодлоо тэр дор нь үгүйсгэлээ. Учиг нь Галсан Хэрлэнг ирээгүй байхад дуудлагын эмч нартай

яасан ч хамт явахгүй гэж тохирсон билээ. Тэгээд ч өөрийг нь байхгүй бол энэ айдас муу ёр шингээсэн байшинд ганц ч хором тэсэхгүй гэдгээ Галсанд хангалттай хэлж ойлгуулсан мэт Хэрлэнд санагдана. Тэгэхээр яалт ч үгүй Галсан гэртээ байх ёстой бөгөөд харин гэрлээ асаагаагүй байгаа нь хачирхалтай санагдаж байлаа.

..... Оюунчимэг баруун гартаа атгасан том балиусаа далайсаар Галсан руу аажимхан дөхөж эхлэв. Харанхуй байшинд нүд нь цусаар эргэлдэх мэт Оюунчимэг ёстой л шар шувуу шиг харж байгаа бололтой. Тэрээр харин хашааны хаалга нээгдэж Хэрлэнг ирж байгааг мэдсэнгүй. Оюунчимэг өөрийн нь махаар Батжаргалд зоог барина гэдгийг Галсан сонссон ч сэрж чадсангүй дэмий л тийчилж байлаа. Галсан зүгээр л гарнаас нь хэн нэгэн татаад авахад сэрчихнэ гэдгээ сайн мэдэж байсан ч түүнийг хэн сэрээх билээ. Харин Оюунчимэгийг өөр рүү нь бага багаар ойртож байгааг мэдэрсээр... Балиусаа улам өндөрт далайн гүд хийтэл хоолойгоо давуулан шүлсээ залгих Оюунчимэг хөлөө чирэн өөр лүү нь ойртох нь Галсанд улам тод сонсогдож эхлэв. Одоо ердөө л тав зургаа алхахад Оюунчимэг Галсангийн унтаж байгаа хүүхдийн орны өмнө тулаад ирэх байлаа. Оюунчимэгийг өөр лүү нь ойртох тусам Галсан яраглан тарчилсаар.

## XVII

... Хэрлэн айдас жихүүдэст хүлэгдэн байшингийн хаалганы өмнө хөшиж орхижээ. Энэ хаалганы цаана юу байгаа бол гэхээс цус нь царцах шиг болж яахаа мэдэхгүй эргэлзэн зогссоор. Магадгүй өнөөх зоорин доороос самардсан ул мөр үлдээж орхисон ад зэтгэрийн этгээд өөрийг нь хүлээж хумса ирлэн суугаа ч юм билүү. Хэрлэн ийнхүү дагжин чичирсээр хаалганыхаа бариулыг атгаад авсан ч татсангүй. Хоёр хацраа давуулан нулимс урсгах хөөрхий бүсгүй өөрийн нь хайтай хамгаас илүү түшиг тулгуур нь болсон эр нөхрөө үхлийн ирмэг дээр байгааг яахан тааварлах билээ.

\* \* \*

... Галсан зүүд нойрон дундаа өөрийнхөө үхлийг хүлээж байх нь тэр. Түрүүхэн өөрөөс нь аврал эрэн уйлж зүүдлэгдэж байсан охин нь одоо аавынхаа үхлийг тохуурхан шоолох мэт ад зэтгэрийн хоолойгоор тас тас хөхөрнө. Зүүднээсээ бас нэгэн болох гэж буй аймшигт үхлээс давхар айсан Галсангийн хагас аниатай нүд нь нулимсанд чийглэгджээ. Хичнээн зоримог эр байсан ч аймшигт зүүд болох нь тодорхой айдсын өмнө ийн өвдөг сөхөрдөг ажээ.

\* \* \*

... Хэрлэн хаалгаа түлхээгүй хэвээр. Түүний санаанд гэнэт өнөөх Цэнгэлийн хэлсэн танай нөхөр та хоёр хоёулаа үхнэ гэж хэлсэн үг орж ирлээ. Бас зоорин доорх шороогоо ух гэсэн үг ч санаанд нь давхар буув. Ингээд л Хэрлэн “Арай нөхрийг маань..” гэж бодмогцоо хаалгаа зоримогхон түлхэж хонгилынхоо гэрлийг асав. Саруулын унтлагын өрөөний хаалга нээлттэй байх бөгөөд орон дээр ухаангүй мэт хэвгэх Галсанг дүрж орхихоор Оюунчимэг хутгатай гараа өндөрт далайжээ.

-Оюунаа чи яаж байна аа хэмээн Хэрлэн хоолойныхоо хамаг чадлыг шавхан хашхирав. Эгчийнхээ энэ хашхирах дуунаар Оюунчимэг цочиж эргэж харсан хэдий ч далайсан хутгаа

хаясангүй эргэж хармагцаа тачигнатал инээд алдан дүрж орхилоо. Хэрлэн хэдий хар хурдаараа харайж очоод үснээс нь зулгаан арагш нь татаж унагасан ч амжсангүй. Дүүгийнхээ гарнаас хутгыг нь салгах гэж хамаг тэнхээгээ шавхан ноцолдох Хэрлэн цурхиран уйлж байлаа. Тэрээр Галсанг үхсэн гэж боджээ. Харин аз болоход хутга Галсангийн мөрийг хальт зүсээд өнгөрсөн бөгөөд Галсан ч нойрноосоо сая л нэг бүрэн сэрсэн бололтой босоод ирлээ. Оюунчимэг, Хэрлэн хоёр ухаан жолоогүй шалан дээр өнхрөлдөн ноцолдож байв. Галсан өрөөний гэрлийг яаран асаагаад эгч дүү хоёрыг салгахаар дөхөв. Оюунчимэгийн нүүр нь цус хөлсөндөө хутгалдан харлаад хүн харахын эцэсгүй нэгэн болж хувирчээ. Чамайг ч бас алж иднэ хэмээн Хэрлэн рүү шүлсээ үсэргэн улангасан дайрах Оюунчимэгийг Галсан бүх биеэр нь тэвэрч аваад татаж холдуулах тэр агшинд тэрээр өнөөг хэр нь гартаа атгасаар байгаа балиусаараа Хэрлэнгийн хоолойг хэрччихлээ. Цус олгойдон үсэрч хамаг бие нь салганан тийчлэх Хэрлэн хариугүй амь тавих гэж байгаа нь Галсангийн нүдэнд харагдах нь тэр. Галсан хоромхон зуур Оюунчимэгийн гарыг хүчтэй цохиж хутгыг нь алдуулаад өөрийг нь өргөж аваад хана руу шидчихэв. Шалаар нэг цус болжээ. Хэрлэн хүзүүнээсээ асгарах цусаа хоёр гараараа халхлах мэт дарсан байдалтай тийчлэн хэвтсээр байгаа нь хараахан үхэж амжаагүйг нь илтгэж байв.

Галсан нэг мэдэхэд л эхнэрийнхээ дагзан доогуур гараа хийн жаахан өргөхчөө аяджээ. Хэрлэнгийн амнаас цахиртсан сөөнгө чимээ сонсогдож нүд нь томрон эргэлдэж байснаа амь тавин хөдөлгөөнгүй боллоо. Галсангийн нүднээс тасралтгүй нулимс урссаар хамаг бие нь салганан чичирч дэмий л эхнэрээ тэврэв. Галсангийн хоолой цахиртан сааралтаж чичирхийлж сөөнгөтсөн чимээ дуулдан бие нь доороо тогтохгүй займчиж эхэллээ. Өрөө тэр аяараа улаан нэлий цусанд умбаж чимээ аниргүй байдал ноёрхжээ.

-Миний хайрт үхэж болохгүй шүү хэмээн Галсан сая нэг дуулдах төдий шивнэлээ.

-Хэрлээн, миний хань битгий үх л дээ, гуйж байна. Ямар нэгэн үг хэлээч ядаж өвдөж байна гээд хэл л дээ.

Тийм, энэ бол эхнэрээсээ хагацаж туйлдаж цөхөрсөн эр нөхрийн үр байв. Хэрлэн хэрчүүлсэн хоолойгоо хэдийн хоёр гараараа дарсан чигтээ амьсгал хураасан ч одоо хүртэл цус шүүрсээр. Галсан жаахан сэхээ авч баруун гараара эхнэрийнхээ хоёр гарыг атгаад Хэрлэнгийн нэг гар нь тас атгаастай байгааг мэдрэв. Зангидсан гарыг нь тэнийлгэн үзвэл Хэрлэн өнөөх худалдаж авсан утасны нэгжийн картаа атгачихсан хэвээр байлаа.

Оюунчимэг Галсанд хүчтэй савагдан шидэгдээд ухаан алдсан байж байгаад сая сэрээд байв. Хэрлэнг ухаангүй хэвтэж байгааг хараад Оюунчимэг давхийтэл цочих нь тэр. Тэрээр яагаад өөрийгөө ухаан алдсан бас эгч нь яагаад цустайгаа хутгалдан үхэж хэвтэж байгааг ч санахгүй байлаа. Өнөөх Батжаргал ах аа гээд сүйд болж байснаа ч бүр мартчихсан өөрөөр хэлбэл оюун ухаан нь одоо л нэг хэвийн ажиллаж эхлэв. Өрөөний хана шал тэр ч бүү хэл тааз хүртэл цусанд будагдчихсан энэ нүд хальтрам дүр зургийг хараад Оюунчимэг өөрийн эрхгүй дагжин чичирлээ. Галсан жаахан сэхээ аваад Оюунчимэг өөр лүү нь айсан харцаар ширтэж байгааг сая анзаармагцаа шүдээ хавиран гараа зангидав. Тэрээр эхнэрийнхээ үхэлтэй нэгэнт эвлэрээд одоо харин өшөө авах хүсэлд автан уур хорсол нь оволзон буцалж байлаа. Саяхан Хэрлэнгийн аминд хүрсэн балиусыг хажууханд нь шалан дээр унасан байхыг Галсан хармагцаа гартаа атган босож ирэв. Хамаг хувцас нүүр царай нь улаан цусанд будагдсан

Галсангийн нүд өшөө хорслоор буцлан өөр лүү нь дөхөхөд Оюунчимэг ухаан баларттала айж амь тэмцэн зугтлаа.

## XVIII

Оюунчимэг байшингаас гарч гүйж завдсангүй. Учир нь гарах хаалгыг Галсан халхалж зогсоод өөрийг нь алах гэж занаж байсан учир тэрээр аргагүй дээд давхар луу хөлийн хурд мэдэн зугтлаа. Галсан түүний араас саяхан эхнэрийн нь аминд хүрсэн хутгыг гартаа чанга гэгч нь атгасаар “Шулам минь, хоолойг чинь хэрчээд өгье л дөө” хэмээн мацсаар. Галсангийн нүүр нь цус хөлс нулимстай хутгалдсан нь гэрэл муутай харанхуй байшинд үл мэдэг ялгаран харагдах шиг. Жигтэйхэн том биетэй ийм булиа залуу нүд нь цусаар эргэлдэн өөрийг нь алахаар хутга барин элдэж байгааг харахаар эгээтэй л зүрх нь зогсчихоо шахна. Оюунчимэг хоёр давхарт гарах хамгийн дээд талын гишгүүр дээр гишгих тэр агшинд Галсан өнөөх хурц хутгаараа хөлийн нь булчинг зүсээд амжив. Ингэхдээ Галсан шатанд бүдэрч унаад Оюунчимэгийг хараахан барьж авч чадсангүй. Оюунчимэг хазганан гүйсээр өнөөх өөрийнхөө орогноод байсан өрөөндөө ороод хаалгаа дотроос нь түгжлээ. Тэгмэгцээ нэг гүнзгий амьсгаа аваад өөрийн нь хөлнөөс айхтар их цус алдаж байгааг сая анзаарч харав. Цус маш их олгойдон гоожиж байгааг хараад эгээтэй л ухаан алдчихсангүй. Оюунчимэг хаалгаа нуруугаараа налан суужээ. Энэ өрөөний гэрэл харин асаалттай байх бөгөөд түрүүхэн өөрийгөө энд сууж байснаа Оюунчимэг огтхон ч санахгүй байлаа. Өрөөний шалан дээр энд тэндгүй махны цус дусалсан харагдах агаад нэг буланд нь дутуу хэмлэж зулгааж орхисон түүхий махны өөдөс харагдав. Гэхдээ энэ бүхнийг өөрөө үйлдсэн гэдгээ Оюунчимэг үнэндээ л төсөөлсөнгүй. Түүний нүүр нь гэсэн махны цусанд халтардаж хачин аймшигийн болж хувирсныг харин өөрөө мэдсэнгүй. Ингэтэл гэнэт Галсан хаалгыг нь цаанаас нь хүчтэй мөрлөх нь тэр.

-Гичий минь хаалгаа тайл. Би чамайг ална аа хэмээн заных Галсангийн дууны өнгө өөрийн нь мөн үү гэлтэй. Оюунчимэг хаалгаа налан суусан хэвээр.

-Галсан ахаа битгий л дээ. Би гуйж байна. Намайг битгий ал, би танд ямар ч муу юм хийгээгүй шүү дээ

Энэ гуйлтын хариуд Галсан хариу ч хэлсэнгүй. Хаалгыг нь хүчлэн балбаж зөвхөн “ална аа” хэмээн амандаа үглэнэ. Ингэхэд нь Оюунчимэг ёстой л нэг нус нулимсандаа хутгалдан хаалгыг хамаг чадлаараа даран зогслоо. Тэгснээ амь авраарай, намайг алах нь. Хэн нэг нь туслаач дээ хэмээн хоолойныхоо хамаг чадлыг бартал орилов. Энэ үед Галсан өнөөх хутгаараа нимгэн модоор хийсэн хаалгыг нэвт дүрэхэд тэр нь яг Оюунчимэгийн гарын алгыг зоож орхижээ. Оюунчимэг муухай хашхиран чарлав. Түүний энэ орилох дуу үнэхээр зүрх зүсэм, яг л амьдаараа шатаж байгаа адгуус амьтан ингэж гаслан чарлах болов уу гэмээр. Галсан хутгаа сугалж аваад ахин бүлэв. Гэхдээ энэ удаад Оюунчимэгийг оносонгүй. Оюунчимэг ч хаалганаас холдож амжжээ. Гарын нь алгыг нэвт зоосон балиусаа сугалж авах тэр агшинд үнэхээр гол тасрав уу гэлтэй аймшигтай их өвдсөн учраас Оюунчимэг ийнхүү яалт ч гүй хаалганаас холджээ. Бас дахин балиусаараа нэвт зоож мэднэ гэж болгоомжилсондоо ч тэрээр хаалганаас холдсон байж мэдэх. Харин хаалганы гадна байгаа Галсан улангасан чарлаж хутгаараа хаалгыг хэд хэдэн удаа хүчтэй бүлээд зогсоо зайгүй өшигчсөөр тэр доор нь нээж орж ирлээ. Оюунчимэгийн гар хөлнөөс нь цус тасралтгүй урсаж



тэсэхүйеэ бэрх өвдөж байв. Тэрээр өрөөний цонхонд нуруугаар тулж иржээ. Галсан хутгатай гарынхаа ар талаар нүүрээ арчаад өөр лүү нь шийдэмгий хэрнээ алгуурхан дөхлөө.

-Чиний нөгөө миний махаар хоол хийж өгнө гэсэн Батжаргал ах чинь хаана байна. Хоёуланг чинь мөчлөөд өгье

-Галсан ахаа та юу яриад байна аа. Намайг битгий алаач дээ. Би яасан юм бэ?

Галсан харин энэ асуултанд хариулсангүй. Гэхдээ энэ мөчид түүнд гэнэт эргэлзэх сэдэл төрөв. Өөрийгөө юу хийж байна аа хэмээн хянаж зогтуслаа. Харин Оюунчимэг өөрийгөө ямар ч авралгүй болсон гэж бодов бололтой Галсангийн гарт амиа алдсанаас өөрийгөө хороохыг илүүд үзжээ. Тэгмэгцээ цонхныхоо шилийг нүцгэн гараараа хага цохиод хэлтэрхийг нь хоолойдоо дүрж орхив. Цонхны шилэнд цус үсрэн будагдаж яг л түрүүний Хэрлэнгийн үхэлтэй ижлээр Оюунчимэг хоёр гараараа хоолойгоо барин татганан хэвтсээр амьсгал хураалаа. Тэрээр хэдий амьсгал хураасан ч гэсэн нүд нь хараастай хэвээр байх бөгөөд хүзүү гар хөлнөөс нь цус асгарсаар байв. Галсан хутгаа шалан дээр алдлаа. Цонх руугаа дөхөж очоод хартал өнөөх хөрш эмгэн бололтой хэн нэгэн этгээд ум хумгүй хашаанаас яаран гарах нь харагдав. Тэр эмгэн Галсанг алуурчин гэж бодсон бололтой. Галсан ч эмгэнтэй уулзаж учир явдлаа тайлбарлаж тусламж дэмжлэг хүсье гэж өөртөө хэлээд гүйн гарлаа. Хашаанд хэн ч байсангүй, бас эмгэний араас гүйцэж очлоо гэхэд эмгэн өөрт нь огтхон ч итгэхгүй харин ч бүр айчихна гэж бодоод зогтусав. Галсан эргэж байшинд орж ирлээ. Энэ үед бүр шөнө болсон байлаа. Хотоос зайдуу зэлүүд газар учраас хүн машины хөдөлгөөн бүр татарчээ.

Галсан охиных нь унтлагын өрөөнд хайртай эхнэрийн нь цусанд будагдсан цогцос байгааг гэнэт санав. Гэрийнхээ босгыг даван орж иртэл унтлагын өрөөний хаалга хаалттай байлаа. Түрүүн Оюунчимэгийн араас улайран хөөхдөө хаасан байна гэж баймааргүй санагдана. Ямартай ч Галсан очоод хаалгыг нээж үзэхээр шийдэн дөхөв. Хаалгыг нээх гэснээ нэг л жийрхэхэд тэрээр эхнэрийнхээ үхсэн байхыг харах болохоор ингэж жийрхэж байгаа хэрэг гэж өөртөө хэлээд хаалгыг түлхлээ. Өнөөх сүнс чөтгөр гэж нэрлээд байдаг Цэнгэл охин айхтар түлэгдсэн бололтой нэг нүцгэн эртэй хамт эхнэрийн нь цусыг сорж махыг нь тасдан идэж байх нь тэр. Тэд Галсанг орж ирснийг ч анзаарсангүй. Үе үе үзэгдэж байсан Цэнгэлийг яая гэхэд хажууд нь зэрэгцэн сууж эхнэрийн нь цогцсоор хоолож байгаа түлэнхий нүцгэн эр тэсэхийн айдас төрүүлж байв. Тэр аймшгийн эр өнөөх Галсангийн зүүдэндээ үзсэн этгээд яг мөн байлаа. Галсан тэссэнгүй. Ер нь энэ аймшгийн нүд хальтрам дүр зургийг хараад хэн ч тэсэхгүй нь ойлгомжтой билээ. Хана шал нь Галсангийн нүдэн дээр нь дайвалзан толгой нь эргэж ухаан балартан уналаа.

## **XIX**

Энэ шөнө нойтон цас хаялж байлаа. Бүх юм дууссан гэж батлах гэсэн мэт хорвоо дэлхий тэр аяараа нэг л нам гүм тэгсэн хэрнээ дүнсийн барайж уйтгар гунигт бүрнээ автан үнэгчлэн нойрсох мэт. Үүр цайж гэгээ орох хараахан болоогүй байв.

Галсан энэ мөчид сая нэг ухаан оров. Тархи толгой нь аймшигтай ангалзан өвдөж хамаг бие нь сульдан буларчээ. Өрөөнд хав харанхуй байх агаад тэрээр ухаан ормогцоо түрүүн эхнэрийн нь цогцсыг идэж байсан хоёр этгээдийг байгаа эсэхийг нягтлах гэсэн бололтой хоёр нүдээрээ

орчин тойрноо нэгжин харав. Гэхдээ боссонгүй. Өрөөнд хэн ч байхгүй байх агаад нэгэн хар бараан дүрс ямар ч хөдөлгөөнгүй дүнсийн хэвтэж харагдах нь Хэрлэнгийн цогцос гэдэг нь тодорхой байлаа. Галсан ийнүү ухаан орсон эхний мөчдөө өөрийгөө магадгүй үхчихсэн юм болов уу хэмээн эргэлзэж байсан ч удалгүй бүх бодит орчинтойгоо эвлэрлээ. Хэдэн цагийн өмнө яг өөрийн нь нүдэн дээр эхнэрийг дүү нь алчихсан, бас тэр дүү нь ч гэсэн хүүе гэхийн завдалгүй амиа хорлочихсон нь санаанд нь бүдэг бадаг орлоо. Энэ бүгдийг үнэндэ зүүд байгаасай хэмээн эрхгүй хүссэн ч харамсалтай нь аргагүй бодит явдал гэдгийг Галсан сайн мэдэж байв. Тэрээр алгуурхан өндийлөө. Түрүүн эхнэрийг нь тасчин идэж байсан өнөө хоёр харин үнэхээр байсан юм болов уу гэдэгт Галсан эргэлзэж байв. Ямартай ч түрүүн ухаан балартан унахын өмнө өрөөний гэрэл асаалттай байсан авч одоо унтарчээ. Түрүүний хоёр унтраасан юм болов уу гэж бодохтой зэрэгцэн нүүрээр нь хүйтэн хөлс дааварлаад ирэв. Үнэндээ Галсан битгий л тийм зүйл болсон байгаасай эрхгүй хүсч байсан ч юутай ч өрөөний гэрлийг асаахар зориг шулуудав. Толгой нь аймшигтай эргэн газар дайвалзаж байсан ч шүдээ зуун унтраалга руу очив. Чаг чаг хийлгэн хэдэнтээ дарж үзсэн ч гэрэл ассангүй. Чийдэн шатсан эсвэл ток тасарсан хоёрын аль нэг нь болж дээ гэж Галсан дотроо бодоод Хэрлэнгийн цогцос гулдайн хэвтэж байгаа зүг рүү эргэлээ. Тэрээр нойтон шалан дээр гишгэн нэг хоёр алхаж байхдаа энэ нь эхнэрийн нь цус гэдгийг сайн мэдэж байв. Ингээд Галсан нэгэнт амьгүй болсон Хэрлэнгийн биенд хүрэх гэснээ гэнэт больж зүгээр л орны бүтээлгээр бүтээж орхив.

Эхнэрийг нь идсэн эсвэл үгүй хоёрын алиныг нь ч мэдсэнгүй. Магадгүй эхнэрийнхээ цогцсыг хэн нэгэн идсэн байхыг харахаас зүрх алдсан хэрэг биз ээ. Галсан Саруулын унтлагын өрөөнөөс гарлаа. Галынхаа өрөөнд ормогцоо гэрлийн унтраалгыг дарахад харин өрөө гэрэлтэй болох нь тэр. Галынхаа өрөөний өнөөх хоолны том ширээгээ шанаагаараа дэрлэн сууж болсон бүх явдлыг толгойдоо эргэцүүлэн сэргээх гэж оролдов. Энэ бүх амьдралынх нь сүйрэл муу бүхэн энэ адын байшинд нүүж ирснээс л эхэлжээ. Ялангуяа энэ зоорь. Хэдийгээр одоо дөрвөлжин модоор шалтай нь холбон хадсан ч энэ дотор урьд өмнө хэзээ нэгэн цагт болж өнгөрсөн муу ёрын зүйлийн нууц хадгалагдаж байгаа мэт Галсанд санагдана. Үнэндээ эхнэрийнхээ гэнэтийн харамсалтайгаар үхэлд маш их цочирдсон ч үүний хажуугаар энэ болсон бүх муу явдлуудын учрыг олохыг тэрээр эрмэлзэж байв. Гэнэт Хэрлэнгийн “зоорин доорх шороогоо ухаж үз гэж Цэнгэл хэлсэн” гэдэг үг Галсангийн санаанд орлоо. Тийм ээ магадгүй энд л энэ бүх муу ёрын үйл явдлын гол нууц хадгалагдаж байгаа байх нь. Ингээд Галсан энэ бодлоо бататгаж учир битүүлэг муу ёрын үйл явдлын учир шалтгааныг олохоор зоорины хаалгыг эвдэж эхлэв. Тэрээр зоорины хаалганы хөндлөвч модыг эвдэж байхдаа түрүүн Оюунчимэгийг үхэх үед хэн нэгэн болсон бүх үйл явдлыг цонхны гаднаас харж амжсаныг саналаа. Тиймээс удахгүй цагдаа нар ирээд өөрийг нь баривчилна гэдгийг тааварлав. Тэгэхээр энэ бүхнээс урьтаж учир нь олдохгүй байгаа муу ёрын энэ шйл явдлуудын учрыг олохоор Галсан хатуу шийджээ. Харин дараа нь яасан ч яахав цагдаа нар ирээд намайг баривад барина л биз гэж бодно. Тэртэй тэргүй Хэрлэн Оюунчимэг хоёрын хоёулангийн нь үхэлд өөрийг нь буруутгана гэдэгт Галсан эргэлзсэнгүй. Харин цагдаа нарт баригдах тэр үед зүгээр л амиа хорлочихно гэж өөртөө хэлнэ. Ингэж бодмогцоо гэнэт инээд нь ч хүрэх шиг болов.

Учир нь түүнд одоо амьд явахын ямр ч үнэ цэнэ байхгүй болсон бөгөөд зүгээр л өөрийнхөө гэмгүй амьдралын сүйрлийн шалтгааныг олж мэдээд үхэхсэн гэсэн л сүүлчийн хүсэлтэй

үлджээ. Ингэсээр Галсан удалгүй зоорины хаалгыг эвдэж дууслаа. Өмнө нь Батжаргалтай хамт доошоо буухдаа хэрэглэж байсан шатаа яг тэр чигээр орхисон нь энэ удаа харин зол болов. Галсан байшингийнхаа гадна түшүүлж орхисон хүрз, жоотуу хоёрыг гарч аваад буцаж галынхаа өрөөнд орж ирлээ. Ингэхдээ тэр хаалга нь хаалттай байгаа Саруулын унтлагын өрөөний зүг ч харсангүй. Сэтгэл нь бүрэн уймарч ямартай ч эцсийн хүчээ шавхаад ч хамаагүй зоорин доорх шороог ухаад дараа нь хурдхан үхэхсэн гэхээс байж ядна. Ингээд Галсан зоорины гүн рүү хүрз жоотуу хоёроо унагаад араас нь галын өрөөний шургуулганд байсан гар чийдэнг барьсаар шатаар уруудлаа. Энэ удаад Галсанд ямар ч айдас төрсөнгүй. Алдах юмгүй болсон хүнд айдсын мэдрэмж төрдөггү бололтой. Өмнө нь Батжаргалтай хамт бууж байхдаа нэг л жихүүцэж байсан бол одоо огтхон ч ажралгүй маш хурднаар бууж зоорины ёроолд тулж ирэв. Газар бүр хөлдүү биш ч гэсэн ухахад маш төвөгтэй хатуу байлаа. Галсан амсхийх сөхөөгүй жоотуугаараа газар балбаж доошоо бага багаар ахиулсаар. Хэдий цаг шахам ноцолдсон ч зоорины ёроолын шороон доороос юу ч гарч ирсэнгүй. Гэсэн ч Галдсан огтхон ч эргэлзэх юмгүйгээр хүрз жоотуугаараа ээлжлэн ухсаар. Тэгснээ үе үе гар чийдэн тусган харж ямар нэгэн зүйл гарч ирсэн эсэхийг ажиглан харна. Тэгээд л дахин жоотуугаараа балбаж гарна. Гэтэл хөлдүү шороо жоотууны ирэнд өртөн цохигдож байснаа нэгэн лүгхийсэн бөглүүдүү чимээ сонсогдож ямар нэгэн өөр зүйл цохигдох нь тэр.

Галсан жоотуугаа орхин яаран гар чийдэнгээ тусгаж харлаа. Хүний цогцос байх бөгөөд Галсан жоотууныхаа ирэр тэр цогцсын яг толгойн тушаа газар нь зоожээ. Хувхайрч өгөршсөн толгой бас нэгэн гарын сарвуу ил цухуйсан харагдана. Ингээд Галсан цаашаа лавшруулан хүрзээрээ малтаж гарах нь тэр. Одоо бүх юм тодорхой ив илхэн харагдахаар болов. Том жижиг хоёр хүний цогцос байх бөгөөд энэ цогцосноос бараг л дан ганц яс нь үлджээ. Том жижиг хоёр чөтгөр юм биздээ гэж Галсан өөртөө хэлээд хүйтэн шороон дээр тамирдан хэвлээ. Өмнө нь хар дарж зүүдлээд сэрэхдээ охиныхоо цамцны товчийг атгачихсан байснаа энэ агшинд санаж магадгүй энэ хоёр цогцосны сүнс л өөрсдийнхөө буруу газар булагдсан шарилаа олуулж хойд төрлөө олон гэсэн үйлдэл байсан юм болов уу гэж тааварлаж байв. Тэр Цэнгэл гэдэг нэртэй биежсэн сүнс бас тэр зүүдэнд нь үзэгддэг түлэнхий царайтай аймшгийн эр хоёр энд байжээ. Энэ хоёрын сүнс л бидний амьдралыг баллаж гүйцсэн байх нь. Гэхдээ энэ хоёр цогцос яагаад энд булагдсан юм болоо. Галсан өөрөө өөрөөсөө асуусан энэ асуултаа өөр хүн хажууд нь байж гэмээнэ дуулдахуйц чанга дуугаар хэлэв. Ингээд Галсан энэ асуултынхаа хариуг олж чадалгүй зоориноос гарахаар дээш мацлаа. Шатаар дээшээ өгсөхдөө байрны хуучин эзнийг олж уулзаад энэ бүхний учрыг асуух хэрэгтэй гэж бодов. Ямартай ч энэ бүхний учрыг заавал олчихоод үхэхсэн гэсэн бодол толгойд нь эргэлдэж мацсаар сая нэг галынхаа өрөөнд авиран гарч ирлээ. Гэгээ оржээ. Бодвол өглөөний зургаан цаг өнгөрч байгаа бололтой. Одоо харин яахаа эргэцүүлэн бодож гараа өмднийхөө халаасанд хийхэд өчигдрийн Хэрлэнгийн авсан утасны карт хуруунд нь тэмтрэгдлээ.

Гал тогооны өрөөний шүүгээн дээр ч гэсэн яг өөрийг нь хүлээж байх мэт талийгаач эхнэрийн нь гар утас харагдав. Утасных нь цэнэг хариугүй дуусах дөхжээ. Ингээд өнөөх картаараа утсаа цэнэглээд хуучин байрны эзний утасны дугаарыг гар утаснаасаа хайж эхлэв. Ашгүй нэг их хайж сүйд болсонгүй. “Байрны хуучин эзэн” гэсэн нэрээр дугаар нь хадгалагджээ. Галсан ямар ч эргэлзэх юмгүйгээр залгаж байшинд болсон явдлуудаас үүдэж ялангуяа зоорины талаар уулзах хүсэлтэй байгаагаа товчхон ойлгуулав. Өнөөх байрны хуучны эзэн ч өглөө эрт залгалаа хэмээн цааргалсангүй, харин ч бүр ярихыг нь хүлээж байсан бололтой гэрийнхээ

хаягийг зааж өгөөд яг одоо хүрээд ир хэмээн дууджээ. Галсан гэрээс гарахаар завдлаа. Байшинд цусны үнэр ханхийх шиг л болов. Гэсэн ч тэрээр дээд доод хоёр давхарт байгаа эгч дүү хоёрын цогцсыг очиж үзэхийг завдсангүй зүгээр л гадуур хувцсаа мөрөндөө углав. Өчигдөр шөнийн эхнэрийн нь цогцсыг магадгүй үнэхээр тасчин идэж байсан тэр үйл явдал үнэн эсэхийг нягталж үзэх гэснээ зүрх алдан бодлоосоо татгалзав. Гарах хаалганыхаа өмнө тулж ирснээ гэнэт зогтосч коридортоо өлгөсөн толинд нүүрээ харав. Толинд харсан өөрийнхөө дүрснээс Галсан цочих шиг болж өөрийгөө үнэндээ таньсангүй. Нүүр нь цусанд, бас зорь онгичсон шороотой холилдон будагдаж хүн харахын эцэсгүй болжээ. Ийм царайтай гудамжинд гарвал хүн битгий хэл нохой хүртэл хараад айх биз гэсэн бодол Галсанд төрж нүүрээ хүйтэн усаар угаасан боллоо. Одоо л нэг өөрийгөө танихтайгаа болов. Галсан автобусны буудал руу сажилж очоод хамгийн эхний микро автобусанд суужээ. Уг автобусанд цөөхөн хүн суусан байх бөгөөд сууж яваа хүмүүсийн ихэнх нь л хичээлдээ яарсан оюутнууд бололтой. Кондуктур түүнээс мөнгө нэхэхэд Галсан биедээ ямар ч мөнгөгүйгээ сая саналаа. Тэгмэгцээ ямар ч эргэлзээгүйгээр бугуйндаа зүүсэн цагаа тайлаад өгчихөв. Кондуктур залуу нэг гайхаж харснаа цагийг аваад чимээгүй боллоо.

## XX

Галсан микро автобуснаас бууж алхах замдаа хамаг сэтгэл нь хоосон оргиж ухаан нь орж гаран хурдхан шиг л үхэхсэн гэхээс байж ядна. Ийнхүү сажилсаар 3-4 р хорооллын орон сууцанд байрлах болсон өнөөх муу ёрын зорь бүхий хашаа байшингийн хуучин эзнийд ирлээ. Өндөр туранхай биетэй цагаан царайтай зүс таних залуу Галсанд хаалгаа тайлж өгсөн нь өөрт нь анх хашаа байшинг худалдсан хүн байв. Галсантай мэндэлсэн боловч Галсан хариу хэлсэнгүй. Өнөөх зүс таних залуу ч түүнээс хариу үг хүлээсэнгүй гал тогооныхоо өрөөнд Галсанг дагуулан орж ирээд сандал дээр суулган цай аягаллаа. Галсан тэр цайнд уруулаа ч хүргэсэнгүй. Галсан үг дуугүй тэр залуу руу хүйтэн харцаар ширтэж байв. Хашаа байшинг Галсанд худалдсан залуу ч Галсангийн тэр харцыг удаан тэссэнгүй бололтой чухам яг ямар хэргээр өөртэй нь уулзахаар ирснийг лавлав.

-Анх яагаад тэр байшинг надад тийм хямдхан үнээр яаран зарсан тухайгаа яриач?

-Тэр байшинд цаашид амьдрах шаардлагагүй болоод. Өөрөөр хэлбэл би өөр орон сууц худалдаж авсан хэрэг л дээ.

-Битгий худлаа ярь. Надад анх тэр байшинг худалдахдаа чи тэр зоорины тухай юу ч яриагүй. Бас галынхаа өрөөний тавилгуудыг ч зоорины тагийг халхалсан хивсэнцэрээ ч үлдээсэн. Чухам яагаад тэгсэн тухайгаа яг үнэнээр нь надад хэлээд орхи. Зоорин доороос ямар нэгэн чимээ дуулдаж хий үзэгдлүүд үзэгдэж байсан болохоор чи тэндээс ум хумгүй нүүсэн биздээ. Би чамайг буруутгах гээгүй ээ. Ердөө л энэ бүхний учрыг олох гэж яваа болохоор чи надад бүх үнэнээ хэл

Ингэж хэлэндээ Галсангийн нүдэнд шийдэмгий дүр төрх тодроод ирлээ. Тэгсэн ч өнөөх зүс таних залуу Галсанд энэ бүхнийг хэлэх шаардлагатай юу гэсэн шиг эргэлзэн харсаар байсанд Галсан яриагаа цааш үргэлжлүүлэв.

-Тэр хараал идсэн байшинд нүүж орсноос хойг охин минь ор сураггүй алгаболж эхнэр минь

үхсэн. Манай нохой ч үхсэн. Үргэлж тэр зоорь луу боргон хуцдаг байсаар нэг өдөр жорлонгийн нүх рүү унаж үхсэн. Бас дүү маань ч тэр зоорь луу унаад эрэмдэг болсон. Галсангийн яриаг анхааралтай чагнаж суусан өнөөх залуу “зоорь луу унаад” гэсэн үгийг сонсоод царай нь хувираад ирлээ. Тэгснээ “Чи зоорийг нээж дотор нь ороо юу?” хэмээн асуув.

-Тийм ээ

-Харин би орох нь байтугай нээж ч үзээгүй. Үнэндээ шөнө дунд болод ирэхийн үеэр тэр зоорин доороос хэн нэгний нүдэх балбах чимээ дуулддаг байсан. Эхнэр хүүхдүүд маань ч шөнө болгон хар дарж зүүдлээд нэг л учир нь үл ойлгогдох зүйлүүд болоод байх шиг байсан нь үнэн. Гэхдээ би тэр байшинд тийм ч их удаагүй. Ердээ л ганц сар хүрэхтэй үгүйтэй хугацаанд байсан.

-Чамаас өмнө ямар хүмүүс тэр байшинд байсан юм бэ?

-Тэр талаар сайн мэдэхгүй. Ямар ч би тэр байшинд орох үедээ өмнөх эзэн нь галзуурчихсан, сэтгэцийн эмнэлэгт хэвтэж байгаа тухай олж мэдсэн. Тэр өмнөх эзэн нь уг байшинд их олон жил амьдарсан гэсэн. Бас тэр хүн л чиний яриад байгаа тэр зоорийг битүүмжилж хадсан байх. Гэхдээ би түүнтэй уулзаагүй. Тэр хүнээс авлагатай байсан хүнээр зуучлуулан тэр байшинг маш хямд үнээр худалдаж авсан л даа. Тэгээд л тэр байшинд удааж тэсэж чадаагүй нүүсэн хэрэг.

-Тэнд амьдарч байхад чинь чамд өөр ямар нэгэн зүйл тохиолдож байсан уу. Шуудхан асуухад ямар нэгэн муу зүйл. Бас тэр дүлий дүмбэ царайлсан хөршүүдийн ухай чи юу мэдэх вэ?

-Тэр хөршүүдтэй нэг ч үг сольж үзээгүй. Хажуу айлынхан биднээс дандаа л цэрвэдэг байсан. Хавь ойрын хүмүүсээс сураг сонсоход миний амьдарч байсан, одоо чиний байгаа тэр байшинд хүмүүс ердөө тогтдоггүй дандаа л муу зүйл болдог байсан тухай сонсож байсан. Нэг удаа гал тогооных нь өрөөнд байгаа тэр зоориноос нэгэн аймшгийн амьтан гарч ирж байна гэсэн яг ижилхэн зүүдийг эхнэр бид хоёр зүүдэлсэн. Тэгээд л сэжиглээд лам авчирч үзүүлэхэд энэ байшинд чинь муу хүмүүсийн сүнс шүглэсэн байна гээд л манайхыг хурдан нүү, бас зоорины тагийг хэзээ ч бүү нээ тэгвэл үхэл дагуулна гэж айлдсан

Галсан энэ үгийг сонсоод анх тэр зоорийг нээсэн мөчөөс эхлэн хайртай нохойноос нь эхлээд бүгд үхэж үрэгдснийг санан харамсч шүүрс алдлаа. Галсан хэдэн хором бодлогшрон сууж байснаа үргэлжлүүлэн асуув.

-Новш гэж, тэгээд л чи тэндээс ум хумгүй нүүгээ юу?

-Тийм ээ. Гэхдээ би чамд тэр байшинг зарна гэж хэлээгүй шүү дээ. Зүгээр л эхнэр маань хашаа байшингаа зардаг ч юм билүү гээд ажлынхаа хүнд хэлэхэд танай эхнэр чинь тэр хүнээс нь олж сонсоод анх сонирхсон. Би авсан үнээрээ л зарна гэж бодоод тийм хямд үнэ хэлсэн хэрэг л дээ. Шуудхан хэлэхэд би өөрөө хохиролгүй үлдэхийг хүссэн. Гэхдээ чамд ямар нэгэн муу муухай явдал болно гэж зөгнөж зараагүй. Магадгүй өөр хүн тэр байшинд орвол зүгээр ч байх юм билүү л гэж бодож байсан. Одоо харин би чамд тохиолдсон бүхэнд чинь харамсаж

байгаагаа хэлэх хэрэгтэй байх. Гэхдээ чамаас уучлах гуйх шаардлага байхгүй гэж бодож байна.

Ингээд Галсан тэр залуугаас дахин өөр зүйл шалгаасангүй гарч одлоо. Угаасаа л том жижиг хоёр чөтгөр шүгэлсэн муу ёрын байшин байж л дээ гэж өөртөө хэлэн алхаж байв. Тэрээр нэг л мэдэхэд Шар хадны сэтгэцийн эмнэлгийг чиглэн алхаж байлаа. “Муу хүмүүсийн сүнс шүглэсэн байна гэж хэлсэн гэнэ ээ? Тэгвэл тэр хүмүүсийн нь тухай олж мэднэ дээ” хэмээн тэрээр өөрөө өөртөө хэллээ. Галсан эмнэлгийн үүдэнд тулж иржээ. Үе үе толгой нь эргэж бодит орчноос тасрах шиг болж байгаа тэрээр өөрийгөө бас юу юунаас илүү тэр чөтгөрийн байшинг сэтгэлдээ хараан зүхэж байлаа. Галсан эмнэлгийн манаачид хүнтэй уулзах гэж байгаа гээд азаар амархан дотогшоо нэвгэрчээ. Галзуурч сэтгэцийн өөрчлөлтөнд орсон хүмүүсээр дүүрсэн энэ эмнэлгийн тасгуудаар тэрээр нэг мэдэхэд л тэнэж байх нь тэр. Ухаан нь орон гаран болж эхнэр охин нь нүдэнд нь үе үе үзэгдэхэд Галсан энд чухам яах гэж ирсэн зорилгоо ч мартаж орхив бололтой. Гэнэт Галсангийн сонирхлыг эрхгүй татаж тарж бутарсан ухааны гнь цуглуулахад хүргэсэн нэгэн үйл явдал болсон нь нэг галзуу этгээдийн яриа байлаа. Галсан тэр хүний яриаг чагнаад эрхгүй зогтуслаа

-Муу новшийн хараал идсэн зоорин доороосоо хурдхан шиг гараад ирээч ээ. Чамайг тэр доор үхсэн хэвтэж байгааг чинь мэдэж байна. Гэхдээ л чи шөнө болохоор тэр хүйтэн зоориноос гарч ирэх гэж зүтгэдэг биздээ. Бас чиний тэр охин ч гэсэндээ юугаа хийгээд там руугаа тонилохгүй сүнс нь намайг ээрээд байгаа юм бэ аан? Хэмээн хараан зүхэж байгаа нь хаалга нь хагас нээлттэй өрөөний цаанаас тодхон сонсогдож байв. Галсан өрөөний хаалгыг гүйцэд нээж харахад хижээлдүү насны халзан толгойтой эр шал руу ширтэн дээрх яриагаа үргэлжлүүлэн хараан зүхсээр байв. Галсан өрөөнд орж түүний дэргэд дөхөж ирлээ.

-Та тэр зоорины тухай өөр юу мэдэх вэ? Гэж Галсан асуув. Өнөөх халзан толгойтой галзуу эр ч Галсанг тээршаасангүй. Харин ч өөрийг нь хэн нэгэн тоосон явдалд баярлав бололтой Галсан руу харан үргэлжлүүлэн ярилаа.

-Чи тэр байшинд миний дараа очиж амьдарсан байх нь ээ. Ха хаби мэдэж байна. Яав тэр хараал идсэн новшийн зоорийг нээж үзээ юу? Хэмээн асуусан ч Галсангийн хариулахыг хүлээлгүй яриагаа цааш үргэлжлүүллээ.

-Битгий тагийг нь нээгээрэй. Тэр хараал идсэн зооринд чинь муу ёрын махчин хүний сүнс хоригдсон байгаа. Хэрвээ нээх л юм бол чи дуусна гэж мэд. Үл таних халзан эр ингэж хэлээд долоовор дунд хуруунуудаа нийлүүлэн хоолойгоо хэрчиж үзүүлэв. Бас нэг новшийн охин тэр зоорийг нээх гэж чамайг ээрэх байх.

-Гишгэсэн мөр нь цасан дээр үлддэггүй тэр охин уу?

-Дүү минь дээ, чиний нүдэнд асар их зовлон хурсан харагдаж байна. Чи тэр хараал идсэн байшинг ялангуяа тэр зоорийг заавал шатаадаг юм шүү. Миний ярианд энэ хүмүүс итгэхгүй энд ингээд хорьчихсон юм. Бушуухан шиг очоод шатаа. Тэгэхгүй бол олон хүмүүсийг сүйд хийж мэдэх гайтай байшин шүү. Заавал шатаа. Муу ёрын сүнс орогносон газрыг шатаахгүй бол тэр нь биеждэг гэдэг. Аягүй бол одоо чамайг энд ингээд явж байхад чинь биежээд эхнэр хүүхдийг чинь цусалж байж мэднэ.

-Тэр байшинг анх хэн барьсан юм бэ? Ялангуяа тэр зоорийг хэн ухсан юм та юу?

-Тийм ээ чи яаж таав аа. Би барьсан юм, би ухсан юм. Харин гай болж тэр новшийн шатаж шхсэн махчны үхсэн газар байшингаа барьснаа даанч мэдээгүй. Чи тэр байшинг олон юм ярилгүй хурдхан очоод шатаа. Дуулав уу чи. Одоо эндээс зайл.

Халзан толгойтой галзуу эр ингэж хэлээд тачигнатал хөхрөөд ирлээ. Тэрээр инээж багйаа хэрнээ нүднээс нь нулимс урсаж байх аж. Тасралтгүй инээж байснаа юу ч болоогүй юм шиг гэнэт зогтусч төв царайлан Галсан руу айсан нүдээр ширтлээ.

-Муу ёрын чөтгөр орогнох газраа олчихоороо улам хүчирхигждэг. Цаад новш чинь газар доор байхдаа улам хүчирхэгжиж магадгүй биежсээр байгаа. Тэгсээр нэг л өдөр гараад ирнэ. Түүнийг хэн зогсоож чадахгүй. Ямар ч цоож түгжээ түүнийг хорьж хүчрэхгүй. Тэр бол адгийг аймшигт араатан гэж мэд. Үхсэн мөртлөө үхдэггүй, хий хоосон мөртлөө бодитой, чи тэрийг харахгүй байсан ч тэр чамайг харж л байгаа. Залуу минь түүнээс болгоомжил, чи бол жинэхэн хүн учраас түүнээс болгоомжлох хэрэгтэй. Бас тэр ад зэтгэрийн новш адын “ухаантай”. Гэхдээ түүний бүх ухаан нь зөвхөн идэхийн тулд л ажилладаг. Түүнтэй хэзээ ч битгий учир, тэгээд новшийн оромжийг нь шатаа. Ямар ч үнээр авсан байсан хамаагүй тэр хараал идсэн байшинг үнсэн товрог болго. Одоо харин гөлрөөд байлгүй хурдан зайлж үз. Тэр чамтай тэмцэлдсээр байгаа шүү. Тэр байшинг устгах гэсэн боловч би чадаагүй, тэд надад бас саад болсон. Чамд ч гэсэн ялгаагүй саад болох л болно. Гэхдээ л заавал тэр новшийн оромжийг үгүй хийх хэрэгтэй. Галсан яахаа мэдэхгүй тэр этгээдийг харан зогсож байтал хажуугийн нь орон дээр хэвтэж байсан нэг хүүхэн Галсанд хандаж”Чи одоо яв даа. Наад ахын чинь эхнэр хүүхдийг нь махчны сүнс үхүүлчихсэн гэсэн” гэх нь тэр. Галсан энэ үгийг хэлсэн хүүхэн рүү харцаа шилжүүлээд хэсэг чимээгүй гөлөрч байснаа “Харин чи яагаад энд байгаа юм бэ?” хэмээн ямар ч бодолгүй зүгээр л зорилгогүй асуув. Би энд байх дуртай болоод л байгаа юм аа. Энэ эмнэлгийн хөргөгчнөөс орой болохоор манай нөхөр гарч ирдэг. Аягүй бол чамайг надтай хардаж мэднэ, манай нөхөр их хартай шүү. Одоо ирэх цаг нь болж байна чи, түргэхэн шиг явж үз. Би хөргөгчний дуугарахыг хүлээж байгаа.

Ингэж хэлээд эл бүсгүй тэсвэрлэхийн аргагүй чангаар хашхирч эхлэх нь тэр. Бүсгүйн хашхирах дуунаар цагаан нөмрөгтэй эрэгтэй эмэгтэй хоёр сувилагч орж ирээд “Бурмаа тайван бай” гэсээр дарж хэвтүүлээд судсанд нь тариа хийлээ. Тэгмэгцээ Галсанг сая анзаарч хараад та юун хүн, энд юун гадны хүн явж байдаг билээ гэсээр ум хумгүй хөөж гаргалаа. Хамгаалалтныхыг дууд, цагдаад барьж өг хэмээн эмч сувилагч нар хашхирч байсан ч Галсан тэр эмнэлгээс яаралгүй гарч одлоо. Галсанд одоо бүх зүйл тодорхой болсон мэт санагдаж байв. Өглөө гэрээсээ гарахдаа авч гарсан гар утсанд нь өч төчнөөн дуудлага, бас хэд хэдэн мессеж ирсэн байсныг Галсан сая анзаарч харав.

Өвлийн илч муутай сүүмгэр наран Галсангийн амьдралын төгсгөлийг зөгнөх мэт ёлтойж хүйтэн салхи сэвэлзэнэ. Галсангийн бодолд Саруул охин нь бүдэг бадаг үзэгдэх шиг болж нүд нь үе үе харанхуйлан бүдчин алхана. Ийнхүү ундуй сундуй алхсаар Галсан арайхийн жаахан сэхээ авлаа. Түүний сэтгэл төсөөлөхийн аргагүй хямарч оюун ухаан нь бүр балран мөхөө юу гэлтэй. Галсан утсан дахь мессежийг уншихаар завдав. Согтуу хүн шиг гар хуруу нь эвлэхгүй байсаар арайхийж утасныхаа хэдэн товчлуурыг дарж хэд хэдэн мессеж ирсэн байсны эхнийхийг нь үсэглэн уншив.

“Дүүгийн чинь бие улам дордоод үхэх нь байна. Хэрлэн та хоёр яагаад одоо болтол ирэхгүй, утсаа ч авахгүй байгаа юм бэ. Цагдаа нар хүртэл ирээд та хоёроос байцаалт авна гээд хүлээж байна” Галсан энэ хэдэн мөрийг арайхийж үсэглэн уншлаа. Дараа дараачийн мессежийг нээж үзсэнгүй. Бодвол Батжаргал ч гэсэн үхээ биздээ хэмээн Галсан амандаа үглэсээр нурууга цэх болгон гэрийнхээ зүг алхлаа. Гэтэл харин зам дагаж явсан түүний хажууд такси ирж зогсоод жолооч нь “Унаа авах уу?” гэж чангаар асуув. Галсан үг дуугүй орж суугаад оршуулгын газартай ойр байрлах гэрийнхээ хаягийг хэлж өглөө. Жолооч ч холхон газар очих боломжийн халтуурын ажил оллоо хэмээн хөөрцөглөж заасан газар луу нь хурдлан давхив.

## XXI

Галсан элий балай амьтан ухаан мэдрэлгүй шахам жолоочийн хажууд суун осолдохгүй л амьсгалж байлаа. Гар утасных нь цэнэг дуусч байгаа дохио өгөн хаанах нь мэдэгдэхгүй нэг хэлээр жаахан хүүхэд нэг юм хэлнэ. Бодвол утасны чинь цэнэг дуусч байна гэж л хэлээд байгаа бололтой. Үүнийг сонссон таксины жолооч Галсангийн гар утсыг ёстой амаа олохгүй магтаж гарах нь тэр.

-Манай охин яг чинийх шиг ийм утастай болмоор байна гээд л намайг ердөө амраадаггүй шүү. Ер нь наад утас чинь ямар үнэтэй байдаг вэ?

-Мэдэхгүй ээ. Манай талийгаач эхнэр л худалдаж авсан. Чи намайг гэрт минь үнэгүй хүргэж өгөөд жаахан бензин нэмээд өгчих. Тэгээд энэ утсыг өөртөө ав тэгэх үү. Одоо надад хэрэггүй, охиндоо өгнө биз.

-Үнэн ярьж байгаа биздээ найз минь хэмээн жолооч санамсаргүй хожоотой наймаа хийх болсондоо урамшин инээд алдан асуулаа.

-Би худлаа яриагүй ээ, үнэн. Галсан ингэж хэлж жолоочийн санааг амраагаад гэртээ нэлээн дөхөж ирснээ сая анзаарч бас одоо оройн 17 цаг болох дөхөж байгааг мэдэж авав. Хоолойноос нь цус олгойдож байсан эхнэрийн нь үхэл нүдэнд нь харагдах шиг болж гэнэт огиудас нь хүрэв. Бас Оюунчимэгийн өөрийгөө хоолойгоо шилээр дүрж хороосон нь ч санаанд нь оров. Ингээд Галсан жолоочид машинаа зогсоо гэж бараг л хашхирах шахам хэлээд зогсоов. Жолооч ч амласан ёсоор багаажиндаа хадгалж явсан таван литрийн хуванцар савтай бензинийг Галсангийн гарт атгуулахад Галсан оронд нь гар утсаа өгөв. Ингээд Галсанг хүргэж ирсэн таксины жолооч эр түүнийг бодлоо өөрчлөх вий гэсэн шиг ум хумгүй ирсэн замаараа буцаад давхиж одлоо. Галсан яг одоо үхэхийг үнэхээр их хүсч байлаа. Гэхдээ үхэхээсээ өмнө амьдралыг нь орвонгоор нь эргүүлсэн махчны сүнс шүглэсэн гэгдээд байгаа муу ёрын байшинг шатааж өшөөгөө авах зорилго өмнөө тавьжээ. Түрүүний эмнэлэгт уулзсан энэ муу ёрын байшинг барьсан эр “Муу ёрын сүнсний орогносон газрыг хурдхан шатаахгүй бол тэр сүнс нь биежчихнэ” гэсэн үг Галсангийн чихэнд цуурайтсаар байлаа. Галсан маш ихээр тамирдан ядарчээ. Тэрээр таван литрийн саваар дүүрэн бензинийг арай ядан өргөсөөр гэр лүүгээ бага багаар дөхөж байв. Гэтэл Галсангийн араас нэг эмэгтэй хүн “Хүүе Саруулын аав аа” хэмээн дуудах нь тэр. Саруул гэсэн охиныхоо нэрийг сонссон Галсан сандарч догдолсон нүдээр эргэн харахад өнөөх өмнө нь гэрт нь ирж байсан охиных нь ангийн багш Ганцэцэг байв. Тэрээр Галсан руу дөхөж ирээд



-Охиноос чинь одоо болтол сураг гараагүй л байна уу? Хэмээн асуулаа

-Үгүй ээ гараагүй л байна

-Ээжийн нь санаа зовоод сүйд болж байгаа байх даа?

-Ээж нь өөд болсон

-Өө яана аа. Уучлаарай би мэдсэнгүй. Их эвгүй юм асуучихлаа.

-Зүгээр дээ. Санаа зоволтгүй. Тэр муу хараал идсэн байшингаас л болж байга нь тэр.

Ганцэцэг Галсангийн саяын үгийг сонсоод бага зэрэг бодолд автсан мэт царайлав. Тэрээр

Галсантай зэрэгцэн маш удаанаар алхаж байснаа

-Нээрээ ч тийм байж мэднэ. Танай тэр байшинд ердөө айл тогтдоггүй гэж хүмүүс ярилцдаг юм билээ.

-Энэ байшинг баригдахаас өмнө тэнд юу байсан юм бэ? Галсан ингэж асуухдаа Ганцэцэг рүү огтхон ч харсангүй зөвхөн өмнөх замаа л ширтэн алхана. Тэрээр одоо юу ч сонссон сонирхохгүй байсан бөгөөд хурдхан шиг л очиж амьдралыг нь балласан муу ёрын байшингаас өшөөгөө авахын түүс болж байлаа.

Ганцэцэг Галсангийн асуултанд хариулах гэж байгаа бололтой ээрч түгдэрч байснаа ярилаа.

-Өмнө нь тэр газар өнөөх Цэнгэл гэдэг охин чинь аавтайгаа амьдардаг байсан юм билээ. Одоогийнх шиг ингэж олон айл тэр газар бууж зүрхэлдэггүй байсан. Тэр охин дандаа л нэг хэвийн дүрэмт хувцастай явдаг, тэр нь хог шороонд хутгалдчихсан, заримдаа бүр цус болчихсон харагдах нь элбэг тохиолдоно. Энэ хавийнхан тэр хоёрт их дургүй байдаг байсан юм. Учир нь тэр аав охин хоёрыг цогцосоор хооллодог гэж ярилцдаг байсан. Харин нэг удаа хүүхдээ энэ энгэрт нутаглуулсан эцэг эх ах дүү нар нь шарилыг нь эргэхээр очтол өнөөх аав охин хоёр чинь шарилыг нь ухааж аваад идэж байсан гэдэг. Үнэхээр аймшигтай. Тэгээд л олон хүмүүс сэжиглээд тэр махчин аавыг нь алаад шатаачихсан, охиныг нь ч гэсэн хороогоод ноорхой гэрийн нь тэр буурин дээр хамтад нь газар ухаад булчихсан гэдэг. Гэхдээ энэ бол цуу яриа л даа. Ямартай ч бараг арваад жилийн өмнө үнэхээр л Цэнгэл гэдэг охин манай сургууль дээр үе үе ирдэг байсан юм. Аймар муухай өмхий үнэртэй гээд хүүхдүүд их сэжиглэж тойрч гүйлддэг байсан санагддаг. Тэр үед би дунд ангид сурч байсан тухайгаа танд дээр хэлсэн шүү дээ. Галсан Ганцэцэгийн энэ хэлсэн бүгдийг нэг бүрчлэн сонсож авлаа. Галсанд бүх юм тодорхой болсон мэт санагдана. Гэхдээ ганцхан зүйл л одоо болтол таавар хэвээр үлдээд байгаа нь Саруулын сураг өнөөг хэр нь гараагүй явдал байв. Галсан Саруулын ангийн багш Ганцэцэгт баяртай ч гэж хэлэлгүй зам салан гудамж тойрон эргэлээ. Галсан цогцосоор хооллодог махчин хүмүүсийн сүнсэнд манай гэр бүл нэг мөсөн хорлогджээ хэмээн амандаа үглэн байшин руугаа бага багаар дөхсөөр байв. Түүнийг бага байхад нь эмээгийн нь ярьдаг байсан “Муу хүний сүнс төөрч будилаад бусдад гай болдог юм” гэдэг үг одоо л үнэн юм шиг Галсанд санагдаж байлаа.

Галсанд өнөөх амьдралыг нь сүйтгэсэн ад зэтгэрийн байшин одоо тодхон харагдахаар болжээ. Тэрээр “хэдэн мөчийн дараа чамаас юу ч үлдэхгүй болтол шатахыг чинь харна аа” хэмээн амандаа үглэн эцсийн хүчээ шавхан алхсаар байв. Түүний толгойд энэ хараал идэж махчин этгээдийн сүнс орогносон байшинг газрын хөрснөөс арчиж хаяхгүй бол дараачийн удаа олон хүнд гай болно гэсэн бодол төрж тэр бодол нь өөрийгөө эцсийн хүчээ шавхан алхахад хүргэж байлаа. Галсан бүр аргагүй тамирдан ядарчээ. Хэрлэн Оюунчимэг хоёрын үхэл нүдэнд нь харагдаж Батжаргалын аврал эрэн зорь луу унаж байсан хар дарсан зүүд нь хүртэл санаанд нь давхар давхар орж ирж байлаа. Энэ мөчдөө Галсан газар дээр ганц хайртай охиноо амьд мэнд байгаасай хэмээн эрхгүй хүсч байгаагаа мэдэрч байв. Магадгүй энэ ертөнц дээр өөрийн үр удмаа үлдээх гэсэн түүний энэ санаа сүүлчийн нь хүсэл байсан биз. Галсан хашаандаа хүрэхэд арваадхан алхам үлдээд байгаа энэ үедээ таварцаглан ойчиход авч яваа савгай бензинийх нь таг мултарч асгарав. Галсан уг бензинийг асгахгүйг хичээн хамаг тэнхээгээ шавхан өндийж саваа өргөх гэсээр байтал бараг тал газар асгарчээ. Гэхдээ үлдсэн тал нь байшинг шатаахад хангалттай хүрнэ гэж өөртөө хэлсээр хашааныхаа хаалганд тулж ирэв.

“Чамайг даа” хэмээн шүд зуун хэлсээр Галсан хашаандаа ороод шууд л байшингаа тойруулан бензинээ цацаж гарлаа. Байшин дотроо ч орсонгүй. Магадгүй дотроос нь ямар нэгэн юм авах хэрэг ч түүнд байсангүй бололтой. Энэ байшинг шатаагаад дараа нь амиа хорлон энэ новшийн амьдралаас хагацна гэж бодож байгаа түүнд ямар нэгэн эд юмны хэрэг байхгүй нь ч аргагүй биз ээ. Ингээд Галсан байшингаа тойруулж бензинээ цацаж дуусаад үргэлж халаасандаа авч явдаг асаагуураа гаргаж ирэх мөчид “Зогс, бүү хөдөл” гэсэн захирангуй дуу ард нь сонсогдох нь тэр. Цагдаа нар түүний байшинг отож байжээ. Хашааны гадна талаас бас байшингийн булан тойроод өч төчнөөн зэвсэглэсэн цагдаа нар гарч ирэхэд өнөөх өчигдрийн аллагын гэрч болсон хажуу айлын өгөр эмгэн ч хамт гарч ирж харагдав. Галсан тэднийг үнэндээ огтхон ч тоолгүй нэг гайхаж харснаа асаагуураа гаргаж асаахыг завдтал буун дуу тасхийж Галсан асаагуураа алдлаа. Цагдаа түүний гар луу нь бууджээ. Гэсэн ч Галсан дахин тонгойж нөгөө гараараа асаагуурыг авах гэхэд цагдаа нар түүнийг барьж аваад дарж унаган гавлалаа. Галсан эцсийнхээ хүчийг шавхан тэмцэж байшинг шатаахыг хичээсэн ч яаж ч чадсангүй. Энэ үед хашааны үүдэн дээр хэд хэдэн цагдаагийн машин дохиогоо хангинуулсаар ирж зогслоо. Галсан байшинг шатаагаад өгөөч хэмээн байдгаараа хашхиран орилсоор. Түүний үгийг цагдаа нар сонссон ч үгүй.

Харин дарга нь бололтой нэгэн энгийн хувцастай махлаг эр “амаа тат” гээд шанаанд нь улаа бугартал цохиод авав. Тэгснээ нөгөө гартаа барьсан станцаараа “Нөгөө хоёр хүний хоолойг огтолж алсан онц ноцтой гэмт хэрэгтнийг баривчиллаа. Хэрэгтэн хэргийн газраа шатаахыг завдсан ч манай мэргэн бууч үйлдлийг газар дээр нь таслан зогсоосон” хэмээн мэдэгдээд хэрэгтэнг машинд суулга гэж тушаав. Гэтэл энэ үед Галсангийн нөгөө эчнээ танил болоод бүр загнуулаад амжсан хэсгийн цагдаа хүрч ирээд Галсанг цохисон саяын даргад илтгэлээ. Гэмт хэрэгтэн Галсангийн ор сураггүй алга болсон гэгдэж байсан охин Саруулын цогцсыг оршуулгын газрын ойролцоогоос оллоо. Хэрэгтэн охиноо зориуд төөрүүлж алаад эхнэр бусад дүү нараа ч хүйс тэмтэрсэн бололтой. Хэрэгтний гуянд нь хүндээр шархдуулсан Батжаргал хэмээх дүү нь хэдхэн цагийн өмнө эмнэлэгт шархны халуунаар өөд болсон мэдээ ирсэн хэмээн мэдэгдэв. Галсангийн зүрхээр хатгуулаад явчихлаа. Хилсдсн бүх үйлдлүүдийг үл тоолоо гэхэд охиных нь үхсэн тухай мэдээ хөөрхий эцгийг галзууруулахад хүргэв. Галсан

“Миний охин Саруул үхэх ёсгүй” хэмээн хамаг чадлаа шавхан эсэргүүцэж байсан ч цагдаагийн машинд чихэгдэн орлоо. Энэ үед Галсан өөрийг нь сугадаж яваа цагдаа нарын нэгнийх нь буу хуйндаа сул байгааг харж амжив. Галсан ухаан мэдрэлгүй шахам тийчлэн орилж машин хөдлөх агшинд шатааж амжаагүй муу ёр шүглэсэн байшин руу эцсийн удаа харахад цонхны цаанаас өнөөх хувхай царайтай Цэнгэл охин инээмсэглэн ширтэж байв. Харин үүнийг нь Галсангаас өөр хэн ч анзаарсангүй.

Галсанг суулгасан цагдаагийн машин дөнгөж хөдөлмөгц уг машин дотроос буун дуу тасхийх чимээ гарч орчлонг цочоолоо.

**Төгсөв**

## ЦАХИЛГААН ШАТ

Лифтны хаалга хяхтнан нээгдлээ. Хэн ч тэр лифт дуудах товчлуурыг дараагүй. Гэтэл бас тэндээс хэн ч гарч ирсэнгүй. Зүгээр л өөрөө хүрч ирээд нээгдчих нь тэр.

“Яг л амьтай юм шиг. Энэ аймшгийн нисдэг авч намайг аль нэг тийш нь авч явах гэж дандаа ингэж аашилдаг юм” Тэргэлийн энэ бодол дөнгөж саяхан нээгдээд байгаа энэхүү бүүдгэр гэрэлтэй лифтэнд төвлөрч байв.

Тэрээр лифт рүү нүд салгалгүй ширтсээр байснаа ямар нэгэн зүйлд ховсдуулан татагдах мэт боллоо. Тэгснээ маш хурдан сэхээ авч тэрхүү тагаа нээсэн авсыг санагдуулам лифтнээс нүднийхээ харцыг арайхийн салгав. Тэргэлийн гэр есөн давхарт байдаг нь түүнийг дандаа л бухимдуулдаг билээ. Учир нь тэрээр цахилгаан шатаар явах дургүй. Харанхуй болсон хойно бол бүр ч үгүй. Ялангуяа яг өөрийнхөө гэрийн энэ цахилгаан шатнаас бараг үнхэлцгээ хагартал айдаг болсон. Тэргэлийнх энд нүүж ирээд удаагүй байгаа ч сүүлийн зургаан сарын туршид тэрхүү айдас нь улам бүр идэвхжээд байгаа. Хэдэн сарын өмнө тохиолдсон цахилгаан шаттай холбоотой учир битүүлэг хэд хэдэн үйл явдал түүний сэтгэлд хургасан айдсыг улам ихээр нэмэгдүүлсэн гэхэд болно.

Цахилгаан шатанд суусан хүмүүс ор сураггүй алга болдог. Тэргэл тэр алга болсон хүмүүсийн тухай өөрийнхөө бодлыг хэнтэй ч хуваалцдаггүй. Зүгээр л өөрийнхөө ойр дотныхондоо “Болж өгвөл лифтэнд битгий суугаарай” гэж захих нь ихэссэн. Харин гэрийхэн нь нэг гайхасхийж хараад “Цахилгаан шат ажилладагүй шдээ” гэж хэлдэг. Ер нь тэгээд барагтай л бол анзаардаггүй гэхэд болно.

...Тэргэл дээшээ явган шатаар өгслөө. Түүнийг дөнгөж дөрвөн давхарт гарч иртэл саяхан нэг давхарт нээгдсэн лифт нь дөрвөн давхарт ч гэсэн нээгдэх чимээ гарав. Тэргэл зогтуслаа. Уг нь тэрээр хүний хөлийн чимээ гарахыг хүлээж байсан хэдий ч юу ч сонсонгүй. чимээ аниргүй хэвээр. Тэргэлийн дотор арзганаад явчих нь тэр. “Лифт намайг дагаад байна” гэсэн бодол Тэргэлд төрөхтэй зэрэгцэн тэрээр хөлийнхөө хамаг хурдаар дээшээ гүйчихлээ. Зургаан давхарт дахиад л лифт ирж зогслоо. Тэргэл дахин зогтусав. Хүний хөлийн чимээ үгүй ядаж хэн нэгний хоолой засахыг сонсохыг хүссэн ч юу ч сонсогдсонгүй. Тэргэл зургаан давхарт хэсэг саатаж дээш өгсөх гэснээ больчихлоо. Энэ лифт намайг дуудаад байна гэсэн бодол Тэргэлийн санаанаас гарахгүй байсаар тэрээр зургаан давхарт нээгдсэн лифт рүү очиж харахаар шийдэх нь тэр. “Дотор нь суухгүй ээ. Зүгээр л очиж харчихаад буцаад шатаараа дээшээ өгсчихнө. Хүн байна уу, үгүй юу гэдгийг нь харчихаад л ирье” хэмээн өөртөө хэлсээр Тэргэл лифт рүү аажмаар зүглэлээ. Түүнийг лифт рүү очихоос өмнө лифт хаагдсанаа дахин нээгдэх чимээ сонсогдов. Тэргэл лифт рүү шагайж харахад урьдын адил хэн ч байсангүй. Уг нь Тэргэлийн хувьд өөрийг нь дагаад байгаа энэ цахилгаан шатнаас хэн нэгэн чимээгүйхэн гэтээд гарад ирнэ гэж болгоомжилж эсвэл горьдож байсан ч тэнд хэн ч байсангүй. Санаа нь ч амрах шиг эсвэл бүр илүү айх шиг ч болсон Тэргэл есөн давхар луу хар хурдаараа гүйлээ. Юу ч болсон түргэхэн шиг гэртээ орчихвол энэ аймшгийн лифтнээс салах болно гэсэн бодол Тэргэлийн толгойд эргэлдсээр тэрээр нэг л мэдэхэд гэрийнхээ хаалганы өмнө ирчихжээ. Ингээд тэрэр яаран сандран хаалгаа балбахад найман давхарт лифтний хаалга нээгдэх чимээ сонсогдлоо. Гэртээ орж ирсэн Тэргэлийн зүрх хурдан хурдан цохилж саяын айдсаасаа

салахыг хичээж байв. Ээж нь түүнээс ямар нэгэн юм болоо юу? Согтуу хүнтэй таараа юу? Хэмээн асуусан хэдий ч тэрээр өөрийнхөө утгагүй гэж үзсэн айдсынхаа тухай юу ч хэлсэнгүй. Өдий хорин таван нас хүрчихсэн аль хэдийн нөхөрт гарах болсон хүүхэн “Өөрөө нээгдсэн цахилгаан шатнаас үхтлээ айгаад...” гэж ярилтай ч биш хэмээн өөрийгөө тайвшруулаад нүүрэндээ хүчээр шахуу инээмсэглэл тодруулан байж ээжийгээ тайвшрууллаа.

Түүнийг хоол идэж байхад нь ч тэр, зурагт үзээд буйдандаа тухлахад нь ч тэр өнөөх өөрийг нь дагадаг цахилгаан шатны тухай бодол санаанаас нь гарсангүй. Уг нь анх нүүж ирэхэд нь цахилгаан шат ажилладагүй гэж хүмүүс ярьж байсан ч хааяа ажиллаад байх шиг байдаг байсан. Энэ лифт өөрийн гэсэн нууцтай, ямар нэгэн адын муу ёрын хар энергийг өөртөө агуулсан нь дамжиггүй мэт Тэргэлд санагдана. Өмнө нь энэ орцонд амьдардаг байсан зарим хүмүүс алга болсон шалтгаан бол зөвхөн энэ цахилгаан шат гэдэгт Тэргэл бат итгэлтэй байдаг билээ. Хамгийн түрүүнд орцны жижүүр хийдэг байсан хижээлдүү насны авгай болсон. Тэр жижүүрийг Цэрмаа гэдэг байсан. Хамгийн сүүлд түүнийг лифтэнд сууж байхыг Тэргэл харсан, гэхдээ хаана хэдэн давхарт буусныг нь мэдээгүй. Магадгүй тэр жижүүр лифтэнд ороод тэндээсээ гарч ирээгүй. Хараал шингэсэн цахилгаан шат түүнийг хаашаа ч юм аваад явчихсан. Нөхөр нь хүүхдүүд нь дүү нар нь гээд өч төчнөөн хүмүүс түүнийг цагдаа нартай нийлэн хайсан ч арваад хоног сураг чимээ нь гараагүй. Бүгд л түүнийг үхсэн гэдэгт итгэлтэй байсан хэдий ч тэрээр нэг л өдөр эргээд ирсэн.

Тэр өдөр Тэргэл ажлаа оройтож тараад юмыг яаж мэдэхэв, цахилгаан шат ажиллаж байвал түүгээр дээш өгсөхөөр шийдэж дуудах товчлуурыг дарж билээ. Цахилгаан шат ч хүнгэнэн дуугарсаар нэг давхарт ирэн нээгдэхэд өнөөх алга болоод арав гаран хоносон жижүүр авгай тэнд зогсож байх нь тэр. Тэргэл цочсондоо эгээтэй л ухаан алдаад уначихаагүй. Цэрмаа авгай амьгүй мэт хүйтэн харцаараа Тэргэл рүү нүд цавчилгүй ширтэж байсан. Тэр нүдэнд ямар ч амьдын гал цог байгаагүй. Цэрмаагийн нүд рүү харсан Тэргэл яг л хурц зүүгээр хатгуулж байгаа юм шиг эмзэглэж билээ. Тэргэл Цэрмаа авгайтай удаан ширтэлцэж тэсэлгүй дээшээ шатаар гүйчихсэн. Эргэж ч хараагүй. Ямартай ч орцны жижүүр хийдэг байсан Цэрмаа авгай урьдын малилзтал инээдэг сайхан ааштай Цэрмаа биш болчихсон байсныг олон хүн баталсан даа. Түүнийг гэнэт цахилгаан шатнаас гараад ирэхэд олон хүн гайхаж юу болсон тухай асуухад тэрээр юу ч яриагүй. Уруул нь хөхөрч, царай нь хувхай цагаан болчихсон байсан Цэрмаа гартаа тааралдсан болгоноо ховдоглон идэж байсан гэх. Хичнээн олон аяга хоол өгөөд ч цадахгүй, сүүлдээ бүр түүхий мах цуслан идэж эхэлсэн тухай хүмүүс ам дамжин ярьж байлаа. Тэргэлийн хувьд нэг өглөө гэрээсээ гараад явж байхдаа Цэрмаа авгайн хальслаагүй түүхий төмсийг яг л алим шиг шижигнэтэл нь зажилж байгааг харсан юмдаг. Түүнээс хойш Тэргэл тэр Цэрмаа авгайтай дахин тааралдахгүйг хичээх болсон. Арваад хоног өнгөрсний дараа тэр Цэрмаа авгай нөхөр хүүхдүүддээ унтсан хойно нь алахаар завдаад оролдлого нь бүтэлгүйтэн өөрөө нөхрийнхөө гарт алагдсан. Яг тэр үед жигшүүрт хэргийн дараагаас эхлээд л Тэргэлийн амьдардаг орцны дээд давхрын айлуудын зарим нэг хүмүүс алга болж эхэлсэн. Гэхдээ урьдынхаасаа шал өөр хүмүүс болчихсон байдаг. Хэд хэдэн удаагийн ийм тохиолдлуудын эцэст энэ орцонд жижүүр тогтохоо больж айлуудын нүүж суух нь ихэссэн.

Ийнхүү Тэргэл цахилгаан шатыг тойрсон элдэв бодлуудаар толгойгоо гашилгасаар нойрондоо дийлдэн нам унтаад өглөө сэрэв. Ажилдаа очих цагаасаа хоцорчихжээ. Ялангуяа сэтгүүлчийн

ажил гэдэг цаг наргүй байдаг юм хойно тэрээр яаран сандран хувцаслаж гарав. Түүний хувьд өнөөдөр өглөө эрт болох шүүх хуралд оролцож тэндээс мэдээ бэлдэх ёстой байсан. Гэтэл тэрээр энэ ажлаасаа бүхэл бүтэн нэг цагаар хоцорчихоод байлаа.

-Миний охин яасан их яарч байх юм. Ядаж жаахан цай амсаад гараач гэсэн ээжийнхээ үгийг Тэргэл авч хэлэлцсэнгүй. Гадуур хувцсаа шүүрэн аваад гэрийнхээ хаалгыг ч гүйцэд хаалгүй шатаар уруудлаа. Гэтэл түүнийг ийнхүү доош уруудсаар найман давхарт ирэхэд лифтний хаалга нээгдэх чимээ сонсогдлоо. “Яг л яарч яваа Тэргэлд туслах гэсэн мэт...”

Тэргэл шатан дээо зогтусч яахаа мэдэхгүй эргэлзлээ. “Өнөөх л цахилгаан шат намайг авч явахаар өөрөө ирлээ ” гэсэн бодлд Тэргэлийн толгойд эргэлдэж айдас төрүүлэв. Гэхдээ тэрээр доошоо гүйчихэж чадсангүй. Яагаад ч юм хэн нэгэн цахилгаан шатанд суухыг ятгаад байгаа юм шиг сэтгэгдэл төрж өөрийн эрхгүй эргэлзэн тээнэгэлзэх аж. Тэргэл яахаа мэдэхгүй ийм байдалтайгаар бараг гурван минут хэрээтэй зогсоод эцэст нь явган шатаар доошоо уруудан гүйлээ.

Тэрээр орцноосоо гараад цээж дүүрэн амьсгалж аваад автобусны буудал руу зүглэн гүйсээр байхдаа “энэ лифт намайг авч явахын тулд бүр нам унтуулж ажлаас минь хүртэл хоцруулдаг болжээ” хэмээн өөртөө хэлж байв.

Үнэхээр л сүүлийн өдрүүдэд Тэргэл өглөө болгон нам унтаж ажлаасаа хоцроод гэрээсээ гарах болгондоо яг найман давхарт өнөөх цахилгаан шат өөрөө ирээд зогсох чимээг сонсдог. Уг нь ажилладаггүй гэж хүмүүсийн яриад байдаг цахилгаан шат гайхмаар мөртлөө нэг бодлын сайшаалтай хэрэг. Гэхдээ тэндээс хэн ч гарч ирэхгүй, бас хаалга нь хаагдаж нээгдэхээс өөр ямар ч чимээ гардаггүй. Ингэж цахилгаан шат өөрөө ирж зогсох болгонд Тэргэл яагаад ч юм лифтэнд орчихдог ч юм билүү хэмээн эргэлзэж яг л хэн нэгэн этгээд өөрийг нь алсаас ятгаад байгаа юм шиг санагддаг тухайгаа бодсоор бүр хямарчихаад байлаа. Тэрээр зам дээр ирээд таксид гар өргөн зогсоож суухдаа саяхан гарч ирсэн орц руугаа эргэн харлаа. “Одоо өнөөх лифт чинь нэг давхарт ирчихээд намайг хүлээж байгаа даа” гэсэн Тэргэлийн бодол машины хөгжмөөр явж буй уянгын аятай нэг л авцалдахгүй аж.

Өдөр өнгөрдгөөрөө өнгөрч Тэргэл харуй бүрий болсон хойно ажлаа тарж гэрийнхээ зүг явлаа. Одоо өнөөх лифт дахиад л намайг дагах болов уу гэсэн бодол түүний санаанаас гарсангүй. Орц руугаа явж орлоо. Доод давхрууд хав харанхуй байх нь тэр. Ямар ч хүн байхгүй, чимээ аниргүй, хав харанхуй тийм орчин Тэргэлийг угтан авлаа. Тэргэлийн орц жижүүргүй болохоор гудамжны хулгайч нар хамаг чийдэнг нь түүчихдэг нь сүүлийн үед хэвийн үзэгдэл болсон. Энэ удаа ч бас өнөөх чийдэнгийн эрлэг болсон сайн эрчүүд Тэргэлийн орцоор дайраад өнгөрсөн бололтой. Тэрээр харанхуйгаас аргагүй жийрхэж дээд давхрууд руугаа харлаа. Ердөө ганцхан давхар л гэрэлтэй байгаа нь сүүмийн харагдана. Лифтний хаалга хяхтнан нээгдэв. Нэг давхрын лифт рүү явж ордог тэр хэсэг газарт бүүдийсэн гэрэл туслаа. Энэ нь үнэхээр лифт ирж зогссоныг илтгэж байх бөгөөд мөн л урьдын адил тэндээс хэн ч гарч ирсэнгүй, хэн ч орсонгүй. “Золиг гэж, надаар ер нь яах гэсэн юм бол доо...” Тэргэл хэдий ганцаараа байсан ч өөрийн эрхгүй ийн шивнэжээ. Тэргэлийн хувьд харанхуй орцонд явган шатаар дээшээ өгсөнө гэдэг тийм ч таатай санагдахгүй байсан бөгөөд цахилгаан шатанд сууна гэдэг дээр бүр ч ярилтгүй байлаа. Хав харанхуй нэг давхарт хэсэг саатан зогссон Тэргэл хэн нэгнийг орц руу ороход нь хамт орьё гэж шийдээд буцаж

гарав. Өлийн жихүүн салхи Тэргэлийн хацар нүүрийг жиндтэл үлээж хүйтний эрч улам бүр нэмэгдэх нь тэр. Гудамжны утаснаас гэрлүүгээ залгаж үзсэн хэдий ч гэрт нь хэн ч байхгүй байгаа бололтой холбогдож чадсангүй. Цонх руугаа харсан ч бүх өрөөнийх нь гэрэл унтраалттай байгаа нь Тэргэлийн нүдэнд өртлөө.

Орц руу орох хүн бараг хагас цаг хэрээтэй хүлээсэн хэдий ч ирсэнгүй. Ингэсээр даарахаас халширсан Тэргэл буцаад дотогшоо оров. Түүнийг дөнгөж ормогц лифтний хаалга урьдын адил нээгдлээ. Энэ удаад Тэргэл юу ч бодолгүй явган шатаар дээш өгсөв. Хоёр хоёр гишгүүрээр алгасан гишгэх тэрээр хурдхан гэртээ орохсон гэхээс байж ядна. Дөрвөн давхарт ирэхэд лифт урьдын адил ирж нээгдлээ. Тэргэлийн дотор хүйт оргиж нүдэнд нь нулимс цийлэгнээд ирсэн ч тэрээр зогссонгүй алхаагаа улам түргэсгэв. Зургаан давхарт дахиад л лифтний хаалга нээгдэх чимээ...

Энэ удаад Тэргэлийн нүднээс нулимс асгарч эхэллээ. “Хараал идсэн, новшийн лифт одоо намайг дагаж явсаар найман давхарт ч гэсэн нээгдэнэ биз. Намайг очно л гэж бодож байгаа юм байхдаа. Гайгүй байлгүй... ёстой гонж...” Гэтэл энэ удаад лифтний хаалга нээгдэх чимээнээс гадна хэн нэгэн жаахан охины мэгшин уйлах нь Тэргэлийн чихнээ сонсогдлоо.

ЭГЧ ЭЭ ТА ХҮРЭЭД ИРЭЭЧ ДЭЭ, ГУЙЖ БАЙНА...

Тэргэл сонссондоо итгэсэнгүй. Жаахан охин цахилгаан шатан дотор мэгшин уйлж бүр намайг дуудаж байна шүү дээ гэж бодохоос ар нурууных нь хүйтэн хөлс чийхрах шиг болно. Тэргэл сонссондоо эргэлзэж тэр өөрийг нь дагаж ирээд нээгдсэн лифтэн дотор ямахуу янзтай охин өөрийг нь хүлээж байгааг төсөөлөн бодохоос нүд нь харанхуйлж ирлээ.

ЭГЧ ЭЭ ТА ХҮРЭЭД ИРЭЭЧ ДЭЭ, ГУЙЖ БАЙНА...

Тэргэлийн толгой эргэх шиг болоход шатны бариулаас хоёр гараараа зуурч авлаа. “Хэрвээ тэр лифтэнд байгаа жаахан охинд би үнэхээр хэрэгтэй юм бол яагаад өөрөө гарч ирэхгүй байгаа юм бол оо” гэсэн бодол Тэргэлийн толгойд эргэлдсээр. Тэрээр зогсож байсан газраасаа хөдөлж чадахгүй байсаар байв. Лифтний хаалга нэг нээгдэж, нэг хаагдах чимээ гарна.

ЭГЧ ЭЭ ТА ХҮРЭЭД ИРЭЭЧ ДЭЭ, ГУЙЖ БАЙНА... гиншин уйлж, шивнэн хэлэн энэ үгс Тэргэлийн чихэнд тодоос тод дуулдсаар. “хэрвээ энэ лифтэнд хэн нэгэн байлаа гэхэд ямар ч байсан тэндээсээ гарч ирж чаддаггүй байх нь” гэсэн дотор жихүүцүүлэм бодол энэ мөчид Тэргэлд төрөөд амжив. Тэрээр ямар ч хөдөлгөөн хийж чадахгүй байсны хажуугаар ядаж хоолойгоо засах чимээ гаргах гэсэн хэдий ч ердөө болсонгүй. Яг л хэн нэгэн багалзуурыг нь шахаад юу ч яриулахгүй байгаа мэт...

Тэргэл лифт рүү очихоор шийджээ. Тэнд ямар ч буг чөтгөр нь байлаа гэсэн энэ мөчид очихоос өөр сонголт байхгүй мэт Тэргэлд санагдана. Ингээд зургаан давхрын сүүмгэр гэрэл тусгах цахилгаан шат байрлах тэр зүг рүү Тэргэл дөхлөө. Нэг алхам, хоёр алхам, гурван алхам... одоо ахиад гурваас дөрвөн алхам хийхэд лифтэнд хэн байгааг харах болно. Тэргэлийн хамаг бие нь салганан чичирч зүрх нь хурдан хурдан цохилж байв. Буцаад гүйдэг ч юм билүү гэж эргэлзсэн хэдий ч энэ хүрчихээд буцна гэдэг гомдолтой мэт санагдана. Тэргэл хүрээд ирлээ. Одоо ердөө ганцхан алхаад эсвэл хүзүүгээ жаахан сунгаад бүүдгэр гэрэлтэй цахилгаан

шатанд хэн байгааг харах болно.

ЭГЧ ЭЭ...

Тэргэл шагайлаа. Тэгээд санаанд оромгүй зүйлийг олж харах нь тэр. Таваас зургаан насны цагаан даашинзтай жаахан охин буруу харан зогсчихоод мэгшин уйлж байх нь тэр. Тэрээр далаа хүртэл ургасан буржгар хар үстэй юм. Даашинзных нь хормой цусанд будагдчихсан байх бөгөөд Тэргэл харцаа улам доошлуулав. Лифтний шаланд өтгөн улаан цус тунаран харагдаа. Тэргэл хэдий хичээсэн ч энэ үзэгдлээс харцаа салгаж чадсангүй. Өнөөх буруу харан зогсоод мэгшин уйлж байсан жаахан охин Тэргэлийн ирснийг мэдэв бололтой аажмаар эргэлээ. Энэ үед охины ард хэн нэгэн насанд хүрсэн эмэгтэй хүн байна гэдгийг Тэргэл мэдрэх шиг болов. Цэлдэн хөх царайтай ямар ч цагаангүй хар нүднээс нь цусан улаан нулимс гоожих адын муухай царайтай жаахан охин Тэргэл рүү аврал эрэх мэт гараа сунгалаа. Гар нь ч гэсэн ялгаа алга, хөшинги байдалтай, цэлдэн хөх байгаа нь цахилгаан шатны сүүмгэр гэрэлд харагдав. Тэргэл арайхийн сэхээ авч энэхүү санаанд багтамгүй аймшигт үзэгдлээс харцаа арайхийн салгаад муухай хашхиран дээшээ гүйчихлээ. Тэрээр замдаа нэг ч удаа зогссонгүй.

Нэг мэдэхнээ Тэргэл гэртээ ороод ирчихжээ. Гэрт нь хэн ч байхгүй байсан хэдий ч чухам яаж цоожтой хаалгаа нээгээд гэртээ орж ирснээ тэрээр санахгүй байв. Энэ хугацаанд Тэргэл айснаасаа болоод ухаанаа алдчихсан байсан бололтой. Ямартай ч тэрээр гэрийнхээ утасны харилцуураас тас атгачихсан байгаагаа мэдсэн бөгөөд ээж рүүгээ ярьж хурдан ирээч хэмээн уйлж унжсанаа бүүр түүрхэн санах шиг. Удалгүй Тэргэлийн аав ээж хоёр нь ирж сүйд болцгоох нь тэр. Тэргэлийг яасан ийсэн хэмээн шалгааж тайвшруулахыг хичээж эмч дууджээ. Дуудлагын эмч ирээд Тэргэлд тайвшруулах тариа хийснээр түүний бие түрүүчийхээс арай дээрдэв. Тэрээр болсон явдлын талар ээж аавдаа хангалттай ярьсангүй. Ердөө л цахилгаан шат намайг дагаад өөрөө нээгдэж байсан гэснээс өөр юм хэлээгүй. Ялангуяа тэр цусаар уйлж байсан аймшгийн нүдтэй жаахан охиныг бүр дурсахыг ч хүссэнгүй, зүгээр л тийм юм огтхон ч болоогүй гэдэгт өөрийгөө итгүүлэхийг хичээж байлаа. Энэ шөнө Тэргэл маш ихээр айж байсан учраас ээжийнхээ өвөрт унтахаар болжээ. Хүний эх гэдэг хамгаас их нөмөр нөөлөгтэй, дулаан таатай мэдрэмж төрүүлдэг юм хойно Тэргэл аажим аажмаар тайвширч эхэллээ.

Өмнө нь алга болоод эргэж ирсэн нэгэн залуу Тэргэлийн санаанд оров. Тэрээр ирснээсээ хойш өнөөх жижүүр байсан Цэрмаа авгай шиг тааралдсан болгоноо идээгүй, харин ч бүр юу ч идэхгүй зөвхөн нэг жаахан охины тухай эцэс төгсгөлгүй ярьсаар байснаа сэтгэцийн эмнэлэгт хүргэгдэж, тэндээ нас барсан гэж дуулдсан. Тэргэл тэр залууг цахилгаан шатанд суугаад алга болсноо хэд хоногийн дараа эргээд ирсэн гэдэгт эргэлздэггүй. Хөршүүд нь түүнийг Хөлөгөө гэж дууддаг байсан. Хэдийгээр Тэргэл Хөлөгөөг цахилгаан шатанд суухыг нь нүдээрээ хараагүй ч тэр залуугийн гэр нь найман давхарт байдаг болохоор ямар нэгэн байдлаар цахилгаан шатанд суух магадлал өндөртэй гэж боддог. Уг цахилгаан шатны ажиллагаа юунаас болоод ч юм бүрмөсөн зогсоосон гэж ярьдаг ч хааяа ажиллаж л байдаг болохоор хүмүүс үйлчлүүлэх нь дамжиггүй. Эсвэл магадгүй хэн нэг нь дураараа ямар нэг юмыг нь хөдөлгөөд л ажиллуулчихдаг биз. Ер нь л энэ орцонд учир битүүлгээр алга болж, дараа нь эргэж ирээд удалгүй нас барсан дөрвөн хүний гурав нь зургаагаас дээш давхарт



амьдардаг байсан. Мэдээж үлдсэн ганц нь жижүүр байсан Цэрмаа авгай. Цэрмаагийн хувьд бол жижүүр учраас дээшээ доошоо байнга явдаг, цахилгаан шат таарвал суухгүй өнгөрч чадахгүй гэдэг нь ойлгомжтой. Тийм болохоор энэ бүх хүмүүсийн амь амьдралыг зөвхөн тэр хараал идсэн цахилгаан шат, бас дотор нь байсан аймшгийн охин хоёр залгисан. Магадгүй цахилгаан шатанд цусаар уйлсан муу ёрын охиноос гадна өөр хэн нэгэн байсан ч байж мэднэ. Охиныг эргэж харах үед ард нь хэн нэгний унжсан гар харагдах шиг болсон. Гэхдээ маш их айсан болохоор юу байсныг нь сайн анзаараагүй. Тэргэл ийнхүү бодол болон хэвтсээр Яагаад ч тэрхүү цахилгаан шаттай холбоотой учир битүүлэг нууцын талаар олж мэдэх гэсэн эрмэлзэл нь улам ихээр нэмэгдэж байгаад өөрийгөө гайхаж байлаа. Тэргэл унтаж чадсангүй. Зүгээр л ээжийгээ тайвшруулахын тулд унтсан дүр үзүүлээд элдвийг бодсоор үүр цайлгажээ. Энэ өглөө Тэргэл өвчтэй гэж ажлаасаа чөлөө аваад явсангүй. Өчигдрийн тэрхүү аймшигтай гэнэтийн дүр зураг санаанаас нь гарахгүй тарчлаасаар байлаа. Тэрээр гэрээсээ ч гарсангүй, хүнтэй ч нэг их юм ярьсангүй. Зүгээр л телевизор ширтэж, сүү хөөрүүлж уусаар гэрээсээ хамраасаа ч цухуйлгасангүй. Энэ янзаараа хэдэн өдөр өнгөрлөө.

Тэргэлийн дотор хуралдаад байгаа айдас бага багаар арилж байсан хэдий ч гэрээсээ гарах тухай бодохоор өнөөх цахилгаан шаттай холбоотой бодлууд урган гарч ирээд хоолой дээр нь нэг юм тулаад ирэх шиг болно. Түүний энэхүү элий балай байдалд нь санаа зовсон ээж нь эмч домч, лам хараар явах нь ихслээ. Тэргэлийн хувьд ажилдаа ч санаа тавихаа больж хөндлөнгийн хүн харахад гэрээсээ хэзээ ч гарахгүй хэмээн шийджээ гэмээр сэтгэгдэл төрүүлэхээр байлаа. Орой болж хүмүүсийн хөл хөдөлгөөн татарчээ. Өглөө эрт дэлгүүр явна гээд гарсан ээж нь одоо болтол байдаггүй. Тэргэл зурагтаар хошин шогийн нэвтрүүлэг үзэж байсан ч дотроо ээжийгээ харуулдсаар. Зурагтныхаа хажууд байрлах ширээний цаг руугаа үе үе хяламхийсээр хорин дөрвөн цаг өнгөрөхөд тэрээр ээждээ илт санаа зовниж эхэллээ. Ядаж байхад энэ өдөр Тэргэлийн аав нь хөдөө ажлаар явчихсан билээ. Тэргэл тогтож сууж чадахаа болино гараа элгэндээ зөрүүлэн алхална. Ээж нь өглөө гарахдаа гар утсаа гэртээ орхичихсон болохоор холбоо барих ямар ч арга байсангүй. Дэмий л утас чагнаж хаалга тогшихыг хүлээж байлаа. “Ээж арай нөгөө цахилгаан шатанд...” гэсэн бодол Тэргэлд төрсөн хэдий ч тэрээр энэ бодлоосоо хурдхан шиг татгалзлаа. Үнэхээр Тэргэлийн хувьд хамгийн ихээр хүсэхгүй байгаа зүйл бол тэрхүү муу юм шүглэсэн лифтэнд суусан байлаа гэхэд бусад хүмүүийн нэгэн адил алга болох болно гэсэн айдас Тэргэлийн толгойд эргэлдэж байлаа. Тэгээд хэсэг хугацааны дараа эргээд ирэхдээ ээж нь огт танихгүй хүн болчихно гэхээс Тэргэлийн нүд харанхуйлах шиг болно. Тэргэлд муу ёры совин татаж огтхон ч тайван сууж чадахгүй байссаар эцэст нь гадаа гарч ээжийгээ тосохоор шийдлээ.

Гар чийдэн бариад дулаан хувцсаа өмссөн Тэргэл харанхуй орцныхоо шатаар аажмаар уруудсаар. Орцонд ямар ч чимээ аниргүй бөгөөд Тэргэлийн тусгаж буй гар чийдэнгийн тусгалаас өөр ямар ч гэрэл үл харагдана. Тэрээр лифтний хаалга нээгдвэл яана аа хэмээн айж байсан ч замаасаа буцсангүй. Ямартай ч найман давхарт лифтний хаалга нээгдээгүй нь Тэргэлд гайхах баярлах мэдрэмжийг зэрэг зэрэг төрүүлж байв. Долоон давхрыг өнгөрөн уруудаж зургаан давхарт ирлээ. Яг энэ давхарт өнөөх ад зэтгэрийн охин сууж байсан...

Тар няр хийх дуу хадаасаар цахилгаан шат нээгдлээ. Энэ чимээг сонссон Тэргэл эгээтэй л ухаан алдаад уначихсангүй. Тэрээр сэхээ авмагцаа хэд хэдэн шат алгасан харайсаар доошоо гүйчихэв. Таван давхар...дөрвөн давхар...лифтний хаалга нээгдэх чимээ...Тэгээд эцэст нь

МИНИЙ ОХИН ХҮРЭЭД ИРЭЭЧ гэсэн ээжийнх нь дуу.

Гурван давхар дөрвөн давхар хоёрын хоорондох шатны голд ээжийнхээ ийнхүү дуудахыг сонссон Тэргэл хөшиж орхижээ. Тэрээр саяынхаа сонссонд эргэлзэж байлаа. Яахаа мэдэхгүй тээнэгэлзэн зогсоор нэлээд удаан саатлаа. Дээшээ очоод хаалга нь нээгдээд байгаа цахилгаан шатанд юу байгааг харахыг хүсч байсан ч тэрээр айсандаа хөдөлж ч чадсангүй. Тэнд юу чбайж мэднэ, нөгөөх цусаар уйлсан аймшгийн охин урьдынх шигээ зогсож ч байж мэднэ. Тийм болохоор очоод хэрэггүй хэмээн Тэргэлийн дотоод сэтгэл өөртөө шивнэж байсан ч гэлээ тэрээр доошоо гүйчихэж чадахгүй л байв. Ингэсээр эцэст нь Тэргэл цахилгаан шатанд ээж нь байна уу үгүй юу гэдгийг очиж шалгахаар шийджээ.

Бурхан минь битгий л ээж байгаасай хэмээн залбирсаар Тэргэл шатаар аажимхан өгслөө. Лифтний хаалга нэг хаагдаж нэг нээгдсээр магадгүй зөвхөн Тэргэлийг л хүлээх мэт. Нүүрээр нь хүйтэн хөлс цутгаж хамаг бие нь салгалах тэрээр урагшаа бага багаар дөхсөөр лифтэнд бараг хүрээд ирчихлээ. Одоо нэгхэн алхам хийгээд лифтэнд хэн байгааг харах болно. Тэргэл нэг гүнзгий амьсгаа аваад сүүлийн алхмаа хийлээ.

Дотор нь хэн ч байхгүй лифтний хаалга өөрөө нээгдэж хаагдсаар байгаа нь Тэргэлийг суухыг урих мэт. Ээж ээ, та хаана байна аа хэмээн дуулдах төдий шивнэх Тэргэлийн үгийг хэн ч сонссонгүй. Зөвхөн цахилгаан шат л “наашаа ороод ир тэгвэл ээжийгээ олно” гэх мэт тар няр хийх дуу хадааж хаалгаа нээж хаасаар... Удтал зогссоны эцэст Тэргэл цахилгаан шатанд орохоор нэг мөсөн шийдэх нь тэр. “Энэ цахилгаан шат намайг хүсч байна. Энэнд зөвхөн би л хэрэгтэй хэрвээ би яг одоо л ийшээ орохгүй бол ээжийгээ дахин хэзээ ч олохгүй байж мэднэ. Тийм ээ, энэ үнэн. Энэ хараал идсэн цахилгаан шат хүний амьдралыг залгидаг гэдгээ өмнө нь олон хүнээр батлан харуулсан. Намайг золиосоо болгохоор шийдсэн хэдий ч бүтэхгүй болохоор нь ээжийг минь аваад явчихлаа...” Тэргэл өөрөө өөртэйгөө ийнхүү бодлоороо ярилцаад цахилгаан шатанд явж орлоо.

Түүнийг ормогц лифтний хаалга хаагдаж ямар ч товчлууур дараагүй байхад доошоо буулаа.

Үнэндээ Тэргэл маш ихээр айж байв. Лифт хаашаа ч юм нэг тийшээ яваад л байна. Ердөө зогсохгүй маш удаанаар явсаар байна. Уг нь хамгийн доод давхарт очих хангалттай хугацаа өнгөрсөн хэдий ч явсаар. Энэ лифт магадгүй ингээд хэзээ ч зогсохгүй юм байх даа гэсэн бодол Тэргэлд төрж хажуудаа байгаа бүх л товчлууруудыг дарж үзээд ямар ч тус олсонгүй. Аргаа барж хаалгаа маш хүчтэйгээр балбасан ч хэн ч хариу хэлсэнгүй, лифт үргэлжлүүлэн явсаар. Тэргэл аргагүй алдан хашхичиж чарлаж гарлаа. Лифт доошоо уруудсаар л байв. Магадгүй энэ цахилгаан шат ингэж явсаар хүнийг тамд аваачдаг юм болов уу ч гэж бодох шиг. Тэргэл цөхрөнгөө баран уйлж явган суугаад ээжээ хэмээн аяархан шивнэж байв.

Ингэсээр цахилгаан шат гэнэт ёгхийтэл зогсчих нь тэр. Явган сууж байсан Тэргэл ухасхийн бослоо. “Ашгүй хаалга нээгдвэл шуудхан гараад гүйчихье” гэж бодсоор Тэргэл биеэ зэхэж байтал хаалга нээгдлээ. Огтхон ч танихгүй орц байх нь тэр. Хананы будаг, шалны плита гээд цөм өөр байлаа. Ойролцоогоор тав зургаан жилийн өмнө л орон сууцнуудын орцууд ийм будагтай байсан мэт санагдана. Хамгийн гол нь Тэргэлд энэ бүхэн өөрийн нь орцноос өөр юм гэсэн санаа төрүүлсэн зүйл бол чийдэн байв. Үргэлж харанхуй байдаг орц нь чийдэнтэй байгаа явдал бол Тэргэлийн хувьд их л гайхмаар санагдав. Ийнхүү Тэргэлийг цахилгаан

шатнаас дөнгөж гарах гэхэд хамраас нь цус гарч нулимсандаа хутгалдсан гуч орчим насны нэг бүсгүй гараасаа жаахан охин хөтөлчихөөд гүйгээд ороод ирлээ. Тэргэл тэдний хажуугаар өнгөрөхийг хүссэн ч амжсангүй, цахилгаан шатны хаалга хаагдах нь тэр.

-Хүлээгээрэй эгч ээ, би буугаадахья гэж хэлсэн ч өнөөх хүүхэд хөтөлсөн үл таних эмэгтэй хариу хэлсэнгүй. Тэрээр зөвхөн гомдол цөхрөл, үзэн ядалт шингэсэн нүдээр гартаа хөтөлсөн охиноо ширтэж байв. Цахилгаан шат дахиад л доошоо явлаа. Энэхүү хөтлөлцөн зогсож буй хоёр харваас ээж охин гэдэг нь андашгүй аж. Тэдний хэн хэн нь Тэргэлийг хажуудаа зогсож байгааг анзаарахгүй эсвэл бүр мэдэхгүй байгаа бололтой. Өнөөх уур хорсол шингэсэн аймшгийн нүдтэй эмэгтэй охин руугаа зэвүүцэнгүй харж байснаа лифт зогсоох товчлуурыг дараад үснээс нь атгаж аваад лифтний хана мөргүүлж гарах нь тэр. Үүнийг нь Тэргэл хэдий хорихыг хүссэн ч ердөө болсонгүй. Ээж охин хоёрын хэн хэн нь түүнийг огтхон ч харахгүй байлаа.

-Чиний тэр өөдгүй бузар эцэг чинь намайг хуурсан, чи бол тэр новшийн адгуус шиг залуугийн зулбасга. Хэдийгээр би чамайг төрүүлсэн ч гэсэн чи тэр новшийн хүүхэд нь мөн. Тэр өөдгүй амьтан чинь чамайг ч намайг ч хаяад өөр хүүхний бөгсөнд донтоод явчихсан. Мэдэж байна уу чи? Сая намайг тэр гичийгээсээ өмөөрөөд алах шахлаа шүү дээ.

-Ээж ээ болиоч дээ, өвдөж байна шүү дээ. Би ямар буруу хэрэг хийгээ вэ?

Охиноо хайр найргүй балбаж байсан үл таних эмэгтэй гэнэт өрөвдөх сэтгэл нь төрөв бололтой хэрцгий үйлдлээ зогсоолоо.

Тэргэл энэхүү золгүй охиныг сайтар ажвал өнөөх хэд хоногийн өмнө өөрийг нь цахилгаан шатанд дуудаж байсан охин мөн бололтой аж.

Үл таних эмэгтэй учиргүй уйлж гарав. Охин минь намайг уучлаарай, ээжийгээ уучлаарай... Эмэгтэй ингэж хэлмэгцээ хумстай хуруугаараа нүүрээ хайр найргүй самардаж гарлаа. Тэр эмэгтэй “Би яах ёстой юм бэ?” хэмээн чарлаж байв. Тэргэл тэр эмэгтэйг болиулах гэж гарнаас нь барьсан хэдий ч түүнд ямар ч саад учруулж чадсангүй. Бүр хүний гарнаас барьсан юм шиг мэдрэмж ч төрсөнгүй. Эмэгтэй өөрийнхөө нүүрийг самардсаар цусаа савируулж бүр нүдээ хүртэл ухаж орхих шиг болов. Тэгмэгцээ халааснаасаа нарийхан мэс заслын хутга гаргаж ирээд хүүе гэхийн завдалгүй хоёр гарынхаа судсыг ээлжлэн ханачих нь тэр. Цахилгаан шатны бүдэг гэрэлд цус тасралтгүй урсаж буй нь харагдаж жаахан охин чарлан дэвхэцсээр.

“Ээж ээ битгий үхээч дээ, битгий үхээч дээ. Би ааваас таныг битгий орхиоч гэж гуйя тэгэх үү ээж ээ...” охин ийнхүү хоолойныхоо чадлаар хашхичин дэвхцэж байлаа. Тэргэлийг харсаар байтал цахилгаан шатны шалан дээр цусан улаан шалбааг бий болов. Охины цагаан даашинзны хормой улаан цусанд будагдаад ирмэгц тэрээр авраарай хэмээн лифтний хаалга балбасан ч хэн ч ирсэнгүй. Жаахан охин өөрийн нь нүдэн дээр амиа хорлосон ээжийгээ хараад байж тэссэнгүй бололтой хамаг бие нь салганан чичирч байснаа зүрхэн тус газраа алгаараа дараад лифтний хана налан унах нь тэр.

...Тэргэл эмнэлгийн орон дээр ухаан орлоо. Түүний хажууд ээж нь санаа нь зовсон байртай цагаан халаад нөмрөн сууж байв.

-Ээж нь охиноо ухаан орохыг хүлээж байлаа. Миний охины бие нь яаж байна. Ээжтэйгээ ярьж чадах нь уу?

-Би зүгээр байна аа ээж ээ. Таныг харсандаа маш их баярлаж байна

-Ээж нь ч гэсэн баярлаж байна. Муу охиноо золтой л эрлэгийн оронд явуулчихсангүй.

-Ээж ээ та намайг хаанаас олсон бэ?

-Чи лифтнээс гарч ирсэн

-Аав хаана байгаа юм бэ?

-Гэрээ нүүлгэж байгаа, охин минь. Одоо хэдүүлээ амар тайван амьдрах болно

-Би хэд хоног ухаангүй байсан бэ?

-Бараг сар гаран болсон байх. Гэхдээ одоо эмч чамайг зүгээр гэсэн, лам багш ч тэгсэн.

-Лам аа?

-Тийм ээ, лам. Чи ухаангүй байх хугацаандаа нэг жаахан охины тухай эцэс төгсгөлгүй ярьж уйлаад л заримдаа инээгээд л байсан. Сайн лам багшийн хүчээр л охиныхоо амийг тогтоолоо. Чамайг муу ёрын сүнсний хорлол болчихсон байна гэсэн шүү.

-Зовж үхсэн хүмүүсийн сүнс өөрсдийнхөө үхлийн шалтгааныг бусдад тайлбарлах гэж оролддог юм шиг байна лээ

-Тэгэлгүй яахав охин минь, лам багш ч гэсэн яг ингэж хэлсэн.

Хэдий цасан шуургатай байсан ч гэлээ Тэргэлийн аав нь олон хүмүүстэй нийлэн хамаг тавилгаа ачаалан нүүж байлаа. Энэ нүүдлийг харж зогссон хоёр эмгэн юу болохыг нь ажиглан цасыг нь арчсан сандал дээр тухлан суусан харагдана.

-Таван жилийн өмнө цахилгаан шатанд үхсэн ээж охин хоёрын сүнс энэ орцныхыг тайван байлгахгүй нь дээ.

-Чухам аа чухам. Бүх юм тэр амиа хорлодог хүүхний нөхрөөс болж байхгүй юу. Өөр юмтай сүүлрээд эхнэрээ баахан доромжилдог байсан гэсэн. Эхнэрээ амиа хорлосны ердөө маргааш нь осолд ороод эрэмдэг, мэдрэл муутай үхсэн амьдын хооронд болчихсон гэсэн. Эхнэр нь ч гэсэн дээ, толгойдоо жаахан юмтай байсан гэдэг.

-Тэр амьд байгаа нөхөр нь үхэж байж л эх охин хоёрын сүнс амрах вий.

-харин тийм ээ. Тэр явдлын гайгаар энэ орцныхон нүүсээр байгаад бараг айл үлдэхгүй болох нь. Уг нь хороонд хүсэлт гаргаад аль эрт цахилгаан шатны ажиллагааг нь зогсоосон гэсэн. Тэгсэн чинь нэг удаа намайг энэ орцонд ороход яах аргагүй л лифтнийх нь хаалга нээгдэх

чимээ гарсан юм. Би ч ум хумгүй л буцаад гараад ирсэн шүү.

-Энэ орц руу орох зоригтой амьд амьтан олдохгүй болох вий

-Шинээр орсон айлуудад уг нь энд ирэх дэмий гэж хэлмээр л байх юм. Даанч хөгшин бидний үгийг сонсох хүн олдох биш.

-Чухам аа, чухам. Би яг наадхыг чинь хүмүүст хэлж үзсэн л дээ. Тэгээд шанд нь “тэнэг хөгшин зөнөг” гэж хэлүүлээд түүнээс хойш амаа хамхиж явахаар шийдсэн юм. Заавал үзэж байж хашрах золигнууд юм даа...

Тэргэлийн гэр ийнхүү нүүж одсоны дөнгөж дараахан нэг залуухан гэр бүл том машинаар дүүрэн тавилгаа ачсаар орцны өмнө ирж зогслоо. Гэрийн эзэн бололтой нэг залуу өөр нэг хүнтэй хамжин хөргөгчөө дамжлан өргөсөөр орц руу явж оров. “Энэ орцны лифт ажилладаггүй гэсэн яаж дээшээ гарна аа” залуучууд хоорондоо ингэж ярилцснаа гэнэт зогтуслаа. Хэдэн хормын дараа гэрийн эзэн инээд алдаад “Ашгүй лифт ирж байх шиг байна” хэмээн баярлан хэлэв.

## **Төгсөв**

# ХОРСОЛ

Гэрт хав харанхуй. Дэнхийсэн том таван өрөө орон сууцанд Ариунаагаас өөр хэн ч байсангүй. Хотын амьдрал ч энэ шөнө хөл хөдөлгөөн багатай эл хульхан нэг л ёозгүй. Зэргэлдээ орон сууцнуудын цонхнуудын гэрэл ч гэсэн тэр аяараа унтраалттай байх аж. Мэр сэр ганц нэгхэн цонх гэрэлтэй харагдах нь энгүй их далайд хаа нэг тааралдах арал мэт сэтгэгдэл төрүүлнэ. Ариунаагийн нойр бүр хулжиж орхижээ. Өнөө гөнө ирнэ гэсэн найз залуу нь байдаггүй. Гэрийнхэн нь цөм амралтанд явахад ганцаараа гэрээ сахиад сайн дураараа үлдсэнсэн. Баяртыг л ирнэ гэж бодсондоо тэр шүү дээ. Уг нь гэрт хэн ч байхгүй ийм боломжтой үед Баярт ирсэн бол шөнийг ямар сайхан өнгөрөөх байсан бол гэдэг бодол эдүгээ 22 нас шүргэж яваа Ариунаагийн санаанаас ер салахгүй байлаа. Хэдий шөнө дунд болсон ч гэлээ Баяртыг хүрээд ирж магадгүй гэсэн бодол сэтгэлийг нь сэрвэлзүүлнэ. Ариунаа хаалга тогших чимээ хүлээхийн хажуугаар утсаа чагнасаар....

Шөнийн 2 цаг. Өдөр шөнөгүй л ямар нэгэн нэвтрүүлэг киногоор тасардаггүй кабелийн суваг нь ёртой юм шиг тасарснаар чаг чаг хийн дуугарах цагнаас өөр чимээ энэ гэрт дуулдахаа болилоо. Ганцаараа цэлийсэн том байшинд нойр хулжин хэвтэх Ариунаа утас дуугарах дуунаар цочсондоо золтой л хашхирсангүй. Хэсэг тайвширсны дараа Баяртыг байж магадгүй гэж бодоод харилцуураа авлаа.

-Байна уу?

-.../таг чиг/

-Байна уу, хариулаач ээ

-Байна Ариунаа юу. Баярт байна аа...

Ингэж хэлээд Баяртын дуу дуулдахаа болилоо. Пэржигнэж сөөнгөтсөн зэвхий зэвүүн дуу чихэн дээр нь үргэлжлүүлэн чангаар хашхирч эхлэх нь тэр.

-Байна уу, байна уу?...Ариунаа яах ч учраа ололгүй ямартаа ч утсаа таслав. Сэтгэлийг нь айдас эзэмджээ. Саяын чихэн дээр нь чарласан тэр аймшгийн дуу хайртай хүний нь хоолой мөн гэхэд үнэхээр итгэхийн аргагүй. Ариунаа тэссэнгүй. Эргээд Баярт руу залгасанд “Холбогдох боломжгүй” гэсэн хариу өгөх нь тэр. Нэг ч их удсангүй “тог, тог” хийн хаалга тогших чимээ сонслоо. Биеийг нь тэр чигээр нь айдас жихүүдэс эзэлсэн ч Баярт үүдэн дээр ирчихээд хаалгыг нь цохиж байгаа юм болов уу гэсэн бодол бүх оюун ухааныг нь эзэмдэх нь тэр ээ. Хурдхан шиг Баяртыг оруулж ганцаардаж жихүүцсэн сэтгэлээ тайтгаруулахаар хаалгаа яаран тайллаа.

...Гайхалтай бас жихүүцмээр. Үнэхээр хэн ч алга. Ариунаа гайхснаа сүүмгэр гэрэлтэй хонгилыг хоёр тийш хэсэг харснаа яаран хаалгаа хааж түгжлээ. Нүдийг нь өөрийн эрхгүй нулимс бүрхээд ирэв. Яагаад, яагаад хэн ч байхгүй байдаг билээ. Уг нь яах аргагүй л хаалгыг нь хүчтэй тогшихыг сонссон доо. Тэгээд ч шөнийн 2 цаг өнгөрч байхад айлын хаалга тогшиж дүрсгүйтэх хүүхдүүд байхгүй гэдэг нь хэнд ч тодорхой. Ариунаа бүр яах учраа олохгүй тээнэгэлзэж утасныхаа харилцуурыг шүүрээд авлаа. Хэн нэгэнтэй ярьж, хэн нэгнийг

дуудахыг хүсчээ. Бас л холбогдож чадсангүй. “Холбох шугам чөлөөгүй байна” гэсэн хариу сонсоод бүр галзуурахаа дөхөв. Гал тогооныхаа өрөөнд орж ус ууж тайвшрахыг хичээсэн ч тус болсонгүй. Жижиг өрөөнийх нь цонх тас хийтэл савагдаж, пир нар хийн хагарах чимээ гарлаа. Өрөөний жижиг цонх нь хүчтэй савагдсанаас шил нь бүр юу ч үгүй үйрээд хагарчээ. Ингэж бүр нарийн ширхэгтэй бяцалсан юм шиг болж үйрнэ гэдэг Ариунаад байж боломгүй мэт санагдаж байлаа. Тэгээд ч зуны ямар ч салхигүй шөнө нээлттэй цонх хүчтэй савагдаж хагарсан нь сэтгэлд нь нэгэнт хуралдаад байгаа айдас түгшүүрийг нь бүр ч нэмэгдүүлээд ирэв.

Ариунаа хагарсан шилний үйрмэгийг ч цэвэрлэхийг хүссэнгүй. Ум хумгүй хөнжлөө толгой дээгүүрээ хучаад хэвтээд өглөө. Гэтэл орных нь хажуугаар хэн нэгэн сүрхийтэл салхи татуулан өнгөрөх нь тэр. Хичнээн айж сандарсан ч Ариунаа хэн байсныг нь мэдэх санаатай хөнжлөө сөхөж харвал нүдэнд нь юу ч өртсөнгүй. Гэхдээ л яах аргагүй хажуугаар нь хэн нэгэн гүйгээд өнгөрсөн гэдэгт тэрээр бат итгэлтэй байлаа. Гэнэт түрүүн хаалга цохиход нь хэн бэ ч гэж асуулгүй хаалгаа тайлсан нь санаанд нь орох нь тэр. Тэгэхэд л хэн нэгэн хүн эсвэл амьтан нүдэнд нь харагдалгүй өрөөнд нь орчихсон юм болов уу гэх бодолтой нь зэрэгцэн ар нурууных нь үс босоод ирэх шиг болов. Өрөөнийх нь цонх хагарсан. Хагарах хагарахдаа бүр юу ч үгүй үйрмэг болтлоо хагарсныг нь бодохоор гайхмаар. Ядаж байхад кабель нь тасарч утас нь гадагшаа залгагддаггүй. Хорин хоёрхон настай урьд нь гэртээ ганцаараа үлдэж үзээгүй залуухан бүсгүй айсандаа мэгшин уйлж Баяртыгаа хүрээд ирээсэй хэмээн тэсгэлгүй хүлээсээр... Бас тэр утасны цаанаас хашхирсан зэвхий сөөнгө дуу. Эрэгтэй хүнийх яавч биш. Хэн нэгэн галзуу солиотой, согтуу хүүхэн гэж хэлэхэд ч багадмаар. Адын буг шүглэсэн гэмээр тэр аймшгийн хахир хоолой санаанаас нь гарч өгөхгүй тарчлаасаар.

...Дахиад л утас дуугарлаа.

-Байна уу?

.../бас л таг чиг/

-Байна уу, хэн бэ? ... ингэж асуухдаа Ариунаа золтой хашхираад уйлсангүй. Гэтэл түрүүний хахир дуу хоолой чихэнд нь сонсогдож өөрийг нь зангаад байгаа ч юм шиг ёрын дуугаар харааж эхлэв. Үнхэлцгээ хагартал айсан Ариунаа харилцуураа хаяад нэг л мэдэхэд хөлс нь асгарчихсан хөнжилдөө шургасан байлаа. Намайг зангах, эсвэл айлган сүрдүүлэх хэн байдаг билээ? Хэмээн тарж бутарсан ухаанаа цуглуулан байж шүүн тунгааж эхэллээ. Хүн болгонтой эелдэг илэн далангүй, найрсаг харьцдаг түүнд “дайсан” гээд оноогоод хэлчих хүн байхгүй мэт. Байз...яагаав нөгөө Бадмаа гэсэн бодол Ариунаагийн санаанд орж гэнэт огло үсрэн босоод ирмээр боллоо. Гэхдээ Бадмаа байлаа гэхэд тэр чинь хэдэн сарын өмнө үхчихсэн шүү дээ. Ариунаагийн бодол өнгөрсөн рүү бэдчин оджээ.

...Бадмаа бол Баяртын хуучин эхнэр. Ариунаа хэдий Баяртыг эхнэртэй, тэр нь хүүхдийг нь тээж байгаа гэдгийг нь мэдсэн хэрнээ л нөхрийг нь булаачихсан. Ганцхан Баярттай амьдрахын тулд хорвоод ганц удаа нүгэл үйлдэхээс айгаагүй билээ. Гэрт нь эхнэрийг нь эзгүйчилж, Баярттай хамт байхдаа Ариунаа бүр хэргээр Бадмаа руу мессеж илгээж дууддаг байсан гээч. Мэдээж эхнэрийг нь ороод ирэхэд Баярттай яг л цавуу шиг наалдчихсан байхыгаа бүр өөрийн зорилго байсан удаа ч бий. Ариунаа өөрт нь дурласан Баяртыг атгандаа оруулж

аваад эхнэрийг нь ийн төрөл бүрээр дарамталсаар амиа егүүтгэхэд хүргэсэн. Баярт жирэмсэн эхнэрийнхээ үхлийг Ариунаад тайлбарлахдаа авто ослоос болсон гэсэн ч амиа хорлосон гэдгийг яваандаа олж мэдсэн билээ. Ариунаа тэр мэдээг сонсоод жихүүцсэн ч Баярттай хоёулхнаа жаргах нь гэсэн өнгөцхөн бодолдоо хөтлөгдөж тэр үхлийн тухай мартаж орхисон. Тухайн үедээ Ариунаа Бадмаагийн үхэлд нэг их ач холбогдол өгөөгүй ч төрж амжаагүй тэр жаахан хүүхдийг бодохдоо өөрийгөө бага зэрэг зэмлэж билээ.

...Ариунаа ийн бодол биеэ хурааж хэвтэхдээ өрөөнийх нь энд тэндээс гарах чимээг чагнасаар... Дахин утас дуугарав. Ариунаа хичнээн жийрхэж байсан ч дахиад л харилцуураа авлаа.

-Байна уу, хэн бэ?

-Уучлаарай, эмнэлгээс ярьж байна. Баярт гэдэг залуу осолд ороод энд ухаангүй үхлүүт байна. Гар утаснаасаа хамгийн сүүлд энэ дугаар луу залгасан болохоор нь ярьж байна л даа. Танай хамаатан уу?

- ...Юу? Баярт осолдчихоо юу. Би одоохон гээд хаягийг нь асуух гэтэл утас нь тасарчихлаа. Тэгэхдээ зүгээр ч нэг тасраад өнгөрсөнгүй. Нөгөө эмх замбараагүй хашхичин занасан эмэгтэй хүний дуу үргэлжлүүлэн чихэн дээр хадах нь тэр ээ. Энэ удаа тэр эмэгтэйн дууг Бадмаагийнх гэдгийг Ариунаа огтхон ч эргэлзээгүй танив.

Тэсэхээ байсан Ариунаа утсаа шидэж орхиод хөнжлөө толгой дээгүүрээ хучин мэгшин уйллаа. Гэтэл нэг их удалгүй хажуугийн өрөөнийх нь хагарсан шилний үйрмэгэн дээр нь хэн нэгэн гишгин явах чимээ гарснаа нярай хүүхдийн уйлах дуун хадлаа. Ариунаа ухаан балартжээ. Өглөөний нарны шингэн туяа цонхоор тусахтай зэрэгцэн Ариунаа сая хагас дутуу ухаан оржээ. Гадаа шувууд жиргэж хүн машины дуу сонсогдоход бага зэрэг тайвширсан Ариунаа хажуугийн өрөөндөө орж харвал нөгөө шилний үйрмэгээс өөр зүйл байсангүй. Гар утсанд нь Баяртыг урьд шөнө ослоор өнгөрсөн тухай мессеж ирснийг олж уншсан хэрнээ тэгтлээ их айж цочирдсонгүй. Элий балай юм шиг гал тогооныхоо өрөө сажилж байтал гэнэт очигдрийн хаалга цохисон яг тэр хэмнэлээр хаалга тогшив.

Бас л хэн ч байхгүй байлаа. Хаалгаа дангинатал түгжээд эргэхдээ Ариунаа ухаан нь балартаж буйгаа дөнгөн данган мэдэрч байв. Нэвсгэр хар хувцас өмссөн цүдгэр гэдэстэй Бадмаа чанх өөдөөс нь цоо ширтэн зогсож байх шиг... Урьд шөнийн айдастаа Ариунаа дахин автжээ. Гомдол цөхрөлдөө идэгдсээр нас барсан бүсгүйн сүнс Ариунааг амраах болоогүй бололтой. Утас дуугарлаа...

**Төгсөв**



# АЛИАЛАГЧ

...2006 оны 6-р сар. Долоо хоног тутмын чөлөөт хэвлэл “Тэргүүн” сонины дугаарт нэгэн учир битүүлэг цуврал үхлийн талаар материал нийтлэгджээ. Зургаан настай гурван хүүгийн учир битүүлэг үхэл. Хүүгээсээ салж хагацсан залуухан эцэг эхийн нулимс дуслуулсан яриа. Мөн урьд өмнө хэзээ ч тохиолдож байгаагүй олон олон хүмүүсийн ор сураггүй алга болж байгаа тухай мэдээ.

## НЭГЭН ТОХИОЛДОЛ

*-Мөнхзориг*

*-Эрэгтэй*

*-6 настай*

*-2006 оны 6 сарын 1-ний өдөр алагдсан*

*-Хүүгийн үхэлд “Алиалагч” сэжиглэгдэж байна*

Олон улсын хүүхдийн баяр зургаан сарын нэгний эл өдөр хайртай ганц хүүгээ эрхлүүлэх гэсэн эцэг эх хоёр тоглоомын парк дээр очсон гэх. Энэ жил дөнгөж л гучин нас хүрч байгаа цагдаагийн ахлах дэслэгч цолтой Ганбаяр гэх залуухан аав хүүгээ мөрөн дээрээ суулгаад олон хүмүүсийн араас дугаарлан алсыг харагчийн тасалбар авахаар зогсож байжээ. Тэр үед энэ улсын бүх хүмүүс энд цугларчихаа юу гэлтэй олон хүмүүс бужигналдаж байсан аж. Хүүгийн ээж Тамир нөхөр, хүүхдээ алсыг харагчид суулгчихаад өөрөө зайрмаг худалдаж аваад тэднийг бууж ирэхийг хүлээж байсан. Харин аав хүү хоёр алсыг харагчинд суугаад нэлээд өндөрт гарч ирсний дараа хөөрч баярлаж байсан бяцхан хүү нь “Алиалагч намайг дуудаад байна” гэж хэлсэн. Харин аав нь нэг их тоогоогүй. Зүгээр л энд тэндгүй холхилдох алиалагчдын нэг нь алсыг харагч руу далласан нь тэр биз гээд орхисон. Тэгтэл харин аз жаргалтай инээж баясч явсан хүү нь гэнэт дуугаа хурааж айж цочиж эхэлсэн. Бууж ирээд ээжийнхээ худалдаж авсан зайрмагийг ч идэхгүй барьсаар бүр хайлуулчихсан.

Уг нь хүү зайрмаганд хамгийн дуртай байсан. Гэтэл яагаад ч юм хүү зайрмагийг идсэнгүй. Хэн нэгнийг хүрээд ирэхийг хүлээсэн юм шиг ийш тийшээ харан дальдчиж аавынхаа хуруунаас тас атгачихсан байсан гэх. Удахгүй Ганбаяр бие засахаар болж эхнэр хүүхдээ түр орхиод явсан. Тэгээд л удахгүй эргэж ирэхэд хүү нь байгаагүй. Эхнэр Тамирын нь санаа нь зовчихсон яахаа мэдэхгүй сандарсан байдалтай байжээ. Алиалагчийн хувцастай нүүрээ будсан өндөр туранхай эр ээж хүү хоёрын дэргэд ирээд хүүг үг дуугүй мөрөн дээрээ суулган авч оджээ. Тамирын хууд эхэндээ зүгээр л хүүг нь өхөөрдөөд эрхлүүлж байгаа нь тэр юм байх гэж санаж байтал өнөөх алиалагч олон хүмүүсийн дунд яг л уусах мэт алга болсон. Араас нь явсан боловч олон хүмүүсийн дундуур зүсч гарах гэж мунгинасаар яаж ч чадаагүй. Тамирын хүүгээ харсан хамгийн сүүлчийн дүр зураг гэвэл “Өндөр биетэй алиалагчид тэврүүлсэн хүү нь уйлчихсан ээж рүүгээ гараа сарвалзуулан тийчилж байсан” гэнэ. Эхнэр нөхөр хоёр хүүгээ цөхөртлөө хайгаад олоогүй. Аргаа барж цагдаад тэмдэглүүлсэн, гэвч хүү олдоогүй. Харин хоёр хоногийн дараа олдсон. Гэхдээ үхчихсэн байж. Хүн харахын эцэсгүй эрэмдэглэгдсэн

бяцхан хүүгийн цогцос олдсон. Хоёр нүдийг нь ухаад авчихсан, бас зарим дотор эрхтэн нь байхгүй, ямар ч цусгүй хатаж хорчийсон амьгүй цогцос. Ямар нэгэн араатанд идүүлсэн нь энэ үү гэтэл огтхон ч тийм биш. Учир нь бүх эд эрхтнийг нь цэвэрхэн гэгч нь салгаад авчихжээ. Цогцсыг ээжид нь үзүүлээгүй, харин аав нь харсан. Аав Ганбаяр нь хүүгийнхээ цогцсыг хараад тэсгэлгүй бүр ухаан алдан унажээ.

*Бас нэгэн тохиолдол*

*-Бямбаа /нэрийг нь бүрэн тодорхойлоогүй/*

*-Эрэгтэй*

*-6 настай*

*-2006 оны 6 сарын 1-ний өдөр алагдсан*

*-Хүүгийн үхэлд “Алиалагч” сэжиглэгдэж байна.*

...Дээрхтэй нэлээд төстэй бас нэгэн эмгэнэлт явдал зургаан сарын нэгний яг тэр өдөр гарсан байна. Зургаан настай хүүхдийн чихгүй ямар ч цусгүй болсон амьгүй цогцос олдсон. Гэхдээ энэ явдал болсноос хойш бүр арав хоногийн дараа цагдаагийнхан уг үхлийн талаар олж мэджээ.

Хөөрхий хүүг үгүйлж хайх хэн ч байсангүй. Учир нь тэрээр эцэг эхгүй өнчин, траншейнд хоног төөрүүлдэг нэгэн байсан бөгөөд хааяа хамт хонодог найз хүүхдүүд нь түүнийг ирэхгүй удаад байхаар нь хайж яваад амьгүй цогцсыг нь санамсаргүй олжээ. Зургаан сарын нэгний тэр үхэл далласан хар өдөр талийгаач хүү найзуудтайгаа хүүхдийн паркаар хүмүүсээс гуйлга гуйгаад явж байсан гэнэ. Хүүхдийн баярын өдөр болохоор бяцхан гуйлгачингуудад ч хүмүүс өгөөмөр хандаж хоол чихэр, жимс харамгүй өгч байж. Гэтэл хаанаас ч юм нэгэн алиалагчийн хувцастай өндөр эр гарч ирээд хүүхдүүдийг хоолоор дайлж гарчээ. Удалгүй Бямбаа тэр алиалагчийг дагаж яваад ирээгүй.

Талийгаач хүүгийн цогцсонд шүүх эмнэлгийнхэн шинжилгээ хийгээд түүнийг “06 сарын 01-ний өдөр нас барсан” хэмээн тэмдэглэжээ. Үүнээс өөр энэ талаар тийм ч тодорхой мэдээлэл байсангүй. Ердөө л энэ. Цагдаагийнхан ч энэ хэрэг явдлын талаар хангалттай мэдээлэл олж чадаагүй байж. Ямартай ч энэ хэргийн талаар цагдаагийнхан алагдсан хүүгийн найз гэх 120 мянгат хавийн траншейнээр хоног төөрүүлдэг арван настай Тулгаас там тум сонссон нь энэ аж.

*Гурав дахь тохиолдол*

*-Баярт*

*-Эрэгтэй*

*-6 настай*

-2006 оны 6 сарын 1-ний өдөр алагдсан

-Хүүгийн үхэлд “Алиалагч” сэжиглэгдэж байна.

Зургаан сарын нэгний өдөр баяраа тэмдэглэж явсан ээж хүү хоёр зургаа авахуулахаар Сүхбаатарын талбайд очжээ. Бас л хөл хөдөлгөөн ихтэй байсан. Зургаа авахуулах гэсэн хүмүүс ч цөөнгүй байж. Гэтэл газрын хаанаас ч юм нэгэн алиалагч гарч ирээд “Хүүг хэдэн настай вэ?” гэж асуусан. “Зургаан настай” гэж хүүгийн эх болох Долгормаа хариулжээ.

Хүү яагаад ч юм алиалагчаас нэг л дөлөөд айгаад байж. Өмнө нь цирк үзэж байхдаа алиалагч хараад баярлаж хөөрч байсан хүүгийнхээ авирыг тэр үед ээж нь бага зэрэг гайхснаа хожим дурсан ярьсан. Хүүгийн ээж Долгормаа бүсгүй 28 настай бөгөөд хүүхдийнхээ эцгээс нэлээд хэдэн жилийн өмнө салаад хүүтэйгээ хоёулхнаа амьдарч байсан гэх. Долгормаа хүүдээ алиалагчтай хамт зургаа авахуулах талаар санал тавихад Баярт огтхон ч зөвшөөрөлгүй толгой сэгсэрсэн. Гэтэл алиалагч өөрөө хүүтэй зургаа авахуулья хэмээн гараа сунгахад хүү яагаад ч юм татгалзаж чадаагүй. Яг л ховсдуулчихсан юм шиг. Ингээд хүү алиалагчтай хамт зургаа авахуулж аппарат чаг хийн дуугармагц өндөр биетэй туранхай алиалагч хүүг зүүн гарынхаа суганд хавчуулаад маш хурдтай гүйгээд алга болсон. Хүүгийн ээж Долгормаа араас нь хөөж хүмүүсээс тусламж гуйж “Хүүг минь хулгайлж байна туслаарай” хэмээн хоолойныхоо чадлаар хашхирч байсан ч хэн ч түүнд тус болж амжаагүй. Тиймээ, тус болж амжаагүй. Учир нь алиалагч яг л харвасан сум мэт хурдан гүйж Төв шуудангийн арын зам дагуу арилж өгсөн. Алиалагч сэтгэл хирдхийлгэм зэврүүн сөөнгө хоолойгоор тасралтгүй инээгээд л алга болсон гэх. Уг явдлын дараа Долгормаа маш шуурхай цагдаад мэдээлж хоёр цагийн дараа олон цагдаа нарыг хамарсан эрэл хайгуул мөрдөн байцаах ажиллагаа явагдсан боловч юу ч олж чадаагүй. Алиалагч ор сураггүй алга болжээ. Харин гурав хоногийн дараа хүүгийн цогцос олдсон. Гэхдээ мөн л дээрхүүдийн адил эрэмдэглэгдчихсэн, хүн харахын эцэсгүй болж хувирсан байж. Ухаан санаа нь уймарч шоконд орсон эх өнөөг хэр нь цагдаа нарт олигтойхон байцаалт өгч чадахгүй байгаагаар барахгүй бие нь тун муу байгаа. Ухаан нь орон гаран болж аймшигтай ад зэтгэрийн шулмын тухай ярих болсон. Товчхондоо Долгормаа бүсгүй хагас галзуурлын байдалтай эмчийн хяналтанд байгаа гэх. Хүүгийн цогцсыг эхэд нь харуулаагүй. Бас тэрхүү үхлийн талаар цагда нар тодорхой мэдээлэл хийхгүй байгаа. Чухам ямар эрхтэн нь эрэмдэглэгдсэн, алга болсон байгаа тухай юу ч зарлаагүй. Гэхдээ хүүхдийн цогцсыг мөн гэдгийг танихад багагүй хугацаа өнгөрсөн болохоор цогцос багагүй “но”-той байсан нь дамжиггүй.

**НЭГ.**

...7 сарын 1-ний өдөр Баттөмөр энэ бүх хэргийн талаарх сонин дээр нийтлэгдсэн материалыг маш хичээнгүйлэн цуглуулж, олон янзын дүгнэлт өгөн, толгойгоо гашилган сууж байлаа. Тэрээр хувиараа мөрдөгч хийдэг, эрэн сурвалжлах сэтгүүлч мэргэжилтэй хүн. Хүүхдийн баярын өдөр гарсан уг гэмт хэрэг хоорондоо нэлээд төстэй, бүгдэд нь “алиалагч” ямар нэгэн байдлаар холбоотой байгаа нь андашгүй байна. Гэхдээ ямар зорилгоор яах гэж энэ бузар хэргүүдийг хийж үйлдэв ээ? Тэр өндөр биетэй будагтай нүүрний цаана чухам хэн байна вэ?

Хүүхдийн баярын өдөр тоглоомын паркаас хулгайлагдаж улмаар алагдсан талийгаач хүү

Мөнхзоригийн аав Ганбаяр Баттөмөрийг “Тэр новшийн алиалагчийн талаар олж мэдэхэд, барихад туслаач” хэмээн хөлсөлжээ. Баттөмөр бол Ганбаярын багын найз, тэгээд ч багадаа хэн юу нууцалж байгааг, юу хийх гэж байгааг, юу сэтгэж байгааг бүгдийг нь олж мэддэг байсан. Тэр ч бүү хэл багшийнхаа сэтгэл санаа гутранги байгаа, нөхрөөсөө салсан гэдгийг нь ч мэдэж байсан. Ийнхүү арван жилийн сурагч байхын л Ганбаяр Баттөмөрийн энэ гайхалтай авьяасыг биширдэг байж. Чухам ямар арга, мэдрэмжээр гэдэг нь бүү мэд. Ямар ч л байсан Баттөмөр хүссэн зүйлээ олж мэдэх гайхалтай чадвартай. Эсвэл магадгүй түүний зургаа дахь мэдрэхүй онцгой хөгжсөн байж болох юм.

Хүүгээ алдсанаас хойш Ганбаяр хэдэн өдөр сэтгэцийн цочролд орж орон гаран ухаантай хүн эмчийн хяналтанд байсан. Тэгээд л энэ стрессээсээ дөнгөж гараад, бодит байдлыг мэдрэхтэйгээ болоод ирмэгцээ багын найз Баттөмөртэйгөө холбогдож тусламж хүссэн. Ганбаярбг хувьд хүүг нь авч явсан, магадгүй хөнөөсөн тэр алиалагчийн хувцастай этгээдийг барьж, өшөөгөө авах гэсэн хүсэл нь хорихын аргагүй оволзож байлаа. Энэ хүсэл нь түүний цагдаагийн мэргэжилтэй хобоотой байсан биз. Ингээд л Баттөмөр цагдаагийнхны хажуугаар өөрөө хувиараа алиалагчийн араас мөрдөх ажилд ханцуй шамлан оржээ. Найзынх нь хүүг авч одсон “алиалагч” гэсэн нэр зүүгээд байгаа тэр этгээд хэн бэ?

06 сарын 01ний өдөр алагдсан гурван хүүгийн цогцсонд ямар ч цус үлдээгүй байсан. Уг нь гадны нөлөөтэй ч бай, нөлөөгүй ч бай цогцсонд их бага тодорхой хэмжээний цус үлдсэн байх учиртай. Гэтэл яагаад цогцос ямар ч цусгүй, бас зарим нүүрний болон дотор эд эрхтэн, зарим нэг гар хөл нь дутчихсан олддог билээ? Энэ хэрэг явдлаас болоод хот тэр аяараа алиалагчийн хувцастай этгээдээс айх болсон. Хүүхдүүдээ гадаа хяналтгүй тоглуулахаас татгалзаж, хүүхэдтэй хүн бүр л дотроо их бага хэмжээгээр айдас тээх болсон. Гэтэл үүний хажуугаар ахлах ангийн сахилгагүй сурагчид алиалагчийн хувцас өмсөн, нүүрээ будаж, хүн айлгаж, дүрсгүйтэх нь газар авсан. Мэдээж энэ хэргийн дараа хүүхдийн соёл амралтын хүрээлэнд алиалагчийн үүрэг гүйцэтгэсэн бүх хүмүүсийг цагдаагийнхан шалгасан боловч сэжигтэй зүйл юу ч олноогүй. Алагдсан гурван хүүгийн цогцсын нэг / Талийгаач Мөнхзориг / 3, 4-р хорооллын арын байрны хогийн цэгээс олдсон. Нөгөө нь / Талийгаач Бямбаа / 120 мянгатын авто машины гаражын ар талаас, харин гурав дахь цогцос / Талийгаач Баярт / Их дэлгүүрийн ар талын 15-р байрны орцноос олдсон. Талийгаач хүүхдүүдийн цогцсыг алуурчин төөрөлдүүлэх гэсэндээ ч юм уу энд тэндгүй тарааж хаяжээ. Эсвэл өөр өөр этгээдүүд хүүхдүүдийг тус тусдаа “үгүй хийгээд” тааралдсан газраа цогцсыг орхисон хэрэг үү. Ямар зорилгоор хүүхдүүдийг ингэж зэрэмдэглэж, алж устгаж, эд эрхтнийг нь тонох болов? Эндээс л бүх сэжүүр эхлэх боломжтой юм шиг. Новшийн алиалагч хүүхдүүдийн эд эрхтнүүдийг цуглуулж, цусыг нь юулж байна. Гэхдээ яах гэж? Ямар ч цусгүй болсон хорчийсон цагаан цогцсуудыг гурвууланг нь арав хоногийн өмнө нутаглуулсан. Баттөмөр шөнөжин элдвийг бодон, дутуу нойртой хоноод өглөөний 07 цаг 30 минутанд гэрээсээ гарлаа. Тэрээр энэ жил 29 нас хүрч байгаа, 179см өндөртэй, чихээ даван ургуулсан бага зэрэг долгионтой хар халимаг нь өтгөн хөмсөг үл ялиг давхраатай нүд, нимгэвтэр уруулыг нь хүрээлж ургасан жирэвгэр хар сахалд нь гойд зохицжээ гэлтэй. Тэнгэр сайхан цэлмэг байгаа ч гэлээ удалгүй бороо орно гэдэгт Баттөмөр цаг агаарын мэдээ сонсоогүй хэрнээ итгэлтэй байв. Гэсэн ч тэрээр хүрэн өнгийн богино ханцуйтай нимгэн срочкон цамц, даавуун саарал өмд, резинэн ултай хар ботинкоо солих хэрэгтэй гэж бодсонгүй. Тэрээр шууд л Ганбаяртай уулзахаар гэрийг нь зорин алхав. Яахав бороо орвол орно л биз, их л удаж жаахан жиндэнэ.

Баттөмөр Ганбаяр хоёр хоёул нэгдүгээр хорооллын байранд амьдардаг бөгөөд тэдний гэрүүн хоорондоо ердөө л хоёр буудлын зайтай. Баттөмөр алиалагчийн тухай элдвийг бодон тайван алхалж байлаа. Баттөмөр өмнө нь өөрөөс нь тусламж хүссэн хүмүүсийн нэгнийх нь ч урмыг хугалаагүй. Ганцаараа хэрнээ л цагдаагийнхнаас ч илүү үр дүнтэй ажиллаж чаддаг. Тэр бүх хэргүүдийн учрыг олж дөнгөхдөө Баттөмөр бүр цаанаасаа мэдэрдэг байсан бол энэ удаагийнх нэг л жигтэй, адын, муу ёрын совин татуулаад байлаа. “Би үүнийг хийж чадах уу, үхлийн талаарх нууцыг тайлж алуурчин этгээдийг барьж дөнгөх үү?”. – Ээ мэдэхгүй, юу л бол? Баттөмөрийн дотоод сэтгэл нь өөрөөсөө асуусан энэ асуултыг асуултаар ингэж хариуллаа. Зам нэлээд хоржээ. Одоо ердөө 100 гаран метр яваад Ганбаярын амьдардаг Саппорогийн ар талын 1-р байранд очно.

... Хаалга зөөлөн цохих чимээнээр Ганбаярын эхнэр Тамир нулимсандаа бөлцийж хавдсан нүдтэй хүн хаалга тайллаа. Тэрээр яг л хариугүй ухаан алдан унах нь уу гэлтэй, бие нь их муу байгаа нь андашгүй байлаа.

- Өө, чи ирэв үү. Ор л доо. / Тамирын дууны өнгө яг л хэвтэрт ороод үхлээ хүлээн хэвтэж байгаа өвчтөн шиг сул дорой сонсогдо байлаа./

- Баярлалаа. Ганбаяр бий биз дээ?

- Байлгүй яахав. Яг чамайг ирэх байх гээд хүлээгээд сууж байна.

Баттөмөрийг талийгаач хүүгийн амьдардаг байсан гэрийн босгыг даван ороход үгээр шууд илэрхийлчихэж боломгүй хүйт дааж, сэтгэл хямраасан нэг тийм муу энерги бүх бие сэтгэлийг нь эзэмдэж байгааг тэрээр мэдэрлээ. Ганбаяр зочдынхоо өрөөнд буйдан дээр суугаад жижиг ширээн дээр хөзрөөр мэрэглэж байх аж. Чухам юу мэргэлэж байгааг нь асуугаагүй ч гэлээ Баттөмөр Ганбаярыг “Дөрвөн хүн сэтгэлдээ товлоод тэдний хэн нь алиалагчийн будагтай нүүрний цаана нуугдаж байгааг таах” гэсэн оролдлого байна гэдгийг шууд мэдэв. Гэхдээ Ганбаярын дотроо таамаглаж байгаа дөрвөн сэжигтний хэн нь ч алиалагч биш гэдгийг Баттөмөр мэдэрч байлаа. Тэр алуурчин бол зүгээр ч нэг хүн биш. Тэр нүүрээ будсан алиа салбадай юу ч байж мэднэ. Ямартай ч энэ хэрэг явдал бол зүгээр нэг гарч л байдаг гэмт хэргүүдийн нэг биш. Энэ хэргийн ард байгаа этгээд санаанд багтамгүй их хүч чадалтай муу ёрын амилсан шулам байгаа мэт.

Ганбаяр Баттөмөр лүү харц шилжүүлмэгцээ хөзрөө түр орхиод босч ирэн гар барьж, түүнийг буйданд суухыг урилаа.

- За тэгээд, өчигдөр сайхан амарч чадав уу, Баттөмөр өө?

- Үгүй яахав дээ. Олон янзын үйл явдлыг хооронд нь харьцуулж бодоод л. Харин чиний мэргэ чинь хэргийн эзнийг хэн бэ гэдгийг чамд хэлж байна уу?

Ганбаяр үл мэдэг давхийх шиг болсноо мөрөө хавчаад үүдэнд зогсож байгаа эхнэр лүүгээ харц шилжүүллээ. Эхнэр нь түүний асуусан харцанд толгойгоо сэгсэрч хариу өгөв.

- Тамир надад чиний мэргийн талаар хэлээгүй ээ. Гэхдээ заавал үүний учрыг олох гэж цаг

алдаад байх хэрэггүй. Бидэнд өөр чухал олон асуудал байна.

- ...Тийм байх аа.

Ганбаярын онигор нүд улам онийж, бүр ширгээд өгөх нь гэлтэй харагдана. Энэ нь мэдээж түүнийг хүүгийнхээ үхлээс болж шаналаад, байнга нойр дутуу хонож байгааг нь илэрхийлж байлаа. Тэрээр Баттөмөрөөс нуруугаар арай өндөр, тачирхан жижиг үстэй. Алхаж гишгэж босож суух болгон нь жирийн хүнээс илүү бяр тэнхээтэй, хурдан шаламгай хөдөлгөөнтэйг нь илтгэх аж.

- Юуны өмнө бид тэр алдаршаад байгаа алиалагчийн хувцас, будагнаас өөр бусдаас ялгагдах таних тэмдгийг нь олж мэдмээр байна. Миний юу хийх гэж байгааг чамайг мэдэхийг хүсч байгаа болохоор чинь би энэ тухай чамд ярьж байна. 06 сарын 01-ний үдээс хойш Сүхбаатарын талбай дээрээс хулгайлагдаж, улмаар алагдсан хүүгийн алиалагчтай хамт авхуулсан фото зургийг олж үзэх хэрэгтэй.

- Цагдаагийнхан чамд тэр зургийг өгөхгүй биз дээ.

- Би мэднэ ээ. Зүгээр л талбай орж тэр гэрэл зургийг дарсан зурагчинтай уулзана. Магадгүй цагдаа нарт ч тэр зураг олдоогүй байх.

- Яагаад?

- Мэдэхгүй, зүгээр л тэгж санагдаад байна.

- Би чамтай хамт явж болно биз дээ?

- Чамайг ингэж асуухыг чинь мэдсэн болохоор л би энд ирсэн. Явцгаая.

Гэтэл энэ үед түрүүнээс хойш үүдэнд гараа элгэндээ зөрүүлэн хөдөлгөөнгүй зогсож байсан

Тамираа нэгийг санах бололтой сандархийж:

- Цай уух уу хө гэж түрүүчийнхээсээ ч сул дорой дуугаар асуув.

- Хэрэггүй ээ, баярлалаа. Бид алхам тутамдаа цаг хожих хэрэгтэй.

Ганбаяр элентра маркийн машинаа гаражнаасаа гаргаж, мөрдөгчид Сүхбаатарын талбайн зүг хөдөллөө. Саяхан хүүгээсээ хагацсан гэхэд ганбаяр маш хурдан сэхээ авч хэвийн байдалдаа орж эхлээд байгаа. Харин үүнийг нь Баттөмөр зүгээр л зөн совингоороо мэдэж байсан болохоор мөрдөх ажлынхаа хамтрагчаар талийгаач хүүгийн аав Ганбаярыг эргэлзэлгүйгээр сонгоод байгаа аж. Мэдээж энэ нь Ганбаярын өөрийнх нь хүсэлтэй нь ч холбоотой хэрэг. Харин Тамирын хувьд өшөн болгон хар дарж зүүдлээд, алиалагчийн аймшигтай чөтгөр шиг нүдний тухай ярих нь ихэсчээ. Ганбаяр бол 10-р ангиа төгсөөд шууд цагдаагийн академид суралцаж, улмаар төрийн ажил хийж, тэр хугацаандаа хэд хэдэн хэрэг илрүүлээд амжсан чамгүй туршлагатай нэгэн.

... Яах ийхийн зуургүй тэнгэр бүрхэж, бороо шивэрч эхэллээ. Машины урд шилэн дээр бөнжигнөсөн усан дуслууд олноор бий болж машины шил арчигч ажиллаж эхлэв. Баттөмөр өглөөний “Бороо орно” гэсэн зөн совингоо эргэн санасан ч үгүй учир нь түүнд энэ бүхэн хэвийн л үзэгдэл.

Баттөмөр бүр жаахан аравхан настай байсан тэр үе. Тэгэхэд түүнд хичээлээ явж байхад нь нэг явдал тохиолдсон, магадгүй тэгээд л тэрнээс хойш тархинд нь нэг юм орчихсон. Юу гэдэг нь бүү мэд, ямартай ч яг тэр үеэс хойш зарим үед түүнийг нүдээ анихад янз бүрийн зүйлс харагддаг болсон. Түүгээр ч зогсохгүй зүүд болгон нь маш эмх цэгцтэй, ямар нэгэн зүйлийг зөгнөөд байх нь олширсон. Өөрийнхөө өнгөрсөн, ирээдүйн зарим зүйлүүдийг олж хараад байгаагаар Баттөмөр анх арван хоёр настайдаа эргэлзэлгүйгээр мэдсэн гэхэд болно. Учир нь бүр долоо хоногийн туршид түүнийг нүдээ аних болгонд ээж нь улаан даавуугаар бүрсэн хайрцган дотор нүдээ аниад, ямар ч хөдөлгөөнгүй, цонхигор царайлан хэвтэж байгаа мэт дүр төрх үзэгдэх болсон. Энэ тухайгаа хүнд хэлэхээс маш ихээр айж байсан. Гэхдээ удаан тэсээгүй. Түүний санаанд ингээд л ээж нь удахгүй тэр улаан даавуугаар бүрсэн модон хайрцган дотор орж хэвтээд тэндээсээ босч ирэхгүй болчих вий гэсэн айдас байж суухын аргагүй оволзож, аавдаа энэ тухайгаа хэлсэн. Харин аав нь түүн рүү хэдэн хором гайхан харж зогссоноо “Муу ёрын хүүхэд” гэж хараагаад айхтар шийтгэсэн... Түүнийг зодсон, Дараа нь Баттөмөр ээж нь хэрвээ өөрийнх нь бодож байгаагаар нүдээ аниад хайрцган дотор орж хөдөлгөөнгүй хэвтээд өөрөөр хэлбэл үхээд өгвөл аав нь өөрийг нь хаяад явна гэдгийг мэдэж байсан. Тиймээ, тэгээд л долоо хоногийн дараа ээжийнх нь бие гэнэт эрс доройтож, шөнөдөө амьсгал хураасан. Баттөмөрийн зөгнөсөн бүх юм тэгэхэд л яг таг биелэлээ олж “Үхэл далласан муу ёрын хүүхэд” хэмээн аав нь Баттөмөрийг харааж түүнийг хаяад ор сураггүй алга болсон доо. Аав ээжээс ийнхүү арван хоёрхон насандаа зэрэг хагацсан Баттөмөр талийгаач ээжийнхээ ээж дээр өссөн. Тэр үед Баттөмөрт үнэхээр ээжтэйгээ ижилхэн гэхдээ арай жижигхэн хэмжээтэй улаан даавуугаар бүрсэн модон хайрцган дотор ороод хэвтэхсэн гэсэн бодол төрж байсан ч чухам яаж тэр хүслээ гүйцэлдүүлэхээ олж мэдээгүй. Дараа нь өдөр хоногууд ээлжилсээр нэг жил хэрээтэй хугацаа өнгөрсний дараа аав, ээжээсээ хагацсан бяцхан хүүгийн уй бага багаар мартагдаж эхэлсэн. Яг чухам энэ үед л түүний нүдээ аниад олж хардаг тэр зүйлүүд нь ямар нэгэн байдлаар биелдэг гэдгийг Баттөмөр ойлгосон. Гэхдээ энэ тухайгаа хэнд ч хэлээгүй. Арван настай байх үед нь тохиолдсон тэр нэгэн учир битүүлэг сонин явдлаа хэнд ч хэлээгүй. Яагаад гэвэл энэ бүхэнд нь хэн ч итгэхгүй болохоор л тэр. Өөрийг нь гажигтай, галзуу солиотой гээд эмээгээс нь тусгаарлаад, ганцааранг нь нэг газар аваачаад хорьчихно гэдгийг мэдэрдэг, тэгээд түүнээсээ айдаг байсан. Баттөмөр бүх л зөгнөсөн зүйлүүдээсээ айдаг байсан. Энэ бүх зөгнөсөн зүйлүүдийн биелэлүүд арван настай байх үед нь тохиолдсон тэр нэгэн явдлаас л үүдэлтэй гэж Баттөмөр өнөөг хэр нь бодсоор явдаг билээ.

... Бороо орсон болохоор ч тэр үү талбайн зурагчид нэг их харагдсангүй. Ганц нэгхэн шүхэр барьсан хүмүүс цүнхтэй аппаратаа норгочих вий гэсэн шиг түүнийгээ сугандаа хавчин бээвийн зогсоно. Ганбаярын хувьд эндээс нөгөөх алиалагчийн зургийг дарсан зурагчинг олж чадна гэлэгт эргэлзэж байсан ч Баттөмөрийн хувьд хангалттай итгэлтэй байлаа. Үнэндээ тэдний хэн хэн нь тэр алиалагчийн зургийг дарсан зурагчинг нэг ч удаа хараагүй, нэрийг нь ч мэдэхгүй байсан билээ.

Алуурчинг мөрдөж байгаа 10 жилийн нэг ангийн хоёр залуу хоорондоо нэг ч үг солилгүй явсаар төв шуудангийн ард машинаа тавиад талбай руу явган алхлаа. “Тэр муу новшийн алиалагч яг энэ замаар хөөрхий Долгормаа бүсгүйн хүүг сугандаа хавчуулаад асар хурдтай гүйж явсан байх даа” гэсэн бодол Баттөмөрийн толгойд төрж, алиалагчийг дотроо дүрслэхийг хичээсэн ч энэ удаад юа ч харагдсангүй. Уг нь тэрээр өмнө нь дандаа л маш сайн анхаарлаа төвлөрүүлж чадвал хайж байсан хүнийхээ царайг дүрсэлчихдэг байсан. Гэтэл энэ удаад ердөө болохгүй байлаа. Харин Ганбаяр өөрийнх нь найз, туршлагатай сайн мөрдөгч бас үгээр тайлбарлаад хэлчихэж боломгүй зөн билигтэй Баттөмөр хажууд нь мөр зэргэцэн алхаж байгаа болохоор өөртөө хачин итгэлтэй байв. Хүүгээ алдсан эцэг өөрийн хамгийн их хүндэлж биширдэг байгын найз, хувиараа мөрдөгч Баттөмөрт зуун хувь найдаж байлаа. Учир нь, өмнө нь Баттөмөр түүнд олон гайхамшгуудыг үзүүлсэн. Түүний таамаглаж, мөрдөж байсан бүхэн нь яг биелэлээ олж байхыг тэр нүдээрээ харсан.

Баттөмөр алиалагчийн төрхийг тархиндаа ургуулж чадаагүйдээ багагүй бухимдаж амандаа “хүн биш юм уу хаашаа юм” хэмээн өөрөө ч мэдэлгүй бас хэн ч сонсохооргүй аяархан дуу алдлаа. Сүхбаатар жиажны хөшөөг тойрон зогссон цөөхөн зурагчид хоёр залууг сонжсон харцаар харах авч тэдний хэн нь ч “Зургаа авхуулах уу?” хэмээн зориглон ирж асуусангүй. Энэ нь мэдээж насаар чацуу, дүнсгэр царайлан алхлах ширүүн харцтай хоёр залуу зургаа авхуулах хүмүүс яавч биш гэж бодсонтой нь холбоотой биз ээ. Мөрдөгчид хотын төв цэгийг тэмдэглэсэн дөрвөлжин дээр ирээд зогтусав. Ганбаяр Баттөмөрийг асуусан харцаар харна. Харин Баттөмөр хуруугаа инчдэн дугаргаж, жанжны хөшөө рүү ширтэн бороонд норж байгаагаа ч ажралгүй ямар нэгэн үг хэлэхгүй зогсоно. Нэг минут хэртэй болсны эцэст Баттөмөр шуудхан чигээрээ алхаж, түрүүнээс хойш буруу харан бээвийн зогсож байгаа борооны цув, цагаан өнгийн саравчтай малгай өмссөн 40 орчим насны хижээлдүү байрын намхан эр лүү дөхлөө. Ганбаяр ч түүний араас тушаал авсан шинэ цэрэг шиг годхийн дагав. Баттөмөр борооны цувтай, буруу харан зогсож буй үл таних эрийн баруун гаранд аяархан хүрээд, “Сайн байна уу, та?” гэж асуулаа. Өнөөх эр ч цочих мэт эргэн харснаа харц нь тогтохгүй дальдчих аж.

- Та сандрах хэрэггүй ээ. Бид таны дарсан алиалагчийн зургийг авах гэсэн юм. Цагдаа нар таныг зөндөө шалгааж зовоосныг чинь мэдэж байна. Бас бид хоёрыг ч олон юм асууж шалгаалгүй хурдхан шиг далдраад өгөөсэй гэж хүсч байааг чинь ойлгож байна. Бид бол хувиараа мөрдөгчид. Та бидэнд туслах ёстой, яагаад гэвэл надтай хамт яваа энэ залуу хөөрхий хүүгийн аав нь байгаа юм.

Ганбаяр энэ үгийг сонсоод “Алиалагчтай зургаа авхуулсан тэр хүү чинь миний хүү биш шүү дээ” гэж бодсон боловч юу ч хэлсэнгүй. Тэрээр зүгээр л Баттөмөрт бүрэн найдаж байлаа. Түүний Баттөмөрийг дагаж яваа нь хүүгийнхээ алуурчныг бүхнээс урьтаж олох гэснээс гадна Баттөмөрийн гайхалтай арга барилаас суралцах гэсэн далд хүсэл байсан биз. Бүр үүгээр ч тогтохгүй түүний цагдаагийн мөрдөгч болсон нь зөвхөн Баттөмөртэй л холбоотой.

Зурагчин эр ямар нэгэн үг хэлэлгүй дүлэгнэн зогсох аж.

Арваад секунд хэн ч юу ч ярьсангүй. Эцэст нь Баттөмөр дахин ам нээлээ.

- Ах аа, бид танд ямар ч муу юм хийх гээгүй байна аа. Танаас тэр алиалагчийн ямархуу



төрхтэй, ямар онцлог шинжтэй байсныг ч асуух гээгүй. Зүгээр л та бидэнд тэр зургийг өгөх хэрэгтэй байна.

Зурагчин эр ямар нэгэн үг хэлэх гэсэн бололтой түгдэрч байснаа арайхийн ам нээлээ.

- Гэхдээ та хоёр зурган дээрээс тэр аймшигтай алиалагчийг олж харахгүй л болов уу. Би тэгж бодож байна. Үл таних зурагчин эр их сөөнгө хоолойтой айсан учраас Баттөмөр, Ганбаяр хоёр түүнийг нь арайхийн олж сонсчээ. Зурагчин эрийн царай үхдэл мэт цонхийн цайж, ямар нэгэн зүйлээс айж хулчийсан мэт ямар ч сүр сүлдгүй харагдана.

- Яагаад тэр билээ?

- Тэр алиалагч зурган дээр байхгүй ээ.

Баттөмөр ямар нэгэн юм хэлсэнгүй. Зүгээр л зурагчин эр лүү ширтсээр зогсох аж. Харин

Ганбаяр тэссэнгүй бололтой ам нээлээ.

- Энэ чинь юу гэсэн үг вэ. Уг нь та тэр новшийн алиалагчийн дарсан биз дээ?

- Тийм ээ, уг нь тийм л гэж бодож байсан.

- Тэгээд. Би юу ч ойлгохгүй байна.

Дахиад бүгд чимээгүй боллоо. Хэн хэн нь хөдөлсөнгүй гурван биенээ ээлжлэн ширтсэний эцэст Баттөмөр бороо дуслахаас өөр чимээгүй нам гүмийг эвдэв.

- Зургийг угаахад алиалагчийн дүрс гараагүй тийм биз?

Зурагчин эр айсан бас гайхсан харцаар Баттөмөрийн нүүр лүү ширтлээ.

- Тийм ээ, яг тийм. Та .. та яаж мэдэв? Бас би тэр алиалагчийг зөвхөн “ алиалагч байна” л гэж харснаас биш өөр ямар нэгэн онцлог шинж тэмдэг энэ тэрийг нь хэлье гээд ч чадахгүй нь. Ер нь бол өнгөцхөн харахад л алиалагч гэмээр боловч үнэндээ тэр өндөр этгээд их аймаар байсан. Ялангуяа тэр нүд. Би уг нь тэр зургийг хэнд ч үзүүлээгүй. Цагдаа нарт ч үзүүлээгүй, би цагдаа нарт зөвхөн кадр гэрэлд цохиулсан болохоор зураг гараагүй л гэж хэлсэн.

- Тийм ээ, та яагаад ч юм тэгж хэлмээр санагдаад байсан. Яг л хэн нэгэн танд тушаагаад байгаа юм шиг. Тийм үү?

- Тийм ээ, яг тийм. Хэн нэгэн надад тэр зургийг хүнд үзүүлэх хэрэггүй гэж тушаасан. Та нар намайг ойлгож байгаа биз дээ. Би ... ,юу би...

- Тийм ээ, бид таныг ойлгож байна. Та санаа зоволтгүй.

Баттөмөр ингэж хэлмэгцээ Ганбаяр луу харцаа шилжүүлэхэд Ганбаярын нүүрэнд бүр учраа олохгүй, гайхаж балмагдсан шинж тэмдэг тодхон үзэгдэв. Дахиад л бүгд ямар нэгэн бодол

болон хэсэг хугацаанд дуугаа хураацгаалаа.

- Ах аа, танд тэр хүүгийн алиалагчтай хамт авхуулсан зургийн хальс байгаа юу? хэмээн Баттөмөр зурагчин эрийн нүд рүү маш нухацтайгаар ширтэн асуув.

- Тийм ээ, байна.

- Тэгвэл та бидэнд тэр хальсаа зарчих. Эргэлзэх хэрэггүй. Бүр харин гай болж мэднэ.

- Тийм байх аа, мөнгө төгрөгөөр зарна энэ тэр гээд яахав. Зүгээр л авч үз. Тэгээд ч тэр өөдгүй, жаахан хүүхдийн эрлэг болсон алиалагчийг ямар нэгэн аргаар байриад шанг нь хүртээ. Манай бага хүү ч гэсэн энэ хэргийн талаархи мэдээллээс болоод гудамжаар тайван явж чадахгүйд хүрээд байгаа шүү. Үл таних намхан зурагчин эр ийнхүү сөөнгөтөн хэлээд аппаратныхаа цүнхний цахилгааныг нээн жижигхэн цагаан өнгийн хуванцар дугуй хайрцагтай боловсруулсан хальс гаргаж ирээд Баттөмөрт өгөв.

- Яг 16 дахь кадр шүү.

- Баярлалаа ах аа, бас май, үүнийг ав.

Баттөмөр ингэж хэлээд түрүүвчнээсээ таван мянгатын дэвсгэрт гаргаж ирээд зурагчин эрд өглөө. Энэ бол бага ч гэсэн таны бидэнд үнэнээ хэлж тусалсны чинь хөлс. Нэрэлхэлгүй аваарай. Ингээд Баттөмөр, Ганбаяр хоёр хальсаа халааслаад шууд л засварт орчихоод байгаа Засгийн газрын ордны баруун талд байрлах гэрэл зураг боловсруулах konika лаборатори луу алхлаа. Тэд хоорондоо ямар ч үг сольсонгүй. Баттөмөр баруун гараа халаасандаа хийж, зүүн гараа хагас атгаад шийдэмгий түргэн алхаж байлаа. Харин Ганбаярын хувьд чухам юу болоод байгааг ч сайн ойлгохгүй байгаа бололтой Баттөмөр лүү үе үе асуусан харцаар харан хажууд нь зэрэгцэн алхална.

- Баттөмөр өө, чи тэр зурагчин ахыг ...

- Битгий асуу, би чиний наад асуултанд чинь өөрөө ч хариулж чадахгүй. Зүгээр л би тэр ахыг алиалагчийн зургийг дарсан хүн мөн гэдгийг шууд мэдэх шиг болсон.

- За за, ойлгомжтой.

Ганбаяр хүүгийнхээ үхэлд өөрийгөө буруутган, эмгэнэн гашуудаж байгаа сэтгэл нь өөдгүй новшийн алуурчин алиалагчийг барих гэж чадварлаг найзтайгаа хамт хөөцөлдөж байгаад бага зэрэг сагааран, уй гашууг түр мартагнаж байлаа. Тэгээд ч тэрээр хүүг нь авч одсон тэр алиалагчийг барихаар өөртөө хатуу тангараг тавьжээ. Тэд явсаар тун удалгүй зураг угаах танхимд орж ирлээ. Баттөмөр борооноос ангид хуурай газар орж ирмэгцээ шууд л хальсыг дэлгэж 16 дахь кадрыг харав. Түүний нүдэнд зүгээр л нэг бүрсийсэн юм харагдахад тэрээр хальсаа Ганбаярт шилжүүлээ. Ганбаяр хальсыг минут хэртэй эргүүлж тойруулан харж байснаа Баттөмөрт буцааж өгчээ. Баттөмөр бөглөх хуудас авч 16 дахь кадр 13x18 гэсэн харьцаан дээр хоёр хувь гэж тэмдэглээд хальсыг тус зураг угаах газрын үйлчлэгчид өгөв. Хорин минтын дараа зураг бэлэн болно гэхэд мөрдөгчид гадаах саравчинд орж тамхилахаар

гарцгаалаа.

... Талийгаач хүүгийн зураг маш тод томруунаар гарчээ. Харин түүний хажууд зэрэгцэн зогсож байсан алиалагч байх ёстой тэр хэсэгт бэх асгачихсан юм шиг нүүгэлтсэн хар толбо болжээ.

- Новш гэж санаанд оромгүй юм.

Ганбаяр өөрийн эрхгүй ийнхүү дуу алдаж хөмхийгөө зуун, тааз ширтэж байснаа Баттөмөрөөс асуулаа.

- Новш чинь ер нь яахаараа зурган дээр дүрс нь гардаггүй байна аа. Зурагчин ахын аппарат нь эвдэрчихсэн, эсвэл энэ зураг угаах лабораторит асуудал гарсан юм болов уу?

- Үгүй л болов уу. Дарсан бусад зурагнууд хальсан дээр бүгд зүгээр харагдаж байна. Зөвхөн энэ зураг л, бүр тэр тусмаа яг энэ алиалагч л зурган дээр гарсангүй. Тэр Баярт гэдэг талийгаач хүү зүгээр л гарсан байна. Харин алиалагчийн дүрс гарсангүй. Энэ хүүгийн царай муу юм болохыг зөгнөсөн юм шиг нэг л гунигтай, айсан шинжтэй харагдаж байна.

- Наад новшийн алиалагч чинь тэгээд юу болж таарч байна даа. Хүүгийн минь амийг авч одсон ад зэтгэрийн муу шулам. Олдог л юм бол ална даа.

- Тийм ээ, яг үнэн. Хүн биш шулам.

- Юу гэнэ ээ?

- Юу ч гэсэнгүй ээ. Хоёулаа одоо 120 мянгат орчмоор эргэлдэж, тэр хавийн траншейнаар хоног төөрүүлдэг Тулгаатай очиж уулзъя. Ганцхан тэр хүү л алиалагчтай бусдаас арай илүү удаан хамт байсан. Тэр хүүгийн юу ярихыг өөрсдөө чихээрээ сонсох хэрэгтэй байх гэж бодож байна. Энэ зураг хэрэг болж магад энгэрийнхээ халаасанд хийчих. Баттөмөр ингэж хэлээд өнөөх алиалагчийн оронд хар бэх нүүгэлтчихсэн юм шиг зургийг Ганбаярт өгөв. Тэд урагшаа зам дагуу явж Төв шуудангийн хойно тавьсан машин руугаа алхлаа.

Яагаад ч юм Баттөмөрийн бие нэг л базаахгүй байлаа. Хамаг бие нь сулахч, толгой нь эргэн шуудхан хөнжилдөө шурган унтаад өгмөөр бодогдоно. Ямар нэгэн зүйл харагдаж магадгүй гэсэндээ нүдээ аних авч юу ч эс үзэгдэнэ. Их ядарч байгаа бололтой, их ядарсны дараа өөрт нь нүдээ аньсны дараа юу ч харагддаггүйг Баттөмөр сайн мэднэ. Түүнийг хүүхэд хулгайлдаг алиалагчийн тухай бодох болгонд толгойг нь алхаар балбаж байна уу даа гэлтэй лугших, цэв хүйтэн нялцгар гар багалзуурыг нь шахах мэт сэтгэгдэл төрүүлэх аж. Гэсэн ч тэрээр бууж өгсөнгүй. Ямар ч хүнд хэцүү зүйл тохиолдож байсан эрлээ үргэлжлүүлж, энэ хэргийн эцсийг үзэхийг өөрөө өөртөө тушаана. Бас тэрээр үүний хажуугаар өөрийгөө бага зэрэг гайхаж байлаа. Урьд өмнө нь өөртөө авч байсан ажлууддаа улам бүр урамшиж, алхам тутамдаа цагаасаа урьтаж бүхнийг олж мэдэрдэг байсан. Харин энэ удаад бүх юм өөрөөр байна. Бурхан тэнгэр өөрөөс нь нүүр буруулав уу, эсвэл буг чөтгөр нь гай болов уу? Ямартай ч түүний энэ удаагийн алиалагчийн араас мөрдөх алхам тутамд далдын ямар нэгэн хүч саад болоод байв. Баттөмөр үүнийг маш сайн мэдэрч байлаа. Магадгүй тэр алиалагч хүн биш,

орчин цагийн ороолон, өөр гарагаас ирсэн буг чөтгөр гэдэгт Баттөмөрийн дотоод сэтгэл эргэлзэхгүй байв. Хүнд хэцүү байаач гэсэн яарах хэрэгтэй. Алиалагч бүр илүү муу юа хийхээр зэхэж байна. Гэхдээ чухам юуны тулд, юу хийх гэж байна?

... Машины хөгжмөөр Харанга хамтлагийн “ Сүүлчийн шөнө” дуу цангинана. Нэлээд хэдэн жилийн өмнө хит болж байсан энэ дууг Ганбаяр чухам яагаад өнөөг хэр нь хадгалж сонссоор байгаа нь жаахан сонирхол татаж байсан ч Баттөмөр энэ тухай түүнээс асуусангүй.

Сүүлчийн шөнө чиний минь амьдрал шиг богинохон байсан Сүүлчийн шөнө чимээгүй саран шиг тодхон байсан Сүүлчийн шөнө эргэж уулзахаар болзоод өглөөг хүлээсэн Эцсийн учрал байсныг хэн хэн нь ч мэдээгүй

Дууны үг Баттөмөрт өнгөрсөн амьдралынх нь уйтгартай буланг санагдуулах мэт. Одончимэг хэмээх оюутан ахуй цагтаа танилцаж байсан охиндоо сэтгэл татагдаж, удалгүй гэр бүл болох юм болоод хамтдаа хэсэг хугацаанд амьдарсан. Удахгүй хуримаа хийнэ гээд л баярлан гүйлддэг байлаа. Гэтэл одоогоос гурван жилийн өмнө яг л өнөөдрийнх шиг бороо шивэрч байсан тэр нэгэн өдөр Одончимэг нь хөдөө аймгууд руу жуулчин дагуулж явах болсон. Тэр үед залуухан хосуудад мөнгө шиг хэрэгтэй юм байдаггүй байлаа. Тэгээд л Одончимэг зээлээр сууж байгаа байрныхаа мөнгөнд бага ч болов нэмэр болох боломжтой боллоо гээд л хөөрцөглөж явах бэлтгэлээ хангаж эхэлсэн. “ Наймхан хоногийн хугацаатай явна. Тэгээд л 400 долларын цалин авна. Алдаж болохгүй боломж байгаа биз дээ, миний хайр аа” гэж хэлээд хүүе гэхийн завдалгүй цүнхээ үүрээд гараад гүйчихсэн. Уг нь Баттөмөр Одончимэгийгээ боломжийн ажил олоод авч ашгүй дээ гэж бодож байснаа гэнэт л нээн муу ёрын совин татаад эхэлсэн. Толгой нь эргэх шиг болоход бие муудлаа гэж санаад ганц ширхэг цитрамон ууж усаар даруулаад нүдээ анин орон дээрээ хэвтэж билээ. Тэгэхэд түүний нүдэнд хэзээ ч төсөөлөөгүй өнөөг хэр нь санаанаас нь гарахгүй байгаа тийм дүр зураг үзэгдсэн. Одончимэгийн сууж явсан Asia маркийн автобус онхолдож олон хүмүүс хашхиралдан шуугилдаж, тар дундаас Одончимэгийн танил болсон ядам хуруундаа бөгжтэй энхрий булбарайхан гар цусанд будагдчихсан байх нь үзэгдэж билээ. Энэ бол зүүд биш байсан. Зүгээр л нүдээ аних болгонд нь тэр аймшигт дүр зураг үзэгдэж, олон хүмүүсийн айж сандарсан дуу чихэнд нь цуурайтаж байв. Бас өөрийнх нь Одончимэгт бэлэглэсэн тэр бөгж цусанд будагдсан гартайгаа юу юунаас илүү тод харагдаж байлаа. Яг л бага байхдаа ээжийгээ улаан даавуугаар бүрсэн модон хайрцганд хэвтэж байгааг урьдчилан харсан тэр үед төрсөн мэдрэмж дахин давтагдсан. Тэгмэгц Баттөмөр Одончимэгийн гар утас руу залгаж автлбусанд битгий суугаарай гэж хэлэхийг хүссэн боловч холбогдож чадаагүй. Тэгээд яаж ч чадахгүй басаар хоцорчихсон. Тэрээр эгээтэй л галзуурчихаагүй. Үнэхээр Баттөмөрийн нүдээ аниад харсан тэр осол хотын захад болсон байсан бас битгий л тийм байгаасай хэмээн бурханд залбиран гуйж байсан ч Одончимэг ослоор өнгөрчихсөн. Тийм ээ, Баттөмөр амьдралдаа тэгэхэд хоёр дахь удаа өөрийнхөө энэ өнөөг хэр нь тайлбарлаж чадахгүй байгаа зөн совингоо үзэн ядсан. Хэрвээ хүсэх л юм бол оюун ухаанаа төвлөрүүлэн хичээгээд, өнгөрсөн бас ирээдүйн талаарх элдэв явдлыг олж мэддэг байсан тэр чадвараа чөтгөр лүүгээ тонилоосой хэмээн харааж байлаа. Гэвч түүний энэ чин сэтгэлээсээ хүссэн хүсэл нь биелээгүй. Түүний далд мэдрэмж улам идэвхижин хөгжсөөр байсан.

... Бороо орох нь, гал гарах нь, ихэр хүүхэд төрөх нь гээд хаа хамаагүй зүйлийг гудамжаар

алхаж байхдаа л санамсаргүй олж мэддэг байсан. Ийм зүйл мэдэрснийхээ дараа инээд ч хүрэн шиг, уур ч хүрэх шиг болдог. Тэгээд өөрийгөө шалгаж үзэхэд 100 хувь биш юмаа гэхэд 90 хувь нь биелэлээ олдог. Тэгэхэд нь ёстой уур хүрч үхмээр болох үе бий. Гэхдээ Баттөмөрийн хувьд би ийм зүйл болохыг мэдрээд байна, ингэхийг нь мэдэж байна гээд хүмүүст гайхуулахыг огтхон ч хүсдэггүй. Тийм ээ, огтхон ч хүсдэггүй. Ялангуяа Одончимэгийн үхлийн дараа далд мэдрэмжийнхээ талаар бүр хэнд ч хэлэхгүй гэж тангараг тавьсан. Хүнд гай зовлон тохиох гэж байгааг нь урьдчилан сануулах шиг том нүгэл байхгүй. Зүгээр л бүх юм үйлийн үрээрээ, хувь тавилангаараа зохицуулагдаж байг.

Энэ мэдрэмж нь заримдаа хүмүүст хэрэг болдог, заримдаа бүр дэмий байдаг. Нэг удаа өнгөрсөн 2005 оны сүүлээр “Бөмбөгөр” худалдааны төв шатахад тэрээр Ганбаярын гэр бүлд ихээхэн тус хүргэж байсан юм. Найзынх нь эхнэр Тамираа тэнд лангуу түрээслэж наймаа хийдэг байлаа. Яг гал гарахын урд өдөр л өглөө үүрээр шахуу Ганбаярын гэрийн утас хангинаж Баттөмөр тэдэнд өнөдрийн дотор лангуугаа буулга гэж зөвлөсөн. Тэгээд энэ тухай өөр хүнд юу ч битгий хэлээрэй гэж аминчлан захисан. Тамираа үүнд маш ихээр дургүйцэж, Баттөмөрийг эргүү мангараар нь дуудаж байсан ч эцэст нь нөхрийнхөө үгэнд орж бараагаа хураасан юм. Гэхдээ Баттөмөрийн хувьд “Бөмбөгөр” шатна гэж найздаа хэлээгүй бас мэдээ ч үгүй. Зүгээр л нүдээ аних болгонд нь найз Ганбаяр нь өрөнд орчихсон яахаа мэдэхгүй шанаагаа тулан сууж, эхнэр Тамир нь уйлж унжиж байгаа харагдаад байсан. Тэгээд л Баттөмөр ердөө гуравхан хоногийн хугацаатай лангуугаа хураагаач ээ гэж тэднээс бараг гуйх шахан утасдсан нь энэ. Гэтэл “Бөмбөгөр” худалдааны төв бадамлан асч, олон наймаачид амьдралаараа хохирох нь тэр. Харин Ганбаяр, Тамир нар цөөн хэдэн азтай хүмүүсийн нэг болон нэрлэгдэж үлдсэн юм. Ганбаяр эхнэртээ “Баттөмөр лангуугаа хураа гэж хэлсэн тухай хэнд ч хэлж болохгүй” гэж хатуу анхааруулсан. Мэдээж хэн нэгэн хүнд үг алдаж гэмээнэ орооцолдох нь дамжиггүй гэдгийг цагдаагийн байгууллагад ажилладаг Ганбаяр хэнээс ч илүү сайн мэдэж байсан нь тэр. Баттөмөрийн хувьд тэрээр өөрийн амьдралд хэрэгтэй нэг зүйлд л энэхүү гайхамшигтай мэдрэмжээ ашигласан. Тэр нь өөрийн гэсэн боломжийн өмчтэй, тохитой орон байртай болох гэсэн явдал байв. Хайртай бүсгүйнхээ дандаа л мөрөөдөж ярьдаг байсан тэр элбэг хангалуун амьдралыг ядаж өнгөрсөн хойно нь ч гэсэн бий болгохоор шийдсэн. Тэгээд л хүнээс мөнгө зээлж нэг сарын турш бооцоо тавьж, мөрийтэй тоглоом тоглож, үер бууж, ток тасрах гэх мэт явдлын дараа гэнэт хэрэг болох зүйлсийг цагийг нь олж худалдаалж эхэлсэн. Тийм ээ, Баттөмөр ердөө л ганцхан сарын дотор банкинд 24000 доллар хадгалуулж үүнээсээ гадна Одончимэгтэй хамт үргэлж худалдаж авахыг мөрөөддөг байсан хэгдүгээр хорооллын гурван өрөө байрыг авсан. Тэгээд л больсон.

Өөрийн энэ чадвараа ашиглаж “ мөнгө хийх” нь нүгэл юм шиг түүнд санагддаг байв. Бурхны өгсөн энэ чадварыг буруу зүйлд ашиглах нь хамгийн ёсгүй хэрэг мэт санагдаж, өөрөөр амьдрах аргаа хайж эхэлсэн. Тэгээд л “Хувиараа мөрдөгч хий” гэсэн Ганбаярын саналыг уухайн тас зөвшөрсөн дөө. Энэ ажил нь өөрт нь яг тохирсон ажил гэдгийг Баттөмөр цаг хугацаа өнгөрөх тусам мэдэрч, энэ ажлаасаа шудрагаар үр ашгаа хүртэж байлаа. Энэ нь мэдээж хаа хамаагүй үзмэрч, мэргэч төлөгч гэсэн нэр зүүж явахаас хамаагүй дээр мэт түүнд санагдах болжээ. Бас мөнгийг ч хангалттай олчихдог болсон.

... Дуу яваад дуусчээ. Ганбаяр машинаа жолоодсоор тэд 120 мянгатад ойрхон ирчихэж. Тэд хуучин байсан танктай хөшөөний хойно байрлах “Монгол арга” дээд сургуулийн машинаа

зогсоогоод буув. Бороо бүр улам ширүүсч эхэллээ. Ганбаяр зүгээр л үг дуугүй Баттөмөрийг ширтэн зогсоход Баттөмөр чухам яг хаашаа явахаа мэдэхгүй дэмий л дороо эргэлдэн зогсоно. Гэхдээ тэд нэг их удсангүй тэр хавийн траншейнуудаар эргэлдэн, Тулгааг хайж гарлаа. Ноорхой хувцас өмссөн, шуудайтай хог лааз араасаа чирсэн болгоноос Тулгааг сураглан асуусаар орон сууцнуудын дунд байх нэгэн траншейнд хүрч ирэв. Орж байгаа бороон дуслуудаас өөрсдийгөө хамгаалах гэсэн бололтой зузаан картонон цаасаар нүхийг хагас таглажээ. Баттөмөр доош тонгойж картонон цаасыг хагас сөхөж Тулгаа байна уу хэмээн чанга дуугаар асуув. Үүний хариуд “ Хэн бэ, яах гэсэн юм” гэх жаахан хүүхдийн шингэн дуу хадлаа.

- Хүү минь чамтай уулзах хэрэг байна. Гараад ирэхгүй юу?

- Та цагдаагаас яваа юм уу?

- Санаа зоволтгүй ээ, гараад ир. Ах нь цагдаа биш. Гэхдээ чамтай уулзах хэрэг байна.

-... За за, одоохон.

Тулгаа бол арван настай гэхэд үеийнхнээсээ харьцангуй өндөр, гуйлгачин гэхэд хүний нүүр лүү эгцлэн харж чаддаг, өөртөө итгэлтэй цовоо дуутай хүү байлаа. Түүний өмссөн хувцас нь тэр аяараа хир даг болсон ч харин хаа очиж ямар нэгэн уранхай, цоорхой байсангүй. Хүүгийн урт ургасан үс нь хог шороонд зууралдан ширэлджээ. Басхүү өмнө нь өөрөө ч юм уу эсвэл хэн нэгнээр үсээ хайчлуулж байсан бололтой үснийхээ зарим нэг газраа өм цөм тайруулчихаж. Баттөмөр, Ганбаяр хоёр гурван секунд орчим тэнүүлчин хүүг ажиглан хараад, хүүд юуны өмнө хоол өгөхөөр шийдэж, цайны газар луу дагуулан алхлаа. Хүүг цадталаа хоолоо идэж дуусан дуустал тэдний хэн нь ч юу ч асуусангүй. Ингээд эцэст нь хоол идэж цадаад сайхан зантай болсон Тулгаа хүү Баттөмөр лүү инээмсэглэн харж “ Та манай үхсэн найзын талаар надаас асуух уу?” хэмээн дуугарлаа.

- Эхлээд найзыг чинь дагуулж явсан тэр алиалагчийн тухай жаахан ярилцмаар байна. Түүнээс гадна чи хүссэн бүхнээ бид хоёрт ярьж болно. Сайн бодож байгаад хүүхдийн баярын тэр өдөр яг чухам юу болсныг нэгд нэгэнгүй чөлөөтэй тайван ярих хэрэгтэй. Яагаад гэвэл бид чиний найз байсан Бямбааг хөнөөсөн этгээдийг барих гэж хичээж байна.

- За. Гэхдээ манай жаахан Бямбааг тэр өндөр алиалагч алсан. Бямбаа бид нараас насаар хамгийн бага нь байсан болохоор бид нар түүнийг тэгж нэрлэдэг юм.

- Алиалагч найзыг чинь алсан гэдэгт чи яагаад ийм итгэлтэй байгаа юм бэ?

- Зүгээр л тэр чинь ойлгомжтой. Бидэнд тэр өндөр алиалагч хоол бас зайрмаг өгсөн. Гэхдээ нэг их юм яриагүй. Уг нь би өмнө нь ерөөсөө тийм алиалагч харж байгаагүй. Эхлээд би монгол биш гадаадын алиалагч юм болов уу гэж бодож байтал харин ганц нэг зүйл биднээс асуусан. Монголоор шүү дээ. Бид нар тэгэхэд парк дээр дөрвүүлээ явж байсан. Биднийг ээлжилж харж байснаа дараа нь Бямбааг хамт явна шүү л гэсэн. Бямбаа ч толгой дохисон. Гэхдээ тэр зөндөө их айчихсан байсан. Би ч гэсэн яагаад ч юм их айгаад тэр алиалагчийн нүүр лүү нь ч эгцэлж харж чадаагүй. Бас тэр алиалагчийн дууны өнгө татгалзахын аргагүй аймаар, сүрдмээр байсан шүү. Би ч гэсэн Бямбаагийн оронд байсан бол яаж ч чадахгүй

түүнийг дагаад л явах байсан.

- Тэр алиалагч та нарт өөр юм ярьсан уу?

- За байз, аан тийм. Нээрэн надтай тааралдсан зургаан настай хүүхдүүд хамгийн азтай. Учир нь надтай таарсан тэр хүүхдүүд хэзээ ч үхэхгүй өлсөхгүй ч гэлүү, нэг тийм юм ярьсан. Уг нь их гоё юм ярьж байсан ч гэсэн үнэхээр аймаар байсан шүү. Яагаад ч юм тэр алиалагчаас болж би одоо болтол айгаад л байгаа. Өндөр биетэй алиалагч ах Бямбааг дагуулаад явсны дараа би түүний авч өгсөн бүх хоолыг бөөлжөөд гаргачихсан. Одоо би тэр алиалагчтай дахиад дайралдах вий гэхээс маш их айдаг. Шөнө болгон траншейнд унтдаг том ах нарын хажууд гуйж байгаад унтаж байгаа.

Ингэж хэлээд хүү нэг хэсэг чимээгүй боллоо. Тэрээр үе үе хөмсгөө зангидаж, нүдээ онийлгон ямар нэгэн зүйлийн тухай бодолхийлж байв. Баттөмөр, Ганбаяр хоёр хүүг үргэлжлүүлэн ярихыг нь хүлээн, өмнөө байгаа аягатай цайнаас нэг хоёр оочлон Тулгаа руу ширтсэн хэвээр. Гэтэл хүү бүр юу ч ярих шинжгүй болчихлоо. Нүд нь юу ч харахгүй байгаа юм шиг хоосон оргиод, бодит орчноосоо тасарчихсан юм шиг сэтгэгдэл төрүүлэх нь тэр. Ганбаяр ингээд л үргэлжлүүлэн суугаад байх уу, гэсэн бололтой Баттөмөр лүү харахад тэрээр “Яарах хэрэггүй” хэмээн гараараа занган ойлгуулав. Тулгаа таг чиг хэвээр. Дөнгөж саяхан л амаа олохгүй ярьж байсан жаахан хүү бүр ямар нэгэн юманд ховсдуулчихав уу гэлтэй харц нь нэг цэгт төвлөрч гөлрөөд, амьд байгаа эсэхдэ нь ч эргэлзэхэд хүрмээр харагдана.

Ганбаяр тэссэнгүй бололтой хүүгийн нүдний өмнө гарынхаа алгыг сэгсрэв. Гэтэл Тулгаа яг л нойрноосоо сэрсэн хүн шиг давхийтэл цочин Ганбаярыг хараад “Яасан бэ?” гэж асуух нь тэр. Ганбаяр түүнээс ямар нэгэн юм асуух гэсэн бололтой биеэ займчсанаа эргэлзэж Баттөмөр лүү харав. Харин Баттөмөр Тулгаа руу нүд салгалгүй ширтэж байснаа

- Чи сая хаана байж байгаад ирэв? хэмээн асуулаа.

- Би мэдэхгүй байна.

- Өөр ярих юм байна уу?

- Өөр би юу ярих ёстойгоо мэдэхгүй байна. Тэр алиалагч бол мангас. Тэрэнд зургаан настай хүүхдүүд хэрэгтэй гэсэн. Тэгээд л манай Бямбааг аваад явсан. Бямбаа бол бид нарын хамийн жаахан нь, зургаахан настай хүүхэд.

Тулгаа ийнхүү бага зэрэг юм яриад үе үе шал өөр ярианы сэдэв рүү хальран орж байв. Болж л өгвөл өөрийнхөө мөрөөдлийн тухай ярьж, хүүхэд үрчилж авдаг сайн аав ээж байгаа эсэхийг мөрдөгчөөс асууна. Хүүг ингэж хадуурах болгонд нь Ганбаяр үндсэн гол ярианыхаа сэдэв рүү түүнийг эвгэйхэн чиглүүлж, алиалагчийн өмссөн хувцас, дууны өнгө гэх зэрэг олон асуултыг дахин тавьж байлаа. Алиалагчийн тухай ярьж түүнийг эргэн санах нь хүүд үнэхээр хэцүү байгаа бололтой. Тэрээр Ганбаярын асуух болгонд бие нь хөлрөн, нүд нь ямар нэгэн учир битүүлэг айдаст авгаж байлаа. Гэвч хичнээн хэцүү байгаа ч гэлээ хамаг оюун ухаанаа төвлөрүүлэн алиалагчийн тухай ямар нэгэн зүйл санахыг хичээж байгаа нь аравхан настай жаахан хүүд үнэхээр ахадсан гэмээр харагдах аж. Тулгаа ийнхүү хичнээн хичээж байгаа ч

гэлээ Баттөмөр, Ганбаяр хоёрт өөр илүү ойлгомжтой зүйл хэлж чадахгүй байв. Гэхдээ л тэрээр хичээж байлаа.

- Миний дүү хэрвээ энэ тухай ярихад хэцүү байгаа бол жаахан амарч байгаад дахиад эхэлж болно шүү дээ.

- Зүгээр ээ, би ярих болно. Намайг тэр алиалагчийн тухай илүү олон юм хэлбэл та хоёр түүнийг хурдан барина шүү дээ.

Тулгаа ингэж хэлэхдээ дууны өнгө нь илт сулран, шанаанд нь хүйтэн хөлс чийхарч эгээтэй л унаад өгөх нь үү гэмээр харагдаж байв. Баттөмөр үүнийг хараад асуултаа даруйхан зогсоож хүүг амраах хэрэгтэй гэж шийдлээ. Учир нь, Тулгаагийн энэ байдлыг Баттөмөр маш сайн ойлгож байсан бөгөөд өөрт нь ч гэсэн алиалагчийн тухай ямар нэгэн зүйл нэхэж бодох тусам тайлбарлахад бэрхтэй гэмээр дарамт учирдаг.

- Одоо болно оо, бид хоёр маргааш чам дээр ирнэ. Тэгээд энэ тухай үргэлжлүүлэн ярилцъя. Чи дэндүү их ядарчихаж, өнөө орой алиалагчийн тухай тайван байж байгаад сайн санахыг хичээ.

- За тэгье ээ. Би уг нь та хоёрт туслахыг маш их хүсч байна.

- Санаа зоволтгүй ээ. Маргааш бидний хувьд их үр дүнтэй өдөр болж өнгөрөх байх.

Баттөмөр, Ганбаяр луу толгой дохиод цайны газраас гарлаа. Харин Тулгаа суусаар хоцров. Тэрээр Баттөмөр, Ганбаяр хоёрын гарахыг ч харсангүй. Харин Ганбаяр явдал дундаа хоёр ч удаа эргэн хараад ямар их биширснээ гайхаж байв. Тийм ээ, Баттөмөр, Ганбаяр хоёр ийм хүүхэдтэй уулзна гэж бодоогүй билээ. Тулгаагийн ярианы өнгө, аравхан настай хүүхдэд дэндүүү ахадсан гэмээр шийдэмгий мөртлөө ухаалаг нүд, хоол идэж байгаа соёл нь ч гэсэн цөм гайхшрал төрүүлээд амжжээ. Хэрвээ энэ хүүхэд цэвэрхэн царайтай, хиргүй хувцастай байсан бол хэн ч түүнийг ар гэргүй, гудамжны хүүхэд гэж бодохгүй гэдэгт тэдний хэн хэн нь итгэлтэй байв. Ганбаяр машинаа асааж дөнгөж хөдөлснөө эргээд зогсчихов.

- Яасан бэ хөө?

- Мэдэхгүй, саяын хүүг өрөвдөөд...Бид хоёр хүний урманд түүний амьдралыг ч сонирхсонгүй.

- Тийм ээ, би ч гэсэн яг л чамтай адилхан тэр хүүг өрөвдөөд байна.

- Аравхан настай хэрнээ ийм хэрсүү, цэгцтэй яриатай, зоригтой хүү байх гэж. Бас жаахан хиртэй л болохоос биш их соёлтой айлд өсч хүмүүжсэн бололтой. Хоол идэхдээ хүртэл элдэв чимээ гаргалгүй цэвэрхэн идэж байгааг нь.

- Ийм хүүхэд траншейнаар хоног төөрүүлдэг ч болох гэж.

- Баттөмөр өө, би Тулгааг өнөөдөр гэртээ аваачиж хонууллаа.

- Эхнэр чинь гайхах биш үү, тэрний оронд хоёулаа манайд аваачиж хонуулъя. Усанд оруулаад



сайхан тордьё. Ямар ч байсан хүү алиалагчтай учирснаас хойш маш их айдас түгшүүрт авгаад шөнө болгон тавгүй хонож байгаа байх.

- Зүйтэй.

Ингэж хэлээд Ганбаяр машинаа унтрааж яаран буулаа. Баттөмөр ч түүнийг дагав. Тэднийг цайны газар эргэн ороход хүү яг л хүлээж байсан юм шиг өөдөөс нь инээмсэглэн хараад сууж байх нь тэр.

Баттөмөр хүүг гэртээ аваачиж, цэвэрхэн дулаахан хөнжлөөр хучин унтуулжээ. Тэр шөнө Баттөмөр бөөн бодол болж хонолоо. Хажуугийн унтлагын жижиг өрөөнд цэвэрхэн цагаан хэрэглэлд унталгүй удсан аравхан настай хүүгийн жигдхэн зөөлөн хурхирах чимээ сонсоно. Тулгаа хүү зургаан сарын турш траншейгаар хоног төөрүүлжээ. Аав ээжтэйгээ гурвуулаа элэг бүтэн амьдарч байтал гай тохион аав нь ослоор өөд болчихож. Тэгээд ээж нь шаналсаар нэг их удалгүй өвчинд ороогдож Тулгаагийн аавын араас бурхны оронд заларчээ. Жаахан хүүд дэндүү хүнд цохилт болж харж хандах хүнгүй ханха хоосон гэрт хэдэн өдрийн турш толгой хоргодож байгаад нэг өдөр гал алдаж, гэрээ шатаагаад түүнээс хойш траншейгаар хоног төөрүүлдэг нэгэн болж хувирсан гэнэ. Баттөмөр, Ганбаяр хоёр Тулгааг гэр лүүгээ авч явж байх замдаа түүнд шинэ хувцас худалдан авч, саунд суулган, хамаг хирнээс нь бүрэн салгажээ. Цэвэрхэн тохилог, дулаахан орчинд ойрд унтаагүй жаахан хүү ямар ч зүүд зүүдлэлгүй үхэр буугаар буудсан ч сэрэхгүй нь үү дээ гэмээр сэтгэгдэл төрүүлнэ.

Өдрөөс хойш Баттөмөрийн санааг зовоосоор байгаа нэгэн зүйл бол би алиалагчийг зогсоож чадахгүй нь үү гэсэн айдас байлаа. Үнэндээ Баттөмөрт урд өмнө нь ийм зүйл тохиолдож байсангүй. Бүх хэргүүдийг маш амархан илрүүлж учрыг нь олж дөнгөдөг байсан. Өөрөө бол мэргэжлийн мөрдөгч биш, гэхдээ өөрийгөө юунд ч торохгүй гайхалтай зөн билэг, далд авьяастай гэдэгтээ итгэдэг. Гэтэл энэ удаад түүнд тэр зөн билэг, далд авьяас нь тус болохгүй байлаа. Алиалагчийн тухай бодолхийлж, анхаарлаа төвлөрүүлэх болгонд нь толгой нь тэсэхүйеэ бэрх ангалзан өвдөж, цэв хүйтэн нялцгар нарийхан гар багалзуурыг нь шахах мэт болно. Басхүү тэрээр энэ байдлаасаа ч болов уу эсвэл урьдын адил зөн совин нь ч түүнд тус болов уу ямартай ч алиалагч хүн биш гэдгийг мэдрээд байх шиг. Гэтэл хүн биш байлаа гэхэд тэр этгээд тэгээд юу болж таарах вэ? Хэн мэдлээ. Би ер нь юутай л зууралдаад байна даа. Бас тэгээд түүнийг хаанаас олж болохоо ч мэдэж чадахгүй, оюун ухаан нь сул дорой арчаагүй байгаа мэт түүнд санагдана. Ийнхүү Баттөмөр элдвийг бодон хөрвөөсөөр нэг л мэдэхэд нүд нь анилдан унтчихжээ. Тэрээр аймшигтай муухайгаар хар даран тарчилж байлаа. Баттөмөр зүүдэндээ бага насныхаа амьдралд эргэн очжээ. Эргэн тойронд түнэр харанхуй эзэгнэж, нүдэнд юу ч үл үзэгдэнэ. Тэрээр гэртээ харихыг маш их хүсч байх хэдий ч урагшаа алхам ч гишгэж чадахгүй байлаа.

Харанхуйд сүүтгэнэсэн өндөр хар амьтан Баттөмөрийг тойрон гүйж байх аж. Тэгснээ зэвүүн муухай сөөнгө хоолойгоор хүйтнээр инээмсэглэж “Би чамд үхэл бэлэглэх болно” хэмээн зогсоо зайгүй шивнэнэ. Аравхан настай Баттөмөр ямар ч хөдөлгөөн хийлгүй доороо зогссоор. Түүний нүдэнд юу ч харагдахгүй хэвээр. Гагцхүү өөрийг нь тойрон зогсоо зайгүй асар хурдтайгаар эргэлдэх өндөр хар амьтан л гүн харанхуйн дундаас үл ялиг ялгаран харагдах аж. Баттөмөр айснаасаа болоод уйлж байлаа. Тэрээр ямартай ч ингээд л хөдөлгөөнгүй зогсоод байвал удахгүй энэ аймшигтай аварга амьтан өөр лүү нь дөхөж ирээд муухай хүйтэн гараараа

багалзуурыг минь шахаж алах болно гэдгийг мэдрэх шиг боллоо. Зугтах хэрэгтэй, тийм ээ, яг одоо зугтах хэрэгтэй. Энэ аварга том сүүдрийг хуураад зугтах хэрэгтэй. Баттөмөр хойшоо ухран гүйх мэт хуурамч хөдөлгөөн хийхэд өнөөх аварга том сүүдэр түүнийг даган харайлгав. Тэгмэгц нь Баттөмөр өөртөө байгаа хамаг хүчээ шавхан урагшаа огцом гүйлээ. Түнэр харанхуйн дунд юу ч үл үзэгдэх хэдий ч Баттөмөр огтхон ч түүртэлгүй бүхнийг оюун ухаанаараа баримжаалан урагшаа гүйсээр байв. Одоо удахгүй машин зам хөндлөн гараад тэгээд л гэрийнхээ үүдэн дээр оччихно гэсэн үг. Одоо жаахан л зам үлдлээ. Ээ, золиг гэж өнөөх аварга сүүдэр чинь яг араас хөөсөөр байна.

Баттөмөр зэрвэсхэн төдий эргэж харахад тэрээр тун удахгүй өөрийг нь гүйцэн ирэх гэж байгаа аймшигт сүүдрийг харанхуйн дундаас төвөггүйхэн ялгаж харав. Баттөмөр машин замын өмнө тулж ирлээ. Түүний өмнүүр машинууд асар хурдтайгаар их дуу хадаан тасралтгүй давхилдана. Гэхдээ тэр машинууд түүнд огтхон ч харагдахгүй байлаа. Машинууд гэрлээ асаагаагүй болохоор харанхуйд ялгарч харагдахгүй байх бөгөөд тэгсэн хэрнээ моторынхоо дууг хүнгэнүүлэн, асар хурдтайгаар тасралтгүй давхилдсаар. Баттөмөрийн хувьд машинд няцартлаа дайруулж үхэхийн тулд ердөө л урагшаа ганцхан алхам хийхэд хангалттай байв. Баттөмөр яаж чадалгүй хэсэг зогссоноо эргэж харлаа. Аварга том сүүдэр айсуу. БИ ЧАМД ҮХЭЛ БЭЛЭГЛЭХ БОЛНО ОО, ЗУЛБАСАГА МИНЬ.

## ХОЁР

Өглөө эрт гал тогооны өрөөнд хэн нэгэн гишгэлэн явах мэт чимээ гарахад Баттөмөр нойрноосоо сэрлээ. Шөнийн хар дарсан зүүднээсээ болоод хамаг бие нь ямар ч тамир тэнхээгүй болон сульджээ. Тулгаа босчихсон гал тогооны өрөөнд идэх юм хайж яваа юм байлгүй дээ гэж бодсоор Баттөмөр өндийлөө. Тэрээр нуухтай нүдээ нухлан галын өрөөнд ороход тэнд Тулгаа байсангүй, харин шал өөр муу ёрын этгээдийг олж харах нь тэр. Таазанд нь арай хүрэхгүй өндөр биетэй, нэвсийсэн ногоон хувцас өмссөн, урт гартай, хэрээний сарвууг санагдуулам чөргөн нарийн хуруутай, өнгөцхөнөөр дүгэнэхэд алиалагч гэж хэлэхэд болмоор нэгэн этгээд түүн рүү харсаар угтав. Нүд нь яг л харанхуй гүн хавцал мэт ямар ч амьгүй гэмээр өтгөн хар ажээ. Тэрээр цагаан улаан өнгө хосолсон шингэхэн буржгар үстэй хувхай цагаан нүүртэй юм. Энэ хувхай цагаан нүүрэнд зөвхөн нүд, ам, хамар нь л ялгаран харагдаж байв. Түүнд ямар ч сахал хөмсөг энэ тэр байсангүй. Алиалагч Баттөмөрийг хараад нүүрэндээ үл ялиг инээмсэглэл тодруулснаа амаа хагас ангайн тас хар өнгөтэй урт хэлээрээ цаас шиг нимгэхэн гэмээр хар өнгийн нарийхан зураасан уруулаа шилэмдэн долоолоо.

Баттөмөр яахаа мэдэхгүй хөшиж орхих нь тэр. “Новш гэж энэ чинь юу вэ. Миний хайж байгаа өнөөх хүүхдийн эрлэг болсон алиалагч чинь тэгээд энэ үү. Тийм байх болов уу гэж төсөөлж байсан алиалагчаас бүр шал өөр юм. Энэ этгээд бол нүүрээ ч үсээ ч будаагүй л байгаагаараа байгаа тийм этгээд байна. Новш гэж мөн байх нь ээ, тэр алиалагч ч биш зүгээр л шулам юм байна” Баттөмөрт ийм бодол хоромхон зуурын хугацаанд төрөөд амжив. Бас тэрхүү шөнийн зүүдэнд нь үзэгдсэн аварга том үхэл бэлэглэгч сүүдэр чинь энэ байх нь. Одоо энэ этгээд яах болдоо гэсэн айдаст автсан арчаагүй бодол Баттөмөрийн хамаг бие сэтгэлийг нь эзэмдэх мөчид үүнийг нь мэдсэн юм шиг алиалагч түүн рүү гараа сунгав. “За хөөрхий ингээд л өнгөрөх нь дээ, энэ амьтныг би яагаад ч барж идэхгүй нь” Баттөмөр өөрөө өөртөө бодлоороо ингэж хэлээд энэ сүрдмээр “алиалагч”-д сэтгэлээрээ бугаад өгчихжээ. Тэрээр өөрийгөө ийм

амархан буугаад өгчихнө гэж даанч төсөөлсөнгүй, эсвэл энэ амилсан шулам өөрийгн ховсдож байгаа байх. Тиймээ, Баттөмөр өөрийгөө үнэхээр ховсдуулж байгаага мэдрэв. Алиалагчийн эсрэг ямар нэгэн үйлдэл хийх тухай бодол түүний санаанд өчүүхэн төдий ч орж ирсэнгүй. Зүгээр л аалзны торонд орчихсон өчүүхэн жижиг шавж үхлээ хүлээн, аварга том махчин аалзыг ширтэж байх шиг тийм мэдрэмж Баттөмөрт төрж байв. Гэтэл энэ үед гэнэт хаалганы хонх дуугарах нь тэр. Үүнийг сонссон алиалагч Баттөмөрийн нүднээс харцаа салгахад Баттөмөр яг л хүлээснээсээ мултрах шиг тийм мэдрэмж амсав. Баттөмөр тэгмэгцээ шууд л өөрт нь ойр байсан галын өрөөний том модон сандлыг аваад алиалагчийг цохиход модон хөлнүүд нь бут үсрэн хугарлаа. Түүний энэ цохилт нь алиалагчид зүгээр л нэг ялаа ирээд мөргөсөнтэй ижил тусав бололтой. Алиалагч Баттөмөрийг нэг гарынхаа нарийхан хуруунуудаар багалзуурдаж аваад “Бусдын хэрэгт бүү оролц. Би чамд үхэл бэлэглэх болно” хэмээн чихарсан муухай дуугаар хэлэв. Энэ үгийг хэлэхдээ алиалагчийн ам хөдөлсөнгүй. Алиалагчийн тухай бодох болгонд төрдөг байсан яг тэр мэдрэмж Баттөмөрт мэдрэгдэж байлаа. Цэв хүйтэн нялцгар нойтон гар багалзуурыг нь шахаж байна гэсэн тэр мэдрэмж одоо яг мөн. Хоолой нь боогдож дуу ч гарах боломжгүй болох нь тэр. Хонх үргэлжлүүлэн жингэнэсээр байлаа.

Баттөмөр алиалагчийн дийлэхгүй нь гэдгээ мэдрэх шиг болов. Тэгмэгцээ тэрээр эцсийнхээ хүчийг шавхан үүдэнд байгаа Ганбаярыг ороод ирээч хэмээн оюун ухаанаа хүчлэн байж зөн совингоороо дуудлаа. Хөлөөрөө угаалтуураа өшиглөхөд крантнаас ус цацагдлаа. Гэтэл гэнэт хаалга маш хүчтэй өшиглөгдөн түгжээ нь мулт үсэрч Ганбаяр ороод ирлээ. Алиалагч Баттөмөрийн хоолойг шахахаа больж гараа авчээ. Баттөмөр хаалганы хажууд гайхан зогсох Ганбаярыг олж харчихаад эргэж хартал алиалагч байсангүй. Дөнгөж саяхан л багалзуур шахаад өөрийг нь эгээтэй л тонилгочих гэж байсан алиалагч арилаад өгч. Баттөмөр хоолойгоо барин хахаж цацан байж Ганбаяр луу харахад тэрээр найзынхаа хаалгыг эвдсэндээ маш ихээр гэмшиж байгаа бололтой сандарсан байртай зогсож байх нь тэр.

Баттөмөр гурван минут хэртэй амьсгаагаа аван Ганбаярыг ширтэн сууж байснаа түүнээс асуулаа

-Чи...чи алиалагчийг харсангүй юу?

-Юу, тэр хаана байна гэж?

Ганбаярын энэ асуултанд харин Баттөмөр хариулсангүй. Ойлгомжтой. Ганбаяр алиалагчийг, алиалагч ч гэж дээ аварга биетэй ороолонг дөнгөж саяхан энд намайг алах гэж байсныг олж харж амжаагүй байх нь. Баттөмөр хэсэг хугацаанд шоконд орсон байснаа нээлттэй байгаа тагтныхаа хаалгаар гарч гадагшаа яаран харав. Юу ч харагдсангүй. Уг нь Баттөмөрийнх зургаан давхарт байдаг. Саяын алиалагч эндээс шууд л доошоо үсэрчихнэ гэж баймааргүй санагдана. Эсвэл дээшээ авирсан уу, үгүй ээ. Тийм байх учиргүй. Гэхдээ ямартай ч үнэхээр дөнгөж саяхан энд намайг алах гэж байсан алиалагч бараа сураггүй арилаад өгч. Зөвхөн тэр алиалагчийн энд байсны баталгаа болсон хэмхэрч унасан модон сандлын сэг шалан дээгүүр хөглөрч хагарсан крантнаас тасралтгүй ус цацагдаж харагдана.

Ганбаяр юу ч ойлгохгүй шилээ маажин Баттөмөрийн зүг асуусан харцаар ширтэн зогсож байлаа. Тэрээр өөрийгөө чухам яагаад найзынхаа гэрийн хаалгыг онгойлгож өгөхгүй байсных

нь төлөө эвдчихснээ бодоод олохгүй санаа нь зовж байв. Тэгснээ гэнэт нэгийг ухаарав бололтой Баттөмөрийн зүг ширтсэнээ “Яагаад сандлаа эвдчихээ вэ, юу болоов?” хэмээн асуув. Энэ үед бөөн дуу чимээнээс болж нойрноосоо сэрсэн Тулгаа тэдний хажууд хүрч ирлээ.

Ганбаярын энэ асуултын нь хариуд Баттөмөр юу ч хариулж хэлсэнгүй. Зүгээр л “хаалга эвдсэндээ санаагаа зовоох хэрэггүй ээ” хэмээн Ганбаярыг тайвшруулахыг хичээн дуугарахчаа аядав.

-Баттөмөр өө, чи зүгээр үү бие чинь муу байна уу?

-Гайгүй дээ. Зүгээр л маш их ядарсан юм шиг байна. Гучхан минут унтаж амраад орхиё. Чи засварчин руу утасдаад наад хаалгаа засуулчих. Бас энэ крантыг ч гэсэн.

Баттөмөр ингэж хэлээд найзаасаа ямар нэгэн үг хүлээсэнгүй чигээрээ алхаж өрөөндөө ород хэвтгээд өгөв. Ийнхүү хэвтгэх үед Тулгаа “Сайн уу Ганбаяр ахаа. Юу болоо вэ” хэмээн түүнрүү дөхөж очлоо. Ганбаяр түүнийг чимээгүй хэмээн хуруугаа уруулдаа хүргэн дохио өгөөд засварчин руу утас цохилоо.

Харин Баттөмөрийн хувьд алиалагчтай нүүрээрээ тулаад амьд үлдэж чадсан азтай нэгэн болж хувирчээ гэлтэй. Тэрээр гурван цаг орчим унтаад босч угаалгын өрөөнд орж хүйтэн усаар нүүрээ угаалаа. Түүнийг гарч ирэхэд Ганбаяр Тулгаа хоёр цай бэлдчихээд хүлээж байв. Хэмхэрхий сандлыг хурааж хагарсан крантыг янзлаад хаалганы цоожийг сольж хуучин хэвэнд нь оруулжээ. Гайхалтай нь Баттөмөр энэ бүхнийг ердөө мэдсэнгүй бүр нам унтчихсан байж. Тэрээр юу ч болоогүй юм шиг ширээнээ суун халуун цай оочиллоо. Өдрийн 13 цаг өнгөрч байлаа. Ганбаяр найз руугаа асуусан харцаар ширтэн суух хэдий ч үүнийг нь Баттөмөр огтхон ч ойшоосонгүй. Зүгээр л ууж байгаа аягатай цай руугаа харсан чигтээ “Чи ч уг нт өглөө яг л тохирсон ёсоороо цагтаа ирсэн шүү. Даанч найз нь шөнө дутуу нойртой хонож жаахан ядраад нам унтчихлаа” гэж хэлээд өөр юу ч хэлсэнгүй. Харин Тулгаа “Би үнэхээр сайхн амарлаа Төмрөө ахаа. Таны ачийг хэзээ нэгэн цагт хариулах болно оо” хэмээн цовоо хэрнээ бага зэрэг болгоомжлонгуй дуугаар өгүүллээ. Үүнийх нь хариуд Баттөмөр муухан мушийгаад өнгөрөв. Түүний хувьд өглөөний алиалагчтай халз таарсан явдал үнэхээрийн гэнэтийн сэтгэлийг нь цочроосон хэрэг болжээ. Тэрхүү аймшгийн алиалагчийн гэмээр муу ёрын сэтгэл хирдхийлгэмээр дүр төрх түүний санаанаас гарахгүй тарчлааж байв. Бас тэрхүү алиалагч Баттөмөрийг өөрт нь хамгийн ихээр гай болох хүн гэж санаад үгүй хийхээр ирсэн үү, ямартай ч өөрийг нь алахыг оролдсон нь хэмжиж хэлэхийн аргагүй таагүй сэтгэгдэл төрүүлж байх нь тэр.

Баттөмөр ийнхүү бодолдоо автсаар...Ямар ч дуу гарахгүй болсон нам гүмийг эвдэхийн тулд Ганбаяр Тулгаа руу нүд ирмээд “Гурвуулаа өчигдрийнхөө ярьж байсан сэдвийг үргэлжлүүлэ” хэмээн хэллээ.

Тулгаа ч уухайн тас зөвшөөрч өчигдрийн алиалагчийн тухай яриаг үргэлжлүүлэв.

-Би зарим нэг юм нэмж санасан. Мэдээж хэрэг тэр алиалагч өндөр байсан ч гэлээ би хэзээ ч тийм өндөр хүн хараагүй. Уг нь эхэндээ модон хөл өмсчихсөн юм болов уу гэж бодож байсан

л даа. Гэтэл тийм биш гэдэг нь түүний явдлаас л андашгүй байсан. Лав танаас миний энэ гарыг хоёр юм уу гурав дахин сунгаад өргөчихсөн юм шиг өндөр гэхэд болно. Нээрээ шүү гээд Тулгаа Ганбаяр луу харан баруун гараа дээш нь байдгаар нь өргөн харуулав. Ганбаярын царай цаанаасаа айдаст автах мэт болоод явчихав. Тэрээр уг нь бол 182 см өндөр. Гэтэл тэр алиалагч өөрөөс нь бүр хавьгүй илүү өндөр байх нь. Уг нь түүнд эхнэр Тамир нь тэр алиалагч их өндөр юм байна лээ гэж ярьж байсан ч Тулгаагийн ярьж байгаа шиг бүр ийм айхтар өндөр гэдгийг төсөөлж байсангүй.

Тулгаа дахиад л өчигдрийн нэгэн адил дуугаа хураан чимээгүй болчихов. Баттөмөр Тулгаа хоёр яг адилхан байдалд орчихжээ. Юу ч ярихгүй чимээгүй гөлрөөд л, ямар нэгэн зүйлийн тухай бодолд автсан бололтой таг болчих нь тэр. Тэдний хэн хэнийх нь нүүрэнд айж эмээсний шинж тэмдэг тодхон үзэгдэх аж. Ганбаяр тэдэнтэй ярих гээд бүр ядаж цөхөөд эцэст нь тамхи аваад ирье хэмээн гэрээс гарлаа. Ганбаяр Баттөмөр Тулгаа хоёрын энэ байдлыг гайхаж яах тухайгаа бодон эргэцүүлж үүний хажуугаар бусдын гарт эмгэнэлтэйгээр алагдаад удаагүй байгаа хайртай хүүгийнхээ тухай бодолд авган байрны өмнөх хүүхдийн тоглоомын талбайн сандал дээр суусаар нэг л мэдэхэд бүхэл бүтэн цаг гаран болчихжээ. Тэрээр яаралгүйхэн босч Баттөмөрийн орц руу ороод зургаан давхар өөд тайван өгслөө. Түүнийг орж ирэхэд өнөөх хоёр чинь суугаад хоцорсон яг тэр хэвэндээ суусаар байгаа нь түүнийг нүдэнд өртөж эрхгүй гайхах сэдэл төрүүлэв.

Тулгаагийн нүүрээр маш их хөлс дааварлаж бүр их даарч байгаа юм шиг хамаг бие нь салганаж байх нь тэр. Ганбаяр ч болохоо байлаа хэмээн Баттөмөрийг угзарч сэгсрэхээс наахнуур юм болоход тэрээр сая нэг юм арайхийн ухаан орох шиг болов. Баттөмөр Ганбаяр хоёр сандарч эхэллээ.

-Ахын дүү яаж байна. Бие нь өвдөж байна уу, бид хоёр чамайг эмчид аваачиж үзүүлье. Ганбаяр ингэж хэлээд гарынхаа алгыг хөөрхий хүүгийн духанд нь хүргэж үзлээ. Халуу шатаж байх нь тэр.

-Баттөмөр өө, яадаг билээ? Тулгаа бүр аймшигтай ихээр халуурч байна.

-Эмнэлэг рүү аваад явья хэмээн Баттөмөр сулхан дуугарлаа.

Баттөмөрийн хувьд Тулгаатай хамт сууж байхдаа яагаад ч юм бөөн бодол болж энэ болж байгаа бүхэн ямар нэгэн зайлшгүй тохиолдох ёстой хувь тавилангийн нэг хэсэг мэт түүнд санагдаж байжээ. Түүний оюун ухаан нь өөр хүнийх болчихсон юм шиг аа хамаагүй үсчин өнгөрсөн ирээдүй хоёроор ээлжлэн тэнүүчилж байв. Тулгаагийн ярьж байсан, үзүүлж байгаа үйлдэл бүхэн бас тэгээд өглөөний тэр алиалагчийн ад зэтгэрийн царай, нялцгар хүйтэн гар түүний өнгөрөн одсон арван насны тэр аймшигт дурдатгалыг нь сануулж байлаа.

...Хар хөх өнгийн сурагчийн дүрэмт хувцсаа өмссөн арван настай гуравдугаар ангийн жаахан хүү хичээлээ тараад гэрийнхээ зүг алхаж байсансан. Яагаад ч юм тэр өдөр гудамжаар явж байгаа ямар ч хүн түүний нүдэнд өртөхгүй байсан. Гэхдээ салхи сэрчигнэж, болжмор жиргэж, сургуулийн ар талын замаар хаа нэгтээ хурдлан өнгөрөх машины дуу сонсогдож байсан. Түүнийг хичээлээ тараад явж байх тэр үед 16 цаг өнгөрч байсныг Баттөмөр одоо болтол маш тодхон санадаг. Хичээл тарсан хэдий ч өөрөөс нь өөр хүүхдүүд яагаад ч юм

харагдахгүй байгаад бага зэрэг гайхаж байсан хэдий ч нэг их тоогоогүй. Хурдхан гэртээ харимаар санагдаж байсан даа. Гэтэл түүнийг сургуулийн хашаанаас гарч амжихаас өмнө гэнэт хав харанхуй болчих нь тэр. Бүр хав харанхуй нөмөрч өтгөн хар манан өөрийн нь эргэн тойрон хүрээлэх мэт болж нүд нь юу ч харахгүй болсон. Нүдээ цавчилж хамаг анхаарлаа төвөлрүүлэхийг хичээсэн боловч хязгааргүй тэнгэрийн эцэс төгсгөл рүү ширтэх мэт гүн харанхуйгаас юу ч ялгаран харагдсангүй. Ердөө л хав харанхуй болчихсон. Дараа нь бас шувууд ч дуугарахаа больж ямар ч чимээ аниргүй таг чиг болох нь тэр. Нүүрийг нь илбэн сэвэлзэж байсан салхи ч гэсэн ямар нэгэн зүйлд хашигдчихсан юм шиг зогсчихсон. Тэгэхэд Баттөмөр өөрийнхөө биеийг муудаж байна, нүд минь сохорлоо хэмээн санаж өөрийгөө шалгахад хамаг бие нь зүгээр л байх шиг.

Тэгээд л хамаг бие сэтгэлийг нь айдас түгшүүр эзэмдэж хязгааргүй гүн харанхуйн ыдунд хаашаа ч хөдөлж чадалгүй хөшчихсөн. Хашхирч, хэн нэгнээс тусламж дуудья гэж санасан хэдий ч айсандаа болоод ч тэр юм уу дуу хоолой нь ч гараагүй. Бас энэхүү үгээр хэмжихийн аргагүй их айдсаасаа болоод өмдөндөө шээчихсэн. Ингээд гуч орчим минутын дараа харанхуй болсонтойгоо адил гэнэт л гэгээ орчихсон. Урьдын бүх юм хэвэндээ орж, шувууд дэрхийн нисэж, машинууд давхилдан хаа нэгтээ нохой хуцах нь сонсогдсон. Хүмүүс ч гэсэн юу ч болоогүй юм шиг аажуу тайван алхаж байгаа нь харагдаж билээ. Энэ бүх дүр зургуудыг олж хараад Баттөмөр маш ихээр баярласан хэдий ч гэнэт тохиосон харанхуйн тухай айдас нь сэтгэлийг нь түгшээсэн хэвээр байсан. Тэгээд л Баттөмөр хөлийнхөө хамаг хурдаар гэрлүүгээ гүйчихсэн. Замдаа ганц ч зогсолгүй, эргэж ч харалгүй гүйсээр гэртээ ирэхэд аав ээж, эмээ нар нь бүгдээрээ уйлж унжин түүнийг зүгээр эсэхийг лавлан асууж тойрон хүрээлэх нь тэр. Тэгээд бас хаана байж байгаад ирэв, хаашаа очсон юм бэ, хэнийг дагаад явчихав, хоол унд идсэн үү? Гээд л төрөл бүрийн асуултаар булж гарсан даа. Баттөмөр учрыг нь олохгүй гайхан эргэлзэж байснаа ээжийнхээ “Бүхэл бүтэн зургаан хоногийн турш хаана байвдаа хүү минь” гэсэн арчаагаа алдан цөхөрсөн дууг сонсоод сая бүхнийг ойлгожээ. Баттөмөр зургаан хоногийн дараа гэртээ иржээ. Гэхдээ үүндээ өөрөө ердөө ч итгэсэнгүй. Зүгээр л өглөө хичээлдээ яваад одоо ирж байна хэмээн Баттөмөр аав ээжийгээ гайхсан харцаар харан хариуллаа. Би гадуур хоноогүй шүү дээ ааваа, ээжээ, эмээ хэмээн сандран хариулсан боловч түүний үгийг хэн ч сонссонгүй. Тэгэхэд нь Баттөмөр гэнэт харанхуй болоод эргээд гэгээ орсон тухай хэлэх гээд ярьж эхэлтэл үүнийх нь хариуд аав нь ердөө л түргэн дуудчихсан. Гэнэт харанхуй болоод тэгээд гуч орчим минутын дараа эргээд гэгээ орсон хэмээн хэлсэн хэдий ч түүнд хэн ч итгэхгүй зүгээр л галзуу солиотой хүн рүү харж байгаа юм шиг тийм нүдээр ширтэцгээж байлаа. Тэгтэл ээж нь түүнийг тэврээд үг сүггүй уйлж эхлэх нь тэр. Баттөмөр бүр яахаа мэдэхгүй гайхаш тасран суусаар байхад аав нь цагдаагийн газар луу утасдаж “Манай хүү өөрөө хүрээд ирсэн” хэмээн хэлээд утсаа салгалаа. Зурагтаар үнэхээр ням гарагийн орой болгон гардаг “Агшин” нэвтрүүлэг явж байх нь тэр. Энэ нэвтрүүлгийг Баттөмөр бүтэн сайн өдрийн орой гарах тухай телевизийн программаас дөнгөж өнөө өглөөхөн олж харснаа ч тодхон санаж байлаа. Бас үүнээс гадна ханан дээрх өдөр тутмын хуанли нь даваа биш ням гарагийг харуулж байх нь тэр. Аав ээж эмээ нар нь өөрөөр нь тоглоод ингээд хуанлиа хүртэл эргүүлж “Агшин” нэвтрүүлгийг зурагтаар гаргана гэж баймааргүй санагдана. Ингэсээр энэ бүхний эцэст Баттөмөр өөрөө өөртөө эргэлзэж би үнэхээр зургаан хоногийн турш алга болчихоод ирсэн юм болов уу гэж бодтол түрүүн айсандаа шээчихсэн өмд нь нойтон хэвээрээ байв. Баттөмөр дахиад л баахан гайхаж өч төчнөөн эргэлзээнд автлаа. Эмнэлгийнхэн ирсэн хэдий ч аз болж түүний ээж эмээ хоёр нь

хаяг андуурсан байна гэж худлаа хэлээд явуулчихсан. Тэгээд тэр оройжин аав ээж хоёр нь өч төчнөөн юм шалгааж, өөрөө ч бас баахан гайхсан хэдий ч энэ бүхнийхээ учрыг олж чадаагүй. Маргааш өглөө нь хичээлдээ ирэхэд ангийн нь бүх хүүхдүүд түүнийг асуусан харцаар угтаж Ганбаяр мэтийн зарим дотнын найзууд нь “Чи зургаан өдрийн турш хаана байж байгаад гараад ирэв ээ” хэмээн шивнэн асууж байсан. Баттөмөр тэдэнд юу ч хариулж чадаагүй. Зүгээр л толгойгоо сэгсрээд сууж байсан. Хичээл эхэлж дэвтрийнхээ булан он, сар, өдрөө тавихад үнэхээр “Өчигдрөөс хойш долоо хоног өнгөрчихсэн” гэдэгт сая нэг юм бүрэн итгэж билээ.

Дараа нь тэр явдлыг Баттөмөрөөс бусад хүмүүс тэгсгээд л мартацгаасан хэдий ч Баттөмөрийн санаанаас өнөөг хэр нь гараагүй хэвээр. Тэр үл мэдэгдэх нууцлаг үйл явдлын хариуг одоо болтол олж чадаагүй. Гэхдээ Баттөмөр нэг зүйлийг маш сайн мэдэж байсан. Тэр нь мэдээж яг тэр өдрөөс эхлээд ямар нэгэн зүйлийн талаар урьдчилан мэдрээд эсвэл өнгөрсний тухай зарим нэг явдлыг хараад байх шиг болсон. Бас үүгээр ч тогтохгүй ирээдүйд болох гэж байгаа ямар нэгэн муу зүйлд түүнийг далдаас хэн нэгэн бэлтгэж байгаа ч юм шиг. Баттөмөр энэ болгондоо итгэхгүй байсан ч өөрийгөө шалгаж үзэхэд бараг ихэнх зөгнөлүүд нь биеллээ олдог байсан. Тийм ээ, өнөөг хүртэл. Түүний өөрийнхөө гайхалтай зөгнөх чадвартаа баттай итгэсэн тэр үе нь мэдээж ээжийнхээ үхлийг урьдчилан харж аавдаа хаягдахаа ойлгосон 12 нас хүрсэн тэр үе байсан. Түүнээс хойш эдүгээ 29 нас хүртэл нь энэхүү зөгнөх чадвар нь өөрийг нь орхиогүй харин ч бүр улам хөгжсөөр ирсэн.

Яг одоо Баттөмөрт магадгүй энэ далдын хүч гэмээр энэ совин нь алиалагчийг зогсоохын тулд өөрт нь заяагдсан юм шиг санагдаж байлаа. Алиалагч бол хүн биш чөтгөр, шулам, ороолон.

Ер нь юу ч гэж нэрлэсэн болно, тэр бол ямар ч байсан бидэнтэй ижил жирийн нэг хүн биш Баттөмөр үүнийг маш хүчтэй мэдэрч байлаа. Тэрээр яг одоо Ганбаярын жолоодож яваа машины арын суудал дэр учиргүй халуурч байгаа Тулгааг мөрөөр нь тэвэрчихсэн явж байв. Хэзээ яаж яваад ингэж машинд орж ирээд хүүгийн хажууд сууснаа ч санасангүй. Бүх оюун ухаан нь бодит байдлаа анзаарахгүй болтлоо бодолд авгчихаж

Ганбаяр хотын төвд байрлалтай Ёнсэй хэмээх хувийн эмнэлгийн үүдэн дээр машинаа зогсоогоод Баттөмөртэй хамтдаа хүүг эмнэлэгт оруулж тусгай өрөө гаргуулан Тулгааг хэвтүүлээ. Эмч хүүг ядарсан байна, бас ханиадтай байга учраас хэвтүүлж хэд хоног эм тариа хийх шаардлагатай гэхэд Баттөмөр зөвшөөрч хүүийн эмчилгээний бүх төлбөрийг нь төлөв. Сувилагч Тулгааг 23 номерийн тасагт оруулж хэвтүүлээд эм уулгалаа. Энэ үед Баттөмөрийн духаар нь хүйтэн хөлс дааварлаж, толгой нь эргэхэд тэрээр нүдээ анин зогтуслаа. Түүний нүдэнд нарийхан хорчгор хар гар ямар нэгэн хаалгыг магадгүй эмнэлгийн хаалгыг түлхээд дотогш орж байгаа нь харагдах нь тэр. “энэ алиалагч мөн байна” хэмээн Баттөмөр нүдээ нээж Ганбаяр луу ширтлээ. Гэтэл энэ үед түрүүнээс халуундаа шаналан дэмийрч байсан Тулга жаахан сэргээд хэвтэж байсан орон дээрээсээ өндийж “Ганбаяр аха, нээрэн тэр алиалагч хүүхдэд хайртай гэсэн. Бас тэгээд зөндөө олон хүүхдүүдийг баярлуулах болно” гэж хэлж байсан шүү гээд буцаж хэвлээ. Энэ үеэ тэдэнтэй хамт Тулгааг хэвтүүлсэн тасагзогсож байсан эмч сувилагч хоёр залуучуудыг гайхсан нүдээр ээлжлэн ширтэж байлаа. Энэ байдал нь мэдээж тэднийг хотыг тэр чигт нь айдас түгшүүрт автуулж байгаа алдарт алиалагчийн тухай яриад байгаа юм болов уу хэмээн сонирхсон нь илт аж. Баттөмөр, Ганбаяр хоёр

эмнэлгээс гарцгаалаа. Тэд эмнэлгийн үүдэн дээр суусаар магадгүй алиалагчийг хүрээд ирэхийг хүлээсээр байв. Ингэсээр нэг л мэдэхэд цаг нэлэд орой болчихжээ. Зарим айлууд гэрлээ асааж согтуу хөлчүү хүмүүсийн явах нь ихсчихэж. Өглөөхөн л алиалагчийн тухай бодох болгонд тархи толгой нь лугшиж байсан Баттөмөр одоо бүр шал эсрэгээрээ болжээ. Түүний эд эс бүхэн нь гайхалтай сайн ажиллаж эрч хүч дүүрэн оволзож байв. Баттөмөр ухасхийн өндийж Ганбаярын машин руу гүйлээ.

Хаашаа ч явахаа мэдэхгүй байгаа ч гэлээ Ганбаяр жолооны ард суун машинаа асаав. Түүний хажууд чимээгүй сууж байсан Баттөмөр шийдэмгий нь аргагүй “Эх нялхас руу яваарай” хэмээн шавдуулан дуугарахад Ганбаяр ч хаазаа нэмэн хурдаллаа.

-Өнөөдөр чинь 7 сарын 1-ний өдөр байх аа. Хараал идсэн алиалагч дараачийн золиосоо хайж байна. Хэрэг гарсан өдрөөс хойг яг нэг сар өнгөрчихөж. Өнөөдөр шөнийн дотор тэр чөтгөр дахиад зургаан настай гурван хүүг цааш нь харуулах нь. Ганбаяр аа, бид хоцорч мэдэх нь түргэн давхиарай.

-Мэдлээ. Хэрвээ тэр муу новш үнэхээр Эх нялхасын эмнэлэг дээр байгаа бол түүнийг би ална аа.

-Ганбаяр аа, чи цагдаа хүн. Цагдаагийн газар луу утасдаж “Алиалагч дараачийнхаа хүүхдийг хулгайлахаар явж байна” гээд хэлээдэхээч. Бид хоцорч мэднэ.

-Тэгэлгүй яхав. Яг зөв.

Ганбаяр ингэж хэлээд гар утсаараа цагдаагийн газар луу залгаж мэдээллээ. Гэсэн хэдий ч тэрээр маш их яарч байв. Учир нь Ганбаярын хувьд бусад цагдаа нараас урьтаж алиалагчийг барьж хүүгийнхээ өшөөг авах нь хамгаас чухал байлаа. Ганбаяр явган хүний замаар ч хамаагүй давхиж замын түгжрээнд оролгүй Эх нялхасын эмнэлэгт дөхөж ирэв. Харин Баттөмөр огтхон ч эргэлзэлгүй машины урд хайрцгийг нээж нэгэн гар буу гаргаж ирээд сумлалаа. Энэ буу бол Ганбаярын хэрэглэдэг буу бөгөөд энд байдгийг нь Баттөмөр бүр эртнээс мэдэх болсон билээ. Орой болж гэгээ тасарсан учир орон байрнуудын гэрэл асчээ. Асар хурдтай давхиж асан Ганбаяр машинаа эмнэлгийн үүдэн дээр огцом тооромслон зогсоож Баттөмөрөөс цэнэгтэй бууг авч машинаас яаран гарлаа. Баттөмөр эрчээрээ гүйсээр эмнэлгийн хаалгаар ороход түүний араас Ганбаяр буугаа халаасалсар алдалгүй дагав. Жижүүрүүд тэдний хаашаа орох гэж яваа юун хүмүүс вэ? Хэмээн саатуулахаар завдсан ч Баттөмөр тэдний хажуугаар сум мэт хурдлан өнгөрлөө. Харин Ганбаяр “Цагдаагийн газраас явж байна” хэмээн үнэмлэхээ хам хум үзүүлээд Баттөмөрийн араас жирийлгэв. Гурван давхар луу маш хурднаар өгсөж байсан Баттөмөр гэнэт явдал нь удааширч шатны хашлага төмрөөс зууран унан туслаа.

-Баттөмөрөө, ясан бэ? Юу болов? Бие чинь зүгээр үү хэмээн Ганбаяр амьсгаадсаар түүний хажууд хүрч ирээд бугуйнаас атгаж духан дээр нь гараа тавьлаа. Баттөмөрийн толгой халуу шатаж байх нь тэр.

-Би явж чадахгүй нь ээ, тэр хаалт тавьчихаж. Намайг нэвтрүүлэхгүй байна. Тэр бол хүн биш. Ганбаяр аа, би мэдэж байна, бас түүнийг харсан. Тэр надад саад хийж байна, яах ч арга алга.



-Тэгвэл чи эндээ байж бай. Би тэр новшийн учрыг нь олчихоод эргээд ирье. Эр яг хаана хэдэн давхарт байна?

-Хэрэггүй ээ. Ганбаяр аа, тийшээ битгий яв. Ойлгож байна уу, сонсооч би маш хүчтэй мэдэрч байна. Тэр миний тархин дотор тас тас хөхөрч удахгүй үхэх гэж байгааг минь сануулж байна. Бидэнд ямар ч боломж байхгүй. Тэр энэ удад хүссэнээ хийг. Бид яаж ч чадахгүй. “тэмээн дээр ямааны гарз” гээч болно. Алиалагч маш хүчирхэг. Тэр дэндүү аюултай байна.

Өмнө нь найзаасаа хэзээ ч иймэрхүү үг сонсож байгаагүй Ганбаяр яахаа мэдэхгүй хэсэг самгардан барьж алдлаа. Гэтэл яг энэ үед тэднээс дөнгөж тав зургаахан гишгүүрийн дээр байрлаж байгаа гурван давхрын хонгилын цаад үзүүрээс хэн нэгний хачин муухай хоолойгоор уйлж байгаагийн алин болох нь мэдэгдэхгүй тийм зэвүүн дуу чихнээ хадлаа. “тэр тэнд байгаа байх нь” хэмээн Ганбаяр амандаа үглээд цэнэглэчихээд байгаа гар буугаа ил гарган дээшээ ухасхийлээ. Баттөмөр түүнд юу ч хэлж амжсангүй. Хамаг бие нь сульдан ядарч толгой нь халуу шатан хөл гар нь чичирхийлэх аж. Тэрээр зөвхөн “хэрэггүй ээ. Ганбаяр аа. Одоохондоо хэрэггүй. Наад новш чинь хүүхэд эвлүүлж байна” гэж сулхан хэлээд ухаан балартан унахад түүний үгийг хэн ч сонссонгүй.

## Гурав

Ганбаяр эмнэлэгийн гурван давхрын нарийн хонгилоор алиалагчтай таарах л юм бол буудахад бэлэн байдалтай биеэ зэхэн, харцаа хэдэн тийш нь хурдан хурдан шилжүүлэн гүйж явлаа. Хонгилоор яваа ямар ч хүн харагдсангүй. Таазнаас өлгөсөн хэдэн ширхэг том гэрлүүд урт нарийхан хонгилыг хангалттай сайн гэрэлтүүлж чадахгүй сүүмэлзэн тусна. Ямар ч чимээ аниргүй нам гүм энд ноёлж байх бөгөөд зөвхөн Ганбаярын чулуун шалан дээр гишгэлэн алхах хөлийн чимээ л дуулдаж байв. Энэхүү ер бусын гэмээр чимээгүй байдал Ганбаярт үхэгсдийн дунд яваа мэт санагдаж, эрхгүй айх сэтгэл төрүүлэх аж. Саяын сонсогдсон тэр зүрх зүсэм адын дуу хоолой чухам аль өрөөнөөс сонсогдов. Баттөмөр яагаад намайг хорих болов, бие нь муудсан байсан зүгээр л байдаг байгаа даа, бас тэр “ тэмээн дээрээс ямааны гарз болно” гэж хэлсэн нь намайг үхнэ гэсэн хэрэг биш үү? Алиалагч хаана байна вэ, түүнийг би барьж чадах уу?

Энэ үед жаахан хүүхдийн “Туслаарай ээж ээ” гэсэн шаналасан дуу хонгилоор нэг хадаж чимээ аниргүй байдлыг эвдлээ. Үүний араас самгардаж сандарсан эмэгтэй “Миний хүүг өгөөдөх” хэмээн хоолой мэдэн хашхирах нь сонсогдов. Гэтэл нэгэн тасалгааны хаалга маш хүчтэйгээр савагдан баруун гартаа жаахан эрэгтэй хүүхэд сугавчилсан алиалагчийн хувцастай нэгэн өндөр эр гараад ирлээ. Алиалагчийн хувцастай ч гэж дээ зүгээр л алиалагч гэмээр харагдаж байна. Түүнээс биш энэ этгээдийг шууд л алиалагч байна, бүр хүн байна гээд нэрлэчихэд ч болмооргүй юм шиг. Нэг л этгээд сонин, муу ёрын хүйтэн зэвүүн өнгө аясыг илтгэж байх нь тэр. Ганбаяр түүнийг өндөр, том, биерхүү гэж сонсож байсан ч ийм өндөр хурдан шаламгай гэдгийг төсөөлж байсангүй. ЭЭ БУРХАН МИНЬ... энэ үг Ганбаярын амнаас өөрийн эрхгүй ийнхүү урсан гарлаа.

- Зогс новш минь буудлаа шүү.

- Өө, ... хөөрхий хүүгийн аав байх шив дээ. Гэхдээ зоволтгүй ээ, хүү чинь удахгүй энэ

ертөнцийг захирах болно. Тэр үхээгүй.

Алиалагчийн хоолой цаанаа л нэг зэвүүн сөөнгөтөн пэржигнэж байлаа. Хонгилын гэрэл хангалттай биш учраас алиалагчийн царай тийм ч сайн харагдахгүй байв.

- Новш минь олон юм донгосохоо болиод хүүг газарт буулга. Тэгэхгүй бол яг одоо буудлаа шүү. / Хүүгийнхээ алуурчинтай тааралдсан Ганбаярын хоолой чичирхийлж, хамаг бие нь үзэн ядалтаар цалгин оволзож байлаа/

- За яахав, бууд л даа. Хүлээж байна би.

Ганбаяр: “ Чамайг алчихья л даа” гэж орилоод алиалагчийн цээжин тус газар луу нь чиглүүлээд хоёр удаа буудлаа. Пан пан... гэсэн маш чанга буун дуу хоёр удаа сонсогдоход эмнэлгийн ажилтнууд болон өвчтөнүүд үймэлдэн сандралдаж хаа нэгтэйгээс зарим нэг хүний хашхирах нь сонсогдлоо. Гайхалтай, алиалагч хүний урманд хөдөлсөн ч үгүй. Ийм ойрхноос буудсан юм чинь онохгүй байна гэж лав байхгүй байлтай. Энэ үед хүүгийн ээж бололтой нэгэн эмэгтэй алиалагчийн гараас зуурч хүүгээ салгах гэхэд алиалагч түүнийг ердөө зөөлөн түлхэх шиг болоход хөөрхий бүсгүй хана мөргөн ухаан алдах шиг болоод уналаа. Эсвэл магадгүй бүр үхчихсэн ч байж мэднэ. Алиалагчийн тэвэрсэн хүү ч бас ухаан алдсан болотой ямар ч хөдөлгөөнгүй, гараа сул хаян гулзайн хэвтсэн харагдана. Ганбаяр бүр яахаа мэдэхгүй гайхаш тасран алиалагчийн зүг ширтсээр хөшчихөв. Өвчтөнүүд тасгийнхаа хаалгыг нээж, толгойгоо цухалзуулах хэдий ч төд удалгүй амиа хоохойлон хаалгаа хаан түгжинэ. Нарийн хонгилийн цаанаас нэгэн цагаан халаадтай залуухан сувилагч эмэгтэй алиалагчийн араас гүйн гарч ирснээ цочирдов бололтой мөн л ухаан алдан унах нь Ганбаярын нүднээ өртөв. Ганбаярын бие салганан дагжиж, бүх биеийг нь хэдэн талаас нь соронздон татсаар тасчиж хаях нь уу гэмээр сэтгэгдэл төрөх аж. Тэрээр ямар нэгэн далдын хүчинд ховсдуулан, хамаг бие нь сульдаж эхлэхэд өөрийнхөө гарт байгаа бууг арай ядан дааж байгаагаа мэдрэх шиг болов. **ЧИНИЙ ХҮҮ ҮХЭЭГҮЙ ЭЭ, АМЬД БАЙГАА. УДАХГҮЙ ХОРВООГ ЗАХИРАХ БОЛНО.**

Алиалагчийн энэ үг Габаярын чихэнд тасралтгүй цуурайтан хадаж байлаа. Тэрээр яагаад ч тэссэнгүй толгой нь эргэн, нүнийх нь өмнө газар дайвалзан босч ирээд бугаа алдан уналаа. Ганбаяр яаж ч хичээсэн сэхээ авч чадахгүй байх бөгөөд оюун ухаанаа хөвчрүүлэн арайхийн нүдээ хагас нээн харахад өнөөх алиалагч өөрийг нь ухаан алдсан жаахан хүүгийн хамт нэг гартаа сугавчилсан явааг олж мэдлээ. **ЧИНИЙ ХҮҮ ҮХЭЭГҮЙ ЭЭ...**

... Баттөмөр эмнэлгийн шатан дээр ухаан балартан унасан хэдий ч түүний оюун ухаан өнгөрөн одсон хүүхэд насныхаа амьдрал дунд хөвж байлаа.

Сурагчийн ширээн дээрээ суугаад хичээлээ хийж байхдаа багшаасаа нууцаар өөр нэгэн үлгэрийн номын хуудас эргүүлж, шимтэн уншдаг байсан нь нүдэнд тодхон үзэгдэж байх нь тэр. Хаана, хэзээ, хэн хэвлэсэн юм бүү мэд. Ямартай ч тэр номыг Баттөмөр бүр гурван удаа олсон. Хамгийн эхлээд гэр лүүгээ орохоор шатаар өгсөж байх замд нь бага зэрэг салбарсан тэрхүү хуучин ном шатан дээр хэвтэж байсан. Авах гэснээ болиод зүгээр л тонгойхоосоо залхуураад аваагүй. Дараачийн удаа байрны найз нартайгаа талбай дээр хөл бөмбөг тоглож байхад өнөөх ном нь хийсч ирээд яг хөл дээр нь буучихсан. Тэр үед Баттөмөр тоглоомондоо

улайраад мөн л тэр номыг тоогоогүй хаячихсан. Харин дараачийн удаа анги дээрээ хамгийн түрүүнд ирэхэд түүний ширээн дээр өнөөх ном яг л өөрийг нь хүлээгээд байж байгаа мэт хэвтэж байх нь тэр. Тэгээд л хичээл эхэлтэл хийх юм олдохгүй байсан аравхан настай жаахан хүү номын хуудсуудыг хайнгадуухан эргүүлж эхэлсэн. Тэгээд дараа нь тэр номын амтанд бүр орчихсон. Ямар хэлээр бичсэн байсныг нь мэдэхгүй ч ямар ч байсан Баттөмөр тэр номыг хачин сайн ойлгож байсан. Тэр номын санаа нь юу байлаа байз. Ямар нэгэн хувь заяагаар гэмээр өөрөөс нь салахгүй дагаж байсан тэр ном эмнэлгийн шатан дээр ухаан балартан хэвтэх өөрийнх нь санаанд орж ирсэнд Баттөмөр гайхаж байв. Гэсэн ч тэрээр бодит байдалдаа эргэн ирж чадахгүй байлаа. Түүний оюун ухаан нь бараг хорин жилийн өмнө нээж байсан номынх нь хуудас түүний мөр бүхнийг өөрт нь сануулахаар улайран ажиллаж байх нь тэр. У г номон дээр зуун жилд нэг удаа жар хоногийн хугацаатай дэлхий дээр ирж ертөнцийг захирахыг санаархдаг нэгэн шулмын тухай бичсэн байсныг санах шиг болов. Тийм ээ, хэрвээ тэр шулмыг зогсоож чадахгүй бол хүмүүсийн хүнлэг энэрэнгүй сэтгэл аажмаар устаж, тэгэх тусам тэр шулам улам бүр хүчирхэгжин бүх дэлхийг тэр чигт нь цусан далай болгон хувиргаж өөрөө түүгээр нь хооллодог болно. Үүнийг цаг алдалгүй зогсоох чадвартай нэг хүнийг бурхан томилдог. Тэр хүнээс өөр хэн ч тэрхүү урилгагүй зочин болсон шулмыш дарж чадахгүй.

... Тиймээ, тэр номон дээр нэг тиймэрхүү л юм бичсэн байсан. Ямар ч байсан бусад үлгэрийн номон дээр байдаг шиг аз жаргалтай төгсгөл байгаагүй. Ер нь ямар ч төгсгөл байгаагүй. Зүгээр л хүн төрөлхтнийг заналхийлсэн аймшигт шулмыг устгах ёстой гэсэн ганцхан санааг чухалчилсан байсан. Бас тэрхүү өөрийнхөө хамтрагч буюу үр хойчоо бэлтгэснээр ертөнцөд амьдрах үүд хаалгаа нээж, аймшигтай хүчирхэг байдлаа хэзээ ч мөхөөхгүйгээр бататгах болно. Тэрхүү хамтрагч нь зургаан настай жаахан хүү байх ёстой бөгөөд жинхэнэ хүмүүсийн үр хойчуудын цуглуулгаас бүрлэх ёстой. Зургаан хүүхдийн эд эрхтнүүдийг өөрийнхөө цустай хольж хүн шулмын эрлийз болсон үхэшгүй ороолонг дэлхий дээр байх жар хоногийн хугацаанд бүтээх зорилготой гэж тэмдэглэсэн байсан. Хэрвээ тэр дэлхий дээр ирэх урилгагүй шулам өөрийн хүүхдийг бүтээж чадвал түүнийхээ биеэр дамжин дэлхийд чөлөөтэй нэвтэрч, мөнх амьдралыг олох болно. Тийм ээ, яг тийм. Тэгж бичсэн номын хуудсуудын мөрүүд Баттөмөрийн нүдний өмнүүр жирэлзэн үзэгдэж байлаа. “Алиалагч хүүхэд хийж байгаа байх нь. Яг зургаан настай хүүхэд хийж байна”. Одоо харин боллоо, хангалттай, ухаан орох хэрэгтэй, босох хэрэгтэй. Тэгээд хараал идсэн алиалагчийг зогсооё. Би бол сонгогдсон хүн. Өөдгүй новшийг энэ ертөнцөд үр үндсээ тарихаас өмнө ирсэн газар луу нь тонилгох хэрэгтэй. Баттөмөрийн бодол хэдий цаашаа үргэлжилж олон юмны хойноос нэхэх байсан хэдий ч тэрээр өөрөө өөртөө ийнхүү хэлээд нүдээ нээлээ. Баттөмөрийн биеэр эргэлдэх цус эрч хүчээр оволзон, өглөө сэрсэн хүн шиг цовоо сэргэлэн, юу ч хийхэд бэлэн байдалтай болсон байлаа. Тэрээр өөртөө асар их хүч хуралдаж алиалагчтай тулахад бэлтгэгдэж байгаагаа ойлгож байв. Гэтэл энэ үед шатаар бүрэн зэвсэглэсэн өч төчнөөн тусгай ангийнхан түүний хажуугаар гүйлдэн өгслөө. Баттөмөр тэдэнтэй зэрэгцэн гурван давхарт гарсан хэдий ч хүчтэй хана мөргөлтөөс болж нас барсан хөөрхий бүсгүйн цогцос, ухаан алдсан сувилагч хоёроос өөр юу ч байсангүй. Ганбаяр ч алга, алиалагч ч алга. Тэд хааччихав аа. Харин Ганбаярын гар буу чулуун шалан дээр хэвтэж байгааг хараад Баттөмөр хурдхан авч халааслахад хэн ч анзаарсангүй. Алиалагч шатаар буулгүй хаашаа гараад зугтсан байх билээ. Үгүй ээ, зугтах гэдэг үг алиалагчид зохихгүй. Тэр зүгээр л явчихсан. Түүнд зугтах шалтгаан байхгүй, яагаад гэвэл тэр үхэшгүй ороолон болохоор тэр. Өнөө өглөө зургаан давхраас үсрээд алга болчихсон юм чинь одоо гурван

давхраас үсрээд буух шиг амархан юм түүнд байхгүй нь лавтай. Нарийн хонгилийн том цонх хагарчээ. Түүгээр доошоо тонгойж харахад гудамжны сүүмгэр гэрэлд ганц нэгхэн шилний хагархай л гялтганан харагдаж байлаа. Уг нь Баттөмөр эндээс Ганбаярын цогцсыг олж харж мэднэ гэж айж байжээ. Азаар харин тийм биш байх бөгөөд алиалагч найзыг нь ямар нэгэн зүйлд ашиглахаар авч явжээ гэдгийг ойлголоо.

Тусгай ангийн ахлагч Базар гэх намхан нуруутай хэрнээ хүдэр чийрэг залуу Баттөмөрийн хажууд ирж мэндэллээ. Тэрээр Баттөмөрийг таньдаг бөгөөд Ганбаяртай хамт олон янзын хэрэг дээр хамтран ажиллаж байсан танил нь билээ. Баттөмөр ч хариу мэндлээд “Өнөөх новшийн алиалагч чинь жаахан хүүг манай найзтай хамт л аваад явчих шиг боллоо” гэж хэллээ.

- Тийм гэж үү. Надад дээрээс хотыг тэр чигт нь айдаст авгуулаад байгаа алиалагчийг яаралтай барь гэж тушаасан. Түүнийг нэн даруй барих хэрэгтэй байна. Анх алиалагч сэжиглэгдсэн гурван хүүгийн үхлээс хойш хүмүүс ор сураггүй алга болох нь ихэссэн. Ганцхан сарын дотор бараг тавин хүн ор сураггүй алга боллоо. Тэд бүгд л ажил амьдралтай, идэвхтэй залуухан хүмүүс байсан. Заримынх нь алга болсон шалтгааныг бас алиалагчтай холбон тайлбарлаж байгаа ч ямар ч сэжүүр олдохгүй байна. Бүр ердөө ганцхан сарын дотор ийм их хүн алга болж байсан тохиолдол манай хотод байхгүй. Баттөмөр өө, би чамайг сайн мэднэ. Чиний илрүүлж байсан олон хэргүүдийн тухай сонсож, материалуудтай нь ч танилцаж байсан. Чи ердөө ганцаараа л бүхэл бүтэн цагдаагийн байгууллагаас илүү үр дүнтэй ажилладаг. Тиймээс надад туслаач. Би чамтай хамтармаар байна.

- Ганбаярт аюул тулгараад байна. Би шаардлага гармагц чамайг дуудъя. Утас чинь хэд билээ?

- Базараа түүнд нэрийн хуудас сарвайв. Баттөмөр ч түүнийг нь авч халааслаад яаран гарч одлоо. Түүний араас “Миний утас үргэлж нээлттэй байх болно шүү” гэсэн Базараагийн баргил хоолой нарийн хонгилоор нэг цуурайтан хоцорлоо.

Баттөмөр хамгийн сүүлд Ганбаярын машины түлхүүрийг өмднийхөө халаасанд хийсэндээ маш их олзуурхаж байлаа. Одоо хотын зүүн зэх руу явах хэрэгтэй. Алиалагч тэр зүгт явсныг яагаад ч юм бэ маш сайн мэдэрч байна. Баттөмөр машиныхаа хаазыг нэмэн хурдалсаар офицеруудын ордон өнгөрч хотын замын хамгийн ачаалалтай хэсгийн ардаа орхилоо. Хэрвээ Ганбаярыг алдчихаад очвол Тамирааг зүгээр л амьдаар нь булшиллаа гэсэн үг. Тиймээс найзыгаа заавал аварч гэрт нь эсэн мэнд хариулах болно хэмээн Баттөмөр өөртөө тушаалаа. Хараал идмэр, дахиад л замын түгжрэл. Тролейбусны эцэс буюу ботаникийн энэ зам дээр ингэтлээ түгжрэл үүсч байсныг Баттөмөр санахгүй байв. Тэр урд л хоёр машин хоорондоо мөргөлдсөн бололтой. Олон машинуудын сигнал чих дөжиртөл үргэлжлэн дугарч, Баттөмөр өөрийн эрхгүй тэсвэр алдан бухимдаж хараалын үг урсган рулиэ цохиж байлаа. Улаанбаатар хотын энэ хавчиг замуудыг чөтгөр аваасай билээ. Новш, өөдгүй муу ороолон. Энэ бүгд чиний хийж байгаа ажил биз дээ. Би чамайг удахгүй зүйл дуусгах болно оо. Чи энэ удаад хаашаа ч зайлж чадахгүй. Түгжрээ арилахгүй хэвээр, цагдаа ч ирэхгүй байсаар Баттөмөр яахаа мэдэхгүй хориод минутыг өнгөрөөв. Гэхдээ энэ хугацааг Баттөмөр зүгээр өнгөрөөсөнгүй. Оюун ухаанаа хөвчлөн байж дахин өнгөрсөн үеийн өөрт нь ирсэн өнөөх номын талаар бодов. Тэрээр нүдээ анин бодол болж уг номыг уншиж байлаа.

Энэхүү буг чөтгөрийн хүн төрөлхтнийг үгүй хийх гэсэн тэмцэл олон зууныг дараалан үргэлжилсээр байгаа аж. Дракулаагаас үүдэлтэй вампирууд бол ердөө л энэхүү буг чөтгөрийн үлдээсэн үр үндсийн өчүүхэн хэсэг. 1400 онд дэлхийд ирсэн өөдгүй чөтгөрийн үр үндсийн тарьж амжсан гайн нэг хэсэг хүмүүсийн дунд орших цус сорогчид, хүн чононууд болон хувирсан. Хэдий буг чөтгөрийг түүний хүүхэдтэй нь хамт устгаж чадсан ч жаахан цаг алдсанаас болоод л цус сорогчид анх бий болсон. Тэр амилсан чөтгөр агаараар амьсгалдаггүй, түүнд амьсгалах шаардлага гэж байхгүй. Ганцхан шаардлагатай зүйл нь хүний цус. Тэр үргэлж цусаар цангаж, бусдын цусыг ховх сорж байдаг. Хүмүүсийн эсэргүүцлийг сулруулж хямраахын тулд хүмүүсийг хооронд нь алалцуулж, зарим нэгнийг нь цус сорогч, эсвэл явдаг үхдэлүүд болгон хувиргадаг. Тэрээр басхүү тоймгүй хүчтэй. Эрт цагийн баатрууд түүний цээжийг жадаар нэвт зоож, сэлмээр сийчиж, биеийнх нь бүх хэсгүүдэд нум сумаар харваж байхад тэр үрээгүй. Түүний үйлдлийг зогсоож устгахын тулд олон залуучууд амиа зольсоор иржээ. Тэр зөвхөн хүүхдээ хийгээд амжсан тохиолдолд бүх эрх чөлөөг олж авна. Учир нь тэрээр үхсэнийхээ дараа өөрийнхөө бүтээсэн хүүхдийн биед эрх чөлөөтэйгөөр нэвтрэх эрхтэй. Тэр цагт тэр хэзээ ч үхэхгүй, хэзээ ч хүч чадал нь сулрахгүй. Тиймээс түүний үр үндсийг ертөнцөд бүү гишгүүлэгтүн. Ороолон өөрийн үр үндсээ үлдээхээс нааш хэзээ ч амсхийхгүй учраас түүнийг ч гэсэн нэн даруй устга. Тэр бол хүн биш, түүнд хүнийхтэй ижилхэн эд эрхтэн гэж байхгүй. Тиймээс түүнийг хорооно гэдэг бүтэшгүй. Харин гагцхүү айдаг зүйлээр нь устгах хэрэгтэй. Тэр айдаг зүйл бол... Баттөмөрийн сууж буй машины араас нэгэн жийп ирж зөөлөн мөргөснөөр түүний бодлыг тасалдуулжээ. Замын түгжрээ ч арилжээ. Баттөмөр толиндоо харахад арын машины жолооч “ Бүх юм зүгээр, юу ч эвдрээгүй, уучлаарай” хэмээн яаран хэллээ. Баттөмөр хаазаа огцом гишгэн урагшаа замаа даган хурдлав. Новшийн алиалагч Улиастайн хуучин Орос цэргийн эзэнгүй орхигдсон аль нэг хуаранд л орогнож байна. Тэнд очиж түүнийг үгүй хийх хэрэгтэй. Тиймээ, тэр муу ороолон яг л тэнд нуугдаж байгааг би мэдэрч байна.

Баттөмөр өөрөө өөртэйгөө ийн ярилцаж явлаа. Гэхдээ тэрээр сэтгэлийнхээ мухарт алиалагч тэнд байхгүй ч байж мэднэ хэмээн айж байв. Хүн дуудах уу, хэрэггүй ээ. Бас дахиад л Ганбаярт тохиолдсон шиг зүйл давтагдах болно. Баттөмөр өөртөө ийн хэлсэн ч дөнгөж хажууханд нь харагдаж байгаа одоо бараг балгас болчихоод байгаа хав харанхуй хуучин цэргийн хуаранд ганцаараа орно гэхээс өөрийн эрхгүй жихүүцэн дөлж байлаа. Хэрвээ цагдаа дуудвал бөөн сүр болж ирээд алиалагчийг амархан үргээчихнэ. Эсвэл тэр алиалагч энд байхгүй бол зүгээр л би өөрөө эвгүй байдалд орох болно. Баттөмөр энэ удаад өөртөө тийм итгэлтэй биш байх аж. Түүний далдыг харах зөн совин алиалагчийн өмнө хүчин мөхөстөж байгаа бололтой, юуг ч оновчтой тааварлан зөгнөж чадахгүй байв.

“ Аа, нээрэн тийм. Базарааг дуудах хэрэгтэй. Тэр надтай хамтрахыг хүсч байна” гэж хэлсэн шүү дээ. Баттөмөр Базараа руу гар утаснаасаа залгаж хобогдоод өөрийнхөө байгаа газрыг хэлэв. Базараа ч уухайн тас зөвшөөрч хар хурдаараа яваад очье гэж хэлээд утсаа салгалаа. Баттөмөрийн хоолой хатаж маш ихээр цангаж байв. Энэ нь магадгүй харанхуй балгас руу алиалагчтай тулахаар ганцаархнаа орох гэж байгаагаас нь болсон биз. Тэрээр машины суудлын араас гурван ширхэг савтай цэвэр ус аваад хоёрийг нь халаасалж, нэгийг нь задлан ухаан жолоогүй залгиллаа.

Баттөмөр машинаасаа буун, гар буугаа өмднийхөө баруун хадаасанд хийж, гартаа гар чийдэн

атгаад балгас болсон харанхуй хоосон байшин руу дөхлөө. Зуны оройн сэвэлзүүр салхи Баттөмөрийн хацрыг таалж сэтгэлд нь хургаад байгаа айдсыг бага ч атугай үргээх гэсэн мэт аашлах аж. Энэхүү цэргийн хуаран байсан балгасаас нэлээд зайдуухан айлууд хашаа барин суурьшжээ. Тэдгээр айлуудын байшингийн цонхны цаанаас ёлтойх бүдэгхэн гэрлүүд энэ холоос дөнгөн данган харагдаж байв. Басхүү хаа нэгтээ нохой хуцах нь энэ ертөнц одоохондоо хараахан алиалагчийн гарт орчихоогүй байна гэж хэлэх гэсэн мэт нэг л дотно, сэтгэлд хүч нэмэхүйц сонсогдож байлаа.

Бурхан минь би ер нь юу хийж байна аа. Би энэ алиалагчтай тулсан шүү дээ. Түүнийг ялагдашгүй болохыг нь мэднэ. Надад энд Ганбаярын гар буунаас өөр ямар ч хань алга. Алиалагчийг буугаар буудах нь зүгээр л түүнийг гижигдсэнээс өөрцгүй. Тийм байтал би одоо яах гэж байгаа юм бэ? Баттөмөр өөрөө өөрөөсөө ийн асуугаад бүр айж орхив. Сарны гэрэлд ямар ч цонхгүй чимээ аниргүй балгас дүнхийн харагдах нь Баттөмөрийг дуэльд дуудах мэт. Тэрээр урагшаа алхаж байснаа доороо зогтуслаа. Гэсэн ч түүний сэтгэлийн аль нэг орон зайнаас байшинд хурдхан орохыг тушаагаад байх шиг. БАЙШИНД ОРОХ ХЭРЭГТЭЙ...

Алиалагч энэ байшинд байгаа гэдэгт Баттөмөр одоо бүрэн итгэж эхэллээ. Түүнд бараг л алиалагчийн үнэр үнэртэх шиг болж энэ хоосон балгасан дунд хүүхдээ хийгээд завгүй байгаа дүр зураг нүдэнд нь үзэгдэх шиг болов. Юундаа айсан юм бэ, хурдхан шиг дотогшоо орж нэгийгээ үзэх хэрэгтэй биш үү. Ингэж хулчийх шаардлага байхгүй. Алиалагчийн үйлдлийг таслан зогсоох цаг бараг байхгүй болж байна. Гүйцээ! Өөр олон юм бодох хэрэггүй, зүгээр л дотогшоо яваад ор. Тэгээд аяндаа учир нь олдоно.

## Дөрөв

Чимээ аниргүй нам жим байлаа. Шарилжны үнэр ханхийж хаяа нэг салхи сэвэлзэнэ. Баттөмөр харанхуй байшин руу явж орлоо. Нүдэнд юу ч үл үзэгдэх учир Баттөмөр машинаас буухдаа урьдаас зэхсэн гар чийдэнгээ асааж өмнөх замаа гэрэлтүүлэв. Хог новш хаа сайгүй хөглөрсөн байх бөгөөд хөгц, чийгний эхүүн үнэр ханхалж эхэллээ. Баттөмөр зүүн гартаа гар чийдэн атгаж, баруун гараараа буугаа шагайсаар дотогшоо аажимхан гэтэв. Тэрээр аль болох чимээ гарахгүйг хичээн, байшингийн дотогшоо үргэлжилсэн нарийн хонгилоор алгуурхан хянуур алхаж байснаа эргэж харахад түүний орж ирсэн хаалга харанхуйн дундаас арай ядан ялгаран харагдаж байв. Баттөмөр энэ хаалгаар эргэж гарч чадах эсэхдээ эргэлзэж байлаа. Учир нь, тэрээр хүн төрөлхтнийг заналхийлж байгаа аймшгийг яаж устгах аргаа ч мэдэхгүй яваа. Ямар нэгэн борооны үүл сарыг халхлаад ингэж харанхуй болж байгаа юм байлгүй дээ гэж Баттөмөр дотроо бодсон ч энэхүү ямар ч гэрэлгүй харанхуй байдал түүнд өөрийн эрхгүй айдас төрүүлэн, өнгөрөн одсон амьдралынх нь харанхуйн дунд өнгөрүүлсэн аймшигт хормыг нь сануулж байв. Энэ мөчид Баттөмөр эргээд л аравхан настай жаахан хүү болоод хувирчээ гэлтэй хамаг бие нь чичрэн салганаж, нүүрээр нь хүйтэн хөлс дааварлаж байлаа. Тэрээр өөрийгөө яг л авсан дотор байгаа мэтээр төсөөлж байв. Өөрийг нь хүмүүс үхсэн гэж санаад авсанд хийгээд газар булчихсаны дараа гэнэт сэтсэн юм шиг тийм мэдрэмж түүний бүх биеийг эзэмдэж, бүр эрүүл ухаанаа гээхэд хүргэж байлаа. Хүмүүс өөрийг нь амьд гэдгийг мэдэхгүй, өөрсдөөсөө тусгаарлан газар булж орхиод уишим ч үгүй яваад өгсөн яг тийм мэдрэмж. Тиймээ, Баттөмөр энэ айдсыг маш сайн мэднэ. Дээр үед эмээгээ өнгөрсний дараа тэрээр “ Үхсэнийхээ дараа гэнэт сэрж хүмүүсээс тусгаарлагдсанаа мэдэх” тэр айдсыг

сэтгэлээрээ мэдэрсэн. Эмээ нь нас барсан тэр өдрийн ердөө л маргааш нь төрөл төрөгсөд, найз нөхөд нь эмээг нь нутаглуулсан. Харин Баттөмөрийн хувьд эмээгээ үхсэн гэдэгт эргэлзэж байсан ч үүнийгээ бусдад хэлээгүй. Өмнө нь нэг удаа ээжийнхээ үхлийн тухай зөгнөснөө аавдаа хэлээд байдлыг бүр ч дордуулж байсан учраас тэр удаад амаа хамхихаар шийдсэн. Мэдээж магадгүй тэр нь зөв байсан байх. Эмнэлгээс үхсэн гээд тогтоочихсон цогцосыг амьд гэж зүтгэх нь хэнд таалагдах билээ. Баттөмөр оршуулах ажлыг чимээгүйхэн өнгөрөөхөөр шийдсэн юм. Эмээгийнх нь оршуулга ч хурдан цомхон болж “Далан давхар” хэмээх оршуулгын газар нутаглуулахад нь Баттөмөр эмээгийнхээ шарилд хүрэх хүрэх газрыг өөрийн мэдэлгүй маш сайн тогтоож авч билээ. Тэр үед Баттөмөр арван таван нас хүрч байсан. Түүний сэтгэл эмээгээ нутаглуулаад буцаж байхад маш ихээр үймрэн сандарч, өөрийн мэдэлгүй “Эмээ маань үхээгүй байна” гэж хэд хэдэн удаа чарласан ч оршуулгын ажилд оролцсон хүмүүс түүнийг эмээгээсээ хагацсандаа уймарч байна гэж үзээд зүгээр л аргадан тайвшруулах гэж оролдсон. Ингэсэн ч нэмэргүй Баттөмөр цамнаж хашхичаад болсонгүйд оршуулгын ажилд оролцогчид арга буюу түүний аманд алчуур чихэн байж дуугүй болгосон. Тэгээд Баттөмөр гараа ардаа хүлүүлээд амандаа алчуур чихүүлж, хоёр хүн түүнийг дундаа суулгаад тэвэрчихсэн болохоор яаж ч чадалгүй дэмий л уйлж байлаа. Хүмүүс түүнийг аргадан тайвшруулахыг оролдож байсан ч Баттөмөрийн нүдэнд эмээгийнх нь авсан дотроо хөдөлж амь орж байгаа нь бодитой юм шиг харагдсаар л байсан.

Ингэсээр эцэст нь Баттөмөр жаахан ч гэсэн тайвширч хүмүүс түүний хүлээсийг тайлж аманд нь чихсэн алчуурыг авсан. Тэгэхэд өөрийгөө золтой л галзуугийн эмнэлэг рүү ачигдчихаагүйдээ Баттөмөр хожим баярлах болсон доо. Тэр үед Баттөмөр эмээтэйгээ хоёулхнаа амьдардаг байсан болохоор анх удаа шөнийг гацаараа өнгөрүүлэх цаг мөч тулж ирсэн. Хүмүүс гэрээс нь уван цуван явсаар оройн 23 цаг гэхэд Баттөмөр гэртээ орь ганцаархнаа өмнө нь зул асаасан эмээгийнхээ хөрөгнөөс өөр ханьгүй хоцорч билээ.

Үхэгсдийн хотоос өөрийг нь дуудах эмээгийнх нь дуу түүнд огтхон ч амар заяа үзүүлсэнгүй. Түүнийг гэртээ ганцаараа үлдсэнээс хойш эмээгийнх нь аврал эрэн дуудах мэт энэ дохио улам хүчтэйгээр ирж байлаа. Амьгүй болсон цогцос авсан дотроо гэнэт сэрээд гарахыг хүсч байна. Агаар муутай, харанхуй, давчуу жижигхэн модон хайрцган дотор гэнэт сэрсэн эмээ нь өөрийгөө үхээгүйдээ маш ихээр харамсаж, хамаг хүчээрээ тийчилж байгаа нь Баттөмөрийн нүдэнд үзэгдэж маш ихээр зовоосоор байсан. Түүний хувьд хамгийн аймшигтай нь тэр давчуу бие барьсан харанхуй авсан дотор эмээ нь нэг мөсөн амиа хорлох боломж ч байхгүй гэдгийг төсөөлсөн төсөөлөл байсан. Тиймээ, энэ төсөөллөөсөө болоод Баттөмөр эгээтэй л солиорчихоогүй. Өөрийгөө дэмий юм бодож байна, эмээгээ үнэхээр үхсэн хэмээн өөртөө дахин дахин хэлж байсан ч эцэстээ ийм байдлаар өөрийгөө тайвшруулах ямар ч боломжгүй гэдгээ ойлгосон. Тэгээд л шийдсэн. Цаг алдалгүй түргэн очиж эмээгийнхээ амийг аврахаар шийдсэн. Магадгүй өөрийнх нь зөгнөл төсөөлөл буруу байж гэмээнэ түүнийгээ батлахаас нааш санаа нь амрахгүй нь гэдгээ ойлгосон.

Ийнхүү Баттөмөр ганцаараа яасхийж тайван хонох билээ гэж бодохын оронд зүгээр л хүрз, жоотуу, гар чийдэн зэргийг шуудайд хийгээд оршуулганд оролцсон хүмүүсийн буяны мөнгийг бүгдийг нь авч өмднийхөө арын халаасанд чихээд гарч одсон. Шууд л үүдэн дээрээсээ такси барьж “Далан давхар газрын наана очно” гэхэд жолооч эр нэг гайхаж харснаа олон юм шалгаалгүй хөдөлж билээ. Шуудайтай юм үүрээд энэ харанхуй болсон хойно оршуулгын

газрын наана очиж яах нь вэ, хүү минь? гэж жолооч эрийг асуухад Баттөмөр эмээгээ аврах гэж байгаа юм л гэж хэлсэн. Өөр юу ч хэлээгүй. Харин үүнийх нь хариуд хижээлдүү насны жолооч эр түүн рүү солиотой хүн рүү харж байгаа юм шиг тийм нүдээр эргэж хараад өөр юм асуулгүй чимээгүй болж билээ. Тэгээд л машины моторын намуухан жигд хүнгэнэх дуунаас өөр чимээ гаралгүй явсаар Далан давхрын наахна хүрч ирсэн. Хэдий Баттөмөр оршуулгын газар луу дотогшоо орохыг хүссэн ч бүтээгүй.

Машины жолооч оршуулгын газрын гүн рүү орохоос сэжиглэн жийрхэж, Баттөмөрийг наана айлуудын захад буулган, мөнгөө аваад арилж өгсөн дөө. Ингээд л Баттөмөр шуудайд хийсэн хүрз, жоотуугаа үүрэн гар чийдэнгээ тусгаж өглөөхөн оршуулсан эмээгийнхээ булшийг ухахаар яаравчлан алхаж билээ. Тэгэхэд түүний урдуур хойгуур янз бүрийн амьтан сүүтгэнэн гүйх шиг болж, булшны цагаан чулуу сарны гэрэлд цайран харагдаж байв. Баттөмөр айснаасаа болоод уйлж байсан ч түүнд буцаж зугтах эрх байсангүй. Учир нь, эмээ нь түүнээс аврал эрэн авсан дотроо амь тэмцэн тийчилж байгаа тийм дүр зураг түүний нүдэнд тасралтгүйгээр үзэгдэн зовоож, ганц хором ч тайван байлгахгүй байсан билээ. Баттөмөр бүдэг бадаг харагдах уулын толгойгоор баримжаалж, гар чийдэнгээр өмнөх замаа гэрэлтүүлэн эмээгийнхээ булшийг хайн гүйж явахад гэнэт хэн нэгэн түүний баруун шилбэнээс хүйтэн гараараа атгаад авсан. Баттөмөр айсандаа дуу алдан салгалж, эргэж ч харалгүй урагшаа зүтгэн зугтах гэсэн хэдий ч хөл нь тушаатай юм шиг хөдлөөгүй. Айсандаа арай л ухаан алдчихаагүй жаахан хүү арга буюу арагшаа хяламхийн харахад түүний нүдэнд юм үзэгдээгүй. Тэгтэл харин хөлийг нь барьж байсан хэн нэгэн гараа / эсвэл өөр юу ч байсан байж мэднэ/ тавьж Баттөмөрийг чөлөөлсөн. Гэсэн хэдий ч түүний баруун хөл нь тушаатай юм шиг урагшаа гишгэж чадахгүй болсон. Ямар нэгэн юманд тээглэн орооцолдоод, өөрийн биш хүний хөл юм шиг л аашилж эхэлсэн нь тэр. Тэр үед Баттөмөр яаж ч хичээсэн баруун хөлөө огтхон ч удирдаж чадахгүй байсан. Түүнийг замдаа саатах болгонд эмээ нь яаруулж, харанхуй авсан дотроо амь тэмцэн амьдрал гуйж байгаа нь мэдрэгдэж байлаа. Баттөмөр бараг нэг цагийн туршид эмээгийнхээ шарилыг унаж тусаж, мунгинан хайсаар арайхийн олж билээ.

Тэгээд хавь орчноо болгоомжилсон нүдээр харсан ч эргэн тойрон ярайн харагдах үхэгсдийн нэр сийлсэн чулуун хөшөөнүүдээс өөр юу ч харагдсангүй. Тэр нас барагсдын нэрийг сийлсэн хүйтэн чулуунууд яг л амьд хүмүүс нас барсан хүнээ чимээгүхэн гашуудан хардагтай адилаар ямар ч чимээ гаргалгүй цоо ширтэх мэт. Чухам энэ үед л тэрээр өөрийнхөө хөлийг удирдахтайгаа болсон юм. Ингээд Баттөмөр шууд л “амьдаараа булагдсан” эмээгийнхээ шаилыг ухаж гаргах ажилд шамдан орсон. Арван тавхан настай жаахан хүү шарилыг нээхээр хамаг хүчээ шавхан жоотуугаар шинэхэн цементэлсэн булшийг балбаж гарах нь тэр. Гартаа атгасан жоотуугаа ч олигтойхон өргөчихөж чадахгүй жаахан хүүд энэ нь үнэндээ л ахадсан ажил байв. Гэсэн хэдий ч Баттөмөр бууж өгөөгүй юм. Хамаг айдас түгшүүр, ядарч туйлдсан байдлаа умартан хамаг хүчээ шавхан балбасаар байлаа. Ийнхүү бараг хоёр цаг хэрээтэй хамаг хүчээ шавхан ноцолдсоны эцэст өглөөхөн цутгасан цемент цөмрөн нээгдэж доороо байгаа модон хайрцган дээр чулууны үйрмэгүүд нүжигнан унаж билээ. Тэгэхэд Баттөмөр авсны дээрээс ээжийг нь оршуулсантай адилаар шороо асгаагүйд маш ихээр олзуурхаж байсан. Хэрвээ авсны дээрээс шороогоор давхар булчихсан байсан бол Баттөмөр авсыг нээх гэсээр бараг өглөө болгочих байсан биз. Тэгэхэд намрын улирал байсан болохоор шөнийн жиндүү салхи хайр найргүй довтолж байв. Баттөмөр цементийг бараг юу ч үгүй үйрүүлэн нураажээ.



Тэгээд зөвхөн доошоо орж авсны тагийг нээх л үлдэв. Яг энэ үед Баттөмөрт нэгэн аймшигт бодол төрсөн нь өнөөг хэр нь түүний санаанд үе үе орж ирсээр байдаг юм. Тэр бол эмээгийнх нь авс өөрийнх нь төсөөлж байсан, магадгүй өглөө харснаас хэтэрхий жижиг бариу байсан явдал бөгөөд хэрвээ энэ авсан дотор эмээ нь ухаан орсон байж гэмээнэ биеийнхээ чилээг гаргаад хөдөлчих ч боломж байхгүй юм даа гэсэн бодол. Хэсэг хугацаанд амьсгалж болох өчүүхэн жаахан агаарын хувьд бүр ч ярих юмгүй. Товчхондоо бол Баттөмөр булшны цементийг цөмлөсний дараа энэ жижигхэн авсанд хүн тийм ч удаан тэсэхгүй юм байна даа гэж бодсон нь өөрийн эрхгүй ухаан балартгал айхад хүргэж байсан юм. Гэхдээ энэ бодол нь Баттөмөрийг хоёр дахин илүү хурдан хөдлөхөд хүргэсэн. **ТЭСЭЭРЭЙ ЭМЭЭ МИНЬ!!!**

Тэрээр булшны хавчиг нүх рүү үсрэн орж авсны таган дээр түг хийтэл буув. Баттөмөр эхлээд авсыг нээхийн тулд дээр нь овоолорсон том том цементийн хэлтэрхийнүүдийг гадагш нь шидлэх хэрэгтэй болж билээ. Тэр шөнө маш хүйтэн, салхи сэвэлзэн үлээж байсан ч хүнд хүчир ажлаасаа болоод Баттөмөрийн хар хөлс нь цутгаж байсан юм. Тэрээр цементийн хэлтэрхийнүүдийг нүхний амсар давуулан шидэлж байхдаа айж сандарснаасаа болоод хамаг бие нь салганан чичирч, нулимс нь урсаж байсан. Уг нь бүхний мартаад буцаад гүймээр байсан ч ямар нэгэн далдын хүч түүнийг уг авсны тагийг нээлгэхийн тулд байгаа газар нь уяж байлаа. Удахгүй авсны тагийг нээнэ. Тэгээд чухам юу олж харах бол?

Энэ асуултыг Баттөмөр өөрөөсөө тасралтгүй асууж хариуг нь төсөөлснөөсөө болоод маш ихээр айж байсан хэдий ч хамаг хурдаараа идэвхийлэн хөдөлсөөр. **ЭМЭЭ ЭНЭ ХАРААЛ ИДСЭН АВСАН ДОТОР АМЬД БАЙГАА, ТҮҮНИЙГ АВРАХ ХЭРЭГТЭЙ.**

Баттөмөр эцсийн эцэст өөрийгөө зоригжуулахын тулд ийнхүү чанга хашхиран хэлж билээ. Харин хариуд нь хаа нэгтэйгээс хэн нэгэн шулмын хоолойгоор тачигнатал инээсэн. Гэтэл түүнд бас нэгэн саад учирсан.

Ээ, чааваас гэж. Авсны тагийг хэн нэгэн монгол цоожоор цоожилчихсон байх нь тэр. Ямар үхснээ хийж, хийх юмаа олж ядсан новш нь үүнийг түгжчихээ вэ? Яах гэж ингэв? Эмээг үхснийхээ дараа авснаасаа гараад ирчихэж магадгүй гэж болгоомжилсондоо ингээд цүүцээр дараад цоожилчихсон нь энэ үү? Эсвэл эмээ үхэхээсээ өмнө аягүй бол намайг шарилыг нь ухааж мэднэ гэж айгаад хэн нэгэнд миний авсны тагийг цоожлоорой гэж захисан хэрэг үү?

За үгүй дээ. Дэмий юм бодохоо больж үз. Зүгээр л энэ цоожийг хурдхан шиг эвдэх хэрэгтэй. Ядаж байхад хэн нэгнийх нь санаачилгаар мөнгө хэмнэж, эмээгээс өөрөөс нь ч богинохон авс хийчихэж.

Тиймээ арван тавхан настай Баттөмөр тэр үед өөртөө ингэж хэлээд хүрзээрээ монгол цоожийг хэд хэдэн удаа балбаад мулталж чадсан. Яг тэр үед бороо цутган тэнгэр дугарч билээ. Газар сайгүй бороо цутган орж, их усны шаагих чимээ чихнээ тодхон сонсогдож байсан. Тэр үед Баттөмөрийг булшнаас гарч ирэхийг нь хүлээн өч төчнөөн муу ёрын сүнснүүд ухсан нүхний ирмэг дээгүүр шавааралдан суучихсан байгаа нь арван тавтай хүүд мэдрэгдэж байсан даа. Хэрвээ эмээ үнэхээр үхчихсэн тэгээд амилаагүй бол би яах билээ? Миний хийсэн энэ бүх үйлдлүүд юу болж таарах вэ? Тэгвэл би зүгээр л галзуу хүн болж таарна.

Угаасаа би галзуу ч байж магадгүй. Тухайн үедээ Баттөмөр ийнхүү эргэлзэж байсан ч эцсийн эцэст авсны тагийг нээсэн. Тэгээд тэр олж харсан. Тиймээ, эмээгийнхээ амьгүй хэрнээ атираад хөдөлчихсөн, хамгийн сүүлд харснаас өөр байрлалтай болж, аниатай байсан нүд нь нээгдсэн цогцсыг олж харсан. Эмээгийнх нь тэр амьгүй нүдэнд маш их зовлон шаналал, айдас хургачихсан байсныг Баттөмөр гар чийдэнгээ тусган байж олж харсан. Тэр айсандаа эсвэл эмээгээ аварч чадалгүй хоцорсондоо харамссан уу, ямартай ч уйлж байсан бөгөөд түүнээс үүдэн гар чийдэнгийнх нь тусгал тогтохгүй чичирхийлэн хөдөлж байсан нь санагддаг. Ингээд л эмээ нь авсанд түгжигдсэнийхээ дараа ухаан оржээ гэдэг нь ойлгомжтой болсон. Авсанд хийсэн цогцсыг ухсан нүх рүү хийхэд ингэж хөдөлнө гэж байхгүй. Хөдлөх хөдлөхдөө бүр гараа нугалаад, хөлөө атираад, хүзүүгээ гилжийлгэчихсэн байх нь яавч энгийн нэг тохиолдол биш байлтай. Басхүү үүгээр ч тогтохгүй эмээгийнх нь авсанд ухаан орсны хөдлөшгүй баталгаа Баттөмөрийн нүдэнд туссан нь авсны тагны дотор талд үүссэн хэн нэгэн самардсаны шинэхэн ул мөр байсан явдал. Хэн нэгний ч гэж дээ, мэдээж эмээгийнх нь гэдэг нь лавгай. Баттөмөр өөрийгөө зоригжуулан байж, арайхийн эмээгийнхээ хуруунд гар чийдэнгийнхээ гэрлийш тусгаж хараад ихэнх хуруу нь шалбараад цус шүүрээд хатчихсан байхыг олж харсан. Энэ нь мэдээж авснаас гарах гэж амь тэмцэн самардсаны ул мөр, гашуун үнэний үлдэгдэл.

Баттөмөр өнгөрөн одсон аймшигт явдлынхаа манан дундаас арайхийн бодит байдалдаа эргэн ирлээ. Гэхдээ тэрээр яагаад энэхүү санахыг ч хүсдэггүй өнгөрсөн рүү оюун ухаан нь хөврөн одсоныг удалгүй ойлгов.

Авсны тагийг нээхэд сэнхийж байсан тэр өмхий эхүүн үнэр. Яг тэрхүү дотор муухай оргим таагүй үнэр одоо үнэртэж байна. Баттөмөрийн алиалагчийг хайн алгуурхан алхаж байгаа энэ балгаснаас яг тэр үхдэлийн гэмээр үнэр үнэртэж байх нь тэр. Энэ үед Баттөмөрийн толгойд энд үхдэлүүд байгаа байх нь ээ гэсэн бодол зурсхийн орж ирлээ. Гэтэл түүний энэ бодолтой зэрэгцэн өмнүүр нь нэгэн сүүдийсэн хар дүрс ухасхийн өнгөрлөө. Энэ юу байсан бэ? Уг сүүдэр өөрийнх нь өмнүүр өнгөрөхөд үхдэлийн үнэр улам хурцаар үнэртэв. Үхдэл амилчихсан нь энэ үү? Баттөмөр өөрөө өөрөөсөө ингэж асуугаад гар чийдэнгийнхээ гэрлийг хэдэн тийш нь маш хурдтайгаар тусган хараад юу ч олсонгүй. Бас тэрээр яагаад ч юм эмээ гэж дуудмаар болсон ч амаа хамхилаа. Гар чийдэнгийнхээ гэрлийг тусгах зүгтээ буугаа давхар онилж өөрт нь заналхийлэх аюулыг хүлээн биеэ бэлтгэж байсан ч түүн рүү хэн ч довтолсонгүй. Баттөмөр урагшаа хэд алхаад урд өмнө нь тусдаа өрөө байсан бололтой хаалга нь алга болсон нарийн аркаар явж орлоо. Энд өнөөх үнэр бүр хурцаар үнэртэж байна. Яг л өмхийрсөн махыг давслаад шарж байгаа мэт тийм үнэр. Баттөмөр гар чийдэнгээр өмнөх замаа гэрэлтүүлсээр урагшаа дахин хэд алхтал түүний араар хэн нэгэн өмхий үнэрээ ханхлуулсаар шуртхийн өнгөрөв. Эргэж хараад гэрэл тусгасан ч бас л хэн ч алга. Гар чийдэнгийн энэхүү өчүүхэн жаахан гэрэл энэ том харанхуй байшинг гэрэлтүүлэхэд дэндүү хангалтгүй байлаа. Энэхүү том харанхуй байшин гар чийдэнгийн жаахан гэрэл хоёр яг л өнөөх сагсан бөмбөг шар будаа хоёрыг харьцуулсан тэр харьцааг санагдуулж байх нь тэр. Баттөмөр өөрийн эрхгүй дагжин чичирч эхэллээ. Урдуур хойгуур сүүтэгнээд байгаа энэ өмхий амьтан ганцаараа биш байх нь. Энэ амьтан алиалагч биш, гэхдээ тийм байлаа гээд ямартай ч сайн сайхан амьтан биш гэдэг нь ойлгомжтой. Баттөмөр чийдэнгээ дахин урагш нь тусгалаа. Тэгмэгцээ тэрээр огло үсрэн цочих нь тэр. Буланд нэг хүн байна. Гар чийдэнгийн гэрлийг нүүрэнд нь тусгаж харвал эмэгтэй хүн байх бөгөөд гэрлийг огтхон ч ажирсан

шинжгүй гараа долоох аж. Уг эмэгтэйн царай харанхуйд сайтар харагдахгүй байсан ч ямартай ч хувцас хунар нь халтартаж, үс нь хог шороонд зууралдан ширэлдсэн байлаа. Эмэгтэйн хамаг бие нь салганан чичирч байх бөгөөд тэрээр гараа долоохоос өөр ямар ч зүйлд анхаарал сарнихгүй байх аж. Энэ харанхуй том балгасанд ганц эмэгтэй юу хийж байгаа юм бол гэсэн бодол Баттөмөрт төрж, айх гайхах сэдэл төрүүлж байсан ч тэрээр түүн рүү ойртлоо.

- Хөөе, эмэгтэй. Та зүгээр үү? Таны гар чинь бэртчихээ юу?

- ... / Үл таних эмэгтэй Баттөмөрийн асуултанд хариулсангүй, эсвэл магадгүй бүр сонссонгүй /

- Хөөе, чи намайг сонсож байна уу?

Баттөмөр ингэж хэлээд түүн рүү улам дөхөв. Үл таних эмэгтэй түүний үгийг сонссон ч үгүй, бүр ядаж хүний урманд харсан ч үгүй. Баттөмөр эмэгтэйн биенд хүрэхэд одоо ердөө тавхан алхмын зай үлджээ. Бүсгүй гараа долоосоор. Яагаад ч юм бүсгүй маш ихээр өлссөн юм шиг мэдрэмж төрүүлнэ. Басхүү ам нь үнэхээр завгүй байгаа бололтой ямар нэгэн зүйл шал шал хийлгэн тамшаалан зажилж байх нь тэр. Энэ бүсгүйгээс өнөөх үхдэлийн өмхий үнэр маш хурцаар ханхалж байлаа.

Бүсгүй гараа долоосоор. Үгүй ээ, бүсгүй гараа долоогоогүй байх нь. Түүний чухам юу хийгээд ингэж ухаангүй байгааг Баттөмөр ойлголоо. Энэ эмэгтэй өөрөө өөрийгөө идэж байна. Гараа тасар татан зулгааж, өөрийнхөө цусыг завьжаа дагуулан савируулан урсгасаар сорж байх нь тэр. Баттөмөр үнэндээ ийм дүр зураг олж харна чинээ санаагүй учир аргагүй барьц алдан сандарч, өөрийн эрхгүй хоёр алхам ухарлаа. Тэнгэр минь энэ чинь юу гээч вэ. Баттөмөр эхэндээ нүдэндээ итгэсэнгүй. “Байж боломгүй юм” хэмээн амандаа шивнэсээр гар чийдэнгээ өөрийгөө идэж буй эмэгтэй рүү дахин тусгаж хараад бүр ч ой гутах шиг болов. Энэ эмэгтэй өөрийгөө ингэж идсээр байгаад үхэх байх даа гэсэн бодол Баттөмөрт төрөхтэй зэрэгцэн түүний араас хэн нэгэн дайрлаа. Нохой шиг хэрнээ бөглүү архирах дуун гарч хэн нэгэн эрэгтэй өөр лүү нь үсрэхэд Баттөмөр зайлж амжжээ. Баттөмөр ийнхүү хажуу тийш үсрэхдээ ямар нэгэн зүйлд тээглэн унаж, гар чийдэнгээ алдав. Харин буугаа алдсангүй. Харанхуйд Баттөмөрийн өөдөөс хэд хэдэн хар бараан дүрс маш хурдтайгаар сүүтгэнэн гүйж ирлээ. Хамар сэтлэх нь үү гэмээр өмхий эхүүн үнэр тогтож суухын аргагүй ханхалсаар. Ээ, новш гэж ЯВДАГ ҮХДЭЛҮҮД. Баттөмөр ямар ч эргэлзээгүйгээр өөр лүү нь дөхөж яваа гурван хар дүрсийн нэгнийх нь толгой руу нь чиглүүлэн буудлаа. Буудуулсан этгээд тэр даруй тас гэдрэгээ саван унасан ч үлдсэн хоёр нь хүний урманд буун дуунаар цочсон ч үгүй. Тэд Баттөмөр лүү маш хурдан үсрээд ирэв. Тэр хоёр одоо Баттөмөрийг бариад авахад ердөө л гурав дөрөвхөн алхам дутуу байна. Баттөмөр хүн буудсандаа бага зэрэг балмагдан сандарч байснаа маш хурдан сэхээ авч амжлаа. Тэрээр газарт хэвтсэн чигтээ өөрт нь бараг тулаад ирчихсэн хоёр этгээдийг цээжин тус газар нь онилоод нэг нэг удаа буудав. Хэрвээ тэрээр ийнхүү сэхээ авч амжаагүй, дахиад ганцхан л хором алдсан бол ямар ч эргэлзээгүйгээр үхэх байсан биз. Тэд хоёулаа чихарсан бөглүү хоолойгоор гинших мэт авиа гаргаад газарт унаснаа удалгүй буцаж өндийхөөр завдан хөдөлж эхэллээ. Харанхуйд болж байгаа энэ бүхэн Баттөмөрт төдийлөн сайн харагдахгүй сүүтэгнэж байсан бөгөөд тэрээр гагцхүү дуу чимээ, үнэрээр л бүхнийг мэдэрч байв. Тэрээр энэ балгасанд орж ирээд даруй хагас цаг хэрээтэй болсон тул харанхуйд нүд нь дасаж хөдөлж байгаа дүрсийг харанхуйгаас ялган харахтайгаа

болжээ.

Баттөмөр буугаа баруун гартаа барьсан чигтээ яаран бослоо. Харин өөрт нь буудуулсан өнөөх гурвын цээжиндээ сум зоолгосон хоёр үхээгүй нь нэгэнт тодорхой болж хоёр хөл дээрээ алгуурхан өндийгөөд ирэв. Энэ үхдэл гэж нэрлэмээр этгээдүүд өөрт нь нэгэнт аюул занал учруулж байгаа болохоор Баттөмөрт тэднийг зүйл дуусгахаас өөр сонголт үлдсэнгүй. Дахиад буудах хэрэгтэй, гэхдээ зөвхөн толгойд нь. Ингээд Баттөмөр сүүтгэнэсэн хоёр дүрсийн толгойн хэсэгт онилж байгаад нэг нэг удаа буудав.

Явдаг үхдэлүүдийн хэн нь ч сумнаас зайлах оролдлого хийсэнгүй. Зөвхөн Баттөмөрийг идэх гэсэн мэт дайрч байгаад буудуулж үхсэн нь энэ байлаа. Баттөмөр хэсэг хугацаанд амсхийв. Ямартай ч энэ явдаг үхдэлүүдийг өмнө нь ном зохиол дээрээс уншиж, зурагтаар үзэж байсантай харьцуулахад хавьгүй хурдан шаламгай хөдөлгөөнтэй юм. Энэ зомби гэж нэрлэхэд тохиромжтой этгээдүүд уг нь болхи удаан хөдөлгөөнтэй баймаар санагдавч үнэн хэрэгтээ тийм биш гэдгийг Баттөмөр ойлголоо. Энэ чинь одоо юу вэ, яагаад над руу дайрав. Би хэнийг алчихав аа? Баттөмөр өөрөө өөртөө ийн асуулт тавиад яаран сандран гар чийдэнгээ олж аваад тусгаж үзлээ. Азаар гар чийдэнгийнх нь гэрэл асаж саяын буудсан цогцос руугаа тусган харав. Тэгээд дараа нь Баттөмөр тэднийг амжиж буудсандаа баярлалаа. Нүүр лүү нь буудсан болохоор улаан нэлий юм болж царай нь сайн ялгарахгүй байсан ч түүний нүдэнд үхдэлийн шүд нь өртжээ. Шүд ч гэж дээ, соёонууд. Харанхуйн дундах сүүмгэр нарийн гэрэлд хурц ирлэсэн хадуурыг санагдуулам тахир цагаан соёонууд цустай холилдон харагдаж байлаа. Өнөөх вампир буюу цус сорогчид хоёр соёотой байдаг бол энэ үхдэлүүдийн үүдэн шүднүүд нь хүртэл соёо гээд нэрлэхэд болмоор харагдаж байх нь тэр. Бүх шүднүүд нь яг ирлэсэн тонгорго гэлтэй. Үүнийг харсан Баттөмөрт өнөөх хорин жилийн өмнөх номын мөрүүд дахин үзэгдэх шиг боллоо.

“ Сэлмэн шүдэт хүн араатнууд муу ёрын чөтгөрийг шөнийн цагаар сахин хамгаалах болно. Цусанд бялуурсан чөтгөр үүр цайхаас нааш хөдөлж үл чадна”. Тиймээ, яг ингэж бичсэн байсан.

Өнөөдрийн энэ явдлыг зөгнөсөн байж. Новшийн алиалагчийг үүр цайхаас өмнө устгах хэрэгтэй. Тэр өнөөдөр хангалттай цус уусан. Харин одоо бялуурчихаад хэвтэж байгаа байх нь ээ. Гэхдээ чухам энэ том балгасны хаана нь нуугдаж байгаа бол? Ямартай ч яарах хэрэгтэй. Хэрвээ тэр өнөө өглөөнийх шигээ хүч тэнхээтэй байвал түүнийг яагаад ч барахгүй. Ийнхүү Баттөмөр яагаад энэ байшин руу зүтгээд байсныхаа уярыг ойлгох шиг болов. Үнэндээ зөгнөж мэддэг гайхалтай авьяас нь алиалагчийг олоход өөрт нь урьдын адил сайн тус болж чадахгүй байсан ч хорин жилийн өмнөх номын хуудсыг эргүүлсэн нь тохиолдлын хэрэг биш гэдгийг ойлгожээ. Тэрээр номон дээр бичсэн байсан бас нэгэн утгат хэсгийг саналаа.

“ Алиалагч хоёр сарын туршид сар болгон гурван хүүхдийн эд эрхтнүүдийг тонож нийтдээ зургаан настай зургаан хүүгийн амиар муу ёрын сүнснээ тахил өргөж, амьгүй цогцсуудын эд эрхтнүүдийг өөрийнхөө цусаар сэлбэн хольж өөрийнхөө хойч үр үндсийг амилуулах болно. Эхний нэг сар үгүй хийсэн гурван хүүгийн эд эрхтнээр өөрийнхөө үр үндсийн дотоод эд эрхтэн, яс болон харах нүд, сонсох чихийг нь хийх бөгөөд дараачийн сард цааш харуулах хүүгийн арьсаар нь хчиж өөрийнхөө цусаар сэлбэн хүн төрхтэй ороолон бий болгох зорилготой” гэсэн нэгэн утгат хэсэг байсан. Баттөмөр одоо бүхнийг алган дээрээ тавьсан мэт

ил харж байлаа. Алиалагч эхний гурван сард өөрийнхөө үүргийг амжилттай биелүүлж, зургаан настай гурван хүүхдийг хөнөөж тэдний эд эрхтнээс хэрэгтэйгээ түүж авсан. Харин өнөөдөр хоёр дахь сар нь эхэлж байна. Өөдгүй муу шулам өнөөдрийн дотор найдвартай гурван хүүг үгүй хийчихсэн байж таарна. Түрүүний эх нялхсын эмнэлгийн жаахан хүү хамгийн сүүлчийн золиос буюу зургаа дахь хүү байж таарах нь. Тийм болохоор одоо яарах хэрэгтэй. Түргэхэн шиг очиж алиалагчийг хүүтэй нь хамт зүйл дуусгахгүй бол хүн төрөлхтөнд аюул нүүрлэх нь!!! Баттөмөр ингэж бодоод өөрийгөө улам бүр зоригжууллаа. Тэрээр балгасны гүн рүү нэвтрэхээр өндийх үедээ нэг зүйлийг мартсан юм шиг санагдаад болсонгүй. Чухам юу вэ гэдгээ санаж амжаагүй байтал бүх зүйл тодорхой болов. Өнөөх өөрийгөө идэж байсан эмэгтэй. Яг л уур нь хүрсэн муурын цээж нь хүржигнэн дуугарах шиг тийм чимээ сонсогдоход Баттөмөр гар чийдэнгээ урагш нь тусган харлаа. Нэг гар нь тасраад уначих нь уу гэмээр цусандаа будагдан улаан нэлий болж санжиганасан эмэгтэй хурц соёонуудаа ярзайлган түүн рүү дайран ирэх нь тэр. Баттөмөр түүнийг буудаж амжсангүй. Буу, гар чийдэн хоёр нь түүний дөнгөж хажууханд унахад махчин эмэгтэйн нүүрэнд гар чийдэнгийн гэрэл тусчээ. Эмэгтэй түүнийг дарж унагаад баруун гараараа багалзуурыг нь шахаж битүү хурц соёо болсон өмхий амаа ангайлгахад Баттөмөр баруун гараа зангидаж хамаг хүчээрээ эрүү рүү нь цохилоо. Урьд нь хэр баргийн булиа залуучуудыг нам цохичихдог байсан бол энэ удаад өөрийнхөө дээр байгаа цус сорогчийг өөрөөсөө холдуулчихаж ч чадаагүйдээ Баттөмөр хэсэгхэн хугацаанд гайхаад амжив. Өөрийнх нь цусыг сорохоор улайран дайрч байгаа энэхүү амьд үхдэл болсон хүүхний хүзүүнд нь Баттөмөр зүүн гараараа туллаа. Тэгтэл тун таагүй мэдрэмж мэдрэгдэх нь тэр. Өөрийнх нь гүрээний судсанд сэлмэн соёогоо зоохоор улайран зүтгэх эмэгтэйн хүзүү мөс шиг хүйтэн байлаа. Баттөмөр өөртөө байгаа хамаг л хүчээ шавхан амьд үхдэлийг хүчлэн түлхэж байсан ч түүний өмхий ханхлуулсан ам хүзүү рүү нь улам бүр ойртсоор байв. Баттөмөр баруун гараараа дахин цохих гэснээ больж долоовор дунд хуруунуудаа нийлүүлэн нүд рүү нь чичиж орхилоо. Түүний хоёр хуруу нь хүйтэн нялцгар юм руу дүрээд гарах шиг болоход махчин хүүхэн үл ялиг гэдийж цус царцмаар чихарсан хоолойгоор гинших нь тэр. Тэрээр Баттөмөрийн багалзуурыг шахаж байсан гараа сулрууллаа. Баттөмөр энэ чөлөөг ашиглан хажуудаа байгаа гар буугаа аван эмэгтэйн толгойд нь бараг тулгаж байгаад гохоо дарав. Махчин эмэгтэйн толгой зад үсрэх шиг болж нялцгар нойтон зүйлс Баттөмөрийн нүүрэнд цацагдлаа. Дөнөж саяхан гүрээнийх нь судсыг хариугүй тас татаж, хамаг цусыг нь ам руугаа юүлэх гэж байсан махчин хүүхэн арагшаа үхэдхийн унажээ. Баттөмөр хоолойгоо барин байж хэдэнтээ амьсгаа авлаа. Тэрээр гар утсаа нээж төв рүү холбоо барьж цагдаа, тусгайгийнхны нэмэлт хүч дуудах гэсэн боловч энэ харанхуй балгасан дотор утасных нь сүлжээ уначихсан байх нь тэр.

Хэрвээ энэ эмэгтэй өөрийнхөө өрөөсөн гарыг идээгүй бол намайг амархан зүйл дуусгачих байжээ гэсэн бодол Баттөмөрт энэхэн агшинд төрөхөд түүний ар нуруугаар хүйт оргих шиг боллоо. Тэрээр хэвтэж байсан газраасаа өндийхөд балгасны цаад булангаас харанхуйд сүүтгэнэсэн тав зургаан махчин үхдэлүүд өөр лүү нь довглон ирж яваа харагдав. Баттөмөр яаран босч гар чийдэнгээ тусгаад хамгийн эхэнд өр лүү нь довтолж буй соёогоо ярзайлгасан цагаан үстэй хижээлдүү эрийн цохонд нь чиглүүлээд буудахад тэрээр үхэдхийн уналаа. Үхдэлүүд ар араасаа цувран Баттөмөр лүү гүйлдсээр.

Баттөмөр дараачийнхаа байнд гэрлээ тусган гохоо дартал сум нь дуусчихсан байв. Тэгмэгц нь тэрээр хоосон буугаа шидэж орхиод эргэтэл гарах хаалганы зүгээс хоёр хар дүрс чихарсан дуу

гарган өөр лүү нь гүйж байх нь тэр. Ингээд өнгөрдөг байжээ гэсэн бодол Баттөмөрийн толгойд зурсхийн орж ирсэн ч ийм амархан үхэлтэйгээ эвлэрэхийг хүссэнгүй, эцсээ хүртэл үзэлцэхээр зориг шулуудлаа. Тэрээр гар чийдэнгийнхээ гэрлээр хавь орчноо тусгаад өөрөөс нь тав орчим алхмын зайтай хурц үзүүртэй бүдүүн төмөр газар хэвтэж байхыг олж харав. Баттөмөр лоом гээд нэрлэчихэд болмоор энэ үзүүртэй бүдүүн тахир төмрийг шүүрэн аваад гардан тулалдаанд орохоор биеэ зэхлээ. Битүү хүржигнэсэн муухай дуугаар исгэрсээр өөрт нь тулж ирсэн хорьхон хастай болов уу гэмээр жаахан охиныг Баттөмөр лоомныхоо үзүүрээр нүүр лүү нь нэвт зоож орхилоо. Нарийхан жингэнэсэн дуугаар могой мэт исгэрсээр охин татваганан унахад Баттөмөр лоомоо суга татан аваад араас нь тулж ирсэн эрэгтэйн толгой руу хамаг тэнхээгээрээ савж орхив. Хүнд төмрөөр толгойдоо цохиулсан махчин эр хажуу тийш өнхрөн унахад дарачийнх нь Баттөмөрийн яг өмнө тулаад иржээ. Нэгэнт тулаад ирсэн болохоор Баттөмөрт гартаа атгасан зэвсгээ ашиглах боломж гараагүй учраас толгойгоороо нүүр лүү нь мөргөж, өөрөөсөө үл ялиг холдуулаад баруун хөлөөрөө гэдэс рүү нь хар тэнхээгээрээ жийж унагав. Гэтэл мөрнөөс нь бас нэгэн хүйтэн гар атган авахад Баттөмөр маш эргэж лоомоороо доороос нь эрүү рүү нь хүчтэй зоож орхиход лоомны үзүүр нь махчин эрийн зулайг нэвт цоолон дээшээ гарах нь харанхуйд там тум мэдрэгдэж чих дөжрүүлэм чарлаан үүслээ. Баттөмөр түүнээс лоомоо сугалан авах гэж мунгинасаар байтал түүн дээр сэлмэн соёогоо ярзайлгасан тав зургаан махчин шаваад ирэв. Баттөмөр нүцгэн гараараа нүүр лүү нь цохиж хамаг хүчээрээ тэмцэж байсан ч нэг мэдэхнээ газар уначихжээ. Энэ удаад түүн дээр нэг гартай эмэгтэй биш бүр хоёр гартай эрэгтэй махчин этгээд дарж хэвтээд хүзүүнд нь соёогоо шигтгэхээр улайран зүтгэж байлаа. Харин бусад нь Баттөмөрийг зүйл дуусгахыг хүлээх мэт хүржигнэн тойрон хүрээлэв. Гар чийдэн нь хаана ч унасан юм бүү мэд, унтарчихсан байх бөгөөд Баттөмөр энэхүү харанхуй орчинд сүүтгэнэсэн хар дүрсүүдтэй хамаг хүчээрээ тэмцэж байлаа. Эдгээр махчин этгээдүүд харанхуйд яг л шар шувуу шиг сайн хардаг бололтой. Баттөмөр хэдий хоёр гараараа махчин эрийн эрүүнд нь тулсан хэдий ч аргагүй хүчин мөхөстөж өмхий ханхлуулсан муухай ам хүзүү рүү нь улам бүр ойртсоор байв.

## Тав

Баттөмөр өөрийн эрхгүй тамирдаж хамаг бие нь сулраад ирэх тэр үед гэнэт гэрэл тусч буун дуу тачигнаж эхлэв. Үүнтэй зэрэгцэн харанхуйн дунд Баттөмөр дээр шавж байсан махчин үхдэлүүд өөр зүг рүү анхаарлаа чиглүүлэн муухай архиран үсрэн довтлох нь тэр. Бүхэл бүтэн нэг минут хэртэй буун дуу тачигнасаар цус сорогчид цөмөөрөө хэдэн тийшээ ханаран ундуй сундуй унацгаалаа. Баттөмөрийн цусыг сорохоор дээрээс нь улайран дарж байсан махчин эрийн толгой бууны суманд яз үсэрч Баттөмөрийн нүүрээр нэг нялцгай нойтон зүйлс нялгандан цацагджээ.

Базараа яг цагаа олж ирсэн нь энэ байлаа. Түүнтэй хамт автомат, гар буугаар зэвсэглэсэн гурван ч залуу зогсож байх бөгөөд тэд Баттөмөрийг амьд эсэхийг нягтлах гэсэн мэт гар чийдэнгийнхээ гэрлүүдийг түүний нүүрэнд тусгаж байв. Хүнд биетэй махчин эрийн амьгүй болсон цогцсыг Баттөмөр өөрийнхөө дээрээс арайхийн хүчлэн холдуулаад өөрийнхөө аврагчид руу цусанд будагдсан нүүрээрээ харж муухан инээмсэглэлээ.

-Баттөмөр өө, чи зүгээр үү?

-Зүгээр ээ. Чи яг цагаа олж ирлээ

-Энэ өмхий ханхлуулсан новшнууд чинь чамайг амьдаар чинь идэх гэж байна шүү дээ. Бас бидэн рүү ч гэсэн хогийн соёонуудаа ярзайлган дайрсан. Энэ юун хүмүүс вэ. Сандрахдаа бодож амжилгүй шууд л буудчихлаа.

-Цус сорогчид. Хүний махаар хооллогчид. Бас өөрөөр нэрлэвэл алиалагчийн бие хамгаалагч нар. Бид одоо түргэлэх хэрэгтэй. Алиалагч энэ балгасын хаа нэгтээ нуугдаж байгаа. Түүнийг яг одоо л үгүй хийхгүй бол дахиж хэзээ ч чадахгүй. Хүн төрөлхтөн ямар ч авралгүйгээр устаж үгүй болно.

Баттөмөр ингэж хэлээд газраас өндийж иртэл түүнтэй зэрэгцэн буудуулж унасан тав зургаан үхдлүүд хөдөлж эхлэв. Базараагийн хажууд зогсож байсан тусгай салааны хувцастай нэгэн эр буудуулсан цогцсууд дахин амь орж байгааг хараад “Энэ чинь одоо юу вэ” хэмээн өөрийн эрхгүй балмагдан дуу алдлаа. Үнэхээр дөнгөж саяхан автомат бууны суманд сийчүүлсэн цогцсууд тэднийг харсаар байтал хоёр хөл дээрээ босоод ирэв.

-Наад новшнууынхаа толгойд нь бууд. Түүнээс нааш үхэхгүй

Базараа болон түүний нөхөд Баттөмөрийн энэ үгэнд ямар ч эргэлзээгүйгээр захирагдан үхдэлүүдийн цохонд онилоод буудаж эхлэв. Гэтэл буудаж буй залуусын хамгийн захад зогсож байсан Хүрлээ гэх залуу ёолон хашхираад уналаа. Дутуу буудуулсан нэг махчин эмэгтэй түүний хөлийн булчинг нь тас хазчихжээ. Залуу өөрийн эрхгүй газар сөхрөн унаж, тэгмэгцээ өөрийн нь дээрээс мордох гэсэн махчин эмэгтэйн цус болсон ам руу гар бууныхаа амыг хийгээд буудаж орхилоо. Цус сорогч эмэгтэй эргэлзээгүйгээр үхсэн хэдий ч хөлийнхөө махыг тас хазуулсан Хүрлээ гэх эр тэсвэр алдан орилж байв. Тэрээр цус савирсан зүүн хөлөө хоёр гараараа барьж “Өвдөж байна” хэмээн орь дуу тавьж байлаа. Залуус сандралдаж эхлэв. Урьд өмнө хэзээ ч таарч байгаагүй ам дүүрэн хурц шүдтэй өмхий ханхлуулсан үхдэлүүд сумнаас ч айлгүй улайран дайрч байгаад бүгдээрээ аргагүй барьц алдах нь тэр.

-Өө новш. Энэ өмхий намайг хазчихлаа. Аймаар өвдөж байна

-Тэсээрэй Хүрлээ

Базараа ингэж хэлээд түүний хөл рүү гар чийдэнгийнхээ гэрлийг тусгаж харав. Зүүн хөлийнх нь булчингийн махыг өм хазаад авчихжээ. Цус тасралтгүй олгойдож залуу чухам яаж тэсч байна аа гэмээр сэтгэгдэл төрүүлэх аж. Харин Баатараа түүнийг мөрөөр нь тэврэн яаж туслахаа мэдэхгүй хэдэн тийш хурдан харж байлаа.

-Баатараа, чи Хүрлээг аваад яаралтай эмнэлэг рүү яваад нэмэлт хүч дууд. Энэ новшийн балгаснаас гармагцаа утсаар залгаж цагдаагийнхыг, ер нь бүгдийг нь дуудаарай. Батсүх бид хоёр Баттөмөртэй цаашаа явлаа.

-ойлголоо Энэ үед хөлийнхөө булчинг тас хазуулсан Хүрлээ ухаан алджээ. Баатараа түүний цус урсах хөлийг цамцаа ханз татан ураад боосон болов. Байшингийн гүн дэх харанхуйгаас дахин хүржигнэн архирах дуу гарч сүүтгэнэсэн хар бараан дүрсүүд маш хурдтайгаар гүйлдэн ирцгээлээ.

-Галлаад

Базараа ингэж хэлээд чийдэнгээ тусган буудаж эхэллээ. Харанхуйд довтлон ирэх махчин үхдлүүд дэндүү олуулаа бөгөөд залуучууд тасралтгүй буудаж байсан ч тэд нэмэгдсээр байв. Буудуулж унасан зарим нэг нь дахин босч ирж байлаа.

-Новш гэж. Бид ухрах хэрэгтэй. Базарааг ингэж хэлэхэд Баатараа ухаан алдсан Хүрлээг мөрлөөд өндийв. Баттөмөр Базараагийн өгсөн нэг гар буугаар өөрийгөө зэвсэглэжээ. Буун дуу пижигнэн дуугарсаар. Баттөмөр ухаангүй байгаа Хүрлээгийн нөгөө талаас мөрлөн өндийлгөж Баатараад туслав. Дөрвөн залуу нэгэн зэрэг буудаж байлаа. Одоо зөвхөн хоёр гар чийдэн л тусч байх бөгөөд энэ хоёр чийдэнгийн нэгийг Базараа нэг гартаа барьж нөгөө гартаа атгасан гар буугаараа тасралтгүй буудаж байв. Базараагийн баруун талд зогсож байгаа Батсүх хоёр гартаа автомат атгаад муухай хашхиран тасралтгүй шүршиж байлаа. Тэрээр бүр улайрчихсан бололтой. Харин нөгөө гар чийдэнг шархнаасаа болоод ухаан алдсан Хүрлээг мөрлөчихөөд байгаа Баатараа амандаа зуусан байх бөгөөд зүүн гартаа атгасан гар буугаар довтлон ирэх махчин этгээдүүдийг алдалгүй буудаж байв.

-Хараал идмэр миний сум дуусчихлаа.

Энэ үгийг Базараа хэлжээ. Харин түүний энэ үгийг Баттөмөрөөс өөр хэн ч сонссонгүй. Баттөмөр яахаа мэдэхээ айн сандарч байгаа Базараад ухаан алдсан Хүрлээгийн бүснээс гар бууг нэг дайз сумтай нь хамт сугалж өгөв. Базарааг буугаа сумлаад дахин буудаж эхлэхэд үхдлүүд тэдний өмнө бараг тулаад ирчихлээ. Махчин этгээдүүд үхэдхийн унаж байгаа ч гэлээ байшингийн цаад харанхуй булангаас тасралтгүй архиран гүйлдэж ирсээр.

-Энэ янзаараа бүгдээрээ өнгөрөх нь ээ. Бид гурав хамгаалж байя. Баатараа чи Хүрлээг аваад эндээс гар, түргэлээрэй.

Базарааг ингэж хэлэхэд Баатараа ухаангүй найзыгаа үүрээд үүдний зүг хурдан эргэлээ. Ийнхүү Базараа, Батсүх, Баттөмөр гурав дундаа ганцхан гар чийдэнтэй харанхуй дундаас довтлон ирэх этгээдүүдтэй тулалдсаар хоцорлоо. Ашгүй аз болж өнөөх тасралтгүй цувран ирэх махчин үхдлүүдийн довтолгоо дууслаа. Базараа, Батсүх хоёр махчин этгээдүүдийн гүйлдэн ирж байсан харанхуй хэсэг рүү гар чийдэнгийнхээ гэрлийг тусган цоо ширтэх аж.

Буун дуун ч тасарсан энэ үед Баттөмөрт нэгэн таагүй мэдрэмж төрж өөрийн эрхгүй эргэн харлаа. Харанхуйд юмс тийм ч сайн харагдсангүй. Тэгмэгц нь Баттөмөр Базараагийн барьж байсан гар чийдэнг шүүрч аваад гарах хаалга байгаа тэр зүгт тусган харав. Тав зургаан махчин этгээдүүд Баатараа, Хүрлээ хоёрын амьгүй цогцсон дээр шавааралдан тал талаас нь тасар татан идэж байх нь тэр.

-Аа, муу новшнуудаа. Та нарыг би ална аа.

Батсүх ийнхүү хоолойныхоо чадлаар хашхиран хүний махан дээр шавааралдсан махчин этгээдүүд рүү гартаа байгаа автоматаар хайр найргүй шүршиж эхэллээ. Хүний мах цусанд донтсон тэдгээр этгээдүүд бууны сум нисч ирээд өөрийн нь биеийг нь сийчихээс нааш юу ч ажрахгүй байх аж. Тэнэсэн сум заримын нь толгойд тусч, цээж, хөл, гарыг онож байлаа.



Харин Базараагийн хувьд өөрийнхөө хоёр хамтрагчийг идүүлж байгааг хараад бүр шоконд орчихсон бололтой. Царай нь гөлийж Баттөмөрийн гар чийдэн тусгаж байгаа тэр зүгээс харцаа ч салгаж чадалгүй мэлрэн зогсох аж. Хоёр залуу дээр овоорч байсан махчин этгээдүүд сая л нэг үхэж дуусав бололтой. Батсүхийн бууны сум аль хэдийнэ дууссан хэдий ч хоосон бууны гох дарах чимээ тачигнан дуугарсаар. Хоёр залуугийн биеийг юу ч үгүй сэглэж орхижээ. Базараа хэдий шоконд орсон ч хурдан сэхээ авч алагдсан хоёр хамтрагчийнхаа цогцосны дэргэд дөхөж ирээд доошлоо тонгойж Баатараагийн барьж байсан гар бууг авлаа.

-Энэ чинь одоо юу гээчийн муу ёрын юм болж байна аа. Эд нар чинь хүн идэж байна шүү дээ. Бүр яг л цусанд донтсон ирвэс шиг юм. Хүний махыг тасар татан идэж байхдаа юуг ч ажрахгүй, бүр буудуулж байсан ч тоохгүй байна. Залуус аа, бид хоёр хүнээ алдлаа. Эндээс түргэн гараад нэмэлт хүч дуудах хэрэгтэй. Энэ новшийн балгаснаас хурдхан шиг амьд дээрээ гарцгаая. Базарааг ингэж хэлэхэд Батсүх “Эндээс түргэн зайлцгаая” хэмээн Базараагийн үгийг батлан дуудах төдий шивнэн хэлэв. Харин Баттөмөрийн хувьд эргэлзэж байлаа. “Хэрвээ эндээс гарах л юм бол алиалагчийг зүйл дуусгах хөг өнгөрөх болно. Нэмэлт хүч ирж дахин энэ балгасан дотор орж ирэх гэсээр байтал үүр цайж алиалагч арилаад өгнө биз. Бас өглөө эрт нар мандахад чөтгөрийн хүү ч гэсэн ертөнцөд шинээр мэндэлж алиалагчийн зорилго ямар ч эргэлзээгүйгээр биелэх нь лавгай. Гэтэл ийм байдалтай, махчин үхдлүүд алхам тутамд заналхийлж байхад яаж устгах аргаа ч мэдэхгүй байж алиалагчийг олно гэдэг бүтэшгүй нь ойлгомжтой” Баттөмөр ингэж бодсоор яахаа мэдэхгүй хэдэн хором саатжээ. Түүнийг ийнхүү яахаа мэдэхгүй алмайран зогсож байтал Базараа нэг зүйлийг олж мэдэв бололтой дуу алдах нь тэр. Тэрээр биендээ дор хаяж зургаан сум зоолгож хагас дутуу үхээд байгаа махчин эмэгтэйн дээрээс болгоомжлон харж байлаа. “Энэ мөн байна. Өнөөх ор сураггүй алга болсон хүмүүсийн нэг. Энэ эмэгтэй бол хорин зургаан настай, нэг хүүхэдтэй. Ээж нь нөхөртэй нь хамт цагдаагийн газар ирээд уйлж унжин ор сураггүй болсон хайртай хүнээ хурдхан олоод өгөөч гэж гуйж байсан. Зургийг нь харуулж, таних тэмдгийг нь үзүүлж байсан тэр эмэгтэй яг мөн байна. Энэ эмэгтэйн хүзүүн дээрх том хар мэнгэ яг л зурган дээр гарсан шигээ тод харагдаж байна шүү дээ” Базарааг ингэж хэлэхэд түүний хажууд Батсүх бараг тулж ирлээ.

-Тэгвэл энэ махчин амьтад чинь өнөөх ор сураггүй алга болоод олдохгүй байгаа хүмүүс болж таарах нь ээ

-Магадгүй тийм байх нь

-Хэрвээ тийм бол энд чинь тавиад хүн байгаа. Өнгөрсөн сард ойролцоогоор бараг тавин хүн сураггүй алга болсон гэж бүртгэгдсэн. Тэгээд бас бүртгэгдээгүй ор сураггүй алга бологсод хичнээн ч байгаа юм билээ хэн мэдлээ.

-Ямар ч байсан сая бид нар гучаадыг нь цааш нь харуулсан. Хэрвээ үнэхээр ор сураггүй алга болсон бүх хүмүүс энэ балгасанд байгаа бол махчин этгээдүүд энэ байшингийн хаа нэгтээ байж л байгаа. Тэгэхээр гурвуулаа яг одоо эндээс хурдан гаръя.

Базараа ийнхүү үгээ дуусгаад гар буугаа дутуу үхсэн махчин эмэгтэйн толгойд чиглүүлэн гохоо дарлаа. Энэхүү гэрэл муутай орчинд Батсүх ямар ч эргэлзээгүйгээр үхсэн хоёр найзынхаа дээрээс айж цэрвэсэн байдлаар нүдээ онийлгон хараад харцаа тийм амар салгаж

чадахгүй байлаа.

-Явцгаая

Базараа ингэж хэлэхдээ түрүүнээс хойш өөрөөс нь зургаан алхамын зайд гар чийдэн тусган зогсож байгаа Баттөмөрт хандаж хэлжээ. Баттөмөр ч энэ үг зөвхөн өөрт нь хамаатай гэдгийг ойлгон Базараа руу дөхөж ирлээ.

-Баттөмөр өө, чи яасан бэ. Эндээс хурдхан гарцгаая л даа. Арай чи эндээс гарах дургүй байгаа юм биш биз. Бид нар цаг алдах хэрэггүй. Энэ утасны сүлжээ унаад байгаа муу ёрын балгаснаас гараад цагдаа дуудъя. Ингээд л яахаа мэдэхгүй зогсоод байвал бид нар ч үхэж мэднэ.

-Базараа чи аан гээч. Бид нар алиалагчийг алахаас нааш эндээс гарч чадахгүй гэвэл чи яах вэ?

-Юу гэсэн үг вэ. Чиний наад үгийг чинь би сайн ойлгосонгүй.

-Совин татаад байна. Бид нарт эндээс гарах боломж алга. Яахав мэдээж чи миний ярьсанд итгэхгүй байгаа байх. Хэрвээ тийм бол оролдоод үз л дээ. Би ч гэсэн эндээс гарахыг хүсч байна. Гэхдээ бас тийм амар гарч чадахгүй гэдгээ мэдэж байна.

-Хөөе залуу минь. Чиний юу гэж ярих чинь надад огт хамаагүй. Манай хоёр найз үхлээ. Бүр үхэх үхэхдээ үхлийн муугаар үхэж махчин этгээдүүдийн хоол болчихлоо. Тэгэхээр одоо би ч гэсэн хоёр найзынхаа адилаар энэ махчин новшнуудын гэдсийг цатгамааргүй байна. Чи үлдвэл үлд, харин би эндээс гарлаа.

Энэ үгийг Батсүх хэлжээ. Тэрээр хэзээ ч төсөөлж байгаагүй махчин этгээдүүдтэй учирсандаа аргагүй айн сандарч, басхүү энэ харанхуй орчноос залхав бололтой Баттөмөр, Базараа хоёрыг үг хэлж амжихаас өмнө гарах хаалганы зүг харанхуйд бүдчин гүйлээ. Харамсалтай нь Батсүхийн энэ хөдөлгөөн түүний амьдралынх нь хамгийн сүүлчийн үйлдэл болжээ.

Баттөмөр түүний араас гар чийдэнгээ тусгаж “”Түр хүлээгээч гэж хэлэхтэй зэрэгцэн харанхуйн дундаас нэг этгээд ухасхийн үсэрч Батсүхийг дараад авлаа. Могой мэт исгэрэх чимээ гарч харанхуйд сүүтгэнэсэн хоёр дүрс ноцолдож буй нь арай ядан харагдах аж. Энэ гэнэтийн довтолгооны үеэр бас нэг махчин өмхий үнэрээ ханхлуулсаар Баттөмөрийг дараад авчээ. Баттөмөр ч харанхуйд унахдаа гар чийдэн буу хоёроо алдлаа. Харин Базараагийн хувьд алинд нь очиж туслахаа мэдэхгүй байгаа мэт гартаа байгаа бууг улам чанга атгаж хоёр тийшээ ээлжлэн харах аж. Ямар ч гэрэлгүй энэ харанхуйд Баттөмөрийн дээр гарч амаа ангайн арьс махыг нь тасчихаар улайран дайрч байгаа этгээдийн ямаршуухан зүс төрхтэй болох нь мэдэгдсэнгүй. Гэнэт буун дуу гурьан удаа тасхийж Баттөмөрийг хариугүй хоолоо болгох гэж байсан махчин хажуу тийш навгас хийн унав. Харин энэ үед Батсүхийн гартаа барьсан хоосон автомат бууны гох дарагдах чимээ тачигнан дуулдаж байснаа чимээгүй боллоо. Хэдий Батсүх рүү дайрсан хамгийн эхний махчин этгээдийг Базараагийн нэг сум оносон ч гэлээ дахин хоёр махчин нэмэгдэн ирж хөөрхий залууг хэдэн талаас нь тасар татан идэж эхэлжээ. Базарааг буугаа цэнэглэж Баттөмөрийг унасан газраасаа босох гэсээр байтал өвдсөндөө болон чарлаж байсан Батсүхийн дуу гэнэт таг чимээгүй болчих нь тэр. Энэ нь Батсүхийн хоолойг нэг

махчин тас хазчихлаа хэмээн Баттөмөр бодсон нь үнэн байлаа. Баттөмөр, Базараа хоёр хэдий харанхуй байсан ч Батсүхийг алсан хоёр махчин руу хоолойныхоо чадлаар хашхичин ойртоод толгойг нь зад буудав. Батсүх хэдэнтээ татваганан хөдлөх шиг болсноо амь тавилаа. Баттөмөр, Базараа хоёр нэгэнт гар чийдэнгүй болсон блохоор гар утасныхаа өчүүхэн жаахан гэрлийг ашиглан Батсүх дээр ирээд түүнийг ямар ч эргэлзээгүй үхжээ гэдгийг мэдэв. Тэд хоёулхнаа үлджээ. Базараад одоо Баттөмөрийн хэлсэн алиалагчийг үгүй хийхээс нааш гарах боломжгүй гэдэг үг үнэмшилтэй санагдаж байлаа. Хоёр залуу гар утасныхаа гэрлүүдийг өөрсдийнхөө нүүрэнд тусган гэрэлтүүлэхэд Базараа “Одоо яах вэ?” гэсэн харцаар Баттөмөрийг ширтэж байх нь тэр.

-Базараа энэ болж байгаа бүхэнд чамайг гайхаж цочирдож байгааг чинь би сайн ойлгож байна. Гэхдээ чи намайг анхааралтай сонс. Магадгүй энэ чиний уншсан ном, үзсэн кинотой чинь ижил санагдаж болох юм. Гэхдээ яг одоо миний чамд хэлэх гэж байгаа бол чин үнэн юм шүү.

-Би чамд итгэж байна аа.

-Би арван настайгаасаа хойш өнөөдрийг хүртэл нэг ч удаа амар тайван байж үзээгүй. Учир нь гэвэл би болж өнгөрсөн эсвэл болох гэж байгаа бүхнийг мэдрээд байдаг. Миний амжилттай ажилладгийн гол нууц бол ердөө энэ. Харин энэ удаагийн алиалагчтай зууралдаж байгаа хэрэг бол бусдаас өөр. Бүр шал ондоо. Өмнө нь дандаа л муу хүмүүстэй зууралддаг байсан бол одоо бид нар амилсан чөтгөрийн араас хөөцөлдөж байна. Бидний энэ амьдрал, сансар огторгуй, хязгааргүй орон зай нууцлаг бүхнээр дүүрэн. Түүн дотроос бидний амьдралыг үгүй хийж, өөрийн ноёрхлоо тогтоох гэсэн нэг новшийн сансрын тэнүүлчин болсон шулам манай дэлхий дээр ирсэн. Түүнд бидний амьдрал таалагддаггүй, харин бидний амьдрач байгаа орчин таалагддаг. Тэр бидний гэр болсон гараг ертөнцийг өөрийн болгохыг хүсч байгаа. Тэгэхийн тулд тэр биднийг бүгдийг нь алж, цусыг минь юулж, өөрийн амьдралын тэжээлээ болгон хувиргах болно. Энэ бол түүний зорилго. Тийм болохоор бид түүний энэ үйлдлийг таслан зогсоох хэрэгтэй.

-Чиний яриад байгаа наад шулам чинь тэгээд бидний хайгаад байгаа алиалагч гэж чи хэлэх гээд байна уу?

- Тиймээ, чи ойлгосон байна. Чи хулгайлагдсан хүүхдүүдийн эрэмдэглэгдсэн цогцсуудыг санаж байгаа байх. Алиалагч зургаан настай зургаан хүүхдийн эд эрхтнүүдийг тонож өөрийнхөө цусыг нийлүүлэн үр үндсээ тарьж байна. Хэрвээ тэр хүүхэд нь амилах юм бол алиалагчийн хувьд ертөнцийн хаалга үргэлж нээлттэй гэсэн үг. Тэр өөрийнөө цусаар бүтээсэн хүүхдийнхээ биеэр дамжин дэлхийд хүссэн үедээ зорчих боломжтой болно. Хэрвээ тэр нь биелэх юм бол алиалагч хэзээ ч үхэхгүй. Өөрөөр хэлбэл алиалагчийн энэ удаагийн зорилго бол хүүхээ хийх. Дэлхийд хүссэн үедээ зорчих визээ авахаар ирсэн нь энэ. Тэр новш дэлхийд жар хоногийн хугацаатай ирсэн. Хэрвээ энэ шөнийг л өнгөрөөх юм бол бүх зүйл дуусна. Түүний дэлхий дээр орших хугацаа дууссан ч гэсэн ердөө л эргээд хэдхэн цагийн дараа хүүхдийнхээ би?эр дамжаад эргээд ирэх болно. Түүнийг яг одоо олж очоод зүйл дуусгах хэрэгтэй. Базараа чи надад итгэ. Өнөө шөнө дуусахад түүний зорилго биелэх нь гэж би маш сайн мэдрээд байна. Магадгүй миний юмсыг тааж мэдэх болсон энэ чадвар өнөөдрийн өдөрт зориулсан бурхны хишиг байж ч мэдэх юм. Ямартай ч бидэнд гарах зам

байхгүй. Би бага байхдаа өөрийн мэдэлгүй надаас огтхон ч шалтгаалахгүй байдлаар юмсыг зөгнөх чадвартай болсныхоо дараа нэг ном олж уншсан. Тэр ном бол бидний өвөг дээдсээс үлдээсэн хувь тавилангийн ном байсан гэж одоо бодож байна. Түүн дээр бичсэнээр бол муу ёрын чөтгөрийг үгүй хийхээс нааш хүний санаанд багтамгүй араатнууд үй олноор болж үржсээр байх болно гэсэн байсан. Тийм болохоор бид алиалагчийг заавал олж устгах хэрэгтэй.

-...Баттөмөр өө, би чамайг, чиний чадварыг чинь үнэлж хүндэлдэг л дээ. Гэхдээ тийм хүнийхээ амнаас ийм үг сонсож байгаадаа жаахан харамсаж байна. Яагаад гэвэл чиний наад яриад байгаа зүйлд үнэмшилтэй зүйл юу ч алга. Тэгээд бас хаа хамаагүй өнгөрөн одсон номын тухай ярьж байгаа чинь чамайг эрүүл биш байгааг илтгэж байна. Чи зүгээр л шоконд орчихож. Амьд хүнийг ямар ч өчиггүйгээр тасар татан идэж байгаа энэ махчин адгууснуудаас болоод оюун санаа чинь хямарчихсан бололтой.

-Үгүй ээ, битгий ингэж ярь. Миний оюун ухаан урьд урьдынхаасаа илүү сэргэг, цовоо байна. Чи надад итгэхгүй байгааг чинь би ойлгож байна аа. Мэдээж хэн ч байсан амархан итгэхгүй. Чи энэ хараал идэж өмхий ханхалсан балгаснаас гарахыг хүсч байна. Гэхдээ гарч чадахгүй. Нар мандаж алиалагчийн зорилго биелэхээс нааш үүдэн дээр овоорч байгаа аймшигт адгууснууд арилж үгүй болохгүй. Чи надад итгэ, Базараа

-Үгүй ээ, харин чи надад итгэ. Бид хоёр эндээс хамтдаа эсэн мэнд гараад цагдаагийн, тусгай ангийн нэмэлт хүч дуудаж энэ балгасанд орогнож байгаа махчин амьтдыг үгүй хийнэ. Тэгээд бас энэ галзуу солиотой яриагаа надад дахиж битгий яриараа мэдэв үү чи. Би энд галзуу хүний яриаг сонсох гээд байж байгаан биш. Өөр юу ч битгий ярь, дахин намайг битгий ятга. Би зургаан жилийн турш хамтран ажиллаж байсан гурван ч найзыгаа ердөө хагас цаг ч хүрэхгүй хугацаанд алдлаа, бүр эднийхээ яаж үхэж байгааг ч үзлээ. Энэ надад хангалттай, гүйцээ

-Чи бага ангийн сурагч байхдаа ээжийгээ өнгөрөхөд ганц ч дусал нулимс унагаагүй. Бусад хүмүүс бүгд уйлж байсан болохоор чи санаа зовсондоо сэмхэн шүлсээрээ нүдээ норгож байсан. Чи арван зургаан настай байхдаа аавынхаа түрийвчинд байсан бүх мөнгийг нууцаар аваад аавдаа ахыгаа тэр мөнгийг авсан гэж худлаа хэлсэн. Ахыг чинь аав чинь мартахын аргагүй болтол нь шийтгэсэн. Чи тэр явдлаас хойш ахтайгаа муудалцаж, улмаар тэр явдалдаа насан туршдаа харамсдаг болсон. Тэр үеэс хойш чи өнөөдрийг хүртэл ахтайгаа харьцаагаа сайжруулж чадаагүй л байгаа. Чиний анхны эмэгтэй бол дээд сургуулийн чинь багш байсан. Чи тэр явдлаас болж ичсэндээ долоо хоног хичээлдээ яваагүй. Тэгээд өөр сургуульд орохоор шийдэж цагдаагийн академид элссэн. Гэхдээ аавынхаа найзын тусламжтайгаар ямар нэг шалгалтгүйгээр тэр сургуульд орсон. Энэ бүхэн бол чиний хэнд ч хэлээгүй нууц. Бүр зүүдэндээ ч ярьж байгаагүй тийм нууц. Бас чи хань ижилтэй болж чадахгүй байсаар өтлөх вий гэж дандаа айдаг. Энэ мэтчилэн би чиний тухай их олон зүйлийг мэдэж ярьж чадна. Базараа чи ойлгож байна уу. Би мэдрээд байна. Миний оюун ухаан хэвийн ажиллаж байгаа болохоор огтхон ч зовох юмгүйгээр чиний амьдралын нууцуудыг чинь нэрлэж байна. Үүнээс ч илүүг ярьж өөр олон юмыг тоочиж чадна. Эцэст нь дахиад хэлье. Би бүгдийг нь мэдэж байна. Гагцхүү чи л надад итгэ. Надад чиний туслалцаа хэрэгтэй, бас үүнээс гадна чи эндээс амьд мэнд гарч чадахгүй гэдэгт би зуун хувь итгэлтэй байна. Одоо эндээс бид хоёр

гарахаасаа өнгөрсөн. Ямар ч байсан алиалагчийг үгүй хийхээс нааш

Баттөмөрийн энэ үгний хариуд Базараа юу ч хэлж чадсангүй. Баттөмөрийн саяын хэлсэн бүх үгнүүд маргахын аргагүй үнэн болохоор Базараа яах ёстойгоо мэдсэнгүй. Саяын Баттөмөрийн хэлснийг өөрөөс нь өөр хэн ч мэдэхгүй гэтэгт тэрээр тангараглахад ч бэлэн байсан. Гэтэл тийм биш байж, үгүй ээ өөрөөс нь өөр хэн ч мэдэхгүй гэдэг нь үнэн. Гэхдээ зөвхөн Баттөмөр л өөрийнхөө нөгөө онцгой чадвараараа мэдсэн хэрэг байх нь. Базараа баахан тээнэгэлзэж зогссоор эцэст нь “Одоо хоёулаа тэгээд яах ёстой вэ?” хэмээн арайхийн дөнгөж дуулдах төдий аяархан шивнэж хэллээ.

-Алиалагчийг олоод тэгээд зүйл дуусгана. Чи надад туслаач. Хэрвээ тэр муу шулмыг үгүй хийж чадлаа гэхэд надад хэн ч юу ч өгөхгүй. Тэгсэн хэрнээ надад түүний хийх муу бүхнийг зүгээр хараад суух эрх байхгүй. Миний хувь тавилан бол түүнийг зогсоох. Тэр хүн төрөлхтний урилгагүй зочин алиалагчийг амиа золиод ч хамаагүй ирсэн газар луу нь буцаах

-Бид хоёрт эндээс гарах боломж үнэхээр байхгүй юу?

-Байхгүй. Хэрвээ тэгвэл бид хоёр үхнэ. Базараа чи надад итгээрэй, гуйж байна. Харин урагшаа яваад байх юм бол үхэхгүй байж мэднэ. Алиалагчийг устгахыг хичээж байгаа тохиолдолд бурхан харж үздэг. Харин шантрах юм бол мартчихдаг гэхэд болно. Энэ үнэн юм шүү. Миний ярьж байгаа бүхэн ганцхан галзуу хүний амнаас л гардаг байх гэмээр сонсогдож байгаа. Гэхдээ л чи итгэ

Гэрэл муутай сүүмгэр харанхуйд Базараагийн царайд Баттөмөрийн үгэнд итгэж байгаа шинж тэмдэг тодорч эхэллээ.

-Ойлголоо, гэхдээ л тэр алиалагч энэ балгасын хаа нэгтээ байгаа болов уу?

-Тийм ээ, байгаа

-Чи итгэлтэй байна уу?

-Тэгэлгүй яахав. Хэрвээ тэр шулам энд байхгүй байсан бол энэ махчин үхдлүүд энд байхгүй байх байсан. Энэ махчид алиалагчийг хамгийн эмзэг сул үед нь сахин хамгаалдаг. Тэр алиалагчид ямар нэгэн сул тал байдаг болохоор л өөрийгөө ингэж хамгаалуулсан байх. Сүүлийн нэг сарын туршид алга болсон бүх хүмүүс зөвхөн энд л байгаа. Энэ хүмүүсийг алиалагч ийм болгосон. Тэдний өлсгөлөн чанарыг нь ашиглаж өөрийгөө хамгаалуулж байна. Бас ямартай ч энэ новшийн махчин амьтад энэ өмхий балгаснаасаа гардаггүй бололтой. Өөрсдийгөө идээд ч хамаагүй энд байж алиалагчийг эмзэг дорой үед нь хамгаалдаг биз. Тийм ээ, яг энэ л надад итгэл төрүүлж байгаа юм. Алиалагч тодорхой хэмжээгээр айж болгоомжилж байна. Энэ чинь түүнийг ямар нэгэн сул талтай гэдгийг хэлээд байгаа хэрэг. Харин одоо түүнийг ямар нэгэн сул талтай гэдгийг хэлээд байгаа хэрэг. Харин одоо түүнийг хурдхан олох л хэрэгтэй.

-Чи нөгөө өөрийнхөө далдыг хараад байдаг чадвараараа алиалагчийг олчихож болохгүй юм уу?

-Яг алиалагч дээр ирэхээрээ л би юу ч хийж чадахгүй болчихоод байгаа юм. Тэр новш чинь аймшигтай ховсдох чадвартай. Тэгээд өөрийгөө миний мэдрэмжээс хамгаалж чаддаг. Чамд хамгийн ойлгомжтой үгээр хэлэхэд ингэж л тайлбарлах байна. Харин одоо Базараа, хоёулаа энэ балгасны хамгийн цаад мухар хүртэл нэгжиж үзээд алиалагчийг олох болно.

-Тэгвэл юугаа хүлээсэн юм. Явцгаая, тэгээд ядаж алагдсан найзуудынхаа үхлийг утга учиртай болгоё хэмээн Базараа нэлээд шийдэмгий дуугарлаа.

-Тийм ээ, Базараа чи зөв ярьж байна. Хоёулаа хамтдаа байхад тэр муу алиалагчийн учрыг олж дөнгөх байх бас Ганбаярыг ч аврах хэрэгтэй.

## ТӨГСГӨЛ

Баттөмөр, Базараа хоёр тэмтэчсээр түрүүн алдсан гар чийдэнгээ хоёуланг нь олж авлаа. Базараад санаанд оромгүй эрч хүч нэмэгдэж, хамаг бие сэтгэл нь эр зориг, шийдэмгий байдлаар буцлан оволзох нь тэр. Одоо тэрээр зөвхөн Баттөмөрийн үгэнд итгэж ямар ч саад бэрхшээлийг даван туулж, алиалагчийн зүрхэнд сум зооход бэлэн болсон шиг санагдана. Магадгүй үнэхээр Баттөмөрийн хэлснээр алиалагчийг устгахаар зориг шулуудсан тэр мөчид бурхан эрч хүч өгч, авран ивээдэг бололтой.

Үхдэлийн үнэр ханхалсан харанхуй балгасан дотор гар чийдэнгийнхээ гэрлийг тусгасан хоёр залуу хонгилын төгсгөлд хүрэхээр яаран гүйлээ. Тэд хоёулаа баруун гартаа гар буугаа атгаж буудахад бэлэн гүйж явахдаа өнөөх махчин этгээдүүд хаанаас хүрээд ирэх бол хэмээн болгоомжлон булан тохой бүр лүү бүлтийтэл ширтэх аж. Тэдний замд тааралдсан хоёр махчинд Баттөмөр, Базараа хоёр ердөө ганц ганцхан сум зориулав. Ийнхүү Базараа Баттөмөр хоёр явсаар балгасны төгсгөл бололтой том хананы өмнө тулж ирлээ. Гар чийдэнгийн гэрэлд сэжигтэй зүйл юу ч өртсөнгүй. Энд хов хоосон бөгөөд өнөөх өмхий үнэр л үнэртэж өөр ямар ч мэдрэмж үл төрнө.

-Новш гэж, энд чинь юу ч алга. Чиний наад эргүү солиотой үгэнд итгэж байхаар хурдхан эндээс арилдаг байсан юм. Найзуудынхаа цогцсыг ч гэсэн эндээс хурдхан гаргах хэрэгтэй. Нэмэлт хүч дуудья, эндээс гарья ойлгов уу, Баттөмөрөө

-Ядаж өнөөх махчин этгээдүүд ч тааралдахаа больчихлоо.

-Хараал идмэр гэж. Баттөмөр өө, чи чинь одоо юугаа донгосоод байгаа юм бэ. Бид хоёрт тэр хурц соёотой махчин новшнууд шиг хэрэггүй юм байхгүй. Харин ч тааралдахгүй байгаадаа баярлах ёстой бишүү. Бид хоёрт хэрэгтэй юм бол ердөө энэ өмхий балгаснаас гарах хаалга.

-Базараа махчин амьтад харагдахгүй байна. Энэ чинь алиалагчид бусдаар хамгаалуулах шаардлага байхгүй болж байгааг хэлээд байгаа хэрэг бишүү. Алиалагч энэ балгасны хаа нэгтээ байсаар байгааг би мэдрээд байна.

-За больж үз. Одоо хангалттай. Чи наад галзуу яриагаа элдэв шашны цуглаан дээр хэлбэл таарна. Тэгвэл итгэх хүн олдож магадгүй. Гурван найзыгаа бусдад идүүлж байгааг өөрийнхөө нүдээр харсан хэрнээ би яагаад энэ хүртэл чамайг дагаж ирснээ огтхон ч ойлгохгүй байна.

Гүйцээ, чи наанаа үлдээд тэр гайтай алиалагчаа хайвал хай. Би ганцаараа ч хамаагүй явлаа. Энэ үгийг хэлсэн Базараагийн дууны өнгө өөртөө хачин итгэлтэй басхүү чамгүй ихээр цухалдаж байгааг нь илтгэж байв. Баттөмөр Базараад юу ч хэлсэнгүй. Зүгээр л Базараагийн зүг чийдэнгээ тусгаж харснаа буцаж эргээд өмнө нь хөндөлссөн чийг даасан тоосгон хана руу хар тэнхээгээрээ өшигчих нь тэр. Гэтэл уг хана Баттөмөрийн өшиглөсний аясаар цааш хонхойж шавар чулуу нурж эхлэв. Баттөмөр улам бүр идэвхийлэн өшигчиж мөрөөрөө хүчтэй мөрлөж гарлаа. Үүнийг харсан Базараа ч Баттөмөртэй хүч хавсран ханыг цөмлөж эхлэх нь тэр. Баттөмөрийн оюун ухаан нь энэ мөчид урьдынхаасаа илүү сонор соргог ажиллаж, бүх бие нь гайхалтай хүч тэнхээгээр сэлбэгдэн буцалж байлаа. Тэрээр цохиж, өшиглөх тусмаа улам бүр хүч орж өмнөх хана нь өм цөм бутарч байв. Энэ үед тэдний араас хэд хэдэн махчин амьтад дайрсан хэдий ч Баттөмөр огтхон ч эргэж харалгүйгээр баруун гартаа байгаа буугаар таван удаа буудаж бүгдийн нь тархинд сум зоолоо. Харин Базараа Баттөмөрийг гайхан биширсэн харцаар харж таг болон хөшиж орхижээ. Хана нэгмөсөн нурж уналаа. Үүр цайж эхэлсний дохиол болон балгасны хананы цоорхойгоор бага зэргийн гэрэл туссан байх бөгөөд хана нурж унах энэ мөчид Баттөмөрийн өөдөөс нэгэн булиа биетэй залуу дайрч ирээд мөргөж унагалаа. Тэрээр тэгмэгцээ нурж унасан хананы том хэлтэрхийг шүүрч аваад Базараа руу шидэж толгойг нь онов. Энэ бол Ганбаяр байлаа. Харин энэ хооронд нь Баттөмөр босч амжаад Ганбаярын нүүр лүү цохиж унагав. Тэгмэгцээ Баттөмөр нураасан хананы цаана алиалагч ямар ч хөдөлгөөнгүй инээмсэглэсэн мэт байдалтай сууж байгааг олж харлаа. Чамайг зүйл дуусгах цаг боллоо гэсээр Баттөмөр газарт алдсан буугаа шүүрч аваад алиалагчийг ямар ч өчиггүйгээр сүүлчийн хоёр сумаараа буудав. Алиалагчийн цээжинд энэхүү хоёр сум тухайн үедээ жижигхэн хар нүх гаргасан хэдий ч түүнийг харсаар байтал алга болж алиалагчийн бие хуучин хэвэндээ орлоо.

Харин хамгийн гайхалтай нь алиалагч огтхон ч хөдлөлгүй, сууж байгаа яг тэр газартаа байсаар байв. Энэ нь магадгүй өөрийнхөө хамаг цусыг өнөөх хийж байгаа хүүхэддээ юүлчихсэн болохоор хүч тамир нь барагдчихсан хэрэг биү хэмээн Баттөмөр таамаглаад амжлаа. Гэтэл энэ үед Ганбаяр босч ирээд Баттөмөрийг араас нь багалзуурдаж “өөртөө хамаагүй хэрэгт бүү оролц” хэмээн чихарсан хоолойгоор хэлэх нь тэр. Тэгмэгц Базараа ч босч очоод Ганбаярыг Баттөмөрөөс салгаж аваад газар унан ноцолдож эхэллээ. Баттөмөр ямар ч эргэлзээгүйгээр Базараагийн газар унагасан гар бууг шүүрч аваад алиалагчийн толгойд нь онилоод бүх сумыг нь дуустал буудлаа. Гэтэл мөн л түрүүчийн адил нүүрэнд нь жижигхэн хар нүх үүссэнээ төд удалгүй алга болох нь тэр. Гэгээ улам орохтой зэрэгцэн алиалагчийн бие илт сэргэж урт гар нь аажмаар хөдөлж эхэллээ.

Базараа Ганбаяр хоёр Баттөмөрийн ард хэн хэнийхээ дээр гарахыг хичээн хамга хүчээ шавхан зодолдож байх бөгөөд энэ үедээ Ганбаяр Тан нарын хэнд ч миний хүүг алах эрх байхгүй хэмээн шивэгнэх аж. Тэрээр алиалагчид бүр мөсөн ховсдуулчихсан бололтлй. Хэдий Базараагийн хувьд бие хамгаалах урлагийн мастер гардан тулаандаа тусгай ангийнхныхаа хамгийн сайн нь боловч хар хүчинд ховсдуулчисан Ганбаярыг яагаад ч хүчрэхгүй байв. Баттөмөр халааснаасаа жижигхэн тонгорог хутга гаргаж ирээд алиалагчийн өмнө гүйж ирмэгцээ хоолойд нь хамаг хүчээрээ чичсэн хэдий ч хутга алиалагчийн төмөр мэт арьсыг цоолж дөнгөсөнгүй. Харин алиалагч Баттөмөрийн зүүн гарын хоёр хуруунаас өрөөсөн гараараа атгаад авах нь тэр. Алиалагчийн бие улам хүчирхэгжин сэргэж байгааг Баттөмөр мэдрэв. Тэрээр хоёр хуруугаа алиалагчийн гараас салгах гэж хүчилсэн хэдий ч чадсангүй.

Тэгээд баруун гартаа атгасан хутгаараа алиалагчийн гарыг зүсч хамаг тэнхээгээрээ зоож үзсэн ч тус болсонгүй. Энэ янзаараа ингээд дахиад жаахан удвал алиалагч бүрмөсөн сэргэж нөгөө гараараа хамжаад намайг маш амархан үгүй хийчихнэ гэдгийг Баттөмөр мэдэж байлаа. Яаж ийж байгаад л эндээс мултрах хэрэгтэй. Гэтэл яг энэ үед алиалагчийн араас нэгэн үзээрийн муухай царайтай зэрэмдэглэгдсэн бие цогцостой жаахан хүү өндийж ирснээ балгаснаас гарах хаалганы зүг бүдчин алхахыг Баттөмөр олж харлаа. Алиалагч “Одоо чи яагаад ч нэмэргүй, бүх зүйл миний хүссэнээр болсон” гэх шиг Баттөмөр лүү инээмсэглэх мэт ширтсээр.

-Базараа наадахаа эндээс битгий гаргаарай. Алах хэрэгтэй хэмээн Баттөмөр хашхиран хэлээд дахиад л алиалагчийн гараас хуруугаа салгахаар идэвхийлэн ноцолдож эхлэв. Гэвч харамсалтай нь Баттөмөр тун удалгүй нэгэн аймшигтай дүр зураг олж харах нь тэр. Ганбаяр гартаа том тоосго атгаад Базараагийн толгой руу хайр найргүй цохиж байлаа. Басхүү тэрээт хамтран ажилладаг байсан найзынхаа толгойг ийнхүү бяц цохин алж байхдаа “Миний хүүг алахыг санаархсан хэнийг ч би өршөөхгүй” хэмээн амандаа үглэж байх нь тэр.

Базараагийн хувьд ямар ч өчигдггүйгээр үхсэн нь тодорхой болжээ. Саяхан л Ганбаярын нүүрэнд хэд хэдэн тэмдэг үлдээж амжсан түүний булиа гар ямар ч хөдөлгөөнгүй гулдайн хэвгэнэ. Баттөмөрийн хоолойноос гинших мэт дуу гарав. Түүний сэтгэлд харамсал гомдлын гал асар хүчтэйгээр дүрэлзэн асаж аль хэдийн үхсэн Базарааг тоосгоор цохисоор байгаа Ганбаярын зүг халаглаж харамссан харцаар ширтэх аж. Баттөмөр одоо яах ёстойгоо мэдсэнгүй. Түүний өнөөх гайхалтай мэдрэмж чадвар, хүч чадал, зориг тэвчээр бүхэн өөрийг нь нэгмөсөн орхин одсон мэт сэтгэгдэл төрүүлнэ. Алиалагчийн нялцгар хүйтэн гар түүний хоёр хурууг нь ямар ч хөдөлгөөнгүйгээр тас атгачихсан байгаа нь Баттөмөрийг аргагүй хүнд байдалд оруулж байлаа. Өнөөх алиалагчийн “бүтээсэн” муу ёрын эрэмдэг “амьтан” балгаснаас гарахыг санаархаж байгаа бололтой ганц нэг гишгэлэн улам холдсоор байв. “Новш гэж би яарах хэрэгтэй, чөтгөрийн хүүг холдож алга болоод бие нь бэхжиж хүчирхэгжихээс нь өмнө тонилгох хэрэгтэй” гэсэн бодол Баттөмөрийг эзэмдлээ. Гэвч би яаж алиалагчийн гараас мултрах билээ. Ингээд байсаар байвал өөрөө үхэд ч зогсохгүй алиалагчийн хүүг эрх чөлөөтэй орхиж ертөнцийг шулмын гарт алдсан гэм нүглийн гол эзэнг нь би болох болно. Тиймээс өөрийгөө эрэмдэглээд ч хамаагүй алиалагчаас мултарч амилуулсан хүүг нь алах хэрэгтэй. Түүнд алиалагчийн гараас салахын тулд гар нь тэр дундаа долоовор дунд хоёр хуруу нь саад болж байв. Ийнхүү Баттөмөр өөртэйгөө бодлоороо ярилцаад цаг алдах эрх байгаагүй учир тэрээр эцсийн шийдвэрээ гаргалаа.

Баттөмөр өнөөг хэр нь баруун гартаа атгасаар байгаа хутгаа нэг харснаа ямар ч эргэлзээгүйгээр алиалагчид атгуулсан хоёр хуруугаа угаар нь тас огтлохоор хутгаараа зүсч эхэллээ. Долоовор дунд хоёр хуруу нь тийм ч амар тасарсангүй. Арьс, мах, шөрмөс, яс нь ээлж дараалан тасарч, үгээр хэлэхийн аргагүй өвдөж байсан хэдий ч Баттөмөр үйлдлээ зогсоосонгүй. Тэрээр үнэхээр хэзээ нэгэн цагт өөрийгөө ийнхүү эрэмдэглэнэ чинээ санаагүй билээ. Бусдын гарт эрэмдэглүүлсэн бол яая гэхсэн, гэтэл энэ удаа бол Баттөмөр өөрөө өөрийгөө ямар ч мэдээ алдуулах эм тариагүйгээр тасчиж байх нь тэр.

Баттөмөр цусаа савируулан “Би чадахгүй нь ээ” хэмээн муухай хашхирч байсан ч энэ үйлдэл нь хамгийн зөв цагаа олсон хэрэг байсан гэдгийг дотоод сэтгэлдээ мэдэж байлаа. Өвдөлт



үнэхээр тэсэхүйеэ бэрх байгаа ч өөрөө өөрийгөө ингэж эрэмдэглэхээс нааш Баттөмөр алиалачгийн гараас мултарч чадахгүй байсан билээ. Баттөмөрийн нүд нь харанхуйлж өвдөлтөөсөө болон хариугүй ухаан алдах дөхөв. Гэвч түүнд бурхан тусалсан уу, эсвэл өөрийн нь зориг тэвчээр нөлөөлөв үү, ямартай ч хоёр хөл дээрээ тогтож тэнцээд, өнөөх холдон одсоор байгаа алиалагчийн хүүгийн хойноос гар дахь хутгаа улам чанга атган бүдчин гүйв. Харин алиалагчийн бие мэдэгдэхүйц хөдөлгөөнд орж Баттөмөрийн цус дуслуулсан хоёр хурууг атгасаар хоцров.

Баттөмөрт тохиолдох гай дууссангүй. Түүний замд Ганбаяр хөндөлсчээ. Тэрээр үзэн ядалтаас өөр зүйлгүй улаанаараа эргэлдсэн аймшигтай нүдээр Баттөмөрийн зүг ширтэж “Чи бас үхмээр байна уу” хэмээн Базарааг цохиж алсан том тоосгоо өндөрт өргөв. Тэгмэгц нь Баттөмөр түүний эрүү рүү хар тэнхээгээрээ амжиж мөргөөд тэнцвэр алдмагц нь зөрж гүйлээ. Гэсэн ч Ганбаяр Баттөмөрийн хөлнөөс зуураад үлджээ. Хэдий Ганбаяр аманд соёо ургаж хараахан амжаагүй байсан ч тэрээр угаас чадал ихтэй, булиа нэгэн болохоор өөрийгөө эрэмдэглэж, үхлээ ядарсан Баттөмөрийг ядах юмгүй дарж унагалаа. Тэрээр Баттөмөрийн хутгатай баруун гарыг бугуйгаар нь атган газарт хөдөлгөөнгүй дарж “одоо чамайг ална аа” хэмээн баруун гартаа атгасан чулуугаа өргөв. Баттөмөрийн нүүрэнд чулуу бараг тулж ирэх үед тэрээр арга буюу хоёр хуруугүй болсон эрэмдэг гараараа цохилтыг орь дуу тавин хашхирав. Түүнд дараачийн цохилтоос өөрийгөө хамгаалах ямар ч хүч үлдсэнгүй.

-ганбаяр аа, ухаан орооч. Би Баттөмөр байна шүү дээ. Наад солиорлоо зогсоогооч, гуйя Түүний энэ үгэнд Ганбаяр хариу хэлсэнгүй. Тэрээр дахин цохихоор тоосго атгасан гараа далайлаа. Энэ үед Баттөмөр хэдий зүгээр л өөрийгөө үхэхэд бүх зүйл дуусчих байсан бол ямар ч эсэргүүцэлгүйгээр тоосгоны цохилтыг нүүрээрээ угтах байсан биз. Гэвч түүнд ядаж үхэх ч эрх байсангүй. Баттөмөрийн үхлийн ард хүн төрөлхтний хувь заяа байлаа. Чухам тийм л учраас тэрээр өөртөө байгаа бүх хүчээ эцсийн удаа шавхан өндийж ганбаярыг цохихоос урьтан нүүр лүү нь духаараа мөргөв. Түүний энэ мөргөлт Ганбаярт маш хүчтэйгээр туссан бололтой арагшаа гэдийж, гартаа атгасан тоосгоо газарт алдах нь тэр. Баттөмөр өнөөг хэр нь өөрийн нь хутгатай баруун гарыг дарсаар байгаа Ганбаярын зүүн гарын шуунаас үүдэн шүдээрээ хүчлэн хазлаа. Ийнхүү сая нэг Баттөмөрийн гар суларч хөдлөхтэйгээ болоод ирмэгц Ганбаяр гараасаа алдсан тоосгоо авах гэж өндийхдөө буцаад хальтирчихав. Тэгэхдээ Ганбаяр яг Баттөмөрийн гартаа атгасан хутган дээр цээжээрээ дараад уначих нь тэр.

Ганбаярын амнаас гинших мэт бөглүү дуу гарснаа хамаг бие нь салганан чичирхийлж эхэллээ.

-Ганбаяр аа, чи зүгээр үү? Чи ... зүг...

Баттөмөрийн дуу тасалдаж өөрийн эрхгүй мэгшин уйлж байлаа. Хэдий өөрийг нь алахыг завдаж байсан ч түүний хувьд ямартай ч хамгийн сайн багын найзаа хөнөөхийг хүсээгүй билээ. Ганбаяр өөрөө хутган дээр цээжээрээ даран унасан ч гэлээ тэр хутгыг Баттөмөр гартаа барьж байсан болохоор аргагүй харамсан халаглаж байв. Амь тавьж буй Ганбаяр Баттөмөр лүү харахад түүний нүдэнд байсан өнөөх үзэн ядалт, уур хилэн ор мөргүй арилж хорь гаран жил нөхөрлөж яваа найзын нь зөөлөн дотно харц эргэж ирсэн байлаа.

-Ганбаяр аа, миний найз үхэж болохгүй шүү. Битгий үхээрэй, гуйж байна. Дуулав уу, чи яасан

ч үхэж болохгүй

-...Баттөмөр өө...чи..

-Юу гэнэ ээ. Ганбаяр аа, дахиад хэл. Найз нь чамайг орхихгүй, хоёулаа одоо эндээс цуг гарна.

-Үгүй ээ...Баттөмөр өө. Би гарахгүй, гарч ч чадахгүй. Харин чи тэр алиалагчийг үр үндэстэй нь хамт заавал устгаарай. Энэ хамгийн чухал гэдгийг чи өөрөө мэдэж байгаа.

Ганбаяр ийнхүү үгээ арай ядан зөөж хэлснээр нүднийх нь амьдын гал цог аажмаар унтарч зүрхнийх нь цохилт зогслоо.

- Ганбаяр аа чи сэрээч дээ. Дуулж байна уу, сэрээч. Үхэж болохгүй, үхэх болоогүй. Чамайг үхчихвэл Тамир яах болж байнаа. Чи үхэж болохгүй, ойлгохгүй байна уу...

Баттөмөр найзынхаа амьгүй болсон цогцсыг тэврэн хэдэн хором саатсанаа тун шийдэмгийгээр босч өнөөх алиалагчийн эвлүүлсэн хүүгийн араас хар хурдаараа гүйлээ. Энэ үед Баттөмөрийн ой ухаанд өнөөх бага насандаа санамсаргүй уншиж байсан номын мөрзэд дахин үзэгдэх шиг болох нь тэр. “Амилсан шулмын эвлүүлж бий болгосон үр үндсийн амин газар нь шилэн хүзүү нь” гэсэн тэр тэмдэглэгээ яг цагаа олж Баттөмөрийн санаанд буулаа.

Өнөөх хиймэл жаал гарах хаалга руу нэлээд дөхчихжээ. Баттөмөр түүний араас гүйцэж очоод ямар ч эргэлзээгүйгээр гартаа атгаж яваа хурц хутгаа шилэн хүзүүнд нь ишийг нь тултал зоолоо. Чихарсан муухай хашхираан чихнээ хадаж алиалагчийн хүү татваганан тийчилсээр амь алдав. Гэтэл нэгэн аймшигтай маш хүчтэй гар Баттөмөрийн мөрнөөс өргөж хана руу саван шидэх нь тэр. Тэрхүү айшигтай хүчтэй этгээд бол алиалагч байлаа. Тэрээр бүрэн сэхээ авчихжээ. өөрийн нь хоёр сарын турш арайхийж эвлүүлсэн хүүг нь хэдхэн хормын хугацаанд үгүй хийчихсэн Баттөмөрийг тэрээр угтаа тултал үзэн ядаж байгаа. Харанхуй гүн ангалыг санагдуулам өтгөн хар нүдээрээ Баттөмөрийг цоргитол ширтсээр урт нарийхан хэлээ гозолзуулан дөхөн ирж буй алиалагчийг харсан хэн ч байлаа аргагүй зүрх алдмаар аймшигтай харагдах аж. Баттөмөр хананд хүчтэй савагдсанаасаа болж ухаан нь балартан нүд нь харанхуйлж цээжинд нь цус амтагдаж байв. Хүчтэй доргилтоос болж түүний халаасанд явсан өнөөх цэвэр усных нь нэг нь бут үсэрчихжээ. Сав нь хагарч цацагдсан усны зарим дуслууд алиалагчийн биед хүрэхэд писс сс... гэсэн чимээ сонсогдон шатаж буй мэт уур гарах нь тэр. Алиалагч яг л галд түлэгдсэн мэт эмзэглэн цочирдож хэдэн алхам ухарчээ. Баттөмөр энэ бүх хугацаанд балгасанд орж ирэхдээ халаасласан цэвэр усаа бүр мартаж орхисон байв. Тэрээр гэнэт нэг зүйл ойлгож бас нөгөөг санах шиг болов.

Алиалагч уснаас айдаг байх нь. Тийм ээ, яг тийм байна. Өнөөх номон дээр бичсэнээр “Бороотой үед амилсан шуламд орогнох газар хэрэгтэй гэсэн байсан” Гагцхүү энэ нь л алиалагчийн үхлийн шалтгаан байх нь. Бууны сум, хутганы ирэнд үхдэггүй алиалагчийн амь зүгээр л бидний ундандаа хэрэглэдэг ус байх нь ээ. Бас түрүүчийн удаа халз тулгарахдаа крантнаас ус цацагдахад л зугтсан хэрэг байна шүү дээ. Баттөмөр бүхнийг ойлголоо. Галын өрөөний крант хагарч ус цацагдсан нь түрүүчийн удаад Баттөмөрийг аварсан байж. Тэгвэл энэ удаа ч гэсэн түүний халаасанд байсан савгай цэвэр ус өөрийг нь алиалагчаас аварчээ. Баттөөр өөртөө байгаа хамаг хүчээ шавхан байж өндийгөөд халаасандаа байгаа савгай цэвэр

усаа гаргаж гурван хуруутай гараараа тагийг нь арайхийж онгойлгов. Энэүйдэл нь яг л анчин бугаа сумлаж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх нь тэр. Баттөмөрийн бие энд тэндгүй шалбаран халцарч толгой хацар, ам бас хоёр хуруугүй болсон гараас нь цус урссаар байлаа. Гэсэн хэдий ч тэрээр шүд зууж усаа гартаа атгасаар алиалагч руу алгуурхан ойртож байв. Харин өндөр биетэй алиалагч Баттөмөрийн довглохыг хүлээн доошоо үл мэдэг бөгтийж хярсан мэт байдалтай байх нь яг л амиа хамгаалах гэсэн араатныг санагдуулах аж. Баттөмөр гартаа барьсан уснаасаа ам руугаа нэг балгалаа. Гэхдээ маш ихээр цанган сурьдаж байсан ч цааш нь хоолой руугаа залгисангүй. Гэтэл яг энэ үед алиалагч маш хурдтайгаар үсэрч ирээд Баттөмөрийн гартаа атгасан усыг цохиж алдуулан дээрээс нь дарахад Баттөмөр аман дахь усаа бүгдийг нь алиалагчийн нүүр лүү тургичихав. Энэ гэнэтийн хариу үйлдэлд алиалагч аргагүй цочирдож арагш холдох гэсэн хэдий ч Баттөмөр түүний үснээс нь амжин зуураад авав. Тэгмэгцээ тэрээр хажууханд нь асгараад бараг дуусч буй савтай усаа гурван хуруутай гараараа шүүрч аваад хэл нь гозгонон чарлаж байгаа алиалагчийн ам руу цөмийг нь цуггачихав.

Алиалагч амьдаараа шаруулж байгаа этгээд л ингэх болов уу гэмээр татваганан тийчилж байснаа хамаг арьс нь буцлан язраад газар урсаж эхэллээ. Чих дөжрөм чихарсан муухай хашхираан гурван минут хэртэй үргэлжилсний эцэст таг чимээгүй болов. Алиалагч үхжээ.

...Баттөмөрийн нүд нь харанхуйлж тархи нь манараад, ухаан нь балартаж байв. Тэрээр гэрэл тусч буй гарах хаалганы зүг эцсийн хүчээ шавхан мөлхөх аж. Түүний нүдэнд Одончимэг нь өөрийн нь бэлэглэсэн бөгжийг гартаа зүүгээд оюутан ахуй үеийнхээ яг тэр төрхөөрөө угтан инээмсэглэж байгаа харагдана. Бас ээж эмээ хоёр нь ч харагдах шиг. Модон хайрцганд орж ар араасаа газарт булуулсан эрхэм хайртай хоёр хүн нь ямар ч өвчин зовиургүй тэнгэрлэг сайхан царайгаар Баттөмөрийн зүг тайван мишээж, түүнийг дуудаж байлаа. Тэд яг л Баттөмөрийн бага насанд нь хамт байсан тэр л царайгаараа хэвээрээ байх бөгөөд Баттөмөр өөрөө ч гэсэн хүүхэд ахуй насныхаа зовлон зүдгүүргүй тэр гэгээн үедээ очсон мэт. Тэнд бас Ганбаяр харагдлаа. Сурагчийн хөх өнгийн дүрэмт хувцастай сахилгагүй жаахан хүү яг дүрээрээ өөртэй нь тоглохоор хүлээж байх бөгөөд энэ бүхэн цөм гэрэл гэгээтэй тайван орчинд байгаа нь Баттөмөрийг эрхгүй яаруулж байв. Тэрээр өмнө нь бүх л үеийн туршид зөвхөн харанхуйд бэдчин тэнүүчилж айн зугтаж харанхуй орчноос гэрэл гэгээг мөрөөдөж зүүд нь хүртэл харанхуйн дунд өнгөрдөг байжээ. Харин одоо түүнийг гэрэл гэгээтэй орчин хүлээж, хайртай дотно бүх хүмүүс нь аз жаргалтайгаар угтаж байна.

...Баттөмөр дөнгөж саяхан өвдөлтөөсөө болон тарчлан зовж гарах хаалга руу эцсийн хүчээ шавхан тэмүүлж байсан бол одоо ямар ч өвчин мэдрэхээ больчихож. Тэрээр аз жаргалтай зүүдээ үргэлжлүүлэн зүүдлэхийг хүсчээ. Магадгүй түүнд зовлон шаналгаа, айдас түгшүүрээр дүүрэн амьдрал залхмаар санагдсан ч байж мэдэх. Басхүү “Өөрийнхөө үүргийг биелүүлчихсэн юм чинь...” гэсэн бяцхан омгорхол цохилт нь суларсаар буй зүрхэнд нь асах шиг болно.

...Балгасны үүдэн дээрх тоос шороо, шарх сорви, цус хөлсөөр нэвчсэн Баттөмөрийн амьгүй цогцос өглөөний наранд яг л тайван унтаж байгаа жаахан хүүхдийг санагдуулам инээмсэглэх мэт байдалтай харагдах аж.

Тэргүүн сонины 2006 оны 7-р сарын дугааруудад гарсан сонирхол татахуйц мэдээллүүдээс....

...Хуучин Орос цэргийн хуаран байсан эзгүй балгасанд ямар нэгэн аймшигтай үйл явдал болсон бололтой. Ямартай ч энэ талын мэдээллийг холбогдох байгууллагууд маш ихээр чандлан нууцалж байгаа бөгөөд цагдаа, цэргийн өндөржүүлсэн хамгаалалттайгаар хөл хорио тогтоожээ. Энэ учир битүүлэг, нууц үйл явдлын талаар холбогдох байгууллагынхаас бусад хүмүүс зөвхөн таамаглал дэвшүүлэхээс өөрөөр юу ч хэлж чадахгүй байна.

...Хүүхдийн баярын өдрөөр “Алиалагч”-д хулгайлагдаж улмаар алагдсан хүүхдийн эцэг эхүүд болон алиалагчтай нүүр тулсан бүх хүмүүс зуурдаар нас барж байгаа нь тодорхой байна. Хэдийгээр энэ талын мэдээллийг олон нийтэд зарлахгүй байх зохион байгуулалттай ажил хийгдэж байгаа ч манай сэтгүүлчийн уйгагүй судалгааны ажлууд энэ бүхнийг баталж байгаа юм.

Сэтгэцийн эмнэлэгт эмчлүүлж байсан Долгормаа бүсгүй /алагдсан хүү Баяртын ээж/ ямар нэгэн муу ёрын шуламсын тухай зогсолтгүй ярьсаар эцэст нь амьсгал хураасан. Мөн “Алиалагч”-д алагдсан гэх хүү Мөнхзоригийн ээж Тамир бараг арваад хоног гэрээсээ гараагүйучраас орцных нь жижүүр гайхаж очоод шалгавал гэрийн нь хаалга нээлттэй байсан бөгөөд шалан дээрээ үхчихсэн байдалтай олдсон.

...Алиалагчийн зургийг дарсан цорын ганц зурагчин эр мөн л амиа хорлочихсон. Тэрээр шөнө болгон зүүдэндээ ямар нэгэн ад зэтгэрийн шулмаас өршөөл гуйн уйлан дуугардаг байсан гэх.

...Тусгай ангийн дарга, цагдаагийн хошууч Базар болон түүнтэй хамт алиалагчийг мөрдөж байсан туслах ажилтнууд болох дэслэгч Хүрэлчулуун, дэслэгч Болдбаатар, ахмад Батсүх нар “Үүргээ биелүүлж яваад амь эрсдсэн. Уг дөрвөн залууд хэдий өнгөрсөн ч гэсэн хүндэтгэл үзүүлж бүгдийг нь цол тэмдгээр нөхөн шагнаж байна” гэснээс өөр илүү тодорхой мэдээллийг цагдаагийнхан хийхгүй хэвээр л байна.

...Зарим нэгэн хүмүүсийн таамаглаж байгаагаар алагдсан хүү Мөнхзоригийн аав Тамирын нөхөр болох ахлах дэслэгч Ганбаяр “хүүгийнхээ өшөөг авахаар алуурчны хойноос мөрдөж байгаад алагдсан” гэх. Ямартай ч ахлах дэслэгч Ганбаяр хэдий эхнэр нь өнгөрсөн ч гэсэн ч оршуулах ёслолд ирсэнгүй, бусдын нүдэнд өртсөнгүй, ор сураггүй хэвээр байна.

...Өмнө нь маш олон хэргүүдийг илрүүлж байсан туршлагатай, хувиараа мөрдөгч, хотын хүндэт иргэн Баттөмөр Ганбаярын нэгэн адил ор сураггүй алга болжээ. Алга болоод байгаа ахлах дэслэгч Ганбаяр түүний арван жилийн нь дотнын найз гэдгийг зарим эх сурвалжууд мэдээлж байгаа. Зургаан настай хүүхдүүдийн эрлэг болсон алуурчин алиалагчийн араас тэднийг хамтдаа хөөцөлдөж байгаад эрсдсэн байж магадгүй хэмээн олон хүмүүс таамаглаж байна. Тэднийг эрж хайх ажлын талаар цагдаагийнхан сэтгүүлчдэд ямар ч тайлбар өгсөнгүй. Үүний цаана ямар нэгэн далд хэрэг, учир шалтгаан байгаа гэдэг нь дамжиггүй.

... Алиалагчийг харсан хүмүүсээс цорын ганцаараа амьд үлдсэн хүү Тулгаа Эх нялхсын эмнэлгийн сэхээний тасагт эмчлүүлж байна. Түүний биеийн байдлыг дээрдэж сайжирна гэж эмч нар амлаж чадахгүй байгаа бөгөөд ямартай ч хэрвээ Тулгааг ухаан орвол энэхүү учир битүүлэг олон хэргүүдийн зангилаа тайлагдаж мэдэх юм. Учир нь тэрээр ор сураггүй алга болоод байгаа хувиараа мөрдөгч Баттөмөрийн хууль ёсны өв залгамжлагч нь болсон. Үүнийг Баттөмөрийн найз өмгөөлөгч Гэрэлчулуун баталж байна. 2006.07.01-ний шөнө Баттөмөр

түүн рүү утасдаж “Хэрвээ надад ямар нэгэн юм тохиолдвол миний нэр дээрх бүх эд хөрөнгө өнөө шөнө манайд хонож байгаа Тулгаа хүүд шилжих ёстой” хэмээн зааварлаад энэ бүхнийг хүлээн зөвшөөрч байгаагаа баталсан өөрийн гарын үсэгтэй захиаг унтлагынхаа өрөөний ширээн дээр орхижээ.

Тэргүүн сонины 2006 оны 8-р сарын нэгэн дугаарт

...Хотыг айдаст автуулаад байсан алиалагчийн талаар ямар ч сураг дуулдалгүй сар гаруй хугацаа өнгөрлөө. Гэмт хэргийн гаралт ч эрс багасаад ор сураггүй алга болох явдал зогсч хэвийн хэмжээндээ хүрчээ. Хувиараа мөрдөгч асан Баттөмөрийн өв залгамжлагч болсон Тулгаагийн бие дээрдэх төлөвтэй байгаа тухай эмчлэгч эмч нь мэдэгдэл хийсэн. Ямартай ч одоогийн байдлаар бүрэн ухаан ороогүй байгаа.

Өнөөг хүртэл хөл хорио тогтоосон хэвээр байгаа цэргийн хуаранд байсан балгасанд чухам юу болсон, Баттөмөр Ганбаяр нар хаашаа явчихаад эргэж ирээгүй вэ? Алиалагч үхсэн үү? Гэх зэрэг олон асуултын хариуг сонсохыг хүссэн мянга мянган хүмүүс Тулгааг сэхээ ороосой хэмээн залбиран хүлээсээр...

**Төгсөв**

## СҮҮЛЧИЙН ХҮЧ

Зуны аагим халуун өдрүүд эхэлжээ. Их хот улам бүр хаяагаа тэлж, хотын нүсэр их дуу чимээ, бохир агаараас зугтах гэсэн айл өрхүүд лагерийн тансаг байшингууд хотын захад барьж эхэлсэн тэр үе. Дэжид эмгэн нас дээр гарч элдэв хууч өвчинд баригдсаар дээрдэхээсээ нэгэнт өнгөрчээ. Харж хандах, тулж түших ах дүү, үр хүүхэдгүй тэрээр харин хур их хөрөнгө хурааж чадсан нэгэн. Идэр залуу насандаа хэд хэдэн нөхөр солиод амжсан ч үр хүүхэд заяасангүй билээ. Чухам энэ л үедээ Дэжид эцэг эхдээ хөсөр хаягдсан улаан нялзрай өнчин охин үрчилж авсан нь эдүгээ 22 нас хүрч байгаа аж. Дэжидийн үрчилж авсан охиныг Зулаа гэх бөгөөд хадамж гарч амжаагүй сайхан бүсгүйчүүдийн нэг. Тэрээр бэлтэй ээжийнхээ ачаар дутагдах зүйлгүй тансаг өссөн ч харин өргөмөл ээжийгээ нас дээр гарсан хойно нь хөсөр хаяжээ. Өөрийг нь өвчинд баригдан хэнд ч хэрэггүй нэгэн болоод ирэх үест өөрөөсөө ийн түлхсэнд Дэжид хөгшин охиндоо баахан гомдож хотын зах руу нүүж ирээд удаагүй байлаа. Хөлсний асрагчдаар өөрийгөө хүрээлүүлсэн Дэжидийн бие улам дордсоор одоо бүр ярьж ч чадахгүй болжээ. Орноосоо өндийх тэнхэлгүй болсон тэрээр өдөр шөнийн аль ч цагийг зөвхөн цонх руу ширтэж өнгөрөөдөг болов. Ядаж байхад ортой нь харалдаа цонхоор олигтойхон харагдаад байх зүйл үгүй. Зөвхөн шигүү модтой уул, хөх тэнгэрээс гадна гэрээс нь тийм ч их зайтай биш хоёр давхар гоёмсог байшин харагдана. Гэвч тэр байшинд хүн байдаг үгүй нь ч мэдэгдэхгүй, нэг л дүнсгэр, цаанаа л нэг муу ёрын сэтгэгдэл төрүүлэх аж.

Ганцаардаж, өвчиндөө баригдан, бэтгэрэн шаналах баян хөгшинд сэтгэлээсээ хандах нэг ч хүн байсангүй. Эмгэнтэй харьцах хоёр асрагч охин ч тэр, бүхнийг мөнгөөр хэмжиж Дэжидийг үнэн сэтгэлээсээ хайрлаж асрана гэж яасан ч байхгүй. Энэ бүх хүйтэн хөндий, арчаагүй үхээнц байдал Дэжидийн биеийг улам бүр дордуулж байлаа.

\* \* \*

Хөгшин Дэжид урьдын л адил ортойгоо харалдаа байх ганц цонхоороо ширтэн хэвтэнэ. Гэтэл харин өнөөх гоёмсог хэрнээ муу ёрын дүнсгэр байшинг чиглэн нэгэн жийп автомашин айсуй. Жолоо барьж явсан залуу жигтэйхэн гоё ганган хээнцэр бүсгүйн гараас хөтөлсөөр байшингийнхаа хаалгыг түлхүүрдэн дотогш ороод таг чиг болов. Бялдуучилахаас цаашгүй хоосон дүр эсгэх хоёр асрагчаас өөр хүний бараа ойрд хараагүй Дэжидэд саяын хүмүүс их л сонирхолтой санагдах нь арга ч үгүй биз. Бусад хүн шиг босоод явчихдаг, хүнтэй юм ярьж чаддагсан бол саяын хүмүүстэй очоод танилцмаар, хол ойрын юу ч хамаагүй ярилцмаар л санагдана. Энэ бүхнийг бодохоор ганцаардсан хөгшний нулимс хацарт нь халуун зам татуулан доошилж байлаа. Дэжид саяын орсон хоёр хүнийг хэзээ гарч ирэх бол хэмээн хүлээсээр бараг нүдээ ч цавчсангүй. Хэ удсаныг бүү мэд ямартай ч нэлээд удсаны эцэст түрүүний байшинд орсон залуу ганцаараа гараад ирлээ. Давжаа биетэй, жартайсан онигор нүдтэй, пагдгар залуу цусанд халтардсан цамцаа гараараа халхалсаар машиндаа яаран суух нь Дэжид хөгшний нүдэнд тодхон тусав. Хамт орсон залуухан бүсгүй харин гарч ирсэнгүй. Гарч ирэхгүй нь ч тодорхой байв. Учир нь саяын нүдэнд хүйтэн пагдгар залуу байшингаа гаднаас нь дангинатал түгжээд тоос татуулан арилж өгсөн.

Хөгшин Дэжид ч нэг их юм бодсонгүй. Гэхдээ л жолооч залуутай түрүүн хамт ирсэн бүсгүй яагаад гарч ирсэнгүй вэ? гэдэг асуулт толгойд нь эргэлдэнэ. Жигтэйхэн хөөрхөн охин

харагдсан. Гэхдээ жаахан хөнгөндүү юм уу гэмээр тэр охиныг саяын пагдгар залуу чухам яачихаад гаднаас нь түгжээд явдаг байна аа гэж бодохоос гайхмаар. Хавь орчиндоо айл саахалтгүй энэ бөглүү уулын мухарт дөнгөж л хорь гарч яваа болов уу угэмээр жаахан охин ганцаараа үлдэнэ гэж яавч байхгүй мэт санагдана. Гэхдээ бүр гаднаасаа цоожлуулаад шүү. Арай саяын залуу охиныг гэртээ оруулж бодийг нь хөтөлчихөөд арилж өгсөн юм биш байгаа гэсэн бодол Дэжидийн толгойд төрөхтэй зэрэгцэн түүний цус болсон цэнхэр өнгийн нимгэн цамц санаанд нь буулаа. Хэд хоног өнгөрчээ. Байшингаас хэн ч гарсангүй бас хэн ч ирсэнгүй. Сүүлийн үед Дэжидийн нойр ч хүрэхээ больжээ. Жаахан зүүрмэглэхэд нь өргөмөл охин Зулаа нь үзэгдэж бэтгэрэн шаналсаар. Хэдий их мөнгөтэй ч хайрлаж түших хүнгүй хөгшин эмгэн энэ ертөнц дээрх хамгийн ядуу хүн гэлтэй. Цонх руу харах болгонд нь л нөгөө байшин дүнсийн харагдана.

Дэжид бараг өдөр шөнийн бүхий л цагт зөвхөн тэр байшин руу ширтэж байгаа ч нөгөө охин гарч ирсэн нь үгүй. Энэ байшинд ороод гарч ирээгүй охины тухай хоёр асрагчдаа хэлэхийг хүсч дохио зангаагаар тайлбарлавч өнөөх хоёр нь тоож ойшоох шинжгүй байх ажээ. Сүүлдээ ингэж ярихыг хичээх нь асрагч охидуудад өөрийгөө доромжлуулах шалтгаан болох болов. Ингээд л Дэжид авгай юу ч ярихаа больж цонх руугаа тайван хэрнээ айдас хуримтлуулсан нүдээр ширтэн үхлээ тэсч ядан хүлээх болов. Өнгөрсөн Бямба гарагт хажуугийн байшинд машин унасан пагдгар залуу нэг хүүхэнтэй ирсэн бол яг долоо хоногийн дараах Бямба гарагт бас л өнөөх нүдэнд хүйтэн пагдгар залуу хорь ч хүрээгүй болов уу гэмээр жаахан охин дагуулж ирлээ. Энэ нь хөөрхий хэлгүй эмгэнд үнэхээр аймшигтай санагдаж залууг дагаж ирсэн тэр жаахан охиныг байшинд битгий ор гэж орилмоор байсан ч яаж ч чадсангүй. Зөвхөн тэр байшингийн гаднах байдлыг л ажиглаж нүдэнд хүйтэн намхан залуу хэзээ ганцаараа гараад ирэх бол хэмээн хүлээсээр. Гэтэл нэг ч их удсангүй түрүүний хамт ордог жаахан охин хаалга онгойлгож зугтахыг завдтал нөгөө залуу охиныг байшинд үсдэж оруулаад хаалгаа савж орхилоо. Үүнийг хэлгүй хэвтэх Дэжидээс өөр хэн ч харсангүй. Ядаж байхад энэ бөглүү газарт утасны сүлжээ ч барихгүй. Үгүй барилаа гээд хэлгүй дээрээс нь босч чадахгүй шаналан хэвтэх хөгшин Дэжид яалтай ч билээ.

Дэмий л хөөрхий охиныг өрөвдөн уйлж хэвтлээ. Нэг хоёр цаг болоод өнөөх нүдэнд хүйтэн харгис залуу юу ч болоогүй юм шиг хавь орчноо ажигласаар ганцаараа гарч ирээд хаалгаа сайтар түгжих нь тэр. Одоо Дэжидэд бүх зүйл дэндүү ойлгомжтой юм шиг санагдаж байлаа. Байшингийн эзэн залуу хэргээр ийм бөглүү газар байшин бариад тэндээ охидыг хуурч аваачаад хүссэнээ хийдэг. Хүн харахад эрүүл юм шиг хэрнээ сэтгэцийн өвчтэй ийм хүмүүс охидыг хүчирхийлж алдаг тухай сонин хэвлэлүүдээс хангалттай олон уншиж байснаа ч Дэжид эмгэн санаж байв. Эмгэн дэмий л шаналж ядаж үхэхийн хооронд ийм аймшигтэй зүйл үзэхгүй байхыг үнэхээр их хүсэх аж.

Дараачийн Бямба гараг. Нөгөө муу ёрын байшинг зүглэн өнөөх жийп машин айсуй. Пагдгар залуу өөр нэг жаахан охин дагуулан байшинд ороод хаалгаа дангинатал нь түгжих нь Дэжидийн чихэнд сонсогдох шиг л болов. Хонины арьс нөмөрсөн чоно шиг тэр аймшигтай залуугийн гарт орсон хөөрхий охиныг өрөвдөн яаж ч чадахгүй хэвтэх Дэжид хичнээн орилж босохыг хичээсэн ч ямар ч үр дүнд хүрсэнгүй. Босож ч чадсангүй, асрагч нар ч түүнийг сонссонгүй. Харалдаа байшинд болж байгаа аллага уг байшингийн дутуу хаасан хөшигнийх нь завсраар хэлгүй эмгэнд тодхон харагдаж байлаа. Чармай нүцгэн хамаг бие нь цусанд

будагдсан тэр хөөрхий охин яаж ч тэмцээд залууг дийлсэнгүй. Өнөөх гаж донтой харгис залуу нэгэнт амьгүй болсон охиныг чирч нэг тийш болсноор хэлгүй Дэжидийн нүдэн дээрх аймшигт дүр зураг төгсгөл боллоо. Жартгар нүдтэй, намхан нуруутай харгис залуу орой болох үед дахиад л юу ч болоогүй юм шиг байшингийнхаа хаалгыг гаднаас нь түгжээд арилж өглөө.

Энэ бүхнийг харахаас өөр яаж ч чадахгүй хэвтэх Дэжид хөгшний бие өдрөөр биш цагаар дордох шиг өөрт нь санагдах болсон нь арга ч үгүй биз. Энэ тухайгаа хүнд хэлье гэхэд хэлж чадахгүй, ядаж үзэг цаас дөхүүлээд өгөхгүй, өөрийг нь ойлгохгүй байгаа хоёр асрагчдаа дэмий л гомдохоос өөр ямар ч ид шид үзүүлж чадахгүй байгаа нь дэндүү эмгэнэлтэй. Шөнө зүүдэнд нь байшинд ороод гарч ирээгүй охид аврал эрэн уйлах шиг, өнөөх хэрцгий залуу охидын амин бус газарт нь хутга зоож, хүчирхийлэн хоолойг нь боох харагдаад амар заяа үзүүлэхээ бүр больжээ.

Дараачийн Бямба гараг. Энэ хараал идсэн муу ёрын өдөр магадгүй залуухан охидын цогцсоор дүүрсэн хоёр давхар дүнсгэр байшинг өнөөх машин дахиад чиглээд ирэх вий гэж бодохооё Дэжидийн бие айдас жихүүдэст бүрэн авгаж байлаа. Харуй бүрий ч болж “Ашгүй өнөөдөр ирэхгүй нь үү, аз болж цагдаа нар алуурчин залууг бариад авсан ч юм болов уу” хэмээн бодож байтал Дэжидийн энэ горьдлого талаар болох нь тэр. Нөгөө л жийп машинаа унасан давжаа биетэй харгис залуу машиныхаа хаалгыг онгойлгон бууж ирээд залуухан сайхан охины гараас хөглөөд өнөөх аймшигт үйлдлээ хийдэг байшингийнхаа зүг дөхлөө.

Байз...үнэхээр яалт ч үгүй алуурчин залуугийн гартаа хөтөлсөн залуухан хөөрхөн охин өөрийн нь өргөмөл охин Зулаа нь байхыг Дэжид эмгэн дэндүү сайн танилаа. “Даанч дээ” Дэжид ийн бодсоор эцсийнхээ хүчийг шавхан орилж, орноосоо өнхрөн уналаа. Харамсалтай нь асрагч охид эзгүй байв. Хэлгүй Дэжид дэмий л уйлж эцсийнхээ хамаг тэнхээгээ баран байж хоёр хөл дээрээ өндийгөөд ирлээ. Шатны бариулаас хамаг хүчээрээ барин байж бугаад галын өрөөнд орж хурц хутга аваад гарч одлоо. Хөл дээрээ арай ядан гишгиж, заримдаа бүр мөлхөж муу ёр шүглэсэн байшин руу тэмцэн зүтгэх хөөрхий хэлгүй хөгшний хамаг биеийн нь хөлс цувж байв. Охины амийг аврах гэсэн чин хүсэл нь Дэжидэд асар их хүч өгөх шиг болжээ. Хорь орчим минут өнгөрсний эцэст Дэжид эмгэн аллагын үүр болсон байшингийн үүдэнд ирж чадлаа. Гадаа хав харанхуй болжээ. Байшингийн хаалга түгжээтэй байх бөгөөд дотроос нь охиных нь чарлах дуу сонсогдож байв. Хөл дээрээ арай ядан тогтох Дэжид эмгэн хаалгыг нээх гэж самардан орилж байгааг хэн ч анзаарсангүй, байшин доторх хоёр ч сонссонгүй. Магадгүй бурхнаас хүч хайрласан ч юм уу хөгшин Дэжид удалгүй түгжээтэй хаалгыг нэг л мэдэхэд онгойлгожээ. Охиных нь аврал эрэн хашхирах зүрх зүсэм дуу харгис залуугийн бах тав нь ханасан инээдтэй хоршин сонсогдох нь Дэжид эмгэнд тамын хаалгыг татаад ороод ирсэн мэт сэтгэгдэл төрүүлж байв. Хурц хутга гартаа чанга гэгч нь атгасан Дэжид эмгэн хоёр давхрын шат өөд бараг л эцсийн хүчээ шавхан өгсч байв. Охиных нь хашхирах дуу сулраад ирлээ. Цусандаа хутгалдан тарчлан тийчигнэх охиныг нь нөгөө намхан эр хүчирхийлж байгааг Дэжид эмгэн олж хармагцаа араас нь дөхөн очиж залуугийн шилэн хүзүүнд нь гартаа атгасан хутгаа хар тэнхээгээрээ дүрж орхилоо. Алуурчин үхэдхийн унажээ. Хагас ухаантай хэвтэх Зулаа охин царай нь цонхийж хар хөлс нь цутгасан өргөмөл ээжийгээ хараад гайхах баярлах нь зэрэгцэж байв.



...Удалгүй түргэн тусламж, цагдаагийнхан бөөн сүр дуулиан болж ирээд байшин дахь зургаан охины цогцсыг алуурчны цогцосны хамт зөөж гаргалаа. Өөрийгөө санаанд оромгүй ихээр хүчилсэн Дэжид эмгэний ухаан балартжээ. Өргөмөл охин Зулаа нь ээжийнхээ толгойг цээжиндээ нөөн эхэр татан уйлж байв. Удсан ч үгүй Дэжид эмгэн хорвоогийн мөнх бусыг үзүүлжээ.

...Гэхдээ л хөөрхий хэлгүй эмгэн нас эцэслэх энэхэн агшиндаа дэндүү жаргалтай байлаа.

## **Төгсөв**

Тогтуун салхитай зуны энэ шөнө Намууны гар утасны мессежний дохио дуугарч түүнийг хар дарсан зүүднээс нь сэрээжээ. Хувийн компанид нягтлан бодогчоор ажилладаг тэрээр энэ жил 28 нас хүрч байгаа бөгөөд хэн мессеж явуулсныг нь тааж ядан утсаа дэлгэж үзэв. “ Үхэх өдрөө хүлээх ямар байна даа. Үхлийн үнэр, үхлийн амт... Үхдэл болох өдөр чинь ирлээ, АДГУУС МИНЬ...” Намуун хэдий нойрмог байсан ч өөрийг нь заналхийлсэн энэхүү мессежийг маш сайн уншиж ойлгов. Сэтгэл нь жихүүцээд явчих нь тэр. Үүрийн дөрвөн цаг дөхөж байхад хэн нэгэн найз нь өөрөөр нь ингэж муухай бүдүүлгээр тоглоно гэж баймааргүй санагдана. Ингээд Намууны нойр айснаасаа болоод бүрмөсөн хулжиж орхиод орон дээрээ өндийж суулаа. Тэрээр уг мессежийг ямар дугаараас явуулсныг мэдэхээр утасныхаа дүрсийг доош нь гүйлгэж харав. Санаанд оромгүй юм. Ямар ч дугаар байхгүй байна. Үгүй ядаж ямар нэгэн дүрсэн тэмдэглэгээ ч байхгүй байна шүү. Ямар хараал идсэн өөдгүй золиг нь ганц бие эмэгтэй рүү ийм мессеж явуулж зугаагаа гаргадаг байнаа, гэсээр Намуун унтахаар буцаж хэвлээ. Гэвч түрүүчийнх шигээ гүн нойронд автсангүй. Хамаг оюун ухаан нь таагүй бодлуудаар дүүрч, өөрийг нь заналхийлэх ямар хүн байж болохыг сэтгэлдээ тунгаасаар.

...” Эзэн минь танд мессеж ирлээ”

Намууны утасны энэхүү мессеж ирж буй дохио чимээ аниргүй харанхуй гэрт дахн хадлаа. Намуун давхийтэл цочих нь тэр. Бас хэн нь вэ, арай саяны нөгө тэнэг амьтан чинь дахиад л заналхийлж байгаа хэрэг биш байгаа даа хэмээн бодсоор Намуун утсаа дэлгэж үзэв. “ Үхэх өдрөө хүлээх ямар байна даа. Үхлийн үнэр, үхлийн амт... Үхдэл болох өдөр чинь ирлээ... АДГУУС МИНЬ” Ээ золиг, дахиад л. Энэ чинь намайг харин яадаг новш вэ. Дугаар нь гардаггүй утаснаас намайг дарамтлах шаардлага энэ хүнд байгаа л юм байх даа.

Сүүлийн хоёр жилийн туршид ганцаараа амьдрах болсон Намуун анх удаагаа л ийнхүү жихүүцэж, айн сандарч байгаа нь энэ байлаа. Түүний нүдэнд бүр нулимс цийлэгнээд ирэв. Ийнхүү Намууныг уг мессежний учрыг олж амжилгүй яахаа мэдэхгүй байтал дахиад л өнөөх мессеж ирэх нь тэр. Дугаар нь гардаггүй утаснаас нэг янзын заналхийлсэн мессеж дахин дахин ирсээр. Намуун тэссэнгүй хэсэг хугацаанд тээнэгэлзэж байснаа шуудхан утсаа унтраагаад хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөн хэвлээ.

Буцах хаяггүй муу ёрын мессежнээс болоод Намууны нойр хүрсэнгүй. Хамаг бие сэтгэл нь тэр аяараа айдаст авган түүнээсээ болоод бүр дагжин чичирч байв. Тэрээр хэдий унтахыг хүсч байсан ч чадсангүй. Элдвийн муу ёрын бодлууд ар араасаа хөвөрсөөр байтал үүр цайжээ. Нарны гэгээ тусч харанхуй арилаад ирэх үест Намуун сая нэг хагас дутуу тайвшраад орноосоо бослоо. Шөнийн мессежний заналхийллээс болоод дутуу нойртой хоносон учраас нүд нь улайж, царай нь цонхийжээ. Намуун утсаа асаах гэснээ эргэлзэж түр хүлээхээр шийдээд угалгын өрөөнд явж орлоо. Тэрээр толинд өөрийгөө хараад цочих шиг болов. Би чинь ийм ядруухан, доожоогүй хүүхэн билүү. Үгүй ээ, би ийм царай муутай хүүхэн биш, энэ зүгээр л ядарснаас болоод өөрийгөө ийм сүр сүлдгүйгээр харж байгаа биз.

Намуун өөрийгөө ийнхүү бодлоороо тайвшруулаад хүйтэн усаар нүүрээ маш хүчтэй үрж угаалаа. Овоо сэргэх ч шиг болох нь тэр. Тэрээр өөртөө өглөөний цай бэлдэхийг ч

завдсангүй. Уг нь Намуун ажлаасаа хоцорч байсан ч хамаагүй өглөөнийхөө цайг заавал гэртээ уугаад гардаг билээ. Гэтэл энэ өдөр Намууны энэхүү бичигдээгүй хууль ямар ч торох юмгүйгээр зөрчигдөх нь тэр. Магадгүй тэрээр хоол идэж цай уудаг гэдгээ хэсэг хугацаанд мартчихсан болотой. Түүнд үнэндээ л хийх юм олдсонгүй. Ажилдаа явах гэтэл цаг хавьгүй эрт байна. Яахав одоо гараад очлоо гэхэд лав л гурван цагийн дараагаас ажилчид цуглаж эхэлнэ. Жижүүрээс өөр хэн ч байхгүй. Эзгүй ажлын байранд очоод яах ч юм билээ. Тэгээд ч хүмүүс намайг шөнөжин шоудаж гадуур хоноод ирлээ гэх нь дамжиггүй. Намуун ийнхүү яахаа мэдэхгүй тээнэгэлзсээр буйдан дээрээ хэсэг суув. Тэрээр шийдэв бололтой гартаа атгасан motorolla маркийн утсаа дэлгээд асаах товчлуурыг дарлаа. Намууны гар утас ажиллахад бэлэн болжээ. Шөнө ирсэн мессежүүдийг цөмийг нь устгаж аваад санаа нь амрах шиг болсон Намуун ажилдаа явахаар шийдэж алгуурхан өндийлөө.

Цэвэрлэгчийн гудамж шүүрдэж буй шир... шир... хийсэн чимээ үйлдвэрийн яндангийн дуутай хоршиж, хаа нэгтээ хурдлан өнгөрөх машны дуу амьдрал эхлэж байгааг илтгэнэ. Намуун өнгөрсөн шөнийн заналхийллийг бүрмөсөн мартахаар шийджээ. “Зүгээр л хэн нэгэн утас андуураад тэгсэн биз. Түүнээс биш намайг ер нь хэн, яасан гэж ингэж заналхийлж байхав. Бүх юм хэвийн байна. Ажлаа сайн хийгээд, амьдардгаараа амьдраад явахад болно” Намууны энэ бодол нь түүнийг тайвшрахад хүргэв бололтой.

Энэ өдөр Намуун ажилдаа хамгийн эрт иржээ. Жижүүр нь түүнийг ийм эрт ирж байгаад гайхав бололтой нэг том харснаа цоожтой өрөөг нь онгойлгож өглөө. Өөрөөс нь өөр хэн ч байхгүй байгаа Намууны ажлынх нь өрөөнд “Эзэн минь танд мессеж ирлээ...” гэх гар утасны дуу дахин хадлаа. Өөрийгөө овоо тайвшруулаад байсан Намуун огло үсэртэл цочив. Утсаа нээгээд харлаа, дахиад л өнөө урд шөнийн мессеж дугаар нь гардаггүй тэр утаснаасаа ирсэн байх нь тэр. “Үхэх өдрөө хүлээх ямар байна даа. Үхлийн үнэр, үхлийн амт... Үхдэл болох өдөр чинь ирлээ...АДГУУС МИНЬ”. Энэ мөртийг уншаад Намууны огиудас хүрэх шиг боллоо. Бурхан минь гэж, энэ одоо хэн юм бол оо хэмээн амандаа үглэсээр Намуун гар утсаа салгаж орхив. Тэрээр дахин утсаа асаахыг ч хүссэнгүй, зүгээр л олон хүн бужигналдсан хөгжилтэй, сэтгэл тайван байх орчныг хүсч байлаа. Ажлынхаа том өрөөнд ганцаархнаа байгаа бүсгүйн сэтгэл хямарч нойр нь ч хүрэх шиг болоод ширээн дээр гараа дэрлээд яахаа мэдэхгүй тэрийн хэвтлээ. “Намайг хэн ингэж дарамтлаад байгаа юм бол оо” хэмээн гиюүрч байтал ажлынхан нь цувран ирцгээв. Ажлын өдөр үргэлжилдгээрээ үргэлжилж, удалгүй хоолны цаг болж нэг өрөөнд хамт ажилладаг зургаан бүсгүй өрөөндөө хооллохоор боллоо. Намуун утсаа асаасан ч үгүй өөрийнхөө суудаг ажлын ширээн дээрээ хөсөр орхиод өрөөний голд байдаг том дугуй ширээн дээр ажлынхантайгаа зэрэгцэж суув. Түүнд хоол идэх өчүүхэн ч хүсэл байхгүй байсан хэдий ч өмнөө байгаа тавагтайгаас хоолой руугаа өөрийгөө хүчлэн арай ядан давуулж байгааг хамт ажиллагсад нь харин анзаарсангүй.

“Эзэн минь танд мессеж ирлээ..”

Дуугаа хурааж бөөн бухимдал болон сууж байсан Намуун өөрийн эрхгүй дагжин чичирч “Ээж минь” хэмээн дуулдах төдий шивнэлээ. Намууны хамт ажиллагсад түүн рүү гайхсан харцаар ширтэж нэг нь бүр тэссэнгүй бололтой “Яагаад мессеж ирээд байхад утсаа үзэхгүй байгаа юм бэ?” хэмээн их болгоомжлонгүй өнгө аястай асуугаад авав. Харин Намуун энэ асуултанд хариулсангүй. Гар утас руугаа цогцос харсан юм шиг айж бачимдсан харцаар нүд салгалгүй

ширтэж байснаа “ Миний утсыг хэн асаачихаа вэ?” хэмээн арай ядан дуугарлаа. Намууны хамт ажиллагсад чухам юу болоод байгааг ойлгохгүй, дэмий л нэг нэгэн рүүгээ асуусан харцаар харна. Намуун утсаа үзсэнгүй, харин мэгшин уйлж эхлэв.

- Уг нь би утсаа унтраачихсан ш дээ. Та нар яагаад асаачихсан юм бэ?

Намууны энэ асуултад хариулах хүн олдсонгүй. Бүр зарим нь бие засах нэрийдлээр өрөөнөөсөө гарч явцгаалаа. Намуун ямар нэгэн хөдөлгөөн хийлгүй байсаар байснаа сууж байсан сандал дээрээсээ арайхийн өндийж бослоо. Тэрээр айснаасаа болоод бүр хөшчихсөн байгаа нь андашгүй байх аж.

- Би уг нь утсаа унтраасан юмсан, та нарын хэн нэгэн нь асаасан уу. Надад үнэнээр нь хэлээч, гуйж байна?

Хэн ч хариу үг хэлсэнгүй, Харин Намууны өөдөөс нь харж суудаг энэ жил дөнгөж сургуулиа төгсөөд байгаа Элбэгзаяа Намуунаас нүд салгалгүй ширтэж байснаа “ Би лав асаагаагүй. Ер нь хэн ч асаагаагүй ш дээ, та өөрөө харж байсан. Тэгээд ч та өөрөө л утсаа гүйцэд унтраагаагүй юм байлгүй дээ, юунд нь санаа зовсон юм. Намуунаа эгч ээ, ингэхэд таны бие зүгээр үү?” гэж асуув.

Намууны ай түгшиж байсан тогтворгүй харц гэнэт ууртай шийдэмгий байдал руу шилжиж гар утсаа ширээн дээрээс шүүрч аваад дэлгэлээ.

“ Утсаа салгахаар л зугтчихна гэж бодоо юу. Үхэх өдрөө хүлээх ямар байна даа. Үхлийн үнэр, үхлийн амт... Үхдэл болох өдөр чинь ирлээ... АДГУУС МИНЬ”

Намуун гар утсаа эгээтэй л хана руу савчихсангүй. Мессежийг уншаад царай нь барайснаа сандал дээрээ суух биш зүгээр л уначих нь тэр. Ажлынхан нь түүнд халуун цай аягалж өгөөд, зарим нэг нь духыг нь алгаараа дарж үзээд халуунтай байгаа эсэхийг нь шалгана. Намуун жаахан тайвширснаа утсаа буцааж унтраагаад “ Надад санаа зоволтгүй ээ, би зүгээр” хэмээн ажлынхандаа хандаж аяархан хэллээ. Удалгүй цөм өөр өөрийнхөө ажилд орцгооход захирал нь орж ирээд “ Бие чинь муу байгаа бол эртхэн харьж амраарай, Намуунаа” гэж хэлчихээд гарав.

Намуун мессежний талаар ажлынхандаа юу ч ярьсангүй. Бас унтарсан байсан утас өөрөө асаад мессеж ирсэн гэхэд хэн ч итгэхгүй нь мэдээж. Тэгээд ч ажлынхандаа хаа хамаагүй өөрийнхөө утсанд ирсэн мессежний талаар ярьж залхаах нь дэмий гэж үзжээ. Намууны ухаан санаа ажлаа хийхэд ер төвлөрч чадахгүй зөвхөн заналхийлсэн мессежийг бичсэн эзэн хэн болохыг эргэцүүлнэ.

Дээрх явдлаас хойш хэдэн өдөр өнгөрчээ. Намууны утсанд заналхийлсэн мессеж энэ хугацаанд үе үе ирсээр байсан бөгөөд тэрээр үүнээс болоод ажлаасаа хэд хоногийн чөлөө авсан байлаа. Тэрээр учир шалтгаангүйгээр дарамтлуулсан байдлаасаа салахын тулд утсаа гэртээ орхиод найзуудтайгаа амралтанд хүртэл явсан хэдий ч огтхон тайвшраагүйгээр барахгүй амралтын газар ухаан алдаж унаад хамт явсан хүмүүсээ бүр сандаргаж орхижээ. Намуун гар утсаа барагтай л бол асаахаас татгалзах болов. Гэсэн хэдий ч бүр яалт ч үгүй гар

утсаа салгасан хойно ч гэсэн утас нь өөрөө асаж өнөөх заналхийлсэн мессеж ирэх нь хэвийн үзэгдэл болжээ.

Ингэсээр Намуун аргагүй тэсвэр алдаж үүрэн телефон утасны компаниудаар очиж шалгуулсан хэдий ч “Манайд яг ийм байдлаар дугаар нууцлах үйлчилгээ байхгүй. Өөр компаниудаас лавла” гэсэн хариу өгсөн аж. Ингээд Намуун аргагүй цагдаад хандсан ч заналхийлсэн мессежний эзнийг хэн бэ гэдгийг тогтоож чадсангүй. Яадахад Намуунд өөрт нь “Намайг дарамтлаад байгаа этгээд энэ л болов уу” гээд таамаглаад хэлчих ганц ч хүн байсангүй. Ингэсээр эцэст нь Намуун энэ мессежинд ач холбогдол өгөхгүй байхаар хатуу шийджээ. Өөрийг нь заналхийлээд байгаа ч гэсэн үнэн хэрэг дээрээ надад халдаж гай болоод байгаа юм байхгүй гэж өөртөө хэлээд бага ч атугай тайвшрахыг хичээж эхэллээ.

Эзэн минь танд мессеж ирлээ

“Үхэх өдрөө хүлээх ямар байна даа. Үхлийн үнэр, үхлийн амт... Үхдэл болох өдөр чинь ирлээ... АДГУУС МИНЬ”

Намуун хэдийн танил болсон энэ мессежийг авангуугаа “өөдгүй новшоо, читийм сүрхий юм бол гараад ир. Тэгээд надтай яриач” хэмээн гар утас руугаа хоолойныхоо чадлаар тэсвэр алдан бархирлаа. Энэ мөчид үдшийн бүрэнхий болж байсан бөгөөд Намуун урьдын адил гэртээ ганцаараа байлаа. Гэрт чимээ аниргүй нам жим байх агаад энэ байдал нь Намуунд яг л хаа нэгтэйгээс үхэл ирээд өөрийг нь авч явах нь уу гэмээр сэтгэгдэл төрүүлэх шиг. Гэтэл тун удалгүй энэхүү нам жим байдал төгсгөл болж Намууны гар утсанд дуудлага ирж хөгжим хангинах нь тэр. Сүүлийн өдрүүдэд Намууны утсанд дуудлага ирэхээ болиод удаж байгаа билээ. Учир нь тэрээр өнөөх муу ёрын мессежнээс болоод ихэнх хугацаанд утсаа салгаж байсан. Тийм болохоор Намууны гар утсанд ингэж дуудлага ирэх нь их л сонин үзэгдэл боллоо. Ойрд дуугараагүй утсаа гэнэт ингэж дуугарахад нь Намуун эхлээд цочсон хэдий ч тэр дороо тайвшран өөр лүү нь хэн залгаж байгааг мэдэхээр дэлгэцрүү харав. Гэтэл гар утсанд ирж буй дуудлага гардаг жижигхэн электрон самбарт нь ямар ч утасны дугаар харагдсангүй. Хэн нэг нь Намуун руу дугаар нь гардаггүй утаснаас залгаж байх нь тэр. Намуун энэ дуудлагыг өнөөх мессежтэй холбож бодоод ар нурууных нь хүйтэн хөлс асгарах шиг боллоо. Гэсэн хэдий ч тэрээр энэ бодлоосоо даруйхан татгалзаж амжив. “Зүгээр л миний утас эвдэрчихсэн байх, эсвэл үүрэн телефон утасны компанид асуудал гарсан биз” хэмээн өөрийгөө хуурсаар хэсэг тээнэгэлзэж байгаад утсаа авлаа.

-Байна уу, хэн бэ?

Намууны энэ асуултын хариуд хэн нэгний чихарсан муухай хүржигнэх мэт дуун гарснаа нэг эрэгтэй сөөнгөтсөн хоолойгоор ярих нь тэр.

-Надтай ярихыг хүсээ юу?

-Чи хэн бэ?

-Үхэх өдрөө хүлээх ямар байна даа. Үхлийн үнэр, үхлийн амт... Үхдэл болох өдөр чинь ирлээ.... АДГУУС МИНЬ

Энэхүү чихарсан муухай сөөнгө хоолойгоор ярьж байгаа үл таних эрэгтэй өнөөх мессежээр дарамталдаг этгээд мөн байх нь ээ гэсэн бодол төрмөгц нь Намуун хурдхан шиг утсаа салгачихлаа.

Тэгмэгц дахиад л мессежний хонх дуугарах нь тэр. “...Эзэн минь танд мессеж ирлээ.”

Үхэх өдрөө хүлээх ямар байна даа. Үхлийн үнэр, үхлийн амт... Үхдэл болох өдөр чинь ирлээ.... АДГУУС МИНЬ

Намуун өөрийн эрхгүй гиншин уйлж, гартаа атгаж байсан утсаа хана руу хамаг хүчээрээ савж орхилоо. Чулуун хананд шидэгдсэн утас бут үсрэн хэдэн хэсэг болсон ч гэсэн гол эх бие нь ажиллагаатай үлджээ. Утсанд дуудлага ирэх хонх дахин дуугарав. Намуун яахаа мэдэхгүй шалан дээр эвхрэн суугаад уйлж байснаа тасралтгүй дуугарсаар буй дутуу эвдэрсэн утсаа очиж авлаа. Өнөөх л саяын дугаар нь гардаггүй үл мэдэгдэх дуудлага. Намуун тэссэнгүй утсаа шүүрч аваад “Новшоо чи тэгээд надаас юу хүсээ вэ. Би энд байж л байна, тийм сүрхий юм бол ирээд тэгээд намайг үхүүлээч дээ” хэмээн хашхирлаа.

Үүний хариуд өнөөх чихарсан сөөнгө хоолойтой эрэгтэй шивэгнэн ярив.

-Үхэх өдрөө хүлээж бай. Чамд үхлийн амтыг мэдрүүлэх болно. АДГУУС МИНЬ.

-Тэнгэр минь, гуйя чамаас. Чи хэн бэ?

-Намайг мартчихаа юу?

-Гуйж байна намайг тайван орхи лдоо тэгэх үү, гуйж байна. Би чамд гай болоогүй шүү дээ.

-Адгуус минь сонсож бай. Хөршийнхөө охины хоолойг хутгаар хэрч. Тэгвэл амьд явах хоногийн чинь тоо уртсана.

-Муу галзуу солиотой, гаж донтой новш. Чамайг цагдаад барьж өгнө шүү

-Дахиад хэлье, адгуус минь. Хөршийнхөө охины хоолойг хэрч. Тэгвэл амьд явах хоногийн чинь тоо уртсана.

-Өөдгүй амьтан минь, тэр чинь дөнгөж зургаахан настай шдээ

Намуунаагийн ийнхүү хашхирч хэлсэн үг маш ихээр цөхөрч байгааг нь илтгэж байв. Дараа нь чухам юу болсноо ч Намуун мэдсэнгүй. Нэг л мэдэхэд тэрээр гартаа байсан утсаа бүр юу ч үгүй болтол нь үйрүүлэн дэвсэж байх нь тэр. Гэрт дахин чимээ аниргүй боллоо. Айдас түгшүүр Намууныг эзэмдэж хоёр өрөө байрных нь нүх сүв болгонд нь чөтгөр ороод үүрлэхсэн мэт таагүй орчин үүсэх нь тэр. Намуун байшингийнхаа буланд нуруугаараа наалдаад өвдгөө нугалан нүүрээ гараараа дарж шалан дээр хэсэг суув. Намуун айж сандарснаасаа болоод ухаан нь балартаж, орон гаран байдалтай болчихжээ. “Одоо утсаа эвдчихсэн юм чинь энэ муу заналхийлсэн гаж донт намайг яахыг нь харъя л даа. Яаж ч чадахгүй юм чинь, намайг хаанаас гэж олох билээ” Намууныг энэхүү бодлоо гүйцээж ч амжаагүй байхад нь гэнэт гэрийнх нь хаалгыг нүдэх чимээ дуулдлаа. Намууны гэрийн үүдэнд

хэн нэгэн ирчихээд дотогшоо орохыг хүсч байна. Ямартай ч үүдэнд хэн ч байлаа гэсэн тэр хүнд өөрөө хэрэгтэй байгаа гэдгээ Намуун мэдрэх шиг болов.

Тэнгэр минь, тэнгэр минь. Арай саяын нөгөө сөөнгө хоолойт биш байгаа даа. Утас минь холбогдохгүй болохоор үүдэнд хүрээд ирчихсэн юм болов уу? Тэнгэр минь битгий л тийм байгаасай. Би ер нь яасан юм бэ. Намайг ямар нүгэл хийсний төлөө энэ үл таних эрэгтэй ингэж дарамтална вэ? Би яагаа ч үгүй шүү дээ. Бас хөршийнхөө охины хоолойг хэрч гэнэ шүү. Хөрш айлын Энхриймаа чинь дөнгөж зургаахан настай шүү дээ. Яагаад заавал би түүнийг алах хэрэгтэй болдог билээ?

Намуун энэ бүх асуултуудыг өөртөө тавьсаар үүд рүүгээ зүглэн нэг хоёр гишгэлэв. Намуун хаалга руугаа бүр тэгтлээ их дөхсөнгүй. Хэдий үүднийх нь өрөөний гэрэл асаалттай байгаа ч гэлээ харанхуйд яваа хүн шиг ханаа налан маш удаанаас алхаж байсан Намуунаа үүднээсээ зургаа орчим алхмын зайтай зогсоод чанга дуугаар “хэн бэ?” гэж асуув.

-Намуунаа эгчээ, би Энхриймаа байна аа. Танд хурц иртэй хутга байна уу?

-Бурхан минь, чи хутгаар яах нь вэ?

Намуунаа ингэж хэлэхдээ өнөөх түрүүний утсаар ярьсан сөөнгө хоолойтой эрийн “Хөршийнхөө охины хоолойг хутгаар хэрч, тэгвэл амьд явах хоногийн чинь тоо уртсана” гэсэн үгийг саналаа.

Намууны асуултанд Энхриймаа охин хэсэг хугацаанд хариулахгүй байж байснаа

-Тэгээд танд хутга байхгүй юм уу?

-Байхгүй ээ, охин минь

Охины учир битүүлэг санаанд оромгүй асуулт, басхүү өнөөх өөрийг нь заналхийлэгч этгээдийн хэлснийг бодон түгшсээр Намуун хаалгаа ч тайлж өгсөнгүй. Уг нь, тэрээр хөршийнхөө бяцхан охин Энхриймаатай маш дотно байдаг хэдий ч энэ удаад түүнийг гэртээ оруулахыг хүссэнгүй.

Яагаад ч юм Энхриймаа охины энэ үг түрүүчийн заналхийлэгч этгээдийн хэлсэн хоёр урьд хождын ямар нэгэн зүйлийг санагдуулаад байх шиг. Гэхдээ чухам яг юу вэ гэдгийг Намуун нэрлэж чадахгүй байлаа.

Энэ шөнө Намуун бүх өрөөнийхөө гэрлийг асаагаад том өрөөнийхөө буланд нуруугаараа налан сууж өөрийг нь заналхийлэгч үл таних эрэгтэй чухам хэн болоод ингэж уйгагүйгээр өөрийг нь зовоож байгаа тухай бодлоо. Ёстой л нөгөө бодоод бодоод бодын шийр дөрөв гэдэг шиг түүний санаанд олигтой учир шалтгаан орж ирсэнгүй.

Энэ шөнө Намуун тайван амарч чадсангүй. Жаахан дугхийх болгондоо өөрийгөө ямар ч эсэргүүцэл үзүүлж чадахгүй Энхриймаа охиныг тарчлаан зовоож том балиусан хутгаар хоолойг нь хэрчиж байгаагаар харах аж. Цус годгодон үсэрч жаахан охины амь тавин тийчилж

байгаа нь тодоос тод харагдахад Намуун зүүднээсээ цочин сэрэв. “Тэнгэр минь, ямар муу ёрын зүүд гээч нь энэ вэ” хэмээн дөнгөж дуулдах төдий шивнэсэн болов. Түүний нүүрээр хүйтэн хөлс дааварлаж хамаг бие нь салганан чичирч байлаа. Орь ганцаархнаа хоёр өрөө байранд шөнийг өнгөрүүлж буй Намуун айдсаа үргээхийн тулд зурагтаа хүртэл асааж хүүхэлдэйн кино үзэх аж. Гэвч саяын тэрхүү муу ёрын зүүд нь санаанаас нь гарсангүй. Басхүү өнөөх сөөнгө хоолойтой муу ёрын заналхийлсэн эрийн АДГУУС МИНЬ гэж ирээд л өөрийг нь заналхийлсэн тэр бүх муу үгсүүд нь бүр санаанаас нь гарахгүй болоод сэтгэлд нь хоногшчихоо юу гэлтэй. Ашгүй тэгсхийсээр байтал үүр цайж Намууны сэтгэлд татсан айдсын манан бага багаар арилж эхэллээ

Намуун утсаа юу ч үгүй үйрүүлж хаясныхаа ачаар хэдэн өдөр хэн нэгний сүрдүүлгийн үг сонсолгүй сэтгэл амар явжээ. Ажилдаа ч эргэж орохоор болж гар утасныхаа хуучин дугаарыг мартаад шинийг авахаар шийдэв. Ингээд Намуун Даваа гарагийн өглөө Мобиком корпорацийн дугаар борлуулах цэг дээр очиж шинэ дугаар шинэ гар утас сонгов. Намууны сэтгэл тайван, айж түгшиж байсан үетэйгээ харьцуулбал жаахан ч гэсэн аз жаргалтай байлаа. Одоо дугаараа сольчихож байгаа юм чинь тэр муу гаж донтой, сөөнгө хоолойтой эр намайг заналхийлж чадахгүй хэмээн бодсоор шинэ гар утсаа асаалаа. Ийнхүү түүнийг дөнгөж утсаа нээмэгц дуудлага ирэх нь тэр. Өнөөх л дугаарын нууцлалтай дуудлага. Намуун эгээтэй л цус харвачихсангүй... Түүний хамаг бие нь салгалж, дуугарч чадахгүй хоолой нь чичирхийлээд өөдөөс нь хараад лангууны цаана сууж буй гар утасны худалдагч руу айсан нүдээр ширтэн харав. Өнөөх нь нэлээд гайхсан байртай харж байснаа өмнөх ажлаа үргэжлүүлэн хаа хамаагүй хүмүүстэй ярилцаж Намууныг авч хэлэлцсэнгүй. Намуун утсаа авсангүй. Тэрээр чухам яахаа мэдэхгүй байсаар нэг л мэдэхэд гэрийнхээ зүг алхаж байв. Энэ үед ч гэсэн Намууны гар утас нь дуугарсаар байв. “Нөгөө сөөнгө хоолойт чинь байх даа” гэсэн айдас санаанаас нь гарахгүй байгаа Намууны ар нурууных нь хүйтэн хөлс асгарч байлаа. Тэнгэр минь, хэрвээ үнэхээр нөгөөх чинь мөн бол яагаад, тиймээ яагаад шуудхан ингэж залгадаг байна аа. Ер нь биш байлаа ч гэсэн намайг өөрийнхөө утасны дугаарыг ч цээжилж амжаагүй байхад хэн ингэж удаанаар дууддаг билээ. Намуун яагаад, яагаад гэсэн асуултыг өөрөө дахин дахин тавьж, гар утас руугаа гөлийсөн нүдээр ширтэн маш удаанаар алхаж байлаа. Ингэсээр эцэст нь тэрээр утсаа авчээ. Намууны хоолой чичирхийлж олигтойхон дуугарч чадсангүй.

-Байна уу, чи юу?

-Адгуус минь, надаас ийм амархан салчихна гэж бодоо юу. Үхэх өдөр чинь хаяанд ирлээ. Хөршийнхөө охины хоолойг хутгаар хэрч. Энэ чиний амьд үлдэж болох цорын ганц зам

-Тэнгэр минь, чамаас гуйя. Чи хэн юм бэ? Надруу дахин битгий залга, би гуйж байна.

-Энхриймааг ал. Өөрийнхөө амийг аварч үлдэхийн тулд охины хоолойг хутгаар хэрчих үү, эсвэл өөрөө үхлийн муугаар үхмээр байна уу?

-Гуйя. Яагаад заавал би энэ хоёр сонголтын аль нэгнийг сонгох хэрэгтэй гэж?

-Үхлийн амтыг мэдэр, АДГУУС МИНЬ. Үхдэл болох өдөр чинь ирлээ

Намуун тэсвэр алдаж шинэхэн авсан гар утсаа зам дээр хага шидчихлээ. Тэрээр гудамжны



сандаал дээр хааш яйш суусан болж эхэр татан уйлж байлаа. Хажуугаар нь зөрж өнгөрөх хүмүүс түүн рүү галзуу солиотой эсвэл согтуу хүн рүү харж байгаа мэтээр сэжиглэнгүй хялайсаар холуур өнгөрөх аж. Уг нь Намуун гэртээ нэлээд ойрхон ирчихжээ. Гэвч түүний оюун ухаан өөрийгөө хаана яваагаа ч мэдэхгүй байлаа. Түүний толгойд зөвхөн “Би амьд үлдэхийн төлөө яагаад заавал Энхриймааг алдаг билээ” гэсэн аймшигтай шаналгаатай бодол эргэлдсээр.

Хичнээн ч цаг суусан юм бүү мэд. Харуй бүрий болж эхэлсэн энэ мөчид Намуун жаахан сэхээ аваад хажууд нь хэн нэгэн зогсож байгааг мэдрэв. Нүүрээ даран доог тонгойгоод сууж байсан тэрээр цочин өндийлөө. Өөрийн нь өмнө хэн зогсож байгааг хараад гайхан балмагдсан Намуун “Чи чинь...” хэмээн дуулдах төдий шивнээд үгээ гүйцээлгүй хөшиж орхих нь тэр.

Намууны уйлсандаа бэлцийж, айж сандарсан нүд рүү Энхриймаа охин ширтэн зогсох аж. Үсээ хоёр хуваагаад боочихсон цэнхэр өнгийн бэлтгэлийн өмд цамцтай жаахан охин Намууны хажуунаас холдохгүй зогссоор байгаа хэдий ч юу ч ярьсангүй нэлээд удлаа. Намуун энэ мөчид Энхриймааг харсаар аргагүй барьц алдаж, яах ёстойгоо, юу ярихаа ч мэдсэнгүй. Гэтэл Энхриймаа Намуун руу маш нухацтайгаар ширтэж байснаа түрүүлж ам нээлээ.

-Намуунаа эгч ээ...

-Юу гэв миний дүү. Чи энд юу хийж байгаа юм бэ?

-Намуунаа эгч ээ танд нээрээ хурц иртэй хутга байхгүй юм уу?

-Чи чинь юу асуух нь энэ вэ. Байхгүй. Байхгүй ээ, байхгүй. Байхгүй мэдэв үү. Байхгүй гэж чи хэд хэлүүлэх гэсэн юм. Эсвэл үхмээр байгаа юм уу. Эндээс зайл чи, муу тамын сүнс минь.

Энэ үгээ Намуун маш чангаар хашхиран хэлжээ. Тэрээр үнэхээр биеэ барьж чадсангүй маш ихээр бухимдаж байлаа. Энхриймаа охин ч Намууны гэнэтийн энэ огцом уурнаас айснаас уу, ямартай ч орц руугаа гүйгээд орчихлоо. Энхриймаа чангаар цурхиран уйлж өөрт нь туслах хэн нэгэн байгаа эсэхийг хайж олох гэсэн мэт эргэн тойрноо харах аж. Гэвч хэн ч түүнийг өрөвдсөн харцаар харсангүй. Зуны шөнө болжээ. Намуун гэртээ орж чадахгүй орцныхаа үүдэн дээр гараа элгэндээ зөрүүлэн нааш цааш холхисоор.

Намууны сэтгэлийн мухарт хүртэл шингэсэн гэлтэй өнөөх заналхийлэгч эрийн сөөнгө хоолой чихэнд нь сонсогдох шиг болж магадгүй ард нь ирчихээд зогсож байгаа ч юм билүү гэсэн бодлоор өөрийн эрхгүй эргэн харна. Цаг явсаар, нэг л мэдэхэд бүр шөнө дунд болжээ. Намуун ингэсээр ямар гадаа хонолтой биш гэж бодоод гэртээ орохоор шатаар өгслөө. Ганцаархнаа амьдардаг хоёр өрөө байрныхаа хаалгыг түлхүүрдэн онгойлмогцоо үүднийхээ өрөөний гэрлийг асаав. Түүний гэрийн нь энэхүү ямар ч чимээ аниргүй орчин өмнө нь маш сайхан амралт болдог байсан бол одоо чөтгөрийн үүрэнд ороод ирчихсэн мэт айдас төрүүлэх нь тэр.

Тог...тог... тог

Намууныг дөнгөж том өрөө рүүгээ ороход ийнхүү араас нь хэн нэгэн хаалгыг тогшив. Энэ шөнө дунд хэн байдаг байна аа гэсээр Намуун хаалга руугаа дөхлөө. Магадгүй хий юм сонсов уу гэж бодсон хэдий ч хаалга тогших чимээ дахин сонсогдсоноор Намууны эргэлзсэн бодлыг бүрмөсөн байхгүй болголоо.

-Хэн бэ?

-Намуунаа эгч ээ, би Энхриймаа байна

-Чи яах гэв. Надад хурц иртэй хутга байхгүй. Чамайг дахиж ингэж асуугаад ирэх юм бол аав ээж хоёрт чинь хэлнэ шүү. Явж унт. Чам шиг ийм жаахан хүүхэд энэ харанхуй шөнө болсон хойно айлын хаалга тогшиж болдоггүй юм.

-Би танаас хутга асуух гээгүй ээ

-Тэгээд яах гэсэн юм

-Тантай нэг хүн утсаар ярьж гээд байна

Энэ үгийг сонссон Намууны зүрх палхийгээд явчих нь тэр. Арай нөгөө....гэсэн бодол Намуунд төрж тэрээр хаалганаасаа хэдэн алхам ухарлаа. Намуун Энхриймаад ямар ч хариу хэлж чадсангүй. Айснаасаа дагжин чичирч, шорвог нулимс хацрыг нь даган урсав. Гэвч хэсэг хугацаа өнгөрөөд дахиад л тог... тог... тог.... гэсэн хаалга тогших чимээ үргэлжиллээ.

-Намуунаа эгчээ, хаалгаа тайлаарай. Тантай хүн утсаар ярьж гээд байна.

-Энхриймаа, чи яв. Гуйж байна. Би одоо хэнтэй ч утсаар ярихгүй. Яв дуулав уу чи. Наанаасаа яв, хэн ч байлаа гэсэн би наад утсаар чинь ярихгүй.

Энхриймаа охин энэ үгийн хариуд юу ч хэлсэнгүй. Чимээ аниргүй байдал нэг минут хэртэй үргэлжиллээ. Ингэсээр эцэст нь Энхриймаа гэрийнхээ шаахайг чирэн буцаж алхах чимээ хаалганы цаана сонсогдож, хөршийн нь хаалга хаагдах чимээ үргэлжлүүлэн дуулдав. Үүнийг сонссон Намуун хагас дугуу тайвширсан боллоо. “Ямар гээчийн муу ёрын юм болоод байна аа. Тэр өөдгүй заналхийлэгч сөөнгө хоолойтой эр намайг хаа ч явсан яг л сүүдэр мэт дагаж бүх үйлдлийг минь хянаж байгаа хэрэг үү. Ээ бурхан минь, би юутай учрах нь энэ вэ. Хэн нэг нь надад туслаач” Намуун өөрөө өөртэйгөө ийнхүү бодлоороо ярилцаж өөрт нь авралынхаа гарыг сунгах хэн нэгнийг эрхгүй хэн нэгнийг үгүйлэх аж.

Хар дарсан зүүднээс өөр ямар ч үзэгдэлгүй муу ёрын харанхуй шөнө ашгүй Намууны ард үлджээ. Өглөөний нарны туяа орчлонг гэрэлтүүлж шувууд жиргэн нисч, “сүү аваарай” гэх худалдаачны баргил хоолой амьдралын шинэ өглөө эхэлж байгааг илэрхийлнэ. Намуун унтсан унтаагүй хоёрын хооронд хамаг бие нь хөшөөд муухай царайлсан хүн угаалгынхаа өрөө рүү гуйвлан зүглэлээ. Тэрээр яг л нөгөө дугуу алсан могойтой өөрийгөө зүйрлэж өрөвдөх ч шиг болов. Угаалгынхаа өрөөний гэрлийг асааж крантаа суллан бүлээн ус гоожууллаа. Тэгээд өглөө болгон харж нүүр амаа янзалдаг том толиндоо өөрийгөө харав. Царай нь цонхийж, үс нь өрвийн ширэлдээд бага зэрэг онигордуу нүд нь уйлсандаа бүлцийн хавдаад ямар ч сүр

сүлдгүй нэгэн болж хувирчээ. Сэтгэл тавгүй байдал, тэр дундаа айдас гэдэг хүнийг яг л хатсан навч шиг юу ч биш болгочихдог юм байна гэдгийг Намуун ойлгох шиг. Түүний царайд ямар ч баяр баясгалан, амьдын гал цог үгүй болжээ. Яг л бүх итгэл найдвараа алдаад үхлээ хүлээж байгаа хүн шиг тийм нэгэн дүр зургийг тэрээр толинд туссан өөрийнхөө тусгалаас олж харав. Тэрээр ийнхүү толинд туссан өөрийнхөө дүрс рүү нүд салгалгүй ширтэж байснаа ярьж эхэллээ.

-Яасан ч сул дорой, ядруухан болчихоов дээ. Ингэж хүнд дарамтлуулж амьдын сүг болж амьдарснаас зүгээр үхчихдэг ч юм билүү. Гэхдээ л үхмээргүй байна, би залуу хүн шүү дээ. Нөхөртэй, хүүхэдтэй болмоор байна. Өөрийнхөө аз жаргалтай ертөнцийг бий болгомоор байна. Гэтэл түүнээс урьтаад үхчихвэл яана аа.

Толь руугаа ширтсээр байгаа Намуун ингэж хэлээд баргар царайгаа улам бүр барайхыг харав. Хүнд ямар ч халширмаар бэрх зүйл тохиолдож байсан амьд явах хүсэл нь бөхдөггүй гэдгийг Намуун өөрөөрөө батлах шиг. Хацраа даган урссан ганц дусал нулимсаа арчсан Намуун “Яасан ч дуусдаггүй нулимс вэ дээ” хэмээн өөртөө зориулж хэллээ. Ганцаардаж өөрийгөө өрөвдсөн бүсгүй толь руу ширтсээр. Гэнэт тэрээр толинд тусаж буй дүрсгийг өөрийгөө биш байх хэмээн эргэлзэж эхлэх нь тэр. Нэг л өөр, өөрийнх нь дотор өөр хэн нэгэн орчихоод даажигнаад ч байгаа юм шиг. Энэ мөчид яг л Намуун өөрийгөө харах биш Намууныг хэн нэгэн хараад байх шиг тийм мэдрэмж төрлөө. Намуун айж эхлэв. “Энэ би биш байна” гэсэн бодол нь улам идэвхжиж өөрөө өөрөөсөө айж эхэлж буйгаа тэрээр мэдрэв. Энэ үед өнөөх өөрийг нь заналхийлэгч сөөнгө хоолойтой эрийн “Намайг мартчихаа юу?” хэмээн утасны цаанаас хэлж байсан нь чихэнд нь дахин сонсогдлоо. Намууны энэ хэн бэ гэсэн бодолтой нь зэрэгцэн өнөөх толинд туссан өөрийнх нь дүрс нүд нь жартайн инээмсэглэх нь тэр. Өөрийн нь тусгал болсон уг дүрс бүр харсаар байтал шүдээ ярзайлган инээгээд цус болсон улаан хэлээ гаргаж ирэн уруулаа шилэмдэн долоолоо. Намуун мэл гайхаж цэл хөхрөнө гээч нь болов. Би өөрөө өөрийнхөө хөдөлгөөнийг хүртэл хянаж чадахаа больчихоо юу хэмээн айхын хажуугаар эргэлзэж байсан Намуун хацар, уруулаасаа чимхэж үзэв. Хацар нь үрчийгээгүй, уруул нь жимийсэн хэвээр байх нь тэр. Тэнгэр минь, тэнгэр минь юу болох нь энэ вэ?

Намуун толинд туссан магадгүй өөрийнхөө дүрснээс хэмжээлшгүй ихээр айж байсан ч тэндээс нүднийхээ харцыг салгаж чадсангүй. Өнөөх толин доторх Намууны дүрс баруун гараа өргөж хоолойгоо зүсэх хөдөлгөөн үзүүлэв. Гэтэл яг энэ үетэй нь зэрэгцэн өнөөх сөөнгө хоолойтой эр “Энхриймаагийн хоолойг хэрч, түүнийг ал. Чи бол АДГУУС” хэмээн шивнэлээ. “Чи бол адгуус, чи бол адгуус, чи бол адгуус...”

Намуун хэдий чихээ тагласан ч өнөөх сөөнгө хоолойтны “Чи бол адгуус” хэмээх үг цуурайтсаар. Харин өнөөх толинд туссан дүрс нь хоёр гараараа амаа таглаад биеэ займчин инээж байх нь үзэгдлээ. Намуун нүдээ улам бүлтийлгэн харж хамаг бие нь салганаж буйгаас үзэхэд тэсэхзйеэ бэрх байгаа бололтой. Гэтэл энэ үед гэнэт хаалга тогших чимээ сонсогдов. Сөөнгө хоолойтой заналхийлэгч эрийн “Чи бол адгуус” хэмээн тасралтгүй шивэгнэх үгсийн хажуугаар энэхүү хаалга тогших чимээ маш тод дуулдаж байлаа. Тэгснээ хаалганы цаанаас “Намуунаа эгчээ би Энхриймаа байна аа. Хурц хутга...” гэх үг дуулдлаа. Намуун нүдэн дээр газар босоод ирэх шиг болж ухаан балартан унав. Тэрээр хэдий айж цочирдсоноосоо болоод унасан хэдий ч оюун ухаан нь хэвийн ажиллаж, өөрийгөө хөндлөнгийн нүдээр хараад ч байх

шиг. Хаалга тогших чимээ сонсогдсоор. Гэтэл гэнэт гэрийн нь хаалганы түгжээ нь торхийн мултарч нээгдэх нь тэр. Энхриймаа өөрөө ингээд ороод ирж чадахгүй нь мэдээж. Тэгвэл хэн нэгэн хаалга тайлж өгсөн байх учиртай. Гэхдээ хэн?

Юу болсон юм бүү мэд, ямартай ч Энхриймаа гэрт нь орж ирээд шууд гал тогооны өрөө рүү орчихыг Намуун мэдрэв. Намууны ухаан сэргэх нь битгий хэл улам бүр балартаж бодит орчноосоо холдсоор. Энэ үед түүний чихэнд өнөөх сөөнгө хоолойтой заналхийлэгч эр “Адгуус минь өмнөх амьдралаа хар” хэмээн шивнэх шиг боллоо.

...Хаана байдаг газар юм бүү мэд. Ямартай ч Намуун чийг даасан гэрэл муутай өмхий хонгилоор нэгэн ухаан алдсан хүнийг чирэн явж байлаа. Араасаа чирч яваа тэр хүн нь эрэгтэй, эмэгтэй алин болохыг мэдсэнгүй. Учир нь тэр этгээд цус нөжиндөө хутгалдчихаад нүүр нь нил шарх, сорви болчихсон байх бөгөөд амандаа алчуур чихүүлчихсэн, гар хөл нь хүлээтэй байлаа. Уг этгээдийг Намуун мөрнөөс нь нэг гараараа чирч яваагаа мэдээд өөрийгөө ямар их хүчтэйгээ гайхах шиг болов. Тэрээр өөрийгөө эрэгтэй хүн гэдгээ сая ойлгох шиг боллоо. Намуун хэдий өөрийнхөө юу хийж байгаагаа мэдэж харж байгаа ч өөрийгөө огтхон ч удирдаж чадсангүй. Яг л оюун ухааныг нь өөрөө автоматаар ажилладаг нэгэн биед аваачаад суулгачихсан юм шиг. Тэрээр зөвхөн өөрийнхөө юу хийж байгаагаа л хөндлөнгийн нүдээр харан гайхах аж.

Усны дусал шол шол хийн дусалж хаа нэгтэйгээс хэн нэгэн жаахан охины мэгшин уйлах чимээ дуулдана. Намуун алхсаар тэрээр өөрөө энэ газрыг их л сайн мэдэг байх бөгөөд тэрхүү мэгшин уйлж байгаа жаахан охинд туслах биш харин ч бүр зүйл дуусгахаар шийдчихсэн мэт. Намуун өнөөх чирч яваа хүнээ огтхон ч орхисонгүй, араасаа уйгаггүйгээр чирэн алхсаар. Гэхдээ тэрхүү чирж байгаа хүнээ өчүүхэн төдий ч хайрлахгүй замдаа тааралдсан чулуу төмөр сэлт дээгүүр хүчлэн чирч байв. Намуун өөрийгөө энэ хүнээр чухам яах гэж байгаагаа мэдэхгүй байлаа. Нэгэн томхон байшингийн хонгил бололтой энэ газраар алхах тусам өнөөх бяцхан охины уйлах чимээ улам бүр тод дуулдаж байв. Охины уйлж буй нь түүнийг дөнгөж тав юм уу зургаан настай байх гэсэн таамаглал төрүүлж байв. Намуун нэгэн жижигхэн төмөр хаалганы өмнө тулж ирлээ. Уг хаалгыг гаднаас нь хүнд төмрөөр даруулан түгжчихжээ. Магадгүй энэ хаалгыг Намуун өөрийгөө түгжсэн байх хэмээн таамаглав. Тэрээр ямар ч эргэлзээгүй явж очоод хаалгыг тайлан дотогш орлоо. Энд өнөөх охины мэгшин уйлах чимээ дөнгөж хажууханд дуулдаж байв. Намуун ухаан алдсан өнөөх этгээдийг чирсээр энэхүү гэрэл муутай жижиг өрөөний булан руу зүглэн алхлаа. Тэнд нэгэн жаахан охин чулуун шалан дээр өвдгөө тэврэн суугаад Намуун руу айсан харцаар ширтэж байх нь тэр. Намууны нүдний харц охиныхтой тулгарсан тэр мөчид тэр охин таньдаг ч хүн шиг санагдаад явчихлаа. Охин Намуунаас айн дальдчиж “аав аа...” хэмээн аврал эрэн шивнэсээр. Намуун тэр охин руу бүр дөхөж очсонгүй, зүгээр л өнөөх чирж ирсэн ухаангүй хүнээ түүний өмнө аваачаад хөсөр орхив. Тэгээд ухаангүй байгаа тэр хүнийхээ хүлээсийг хурц иртэй хутгаар тасалж суллалаа. Тэгмэгцээ аль хэдийн зэхсэн бололтой энэхүү жижиг өрөөний өөр нэгэн булан руу очиж савтай ус авчран ухаангүй байгаа хүний дээрээс цацав. Тэр ухаангүй этгээд эрэгтэй хүн байсныг Намуун сая л анзаарав. Тэр ухаан орж буй бололтой бие нь үл мэдэг хөдөлж эхлэх нь тэр. Тэгмэгц нь Намуун халааснаасаа нэгэн тариур гаргаж ирээд ухаан орж буй эрэгтэйн судсанд тарьж орхив. Чухам энэ үйлдлийг хийхдээ Намуун өөрийнхөө гарыг ямар аймшигтай том, тэгээд бас хэлбэргүй бүдүүн хуруутайг олж харлаа. Яг л алуурчных гэмээр... Намуун

өөрөөсөө айж байлаа. Арай би энэ эрэгтэйг алж байгаа нь энэ биш байгаадаа гэж бодон жихүүцсэн хэдий ч түүнд зөвхөн харж мэдрэхээс өөр сонголт байхгүй аж. Би урьд насандаа алуурчин байсан юм байна гэсэн жихүүцмээр бодол Намууны эрүүл ухааны аль нэгэн өнцгөөс шивнэн хэлэх шиг боллоо. Намуун зүүдэлж буй эсвэл урьд насныхаа амьдрал руугаа эргээд оччихсон хоёрын алин болохыг мэдсэнгүй. Ямартай ч тэрээр сэрээд бодит байдалдаа эргэн очихыг хүсч байсан ч чадахгүй байлаа. Бүх юм яг л хувь тавилангаар болж харах ёстойгоо харж байгаа нь энэ юм байх гэсэн мэдрэмж Намуунд төрөх аж.

Бүүдгэр гэрэлтэй энэ чийг даасан умгар өрөөний хана шал зэрэг нь энд тэндээ цусанд халтартчихсан урагдаж тасраад цус болсон хувцас хунар хаа сайгүй хөглөрчихсөн байх нь тодхон үзэгдэнэ. Гэсэн хэдий ч Намуун энэ орчноос огтхон ч цэрвэсэнгүй. Энэ бүх орчинд яг л өөрийнхөө гэр шигээ хандаж хаана юу байгааг сайтар мэдэж байх нь тэр. Айснаасаа болоод бөмбөгнөтөл чичрэх жаахан охин Намууны үйлдлийг хянан нүд салгалгүй ширтсээр. Ухаангүй байсан залуу бага багаар ухаан орж эхэллээ. Өөрийн нь тарьсан тариа тэр залууг ухаан оруулсан хэрэг биш гэдгийг яагаад ч юм Намуун маш сайн мэдэж байв. Намуун ухаан орж байгаа залуу, охин хоёр луу ээлжлэн харснаа үүд рүү эргэлээ. Тэрээр хаалгаа онгойлгоод гарахдаа “Үхлийн үнэр, үхлийн амтыг мэдэрцгээ” хэмээн чихарсан хоолойгоор хашхиран хэлэв. Намуун өөрийнхөө дууны өнгийг сонсоод маш ихээр айн цочирдсон хэдий ч бодит байдалдаа эргэж ирж чадахгүй л байлаа. Ингээд тэрээр гарахынхаа өмнө энгэрийнхээ дотор талын халааснаас нэгэн хурц иртэй балиусан хутга гаргаж ирээд газар орхичихов. Намуун төмөр хаалгыг гаднаас нь түгжлээ. Хүнд төмрөөр даруулж хэдэн давхар цоожилсноор хэн ч дотроос нь гарч чадахааргүй болов. Удалгүй Намуун нэгэн шатаар дээш өгсөж өнөөх үл таних залуу, жаахан охин хоёрыг түгжсэн өрөөний харалдаах дээд давхарт гарлаа. Энэ өрөө доор юу байгаа нь харагдаж болохуйц торон шалтай юм. Өөрөөр хэлбэл түрүүн Намуун ухаан алдсан залууг чирч оруулсан бүдэг гэрэлтэй жижиш өрөө төмөр торон таазтай ажээ. Гэхдээ энэ тааз шалнаасаа бараг гурван метр өндөр бөгөөд өрөөнд байгаа хэн ч гэсэн төмөр торон таазанд яагаад ч хүрэхгүй нь тодорхой байв.

Намуун бүрээс нь урагдсан түшлэгтэй зөөлөн сандал чирч ирээд доор байгаа хоёр хүнийг чөлөөтэй харж болохуйцаар тухлан суулаа. Хорь орчим минут өнгөрсний дараа түрүүний тариа хийлгэдэг залуу бүр мөсөн ухаан оржээ. Тэрээр орчин тойрноо гайхсан нүдээр ширтэж шанаа дух зэргээ эмзэглэн барьж үзэж буй нь өвдөлтөө мэдэрч байгааг нь илтгэх аж.

-Сайн уу залуу минь /Намуун өөрийнхөө чихарсан хоолойг сонсоод дахиад л хирдхийх нь тэр./

Намуун өнөөг хэр нь өөрийг нь олж хараагүй байгаа залуу руу ийнхүү хандаж хэлжээ. Энэ үгийг сонссон уг залуу цочих шиг болж дээшээ харав.

-Би хаана байна аа?

-Үхлийн амт, үхлийн үнэ цэнийг мэдрэх газар

Үл таних залуу Намууны чихарсан хоолойг сонсоод аргагүй барьц алдан сандарч “Та хэн бэ?”

хэмээн арай ядан асуув

-Үхэл бэлэглэгч. Там эсвэл диваажинд очих замыг чинь заагч бурхан чинь байна. Зулбасга минь чи намайг сайн сонсож бай. Чамд гарах гарц байхгүй. Эндээс гарах гэж, зугтах гэж яаж ч оролдоод нэмэргүй. Өөрөөр хэлбэл амьд гарах гарц чинь зөвхөн миний гарт байна.

Үл таних залуу Намууны сөөнгөтсөн яриаг үргэлжлүүлэн сонссонгүй гарах хаалга руу очоод балбаж гарлаа.

-Наад хаалгаа чи яаж ч хичээгээд онгойлгож чадахгүй. Зөвхөн би хүсвэл л наадахыг чинь онгойлгож болно. Залуу хараал тавин тийчилж ханануудыг тэмтчиж байснаа түрүүнээс хойш огтхон ч хөдлөхгүй сууж байгаа жаахан охиныг олж хараад цочих нь тэр.

Намуун сөөнгөтсөн муухай хоолойгоор инээд алдлаа. Танилц түүнийг Энхриймаа гэдэг юм. Энэ жил дөнгөж зургаан нас хүрч байгаа. Харин чамайг хэн гэдэг вэ залуу минь. /Намуун өөрийнхөө ингэж хэлэхийг сонсоод аргагүй цочирдох аж. Энхриймаа, тэгээд бас хурц хутга. Хөрш айлын Энхриймаатай яг ижилхэн чихэр горьдсон хүүхдийнх шиг нүдний харц. Гэсэн хэдий ч Намуун сэрж чадсангүй/

-Миний нэр чамд хамаагүй ээ новш оо

-Хамаатай, хамаатай. Чиний эхнэр чамайг хайрт минь, зургаан настай охин чинь ааваа гэж дуудахыг л би сонссон. Түүнээс биш чамайг өөрөөр дуудаж байсныг чинь сонсоогүй юм байна. Чи тэдэн дээрээ хэзээ ч эргэж очмооргүй байгаа юм биздээ, зулбасга минь.

-Ээ новш гэж. Надаар ер нь яах гэсэн юм бэ. Чамд мөнгө хэрэгтэй байгаа юм уу. Тэгвэл ав. Би хангалттайг өгнө. Надад зөндөө мөнгө байгаа

-Надад мөнгө хэрэггүй. Одоо зөвхөн чиний нэр л хэрэгтэй байна.

-Галбадрах, Галбадрах гэдэг юм. Сонсов уу чи, би Галаа байна. Одоо харин намайг эндээс гарга. Би чамд ямар ч муу юм хийгээгүй, тийм биздээ. Зүгээр л намайг явуулчих.

Залуу ингэж хэлээд бөгшүүлэн ханиалгаж эхэллээ.

-Чи надад муу юм хийгээгүй ээ. Гэхдээ чиний наад амьдрал чинь надад таалагдахгүй байна, Галаа. Чи дэндүү аз жаргалтай амьдарч байна шүү дээ. Гэтэл би ма их зовж байна. Чамаас ялгаатай юм надад юу ч байхгүй. Тэгсэн хэрнээ л би зовоод байна. Би гэр бүлгүй. Мэдээ орсон цагаасаа л өлсгөлөн гэж юу байдгийг мэдэрсэн. Өвчтэй ээжийнхээ аягатай хоолонд хор хийж алаад, олдсон жаахан хоолоо ганцаараа иддэг болсон. Чи муу зулбасга юу ч мэдэхгүй шүү дээ. Юу ч мэдэхгүй, намайг өлсгөлөнгөөс өөрийгөө аврахын тулд ээжийхээ амиар дэнчин тавьсныг чи мэдэхгүй.

-Чиний амьдрал чинь надад хамаагүй ээ. Чи буг ч байна уу, бурхан ч байна уу надад огтхон ч хамаагүй. Намайг яг одоо эндээс гарга.

Залуу ингэж хэлээд хаалга руу хар тэнхээгээрээ өшигчин тийчилж, орилж гарлаа.

-Галаа чи тайван бай. Наад хаалга чинь онгойхгүй гэж би чамд хэд хэлэх ёстой юм бэ. Зүгээр

л жаахан тайван байж бай л даа. Хоёулаа ярилцъя

-Новш гэж. Би хаана байна аа?

-Чи манайд байна аа. Манайх жаахан тохь муутай байгаа байх л даа. Ирсэн зочид маань дандаа л явах гэж яардаг юм. Чи ч гэсэн бас тэдэнтэй адил юм шив дээ.

-Би явмаар байна. Чамд юу хэрэгтэй вэ, би чамд хангалттай мөнгө өгч чадна, нээрээ шүү

-Надад чиний мөнгө хэрэггүй ээ. Мөнгө хэрэгтэй байсан бол би ийм арга хэрэглэхгүй. Чи дуулж бай. Би ганцаардаж байна. Үхнэ гэдгээ мэдэхгүй хүмүүс энэ хорвоогоор дүүрэн байна. Тэд нар ууж идэж, наргиж цэнгэж, унтаж хэвтэж байна. Тэд нар юу ч мэдэхгүй сохор амьтад дэндүү их жаргаж байна. Чи бол тэдний л нэг. Галаа чи хэзээ нэгэн цагт үхнэ гэж бодож байсан уу. Мэдээж чи бодохыг ч хүсдэггүй л дээ. Гэвч чи үхнэ гэдэг чинь үнэн. Нэгэнт л үхэх юм чинь эрт орой байх нь ямар хамаа байна. Гэтэл тэрэн дээрээ тулаад ирэхээр чи үхэхийг хүсэхгүй. Амьд үлдэхийн төлөө яаж тэмцэж тэмүүлэх бол доо. Тэнэг усан тэнэг. Хэдий тухайн үедээ амь гарч чадлаа ч гэсэн дараа нь тэгээд л үхнэ шүү дээ, тийм биздээ. Бусад хүмүүсийн үхэж байгаа нь чамд огтхон ч хамаагүй байдаг. Чи үхлээс үнхэлцгээ хагартал айдаг хэрнээ бусад хүмүүсийн үхэж байгааг ерөөсөө тоодоггүй.

-Тэгээд энэ бүхэн чинь надад ямар хамаатай юм бэ?

-Дуугүй сонсож бай. Галбадрах аа. Чи үхлийн үнэ цэнэ, амьдралын үнэ цэнийг ойлгох хэрэгтэй. Чи эндээс гарах гэж яасан их хүсч тэмүүлж байгааг чинь би харж байна. Энэ чинь л чамайг амьдрах агуу их хүсэлтэй байгааг чинь харуулж байна шүү дээ. Чиний энэ амьд явах хүсэл чинь хэр их болохыг би харахыг хүсч байна. Ойлгож байна уу, чи. Чиний энэ амьд явахсан гэсэн новшийн хүсэл чинь чамайг ямар үйлдэл хийлгэхийг чинь харъя лдаа.

-Бурхан минь, чи юу яриад байна аа. Би чамайг ерөөсөө ойлгохгүй байна. Галбадрах ингэж хэлээд түрүүчийнхээсээ ч илүү удаанаар бөгшүүлэн ханиалгалаа

-Би чамд нэг муу нэг сайн зүйлийг хэлье. Чи тайван сонсох ёстой. Өрөөний голд байгаа тэр хоосон тариаг харж байна уу. Тэр дотор хор байсан юм. Ямар ч хүнийг хоёр цагийн дотор үхүүлчихэж чадах гайхалтай хор. Их ч үнэтэй. Гэтэл одоо тэр үнэтэй хор маань чиний биен дотор орчихоод өөрийнхөө үүргийг гүйцэтгэж байгаа. Лав л би чамд энэ тариаг хийсний дараа хагас цаг хэртэй хугацаа өнгөрснийг дуулгахад жаахан харамсалтай байна гэх үү дээ

-Юу гэнэ ээ, муу өөдгүй новш. Би чинь жаахан хүүхэдтэй хүн шүү дээ. Би чамд ямар гай болсон юм бэ. Би охиндоо хэрэгтэй, ойлгож байна уу. Тэр дөнгөж зургаахан настай.

-Тийм ээ, яг л Энхриймаа шиг. Энхриймаа бас зургаахан настай. Тэр түрүүнээс хойш бид хоёрын юу ярьж байгааг сонсоод уйлаад л томоотой нь аргагүй сууж байна. Магадгүй их айж байгаа болохоор л уйлж байгаа биз. Түүнд бас аав, ээж байгаа. Тэд нар нь одоо түүнийг хайгаад сүйд болж байгаа нь мэдээж. Даанч охиноо энд байгаа гэдгийг яаж мэдэхэв. Шал өөр газраар цагдаа нартай нийлээд л хайгаад байгаа сурагтай байсан. Би түүнийг өчигдөр шөнө энд авчирсан. Тэг яг танай охинтой чацуу, цэцэрлэгт явдаг хөөрхөн охин.

Галбадрах Энхриймаа руу харлаа. Өөрийн нь охинтой дэндүү адилхан охин аврал эрсэн нүдээр өөр лүү нь ширтэж байхыг Галаа олж харжээ

-За тэгээд Галаа чи цааш нь сонсож бай. Би чамд сая муу мэдээг нь дуулгалаа. Одоо харин сайныг нь дуулгана. Чамд амьд үлдэх боломж байгаа. Бүр амьд үлдээд эндээс гараад явах боломж байна. Гэхдээ энд нэг дүрэм үйлчилдэг юм. Энэ өрөөнд хоёр хүн байна. Энэ хоёр хүний нэг л амьд гарах болно. Миний юу ярьж байгааг чи ойлгож байна уу. Чи Энхриймааг ал. Хоолойг нь хутгаар хэрч. Тэгвэл би чамд хорны ерөндөгийг өгөх болно. Энэ тариаг өөрийнхөө судсанд тарихад л болно. Ойлгов уу

Өөрийгөө ингэж хэлээд бас нэгэн өөр тариаг атган авч Галаад харуулж байгаагаа Намуун харж байлаа.

- Энэ бол ерөндөг. Чамайг Энхриймааг алж чадвал энэ ерөндөг чиний шагнал байх болно. Тэгээд чи өөрийнхөө эхнэр хүүхэд дээрээ очих боломжтой болно гэсэн үг л дээ. Тэд чинь чиний дуртай хоолыг хийчихээд хүлээж суугаа гэдэгт би итгэлтэй байна.

- Новш гэж. Юу гэсэн үг вэ. Тэр чинь ямар ч эсэргүүцэл үзүүлэх чадваргүй жаахан охин байна шүү дээ. Би яаж түүнийг алах юм бэ. Би үүнийг хийж чадахгүй шүү дээ

-Сайн байна. Бас хүн чанартай эр байх нь ээ. Мэдээж чи Энхриймааг алахгүй байж болно оо. Тэгвэл энэ жаахан охин надаас илүү чамд баярлана. Гэхдээ мэдээч цаг орчмын дараа үхэхэд охин эндээс ганцаараа гарах болно. Энэ бол шудрага хэрэг. Чи охиныг амьд үлдээхийн тулд өөрийнхөө бүх амийг зольж чадах уу. Энэ бол миний тоглоомын гол дүрэм. Бүх шийдвэр чиний гарт байна. Охиныг алаад өөрийгөө амьд үлдээх үү, өөрийгөө үхүүлээд охиныг амьд үлдээх үү?

Энэ бол чиний сонголт. Эцэст нь хэлэхэд чиний сонголт оо хийх хугацаа чинь улам бүр багассаар байгаа гэдгийг сануулъя. Хор чиний биед маш хурдтайгаар тархаж байгаа.

-Тэнгэр минь, заавал ингэх хэрэг байгаа юм уу. Надад ерөндгөө өгчихөөч дээ, гуйж байна. Галбадрах ингэж хэлээд цусаар бөгшүүлэн ханиалгав.

-Чи харж байна уу. Хор магадгүй миний хэлсэн хугацаанаас ч өмнө чамайг үхүүлж мэдэх юм. Ямар ч үйлдэл шагналтай байх ёстой. Чиний охиныг алсны төлөөх шагнал бол ерөндөг

-Тэнгэр минь би яаж ийм жаахан охиныг алах юм бэ. Би чинь амьдралдаа хонь ч алж үзээгүй шүү дээ

-Би чамайг заавал ал гэж албадаагүй биз дээ. Зүгээр л сонголт өгсөн. Харин алийг нь сонгохоо л чи өөрөө шийд. Яахав хэрвээ охиныг өрөвдөж байгаа бол чи хэсэг хугацаанд тарчилж байгаад л дуусчихна. Харин охиныг алья гэвэл би хаалганы ойролцоо хутга орхичихсон байгаа шүү. Тэр хутга чиний үйлдлийг чинь хөнгөвчлөх болно

-Хараал идсэн муу гаж донт оо. Би энэ хоёр сонголтын чинь алийг нь ч хийхгүй мэдэв үү. Би эндээс гараад чамайг барьж зохих газарт нь аваачиж шийтгүүлэх болно.



-Тэг ээ, тэг. Оролдоод үз. Харин дэмий л цаг алдсан хэрэг болох болов уу гэж би айж байна.

-Өөдгүй амьтан, амилсан чөтгөр. Гаж донтой муу новш. Чи бол адгуус. Муу адгуус, чи муу бол ердөө л нэг муу гаж донтой адгуус...

Галаа үгээ гүйцээж чадалгүй бөгшүүлэн ханиалгаж бүр эвхрэн унаад цусаар бөөлжив. Гэтэл энэ үед аль түрүүнээс хойш өрөөний буланд чимээгүйхэн мэгшин уйлж байсан Энхриймаа охин Галаагийн хажууд гүйж ирлээ. Тэрээр “Ах аа та зүгээр үү” гэж хэлээд өөрийнхөө цэцгэн хээтэй жижигхэн алчуураар завжийг нь даган урссан цусыг арчиж байв. Галбадрах юу ч хэлэлгүй охин руу ширтсээр...

Намуун энэхүү хар дарсан аймшигт зүүднээсээ сэрэх гээд чадахгүй байлаа. Тэрээр өөрийнхөө өмнөх насны амьдралдаа хэн байснаа харж байгаагаа маш сайн ойлгож байв. Би алуурчин байсан байх нь гэсэн бодол түүний оюун ухаанд эргэлдэж байгаа ч тэрээр энэ үзэгдлээсээ салж чадахгүй тарчилсаар.

-За тэгэхээр Галаа минь. Чамд одоо ердөө их л удаж гучин таван минут үлдсэн шиг байна. Гэхдээ энэ бол миний тооцоо л даа. Үхэх мөч хүртэл чинь гучин таван минут. Яахав бас ч гэж багагүй хугацаа. Чамд сонголтоо хийх цаг байна аа.

-Өөдгүй адгуус

Галбадрах ингэж хэлээд өндийлөө

-Галаа чи охинтой, тэр охиндоо өөрийгөө маш их хэрэгтэй гээд л үсчээд байсан биш билүү? Чамайг тэр охиныхоо төлөө бас өөрийнхөө амьд явах өдрүүдийнхээ төлөө юу хийж чадахыг чинь би харж байна. Эсвэл бас хаа хамаагүй харь элгийн жаахан охины амийг аврах өрөвчхөн сэтгэлтэй юу гэдгийг чинь үзье. Гэхдээ чи хичнээн өрөвчхөн байлаа гээд өөрийнхөө амийг золиослоно шүү дээ. Энэ бол гайхалтай тоглоом, хамгийн гайхалтай сонголт. Алийг нь ч сонгосон ялгаа байхгүй ээ. Үхэл амьдрал хоёрын үнэ цэнийг ойлгох, үхлийн амтыг мэдрэх энэ гайхалтай тоглоомыг би хүн бүхэнд тоглуулахыг хүсч байна. Үхэл эсвэл амьдрал. Амьд явах эрхээ авахын тулд эсэргүүцэл үзүүлэх чадваргүй охинд үхэл бэлэглэх ёстой. Ха, ха....ямар гайхалтай хэрэг вэ

Намууны энэ үгийг хэлсэн сөөнгө хоолой хонгилоор нэг хадав. Энхриймаа охин Галаагийн гараас барьж хажууд нь чимээгүйхэн суух нь түүнээс амьдрал гуйх мэт. Чимээ аниргүй хэдэн хором өнгөрөв. Галаа гэнэт шийвэл боллолтой маш огцом өндийж босоод охиныг маш хүчтэй түлхэж унагаалаа. Тэгмэгцээ тэрээр бүдчин алхаж үүд рүү зүглэн очоод гарагт унагасан хурц хутгыг авах нь тэр.

-Зүйтэй. Галаа чи өөрийнхөө төлөө, бас өөрийнхөө гэр бүлийн төлөө гайхалтай сонголт хийх гэж байна. Охиныг ал, гэхдээ охины амьдрал гуйсан харц чамайг үхэн үхтэл санаанаас чинь гарахгүй гэдэгт би итгэлтэй байна.

-Амаа тат, адгуус минь. Би чиний хэлснээр охиныг ална. Харин чи амласан ёсоороо надад ерөндгийг өг.

-Тэгэлгүй яахав. Би адгуус ч гэсэн хэлсэндээ хүрнэ шүү

Намуун ерөндгийг Галаад үзүүлж хөгжин баясч байв. Харин Гадаа хутгыг авч Энхриймаа руу дөхөж байлаа. Тэрээр замдаа бөгшүүлэн ханиалгаж ам хамраас нь цус садрах аж. Гэсэн ч Галаа охин руу улам дөхсөөр. Тэрээр охиныг алж өөрөө амьд үлдэхээр эргэлт буцалтгүй шийдсэн бололтой. Жижигхэн дөрвөлжин өрөөний булангуудыг дамжин Энхриймаа уйлан зугтах аж. Тэрээр “Ахаа намайг битгий алаач дээ гуйж байна. Би танд өөртөө байгаа бүх тоглоомуудыг зөндөө олон чихэртэй өгье тэгэх үү гуйж байна. Намайг битгий алаач дээ” хэмээн уйлан дуугарна

Галаа энэ үгийг сонсоод тэссэнгүй бололтой гартаа атгасан хутгаа хана руу шидэж орхиод газар сөхрөн унаж духаараа шал мөргөж байв. Харин энэ бүхнийг дээрээс нь харан сууж буй Намууны урьд төрөл тааламжтай нь аргагүй инээд алдаж байлаа. Галаа дахин бөгшүүлэн ханиалгаж хамар амнаас нь бүр чихнээс нь хүртэл цус гарч эхлэв.

-Охин чинь чамайг хүлээж байгаа даа Галаа. Гэхдээ зүгээр ээ, чи Энхриймаа охиныг аварсан юм чинь диваажинд очих байх. Гэхдээ л эхнэр охин хоёр чинь чамайг хүлээж байгаа. Эхнэр чинь чиний дуртай хоолыг хийчихээд хамтдаа орондоо орохыг хүсч байгаа. Гайхалтай, гэтэл чи энд айлын охиныг авраад өрөө үхэж байдаг.

-Адгуус минь чи амаа татаач

Галаа тэссэнгүй бололтой чангаар хашхиран босоод саяын шидсэн хутгаа очиж авлаа. Галаагийн нүд яг л улангассан араатных шиг болон хувирч Энхриймаа руу дөхөв. Энхриймаа хэдий зугтахыг хүссэн ч Галаа хоёрхон харайгаад жаахан охины үснээс шүүрээд авлаа. “Би амьд үлдэхийг хүсч байна, би амьд үлдэхийг хүсч байна. Надад ямар ч буруу байхгүй” гэсэн Галаагийн шивнэх үгс Намууны чихэнд дуулдах төдий сонсогдох аж. Гүйцээ, Галаа жаахан охиныг орилуулан ар нуруугаар нь газар унагаж байгаад гартаа атгасан хурц хутгаар хоолойг нь хэрччих нь тэр. Галаагийн нүүр лүү цус үсрэхэд тэрээр муухай орилж хутгаараа охины биеийг ямар ч өрөвдөх сэдэлгүйгээр бүлж орхилоо. Бас дахиад бүлэв. Бас дахин...бас дахин... бас дахин...

Цус харсандаа ч тэр юм уу, Галаа бүр аймшигтайгаар улангасч орилж байхдаа ерөндгийг авах ёстойгоо мартчихав бололтой. Өндийж ирээд дээшээ Намуун руу харан хараал урсгаж АДГУУС МИНЬ хэмээн чарлаж байлаа. Би чамайг ална даа, харж л байгаарай. Би чамайг заавал ална. Галаагийн хоолой нь дахин дуулдахаа больж хахаж цацан долоон сүвээр нь цус цутгаад хөсөр унав. Намуун хэдий ерөндөгтэй тарилгыг доош нь унагасан ч Галаа түүнийг нь авч амжилгүй амьсгал хураажээ. Өшөө хорсол дүүрэн шингэсэн түүний нүд Намуун руу цоо ширтэж байлаа. Өмнөх амьдралаа харж байсан Намуун гэнэт сэхээ оров. Тэрээр өөрийгөө алуурчин байснаа ойлголоо. Уг нь Намуун угаалгынхаа өрөөний үүдэнд ухаан алдан унасан ч тэндээсээ хөдөлчихсөн байх нь тэр. Гал тогооныхоо өрөөнд баруун гартаа хутга барьчихсан явж байх бөгөөд зүүн гараараа хөрш айлынхаа Энхриймаагийн үснээс чирчихсэн байдалтай байлаа.

-Намуунаа эгч ээ, та намайг битгий алаач дээ тэгэх үү, би гуйж байна. Би танд хүүхэлдэй бас өөртөө байгаа бүх чихрүүдээ өгье. Энхриймаагийн энэхүү уйлан дуугарах үг Намууны

зүрхийг зүсэх шиг болов. Тэрээр Энхриймаагийн үсийг ч тэр, хутгаа ч тэр зэрэг тавьлаа. Намуунаа өөрийгөө чухам яагаад ийм үйлдэл хийж байгаагаа ойлгосонгүй. Ямартай ч түүнтэй учраад байгаа энэ бүх муу муухай зүйлүүд өөрийн нь урьд насны алуурчны амьдралтай нь холбоотой гэдгийг тэрээр ойлгох шиг.

Энхриймаа охин гал тогооны өрөөний буланд суугаад мэгшин уйлж эхэллээ. Энхриймаагийн уйлахаас өөр чимээгүй энэ мөчид гэнэт утас дуугарах чимээ хадлаа. Энхриймаа охины хүзүүнээс зүүлттэй гар утас дуугарч байх нь тэр. Охин утсаа авснаа Намуунаа руу харав.

-Намуунаа эгчээ, тантай Галаа ах ярья гэж байна.

Хоёр хацрыг нь даган урсаж байсан нулимсныхаа шорвог амтыг Намуун хэлээрээ амталлаа. Тэрээр нэг л мэдэхэд харилцуурыг авчээ. Харин Энхриймаа охин зөрж гараад гүйчихэв.

-Үхлийн үнэр, үхлийн амт ямар байна даа. АДГУУС МИНЬ. Үхдэл болох цаг чинь ирлээ.

Намуун энэ үгний хариуд юу ч хэлсэнгүй. Тэрээр тагтан дээрээ гарчихсан зогсож байв.

"Адгуус минь үхлийн амтыг мэдэр" гэсэн үгс Намууны чихэнд цуурайтсаар.

Намуун тагтан дээрээсээ доош тонгойн харахад газар дайвалзан харагдаж нүүр лүү нь босоод ирлээ.

**Төгсөв**

## ЦОГЦОС ЧАНГААГЧ

Салхины аясаар нээлттэй цонх хяхтнан дуугарна. Зуны сэрүүн шөнийн бүүдгэр тэнгэрт өнчин сарнаас өөр юу ч үл үзэгдэх энэ үед зуслангийн байшингийн хоёр давхрын жижиг өрөөндөө хүлээтэй хэвтэх хорин хоёр настай бүсгүй айдаст автан шаналсаар.

Эл бүсгүйг Уянга гэх бөгөөд нөхөр нь, нөхөр нь ч гэж дээ найз залуу нь өглөө гараад явсан. Гэхдээ одоо удахгүй ирэх байх. Урьд шөнөжингөө архи ууж, огтхон ч унтуулахгүй хэрүүл өдөн, сүүлдээ гартаа тааралдсан бүхнээ авч шидээд баахан агсам тавьсан. Түүгээр ч зогсохгүй бүр гар хүрч зодсон. Уг нь энэ этгээд өмнө нь хэзээ ч ингэж байгаагүй бловч өчигдөр шөнө огт өөр хүн болчихсон гэлтэй.

Уянга аав ээж, хамаатан садангүй орь ганцаараа нэгэн бөгөөд Дэрмээ хэмээх эл залуутай хамтран амьдраард хагас жил хэрээтэй болж байгаа. Тэрээр уйлсаар нүд нь бөлцийн хавдаж, хацар нь нулимсандаа түлэгдсэнээс чимчигнэн хорсож байлаа. Хамаг сэтгэлийг нь айдас жихүүдэс эзэмдэж, зүрхнийх нь цохилтоос өөр юу ч энэ умгар өрөөнд сонсогдохгүй байх шиг. Яах ч аргагүй үхлээ хүлээх мэт шаналан хэвтэх хөөрхий бүсгүйн ухаан санаа самуурч гүйцээд байснаа саяхан жаахан сэхэл авах шиг болжээ. Харанхуй өрөөнд бараг нүдээ ч цавчилгүй хаалга руу ширтэн суугаа тэрээр өчигдөр шөнө ёстой нэг үзээгүй юмаа үзсэн гэхэд болно. Дэрмээ түүнийг хоосон хардаж нүүр нүдгүй балбаж, хоолойг нь багалзуурдан эгээтэй л алчихаагүй. Тэгснээ сүүлдээ “Чамайг алахгүй бол алдахгүй байх ямар арга байгаа бол?” гэж хэлээд үзэн ядалтаар дүүрэн харцаар ширтсэн. Тэгж хэлэхдээ Дэрмээгийн хоолой чичирхийлж гар нь салгалж байсан нь эрүүл ухаанаа аль хэдийн гэж орхисныг нь илтгэж байсан. Тэгээд “Чамайг амьдаар чинь хөлийг чинь тайраад зөвхөн өөрийнхөө эмэгтэй болгоно” гэж хэлээд явсан. Уянга энэ бүхнийг бодон айдаст автан шаналсаар.

...-Би чиний гар хөлийг чинь тайраад хаячих уу? Тэгвэл чамайг надаас өөр хүн тоож харахгүй, бас чи хаашаа ч явж чадахгүй. Энэ жаахан зэрлэг сонсогдож байгаа байх л даа. Гэхдээ чи үүнийг зөв талаас нь ойлгож надад хайртайгаа баталбал бид хоёр хэмжээлшгүй аз жаргал амсах болно.

-Дэрмээ чи чинь...юу яриад байна аа. Би ...би ерөөсөө ойлгохгүй байна. Дөрвөн мөч нь хүлээтэй хэвтэх Уянга айж сандарсан нүдээр Дэрмээг салахгүй ширтэж байлаа.

-Үгүй ээ чи сайн ойлгож байгаа. Би чиний зарим нэг мөчийг чинь тасдаж хаяна. Тэгснээр зөвхөн чи бид хоёр л хамтдаа жаргалтай байх болно. Үүнд чинь ойлгож ядаад байх юм юу ч байхгүй. Би зүгээр л чиний нэг хөлийг чинь цэвэрхэн гэгч нь тайрчихья. Тэгээд л гүйцээ. Харин чи аль хөлөө тайруулахаа өөрөө мэднэ биз.

-Дэрмээ би чамд хайртай шдээ. Чи тоглож байгаа биздээ. Ингэж хэлэх үедээ Уянга түүнийг үнэхээр өөрийн нь хөлийг тайрчихаж чадна гэдгийг мэдэж байв. Өмнө нь дунд сургуульд нэг ангид сурдаг байсан залуу өөртэй нь мэндлээд өнгөрөхөд Дэрмээгийн нүд яг одоогийнх шигээ ийм хачин аймшигтай болж хувирсныг санах.

-Боль доо, би үнэнээсээ хэлж байна. Хөлийг чинь тайрна гэдэг чамд яг тохирсон шийтгэл өлөгчин минь. Чи надаас хаашаа ч холдохгүй, зөвхөн энд, зөвхөн миний эмэгтэй байх болно.

Чи баяртай байгаа биздээ. Чи бол өөрөө ч мдэхгүй нэг л мэдэхэд хөлд нь хий ургаад эр хайгаад явчихдаг. Тийм болохоор миний энэ үйлдэл чамд л тусалж байгаа хэрэг. Чиний дутагдалтай сул талыг чинь засаж байгаа юм. Тэгээд л ойлгочиход болно.

-Өөдгүй адгуус минь, чи ингэж чадахгүй. Энэ хүлээсээ тайлаадах.

Уянга ингэж хэлснийхээ төлөө гэдэс рүүгээ хэд хэдэн удаа хүчтэй өшиглүүлээд авлаа. Цээжинд нь цус амтагдаж цурхиран уйлах гэсэн хэдий ч дуу нь гарсангүй. Зүгээр л ам нь ангалзан нулимс урсаж бие нь чичирхийлэх аж. Тэгснээ Уянга хэл амаа эвлүүлэн байж арайхийн дуугарлаа.

-Хэрэв би үхэх юм бол миний сүнс чамайг ээрч багалзуурыг чинь шахах болно доо.

-Өлөгчин минь амаа татахгүй бол наад хэлийг чинь ч гэсэн огтолж орхино гэж мэдээрэй. Уянга айсан бололтой таг чимээгүй болон эвхрэн хэвтлээ.

...Энэ явдал яг үүр цайхын алдад болсон бөгөөд хөөрхий бүсгүйн шаналж гасалсан дууг

Дэрмээгээс өөр хэн ч сонссонгүй. Дэрмээ Уянгаад хоол цай идүүлэх гэсэн боловч Уянга түүнийг нь харсан ч үгүй. Тэгэхээр нь Дэрмээ дахин галзууртлаа уурсаж хүлээтэй хэвтэх бүсгүйн дээрээс хэдэнтэй хүчтэй дэвсэлж орхиод өрөөний хаалгыг саван гарав. Уянга сая нэг тамлалаас саллаа гэж санаад хүлээсээ тайлахыг оролдтол өрөөний хаалга онгойж Дэрмээ эргэн орж ирлээ. Тэрээр Уянгаагийн хүлээсээ тайлах гэж оролдож байгааг ойлгоод ачаа бараа боодог ногоон өнгөтэй нарийн олсоор дахин давхарлан хүлэв. Одоо Уянга хэчнээн хичээж зүтгээд ч хүлээсийг тайлж чадахаас нэгэнт өнгөрснөө ухаарав. Дэрмээ бүр галзууртлаа уурласан байх бөгөөд “Би мэс заслынхаа багажийг авчраад чамайг амьдаар чинь мөчлөх болно. Чи харж л байгаарай. Чи дөнгөж саяхан сүүлчийнхээ боломжийг алдлаа” хэмээн хашхираад Уянгаагийн амыг скочоор дарчихав. Дэрмээгийн хувьд одоо гуч дөнгөж гарч байгаа, өмнө нь мэс заслын эмчээр ажиллаж байсан, олон ч хүмүүсийн хөл гарыг тайрч тасдсанаа гайхуулан ярьдаг нэгэн. Тиймээс Уянгааг “амьдаар нь мөчлөнө” гэсэн нь үнэн байж тун мэдэх юм.

Дэрмээ байшингаа гаднаас нь цоожилж орхиод машинаа асаан хот руу давхилаа. “Арай ч дэндүүлчихэв үү дээ” гэсэн бодол Дэрмээд төрөх авч “Ингэж бага зэрэг айлгах хэрэгтэй тэгэхгүй бол давраад хүссэн үедээ араар тавьж самуураад байх санаатай” хэмээн өөртөө хэлж өөрийгөө зөвтгөх аж. Дэрмээ хотын төвд ирээд ганцаараа бааранд орж баахан пиво уув. Нүргэлсэн чанга хөгжмийн чимээ, хоолой хорсгосон тамхины гашуун утаа бас худалдаж авсан зуун грамм цагаан архи нь Дэрмээгийн уусан пивонд нь нэмэрлэсээр түүнийг амархан согтоох нь тэр. Орой болж нар шингэхийн алдад нэлээд халамцсэн тэрээр хотод байдаг орон сууцандаа очиж өмнө нь ашигладаг байсан мэс заслын хэрэгслийн иж бүрдэл бүхий цүнхийг авлаа. Дэрмээ гарах хаалганд өлгөөтэй байдаг гоёмсог хүрээтэй толиндоо нүүрээ харан хэсэг саатав. Хэдий тачирхан ч гэлээ үргэлж тосолж тордож байдаг үс нь бүр өнгөө алдаад сааралтчихаж. Бараг үсгүй шахам хөмсөг, жартгар нүд, булцгар хацар, нарийн жимбэгэр уруул гээд энэ бүхэн нь цөм Дэрмээгийн өөрийн нь уур бухимдлыг төрүүлэх нь тэр. Тэрээр бүр дунд сургуулийн бага ангид байхдаа л өөрийнөө энэ зохимж муутай царайнд сэтгэл дундуур байдаг байсан. Одоо тэр бүгд нь яг л хэвээрээ. Сэтгэлд таасан гоё сайхан

хүүхнүүдтэй уулзахаараа дандаа л царайгаараа гологдчихно. “Эр хүн сармагчинаас арай илүү царайлаг байхад л ОК” гэсэн хэн нэгний хэлсэн үгээр өөрийгөө тайвшруулж явдаг байсан ч өмнө нь бааранд танилцсан нэг хүүхэн түүнийг “Чамтай унтсанаас сармагчинтай унтсан нь хавьгүй дээр” гэж хэлээд Дэрмээг амьдаар нь үхүүлчихсэн гэхэд болно. Дэрмээ өөрийгөө толинд харах энэхэн агшиндаа мөн л урьдын адил өөрийгөө голонгуй харж байснаа муухан мушийгаад гарч одлоо. Оройн 22 цаг өнгөрч байв. Уянга муу өлөгчин яаж байгаа бол. Намайг очоод мэс заслынхаа хутгыг үзүүлээд жаахан айлгачихаар дараачийн удаа гадуур сэмбэгнэж явахыг чинь харна аа гайгүй. Дэрмээ амандаа ийн үглэсээр орцны үүдэн дээр түр орхисон RAV4 гэсэн бага оврын жийп машиныхаа хаалгыг татлаа. Энэ агшинд Дэрмээгийн харын сэтгэл гэнэт асар хүчтэйгээр оволзон оргилж “Уянга муу шулам арай хүлээсээ тайлчихаад нэг новштой заваараад байж байгаа юм биш биз” хэмээн өөртэйгээ бодлоороо ярилцаад авав. Энэ бодолтой нь зэрэгцэн түүнд Уянгааг эзэмдэхсэн гэсэн хүсэл байж ядтал төрөх нь тэр. Ингээд Дэрмээ зуслангийн байшин руугаа ум хумгүй яаран давхилаа.

Уусан пиво нь толгойд нь орж манаруулж байсан ч зовох юмгүй машинаа жолоодож байсан түүнтэй замын цагдаа таарсангүй. Тэрээр 32-ын тойргоор эргэхдээ нэгэн элентра маркын машинтай тун ойрхон зөрж мөргөлдөх шахлаа. Зуны орой машиныхаа цонхыг нээн салхи татуулан хурдалж яваа Дэрмээ өөрийг нь “Солиотой новш” гэж хараахыг сонсоод хариуд нь дунд хуруугаа гозойлгон хаазаа нэмэв. Ха ха, солиотой новш гэнэ шүү. Зүйтэй яг үнэн. Би бол солиотой новш. Тиймээс ч би одоо очоод Уянгаад мэс засал хийнэ гэж айлгана. Уг нь зүгээр л айлгана гэж бодож байгаа ч шаардлага гарвал ямар ч эргэлзээгүйгээ хөлийг нь огтолж орхино доо. Тэгээд л гүйцээ.

..Уянгаа ухаан нь дахин балартаж байгаагаа мэдэрч байсан ч хүлээснээсээ хэрхэн яаж мултарч болохоо эргэцүүлж байлаа. Үүний хажуугаар Дэрмээ хэзээ хүрч ирээд миний хөлийг салгах бол гэж бодохоос биеэр нь гүйх цус царцах шиг болно. Бас дээрээс нь бүтэн өдөр юу ч идээгүй байгаа болохоор ходоод нь хонхолзож, толгой нь эргэх аж. Хэрвээ Дэрмээ үнэхээр хүрч ирээд миний хөлийг тайрах дээрээ тулбал би өрсөөд үхэх хэрэгтэй гэж Уянгаа өөртөө хэллээ. Өөдгүй, царай муутай, гаж донтой новш. Мөнгөтэй царайлаад гайхуулаад байхаар нь хууртчихсан нь миний амьдралын хамгийн том алдаа болжээ. Ингэж хүний ад болж, хүний гарт орж, өнчин өрөөсөн амьдарч явахаар үхчихвэл мөн амар аа. Уянгаа хэдий ингэж бодох авч энэ бодолтой нь зэрэгцэн амьд явахын агуу их хүслэн оргилох аж. Оройн салхи сэвэлзэж, моддын навчис сэрчигнэн ямар нь үл мэдэгдэх шавжнуудын исгэрэх дуу сонсогдоно. Уянгаа хүлээсээ тайлах гэж дэмий оролдох болгондоо шалан дээр өнхөрч хүчээ барах аж. Ядаж байхад ам нь скочоор дараастай байгаа болохоор зөвхөн хамраараа амьсгалж, түүнээс болоод заримдаа амьсгал нь давчдан бачуурч байлаа. Элдэв хүн% машины чимээ сонсогдох нь эрс багасч харанхуй нөмөрлөсөн байгаагаас үзэхэд шөнийн 24 цаг болчихсон бололтой. Дэрмээ хэзээ ирэх бол, эсвэл ирэхгүй юм болов уу. Хэрвээ ирэхгүй байвал тун сайнсан. Ийм орой болчихсон болохоор тэр муу хөсрий архичин хаа нэгтээ тасраад уначихсан байж мэдэх юм. Харин өдийд ирдэг юм аа гэхэд лав л сайн юм болохгүй дээ. Машинаа согтуугаар жолоодож яваад осолд ороод бэртээд, эсвэл нэг мөсөн үхчихсэн байгаасай билээ. Уянгаа үнэхээр Дэрмээг үхчихсэн байгаасай хэмээн тэсгэлгүй хүсч байв. Гэвч түүний энэ хүслийг нь айдсаар солин нэгэн машины дуу улам бүр тодрон сонсогдож яг Уянгаагийн хэвтэж байгаа байшинг чиглэн явсаар үүдэнд нь ирж зогслоо.

Хараал идмэр, энэ чинь Дэрмээгийн машины дуу яг мөн байна. Муу өөдгүй гаж донт удахгүй ороод ирэх байхдаа. Уянгаа ингэж бодмогцоо хүлээсээ тайлах гэж эцсийнхээ хүчийг шавхан тийчиллээ. Гэтэл харин чангалж эрчилсэн хүлээс нь овоо сулрах янзтай болоод ирэв. Хүн айж сандрахаараа ердийнхөөсөө хэд дахин илүү хүч гаргаж чаддаг ажээ. Байшингийн хаалга нээгдэж, гартаа жижгэвтэр хар цүнх атгасаар Дэрмээ ороод ирлээ. Тэрээр амандаа ямар нь үл мэдэгдэх дуу аялж, эцэст нь “Би бол солиотой новш” хэмээн амандаа үглэх нь сонсогдов. Тэрээр огтхон ч түүртэлгүй дээд давхар өөд шатаар өгслөө. Энэ үед Уянгаа бүр хүлээсээ тайлж эхлэх нь тэр. Харин Дэрмээ дээд давхарт гарч ирэхэд ердөө л шатны дөрөв тавхан гишгүүр үлджээ. Уянгаа хөл дээрээ дөнгөж босоод амнаасаа скочоо салгах агшинд өрөөний хаалга нээгдэн Дэрмээ орж ирээд гэрэл асаав.

-Өө муу янхан. Хүлээсээ тайлаад хаана очиж хэнтэй самуурах гэв?

-Дэрмээ чи...юу...би хаашаа ч явах гээгүй. Нөгөө ....

Дэрмээ түүний үгийг гүйцээлгүйгээр гараа зангидан Уянгаагийн шанаан тус газар нь хүчтэй цохиж унагав. Уянгаагийн толгой аймшигтай хөндүүрлэн өвдөж, шанааных нь яс янгинах аж. Тэрээр босъё гэж бодсон ч чадсангүй. Харин Дэрмээ өрөөний хаалгыг цоожлоод түлхүүрийг нь халаасандаа хийлээ.

-Хайрт минь надад цохиуллаа гээд гомдох хэрэггүй ээ. Би чамд бяцхан бэлэг авчирсан. Дэрмээ ингэж хэлээд мэс заслын багажны цүнхээ онгойлгон нэгэн жижгэвтэр мөнгөлөг өнгөтэй хурц иртэй хутга үзүүлэв.

-Үүнийг чи юу болохыг мэдэж байна уу? Энэ бол чиний наад хэнд ч хэрэггүй новшийн хөлийг чинь хэрчих хутга. Энэ хутга өмнө нь олон хүний хөл гарыг тайрахад тусалсан миний үнэнч хамтрагч байгаа юм.

Уянгаа нүднийхээ булангаар хутгыг харлаа. Дэрмээ үнэхээр намайг алах нь шиг байна. Энэ залуу бүр солиорчихжээ. Энэ яргачны гарт тамлагдсанаас зүгээр амиа хорлочихъё. Харин яаж...

Дэрмээ гэнэт нэгийг санах бололтой Уянгаагийн өмссөн богино банзлын доогуур гараа шургуулав

-Болиоч, гаж донтой новш минь. Надад бүү хүр

-Чи эсэргүүцэх хэрэггүй ээ. Хэрвээ эсэргүүцэх юм бол би чамд мэдээ алдуулах тариа хийлгүйгээр мөчлөх болно шүү

Уянгаа айж сандрахдаа бүр яахаа мэдэхгүй дагжин чичирч байлаа. “Цонх... тиймээ цонх” Уянгаа амандаа ингэж шивнэмэгцээ хоёр гараараа Дэрмээгийн нүүрийг самардаж орхилоо. Их хүчтэй самардсан болохоор түүний урт ургуулсан гурван ч хумс хугарчээ. Дэрмээ муухай орилон нүүрээ алгаараа дарахад хурууных нь завсраар цус урсав. Энэ агшинд Уянгаа ухасхийн өндийж, цонх мөргөн хагалж тэр чигтээ доошоо уналаа. Хуурай газар пидхийн унах чимээ гарснаа нам жим болох нь тэр.

-Муу янхан минь чамайг ална даа гэсээр Дэрмээ нэг гараараа нүүрээ дарж саяхан хагарсан цонх руу гүйж очин доош харлаа. Шөнийн харанхуйд нэгэн бараан дүрс газарт бүдэг бадаг харагдах аж. Дэрмээ халаасаа ухан тэмтчээд өрөөний түлхүүрийг гарган хаалгаа нээгээд шатаар доошоо буув. Уянгаа амьсгал хураажээ. Уг нь Дэрмээ хоёр давхраас унаад ингээд шуудхан үхчихнэ гэж байхгүй хэмээн сэтгэх авч ямартай ч Уянгаа үхчихэж. Дэрмээ түрүүлгээ харан унасан цогцсыг мөрнөөс нь татан эргүүлж хараад үхлийн шалтгааныг энэ харанхуйд там тум ойлгох шиг болов. Үхлийн шалтгаан бол хоёр давхраас унасанд биш харин хагарсан шилэнд байсан ажээ. Дэрмээ Уянгаагийн хүзүүг өргөөд доор нь хар бараан шингэн бүээн зүйл тунаран байхыг олж мэдэв. Уянгаа шилэнд хүзүүгээ зүсчихсэн бололтой. Хоолой нь хэрчигдэж үхсэн хүн яг л агааргүйдэж амьсгал нь боогдож үхдэг хүнтэй ижил мэдрэмж амсдаг гэсэн хаа нэгтээ сонсож байсан яриа нь Дэрмээгийн санаанд орлоо. Уянгаа одоохондоо үхээгүй, гэхдээ үхэж байгаа хэмээн Дэрмээ зөвхөн өөртөө дуулдахуйцаар аяархан шивнэлээ. Уянгаагийн бие аажмаар хөрөөд эхлэв. Дэрмээ яахаа мэдэхгүй амьгүй болсон цогцсын дэргэд толгойгоо салаавчлан газар сууж байлаа. “Новш гэж, муу өлөгчингөөс болоод хүн амины хэрэгт холбогдох нь дээ. Гэхдээ энэ өлөгчинг үхсэн гэдгийг нь хүмүүс мэдсэн тохиолдолд л би хэрэгт татагдана шүү дээ. Тийм болохоор энэ цогцсыг хэн ч олохгүй газар аваачаад булж орхиход л болох биш үү” Дэрмээ өөртөө ийн хэлээд газраас өндийлөө. Түүний уусан архи, пиво нь энэ гэнэтийн үйл явдлаас болж толгойноос нь ор мөргүй арчигдан алга болжээ. Нүүрээ маажуулснаас урсаж байсан цус нь тогтсон ч гэсэн чимчигнэн хорссон хэвээр байв. Дэрмээ гэртээ буцаж ороод үүднийхээ өрөөнөөс хог хийх зориулалтай 4-5 метрийн урттай хар өнгөтэй том гялгар уут, жижгэвтэр хүрз, жоотуу, гар чийдэн аваад буцаж эргэв. Новш гэж ойр хавьд хүн амьтан байсан болов уу, уг нь бараг уулын мухарт айлуудаас нэлээд зайдуу байрлалтай болохоор энд чухам юу болж байгааг хүмүүс төдийлөн мэдэхгүй бас сонирхох ч үгүйсэн. Хүмүүс мэдээгүй ээ, мэдээгүй. Бүр юу ч мэдээгүй. Бас би айхгүй байна, яагаад гэвэл би бол “Солиотой новш” Тийм ээ, солиотой новш юунаас ч айдаггүй юм. Одоо юу хийхээсээ ч бас айхгүй.

Дэрмээ Уянгаагийн амьгүй болсон цогцосын дэргэд иржээ. Тэрээр орчин тойрноо ажиглан хэсэг харав. Тээр доор, байшингаас нь нэлээд зайтай нэгэн машины гэрэл гялсхийгээд өнгөрлөө. Өөр гэрэл чийдэн харагдсангүй. Бас доор байгаа айлуудын нохдын хуцах дуу Дэрмээ рүү биш өөр ямар нэгэн зүйлд чиглэсэн нь андашгүй аж. Дэрмээ бүр зориг ороод ирлээ. Хэн ч хараагүй юм чинь энэ муу янхны цогцсыг мод руу оруулаад хурдхан булчихъя. Тийм ээ, солиотой новшийн хувьд энэ зэргийн юмыг хийх нь гарын алгаа эргүүлэхтэй адил хялбархан зүйл. Дэрмээ өнөөх хогийн том гялгар уутаа дэлгээд түүн дээрээ Уянгаагийн цогцсыг өргөж тавьлаа. Цогцос ямар ч уян налархай биш хөшингө байдалтай болсон нь Дэрмээд жигтэйхэн эвгүй санагджээ. Яг л арьс махных нь завсраар аалз ороод гүйж байх шиг тийм мэдрэмж төрөх нь тэр. Одоо энэ цогцсыг гялгар уугаар битүү ороох хэрэгтэй. Дөнгөж ороож эхэлмэгцээ Дэрмээ нэг зүйлийг мартсанаа санан гэр лүүгээ буцаж гүйлээ. “Олс” хэмээн Дэрмээ амандаа үглэсээр түрүүний Уянгаагийн үсэрсэн хоёр давхрын өрөөнд орон түүнийг хүлж байсан ногоон олсыг авлаа. Одоо яаравчлах хэрэгтэй. Хурдлахгүй бол түрүүн доогуур явж байсан машин энэ хавиар хүрээд ирж мэдэх юм шүү. Зугаалж яваа хэсэг залуус майхан барьчих газраа хайгаад ирж юуны магад. Хэдий харанхуй шөнө болсон ч гэсэн архи ууж халамцсан залуус үүгээр хүрээд ирэхийг үгүйсгэх аргагүй. Тиймээс хурдлах хэрэгтэй. “Солиотой новш” минь түргэлээрэй.



Цогцсыг гялгар уугаар ороогоод өнөөх саяын авчирсан нарийн олсоор тойруулан хүлжээ. Дэрмээ энэ ажлаа хийж дуусмагцаа чухам яагаад ингэж хүлсэн юм бол оо гэж өөрөөсөө асуув. Үхсэн хүн ямар амилаад босоод ирэх биш, ингэх шаардлага уг нь байхгүй л байждээ. Гэсэн ч ямар буцааж тайлалтай биш. Энэ үед Дэрмээ өөрийнхөө нэгэн далдын учир нь үл ойлгогдох аймшигт хүслийг мэдрэх шиг болжээ. Тэгмэгцээ хоёр гараараа нүүрээ хүчтэй үрээд цогцсыг өргөж зүүн мөрөн дээрээ тохлоо. Цогцсыг ороосон гялгар уут шажигнан дуугарсан нь Дэрмээг давхийтэл цочиход хүргэв. Тэрээр гар чийдэнгээ өмднийхөө халаасанд хийж, баруун гартаа хүрз жоотуу хоёроо хамтад нь атган алхлаа. Цогцос хүнд байна, гэсэн ч энэ бол солиотой новшийн хувьд асуудал биш байх ёстой. Дэрмээгийн нүүрээр нь хөлс урсаж, хамаг бие нь чилж байсан ч шүд зуун ойн гүн рүү өгссөөр. Дэрмээ гэнэт зогтусах нь тэр. Түрүүний адын хүсэл нь төрөв үү эсвэл залхуу нь хүрэв үү. Ямартай ч тэрээр дахин дээшээ алхсангүй. Дэрмээ хэдэн хором тээнэгэлзэн зогссоны эцэст хүрз жоотуугаа доош нь хаяад цогцсыг газарт буулгаж тавьлаа. Тэгмэгцээ халаасаа ухан гар чийдэнгээ гаргаж ирээд орчин тойрноо ажилгав. Болно оо, яг энд л булчихъя.”Хол явах хэрэггүй ээ, хэрэггүй. Юмыг яаж мэдэхэв буцаагаад...” Дэрмээ амандаа шивнэсэн үгээ гүйцээсэнгүй. Тэрээр өөрөө ч мэдэлгүй газар ухах ажилдаа идэвхийлэн орчихсон байлаа. Саяхан бороо орсон болохоор ч тэр үү газрын хөрс ухахад тохиромжтой зөөлөн аж. Хар хөлс нь цутган эцэж цуцаж байсан ч Дэрмээ нэг ч удаа амралгүй нэг метр орчим гүнзгий нүх ужжээ. Гялгар уугаар ороож дээрээс нь олсоор хүлсэн Уянгаагийн цогцос руу Дэрмээ хяламхийн харснаа тун шийдэмгий өргөж аваад нүх рүү шидчихлээ. Тэгснээ дээрээс нь шороогоо булж эхлэв. Гэхдээ тэрээр шороогоо хүрзний талаар хутган бага багаар нүх рүү хийж байв. Дэрмээгийн хамаг бие нь салганан чичирхийлэх аж. “Новш гэж, би ер нь юу болчихоод байна аа” хэмээн тэрээр цөхөрсөн шинжтэй дуу алдлаа. Тэгснээ баруун гараараа өөрийнхөө хацар луу хүчтэй алгадаад авав. Энэ нь яг л ухаанаа алдатлаа уусан хүнийг сэргээх гэсэн үйлдэл мэт. Дэрмээд энэ үйлдэл нь тус болов бололтой хүрзээ дүүртэл шороо хутгаж эхлэв. Цогцсыг булжээ. Гэхдээ түрүүний ухаж гаргасан шороог бүгдийг нь буцааж хийсэн ч гэсэн энэ хэсэг газар урьдын шинжиндээ орсонгүй бага зэрэг хонхойж хоцров. Дэрмээ хүрз, жоотуу, гар чийдэнгээ аваад гэр рүүгээ уруудан алхлаа. Тэр Уянгаагийн үхэлд огтхон ч харамсаагүй атал яагаад ч юм энэ цогцос булсан газарт хорогдоод байгаагаа мэдэрч байв. Дэрмээ хэд хэдэн удаа эргэж харахад түүний нүдэнд айдас биш өөр ямар нэгэн далд хүслийн гал оргилж байх шиг. Тэрээр энд эргэж ирэхээ мэдэж байлаа.

...Хөшиг нь нээлттэй цонхоор зуны өглөөний нарны хурц гэгээ тусахад Дэрмээ хар дарсан зүүднээсээ давхийтэл цочин сэрэв. Өчигдөр шөнө, бараг үүр цайхын алдад Дэрмээ үхтлээ ядарсан хүн Уянгаагийн цогцсыг булаад гэртээ иржээ. Яаж орон дээрээ хэвтээд унтсанаа ч санахгүй байв. Ямар ч байсан өчигдрийн өмсөж байсан хувцастайгаа тэр чигтээ бүхлээрээ унтжээ. Өмд цамцных нь энд тэндээ шороо болон халтардсан байхыг олж харав. Дэрмээ ум хумгүй хувцсаа солиод өчигдрийн Уянгаагийн хоёр давхраас унасан газарт хүрч ирлээ. Хэдий өглөө болсон ч гэсэн ойр хавьд нь хүн амьтан харагдахгүй байгаа нь Дэрмээд ихээхэн олзуурхууштай хэрэг болов. Учир нь өчигдөр шөнийн Уянгаагийн хүзүүнээс асгарсан цус нь хэн ч харсан анзаармаар хэсэг газрыг улаан хүрэн болгожээ. Дэрмээ өчигдөр шөнө газар ухахдаа ашигласан хүрзээ гэрийнхээ үүдний хажуухнаас олж тэр хэсэг газрыг яаравчлан сэндийлж орхив. Одоо бол ямар ч байсан цус урссан гэсэн ул мөр үлдсэнгүй. Хэрвээ хүмүүс сонирхвол цонхныхоо харалдаа доор цэцэг тарих гэсэн л хүн байгаа биз. Бас хагарсан шилний үйрмэгийг ч цэвэрлэж, цонхоо дахин шиллэж амжив. Дэрмээгийн санаа бага зэрэг

амарч гэр лүүгээ орж явахдаа Уянгааг булсан газрын зүг өөрийн эрхгүй харлаа. Өчигдөр шөнө Уянгааг үхсэний дараа төрөөд байсан тэрхүү тааж хэлэхэд бэрхтэй адын хүсэл замхран арилах биш харин ч бүр улам хүчтэй сэргэжээ.”Тийм ээ, Уянгааг эзэмдэх юмсан” Түүний энэ хүсэл нь бүр хотод очиж мэс заслынхаа багажийг авах үеэс л төрж байсан. Гэтэл харамсалтай нь Уянгаа үхчихсэн шүү дээ. “Гэхдээ...гэхдээ л...” Дэрмээ энэ бодлоосоо өөрийн эрхгүй цочиж, өөрөөсөө айн самгардав. Ер нь өчигдөр шөнө яах гэж цогцсыг уугаар битүү ороож бүр дээрээс нь олсоор хүлэв ээ. Магадгүй ийм зүйл болж мэдэхээс сэргийлсэн хэрэг үү? Далд ухамсар аа гэж. Өөрийн нь дотор өөр нэгэн хүн орчихоод эрүүл ухаанд багтамгүй адын хүслийг өдөөгөөд байх шиг Дэрмээд санагдах аж. Гэтэл яг энэ бодолтой нь зэрэгцэн хэн нэгэн түүний чихэнд “Чи бол эрүүл хүн биш, чи чинь солиотой новш шүү дээ” гэж хэлэх шиг болов. Хараал идмэр гэж. Дэрмээ амандаа ийн хараагаад гэртээ орж түрийвчээ авлаа. Машиныхаа түлхүүрийг авах гэснээ больж нэлээн доор байрлах дэлгүүрийн зүг явган алхлаа.

Лагерийн жижигхэн дэлгүүрт өнөөдөр харьцангуй хүн ихтэй байв. Дэрмээ ч ямар нэгэн зүйл худалдан авахаар дараалан зогсож байгаа арав орчим хүмүүсийн ард очлоо. Гэтэл лангууны хажууд дараалан зогсож байгаа хүмүүсийн эсрэг талд байсан 40 орчим насны хоёр халамцуу залуугийн нэг нь Дэрмээг харснаа уулга алдах нь тэр.

-Хөөх, өнөөх сайхан хүүхний чинь нөхөр архи авахаар зогсож байх шивдээ. Бас нүүрэн дээрээ шинэхэн сорви олчихсон байна. Чамайг чинь Дэрмээ гэдэг байх аа залуу минь?

-..../Дэрмээ энэ асуултанд хариулах шаардлагагүй гэж үзсэн бололтой/

-За яахав ээ, чи дуугархгүй байсан ч болно. Чамайг эмч байсан гэдгийг чинь би мэдсэн. Чам шиг ийм эмч хүн манай зусланд нэг ч байхгүй. Тийм болохоор чи энэ хавьд их хэрэгтэй хүн. Түүнийгээ дагаад их мөнгөтэй ч болж болно. Даанч чи хүмүүсээс дайжиж ганцаараа тэр дээр уулын энгэрт байшин барьсан байдаг.

Энэ хүн өөрийг нь ийм сайн мэдэж байгаад Дэрмээгийн уур хүрлээ. Уянгааг бас сайхан хүүхэн гэж байна. Муу янхан энэ хавийн хэдэн архичидтай хүртэл явалддаг байсан байх нь ээ. Тэгээд л намайг хүртэл инэж сайн мэдэж байгаа биз. Муу новшийн хүүхэн үхсэн нь болсон юм. Энэ үед Дэрмээгийн өмнө зогсож байсан хүмүүс хүссэн юмаа авч явснаар түүний ээлж иржээ.

-Хоёр шил архи, бас зургаан лааз пиво авья

Дэрмээ худалдагчид мөнгөө тоолж өгөөд эргэхэд өнөөх яриа өдөөд байгаа халамцуу эр түүний гарнаас нь татаж зогсоов.

-Хүн юм яриад байхад огтхон ч тоохгүй муу байна шүү. Танихгүй ч байсан хүнтэй ядаж мэндлэх хэрэгтэй. Муугийн ёс биш Монголын ёс байна даа. Намайг Базараа гэж дуудаж болно, энэ хавийнхан андахгүй. За тэр яахав. Эр хүн эр хүндээ хайртай гэдэг. Өчигдөр жаахан хэтрүүлж орхисон чинь дотор гэж авах юм алга. Яг л баахан зараа орчихоод секунд тутам үржээд байх шиг байна. Миний юу хүсээд байгааг ойлгож байгаа биздээ.

Дэрмээ түүнд юу ч хэлсэнгүй, юу ч өгсөнгүй дэлгүүрээс гараад явчихав. Тэрээр тортой пиво,

архиа барьсаар гэрийнхээ зүг цухалдан алхав. Гэтэл Базараа түүнийг ингээд явуулахыг хүссэнгүй бололтой араас нь гараад иржээ.

-Хөөе новшийн харамч, хувиа хичээсэн залуу минь чиний хүүхэнтэй унтахад сайхан байсан шүү. Ялангуяа урт хөл, тонтгор өгзгийг нь илж таалахад түүнд их таалагдаж байсан. Чамд нэг зөвлөгөө өгөхөд өөрийнхөө эрхтнийг томруулах тал дээр анхаарахгүй бол удахгүй хаягдаж мэдэх юм шүү.

Дэрмээ эргэж харсангүй. Халамцуу Базараатай зодолдоод ямар ч сайн юманд хүрэхгүй. Энэ согтуу толгойт өөртэй нь хэрүүл зодоон үүсгэх гэж л ингэж байгаа юм хэмээн бодов. Гэхдээ Дэрмээ түүний хэлсэн “өөрийнхөө эрхтнийг томруулахгүй бол хаягдана” гэснээс бусад бүх үгэнд итгэжээ. Учир нь одоо Дэрмээ ямар ч байсан Уянгаад хаягдахаас нэгэнт өнгөрсөн. Царай муутай, цалин багатай, гаж донтой бүр жижигхэн эрхтэнтэй байсан ч Уянга одоо өөрийг нь хаяж чадахгүй. Тийм ээ, солиотой новшийг үхсэн хүүхэн хаяж чаддаггүй юм. Бас түүнийг хүссэнээрээ эдэлсэн ч болно. Тэр яаж ч чадахгүй. Яагаад гэвэл тэр үхчихсэн бас би солиотой новш болохоор. Түүнтэй унтахын тулд заавал гуйж царай алдаж элдэв бэлэг сэлт эсвэл уран цэцэн үг хэрэглэх шаардлагагүй болсон. Гүйцээ, ӨНӨӨ ШӨНӨ СОЛИОТОЙ НОВШ ҮХСЭН ХҮҮХНИЙ ЭДЛЭХ БОЛНО. “Би бол солиотой новш” хэмээн амандаа зоргоороо аялсаар Дэрмээ гэртээ бараг хүрээд иржээ.

...Өдрийн халуун нар шатаж байлаа. Тээр доор урсах голын эрэг дээр хүүхдүүдийн шуугилдан тоглох нь сонсогдох төдий аж. Дэрмээ байшингийнхаа босгон дээр бөгсөөрөө суугаад пиво шимж байв. Базараа муу новш хүн доромжилчихоод бас юм олж долооно гэж бодсон юм байх даа. Муу хувхай архичин үхэж далдраасай билээ. Дэрмээ ийнхүү өнгөн дээрээ Базарааг зүхэж суугаа ч дотоод сэтгэл нь орой болохыг тэсгэлгүй хүлээж байв. Тийм ээ, өнөө орой ч халуухан юм болно доо гэж хэн нэгэн түүний чихэнд шивнэх шиг. Дэрмээ өөрөө өөртэйгөө бодлоороо тэрсэлдэж эхэллээ.

-Чөтгөр авмар гэж, би одоо ер нь яагаад байна аа. Хэчнээн хүсч байсан ч гэсэн цогцостой нөхцөж болохгүй шүү дээ. Энэ бол бузар хэрэг.

-Үгүй ээ, огтхон ч бузар биш. Муу новшийн хүүхнийг хүссэнээрээ эдэлж, хууртагдаж байсныхаа өшөөг авах хэрэгтэй.

-Гэхдээ л Уянгаа үхчихсэн шүү дээ

-Үгүй ээ. Тэр зүгээр л хөдөлж, өөдөөс эсэргүүцэж чадахгүй болчихсон. Энэ нь харин ч сайн хэрэг. Чи түүнтэй яг өөрийнхөө хүссэнээр хиймээр байсан ч хэзээ ч тэгж чадаагүй шүү дээ. Одоо бол хүслээ гүйцэлдүүлэх боломж гарч ирлээ. Тэгээд ч Уянгаа бол маш тачаангуй, сайхан хүүхэн. Тэрэн шиг тийм хүүхэн дахиж амархан олдохгүй.

-...Новш гэж, миний эрүүл ухаан хаана явна аа

-Эрүүл ухаантай байх албагүй. Эрүүл ухаанаар амьдарч байна гэж өөрөө өөрийгөө сэтгэлийн шоронд хийн тарчлааж байснаас хүссэнээрээ жаргасан нь дээр. Тэгээд ч чи бол эрүүл ухаантан биш солиотой новш. Солиотой новшийг хэн ч зогсоож чаддаггүй юм. Солиотой

новш хүссэнээ хийх болно. Түргэлэхгүй бол цогцос муудаад ялзарч эхэлнэ. Тиймээс өнөө шөнөөс хэтрэх хэрэггүй

Дэрмээгийн харц нэг л мэдэхэд өнөөх өчигдөр шөнө Уянгааг аваачиж булсан уул өөд, ойн гүн рүү тэнүүчлэн оджээ. Уг нь яг одоо ч хамаагүй явж очоод Уянгааг авчирмаар байгаа ч өөдгүй хүмүүс харчихна. Тэгэхээр миний хүссэн юм бүтэхгүйд хүрэн шүү дээ. Зүгээр л шөнө болохыг тэвчин хүлээе.

Дэрмээ худалдаж авсан хоёр шил архиныхаа нэгийг задалж аяганд хийгээд залгиж орхив. Дотор нь халаад нэг л сайхан болох шиг. Эрүүл ухааных нь эцсийн үлдэгдэл болох айдсыг нь ч гэсэн энэ халуун шидэт ундаа ор мөргүй хөөн зайлуулах шиг боллоо. Шөнө болохоор очиж газар ухах болно. Амьгүй цогцсыг гаргаж ирэхийн тулд газар ухна. Тийм болохоор муу хувцсаа өмсөж багажаа бэлдэх хэрэгтэй. Бас хамгийн гол нь сэтгэл зүйн бэлтгэлтэй байх ёстой. Орой хүчтэй байхын тулд чадвал одоо унтах хэрэгтэй. Тэртээ тэргүйөчигдөр шөнө дутуу нойртой хоносон. Дэрмээ архинаасаа аяганд дахин нэг хийж аваад хоолой руугаа гулгуулчихав. Түрүүчийнхээсээ ч илүү сайхан болж байна. Харин одоо унтах хэрэгтэй. Алив солиотой новш минь шөнө жинхэнэ эр хүн шиг байхын тулд одоо хангалттай сайн амарч ав, ор луугаа яв. Энэ орон дээрээ чи одоо ганцаараа унтах ч гэсэн шөнө хоёулаа болсон байх болно.

Дэрмээ нам унтчихжээ. Түүнийг сэрэхэд нар жаргачихсан гэгээ тасарч байв. Уусан архинаасаа болоод ч тэр үү, толгойд нь дөчин литрийн савтай ус хийчихсэн юм шиг хүнд оргино. Бугуйн дахь цагаа харвал оройн 22 цаг болж байлаа. Одоо хурдхан шиг босч Уянгааг авчрах бэлтгэлээ базаах хэрэгтэй. Дэрмээ хүйтэн усаар нүүрээ угаагаад дараа нь түрүүний ууж байсан архиныхаа үлдэгдлээс аягалаад татаж орхив. Янгинаж хүнд оргиж байсан толгой нь хөнгөрч дахин төрсөн юм шиг болох нь тэр. Хөөрхий өдөр өөрөөс нь архи гуйж хэрүүл өдсөн Базарааг одоо л нэг ойлгох шиг. Архи гэдэг энэ жигтэй ундааг ямар нь бий болгож надад ингэж буян болдог байна аа. Гайхалтай, сэтгэл санаа бие эрхтэн цөм өөлөхийн аргагүй сайн байна. **ОДОО ТУН УДАХГҮЙ СОЛИОТОЙ НОВШИЙН ОРГИЛ ЦАГ БОЛНО.**

...Дэрмэ хар бор ажилд өмсдөг муу өмд цамцаа өмсөөд гар чийдэндээ шинэ батарей сольж хийв. Үүдний өрөөнд хүрз жоотуу зэхээтэй, түүнээс гадна хутга хэрэг болж мэднэ, тэгээд бүх багажаа үүргэвчинд хийж үүрнэ. Дэрмээ ийнхүү өөрт хэрэгтэй бүх зүйлээ бэлджээ. Оройн

23 цаг болж байна. Гэгээ тасарчихсан, бас гэрт хүн ирэхгүй болохоор одоо явахад аюулгүй. Дэрмээ байшингийнхаа хаалгыг түгжих гэснээ орхиж зүгээр л хаалыг нь хаачихав. Тэрээр хүрз, жоотуу, ажлын бээлий хийсэн үүргэвчээ үүрээд уул руу, ойн гүн рүү тайван алхаж эхэллээ. Өчигдөр шөнө өөрийгөө нэг их хол яваагүйгээгээ Дэрмээ сайн мэдэж байлаа. Цогцос булсан газрыг хүртэл ердөө 300 метр орчим л байлаа. Хэсэг алхсны дараа Дэрмээ гэр лүүгээ эргэж харлаа. Хав харанхуй дэнхийсэн том хоёр давхар байшин ганцаараа явсан эзнээ хоёулаа болж ирэхийг нь хүлээх мэт байсан байрандаа харагдана. Өөрийн нь байшингаас цааш нэлээд доор ганц нэг гэрэл бүдэг бадаг ёлтойн харагдана. Дэрмээ буцаж эргээд цогцос булсан газрынхаа зүг үргэлжлүүлэн алхлаа. Одоо ч нэг их удахгүй зорьсон газраа хүрэх нь ээ.

...Дэрмээ Уянгаагийн цогцсыг булсан газраа яг олоод иржээ. Хүрзээр ухаад дараа нь дахин булсан яг тэр хэсэгтээ хонхойсон байгаа нь Дэрмээгийн нүдэнд өртөв. Тэрээр гар чийдэн

тусгаж ойр орчмоо тандан харав. Ямар ч сэжигтэй зүйл алга. Эргэн тойрон моддоос өөр юу ч үл үзэгдэх бөгөөд чимээ аниргүй байдал ноёрхож байв. Дэрмээ хэдий санаа амарсан ч энэ байдал нь түүнд нэг л айдас төрүүлэх нь тэр. Энэ ургахаас өөр ид шидгүй моднууд гэнэт амилж ирээд цогцос ухааж байгаа түүнийг тасар татаад хаячих юм шиг санагдана. Гэсэн хэдий ч Дэрмээ гүнзгий амьсгаа аваад хүрээрээ ухааж эхэллээ. Солиотой новш юунаас ч айдаггүй юм. Түүний гар хөл нь чичирхийлж нүүрнийх нь арьс таталдан чимчигнэнэ. Дэрмээ нэг их хүч хөдөлмөр, цаг зав гаргасангүй ухааж дууслаа. Тэрээр хүрзний ир гялгар уутанд хүрэхэд ухахаа зогсоож гар чийдэнгээ тусгаж харав. Гялгар уугаар битүү ороож, чивчиртэл нь хүлсэн цогцос шороон дундаас цухалзан харагдаж байлаа. Бас үүнтэй зэрэгцэн ялзалын эхний шинж тэмдэг эвгүй муухай үнэр хамар өөд цоргив. Дэрмээ амьгүй болсон цогцсыг ороосон олсноос хоёр гараараа чангаасаар нүхнээс гаргаж чадлаа. Дэрмээ ухсан нүхийг буцааж булах гэснээ шаардлагагүй гэж үзсэн бололтой тэр чигт нь орхиод багажаа үүргэвчинд хийж үүрэн Уянгаагийн цогцсыг хоёр гар дээрээ өргөн өндийв. Огтхон ч амсхийлгүй хамаг хүчээ шавхан хөдөлсөн түүний бүх бие нь чилж, жаахан амармаар байсан ч тэрээр тэгсэнгүй. Цогцсыг хоёр гартаа өргөсөн чигтээ доошоо алхлаа. Түүний нүүрээр нь хөлс дааварлан, зүрхнийх нь цохилт түргэсч хөл нь үе үе гуйвлана. Гэхдээ ингэж гуйвж байгаа нь уусан архинаасаа биш ядарснаасаа болсон хэрэг байв.

Хорь орчим цагийн өмнө Уянгаагийн цогцсыг зүүн мөрөн дээрээ өргөөд явж байхад түүний гуя зөөлхөн байгаа нь гялгар уутны гаднаас мэдэгдэж байсан. Харин одоо тийм биш байлаа. Нэг л хатуу, хөшсөн байдал мэдэгдэж байв. Бас тэгээд цогцос хийсэн гялгар уут нойтон байгаа нь цогцос муудаж эхэлснийг илтгэх мэт.

-Тэнгэр минь би юу хийж байна аа. Энэ цогцосоор би яах нь вэ. Хүзүү хоолой нь цус нөж болоод шороонд булагдсан бие нь муухай болчихсон байгаа. Зуны улиралд хөргөгчинд хийгээгүй мах ялзарч өмхийрдөг биз дээ

-Зүгээр ээ. Тэр яадаг юм. Солиотой новш сайхан цэвэрлэчихнэ. Тэгэдэ л дараа нь яг өөрийнхөө хүслээр сайхан секс хийнэ. Сайхан хүүхнийгэдэлнэ гэдэг хосгүй завшаан. Түүнд амьд эсвэл үхсэн байх нь ямар ч ялгаагүй. Зүгээр л сайхан цэнгэ. Эрүүл ухаантай байснаас солиотой новш байсан нь хавьгүй дээр. Чи бол солиотой новш, солиотой новш хүссэн бүхнээ хийж чаддаг.

...Дэрмээ байшингийнхаа өмнө иржээ. Гэтэл түрүүн цоожлолгүй зүгээр хаагаад явсан гэрийн нь хаалга нээлттэй байх нь тэр. Байшингийн гэрлийг асаагаагүйг бодоход хүн ирээгүй байлтай. Эсвэл магадгүй цагдаа нар бүхнийг олж мэдчихээд өөрийг нь энд ирэхийг хүлээгээд отоож байж мэднэ. Ямартай ч болгоомжлох хэрэгтэй. Ийнхүү Дэрмээ юмыг яаж мэдэхэв гэсэн шиг Уянгаагийн цогцсыг байшингийн буланд тавиад өөрөө үүргэвчнээсээ хутгаа гаргаж аваад байшин руу орлоо. Чих тавин чагнаад юу ч сонссонгүй. Дэрмээд гэнэт Уянгаагийн хэлсэн “Хэрвээ би үхвэл миний сүнс ирээд чиний багалзуурыг шахах болно” гэсэн үг сонсогдох шиг боллоо. Дэрмээгийн ар нуруугаар нь хүйт оргиж, нүд нь харанхуйлав. Тэрээр Уянгааг үхэхэд, булахад бас булчихаад дахин ухааж гаргаж ирэхдээ ч ингэж айгаагүй билээ. Дэрмээд айдсыг жинхэнэ утгаар нь амьдралдаа анх удаа мэдэрч байгаа юм шиг сэтгэгдэл төрөв. Нээрээ үхсэний дараа сүнс гэж байдаг юм болов уу, ингэхэд угаасаа л сүнс чөтгөр гэж байдаггүй байсан бол тийм “сүнс, чөтгөр” гэсэн нэр томъёо хаанаас үүсэх билээ. Хүн мэдэхгүй, бас

үзэж хараагүй зүйлдээ нэр өгч чадахгүй шүү дээ. Дэрмээгийн оюун ухаан тэр чигтээ айдас түгшүүрт бүрэн эзлэгджээ. Гэхдээ энэ айдас нь түүний адын хүслээ биелүүлэх сэрлийг үгүй хийж чадсангүй. Дэрмээ хэсэг тээнэгэлзэж байснаа байшиндаа ороод “гэрт хэн нэгэн байна уу?” хэмээн чанга хашхиран асууж гэрэл асаав. Таг чиг, магадгүй хэн ч байсангүй. Дэрмээ гартаа байгаа хутгаа улам чанга атгасаар бүх өрөөнүүдийг нэгжиж гэрэл асааж харав. Түүний нүдэнд хэн ч өртсөнгүй. Хаха солиотой новшийн нүдэнд хэн харагдаж зүрхлэх билээ. Хэн ч харагдаж чадахгүй, ямар ч сүнс, буг, чөтгөр харагдахгүй

-Гэхдээ надаас бусад нь

-Хэн бэ?

Дэрмээ огло үсрэн цочиж эргэн харжээ. Хэн ч алга. Гэхдээ сая яалт чгүй л миний ард, тийм ээ, яг ар талаас Уянгаа дуугарсан. Тэр мөн байсан, үгүйсгэхийн аргагүй бодитой байсан. Тэр энд байсан.

-Хэн бэ, чи хэн бэ? Чи хаана байна?

.../Таг чиг/ Гэрт Дэрмээгээс өөр амьд хүн байхгүй мэт. Дэрмээ дахин бүх өрөөнүүдээ нэгжиж үзээд хэнийг ч олж харж чадсангүй. Арай нөгөө Уянгаа чинь үхээгүй надаар тохуурхаж байгаа юм биш байгаа даа хэмээн бодсоноо Дэрмээ байшингаасаа гүйж гарлаа. Арай ч дээ бүхэл бүтэн хорь орчим цаг шороонд булаатай байсан хүн амьд байх учиргүй дээ. Байшингийн хажууд тавьсан Уянгаагийн цогцос гялгар уутанд боолттой, хүлээтэй яг тэр хэвээрээ байгааг Дэрмээ олж харав. Дэрмээгийн санаа амрах шиг, бас айдас ч төрөх шиг боллоо. Тэрээр “Шал тэнэг бодол” хэмээн амандаа шивнээд чангаар худал инээлээ. Гэхдээ түүний энэ инээд зөвхөн өөрийгөө л тайвшруулах гэснийх гэдэг нь андашгүй аж. Айж сандрах хэрэггүй ээ, солиотой новшид айх эмээх юм гэж байдаггүй. Би бол солиотой новш.

Дэрмээ Уянгаагийн цогцсыг өргөөд гэртээ оруулж ирлээ. “Сайн уу гэр минь. Үхдэл болсон эзэгтэйтэйгээ мэндлээрэй” Дэрмээ цогцсыг хоёр давхарт гаргах гэснээ больж түрүүн өөрөө ганцаараа унтсан нэг давхрын унтлагын өрөөний том орон дээр тавьлаа. “Хүмүүс ээ, солиотой новш үхдэл болж хувирсан шалиг хүүхнийг ил гаргах гэж байна. Дараа нь түүнийг хэрхэн эдлэхийг хараарай” Дэрмээгийн бодол ийнхүү ямар ч хаалт хашилтгүй үсчин тэнүүчилж байлаа. Тэр үнэхээр солиотой новш болжээ. Дэрмээ түрүүн гартаа атган явж байсан хутгаа халааснаа гаргаж ирээд ууттай цогцсыг ороосон ногоон өнгөтэй нарийн олсыг тас огтлов. “Энэ уутанд богино банзлынхаа дотуур дотоож өмсөөгүй эсэргүүцэх чадваргүй залуухан тачаангуй хүүхэн солиотой новшийг хүлээгээд хэвтэж байна” Дэрмээ өөртөө ингэж хэлмэгцээ цогцсыг уутнаас нь яаран салгаж эхлэв. Цогцос ороосон уутыг задалж, урж тасдаж эхлэхэд эхүүн үнэр ханхийв. Өмхий чийгний үнэр хамар сэтлэх мэт үнэртэж, байж суух аргагүйд хүргэлээ. Уянгаагийн амьгүй болж хөшсөн цогцсыг уутнаас бүрэн салгалаа. Дэрмээ амьгүй болсон Уянгааг сая бүтэн харах нь тэр. Нүд нь хорсож занасан шинжтэй хараагаараа хэвээр байх бөгөөд хамаг бие нь хөшчихсөн цэлдэн хөх өнгөтэй харагдаж байв. Урьдын тэр хүсэл тачаал оргилуулдаг залуухан сайхан хүүхэн одоо биш болжээ. Уянгаа зүүн хөлөө бага зэрэг нугалсан хэлбэрээр хөшчихсөн байлаа. Хар өнгийн хөхөвч нь цаанаас нь гэрэлтэн харагдах нимгэн цагаан майз, богино цагаан банзал нь чийж даажээ. Бас юу юунаас илүү аймшигтай зүйл бол цусанд халтардаж шил шигдсэн ангархай хүзүү байв. Тэр хүзүүнээс цус

савирсаар бүр юүлэгдэж дуусаад хатжээ гэмээр сэтгэгдэл төрүүлэх аж. Энэ бүхнийг харан яахаа мэдэхгүй алмайран зогсох Дэрмээ гэнэт нэгэн аймшгийн дүр зургийг мэдэрлээ. Тийм ээ, нэг давхрын унтлагын өрөөний цонхны цаанаас Уянгаа өөрийгөө бас намайг ширтээд зогсож байна. Ямар ч амьгүй цэлдэн хөх царайтай Уянгаа цус нь хатаж ширгэх шахсан аймшгийн онигор хар нүдээр наашаа цоо ширтэж байна. Тэнгэр минь үнэхээр энэ дүр зураг Дэрмээгийн нүдэнд өртөх шиг боллоо. Тэрээр айж цочирдсондоо золтой л ухаан алдчихсангүй. Гэсэн хэдий ч удалгүй хэсэг хугацааны дараа Дэрмээ тайван байдлаа хадгалан үлдэж чадлаа. Тэрээр аажмаар зүүн тийш эргэж цонх руу харав. Уянгаа байхгүй байна аа. Дэрмээгийн нүдэнд юу ч өртсөнгүй. “Солиотой новш юугаа хийгээд гөлрөөд зогсчихов оо. Явж ус авчраад энэ өмхийрсөн цогцсыг угаагаач. Бас энэ өмхий ханхлуулж байгаа илжирсэн уутыг гаргаж хая.” Дэрмээ өөрөө өөрийнхөө тушаалыг үг дуугүй биелүүлэхээр илжирсэн уутыг хамж аваад Уянгаагийн цогцсыг ганцааранг нь магадгүй сүнстэй нь хамт орхиод гарч одлоо. “Новш гэж хүн үхэхээрээ ийм муухай болчихдог билүү. Уг нь өмнө нь зөндөө л үхсэн хүн харж байсан ч яг иймийг хараагүй юм шиг. Ядаж байхад тэр нүд нь нэг л зэвүүн, аль хэдийн үхсэн ч гэлээ яг л намайг эргэж харахад араас дагуулж ширтээд байх шиг байна.” Энэ удаад Дэрмээ бодлоо эсэргүүцэж тайвширч чадсангүй. Үүдний өрөөнд орж ирээд чухам яах гэсэнээ мартаад хэсэг тээнэгэлзэн зогслоо. Тэгснээ байшингийнхаа үүдийг нээж гадаах орчин тойрныг ажиглав. Сарны гэрэлд уулын энгэрийн ой модод бараантан харагдаж, сэрүүн салхи үе үе сэвэлзэх аж. Ямар нэгэн машин, амьд амьтны дуу сонсогдсонгүй. Хүн бүхэн өөрийн нь чухам юу хийхийг нь анхааралтай ажиглаж байх шиг тийм мэдрэмж Дэрмээд төрж байв.

-Ээ новшнууд аа. Та нар миний юу хийхийг хармаар байна уу. Түүнтэй яаж секс хийхийг үзмээр байна уу. Тэгвэл үз, хар л даа, ханатлаа харж ав. Та нар харж л таашаал авна л даа муу аймхай новшнууд. Та нар хэзээ ч над шиг хүссэнээ хийж чадахгүй шдээ. Солиотой новш та нарыг удаан хүлээлгэхгүй ээ, одоохон. Би хүслийг чинь биелүүлээд өгье.

Дэрмээ энэ үгийг чанга хашхиран хэлэхэд нь ядаж хариуд нь хаа нэгтэйгээс нохой ч хуцсангүй. “Солиотой новшийн шоу эхэллээ. ЭРХЭМ ХҮНДЭТ ҮЗЭГЧИД ЭЭ”

Дэрмээ тун удалгүй хорин литрийн канистртай ус барьсаар Уянгаагийн цогцсыг орхисон өрөөний хаалганд тулж ирэв. Хаалга хаалттай байх чинь. Уг нь хааснаа санахгүй байгаа ч гэсэн өөрөө мэдэлгүй рефлексээрээ хаачихсан юм байлгүй дээ. Дэрмээ хаалга хаалттай байгаад үл ялиг жийрхсэн ч гэсэн өөрийгөө тайвшруулж чаджээ.

-Тог, тог, тог. Хонгорхон тачаангуй үхдэл минь би чам дээр очлоо шүү. Чи бэлэн үү?

-Хүлээгээрэй. Би хараахан бэлэн болоогүй байна

...Дэрмээ сонссондоо итгэсэнгүй. Байж боломгүй юм. Уянгаагийн хэлсэн саяын энэ үг үгүйсгэхийн аргагүй тод сонсогджээ. Хонгилын үзүүрээс цуурайтах мэт цангинасан, тэгсэн хэрнээ нэг л зэврүүн сэтгэл хирдхийлгэмээр тийм өнгө аястай эмэгтэй хүний ямар ч амьгүй дуу хоолой.

-...Чи, ...чи, ...чи амьд байгаа юм уу?

-... /Энэ удаад харин Дэрмээд хэн нэг нь хариулсангүй. Таг чиг/

За тэр харав уу. Саяынх зүгээр л хий юм. Хий юм сонссон байна шүү дээ. Ийм зүйл хүн болгонд л тохиолддог. Надад ч гэсэн энэ удаа тохиолдоо л биз. Сонин дээр хий юмтай учирсан, түүнийг харсан тухай элдвийн л юм гардаг. Тиймээс үүнд ердөө санаа зовох хэрэггүй. Тиймээс солиотой новш минь өрөөний хаалгыг түлхээд дотогшоо орогтун. Чамайг тачаангуй үхдэл хүлээж байна.

Хаалга хяхтнан дуугарч хорин литрийн савтай ус барьсан Дэрмээ айсан нүдээр ширтсээр өрөөнд орж ирлээ. Бас тэрээр нэг гартаа нүүр гарын алчуур атгачихсан байх бөгөөд тэр гараараа өрөөний хаалгыг хаав.

-За тэр. Новшийн сүнс минь чи тэгээд хаана байна даа. Би чиний цогцсыг чинь одоохон эзэмдэх гэж байна. Гэтэл чи амьгүй болсон цогцосоо хаяад хар амиа бодон ум хумгүй арилж өгөө шив.

Дэрмээ орны хажууд савтай хүйтэн усаа тавьлаа. Илжирсэн гялгар уутыг үүдний өрөөнд оруулсан ч гэсэн энэ өрөөнөөс өмхий ханхалсан хэвээр л байв. Тэгсэн ч гэсэн Дэрмээ энэ үнэрээс огтхон ч дайжиж цэрвэхгүй байгаа бололтой. Уянгаагийн нүд өнөөх янзаараа зэвүүнээр ширтсэн хэвээр байгаа нь Дэрмээг сэрдхийлгэхэд хүргэв. Тэрээр түүний нүдийг аниулах гэж зовхийг нь буулгахаар хуруугаараа дарсан ч гэсэн нэмэр болсонгүй. Цогцос харсан хэвээрээ л байв. Магадгүй Дэрмээ цогцосны зовхийг олигтойхон дараагүй ч байж мэднэ. Дэрмээ Уянгаагийн хараастай байгаа нүдийг аниулах гэж цогцсонд нүцгэн гараараа анх удаа хүрсэн нь энэ байлаа. Түүний долоовор дунд хоёр хуруу нь нойтон нялцгай бас хүйтнийг мэдэрчээ. Дэрмээ Уянгаагийн биедээ өмссөн цагаан майкыг тайлахаар шийдлээ. Хэдий гадуур нь уугаар битүү ороосон байсан ч гэсэн Уянгаагийн хувцас халтартаж өлөн чийг авчээ. Дэрмээ түүний майкыг сөхөж дээш нь толгойгоор нь гаргаж тайлах гэсэн боловч хувцас нь биендэ наалдаад нэг л болж өгсөнгүй. Бас түүгээр ч зогсохгүй Дэрмээ өнөөх Уянгаагийн цавчилгүй ширтэх амьгүй зэвүүн харцтай дахин тулгарахыг хүссэнгүй. Тэрээр майкыг өөр аргаар тайлахаас өөр сонголтгүй болжээ. “Ямар дараа нь өмсөнө гэх биш үүнийг нь ураад л хаячихъя. Тэгээд л гүйцээ” хэмээн Дэрмээ өөртөө зориулан амандаа аяархан шивнээд халааснаасаа хутга гаргаж ирлээ. Тэрээр майкны доороос сөхөөд хутгаа завсраар нь хийн майкыг зүсэж цуулж эхлэв. Тэгсэн хэдий ч хувцас амьгүй болсон биетэйгээ зууралдаад сайн явж өгсөнгүй. Дэрмээ үүний учрыг гэнэт олж мэдээд цочих мэт давхийх нь тэр.

-Новш гэж, энэ чинь хөөчихөж. Хөөгөөд пэндийчихсэн байна. Тэгээд л чихэлдээд бие нь хувцсандаа багтахаяа больчихсон юм байна шүү дээ.

Дэрмээ энэ үгийг яг л хэн нэгэнтэй ярилцаж байгаа юм шиг тод хэлжээ. Үнэхээр цогцос бага зэрэг хөөгөөд эхэлчихэж ээ. Ингэж хөөж байгаад л дараа нь язраад шүүс гоожиж, тэгээд хорхой шавжны хоол болдог байх нь л дээ. Дэрмээгийн оюун ухаан, бодол санаа хаа хамаагүй үсчин тэнүүчилж юунд ч торолгүй цаг хугацаа бодит байдлын хаалтыг даван одож байлаа. “Хөдөөний зами хүмүүс нас барагсдаа ил газар тавьж орхиход тэр нь халуун зун хөөснөөс болоод бүр босоод ирдэг. Түүгээр ч барахгүй бүр биелгээ хийж байгаа юм шиг хөдөлдөг” гэсэн хаа нэгтээ сонсож байсан яриа түүний санаанд оржээ. За за, гэхдээ одоо энэ хамаагүй ээ. Солиотой новшид бүр ч падгүй хэрэг. Үндсэн ажилдаа л түргэн орох хэрэгтэй.

Дэрмээ амьгүй хүүхний майк, хөхөвч хоёрыг хутгаар тас огтлон тайлжээ. Амьгүй хүүхний



нүцгэн цээж цэлдэн хөх өнгөтэй чийглэг шинжтэй байв. Зүрхний цохилт, хэвлийн амьсгалах хөдөлгөөн гээд амьд хүний ямар ч шинж тэмдэг алга. Дэрмээ хүүхний хөхийг хоёр гараараа атгаж үзлээ. Нялцгай нойтон, түүхий мах барьж байгаа юм шиг. Тийм ээ, яг л тийм мэдрэмж Дэрмээд мэдрэгдэв. Гэсэн хэдий ч тэрээр бах тав нь ханасан байртай цогцосны хөхийг атгасан хэвээр инээмсэглэж байснаа түр орхиод савтай усыг авч хүүхний бие дээр талыг нь шахуу асгалаа. Цогцосны нүд хараастай хэвээр, гэхдээ бүр Дэрмээг яг л хараад байх шиг огтхон ч цавчихгүй бас чигээ өөрчлөхгүй ширтсээр. Гэсэн ч Дэрмээ энэ үхдлийн амтгүй харцтай дахин тулгарахгүйг хичээж нүүр гарын алчуураар биеийг нь болгоомжтой арчиж эхэллээ. “Хүйтэн усаар хөл гар, биеийн нь бүх хэсгийг сайтар арчих хэрэгтэй. Тэгвэл хөшингө байдал нь алга болно” гэж тэрээр өөртэйгөө аяархан ярьж байв. Дэрмээ бүр өөрийнхөө хувцсыг нимгэлээд үхдлийн хэвлийг хоёр хөлнийхээ завсраар хийн суув. Өнөөх л хүйтэн нойтон мэдрэмж, гэхдээ эрчилсэн юм шиг гэмээр хөшингө байдал нь түүний санааг дагаад ч тэр юм уу бага зэрэг зөөлөрчээ. Гэнэт Дэрмээгийн араас өрөөний хаалга онгойж хяхтнан дуугарах чимээ гарав. Дэрмээ огцом эргэн харлаа. Хаалга аяархан нээгдэж байв. Гэхдээ хэн ч байсангүй. Хов хоосон үүдний өрөө Дэрмээгийн нүдний өмнө цэлийтэл харагдав. Дэрмээ үүдний өрөөнийхөө гэрлийг түрүүн орж ирэхдээ асаагаад дахин унтраагаагүй болохоор бүх юм ил тод харагдаж байлаа. Хэн ч байгаагүй болохоор Дэрмээгийн санаа амрах шиг болсноо төд удалгүй энэ нь айдсын мэдрэмжээр солигдлоо. Чөтгөр авмар, яагаад хэн ч байдаггүй билээ. Нүдэнд харагдахгүйгээр хэн нэгэн ороод ирсэн шүү дээ. Өрөөний хаалга өөрөө нээгдэх учиргүй. Би түрүүн орж ирэхдээ хаалгыг хааснаа сайн санаж байна. Гэтэл одоо нээгдчихлээ, гэхдээ хэн нээчихэв ээ?

Дэрмээ өөрөө өөртөө энэ асуултыг тавьжээ. Тэрээр энэ асуултынхаа хариуг олох гэсэн мэт хэдэн тийш айсан харцаар ширтэж байснаа өөрөө дээр нь суучихсан байгаа цогцос руугаа харц шилжүүлэв. “Ээ бүү үзэгд, энэ чинь юу вэ. Үхдэл над руу хараад инээмсэглэж байна. Байж боломгүй юм” Дэрмээгийн энэ бодолтой нь зэрэгцэн ар нурууных нь үс босоод ирэх шиг...

-Байж боломгүй юм, цогцос яагаад инээмсэглэсэн төрхтэй болчихов оо. Новш чинь намайг тохуурхан шоолж байгаа нь энэ үү. Муу гичий, чамайг одоохон эзэмдээд дараа нь мөчлөх болно доо.

Дэрмээ энэ үгийг бараг хашгирах шахам чанга хэлснээ Уянгаагийн богинохон цагаан банзлыг хоёр гараараа доош нь шувтлав. Гэтэл бас дахиад л арьсандаа зууралдаад явсангүй. Дэрмээ дахин хүчээ шавхаад угз татах гэтэл түүний гарыг хэн нэгэн зогсоох нь тэр. Түүний гарнаас нь атгаад авчээ. Тиймээ, Дэрмээгийн хоёр гарыг саяхан үхдэл байсан Уянгаа атгаад авчээ. Гэхдээ Уянгаагийн нүүрэнд ямар ч амьдын шинж байхгүй хэвээр бөгөөд яг Дэрмээгийн нүүр лүү ширтэн хүйтнээр инээмсэглэж байлаа. Дэрмээ муухай хашхиран гараа авах гэж тийчилсэн ч тэрээр тийм амар тавиулж чадсангүй. “Туслаарай, хэн нэгэн туслаарай. Энэ өлөгчин үхээгүй байна. Намайг авраач” Дэрмээ ийнхүү хоолойныхоо хамаг чадлаар хашхирсан ч хэн ч түүнийг сонссонгүй. Тэрээр түрүүхэн бусдад ямар нэгэн чимээ сонсгочих вий хэмээн болгоомжилж байсан бол одоо шал эсрэгээрээ болжээ. Дэрмээ тасралтгүй хашхирч байлаа.

Тэрээр дахин хөл, гар, цээжний гээд бүх хүчээ шавхан угз татаад үхдлийн нударганаас

өөрийгөө арайхийн салгаж чадлаа. Дэрмээ муухай хашхиран орноос унаж эргэж харалгүй суугаа чигээрээ нуруугаараа үүд рүү ухрав. Саяхан үхдэл байсан Уянгаа нүүрний ямар ч хувиралгүй өндийгөөд ирлээ. Тэрээр хүйтэн зэвүүн инээмсэглэлээрээ Дэрмээг огтхон ч цавчилгүй ширтэж гараа сунган түүн рүү мөлхөн зүтгэв. Дэрмээ Уянгааг нүд салгалгүй ширтэн ямар нь мэдэгдэхгүй маани бололтой нэг зүйл амандаа уншиж ар нуруугаараа дөрвөн хөллөж ухарсаар үүдний өрөө рүү орлоо. Хагас шувтарсан богино банзал нүцгэн цээжтэй Уянгаа Дэрмээ рүү гараа сунган ойртов.

-Чи үүнийг хүсээ биз дээ. Алив тэгээд хүрээд ирээч.

-Үгүй ээ...үгүй, ... зүгээр л үгүй

Уянгаа арван хуруугаа дэлгэлээ. Түүний урт ургуулсан хумсны гурав нь хугарчээ.

-Би чиний багалзуурыг чинь шахна гэж хэлсэн биз. Долоон хумс чиний хүзүүнд хангалттай. Тийм үү?

-Үгүй ээ, хэрэггүй. Гуйя, надад битгий ойрт...битгий ойрт, битгий, .... битгий надад.../тэрээр үгээ гүйцээж чадсангүй/

Гүн шөнийн харанхуйд Дэрмээгийн ийнхүү аврал эрэн хашхирахыг хэн ч сонссонгүй.

\* \* \*

Өдрийн халуун нар ээж байв. Дахиад л хэтрүүлж орхиод шараа тайлах аргаа олохгүй байгаа Базараа Дэрмээгийн уулын энгэр дэхь ганц байшинг чиглэн айсуу. Хаалга тогшлоо, хэн ч хариу өгсөнгүй таг чиг. Базараа урам нь хугарсан байртай хаалгыг хүчлэн түлхэхэд бага зэрэг нээгдэв. Гэхдээ гаднаасаа түлхэж нээгддэг хаалганы цаана ямар нэгэн хүнд юм байгаа бололтой. Байшингийн хаалганы завсраар муудсан махны өмхий үнэр сэнхийв. Базараа дахин хамаг хүчээ шавхан түлхээд Дэрмээгийн гэрт ороод ирлээ. Дэрмээ хаалгаа нуруугаараа дарж суусан чигтээ өөд болжээ. Базараа эхэндээ Дэрмээг таниагүй ч түүний нүүрэн дэх сорви Дэрмээг мөн гэдгийг нь ойлгуулахад тус дөхөм болжээ. Учир нь Дэрмээгийн нүд ямар нэгэн зүйл рүү маш ихээр айсан шинжтэй цоо ширтсэн байх бөгөөд ам нь хашхирсан байдалтай ангайчихсан, тачирхан хар үс нь цал буурал болтлоо цайжээ. Өрөөнд муудаж өмхийрсөн үнэр хамар сэтлэх нь үү гэмээр ханхийж байсан ч Базараа чухам юуных гэдгийг тааж чадсангүй.

Нэг давхрын хагас нээлттэй унтлагын өрөөний хаалга Базараагийн нүдэнд туслаа.

**Төгсөв**